



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-13
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	14-219

1. <i>Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах</i>	15-16
2. <i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	17-21
3. <i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	21-53
4. <i>Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар/</i>	53-81
5. <i>Хуралдаан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалт</i>	81-82
6. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	82-201
7. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	201-208
8. <i>Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай</i>	209-219

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, С.Амарсайхан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Б.Бейсен, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, С.Замира, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Н.Учрал, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Ч.Анар, О.Номинчимэг, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Д.Рэгдэл, Ц.Туваан;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, З.Мэндсайхан;

Тасалсан: Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, Л.Энх-Амгалан;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-2 цаг 41 минут, Ц.Баатархүү-22 минут, Б.Батбаатар-05 минут, Э.Бат-Амгалан-20 минут, Д.Батлут-02 минут, Б.Батцэцэг-1 цаг 01 минут, Д.Батчимэг-02 минут, Ж.Бат-Эрдэнэ-01 минут, Ж.Баярмаа-02 минут, Ш.Бямбасүрэн-05 минут, С.Бямбацогт-03 минут, С.Ганбаатар-1 цаг 02 минут, Д.Ганбат-18 минут, П.Ганзориг-08 минут, Д.Ганмаа-05 минут, Б.Дэлгэрсайхан-05 минут, Б.Жавхлан-55 минут, Б.Жаргалан-11 минут, Л.Мөнхбаатар-42 минут, Ц.Мөнхтуяа-01 минут, Б.Найдалаа-12 минут, С.Одонтуяа-03 минут, Б.Пунсалмаа-07 минут, Д.Пүрэвдаваа-06 минут, О.Саранчулуун-09 минут, Ч.Ундрэм-1 цаг 11 минут, Д.Цогтбаатар-29 минут, С.Цэнгүүн-15 минут, Ж.Энхбаяр-1 цаг 07 минут, Д.Энхтуяа-03 минут, Р.Эрдэнэбүрэн-2 цаг 17 минут.

Нэг.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 18

Бүгд: 86

79.1 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 17

Бүгд: 86

80.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 16

Бүгд: 86

81.4 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 16

Бүгд: 86

81.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Д.Амарбаясгалан: 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 18

Бүгд: 87

79.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 16

Бүгд: 87

81.6 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	29
Бүгд:	90
67.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	59
Татгалзсан:	31
Бүгд:	90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	27
Бүгд:	90
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

4.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 27
Бүгд: 90
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 28
Бүгд: 90
68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Р.Ринчинбазар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх,

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын ахлах шинжээч Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Н.Наранбаатар, Ж.Баясгалан, Да.Цогтбаатар, Б.Мөнхсоёл, О.Цогтгэрэл, Ж.Ганбаатар, Д.Амарбаясгалан, Л.Соронзонболд, М.Мандхай, Б.Түвшин, Д.Пүрэвдаваа, О.Саранчулуун, Ц.Баатархүү, С.Ганбаатар, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:35/

Уг асуудлыг 12 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдааны 2 цаг 32 минут үргэлжилж, 12 цаг 35 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 12 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны

Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ё.Азжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаарх мэдээллийг хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар индрээс үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Г.Ганбаатар, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, С.Цэнгүүн, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ё.Азжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Татгалзсан: 40
Бүгд: 99
57.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 42
Бүгд: 99
57.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга

З.Баасанням, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Р.Ринчинбазар, А.Энхбат, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны дарга Б.Ганболд, Татварын ерөнхий газрын Дэд дарга А.Энхболд, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Төсвийн төслийн талаарх Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус зөвлөлийн гишүүн А.Энхбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 16 цаг 11 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, У.Отгонбаяр, Б.Баярбаатар, М.Бадамсүрэн, Ц.Мөнхбат, П.Сайнзориг, С.Зулпхар, Ж.Баясгалан, А.Ариунзаяа, Ц.Сандаг-Очир, Ж.Золжаргал, Г.Ганбаатар, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Х.Ганхуяг, С.Эрдэнэбат, Т.Мөнхсайхан, Л.Мөнхбаясгалан, Г.Хосбаяр, Л.Соронзонболд, Ч.Номин, Ч.Лодойсамбуу, М.Мандхай, Х.Баасанжаргал, М.Энхцэцэг, Л.Энхнасан, Х.Булгантуяа, Ж.Батжаргал, Д.Ганмаа, О.Цогтгэрэл, Ш.Бямбасүрэн, Д.Пүрэвдаваа, О.Саранчулуун, Б.Жаргалан, Ж.Алдаржавхлан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эрүүл

мэндийн сайд Ж.Чинбүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Боловсролын сайд П.Наранбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Татварын ерөнхий газрын Дэд дарга А.Энхболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 18 цаг 02 минутаас 19 цаг 43 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, А.Ариунзаяа, Ч.Номин, М.Мандхай, Д.Пүрэвдаваа, Ж.Алдаржавхлан, Д.Ганбат нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 19 цаг 43 минутаас 22 цаг 58 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 22 цаг 58 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	41
Бүгд:	96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 23 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын ерөнхий газрын Дэд дарга А.Энхболд, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	47
Бүгд:	100
53.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	46
Бүгд:	100
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 44
Бүгд: 100
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 45
Бүгд: 100
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 23 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Ц.Оч, Э.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар танилцуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Д.Пүрэвдаваа, Б.Батбаатар, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулгатай танилцав.

Уг асуудлыг 00 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 12 цаг 46 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 06 дугаар сарын 28-ны өдрийн 00 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 03 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтга. 64 гишүүн бүртгэгдэж, ирц 50,8 хувьтай байна. Гишүүд Байнгын хороодын хурлаас орж ирж байх шиг байна. Ингээд ирц бүрдсэн тул 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 10 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. Санал хураалт байгаа. Гишүүдийг дуудъя. Эцэслэн батална.

2 дугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа нарын 20 гишүүн өргөн барьсан хуулийн төсөл байгаа.

3 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

4 дүгээрт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ. Энэ нэг дэх хэлэлцүүлгийн өмнө бид өмнөх асуудлуудыг хэлэлцэж байгаа цагаасаа харгалзаад намын бүлгүүдийг бас товчхон хуралдаж, төсвийн тодотгол болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар хэлэлцэх боломжийг олгоё гэж бас ярьж байгаа.

5 дугаарт үдээс хойших хуралдаан буюу 14 цагаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

6 дугаарт Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсны дараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт Улсын дээд шүүхэд

8 дугаарт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

9 дүгээрт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

10 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалд оръё.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Хууль зүйн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Хууль тогтоомжийн хуулийг эцэслэн батална. Санал хураалтад бэлдэж байх хооронд бас 1, 2 үг хэлье гэж бодож байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл Улсын Их Хурлын хаврын чуулган эхлэхтэй зэрэгцэж өргөн баригдаж, парламентад олон шатын хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулсан.

Улсын Их Хурлын ээлжит 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр 126 гишүүнтэй парламент 5 нам, эвслийн оролцоотой жендерийн эрх тэгш байдлыг өндөр түвшинд хангасан, нийгмийн бүлэг, сегментийн төлөөллийг хангасан ийм парламент бүрдсэн.

Энэ парламент маань хүн төвтэй хууль, эрх зүйн орчныг бий болгох зорилго тавьж, стратегийнхаа бодлогын бичиг баримтыг баталсан. Энэ 3 төгөлдөршлийн бодлогын хүрээнд Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль, тогтоол, бүх зүйл хүн төвтэй байх үндсэн зарчим дээр суурилж явна гэсэн ийм том зорилгыг бол өнгөрсөн намрын чуулганаар бид хэлэлцэн баталж байсан. Тэгвэл хаврын чуулганаар Монгол Улсад цаашдаа хууль төсөл боловсруулан өргөн барих, батлуулах бүх процессыг зохицуулдаг суурь хууль болсон Хууль тогтоомжийн хууль ийнхүү өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар эцэслэн батлагдахаар болж байгаа. Энэ хууль батлагдсанаар цаашид Монгол Улсад хэрэгжих хуулиуд нь хүн төвтэй үзэл баримтлалыг хэрэгжүүлдэг, цаг үеэсээ хоцрохгүйгээр хүний эрхийн зөрчлийг үүсгэдэггүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хууль өөрөө аливаа төрлийн олон журам дагаж хүчин төгөлдөр байдаг бус хууль нь өөрөө иж бүрэн зохицуулалтаа бие даан хэрэгжүүлж чаддаг болох энэ том үндэс суурийг тавьж байгаа ийм том хуулийн төслийг та бид эцэслэн баталж байна. Энэ хууль батлагдсантай холбогдуулаад Монгол Улсын Засгийн газарт Улсын Их Хурлаас хугацаатай үүрэг, даалгавар өгч, өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа өдөр тутмын нийгмийн харилцааг зохицуулж буй 350 орчим хуулиудыг энэ Хууль тогтоомжийн хуульд нийцүүлж өөрчлөх, тэдгээр хуулиудыг дагаж гарсан журам, дүрэм, эрх мэдэлтэн, албан тушаалтанд илүү давуу эрхийг олгоод байгаа тэр зүйлүүдийг байхгүй болгох боломж нөхцөл бүрдэх юм гэж үзэж, өнөөдрийн Хууль тогтоомжийн хууль хэлэлцэгдэж, эцэслэн батлагдахаар болсон гэдгийг бас гишүүддээ хэлье.

Ингээд санал хураалтад оръё. Пүрэвдаваа гишүүн санал хураалттай. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалтад оръё. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж, бэлэн больё. Бямбасүрэн гишүүн хааччихав. Сая энд сууж байсан чинь. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан. Санал хураалтын өмнө ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Санал хураалтад орж амжаагүй хүн байна уу. Баатаржавын Мөнхсоёл, Батын Батбаатар, Мөнхчулууны Энхцэцэг 3 гишүүн. Санал хураалтаа эхэлье. Санал хураалт.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 68 гишүүн буюу 79,1 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69 гишүүн буюу 80,2 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 гишүүн буюу 81,4 хувиар санал дэмжигдлээ.

4.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 гишүүн буюу 81,4 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69 гишүүн буюу 79,3 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 71 гишүүн буюу 81,6 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүд эцэслэн батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

10.22 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан болно.

Тус ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилт, гадаад зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон нийгмийн салбарын төсөв, эдийн засаг, дэд бүтцийн салбарын төсөв, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой мэдээлэлтэй танилцаж, санал, дүгнэлтээ нэгтгэн Төсвийн байнгын хороонд танилцуулсан болно.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар өргөн барилаа.

Тус хуульд төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдөр өргөн барьж, 11 дүгээр сарын 15-нд батлахаар хуульчилсан боловч Улсын Их Хурлын намрын чуулган 10 дугаар сард эхэлж, эхэлсэн даруйдаа төсвийн төслийг хэлэлцэж эхэлж байгаа нь төсвийн талаар Улсын Их Хурлын гишүүд, намын бүлэг, холбогдох талууд бүрэн танилцах, олон нийтийн хэлэлцүүлэг хийж, үр дүнтэй ажиллах боломжийг хязгаарлаж байгаа тул намрын ээлжит чуулганыг 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, төсвийн төслийг намрын чуулган эхэлсэн өдрөөс эхлэн хэлэлцүүлэхээр төсвийн төсөлтэй танилцах хэлэлцүүлгийн шинэ үе шат нэмж, нийт 5 үе шаттайгаар хэлэлцдэг байх нэмэлт, өөрчлөлт холбогдох хуульд оруулах, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг зөвхөн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонсож, ердийн хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу Улсын Их Хуралд хэлэлцэн баталж байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараа жилийн макро эдийн засгийн нэн чухал холбогдолтой баримт бичиг тул 4 үе шаттайгаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх тусгайлсан дэгийг бий болголоо.

Монгол Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээгээр баталдаг. Мөн Засгийн газар Улсын Их Хуралд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хамт өргөн мэдүүлээд, Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол баталдаг. Энэ нь Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлийг бүхэлд нь хянаж батлахгүй байгаа буюу өөрөөр хэлбэл орон нутаг, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг хянан батлахгүй байгаа явдал юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зохих өөрчлөлтийг оруулах, Засгийн газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөгөөний төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг тодорхой хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх, Улсын Их Хуралд танилцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбоотойгоор төсөв хэлэлцэн батлах хугацаа, чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна. Ингэснээр хоригийг хүлээн авснаас шалтгаалан төсвийг шинээр хэлэлцэх асуудал хууль зүйн маргаан үүсэхгүй байх дэгийн хувьд эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно.

Үүнийг дагалдан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы эхлэх огноог 09 дүгээр сарын 15-ны өдөр болгож өөрчлөх хуулийн төслийг боловсрууллаа. Эдгээр хуулиудыг дагалдуулан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад өөрчлөлт оруулан өргөн мэдүүллээ. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлаар төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэх 4 үе шаттай тусгайлсан дэгийг шинээр бий болгох, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэхэд төрийн аудитын байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг нэгдсэн чуулганд танилцуулах, тухайн жилд төсвийн төсөлтэй танилцах үе шатыг шинээр нэмж, нийт 5 үе шаттайгаар хэлэлцэх, намрын чуулган эхэлсэн өдрөөс хэлэлцүүлэх, Монгол Улсын тухайн жилийн төсөвт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч, хууль тогтоолыг хүчингүй болсонд тооцсон тохиолдолд хэрхэн хэлэлцэх талаарх дэгийг шинээр боловсруулах, мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы эхлэх огноог 09 дүгээр сарын 15-ны өдрөөр болгож өөрчлөх хуулийн төслийг боловсруулах, хуулиар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг хүлээсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл мэдээллийг Засгийн газар Төрийн аудитын төв байгууллагаас албан ёсоор авах эрх зүйн орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн болон Төрийн аудитын байгууллагын төсвийн асуудлыг хэлэлцэх зохицуулалтын талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69,2 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69,2 хувийн саналаар, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 61,5 хувийн саналаар, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69,2 хувийн саналаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64,3 хувийн саналаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 71,4 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна. Даваасүрэн гишүүн горимын санал.

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг эрье. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт бол төсөв хэлэлцэхтэй холбогдолтой байгаа байхгүй юу. Төсвийг тусгайлсан дэгээр хэлэлцдэг. Тийм учраас эрхлэх асуудлыг нь хариуцаж байгаа Байнгын хороогоор орохгүйгээр хэлэлцэх эсэхийг нь шийдэж болохгүй. Тэгээд төсөв хэлэлцэх хугацааг нь богиносгож байгаа юм. 9 сарын 1-ээс эхэлж байгаа юмыг 9 сарын 15 болгож байгаа юм. Тэгээд ер нь бол Тэмүүлэн нарын санаачилж оруулсан тэр хуульд бол буруу юм ерөөсөө байхгүй. 9 сарын 1-нд өргөн мэдүүлчхээд хэлэлцүүлэг, сонсгол хийхээр зохицуулчихсан байгаа байхгүй юу. Тийм учраас Байнгын хороод өөрсдөө зохион байгуулалтад ороод төсвөө сонсгол хийгээд, иргэдтэйгээ хамтраад хэлэлцүүлэг хийгээд яваад байх бүх юм нээлттэй байгаа. Тийм учраас 20, 30 жил мөрдөж ирсэн төсвийнхөө дэгийг өөрчлөх нь зохисгүй байхгүй юу. Шинэчилнэ гэдэг л хамгийн зөв зам гэж ойлгож болохгүй. Байгаа зүйлээ зөв аваад явах нь хамгийн зөв зам. Тийм учраас би энэ асуудлыг эрхлэх асуудлынх нь хүрээнд Төсвийн байнгын хороогоор хэлэлцэж байж хэлэлцэх эсэхээ шийдээч ээ гэсэн ийм горимын санал гаргаж байна. Хурааж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Үгүй ээ яах вэ, Даваасүрэн гишүүн энэ чинь нөгөө Улсын Их Хурлын тухай хуульд орж байгаа өөрчлөлт гэдэг агуулгаараа шууд Төрийн байгуулалтын байнгын хороо руу ороод хэлэлцэгдээд явчхаж байгаа юм. Одоо яах

вэ хэлэлцэх эсэхээ шийдээд харин Төсвийн байнгын хороо, Ёс зүй дэгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо хамтраад яг асуудлаа таны хэлж байгаа хувилбараар ярилцаад явахад ерөөсөө буруудах юм байхгүй байх гэж бодож байгаа. Тэгэхээр хэдүүлээ хэлэлцэх эсэхээ шийдчихээд өглөө бас ярилцъя. Таны гаргасан саналтай холбогдуулаад. Тэгээд хэлэлцэх эсэх дээрээ шийдчихээд Байнгын хороо руугаа ороод, мэргэжлийн Байнгын хороо саналаа хэлээд ингээд явчихъя гэсэн ийм байдлаар тогтсон байгаа. Энэ зүгээр гол зорилго нь ийм шүү дээ. Өнгөрсөн намар намрын чуулганаар бид төсөв батлах үе дээр Улсын Их Хурлын гишүүд төсөвтэйгөө танилцах хугацаа өгөхгүй байна. Аудитын байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс төсөв, дүгнэлттэйгээ ирдэг. Хангалттай хэмжээнд судалж, тойргоороо болон хэсэг сегмент, бүлгүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж чадахгүйгээр хэлэлцэх эсэх кноп дараад байгаа учраас энэ дээр цаглавар дээр тодорхой хэмжээний өөрчлөлт зайлшгүй шаардлагатай байна гэж үзээд энэ чинь ахиад хугацааг нь нэмж өгч байгаа шүү дээ. Хуучин төсөв хэлэлцдэгийн урд талд нь 15 хоногийг нэмж өгч байгаа байхгүй юу. Гишүүд төсөвтэйгөө танилцаж, тойрогтоо хэлэлцүүлэг хийх боломжийг нь л гаргаж өгч байгаа 1 шатын хэлэлцүүлгийг гаргаж өгч байгаа юм. Тэгээд яах вэ хэдүүлээ хэлэлцэх эсэхээ шийдчихэнгүүтээ та Байнгын хороо дээрээ аваад, энэ асуудлаараа хэлэлцээд явчих.

Ингээд асуудлаа үргэлжлүүлье. Өлзийхүүгийн Шижир гишүүний нэрийг хассан. Нэмээд оруулчихсан байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн арга хэмжээнд оролцоод явчихсан байгаа. Ингээд асуулт асуух гишүүдийн урьдчилан ирүүлсэн нэрс дууслаа. Үг хэлэх гишүүн бас нэрээ өгөөгүй юм байна.

Энэ Булгантуяа даргын ажлын хэсэг чинь 26 гишүүний бүрэлдэхүүнтэй нэлээн олон удаа хуралдаад, гишүүд бас мэдээлэл өргөн авчихсан учраас асуулт асууж, үг хэлэхгүйгээр шууд явж байна. Тэгэхээр гишүүд асуулт асууж, үг хэлэх дэг дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд бас нэрээ өгөөгүй байгаа учраас шууд санал хураалт руу оръё.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61 гишүүн буюу 67,8 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59 гишүүн буюу 65,6 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63 гишүүн буюу 70 хувиар санал дэмжигдлээ.

4.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63 гишүүн буюу 70 хувиар санал дэмжигдлээ.

5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62 гишүүн буюу 68,9 хувиар санал дэмжигдлээ.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59 гишүүн буюу 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 6 санал хураалт дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо болон Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.36 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсвийн зохицуулалт хийх зорилгоор 2025 оны төсөвт тодотгол хийх нөхцөл, шаардлага үүссэнтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлэн та бүхэнд танилцуулж байна.

Олон улсын байгууллагуудын тодорхойлж байгаагаар дэлхий дахинд тодорхой бус байдал урьд өмнө тохиолдож байгаагүй өндөр түвшинд хүрсний улмаас ихэнх

улс орнуудын эдийн засгийн идэвхжил муудаж байна. Улмаар 2025 оны эхний 5 сард манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний дундаж үнэ 72 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар унаснаар нийт экспорт 5,4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 1 тэрбум орчим ам.доллараар, төсвийн нийт орлого 11,4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 1,3 их наяд төгрөгөөр буураад байна. Цаашилбал эдийн засгийн өсөлт 2023 онд 7,4 хувь, 2024 онд 4,9 хувь байсан бол Үндэсний статистикийн хорооноос 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр зарласнаар 2025 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 2,4 хувь болж буураад байна. Эдгээр нөхцөл байдлын улмаас 2025 онд нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл төсвийн хүрээний мэдэгдэлд заасан орлогын доод хэмжээнд хүрэхээргүй байгаа тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,2 их наядаар бууруулж, нөгөө талд нь төсвийн зарлагыг 1,9 их наядаар бууруулж, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 365 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тусгаж байна. Мөн хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2025 онд 5,5 хувь, 2026 онд 5,7 хувь, 2027 онд 6,3 хувь байхаар тусгаж тооцсон болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Баясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороо 2025 оны 6 сарын 26-ны өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах зарлага нэмэгдэж,

нэгдсэн төсвийн алдагдал ДНБ 3 хувиар нэмэгдэх гэж, мөн хуулийн 34.1.4-д төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн гэж, мөн хуулийн 34.1.4-д төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төсвийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлсэн байна. Хуулийн төсөлд 2025 онд нэгдсэн төслийн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,2 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагыг 1,9 их наяд төгрөгөөр тус тус бууруулж, тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,4 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахдаа хэрэглээний үнийн өөрчлөлтийг тооцсон аргачлал болон Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь хэрэглээний үнийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан төсөлд тусгагдсан хэрэглээний үнийн өсөлтийн түвшин, валютын ханшийн өөрчлөлтийг тооцсон аргачлалын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нэгдсэн төсвийн өсөлттэй холбоотойгоор төсвийн зардлыг тооцоололгүйгээр бууруулах нь төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа болон төрийн албан хаагчдад сөргөөр нөлөөлж байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн олно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Энэ ажлын хэсгийн хүмүүс ирсэн юм уу. Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын

зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга,, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Бат-Ирээдүйн Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Бид төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж эхэлж байна. Манай улс бол үндсэндээ ганцхан эдийн засаг нүүрс дээр суурилсан эдийн засагтай ийм л улс. Тэгээд нүүрсний үнэ буурахаар зэрэг аль эсвэл өсөхөөр зэрэг эдийн засаг тэр чигээрээ хөдлөөд ингээд төсөвтөө тодотгол хийх хэмжээнд хүрдэг ийм л улс байгаа. Цаашдаа бид нар эдийн засгаа солонгоруулах, уул уурхайн бүтээгдэхүүн дотроо солонгоруулах, цаашилбал хөдөө аж ахуй, бусад салбаруудаа аялал жуулчлал гэх мэт салбаруудаа хөгжүүлэх ийм зайлшгүй шаардлагатайг бол харуулж байгаа юм. Өнгөрсөн намар бид 2025 оны төсөв батлахдаа алдагдалгүй төсөв батална гэж тал талаас нь ярьж байгаад, алдагдалгүй баталсан. Ерөнхийлөгчийн хориг тавьсан, түүнийг хүлээж авсан.

Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг чинь харвал энэ 2025 онд 1,3 их наядын алдагдалтай, 2026 онд 1,1 их наядын алдагдалтай, 2027 онд 0,8 их наядын алдагдалтай ийм төсөв байхаар оруулж ирсэн байна гэж ойлгосон. Тэгээд энэ дээр тодруулаадхаач. Би зөв ойлгож уу, буруу ойлгож уу. Цаашдаа ингээд төсөв алдагдалтай батлаад явах юм уу.

Тэгсэн мөртөө төсөв алдагдалтай баталчхаад цаашаа эдийн засаг өснө, инфляц буурна гэсэн байгаа. Тухайлбал инфляцыг 2025 онд 9,5 хувьтай байхаар, 2026 онд 7, 2027 онд 6,4, 6 гээд ингээд цаашаа инфляц багасна гээд. Тэгээд энэ танилцуулга дээр харвал энэ нүүрс болон зэс, алтны үнэ бас цаашдаа буурахаар юм танилцуулга. Тэгээд төсөв нь алдагдалтай, гол нэрийн бүтээгдэхүүний үнэ нь бууралттай гэж тооцсон мөртөө инфляц нь буураад цаашаа явна гэж тооцсон байх юм. Энэ ямар учиртай юм бэ. Цаашдаа инфляцыг 7, 6 хувь байна гэдэг чинь хэр бодитой юм бэ. Бид нар чинь цахилгаан, дулааны үнэ, тэгээд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн явж байгаа нөхцөлд үүнийг цаашаа буурна гэж

яагаад төлөвлөсөн юм. Юуг үндэслэж ингэж төлөвлөсөн юм бэ гэсэн 2 дахь асуулт байна.

3-д нь бид энэ уул уурхайгаа хайгуул, ашиглалтаа нэмэгдүүлж байж. Цаашдаа ирэх жилүүдэд бид бас тодорхой хэмжээний төсвийн орлогоо бүрдүүлэх валют олох ийм л ирээдүй харагдаж байгаа. Тийм учраас энэ ашигт малтмалынхаа нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлэхийн тулд тэр ашигт малтмалынхаа хайгуул ашиглалтын ажлыг эрчимжүүлэхийн тулд тухайн орон нутагтайгаа зохицож, орон нутагт нь аль болохоор үр өгөөжтэйгөөр энэ цаашаа уул уурхайнхаа олборлолтыг явуулах ёстой. Гэтэл өнөөдрийн байгаа энэ хууль, эрх зүй энэ төсвийн хуулиараа орон нутагт үр өгөөж байхгүй байгаа. Уул уурхайгаас орж ирэх ямар нэгэн ийм үр өгөөж муутай. Бүгдийг нь улсын төсөвт татаж авдаг ийм л тогтолцоотой байгаа. Тийм учраас цаашдаа та бүхэн ямар бодлого барьж байгаа юм. Уул уурхайн хайгуул олборлолтоо нэмэгдүүлэхийн тулд орон нутагтаа оногдох, хүртэх өгөөжийг нь нэмэгдүүлэх дээр ямар бодлого барьж ажиллах юм бэ гэсэн ийм 3 асуулт байна. Тэгээд дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр. 3, 4 дүгээр индрээс хариулт өгнө шүү. 4 дүгээр индэр. Өөрийгөө танилцуулаад.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт нь бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр төсвийн алдагдлыг өнгөрсөн онд батлахад алдагдалгүй баталж байсан мөртөө энэ онд төсвийн хүрээ дээр тодотгол оруулж байгаатай холбоотой асуулт тавьсан. Тэгэхээр өнгөрсөн оны төгсгөлөөр бол эдийн засгийн нөхцөл байдал идэвхжилтэй, үйлдвэрлэлийн потенциал буюу бодит GDP-ийн боломжийн харилцаа нь бол эдийн засаг эерэг үзүүлэлттэй, идэвхжилтэй үе байсан. Дунд хугацааны төсвийн хүрээ дээр бол төсвийн бодлогоороо энийг хадгалж, мөчлөгийн эсрэг бодлогын хүрээнд бол алдагдалгүй төсвийн бодлогыг оруулж ирж байсан байгаа. Он гараад олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдааны дайн, бусад хүчин зүйлс гадаад хүчин зүйлээс буюу Монгол Улсын өөрсдөө контролдож, Засгийн газрын контрол хийх боломжгүй гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалаад, эдийн засгийн нөхцөл байдал нэлээн хүндэрсэн. Тухайлбал, төсвийн орлого тасрах, гадаад экспортын хэмжээ буурах, экспортын орлого буурах зэрэг манай гол уул уурхайн экспортын бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаантай эдийн засгийн нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн байгаа. Тухайлбал энэ оны 4 сарын үед төсвийн хүрээний мэдэгдэл, ирэх 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж хэлэлцүүлж байх үед бол энэ оны болон хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрсний үнийг 80 ам.доллар, ирэх онд бас ингээд арай өндрөөр тооцож байсан бол яг одоогийн нөхцөл байдлаар нүүрсний дундаж үнэ 70 ам.долларын хэмжээнд буучихсан байгаа. Тэгээд бас энэ төсвийн хүрээгээ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хууль өөрчлөгдөөд, төсвийн тодотгол хийх шаардлага гарсантай холбогдуулаад төсвийн хүрээ дээр зааж өгдөг орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг бас өөрчлөх шаардлага үүссэн. Тэгээд эдийн засгийн бодит нөхцөл байдалтай уялдуулаад энэ тоонуудыг өөрчилсөн байгаа.

Яг түрүүн хэлсэн төсвийн алдагдал яагаад гарч ирж байгаа юм бэ гэвэл эдийн засгийн улирлын өсөлтөөр авч үзэх юм бол өнгөрсөн оны сүүлээр 4,6 хувийн өсөлттэй байсан бол энэ оны эхний улирлаар 2,4 хувийн өсөлттэй гарсан байгаа. Эдийн засгийн өсөлтийн хурдац нь удаашраад, саарч байгаа учраас мөчлөгийн эсрэг бодлогоороо бас тодорхой хэмжээнд алдагдлыг зөвшөөрч байгаа. Ер нь бол

Монгол шиг хөгжингүй улсын хувьд бол төсвийн алдагдал тухайн жилийн төсөв дээр алдагдал байх нь бас боломжтой. Ялангуяа манай Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр заагаад өгчихсөн 2 хувийн алдагдлын түвшин дотроо бид энэ тоогоо барьж оруулж ирж байгаа.

Инфляцын хувьд бол Засгийн газрын гаргаж байгаа инфляцын тооцоолол бол зорилтот түвшин бодлогын хэмжээнд Монголбанкны мөнгөний бодлогын уялдаа төрийн сангийн бодлогын уялдааг хангаад ийм түвшинд хүрэх нь зүйтэй гэж, ийм түвшинд барих нь зүйтэй гэж зорилтыг илүү харуулж байгаа. Бусад хөндлөнгийн байгууллагууд олон улсын байгууллагууд бол ер нь хүлээлт буюу таамаглалын түвшинд инфляцын тооцоонууд гардаг. Жишээ нь яг мөнгөний бодлогоор инфляцыг гол барьж тохируулга хийж явж байгаа Монголбанк маань зорилтот түвшин 6 дээр нэмэх, хасах 2 хувь буюу хамгийн дээд тал нь 8 хувь гэж үзэж болно. Ирэх онуудад бас Монголбанкны зорилтот түвшин нь бас буураад явж байгаа. 5 хувь дээр нэмэх, хасах ингээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дутуу хариулаад байдаг. Жоохон чангахан. Тэгээд жоохон ойлгомжтой хариулт өгөөч.

И.Батхүү: Тэгэхээр Засгийн газрын хувьд энэ оны гүйцэтгэлээ инфляцыг бас 8 хувь гэж барьж байгаа нь бол Монголбанкны зорилтот түвшинтэй уялдуулж тавьсан дүн байгаа. Инфляцыг эрэлтийн талаас болон нийлүүлэлтийн талаас 2 талаас нь авч үзэж, хүчин зүйлээр нь төсөөлж, тодорхойлж болдог. Засгийн газрын зүгээс хөдөө аж ахуйн салбарт, мөн тээвэр, логиستيкийн гаалийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд бол нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулах, энэ Монголбанкнаас авч явж байгаа төгрөгийн ханшийг тогтвортой хадгалах валютын нөөцтэй холбоотой асуудал бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөллөөр гадаад шалтгаантай инфляцын нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ хүрээндээ 8 хувьд барья гэсэн зорилт тавьж ажиллаж байгаа. Ирэх онуудад бол инфляцыг бас ингэж үе шаттай бууруулах Засгийн газрын зорилт тавьж байгаа нь бол макро эдийн засгийн хувьд бол инфляц бол нэлээн том харгалзах үзүүлэлт байдаг. Энэ дээрээ бас инфляцын түвшин нам доор түвшинд үе шаттайгаар бууруулж байж зээлийн хүүг бууруулах бусад бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл чухал асуудал явж байхад Улсын Их Хурлын дарга аа, Сангийн сайд ч байхгүй, Ерөнхий сайд ч байхгүй, яг хариулах сайд нар нь ерөөсөө байхгүй байгаад байна. Тэгээд яамнаас ирсэн мэргэжилтнүүдийнх нь хариулт нь ингээд яг Төсвийн байнгын хороо дээр ч ялгаагүй ийм бөөрөнхий л байсан. Яг товч тодорхой хариулт байхгүй. Энэ төсөв явж байхад уг нь Ерөнхий сайд ч тэр, Сангийн сайд ч тэр өөрсдөө байх ёстой шүү дээ. Сангийн сайд орж ирж байна.

Энэ Засгийн газраас барьсан төсөлд инфляц бол өсөхөд энэ удаагийн энэ 9,5 хувь гээд 2025 онд өсөөд ороод ирлээ. Энэ өсөхөд хамгийн гол нөлөөлсөн юм бол Засгийн газраас өргөн барьсан төсөлд чинь бол тусгачихсан байгаа шүү. Өрхийн цахилгааны төлбөр, цахилгааны үнэ нэмсэн. Тэгээд орон сууцын түрээсийн зардал болоод хэрэглээний үнийн өсөлт голлон нөлөөлсөн гэж үзсэн байгаа шүү дээ. Хамгийн гол нөлөөлсөн юмнуудыг. Тэгэхээр яг 2026 онд 7 хувь гэчихсэн байгаа. Би

энийг бүр дахиад асуух гээд байгаа юм. 2025 онд энэ чинь 9,5 хувь болчихоод байгаа юм. Монголбанкны мэдээлснээр Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн хэлснээр бол энэ чинь бол 2 оронтой тоо руу оны эцсээр орно гэсэн байгаа шүү дээ. 2 оронтой тоо руу оны эцэс гэхэд бол инфляц орно. Зүгээр бизнес эрхлэгчид өнөөдөр ард иргэд бол бүгдээрээ 10 хувь аль эрт гарчихсан юмны үнэ гэдгийг бол захын дэлгүүрийн худалдагч хэлж байгаа. Тэгээд 2026 ондоо 7 хувь гээд тавьчихсан. Сая ярихдаа болохоор бид нар Засгийн газар жил болгон инфляцыг бууруулах гэдэг зорилготой байгаа. Зорилготой байгааг бүгд ойлгож байгаа. Гэхдээ бодит амьдралтайгаа жоохон ойрхон баймаар байна шүү дээ. 2026 оны 1 сарын 1-ээс дулааны үнэ нэмэгдэнэ. Ард иргэдийн өрхийнх нэмэгдэнэ, албан газар нэмэгдэнэ, халуун, хүйтэн усны үнэ нэмэгдэнэ, бохирын үнэ нэмэгдэнэ. Энэ бүгд нэмэгдээд байхад 7 хувь байх боломжтой юм уу. Энэ дээр асуухаар өөр юм хариулаад байсан шүү. Энэ дээр яг дулааны үнээ, халуун, хүйтэн усаа инфляц өсөхтэйгөө яг уялдуулж тооцсон юм уу. Яг 7 хувьдаа байж чадах юм уу. Дахиад ирэх ондоо бид нар ингээд төсвийн тодотгол хийх ёстой юм уу. Энэ дээр бүр тодорхой хариулт авъя.

Мэдээж энэ нүүрсний үнийг бол дахиад бид нар ярих ёстой. Бүгдээрээ энийг бол бүр ёстой өдөр болгон санаж байх хэрэгтэй. Нүүрсний үнэ ч буураад, худалдан авалт ч буураад байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ яаж тусгасан юм бэ. Валютын ханшийн өсөлт бид нар барих боломжтой юм уу. 2026 онд энэ нь өсөх юм уу. Энэ валютын ханшийн өсөлтийг тооцсон юм уу. Энэ 7 хувь гэдэгтэй. Хэтэрхий өөдрөг төсөв байгаад байх юм. Тэгээд дахиад энэ нь орж ирээд л дахиад л өөрчлөгддөг. 2026 онд дахиад төсвийн тодотгол хийх болох вий дээ.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Сангийн сайд хариулт өгөх үү. Батхүү. 4 дүгээр микрофон.

И.Батхүү: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Инфляц гэдэг маань өөрөө эдийн засгийн зах зээл дээр байгаа маш олон тооны бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг индекс маягаар харуулдаг. Албан ёсоор баталгаажсан, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг аргачлалын дагуу тооцогддог ийм зүйл байгаа. Нийт 430 нэр төрлийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг жинлэж, дундажлаад гаргадаг тоо. Тэгэхээр энэ тоог гаргадаг албан ёсны Үндэсний статистикийн хороо маань Улсын Их Хурлын харьяа, бие даасан байгууллага учраас гаргаж байгаа албан ёсны тоон дээр Засгийн газар болон ямар нэгэн яамны зүгээс нөлөөлөх боломжгүй. Тэр 430 нэр төрлийн бараа дундаасаа аль нэг хэсэг нь ч юм уу нэмэгдэх тоон үзүүлэлтүүд нь бол ард иргэдийн хувьд энэ өндөр өсөлттэй байна гэдэг тоонууд ярих бүрэн боломжтой байгаад байгаа.

Бид түрүүн дурдсан инфляцыг нам доор түвшинд үе шатаар бууруулах нь бол Засгийн газрын зайлшгүй авч хэрэгжүүлэх ёстой бодлогын чиглэл байх ёстой. Ингэж байж зээлийн хүү буурна. Гадаадын хөрөнгө оруулалтаас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын өгөөжийг хадгална. Бас бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын бизнесийн орчинд хамгийн их дурдагддаг хүндрэлтэй зүйл болох санхүүжилтийн зардлыг бууруулах ач холбогдолтой. Инфляцын бас нэг нөлөөлдөг хүчин зүйл болох ам.долларын ханш буюу төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хадгалах нь бол Монголбанкны бас үндсэн чиг үүргийн нэг байгаа. Тэгэхээр Монголбанкны зүгээс бол валютын ханштай холбоотой асуултад хариулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: За байз. Эдийн засаг, хөгжлийн сайд бас гадаадад томилолт аваад, чөлөө аваад явчихсан байгаад байдаг. Гишүүд хариулт хангалтгүй байна гэдэг асуудал хөндөж байна шүү. Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Статистикийн дарга нар нэмж ирсэн байна. Та бүхэн маань энэ Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаа асуултад яг өөр өөрсдийн хариуцаж байгаа чиглэлээр маш тодорхой хариултууд өгье. Тэгэхгүй бол энэ асуудал чинь цаашаа явахгүй болох гээд байна шүү. Монголбанкны Дэд ерөнхийлөгч нэмж хариулт өгөх үү. Энхтайван 3 дугаар индэр. 4 дүгээр индэр.

Г.Энхтайван: Гишүүний асуултад хариулъя. Гадаад валютын албан нөөц болон валютын ханштай холбоотой асуулт асуусан гэж ойлголоо. Ер нь бол одоо байгаа бид хэдийн төсөөллөөр бол энэ оны төлбөрийн тэнцэл бас 1 их наяд гаруй төгрөгийн алдагдалтай бол гарахаар байгаа. Энэ нь бол гадаад валютын албан нөөц дээр бол томоохон хэмжээний дарамтыг учруулж байгаа. Оны эхнээс он гарснаас хойш гадаад валютын америк доллартой харьцах төгрөгийн ханш бол ойролцоогоор бол 5 орчим хувь суларсан байгаад байгаа. Тэгээд инфляцын хувьд бол 8 орчим хувь дээр бол 8,6 хувьтай байгаа учраас төв банкны зүгээс бол инфляцтай уялдуулаад төв банкны зүгээс ханшийг бол бас яг инфляцын түвшинд нь сулрах бодлогын орон зай байгаа гэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Г.Энхтайван: Бодлогын орон зай байгаа гэж үзэж байгаа. Төлбөрийн тэнцлийн хувьд бол 2025 онд 1 их наяд төгрөгийн бас алдагдалтай байхаар, 2026 онд бас үүнээс ч давсан хэмжээний төлбөрийн тэнцлийн алдагдал байх магадлалтай гэж бол үзэж байгаа учраас Төв банк бол гадаад валютын албан нөөцийг илүү хамгаалах, ханшийн уян хатан бодлого явуулах бодлогыг бол барьж явна. Ханшны хувьд бол түрүүн хэлсэн оны эхнээс бол 5 орчим хувиар суларсан. Энэ бол дэлхий даяар АНУ-ын Холбооны нөөцийн банкны бодлогын хүү бас чанга байгаатай холбогдуулан дийлэнх валютын хувьд бол сулраад явж байгаа. Инфляцтайгаа уялдуулаад бас инфляцын түвшинд хүрч сулрах бол орон зай байгаа гэж бол төв банкнаас бол харж байгаа. Дараа жилийн хувьд бол мэдээж томоохон хэмжээний төлбөрийн тэнцлийн алдагдал дээрээс бид бүхэн бодлогын тохируулгын арга хэмжээнүүдийг аваад, ханшийг илүү уян хатан түвшинд нь барих тийм бодлого хэрэгжүүлнэ.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Манай Эдийн засаг, хөгжлийн яамныхан маань макро төлөвлөлтөө хийгээд, өнөөдөр хүрээний өөрчлөлтийг танилцуулж байна. Хүрээгээ өөрчлөхгүйгээр бид тодотгол хийх бас боломжгүй. Хүрээ дотроо гол макро тоонууд буюу орлогын доод хэмжээг заасан байдаг. Энийгээ бид нэгэнт орлого цөмөрч байгаа учраас заавал бас хүрээгээ тодруулахгүй бол болохгүй юм байгаа юм. Саяын Баясгалан гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл өгөхөд тэр инфляцын түвшин бодлогын зорилтот түвшин шүү. Тэрнээс энэ бол гүйцэтгэл биш. Бид Төв банкны бодлогыг баталж өгөхдөө бдээр нэмэх, хасах 2 гэж баталж өгсөн. Өөрөөр хэлбэл бүх бодлогын шийдвэрүүд нь инфляцыг нам доор 6 орчим байхаар тэр лүү чиглүүлнэ шүү гэдэг даалгавар өгч байгаа юм. Тэгэхгүй одоо юу гэдэг юм, бодит байдал ер нь 10 болчихлоо. Зорилтот түвшин нь 10 байна гэхих юм бол энэ бодлогын орон зай нь хатууруулах .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Статистикийн үндэсний хорооны дарга Батдаваа хариулт өгье. 3 дугаар индэр.

Б.Батдаваа: Гишүүний асуултад хариулъя. Үндэсний статистикийн хороо. Монгол Улсын инфляцын түвшин 2025 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 8,3 хувь, Улаанбаатар хотод 9,4 хувьтай байгаа. Инфляцын түвшин ерөнхий түвшнээрээ ийм байгаа боловч энэ дотор бүлгээрээ бас харилцан адилгүй байгаа. Сүүлийн жилийн хугацаанд инфляцын бүрэлдэхүүнд гарч байгаа өөрчлөлтийг дурдах юм бол ковидын ид үед буюу 2021, 2022 онд хүнсний бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ 18, 19 хүртэл жилийн өсөлттэй байсан бол 6,5 болж буураад, харин эсрэгээрээ үйлчилгээний инфляц 17 хувь болж өссөн ийм үзүүлэлттэй байгаа. Инфляцын түвшин маань өнгөрсөн оны 5 сартай харьцуулахад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний дундаж үнэ өсөж байгаа үзүүлэлтийг тооцдог. Хэрвээ бид нар инфляцын түвшнийг 2020 оны эхэн үетэй харьцуулах юм бол хүнсний бүлгийн инфляц 94 хувиар, нийт инфляц .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Б.Батдаваа: Бид 2020 оны эхэн үетэй өнөөдрийн үнийн түвшнийг харуулах юм бол ерөнхий инфляц буюу ерөнхий үнийн өсөлт 58 хувийн өсөлттэй. Энэ дотроо хамгийн их өсөлттэй нь бол хүнсний бүлэг байгаа. Бараг 2 дахин буюу 94 хувийн өсөлттэй явж байгаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя. Уучлаарай Жадамбаагийн Баясгалан гишүүн тодруулж асууя.

Ж.Баясгалан: Бүгдээрээ ирчихсэн байгаа дээр нь сайн тодруулчихъя. Үйлчилгээний бүлгийн үнэ 17 хувиар өссөн гэж байна шүү дээ. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам бол ерөөсөө яг тодорхой хариулахгүй юм. Би яг л ганцхан л юм асуусан шүү дээ. Ер нь 7 дээр нэмэх 1, 2 гэж ойлголоо Сангийн сайд аа, инфляцын түвшин бол. Тэгэхээр энэ 7, 8 хувь магадгүй ирэх 2026 оны инфляц. Тэгвэл эндээ байлгаж чадах юм уу л гэж асуугаад байгаа шүү дээ. Энэ 400 гаруй нэр төрлийн, үйлчилгээний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхэд гол нөлөөлөх юм нь юу юм бэ. Энд чинь тэрийг үйлдвэрлэж байгаа албан газрын хэрэглэж байгаа тог цахилгаан, дулаан, цэвэр, бохир бүх юм чинь нөлөөлнө шүү дээ. Дээрээс нь нэмэгдээд энэ үйлчилгээний бүлгийн үнэ өссөн гэдэг чинь бол өөрөө үйлчилгээний бүлэг гэдэг чинь дахиад энэ бүтээгдэхүүнийг чинь тарааж байгаа юм байгаа юм. Ингэхээр энэ инфляц .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд нэмж хариулах уу. Тэгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Баясгалан гишүүн ээ, би түрүүн хэлэх гээд арай амжсангүй. Минутдаа багтсангүй. Ер нь бол зорилтот түвшин гэдэг нэг тийм ойлголт нь арай өөр шүү. Хэрвээ бид нар ер нь инфляцаа буулгаж чадахгүй юм байна. Тэгвэл энэ дээрээ ингээд 10, 11, 12 гээд тавьчихаж болно. Тэгэхээр ямар ч хариуцлага байхгүй болно. Бодлогын шийдвэрүүдийн тийм хатууруулах орон зай байхгүй ингээд л тайвширчихна. Мөнгөний бодлого дээр ч тэр, энэ Засгийн газрын макро төлөвлөлт энэ 2 маань хоорондоо маш сайн уялдаж байх ёстой. Харин ч тэр 2026 оныхыг 9 гэж оруулаад ирсэн дээр бол би бас жоохон шүүмжлэлтэй хандаж байгаа. Монголбанкныхтайгаа уялдах ёстой байхгүй юу. Ядаж Монголбанкны зорилтот

түвшний дээд хязгаар буюу 8. Тэгж байж төсөв, мөнгөний бодлого 2 маань нийцтэй, төсөв нь хэмнэлттэй, мөнгөний бодлого нь хатуу төлөвтэйгөөр ингэж цаашаагаа явах юм байгаа юм. Тэгэхээр энэ гүйцэтгэл биш зорилтот түвшин гэдгийг л би тодруулж хэлье дээ.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Өглөөний мэнд хүргэе. Энэ төсвийн өмнөх тодотгол болон 2025 оны төсөв ярьж байх үед Сангийн сайд, Эдийн засгийн яам болон бусад холбогдох албан тушаалтнууд нь төсөвтэй холбоотой төслүүд дээр эрэмбийн асуудал зарчмынхаа асуудлуудыг оруулж ирнэ гэж ярьж байсан. Тэгээд энэ асуудал чинь хэзээ орж ирэх вэ. Одоо энэ төсвийн тодотгол чинь бас нэг яаралтай горимоор өргөн баригдчихсан. Төсвийг харахаар шаардлагагүй замууд, сумыг сумтай холбосон, сумыг аймагтай холбосон 200, 300 тэрбумаар нь гаргасан, төсөв хүндэрч байгаа үед бас хойш нь түр тавиад явчихмаар эрэмбэ зарчмын асуудал шийдэгдчих юм бол үлдээчхэж болмоор иймэрхүү тоонууд бас байгаад байна. Тэгэхээр энэ дээр эрэмбэ зарчмынх нь асуудал хэзээ орж ирэх вэ гэдэг 1 асуулт Сангийн сайдаас.

Тэгээд “Алт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж байгаа. “Алт 3” гэдэг асуудал явна гэсэн. Нүүрсний үнэ унаж байна. Бусад уул уурхайн баялгаасаа олох орлогоо нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Алт 3” гэдэг нэг хөтөлбөр гаргаж явуулна гээд байгаа тогтоолын төсөл санал нь Төсвийн байнгын хороо дээр орж ирж байгаа. Энэ тогтоолын төслийг нь харахаар өмнө гарч байсан тогтоолын төслүүдтэйгээ зөрчилдөж магадгүй тогтоолын төсөл орж ирсэн байсан. Энэ дээр Дамдинням гишүүн, Уул уурхайн сайд хариулж өгөх үү.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Гонгорын Дамдинням сайд хариулт өгье.

Г.Дамдинням: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын үед бас манай салбарын бүтээгдэхүүнүүдийн онцлогийг тодорхойлсон өөр бодлогуудыг гаргах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Өмнөх Засгийн газрын үед яригдаж байсан “Алт” аян гэж нэрлэгдэж байгаа. Хөтөлбөр гэх юм бол Цогтбаатар гишүүн ээ хуультай байх ёстой юм байна лээ. Журмаараа. Энэ бол аян. Энэ аяны хүрээнд үндсэндээ энэ оны төгсгөл гэхэд шууд металлаа өгөх боломжтой, үндсэн ордуудыг эргэлтэд оруулъя гэсэн ийм зорилго агуулж, ажлыг нь эхлүүлэх ийм зорилготой тогтоолын төсөл орж ирж байгаа. Энд ямар арга хэмжээнүүд авагдах вэ гэхээр 1 дүгээрт бас тодорхой хэмжээний хязгаарлалтад орчхоод байгаа, нөөц нь тогтоогдчихсон, үйлдвэрээ барьчихсан ийм үндсэн ордуудыг шууд эргэлтэд оруулъя. Шороон ордуудын асуудал бол байгаль орчны хор хөнөөл нь бас илүү байдаг учраас энэ рүү одоохондоо бас орохгүй байя. Тэгэхдээ энэ асуудлаар бол манай яамнаас судалгаа шинжилгээ хийгээд бэлдэж байна. Алт бол 3 тонноос дээш болоод, нөөцтэй болоод ирвэл үндсэн орд руу ордог энэ хэсэг дээрээ л явъя гэсэн ийм зорилготой явж байгаа. 2 дугаар чиглэл нь энэ алт олборлогчдод татварын бас дэмжлэг үзүүлбэ. Яагаад вэ гэвэл Монголбанканд тушаагдаж байгаа алтны хэмжээ өнгөрсөн оноос 16 хувиар буучихсан байгаад байгаа юм. Гэтэл дэлхийн зах зээл дээр алтны үнэ 3300-аас дээш гарчихсан. Үүнээс цааш нэмэгдэнэ гэсэн ийм хүлээлттэй байгаад байгаа. Тэгэхээр энэ аяны хувьд төсөвт нэмэр болох гэхээсээ илүүтэй мөнгөний бодлого талдаа илүү нэмэртэй, манай валютын ханшийг тогтвортой байлгах ийм л зорилготой эхэлнэ.

Хэрэвзээ Их Хурлын гишүүд маань бас энэ тогтоолын төсөл шаардлага нь бас хүрэхгүй байна гэвэл Их Хурал дээрээ гишүүд маань санаачилга гаргаад, тогтоолын заалтууд дээр тодорхой өөрчлөлтүүдийг оруулаад, зарчмын зөрүүтэй санал гаргаад, ингээд оруулж ирэх нь бол нээлттэй. Бид бол Засгийн газрынхаа түвшинд томьёолж болох хэмжээнд нь томьёолоод оруулаад ирчихсэн ийм л байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хэлэхэд энэ төсвийн тодотголыг хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдээр тус бүрээр нь ажлын хэсэг гаргая гэж байгаа. Тэгэхээр яах вэ гишүүд бас энэ асуудлууд дээр тодорхой анхаарал тавьж, ажиллаж байгаа бол тал талаасаа оролцоод, санаа бодлоо нэгтгээд, дүгнэлтээ нэгтгэж гаргаад, тэгээд Улсын Их Хурлын шийдвэр болгож гаргах боломжтой. Би энийг бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай өчигдөр зөвшилцөж ойлголцсон байгаа. Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Одоо бид төсвийн хүрээ буюу макро хязгааруудаа ярьж байна. Тэгээд таны ярьж байгаа асуудлууд тэр хөрөнгө оруулалтын эрэмбэ, зарчим энэ асуудлууд бол нөгөө төсвийн төлөвлөлтийн үед яривал илүү их дэлгэрэнгүй мэдээлэлтэй болчихсон байна. Тэгэхээр 2026 оны төсвийг бид энэ жил 9 сарын 1-нд өргөн барих цаглавартай. Тэр үед илүү их тодорхой болно. Одоо 7 сарын 25 гэхэд яамнууд яг саяын таны асуусанчлан хөрөнгө оруулалтуудынхаа эрэмбийг тогтоогоод, саналууд нь ирэх учиртай. Тийм одоогоор бол шууд мэдээлэл өгөх бол боломжгүй байна. Тэгэхээр 9 сарын 1-нд илүү их тодорхой ярих боломж гарах байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя. Б

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өглөөний амар амгаланг айлтгая. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэлд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 5,5, 2026 онд 5,7, 2027 онд 6,3 хувь гээд харьцангуй бас өмнөх төсөөллөөсөө 0,2-2,5 функтээр бууруулсан, бодит байдал руугаа дөхүүлсэн ийм төсөл өргөн баригдлаа гэж харж байна. Түрүүн гишүүдээс асууж байна. Хэрэглээний үнийн индекс буюу инфляцын түвшнийг ч гэсэн бас өмнөх төсөөллөөсөө бодит руугаа илүү чиглүүлсэн байна. Гэхдээ мэдээж яг бодит байдалдаа буулгахад илүү нарийн судалгаа, шинжилгээ шаардлагатай байгааг бас гишүүд хэлж байгаатай санал нийлж байна.

Тэгээд асуух асуултаас өмнө төсөөллөөр бол энэ оны төсвийн орлого бүр 3,3 их наяд төгрөгөөр бүрдэхгүй байх ийм магадлал байна. Буурах магадлал байна. Гэтэл энэ 2025 оныхоо төслийг болохоор 1,9 их наяд төгрөгөөр бууруулахаар төлөвлөж орж ирсэн байна шүү дээ. Яалт ч үгүй алдагдалтай гарах нь. Энийгээ илүү бас танах чиглэл рүүгээ явбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Яагаад вэ гэхээр олон бас ажлуудыг энэ цаг үеийг далимдуулаад хийх боломж байна. Төрийн үйлчилгээний чиг үүргийн давхардлыг арилгах, бууруулах, мөн цомхон байлгах. Энэ дээр дарга ангилал дээрээ илүү анхаарна гэсэн чинь илүү бас эмч, багш нар луу чиглэсэн зүйлүүд харагдаад байна.

Мөн зурагтаар ярьж байна лээ шүү дээ. Сангийн яамныхан. Нийт 208 хуульд 1028 заалтаар төсвийн нэгдмэл бодлогыг алдагдуулах төсөв хуваарилсан ийм заалтууд байна. Салбарын хуулиудаар төсөв хуваарилаад байна. Энэ дээр анхаараач ээ. Энийг далимдуулж хийх гээд олон ажлуудыг бас хийх төсвийн жинхэнэ реформыг хийх боломж байна. Энийгээ ашиглаач ээ гэж бас хэлмээр байгаа юм. Нөгөө талдаа төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг харахаар

дөнгөж 12 хувьтай байна шүү дээ. Энийгээ яаж эрчимжүүлэх юм бэ. 12 хувь. Одоо гэтэл хэдэн сар билээ. 7 сар болох гэж байна. Наадмаар олигтой юм хийгдэхгүй гээд ийм нэг талдаа танах боломж байна. Нөгөө талдаа зайлшгүй гэж үзэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээмжийн ажлууд хийх хэрэгтэй болчихжээ. Тэгээд өөр бас хөндөөд байвал олон асуудал байна.

Төсвийн тусгай шаардлага гээд нэг дүрэм дотор юу байдаг вэ гэхээр төсвийн урсгал зардал ДНБ-тэй харьцуулахад 30 хувиас илүүгүй байх ёстой шүү дээ. Энийгээ нөгөө нэгдсэн хүснэгтдээ оруулж баймаар байна. Зөвхөн нийт зарлагыг оруулах биш. Тэгж байж бас харьцуулалт илүү тод хийгдэх гээд байна гэсэн санал байна.

Мөн төсвийн хүрээний мэдэгдэлд оруулж байгаа өөрчлөлтөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зохицуулалт хийж өөрчлөх боломжтой гэдгээ хууль ёсоор нь баталгаажуулахгүй бол болохгүй ийм цаг үе ирсэн байна шүү. Тэгээд энэ нь бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр саяын миний сүүлийн хэлсэн санал бас давхцаж, санал нийлж орж ирсэн байна лээ. Тэгэхээр зориуд бас хэлчихье гэж бодож байна. Хариулт 2 асуулт байлаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр Батхүү.

И.Батхүү: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Манай Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хамгийн гол бас хүчин зүйл нь бол уул уурхайн салбар. Уул уурхайн салбарын экспорт. Тэр дундаа нүүрсний үнэ бас их эрэлт их нөлөөтэй байдаг. Тэгэхээр таны дурдаж байгаа энэ оны 4 сарын үед төсвийн хүрээний мэдэгдлийг ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, хэлэлцүүлэг хийх явцад бол энэ оны хүлээгдэж буй нүүрсний хил үнийн дундаж үнийг бол 80 ам.доллараар тооцсон байгаа. Тухайн үед бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн нүүрсний дундаж үнийн төсөөлөл бол 85 ам.доллар, ирэх онд 88 ам.доллар, тэрний дараагийн жилүүдэд 92, 96 гээд өссөн байдалтай тооцоолол ирүүлж байсан. Мөн тухайн үед бол яг оны эхнээс хилийн дундаж үнэ маань бас 80 орчим доллартой байсан. Гэтэл гадаад зах зээл дээр ялангуяа БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, эрэлттэй холбоотой хүлээгдэж байсан тодорхой асуудлууд бас хүндэрсэн. Гадаад худалдааны дайнтай холбоотой. Үүнтэй холбоотой нүүрсний дундаж үнэ маань бол 70 ам.доллар луу хүрч ирээд буучихсан байгаа. Саяхан бас валютын сангаас гаргасан Монгол Улсын яг нүүрсний дундаж үнийн тооцоолол бол энэ онд 68 ам.доллар, ирэх онд 73 ам.доллар, тэрний дараагийн жилүүдэд 72, 72 гэсэн ам.долларын тооцоолол гаргаж байгаа. Бидний зүгээс бас олон улсын нүүрсний үнийг тооцоолол гаргадаг 10 хэдэн байгууллагын тооцооллыг байнга ажиглаж байгаа. Эдгээр байгууллагуудаасаа энэ ондоо бол 30 хувь хүртэл нүүрсний үнэ унах тооцоололтой байсан. Гэтэл манай Монгол Улсын гаргадаг экспортын дундаж үнэ бол 39 хувь буюу бараг 40 хувиар уначхаад байгаа. Ирэх оны хувьд бол эдгээр байгууллагуудын дийлэнх нь үнийн өөрчлөлт хадгалагдах буюу эсвэл 5 хувь хүртэл өснө гэсэн бас тиймэрхүү тооцооллууд гаргаж байгаа. Саяын бас Валютын сангийн үнийн тооцооллоос харахад ч гэсэн тийм байгаа. Гэхдээ бид бол өсөлтөөр биш 70 ам.доллараар тооцож гаргасан байгаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Уучлаарай Баатаржавын Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

Б.Мөнхсоёл: Асуултын хариулт нь жоохон буруу ирчихлээ шүү дээ. Асуултаа сайн ойлгохгүй бол. Ингэж асуусан шүү дээ. Нэг талдаа олигтой танамаар байна. 1,9 их наяд чинь хангалтгүй. Маш олон төсвийн реформ шинжтэй ажлуудыг хийдэггүй юм гэхэд ялангуяа давхардлыг арилгах дээр анхаармаар байна. Төсвийн хөрөнгө оруулалтаа эрэмбэлмээр байна. Зарим зайлшгүй бишийг хойшлуулж царцаамаар байна. Давхардсан чиг үүргийг арилгамаар байна. Ер нь бусад салбарын хуулиудад байгаа төсөв хуваарилдаг энэ ажлуудаа болимоор байна гэж хэлсэн юм.

2 дугаарт нь төсвийн хөрөнгө оруулалт чинь гүйцэтгэл нь 12 хувьтай байгаа юм чинь одоо үлдсэн 4 сардаа амжих юм уу гэж асуусан. Нүүрсний үнийг би асуугаагүй. Гэхдээ санал нэг байна. Зөв. Тэр зөвхөн олон улсын байгууллагуудын гаргадаг үнийн таамаглал дээр биш, Монгол Улс өөрөө хилээр гаргаж байгаа экспортын үнэ дээрээ суурилах чинь маш чухал болчихоод байна шүү. Бодит руугаа дөхөөд. Тэр дээр бол оруулж байгаа гэж ойлголоо. Тэр маш зөв шүү. Дутагдалтай байдаг шүү. Цаашдаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Мөнхсоёл гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Царцаана гэж ярихад их амархан. Энэ жилийн хувьд хөрөнгө оруулалтууд шинэ хөрөнгө оруулалтууд маш бага байгаа. Маш бага байгаа. Дээрээс нь сая 5 сарын 31-ээр нийтдээ 535 тэрбум төгрөгийн шинэ хөрөнгө оруулалтууд хэмнэлтэд орчихсон. Энэ бол бага зүйл биш. Бас нэг их хүсээд байх зүйл ч биш. Бид арайхийж төсвийн орон зай гаргаад, хөрөнгө оруулалтыг бас хөгжилд нэмэр болно гээд салбар салбарын ийм асуудлууд тавьсан боловч ингээд хариуцлага алдаж, хугацаандаа худалдан авалтаа амжуулаагүй учраас хураагдчихсан байгаа.

Дээрээс нь Төсвийн хууль дээр 1 ийм заалт байдаг юм. Нэгэнт гэрээ хийгээд үргэлжлээд явж байгаа хөрөнгө оруулалтыг төсвийн жилийн дундуур тодотгол хийх үед хасаж болохгүй гэдэг ийм заалттай. Өөрөөр хэлбэл царцааж болохгүй гэсэн заалттай. Тэгээд үүний цаана чинь өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн харилцаа үүсчихсэн, тэд нар нь зээл авчихсан, баахан хүмүүсийг цалин .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас нэгэнт эхэлчихсэн хөрөнгө оруулалтыг бол царцаана гэдэг ойлголт бол ер нь байхгүй болсон байгаа. Дээрээс нь тэр 208 хууль дээр харин би танд баярлалаа гэж хэлье. Тэрийг та бараг ажлын хэсэгт нь байгаа байх шүү. Булгантуяа дарга ахлаад энэ ажлын хэсэг ажиллаж байгаа. Бид бол саналаа хүргүүлчихсэн Их Хуралд. Үүрэг авсан байсан учраас. Энийг нь царцаамаар байна. Энэ хуулиудынх нь энэ заалтуудыг нь хүчингүй болгомоор байна. Энийг нь бүр хойшлуулмаар байна гээд. Нийтдээ энэ чинь бараг 8 их наядын ийм төсөвт багтаж чадаагүй тэгэхдээ хуулиараа төсөвт оруулах ёстой ийм хуулийн заалтуудтай байдаг юм. Энийг л хэрвээ больчих юм бол, эд нарыг манайхаас явуулсан саналаар зохицуулалт хийж чадах юм бол ирэх жилүүдийн төсвийн ачаалал эрс буурах юм байгаа юм. Уг нь тодотголоор бас хэлэлцэхэд бэлэн болчихсон байгаа. Гэхдээ тодотгол ийм богино хугацаанд хэлэлцэх учраас тэр амжихгүй л дээ. Тэгээд тэр чинь бараг бүх салбарын хуулиуд дээр тийм заалтууд байгаа. Энэ бол маш том хэлэлцүүлэг болно. Маш том эсэргүүцэлтэй тулна. Маш том лобби, их л юм болно доо. Тийм учраас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль энэ тэрд ямар заалтууд байгааг сайн мэдэж байгаа. Цаг хугацаа хэрэгтэйг ч ойлгож байгаа. Түрүүний удаа бас хэлсэн. Сангийн сайд хийхэд хэцүү. Лобби ордог, бүгд гуйдаг, нөлөөлдөг. Монгол жижигхэн гээд. Тэгэхдээ 530 тэрбумаар хасах гэж байгааг ч мэдэж байгаа шүү дээ. Мэдээлэл нэлээн явчихсан. Гэхдээ нэмээд 1,9 их наядаа нэмчихийг хичээгээрэй л гэж хэлээд байна. Санал оруулаад байна. Булгантуяа дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг байгаа. Тогтоолоо бол хүргүүлсэн, санал дүгнэлтээ. Тэгээд цаашдаа ажиллахад бас хугацаа хэрэгтэй учраас далимдуулаад энэ реформын шинжтэй ажлуудаа хийх ёстой, цаашдаа ч хийнэ гэдгээ бас гишүүд болон олон нийтдээ ойлгуулж байх нь зөв гэж дуу хоолойгоо өргөөд яваад байгаа шүү. Хийх ажил их байна. Яриад байвал энэ төсөв гэдэг чинь өөрөө ном гэхэд хэдэн 100 хуудастай билээ. Мэдээж ойлгомжтой нүсэр их ажил.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Төсвийн хүрээний мэдэгдлийг ярьж байна. Сая ингээд тоолж үзэхээр өнгөрсөн жилийн 6 сар, дараа нь сонгуулийн дараах тодотгол, тэрний дараа 10 сарын төсөв, 12 сарын төсөв, сая 6 сарын 1-ээс өмнөх, одоо төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар сүүлийн 12 сарын дотор 7 дахь удаагаа ярьж байна. Төсвийг, төсвийн тодотгол, төсөв дахиад 12 сарын тодотгол, одоо ингээд тодотгол 12 сар хүрээгүй хугацаанд 4 дэх удаагаа төсөв ярьж байна. Он дуустал дахиад хэд ярихыг таашгүй. Тэгэхээр үүний цаана төсвийн тоо баримтуудын асуудлуудаасаа гадна ер нь энэ төсөв, төсвийн сахилга бат, төсвийн тогтвортой байдал гээд энэ үзүүлэлтүүдтэй холбоотой тогтолцооны асуудлыг бид нар эргэж ярихгүй нэг хэдэн тонн нүүрс зарахаараа энийгээ дагаад урсгал зардал, бүхий л халамж, бүхий л зүйлээ тэнгэрт тулгачихдаг. Тэгээд сарын дараа, 2 сарын дараа нөгөө тэнгэрт гарч байснаа шал дээр буудаг. Үгүй ээ, энэ чинь бас улс орон байна даа. Энэ чинь бараг жилийн хэдэд нь ч төсөв яриад байгаа юм. Өөр ярих, хэлэх, ярилцах тогтвортой ийм хууль, эрх зүйн ажлууд гэж бид нарт юу билээ. Тэгэхээр үүний цаана ийм тогтолцооны асуудлууд л яригдаад байна л даа. Энэ төсөв яригдах бүрд, төсвийн хүрээ яригдах бүрд макро тоонууд яригдах бүрийн чинь цаана нийгэмд, эдийн засагт, бизнес эрхлэгчид дээр өөр өөр хүлээлтүүд л очиж байдаг. Одоо бүр улс орон хөгжөөд, дэвжээд 7, 8, 9 хувийн өсөлттэйгөөр бүр алаад өгөх юм байна. Төсвийн хөрөнгө оруулалт олон олон зүйл нь ингэх юм байна гээд баахан компани төсөл тендерт ордог. Эргээд сарын дараа бүх зүйл нь худлаа болчихсон байж байдаг. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гээд суурь болсон айхтар том хуулиа дандаа бид нар төсөв дагуулж орж ирээд, уг нь Төсвийн тогтвортой байдлын хуульд Төсвийн хууль нь захирагдаад явах ёстой гэж ойлгож байгаа. Гэтэл төсөв дагуулж орж ирээд энэ хуулийг дураараа өөрчилчихдөг. Тэгэхээр үүний цаана бид нарт энэ тоо баримтуудыг мэдээж төсөв дээр, төсвийн тодотгол дээр илүү сайн ярих ёстой байх. Үүний цаана тэр төсвийн тоо, жинхэнээсээ төсвийн тогтвортой байдал, жинхэнээсээ тэр чиг хандлага, жинхэнээсээ тэр мөчлөгийг яаж явах юм гэдэг энэ зүйлүүдийг чинь тэр Төсвийн тогтвортой байдлын хуулиа ер нь яаж дагаж мөрддөг, сахидаг болох юм гэдэг асуудал бид нарт хүчээр л яригдах болж байна л даа. Энэ дээр тэр хуучин ч бас яригдаж байсан байх. Тэр босго, зүгээр төсөвтэйгөө адилхан бусад хуультайгаа адилхан дагуулж орж ирээд алх цохиод гаргачихдаг болох юм уу. Энэ дээр илүү өндөр босгоор энийг хамгаалдаг, тэр болгонд гар хүрч чаддаггүй, Ирээдүйн өв санд мөнгө орно гэснийг төсөв дагуулж орж ирээд л дураараа 60 хувийг нь, 40 хувийг нь биш 20 хувийг нь л үлдээе. Бусдыг нь аваад

зарцуулъя гээд бүх зүйлийг ингээд мөчлөг дагаад, жоохон орлого дагаад явчихдаг Тэгээд улс төрчдийн, улс төрийн намуудын хүсэл сонирхол бол угаасаа тодорхой. Өөрийгөө байгаа үед том том мөнгө зарцуулаад, ард иргэдэд их том ажил хийснээр авъя л гэдэг энэ аль ч нам гэлтгүй, аль ч улс төрч гэлтгүй бүгдийнх нь л хүсэл эрмэлз шүү дээ. Тэгээд энийг яаж хааж, хязгаарлаж, жилд 7 удаа, жилд 8 удаа, 9 удаа бараг төсвийн хүрээ ярьдаг. 4, 5 удаа тодотгол ярьдаг энийгээ ер нь яаж болих юм. Энэ чинь ярихгүй гэдэг нь бид нар жоохон бодит хөрс дээрээ л буух ёстой л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр ер нь аливаа муу зүйлд ч гэсэн дагалдаад сайн зүйлүүд нь явж байдаг юм гэнэ лээ. Тэгэхээр дагаад энийг тогтолцооны асуудлаа, тэр тусмаа төсвийг танах, багасгах асуудлууд орж ирж байгааг би маш зөв л л гэж бодож байгаа. Надтай холбоотой ганц 2 төсөв улсын төсөвт бас миний санал болгож байсан төслүүд байсан байна лээ. Бүгдээрээ л хасагдаж байна лээ. Хамаагүй. Би бол тэрийг 100 хувь дэмжинэ. Зарчим бол зарчим. Бүгдийг дэмжээд явна. Тэгэхдээ үүний цаана тэр тогтолцооны өөрчлөлтийг яаж илүү хийх юм бэ гэдэг дээр хариуцаж байгаа хүмүүс, Сангийн сайд ямар бодолтой байдаг юм. Тэр Төсвийн тогтвортой байдлын хуулийг батлагддаг, өөрчилдөг хувь хэмжээг 2-ны 1-ээр биш, 3-ны 2-оор ч юм уу болгож өөрчилж болох уу. Ийм л юманд хийхгүй бол тэгээд байнга төсөв ярьсаар, худлаа үнэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье. Ер нь яах вэ, энэ хуулийг бас 3-ны 2-оор дэмжих өөрчлөлт оруулах гэдэг асуудал өмнө нь бас өмнөх парламентын үед бас шийдэгдээд, цэц дээр очоод уначихсан 1 асуудал гарчихсан юм байна лээ. Тэгэхээр хуулиудыг ялгавартай байлгах боломжгүй. Харин зүгээр 2019 онд Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн үр дүнгээр аливаа хуулийг эцэслэн батлахдаа нийт гишүүдийн олонх гэдэг ийм хэлбэртэй болчихоод байгаа. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь тэр хөрөнгө оруулалтаа хэмнэлтэд орж байгаа нь тодотголоор биш шүү гэдгийг би дахиж тодруулж хэлье. Төрийн хэмнэлтийн хуулиар 5 сарын 31-ний дотор гэрээ хийгдээгүй худалдан авалт, хөрөнгө оруулалтууд бол шууд хэмнэлтэд ордог ийм хууль энэ жилээс мөрдөж эхэлж байгаа. Тийм учраас тодотголоор ямар ч хөрөнгө оруулалт хасагдаагүй. Төрийн хэмнэлтийн хуулиар хасагдсан шүү гэдгийг тодруулж хэлье.

Таны бусад саналуудтай бол би 100 хувь санал нийлж байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудын хувьд дээрээс нь уул уурхайгаас хамааралтай ийм эдийн засагтайн хувьд маш их ийм савлагаа үүсэх өндөр эрсдэлтэй байдаг. Тийм учраас түрүүн бас Мөнхсоёл гишүүний хэлсэн тэр 208 хууль буюу манай бараг бүх салбарууд хоорондоо уралдаад, салбар салбарынхаа хуулиуд дээрээ ийм төсвийн хуваарилалтуудыг маш хатуу оруулчихсан байдаг. Бид энэ том савлагааг арилгахын тулд тэр салбар салбарын хууль руу гар дүрэхээс өөр аргагүй болж ирж байгаа. Энийг 9 сарын 1-нд бид ирэх жилийнхээ төсвийг өргөн барихдаа энэ хуулиудыг бид зоригтой өргөн барина. Энэ бол маш том ийм реформ болох учиртай. Ер нь салбар салбарын маш их эсэргүүцэлтэй тулна. Энэ дээр л харин гишүүд бид зориг гаргаж энэ том реформыг санал нэгтгэйгээр бүгдээрээ хийнэ гэдэгт итгэж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу. Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тэгээд энэ төсвийн тогтвортой байдлын хууль бас босго өндөртэй байх ёстой гэдэгтэй тантай санал нийлж байна.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Үгүй ээ энэ саяхан л төсөв тодотгохгүй гээд л сайд нь ч ялгаагүй, тэнд сууж байгаа хүмүүс ч ялгаагүй бүгд л бид нарыг загнаад байсан шүү дээ. Та буруу бодож байна, та буруу яриад байна, таны тооцоолол буруу байна гээд. Цогтгэрэл гишүүний хэлж байгаа энэ олон төсөв ярьж байна гэдэг чинь буруу ажиллаад байна шүү дээ. Худлаа тооцоолоод байна. Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам. Тооцоолж чадахгүй байна шүү дээ, урьдчилж харж чадахгүй байна. орлогыг чинь буруу тооцоолж байна гээд зөндөө хэлсэн биз дээ. Баахан загнасан биз дээ буцаагаад. Тэгээд буруу тооцоолоод байна гэдэг чинь ажлаа хийж чадахгүй байгаа юм биш үү. Хэрэглээний үнийн индекс ярьж байгаа өнөөдөр. Өнөөдрийнхөө сэдэв рүүгээ оръё. Хэрэглээний үнийн индекс ингээд 8 хувьтай, 10 хувьтай. Энэ дотор сууж байгаа хүмүүс дэлгүүр орж байгаа юу. Орж байгаа бол тийм байна уу. Үгүй байгаа биз дээ. Тэгээд дараа жил ахиад 7 хувьтай байх уу. Тэрний дараа жил 6 хувьтай байх уу. Би энийг өнөөдөр ярьж байгаа юм биш. Би үргэлж ярьдаг Жаргалмаа гишүүн ээ, байнга ярьдаг Баярмаа гишүүн. Тэгээд энийг бол ер нь биелүүлдэг тохиолдол байхгүй. 2016 оноос хойш юмны үнэ яаж өссөн билээ. Төсөв яаж тэлсэн билээ. Тэгээд би нэг юм асууя. Энэ аргачлалдаа байгаа юм уу, эсвэл буруу тооцоолоод байгаа юм уу, эсвэл аргачлал нь буруу юм уу. Энэ тооцож байгаа хүмүүс дэлгүүр орж байгаа юу. Надад хариулаарай.

Тэр долларын нөөц 5 тэрбум доллар байгаа. Үгүй ээ, тэгээд яагаад доллар олдохгүй байна. Яагаад доллар чинь өсөөд байгаа юм. Энэ дээр Монголбанк, энэ Монголбанкны Ерөнхийлөгч ч ирэхээ больчихсон юм байна. Энэ нөхөр ирэхгүй. Дандаа тэр Энхтайван. Энхтайван сая босоод хариулах шиг болсон. Үгүй ээ, тэр хүн ер нь хааччихсан юм. Хэнийг дуурайгаад байгаа юм. Нямбаатарыг аа. Ямар хүмүүсийг дуурайгаад байгаа юм. Мэдэхгүй. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байхад чинь тэгээд энэ долларын ханшийг яаж тооцож байгаа юм. Эдийн засаг чинь долларын ханш, хэрэглээний үнийн индекс бүх юм чинь долларын ханштайгаа маш уялдаа холбоотой шүү дээ. Эдийн засгийн өсөлт. Тэгээд Монголбанк ер нь яаж тооцсон. Одоо энд яагаад 5 тэрбум доллартой мөртөө доллар олдохгүй байгаа юм. Доллар чинь өсөөд байгаа юм. Тайлбар сонсмоор байна.

Өмнөх Засгийн газрын үед өмнөхийн өмнөх шүү. Засгийн газрын үед 5 тэрбум доллар боллоо гээд доллар 3290 хүрсэн. Үгүй ээ, өнөөдөр тэгээд их олон сая, тэрбум доллартой гэж зарлаад байдаг доллар чинь олдохгүй өсөөд байдаг. Би юм ойлгохгүй байна уу, эсвэл тоо чинь буруу юм уу. 2 тоон дээр л ярья л даа. Эдийн засгийн өсөлтийг нь орхиё. Хэрэглээний үнийн индекс чинь буруу байна. Аргачлал нь буруу юм уу, эсвэл би буруу ойлгоод байгаа юм уу. Энийг тайлбарлаж өгөөч. Ямар гоё инээж байна аа. Инээхээр ч юм болохгүй л байгаа л даа.

Тэр “Алт” хөтөлбөр дээр ярихад бол тэр алт авна гэж явж байгаа байгаль орчин нээрээ үнэхээр нээрээ том асуудал шүү. Алт бол ер нь Дамдинням сайд шинэхэн томилогдсон. Энэ алт дээр жоохон болгоомжтой хандахгүй бол. Одоо Монголд шороон орд гэж бол байхгүй шүү.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам Батхүү. 4 дүгээр индэр.

И.Батхүү: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ инфляцтай холбоотой гарч байгаа асуудлууд 2 талаар яваад байна. Нэг нь болохоор яг бодит инфляцын

гүйцэтгэлийг гаргадаг тооцооллын аргачлал. Тэгээд энэ 430 нэр төрлийн барааны багцаас гаргаж байгаа, бодитой судалгаа явагдаад гаргаж байгаа. Үүнтэй холбоотой тухайн тодорхой бүлэг барааны үнийн өсөлтийн бас ард иргэд буюу хүмүүст мэдрэгдэж байгаа байдлыг бас нийт инфляцын түвшинтэй бас ойлголтын зөрөөнүүд гараад байна. Энэ дээр бол түрүүн бас Батдаваа дарга тодорхой мэдээлэл өгч байсан. Яг Эдийн засаг, хөгжлийн яамнаас зүгээр цаашдаа энэ төсвийн бодлого, төсвийн хүрээний мэдэгдэлдээ гаргаж байгаа тоо бол бодлогын зорилтууд байгаа. Яг жишээ нь Монголбанк бол 6 дээр нэмэх нь 2, хасах нь 2 хувь гээд бодлогын зорилт тавьдаг шиг, Засгийн газрын зүгээс инфляцын түвшнийг хүргэх гэж байгаа зорилтоо тавьж байгаа юм. Энэ зорилтыг тооцохдоо бол яг бодит сектор дээр эрэлт, нийлүүлэлтийн харилцаа, хөдөлмөрийн зах зээлийн тэнцэл, гадаад секторын нөлөөлөл гээд олон талын хүчин зүйлийг харгалзаж үзэж байгаа. Мөн бас Монголбанкны батлагдсан мөнгөний бодлого дээр тавьсан зорилт, тэр дээр энэ үйлчлэх ханшийн болон гадаад валютын нөөцтэй холбоотой зорилтуудыг анхаарч гаргаж байгаа. Тэгэхээр энэ зорилтот түвшин. Тэгээд энэ зорилтот түвшиндээ хүрэхийн тулд Засгийн газрын харьяа байгууллагууд нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулах чиглэлээр жишээ нь хөдөө аж ахуйн салбарт ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ, тээвэр, логистик дээр юунд анхаарах вэ, хил, гааль дээр юунд анхаарах вэ гэх мэтчилэн олон төрлийн арга хэмжээнүүдийг шахаж ажиллах зорилттой. Энэ зорилтын тоо гэж хэлж болно.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван. 3 дугаар индэр. Лхагвасүрэн Ерөнхийлөгч яасан.

Г.Энхтайван: Гадаад томилолт байгаа.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Тэгээд энэ тоонууд чинь буруу байна гээд. Тэгээд орлогоо зөв тооцоолоорой гээд зөндөө хэлсэн шүү дээ. Нөгөө алдагдалгүй төсөв гэдэг рүү бүгдээрээ яваад орлогыг нь анхаараагүй байхгүй юу. Орлого тал чинь хамгийн чухал. Хувь хүн ч ялгаагүй, компани ч ялгаагүй орлого талаа л зөв тооцдог шүү дээ. Тэгээд л нэг алдагдалгүй төсөв гэдэг бүгд хуулиараа л аваачаад орлого талыг нь хэт өндөр тавьчихсан. Тэрийг ерөөсөө анхаарч яриагүй. Тэгээд буруу тооцоолсон гэсэн үг. Энийгээ урьдчилж хардаггүй юм уу. 4, 5 сарын дараахыг хардаггүй юм уу. Тэрний төлөө бүхэл бүтэн 2 яам ажиллаж байгаа биз дээ. Тэгээд гишүүд зөндөө хэлээ биз дээ. Энэ нүүрсний үнэ бууна гэж. Тэгээд баахан загнасан биз дээ өөдөөс. Хэвлэлээр баахан худлаа худлаа юм явуулсан. Тэгээд өнөөдөр ийм юм яриад сууж байдаг. Төсөв тодотгох гээд өнөөдөр хүрээ ярьж байгаа шүү дээ. Төсөв тодотгох гээгүй бол хүрээ ярих шаардлага байхгүй.

Д.Амарбаясгалан: Энэ бас яг Ганбаатар гишүүний хөндөж байгаатай холбоотой 2025 оны төсвийн хүрээнд өөрчлөлт оруулах, дагуулаад бас 2026 оны төсвийн хүрээнд өөрчлөлт оруулах асуудал орж ирчихсэн байгаа. Энийг нэг тайлбарлаж бас хэлж өгмөөр байгаа юм. Гишүүд бас асуугаад болж өгөхгүй байна.

Одоогийн энэ Засгийн газрын энэ бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал бол 2025 оны төсвийн хүрээнд өөрчлөлт орох шаардлага бий болгосон. 2026 оныхыг бий болгож байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуулт бас давхар яваад байгаа юм. Жавхлан сайд энэ дээр та нэг хариулаад өгөөч. Нэмээд.

Б.Жавхлан: Одоо бид 2025 оны жилийн гүйцэтгэл дундаа орчихсон явж байгаа үед тодотгол хийх гэж байгаа юм. Тэгэхээр 2025 оных дээрээ бид нар төсвийн хүрээ дээрээ өөрчлөлт орохоор тэнд хамт батлагдсан дараагийн 2 жилийн буюу 2026, 2027 оны төсөөлөл дээр бас өөрчлөлт орно. 2026 оны төсөөлөл дээр өөрчлөлт орчихоор сая 1 сарын өмнө баталсан 2026 оны төсвийн хүрээнийхээ мэдэгдэл дээрх 2026 оныхоо тоонуудаа өөрчлөлт хийхгүй бол бас болохгүй болчхож байгаа юм. Тэгэхгүй болохлоор 9 сарын 1-нд бид нар төсвөө өргөн барихдаа одоо энэ тодотголоор өөрчлөгдсөн тоотойгоо уялдуулж бид нар төсвөө өргөн барина. Гэтэл энэ сарын өмнө батлагдсан тоонууд нь өөр байгаа учраас энийг дагаж өөрчлөхөөс өөр аргагүй ийм л логиктой болж ирж байна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Энэ дээр тэгээд нөгөө 3 сарын чинь асуудал мөрдөгдөөд 9 сарын 1-нд төсвөө өргөн барьж чадахгүй болчих юм биш биз дээ. Тэгээд 9 сарын 1 дөхөөд ирэхээр ээлжит бус чуулган зарлаж, төсвийн хүрээнд өөрчлөлт оруулж өгөхгүй гэдэг юм уу, тодорхой хуулиудын өөрчлөлт ярихгүй бол бид төсвөө өргөн барьж чадахаа болилоо гэдэг асуудал үүсэх үү. Тэгээд Их Хурлын гишүүд амарчихсан байна. Одоо бид төсвөө чадахгүй байна гэдэг дээр Жавхлан сайд хариулаач.

Б.Жавхлан: Яг тийм асуудал бол үүсэхээр байсан. Харин сая бид Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулиудын өөрчлөлтүүд батлагдахтай зэрэгцээд нөгөө дагасан хуулиуд дээр өөрчлөлт оруулчихсан учраас төсвийн суурь хууль дээрээ ч тэр, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр ч гэсэн нөгөө 14 хоног, 3 сар гэдэг дээрээ бол зохицуулалтуудаа оруулаад баталчихсан учраас одоо бол тийм асуудал үүсэхгүй.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн нэмэлт хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм сая Их Хурлын даргын асуугаад байгаа асуудал Байнгын хороо дээр бас яригдсан юм. Тэр асуудал үүсэж болзошгүй гэсэн учраас нөгөө 2026 оны төсвөө өргөхөд 3 сарын асуудал үүснэ гэдэг агуулгаар нь одоо өөрчлөөд явчхаж байгаа юм байна лээ. Хуучин бол зүгээр тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл төсөөлөлтэйгөө яваад байсан юм. Энэ удаа орж ирэхдээ төсвийн хүрээний мэдэгдэл гэсэн мөртөө ахиад төсвийн хүрээний мэдэгдэл гэж орж ирчхээд гишүүд гайхаад байх шиг байгаа юм. Тэгээд тэр нь нөгөө дараагийн төсөв өргөн барихад өөрчлөгдчихсөн байх гэдэг агуулгаар бас тэгж байгаа юм байна лээ шүү гэдгийг хэлье.

2-т гол гишүүдийн асуугаад байгаа зүйл бол инфляц худлаа байна гэдэг зүйл яриад байгаа юм. Дэлгүүрээс юм ороод байхаар 2, 3 дахин болчхоод байхад энэ 3 жилийн инфляцыг нэмэхээр 30, 40 хувьтай байна гээд. Тэгээд би энэ аргачлалаа яаж хийж байгаа, төсөөллөө яаж хийж байгаа гээд холбогдох байгууллагууд нь ирж тайлбар хийсэн. Төсөөллийг бол би Эдийн засаг, хөгжлийн яам хийж байгаа гэж бодож байгаа шүү дээ. Та нар тодорхой загвараар хийж байгаа байх. Тийм учраас тэр загварчлалынхаа гол юуг яриа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн даргын микрофоныг нэмж өгье.

Ц.Даваасүрэн: Төсөөллөө бол Эдийн засаг, хөгжлийн яам нь ингээд хариулна гишүүд ээ. Яагаад гэвэл эд нар төсөөллийг хийнэ. Тэр гүйцэтгэл, явцад ямар инфляц гарч байгаа гэдгийг бол аргачлалаараа Статистикийн төв газар тодорхойлж

байгаа учраас тэр өмнө гарсан инфляцын дүн үнэн, буруу зөрүүтэй байгаа бол ямар аргачлалаар инфляцын сарын түвшнийг тодорхойлоод байгаа, жилийг гаргаад байгааг бол Статистикийн төв газрын дарга ирчихсэн байгаа учраас ингээд асуугаад явъя. Мөнгөний бодлоготой холбогдолтой бас эдийн засгийн гол үзүүлэлтийн нэг нь инфляц учраас тэр валютын ханштай нь уялдуулаад Төв банкны Ерөнхийлөгч байхгүй байгаа юм байна. Бид нар уг нь Төв банкны Ерөнхийлөгчийг ир гэсэн байсан. Тэгээд тэргүүн дэд дарга нь ирчихсэн байгаа учраас та бүхэн яг мэргэжлийн холбогдох байгууллагуудаас нь тодруулаад асуугаад яваарай. Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх үед энэ байгууллагын удирдлагууд оролцоод явна гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Дамдинням сайд нэмэлт хариулт өгье.

Г.Дамдинням: Манай Ганбаатар гишүүн маань бас манай салбарыг толгойлж байсан хүн болохоор бас аргагүй салбартаа санаа зовж, зөв зүйтэй юмыг хэлж байна. Ер нь бол манай салбарын хувьд, манай улсын хувьд бол бүртгэгдсэн 500 тонны нөөц байгаа. Алтны. Үүний 85 хувь нь бол үндсэн орд, 15 хувь нь бол шороон ордын бүртгэлтэй явдаг. Үндсэн ордын хувьд байгаль орчны нөхцөл байдал бол шороон ордыг бодвол харьцангуй гайгүй. Шинэ сайн технологиуд гарчихсан, шинэ сайн стандартууд гарчихсан байгаад байгаа. Тэгээд ер нь бол байгаль дээр ургаагүй л бол олборлодог ийм л зүй тогтолтой. Бидний хэрэглэж байгаа бүх зүйл. Тийм учраас Улсын Их Хурлын тогтоолын 1 гол үндсэн агуулга бол байгаль орчны нөхөн сэргээлт, хаалтын дэнчин, барьцааг бас авах тухай утгыг бас тодорхой оруулчихсан байгааг бас энд тодорхой хариулъя.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр болохоор бол 2024 оны төсвийн төлөвлөлтийн эдийн засгийн үр өгөөж бол маш бага байсан гэсэн ийм дүгнэлт хийсэн байгаа юм. Тэгэхээр 2025 онд бол экспортын орлого нэлээн буурчихсан энэ үед 2025 оны төсвийн тодотгол хийхдээ энэ асуудлыг яаж анхаарч тусгасан бэ гэдэг ийм асуулт байгаад байна.

2 дугаарт болохоор бол дунд хугацааны төсвийн хүрээний төсөөлөл тооцохдоо хамгийн муу тохиолдлоо ер нь тооцдог юм уу гээд байхгүй юу. Нүүрсний орлого экспорт бол бүр зогссон тохиолдол бас байж болно шүү дээ. Ер нь бол зүгээр тохиолдлын хувьд бол. Иймэрхүү муу тохиолдлыг хамгийн сайн тохиолдол нь ч гэдэг юм уу, хувилбар нь ч гэдэг юм уу ийм байдлаар ер нь тооцдог юм уу Эдийн засаг, хөгжлийн яам гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам. 4 дүгээр индэр.

И.Батхүү: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн сайн, муу, дунд хувилбаруудыг бол тооцож үзэж байгаа. Жишээлбэл, сайн хувилбар гэдэг нь бол батлагдсан төсөв, төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэхээс илүү арга байхгүй. Суурь төсөөлөл гэдэг нь бол яг гадаад зах зээл дээр олон улсын байгууллагууд манай дотоодын холбогдох байгууллагуудын гаргаж байгаа таамаглалын үнэ, биет бодит хэмжээнүүд дээр тооцоолоод гаргаж байгаа төсөөлөл. Жишээ нь энэ төсөөлөл бол саяхан хүртэл төсвийн алдагдал оны эцэс хүртэл 2,3 их наядаар тасрахаар байна гэсэн тооцоолол 2 сарын өмнө гарч байсан бол муу хувилбар буюу хамгийн сүүлийн үеийн чиг хандлага дээр дахиад update хийсэн тооцооллоороо бол

70 дээр тооцоход 3,3 их наяд төгрөгийн төсвийн алдагдал гарахаар байна гээд ийм хувилбарууд тооцож байгаа. Энэ хувилбарууд яагаад яригдаж байгаа юм бэ гэх юм бол Монгол Улсын эдийн засаг уул уурхай түшиглэсэн эдийн засгийн бүтэцтэй. Уул уурхайн бүтээгдэхүүний хэлбэлзлээс маш их хамаардаг. Үүнтэй холбоотой тооцоолол бол гадаад сектор дээр их хэлбэлзэлтэй байдаг. Олон улсын тодорхойгүй байдлын индекс гээд гаргадаг индекс бол economist business unit гээд сэтгүүлээс гаргаж байгаа индексээр бол ковидын үеийн гаргаж байсан тодорхойгүй байдлын индексээс өнөөдрийн тодорхойгүй байдлын индекс бол хамаагүй өндөр болчихсон. Яг дэлхийн түүхэнд хамгийн өндөр тодорхойгүй байдал явагдаж байгаа ийм нөхцөл байдалд байгаа. Тэгээд бас бид байнга олон улсын худалдааны нөхцөл байдлыг ажиглаж, мониторинг хийж байгаа. Энэ дээр тодорхой тэнцвэртэй түвшинд хүрэх тийм нөхцөл байдал одоохондоо үүсээгүй байгаа. Энэ жил дуусаад ирэх жилийг дуустал ер нь олон улсын эдийн засгийн өсөлт гол худалдааны түнш улс орнуудын эдийн засгийн өсөлт дээр дандаа сөрөг нөлөөллүүд нэмэгдэж гарахаар байгаа. Ийм тодорхойгүй байдлаас үүсэж.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэгэхээр Монгол Улс бас дан ганц уул уурхайн салбарын экспорт бүрэн зогсвол бид нар төсөв ер нь ямар хэмжээнд байж болох вэ гэдэг ийм хувилбар бас тооцож явах ёстой байх л гэж бодоод байна л даа. Одоо болохоор уул уурхайн экспортоо дагаад бид нар төсвөө нэлээн тэлчихсэн. Төсөвт байгууллагууд албан хаагчдынхаа тоог нэмчихсэн, барилга байшин бариад байдаг. Хэрвээ уул уурхайн экспорт үнэхээр тодорхой хэмжээнд зогсвол манай төсвийн хамгийн дээд талын зарлагын боломжит хэмжээ нь хэд юм бэ гэдэг дээр бол бас тооцоо байх ёстой байх л гэж бодож байна. Цаашдаа бол нүүрсний үнэ ингэж нэг их өсөхгүй юм байна лээ шүү дээ. Хятад Улс чинь нүүрс авахгүй юм байна. Тэгэхээр бид нар ер нь цаашдаа яах ёстой вэ. Энэ төсөвт байгууллагын төсвийн зардал маань хамгийн дээд талдаа хэд байх ёстой юм бэ гэдэг дээр тооцоололтой байх ёстой л гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр үндсэндээ олон улсад ч бай, манай улсын хувьд ч бай уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ буурч байгаа нь нэг талдаа тодорхойгүй байдлыг үүсгэж, эдийн засгийн нөхцөл байдлыг хүндрүүлж байгаа гэж хэлж байгаа. Нөгөө талдаа бид нарыг яг бодит байдал руу л дөхүүлэх гээд байна л даа. Энэ бол боломж. Нэг ёсондоо бид нар өнгөрсөн жилүүдэд Оюутолгойгоос авсан татвар, Эрдэнэтээс олсон мөнгөнүүд, энэ Тавантолгойгоос олсон мөнгөнүүдээр юу хийсэн бэ гэхээрээ л төсвийнхөө урсгал зардлыг л санхүүжүүлсэн. Маш цөөхөн хэдхэн барилга, зам тавьсан байх. Тэгээд эргээд ажлын байр бий болгож чадаагүй, эргээд иргэдээ ажилтай, орлоготой болгож чадаагүй. Өнөөдөр бол бид нар хэлсээр байгаад бодит байдал руугаа л шилжиж байна. Төсвийн урсгал зардал хэд дээр байх вэ. Энэ үнэ ханшууд дахиад хэлбэлзэхэд бид нар эдийн засгаа том хэлбэлзүүлчихгүй байх тэр зохистой хэмжээ рүү очих ёстой. Энэ дээр бол түрүүний тэр Булгантуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг, Сангийн сайдаас гаргасан тэр олон хуулийн өөрчлөлтүүдийг бид нар зоригтойгоор хийх ёстой. Урсгал зардлыг ер нь бол 15 их наяд руу дөхүүлж буулгаж байж байж л бид нар аль нэгэн ашигт малтмал, уул уурхайн бүтээгдэхүүнээс хамаарал багатай болно.

Тийм учраас өнгөрсөн жилүүдэд уул уурхайн энэ хамааралтай байдлаа бууруулж чадаагүй дагаад үнэ өссөн, дагаад бүх зардлаа өсгөсөн. Одоо эндээсээ бид нар сургамж үлдээж авч дараа дараагийн тогтвортой байдал руугаа шилжих энэ боломж болгож хувиргах ёстой гэж бодож байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд 1 харамсалтай зүйл байгаад байгаа юм л даа. Төсөв бол яах вэ өсдөг, буурдаг. Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулна гэдэг бол ерөөсөө ирээдүйн 3 жилийг хардаг. Гэтэл жоохон хэлбэлзэнгүүт нь л хэдүүлээ төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилж байдаг. Тэгвэл энэ ирээдүйн 3 жилийн хэлбэлзлүүд дээр хэн дээр хариуцлага тооцох юм. Ирээдүйн мөрөөдөл гэж хэлээд байгаа юм. Мөрөөдөл биш шүү. Мэргэжлийн баг гаргаж ирээд тийм болгож удирдах ёстой гэж байгаа юм. Эдийн засгаа ч буруу хараад байх шиг байна. Өнөөдөр эдийн засгийг Засгийн газрын орлого, зардал гэж харж байгаа бол андуураад байна. Энэ Засгийн газрын орлого, зардал дээр нэмэх нь иргэд бизнесийн орлогуудыг нэмж байж хүлээлтээр эдийн засгийн механизмын аргаар энийг бид нар удирдаж, тэнд хүргэж чадна гэдэг амлалт шүү дээ. Тэгж байж энэ амлалтын бичиг баримт гарч ирж байгаа. Амлалтаа хийж чадахгүй энэ бичиг баримтаа хийж чадахгүй бол яаж хариуцлага тооцох юм. Тэгэхээр өнөөдөр энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ингээд л төсөв жоохон өөрчлөгдөнгүүт л өөрчлөөд байдаг. Төсвийн тогтвортой байдлын хуулийг л ингээд өөрчлөөд байдаг. Энэ тогтворгүй байдал чинь өөрөө бид нарыг ямар ч эдийн засгийн алсын хараагүй бодлогогүй болгоод байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад хэдхэн асуултыг асууя.

Тэнцвэржүүлсэн үнэ алт, нүүрс, зэс дээр хэд хэдээр тооцсон бэ. Ер нь бол зах зээлийн үнэ хэд байгаа юм. Миний харж байгаагаар бол нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ зах зээлийн үнээсээ өндөр байгаад байгаа. Тэгвэл тэрийг нөхөх сан нь байгаа юм уу. Нэг ёсондоо зах зээлийн үнэ огцом унаж байгаа үед тэнцвэржүүлсэн үнээр тооцдог энэ аргачлал нь орлогыг хий өсгөөд байгаа юм биш үү. Энэ дээр ямар дүгнэлт хийсэн юм. Энэ дээр өөрийн гэсэн үндэсний аргачлал байна уу. Тэр байтугай олон улсын зах зээлийн үнэ Монгол Улсын худалдах чадвартай хамааруулаад Монгол Улсын экспортын үнэ 2-ын бас хооронд үнийн зөрүү байгаад байгаа. Энэ зөрүүг яах вэ. Тэнцвэржүүлсэн үнэ, эдийн засгийн үнэ буурах асуудал дээр хэрвээ дүгнэлт хийсэн бол энийг ер нь цаашид яаж явах юм. Ер нь цаашдаа ингээд төсөв өөрчлөгдөх үед бид нар төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд байх юм уу гэдэг ийм асуудал байна.

Дээрээс нь энд манай улсын өр буурах юм уу. Одоо бид нар алдагдалтай төсөв рүү орчихлоо гарцаагүй байдалд. Гэтэл ДНБ-д эзлэх байдлаар өрийг чинь бууруулна гэж ингэж тооцоолж орж ирээд байгаа. Валютын ханш өсөөд байдаг. Хэрвээ алдагдалгүй төсөв батлаагүй байсан бол дахиад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам. 4 дүгээр индэр.

И.Батхүү: Гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдэл бол дунд хугацааны төсвийн макро эдийн засгийн төсөөллөөс гадна бас давхар бодлогын чиглэлүүд явж байдаг. Таны хэлж байгаа зарлагын түвшнийг ДНБ-ийг хэдэн хувьд нь хадгалах вэ, бууруулах вэ, алдагдалтай байх вэ гэдэг ийм бодлогын шинж чанартай тоонууд байж байгаа. Жишээ нь таны хөндсөн урсгал зардлын асуудал байгаа. Бидний тооцооллоор 2026 онд урсгал зардлыг GDP-ийн 2027 онд 23, 2028 онд 22 хувь болгож бууруулна гэсэн энэ бол яг бодлогын чиглэлийн нэг жишээ нь байгаа. Урсгал зардлыг бууруулна гэдэг маань өөрөө GDP-д эзэлж байгаа хувийн

хэвшлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх төрийн оролцоог багасгах гэсэн бодлогыг агуулж байгаа. Яг хуульд заасан хязгаар нь бол 30 хувь байгаа. Яг энэ тодорхой тоонууд нь бол цаашаа төсвийн тодотгол төсөв хэлэлцэх үеэр яригдаад явна. Улсын төсвийн орлогыг тооцохдоо тэнцвэржүүлсэн үнийг буюу бодитой зах зээлийн төсөөлсөн үнэ 2-ын аль багаар нь тооцдог. Нүүрсний үнэ бол түрүүн тэнцвэржүүлсэн хуульд заасан томъёогоор боддог дүнгээсээ бага байгаа. Тэгэхээр нүүрсний үнэ бол тэнцвэржүүлсэн үнэ нь 133 доллар, зэсийнх нь 8341 доллар гэж 2026 онд тэнцвэржүүлсэн үнээр тооцогдож байгаа. Бид түрүүн дурдсан нүүрснийхээ үнийг 70 доллароор авсан байгаа. Зэсийнхийг зэсийг 9200 доллароор тооцсон байгаа. Алт бол нөгөө тэнцвэржүүлсэн үнэ тооцдоггүй хуулиараа.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Ер нь алт өөрөө тодорхой ДНБ-д эзлэх хувийн шаардлага хангаагүй гэдэг шалтгаанаар энд тэнцвэржүүлсэн үнэд орохгүй байгаа боловч бодит эдийн засаг дээрээ орох зайлшгүй шаардлагатай байгаа шүү дээ. Яг одоо тэр алтны орц хольцуудыг нь яг зөв гаргаж байна уу, үгүй юу гэдэг асуудал өнгөрсөн төсвөөр яригдаж л байсан. Энэ дээр ямар дүн шинжилгээ хийсэн юм. Тэгээд өнөөдөр эдийн засаг төсөв буурлаа гэхээр алтаа л ярьж байгаа биз дээ. Тэгсэн мөртөө энийгээ тэнцвэржүүлсэн орлого тооцохдоо тооцохгүй байна гэдэг чинь ямар бодлого юм бэ.

Тэр өрийг яаж бууруул бууруулна гэж тооцож байгаа юм. Ер нь бол алдагдалгүй төсөв баталснаараа Засгийн газрын өрийг 2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний доллароор бууруулсан. Тэгэхээр энэ Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ өрийг ер нь яаж тогтвортой бууруулах юм. Урсгал зардлыг аль түвшинд байж байж бид нар уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хамаарлаас хамаарал багатай болох юм.

3 дугаарт дахиад энэ тодорхойгүй байдал гэж байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье. Тэр алт бол ийм учиртай юм байгаа юм. Тэнцвэржүүлсэн үнэ тооцдоггүй учир нь ДНБ-ий 2 хувиас давсан төсвийн нөлөөлөлтэй ийм түүхий эдүүд дээрээ л энийг ач холбогдол өгч, тэнцвэржүүлсэн үнэ тооцдог гэсэн үг. Алтны хувьд бол төсөв дээр нөлөө бол маш. Нүүрстэйгээ харьцуулах юм бол маш бага, маш бага. Одоо онцолж “Алт 3” аяныг яриад байгаа маань ерөөсөө л валютын нөөц дээр юм байгаа юм. Төв банк дээрх валютын нөөц. Энэ бол Монгол Улсын валютын нөөц. Одоо тонн нь үндсэндээ одоогийн ханшаар бол энэ чинь бараг 100 сая доллар болчихоод байгаа байхгүй юу. 1 тонн нь. Бид өмнө нь 22, 23 тонн жилдээ авч байсан өндөр үеүд байгаа. Одоо бид яг тэр хэмжээндээ л хүрчихэд манай валютын нөөцийг бараг 2 дахин нэмэхээр ийм боломж байгаа байхгүй юу. 20 тонн авчихад л 2 тэрбум .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас алтан дээрээ бид өндөр ач холбогдол өгөөд байгаа юм. Харин зүгээр энэ ханш өндөр байна гээд төсөв дээрээ их ач холбогдол өгөөд энэ алтыг дагуулаад төсвийнхөө орлогыг нэмэх бол улам л эрсдэлд оруулна. Тийм учраас аль болох төсвийн нөлөөллийг нь бол бага тооцож, гол нь валютын нөөц дээрээ л ач холбогдол өгөх ёстой.

Өрийн хувьд бол юу гэдэг юм 1,2 их наядын ийм алдагдалтай төсөв баталлаа гэхэд тэр хэмжээгээр өр бол нэмэгдэхгүй шүү Түвшин гишүүн ээ. Энийг бид аль болох төрийн сан дээрээсээ санхүүжилтээ хийгээд, төрийн сан дээрээ жоохон ачаалал аваад явна л гэсэн үг. Тэрнээс бол өр бол нэмэгдэхгүй.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Энэ ажлын хэсгийн оруулж ирсэн материалд итгэмээргүй байна. Энэ худлаа санагдаад байх юм. Өнгөрсөн 2024 оны 8 дугаар сард тодотгол оруулж ирэхдээ, мөн 9 дүгээр сард 2025 оны төсөв оруулж ирэхдээ ярьж байсан зүйлүүд өнөөдрийн нөхцөл байдлаас тэнгэр газар шиг ялгаатай байна. Өнгөрсөн жил юу гэж ярьж байснаа та бүхэн санаж байх ёстой. Эдийн засаг 2025 онд 8 хувийн өсөлттэй байна. Та бүхний тарааж өгсөн энэ материал дээр чинь өнөөдөр эдийн засгийн өсөлт 2,4 хувьтай байна гэж байна оны хагаст. Энэ зөрүү дээр хэн хариуцлага үүрсэн юм бэ. Ингээд цаашдаа худлаа яриад байж болох юм уу. Энэ чинь 8 гэж төсөөлөөд 2,4 байна гэдэг чинь асар том ялгаа шүү дээ. Тэгээд энэ тооцоолсон аргачлалууд дээр инфляцын тооцоолсон аргачлал ямар ч хөндлөнгийн мэргэжилтнүүд хэлээд байгаа байхгүй юу. 9,5 байна гэдэг бол хэт доогуур тооцоолсон байх магадлалтай байна. Тэгээд энэ дээр маш тодорхой хариулт авмаар байна.

Энэ та бүхний өгсөн материалаас үзэхээр 15,2 хувиар мөнгөний нийлүүлэлт өссөн гэж байгаа юм. Мөнгөний нийлүүлэлт хэдээр нэмчхээд инфляцад хамгийн нөлөөлдөг зүйл нь бол энэ мөнгөний нийлүүлэлт. 2024 оны зээлийн үлдэгдэл 36,8 их наяд төгрөг байна. Энэ инфляцад нөлөөлж байгаа юу. Мөн цахилгаан, дулааны үнийг бараг нэг дахин нэмчихсэн. Зүгээр иргэдэд ноогдож байгаа тодорхой 150квт цагийг л багасгасан болохоос биш нийт аж ахуйн нэгжүүдэд төлж байгаа дулаан, цахилгааны үнэ бол өсөх төлөвлөлттэй байгаа. Энийг яаж тооцоод, та бүхэн маань 9,5 гэж тооцож байгаа юм. Дээрээс нь эдийн засгийн өсөлтийг дахиад 5,5 байна гээд өнөөдөр 2,4 байна хагас жил болж байхад. Буруу тооцчихсон байвал яах вэ. Тэгээд энэ тооцсон аргачлалаа өгөөд жишээ татаадхаач гэсэн чинь хариулт өгсөн цаас нь өнөөдөр ирсэн. Зүгээр л сайдын тушаалыг л явуулчихсан болохоос биш яаж тооцоод инфляцыг 9,5 болгосноо өгөөгүй байна шүү дээ. Төсвийн байнгын хорооны хурал дээр тэр аргачлалаа тооцсон тооцооллоо өгөөч гэхээр зэрэг сайдын тушаал явуулчихаад хүн залилан мэхлэх ийм арга хэрэглээд байгаа юм уу гэмээр санагдаад байна. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. 4 дүгээр индэр.

И.Батхүү: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Инфляцтай холбоотой асуултууд нэлээн хэд давтагдсан. Нэг хэсэг нь бол инфляцын бодит гүйцэтгэл, бодит тоон статистикийг асуугаад байгаа. Тэр нь түрүүн хэлээд Батдаваа дарга хариулаад байгаа. Нөгөө талаасаа инфляцыг яаж тооцдог вэ гэдэг аргачлалын талаар бас асуугаад байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яамнаас бол эдийн засгийн идэвхжил, хөдөлмөрийн зах зээл, төсөв, төсвийн зарлага, гадаад сектор зэрэг олон төрлийн салбаруудын бодит тоон мэдээллийн таамаглалыг гаргаад, бүтцийн гап загвар ашиглаад энэ тооцоолоог гаргаж байгаа. Мөн бас инфляц тооцдог аргачлалтай нь уялдуулаад тухайн нөлөөллийн хүчин зүйлсийг нь бас өгөгдлүүдийн хувь дээр бас сценариуд гаргаад бас инфляцыг тооцож үзэж байгаа. Мэдээж олон байгууллагын инфляцын төсөөлөл таамаглалууд нь өөр байх нь аргагүй. Та бүгдээс

гарч байгаа олон улсын банк санхүүгийн байгууллагуудын гаргадаг төсөөллүүд ч гэсэн өөр өөр байдаг. Аль нэг байгууллагын тоонд туйлын үнэн зөв гэж таамаглах арга байхгүй. Ялангуяа дэлхийн гадаад зах зээл, сектор дээр тодорхойгүй байдал их өндөр байгаа. Гадаад секторын нөхцөл байдал өдөр хоногоор өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд инфляцын тоо хэмжээг шууд ингээд бодитой хэлдэг тийм хүн, байгууллага хаана ч байхгүй байгаа гэдгийг хэлье. Бодит инфляцын талаар бас Статистикийн хорооноос хариулчих байх.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун. Пүрэвдаваа гишүүн тодруулах юм байна. Тодруулж асууя. Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Үгүй ээ, ер тоймтой хариулсангүй шүү дээ. Яаж бодоод 9,5 гаргасан юм бэ гэдгээ цаасаар өгчих гэхээр сайдын тушаал явуулаад байна гэдэг чинь үндсэндээ энэ чинь хариулахгүй л гэсэн үйлдэл биз дээ. 2,4 хувьтай өсөлттэй байна гээд та нарын тарааж өгсөн материал дээр байна. Өнгөрсөн жил 8 хувь байна гээд мэдэгдээд байсан. Одоо 5,5 гэж оруулж ирж байна. Энийгээ яаж нотлоод байгаа юм бэ. Энэ дээр хэн хариуцлага үүрсэн юм бэ гээд маш тодорхой асуулт асуухаар ер тодорхой хариулт өгөхгүй юм.

Мөнгөний нийлүүлэлттэй яриач ээ, тайлбарлаад өгөөч ээ. Хариултаа гүйцэт авмаар байна Хурлын дарга аа. 15 хувийн мөнгөний нийлүүлэлт инфляцад яаж нөлөөлөөд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ. Тодорхой хариулт өгөх боломжтой, чадамжтай хүн байна уу. Статистик хариул. 3 дугаар индэр.

Б.Батдаваа: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Инфляцыг бид ОУВС-аас улс орнуудад зөвлөмж болгодог аргачлалын дагуу жилдээ 11 мянга орчим өрхөөс судалгаа аваад, энэ өрхийн хэрэглээний гол бүтэц, зардал нь ямар ба бүтээгдэхүүн үйлчилгээ дээр гарч байна гэдгээр тооцдог байгаа. Ингээд тооцоод үзэхээр улсын хэмжээнд 8,3, Улаанбаатар хотод 9,4, үйлчилгээнийх 17 хувь, хүнснийх жилийн 6,5 гараад байгаа. Яг гишүүдийн шүүмжлээд байгаа бараа бүтээгдэхүүн нь өндөр байгаа гэдэг дээр зүгээр жишээ дурдахад гол инфляц маань өөрөө өнгөрсөн оны 5 сартай дундаж үнийг энэ оны 5 сард харьцуулаад байгаа. Энэ дотор 430 бараа бүтээгдэхүүн орж байгаа. Гишүүний хэлдэгчлэн цахилгааны үнэ жишээлбэл, дунджаар 65 хувь, нөгөө хэрэглээнээсээ хамаараад 98 хувь хүртэл инфляц дээр өсчихсөн явж байгаа. Махны үнэ гэхэд жишээлбэл 4 дүгээр сард ямааны мах гэхэд 22.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу. 3 дугаар индэр.

Б.Батдаваа: Тэгэхээр тооцоо дээр бол тэгж явж байгаа. Жишээлбэл, Атар талх гэж бодоход 4 жилийн өмнө 1280-тай байсан бол одоо 2600 гээд явж байгаа юм. Тэгэхдээ сүүлийн 1 жилийн үнийн өсөлт бол харьцангуй гурилан бүтээгдэхүүн дээр тогтвортой, махны үнэ дээр өндөр. Тэгээд эдгээрийг дундажлаад ирэхээр дундаж нь ийм байгаа. Бид нар бүтээгдэхүүний задаргаагаар бүлгээр нь харилцан адилгүй байгааг бол нийтэд мэдээлээд, статистикийн нэгдсэн мэдээллийн санд бол тавьж явж байгаа.

Д.Амарбаясгалан: Гурилын татвар тэглэсэнтэй холбоотой гурил болон гурилан бүтээгдэхүүн дээр үнийн өсөлт гараагүй. Харин тодорхой хувиар бууралт

бий болсон гээд энэ статистикийн мэдээ дээр байна лээ. Одоо татвар тэглэх хууль хүчингүй болсон. Буцаад дахиад та бүхний тооцоо төсөөлөлд өөрчлөлт орох л байх даа. Пүрэвдагва гишүүний асуугаад байгаа асуултад агуулгад бас та хэд маань бас тэрийгээ бодно биз. Одоо гурил, гурилан бүтээгдэхүүн чинь дараа жил гэхэд шал өөр л нөхцөл рүү явна шүү дээ. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: 2 асуулт асуучихъя. Хууль санаачлагчаас ирсэн 2 төсөл 2025 он, 2026 оны хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төсөөлөл гээд. Энэ 7 хоногт бид нар нөгөө Засгийн газрын бүрэлдэхүүний хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Тэгээд энэ нь болохоор 3 сарын хугацаанд нэмэлт өөрчлөлтийг нь өргөн мэдүүлэхгүй гээд тийм заалт байсан шүү дээ. Тэгэхээр одоо энэ 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт нь Засгийн газрын бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотой юм уу гэдэг асуудал байгаа.

2 дахь асуулт нь өмнөх чуулган дээр би асууж байсан. 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсөөллийн тухай хуульд файл дээр тодотголыг нь харахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой 5 багц зардал дээр дүнгүүд бас хасагдаж байгаа. Ялангуяа сэргээн засалтын зардал хасна гэсэн тийм мэдээлэл байгаа. 86,8 сая гэхихсэн ийм дүн байгаа. Тэгэхээр тэр багц зардлаа харахаар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний журам гэдэг тэр зардлын ангилал руу оруулж байгаа. Тэгэхээр энэ хасаж байгаа, танаж байгаа зардал чинь өөрөө ямар эрэмбэ дараатай танагддаг юм бэ гэдгийг асуумаар байгаа.

Дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн багц дээр ямар үндэслэлээр энэ зардлыг хасаж байгаа юм бэ гэдгийг бас тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт орж байгаа маань тэр Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд орж байгаа өөрчлөлтүүдтэй шууд холбоотой шүү. Үүний дараа тодотгол бид өргөн барьчихсан байгаа. Энийгээ яриад явна. Тэгэхээр энэ удаагийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлтүүд хийхгүйгээр тодотгол хийх боломжгүй. Тодотгол маань өөрөө 34.1,2, 34.1,4 гээд 2 заалтаар үндэслэж байгаа. Тэр 1 нь таны саяын асуусан тэр Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд орж байгаа өөрчлөлттэй холбоотой гэсэн үг. Тэгэхээр ингээд дамжаад дамжаад нөлөөллүүд нь хоорондоо бол холбоотой гэсэн үг.

Тэр хасагдаж байгаа зардлуудын хувьд уг нь тодотгол дээр яривал илүү их тодорхой болно доо. Энэ удаа хэдүүлээ хүрээ ярьж байна. Тэгэхдээ Сангийн яамнаас Санжаа дарга мэдээлэл өгчих үү. Тэр дүнгүүдтэй холбоотой.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд гүйцээж хариулах уу. 4 дүгээр индэр Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголтой холбоотойгоор бид нар 2 зүйлийн өөрчлөлт орж ирсэн байгаа.

1 дүгээрт Төрийн хэмнэлтийн тухай хуулиар бол хуулиараа хэмнэгдсэн зардлын өөрчлөлтийн тооцоо орсон.

2 дахь нь бол төрийн хувьд яг бүсээ чангалах, хэмнэх ийм горим орж ирсэн байгаа. Тэгэхээр байгууллагуудын хувьд нэг л ижилхэн зарчим барьсан. Тэр нь юу вэ гэхээр 1-6 дугаар сарын буюу эхний хагасын хуваарилагдсан зардлыг бол бид хөндөөгүй. 2 дугаар хагасын зардал дээр бол хөндөөд явсан. Мөн хөндөөгүй зардал дээр нэмээд тэтгэвэр тэтгэмжийг хөндөөгүй, халамжийг буюу хүүхдийн мөнгийг хөндөөгүй. Тэгээд хүн амтай холбоотойгоор үржүүлж тавигддаг гэх юм уу цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө, сургуулийн хүүхдийн хоолны мөнгө, мөн төрийн тусгай албан хаагчдын цалин хөлстэй холбоотой тийм зардлууд хөндөөгүй. Бусад бүх зардлыг хөндсөн. Хөгжлийн бэрхшээлтэй бас ялгаагүй.

Д.Амарбаясгалан: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Би зүгээр санал л хэлчихье гэж бодож байна. Одоо би яг 1 жилийн төсөвтэй холбоотой асуудал дээр дахин дахин ярьж байгаа нь бол салбарын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Сангийн яам бүгдээрээ хамтарч байгаад хэдүүлээ нөгөө зардлын ангиллаа илүү нарийвчлалтай гаргахгүй бол олны дундаас буруу ойлголт гарах гээд байгаа. Тэгэхээр зардлын ангилалтай болж байгаа нь маш сайн хэрэг. Гэхдээ бид нар энэ дээр зардлын ангиллыг нь илүү тодорхой болгоод бэлдэж байгаа шүү. Тийм болохоор дараагийн удаагийн төсөв дээрээ энийгээ заавал оруулах дээр энд байгаа мэргэжилтнүүд болон хүмүүс нь анхаараарай гэдгийг далимдуулж хэлье.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсөв гэдэг бол тоогоор илэрхийлж байгаа хөгжлийн бодлого гэж ойлгодог. Тэгээд Монгол Улсын ирээдүйн хөгжлийн, тэр дундаа эдийн засгийн хөгжлийн бодлогыг өнөөдөр хэлэлцэж байна. Тэгээд Жавхлан сайд, Дамдинням, Ундрэм сайдаас өөр сайдууд энэ танхимд алга л даа. Тэгэхээр энэ Засгийн газарт эдийн засгийн бодлого бол нэг их сонин биш байх шиг байгаа юм. Ер нь Жавхлан сайдын хариултаас харахад Монгол Улсад эдийн засгийн бодлого байна уу даа гэдэг ийм бодол төрж байна. Учир юу юм бэ гэхээр өнгөрсөн Засгийн газарт бид нар хамтарч ажилласан. Тухайн үеийн Сангийн сайд төсөв тодотгох шаардлага байхгүй. Төсвийг тодотгоход бол шалтгаан хэрэгтэй гэж хэлдэг байсан. Одоо ингээд төсвөө тодотгож байна л даа. Юу илэрхийлж байна вэ гэхээр Засгийн газар өөрчлөхийг л хүлээж байсан юм шиг байгаа юм.

2 дугаарт энэ төсвийг тодотгож байна гэдэг бол бид нар төсвийн төлөвлөлт дээр алдаа гарч байна л гэсэн үг. Төлөвлөлтийн алдаа гарч байна. Тэгээд Их Хурлын гишүүд бол ингээд төлөвлөлтийн алдаа гараад, төсвийн хүрээний мэдэгдэл чинь 2, 3 жилдээ тогтвортой байгаад, ингээд жил болгон төсвөө батлаад явах энэ явц чинь 6-7 удаа төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд, төсвийн тодотгол хийгээд байна, төсвөө буруу төлөвлөөд байгаа юм биш үү, эдийн засгийн хөгжлийн бодлого байна уу, нүүрс, зэсийн дэлхийн үнэ ханшийг тойрсон зүгээр л нэг ийм нягтлан бодохын бүртгэл байгаа юм биш үү гэдэг ийм хандлагаар асууж байна л даа. Тэгээд хариултауд бол жоохон хангалтгүй байна. Өмнө нь их сайн хариулдаг байсан. Тэгээд Жавхлан сайд Гантөмөр сайд байхгүй болохоор ганцаардаад байгаа юм уу. Яасан юм. Их тааруу хариулаад байна та. Их ач холбогдол өгөхгүй байгаа юм уу.

Энэ бас энэ Эдийн засаг, хөгжлийн яамныхан маань юу болсон юм. Ерөөсөө хариулдаггүй. Тэгээд тодорхой хариултууд өгмөөр байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл дээр би ийм зүй гэвэл асуумаар байна. Одоо Улсын Их Хурал хэд хэдэн хуулийн төслийг өргөн барих гэж байгаа шүү дээ. Энд нь жишээлэх юм бол нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувь болгох хуулийн төслийг өргөн барьчихсан. Одоогийн Ерөнхий сайд бол энэ хуулийг дэмждэг. Ингээд татварын маш олон өөрчлөлтүүд гарна. Энэ татварын орлого бүрдүүлэлт дээрээ энийгээ тооцож үзсэн үү. Дахиад буруу төлөвлөөд оруулаад ирсэн юм биш биз дээ. Инфляцтай холбоотой зүйлийг олон гишүүн асуусан учраас би энэ татварын орлоготой холбоотой зүйлийг нэмж асуумаар байгаа юм.

2 дугаарт нийгмийн даатгалын реформ хийгдэнэ. Нийгмийн даатгалын шимтгэлд өөрчлөлт орно. Энэ асуудлыг энэ төсвийн орлого бүрдүүлэх талдаа оруулсан юм уу гэж асуумаар байна.

2 дугаарт нь аудитын байгууллага 9,3 их наядын зөрчил байна. 61 төсвийн ерөнхийлөн захирагч бол алдаа гаргасан байна гэж байгаа юм. Ер нь энэ аудитын дүгнэлт дээр хариуцлага хүлээлгэдэг яасан юм бэ. Монгол Улсын аудит бол зөрчлийг танилцуулдаг байгууллага болж хувирлаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр Баярмаа гишүүн маш оновчтой саналыг бол хэлсэн байна лээ шүү дээ. Ингээд нэг ийм төсвийн хариуцлага гэдэг зүйлийг 1 удаа энэ парламент, Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан дарга аа, аудитын байгууллагын дүгнэлт дээр ач холбогдол өгөхгүй бол цаашдаа бол энэ явахгүй нь гэж хармаар байна.

3 дугаарт маш олон хууль дээр энэ татварын хөнгөлөлт авахаар байгаа шүү дээ. Жишээлэх юм бол Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хуулийг дагаад Монгол Улсын инновац, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд 8 төрлийн дэмжлэг үзүүлэхээр байгаа шүү дээ. Энэ төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлнө.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ, одоо энэ чинь төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт ярьж байгаа шүү. Төсөв биш. Тийм учраас төсөв дээр бол би бүх асуултад нь хариулаад явна. Төсвийн хүрээний мэдэгдлийг Эдийн засаг, хөгжлийн яам маань өөрөө макро төлөвлөлтөө хийдэг. Инфляцтай холбоотой макро төлөвлөлт, бүх асуудлуудаа Эдийн засаг, хөгжлийн яамтай болсных энэ яам маань бүтэн ажиллана.

Бид тэр таны ярьж байгаа татварын орлого болон нийгмийн даатгалтай холбоотой энэ өөрчлөлтүүд бол 2026 оны төсөв дээр нөлөөллүүд нь гарч ирнэ. Бид одоо 2025 оны сүүлийн хагас жилийн төсвийн тодотголыг хийгдэж байгаа юм. 3, 4 сард ер нь бол тодотгол хийх шаардлагагүй байсан. Бид хууль зөрчиж тодотгол хийж болохгүй. Хэн нэгэн хүнийг тодруулах гэж зорилготойгоор тодотгол хийж болохгүй. Тийм хүсээд байх зүйл ч биш. Өдөр өдрөөр нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Шинэ Засгийн газар байгуулагдаад бүтцэд нь өөрчлөлт орсон учраас энэ бол хамгийн яг хуулийн дагуу зөв үндэслэл нь өөрөө энэ. Энийг дагаад хэмнэлтийн тодотгол хийгдэж байгаа ийм л асуудал.

Тэр мэдээлэл технологийн тэр 8 төрлийн дэмжлэг эд нар гээд ер нь салбар болгон дээр ийм зүйлүүд байгаа. Ер нь салбар салбарын энэ 208 хуулиар аль хэдийн төсвийг хуваарилчихсан байж байдаг. Гэтэл төсөв маань энэ хуваарилалтдаа ч хүрдэггүй байгаа. Энэ мэдээлэл технологийн бид санал хүргүүлсэн энэ олон төсөв дээр ачаалал ирж байгаа энэ хуулиудыг цэгцлэх дотор бас энэ орчихсон л явж байгаа. Энэ нөлөөллүүдийг нь хойшлуулъя. Эсвэл бүүр энэ хуулийг нь цуцалъя гэсэн ч саналууд байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Үдээс хойш төсвийн тодотгол хэлэлцэнэ. Би энэ хүрээний мэдэгдэл дээр уг нь асуугаад байгаа юм. Энэ 2, 3 жилдээ Монгол Улсын эдийн засгийн бодлого, төлөвлөлт, байр байдал ямар байх юм бэ гэдгээ тодорхой болгочихвол гаднын хөрөнгө оруулагчид, мөн дотоодын бизнес эрхлэгч нарт их ойлгомжтой байдаг. Төрийн бодлогыг илүү тодорхой, нээлттэй, тогтвортой байлгах нь хөрөнгө оруулагч нарт бол ээлтэй байдаг. Энэ утгаараа энэ хүрээний мэдэгдэл дээр бол би энэ зүйлүүдээ яаж төсөөлж байгаа юм бэ гэдэг энэ төсөөллийг асуусан. Төсөв дээр бол төсвийн тухай бол тодорхой асуултуудыг асууя. Ер нь бол 2 зүйл дээр анхаараач ээ гэж хэлмээр байна Сангийн яамныханд. Энэ Эдийн засаг, хөгжлийн яамны асуудал бол энэ хүрээний асуудал, Төсөв бол манай асуудал гэж хандаж болохгүй. 2 яам нийлээд Монгол Улсын эдийн засгийн бодлого, сангийн бодлогыг яг ингээд маш зөв төлөвлөж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Жавхлан сайдын ч нэг их буруу биш шүү дээ. Энэ чинь ямар мэргэн хүн биш. Трампын ингэж галзуурахыг энэ чинь жилийн өмнө юугаа мэдэх вэ дээ. Ер нь бол нүүрс унасан. Энэ бол Хятад хөрш орон дээр ийм зах зээл ийм боллоо. Ерөөсөө л энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулж ярья. Макро эдийн засгийн хувьд ярья. Төсөв бол орлого, зарлага 2-ыг л хэлдэг. Орсныг гаргадаг зарлага. Орлого, зарлага 2 тэнцэх ёстой. Төсвийн тэнцвэржүүлэлт. Тэгэхээр орох орлого маань гэнэтхэн уначихлаа. Одоо яах вэ гэвэл хоёрхон алхам байгаа. Зарлагаасаа хасна. Аль сургууль, цэцэрлэгээ хасах вэ гэдгээ ярина. Дээр нь нэмээд ерөөсөө хулгайлагдаж байгаа орлогуудаа бас тэмтэрч үзэх шаардлагатай байна л гэсэн үг. Монгол оронд өнөөдөр юм олохгүй байгаадаа бид зовж байгаа юм биш. Олсон юмаа улс төрчид нь цөм шаадаг учраас л бид шаналж байгаа. Сайд дарга нарын тансаглалаас болж бид ингэж хуралдаж байна. Тэгэхлээр яах вэ манай Засгийн газар, манай орон чинь ер нь тэгээд л нэг ня-бо-доо хага хатгуулчихсан сургуулийн захирал шиг л амьтад шүү дээ. Ня-бо бол олсон мөнгийг л тоолдог амьтад. Нэг их айхтар юм биш. Тэгээд их амархан юмыг үгүй ээ, мөн хэцүү гоёор тайлбарлах юм.

Тэгэхээр би Жавхлангаас асууя. Жавхлан Жанлавцогзол сайн уншуулаарай. Тэгээд хулгайч нартайгаа сайн тэмц. Асуулт байна. Энэ Хүрэлсүх ба түүний командын энэ түрийвч хулгайч нарын энэ аймшигтай хулгайг зогсоочихвол наадах чинь гайгүй болчих гээд байна.

1 дүгээрт. Газрын тосны үйлдвэрийн газар гэж 1,7-2,2 тэрбум долларын луйвар явж байгаа. Энэ баригдахгүй. Би газрын тосны үйлдвэртэй болохыг хүсэж байгаа, мөрөөддөг Монгол хүн. Норенко гээд тэр газрын тосны 500 орчим сая байх, 420 байна уу сая долларын хэнд ч хэрэггүй тэр баахан хоолой барьсан. Хүрэлсүхийн

хамаарал бүхий этгээдүүд барьсан гэж би ойлгож байгаа. Энийг нягталсан уу. Энэ дээр хариуцлага тооцсон уу. Энийг төсөвт оруулж ирэх боломж байна уу. 1 дүгээр асуулт.

2 дугаарт Эрдэнэтийн үйлдвэр сонин дээр өнөөдөр биччихсэн байна. Содбаатар үйлдвэр гээд нэр өгчихсөн байна лээ шүү. Ёндон манай Хүрэлсүхийн найз. Энэ дээр байгаа энэ олон тендерийн хулгай луйврууд тэр сонин дээр биччихсэн байна лээ. Энэ олон баяжмалын гэрээ нууцаас хэзээ гарах юм бэ. Энэ чинь Монголын ард түмний 100 хувийн өмч шүү дээ. Хүрэлсүхийн өмч биш. Жавхлангийнх бүр биш, Ганбаатарт бол бүр падгүй. Би төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулж асууж байна шүү. Монгол Улсад орж ирэх ёстой байсан орлого замаасаа хулгайлагдаж байна. Энэ асуудал дээр ямар нэгэн арга хэмжээ авсан уу. Миний 2 дахь асуулт. Хариулж өгөөрэй. Төсвийн тодотгол дээр бүр дэлгэрүүлэхийг хичээнэ.

3 дугаарт Цэнгэл. Манай Хүрэлсүхийн найз. Дарханы сайхан залуу. Төрийн өмчийн компаниуд дээр тэр Тавантолгой цахилгаан станц, Баянгийн цахилгаан станц, Шивээ-Овоогийн цахилгаан станц гээд 7 жагсаалт байна. Энэ асуудлууд дээр орж ирэх ёстой мөнгө орж ирэхгүй байна гэж би үзэж байна. Энэ дээр арга хэмжээ авсан уу. Та нар нягталсан уу. Төмөр зам Хэрлэнгийн төмөр замыг яривал нөгөө хүрээний булай булай булай гэдэг шиг аймшигтай. Төмөр замын энэ их мөнгө орж ирж байгаа мөнгө замдаа саатаж байгаа юу, үгүй юу. Энэ сонин дээр бичигдээд байгаа зүйлүүд худлаа юу, үнэн үү. Нягталсан уу. Эсвэл та нягтлах шаардлагагүй байж болно. Зүгээр тэрийгээ ядаж хэлээч. Танд энийг хариулах ёстой тэр Аудит болон холбогдох хүмүүс нь айгаад ярьдаггүй юм уу.

Яах вэ Монголын төр орлогогүйдээ шаналж байгаа юм биш. Төсөв сүүлийн арваад жил хэдэн 10 дахин нэмэгдсэн. Монголчуудын амьдрал хэдэн 10 дахин нэмэгдэх нь битгий хэл 1 дахин ч нэмэгдээгүй. Харин хулгайч, том том дарга .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Гонгорын Дамдинням хариулт өгье.

Г.Дамдинням: Ганбаатар гишүүний асуултад манай салбарт харьяалагдах хэсэг дээр нь хариулт өгье. Газрын тосны үйлдвэр стратегийн чухал үйлдвэр. Саяхан бид нар хэрвээ санаж байгаа бол онгоцны түлш дээр манай хойд хөршид гэрээ байгуулах асуудал үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал гэж гацаах тухай асуудал яригдаж байсан. Энэ бол манай улс хойд хөршөөсөө бүрэн хэмжээний хараат байдаг ийм л салбар шүү дээ. Энэ салбарыг хараат байдлаас гаргая гэж зорьж байгаа энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн асуудал бол манай улсын амин чухал асуудал. Энийг бид нар явуулах ёстой. Нам хамаагүй, хувь хүний улс төр хамаагүй бид явуулах ёстой. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хувьд энэ салбарын төлөө хамгаална, өмгөөлнө, дуугарна. Энэ үйлдвэрийн бүтээн байгуулалт дууссаны дараа дизель түлшнийхээ 50 хувийг, АИ-95 бензинийхээ 100 хувийг, АИ-92 бензинийхээ 43 хувийг, онгоцны түлшээ 100 хувь, зуухны түлшээ 100 хувь, хийн хангамжийнхаа 50 хувь гэсэн ийм хэрэгцээгээ Монгол Улс дотооддоо хангах гэж байгаа юм. 2028 оны 1 дүгээр улиралд ашиглалтад орно. Тэгэхээр би бол Ганбаатар гишүүнийгээ бас ойлгож байна. Зүгээр энэ дээр хэдүүлээ улс төржилгүй шиг явчихмаар байгаа юм даа. Тэр газрын тос дамжуулах суваг бол энэ үйлдвэрийн жилийн хэрэгцээг дамжуулах хамгийн хэрэгцээтэй бас л суваг байгаад байгаа юм.

Энийг олон улсын байгууллагуудаар хийсэн ТЭЗҮ-ээр бид нар хийсэн. Хийлгэсэн юм байна лээ. Энийгээ авч хэрэглэнэ. Өөр гарц байхгүй. Монгол Улс бас 1 ч гэсэн хараат байдлаасаа арилчихмаар байгаа байхгүй юу даа. Бид Монгол улсынхаа төлөө тангараг өргөчихсөн улс төрчид шүү дээ. Улс төржих юмаараа улс төржье. Бас болохгүй юмаар улс төржмөөргүй байна гэдгийг бас уриалж байна.

2 дугаар асуудал уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэртэй холбоотой асуудал байна лээ. Би тодруулсан. Одоо хяналт шалгалт хариуцсан менежер нь Ардчилсан намаас томилогдсон хүн байгаа. Тэр хүн худалдан авах үйл ажиллагааг бүрэн хариуцаж байгаа. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт худалдан авах ажиллагаа АИ дээр суурилсан Ардчилсан намаас томилогдсон хүнээр удирдуулаад ингээд явж байгаа гэсэн мэдээллийг би түрүүхэн аваад сууж байгаа. Шаардлагатай шалгаж болно. Үзэж болно. Гүтгэж бас болохгүй байх л гэж бодож байна. Эрхэм нөхрөөсөө хүсэхэд тийм байна Ганбаатар гишүүн ээ.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Ойлголоо. Дамдинням гишүүн бол бас Канадад сургууль төгссөн. Яг энэ уул уурхайн асуудлаар бас мэргэшсэн хүн. Ажлаа аваад дөнгөж хэдхэн хонож байгаа хүнээс юу асуух вэ дээ. Яах вэ та нягтлаарай. Газрын тосны үйлдвэрийн тал дээр бол том луйвар болчихсон. 2 жилийн дараа бид ингээд бие биеэ хараад суухын оронд энэ чинь болохгүй болчихсон байна гэдгийг Үндэсний аюулгүй байдал руу би бичиг явуулсан. Нууцад оруулчихсан. Яагаад гэвэл эд нар чинь хулгайгаа нуучихсан. Би ил гаргаж чадахгүй. Би Дамдинням сайд руу ойрын үед явуулна. Энэ яваасай гэж хүсэж байгаа. Даанч хулгай болчихсон гэдгийг л хэлж байгаа. 2 жилийн дараа миний үнэн байна гэдгийг би тэр би хэлээгүй юу гэж л лав би хэлэхгүй. Би тэрний төлөө өнөөдөр яриагүй шүү.

2 дугаарт яах вэ, Эрдэнэт үйлдвэр дээр баяжмалын гэрээний тухай л асуусан. Сайд маань баяжмалын гэрээг Монголчуудад ил тод болговол буян болно гэж би үзэж байна. Үүний ард том хулгай байгаа үе үеийн Ерөнхийлөгч нар энэ дээр хулгайлдаг гэж би ойлгодог. Тэгэхээр энийг Монголын ард түмний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа та бүхэнд. Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Түрүү жилийн төсөв батлахад Монгол Улсын эдийн засгийг 8 хувийн өсөлттэй байна гэж оруулж ирсэн. Дотоодын нийт бүтээгдэхүүн 93 их наяд, 83 сая тонн нүүрсийг 105 ам.доллараар бид нар экспортолно гээд төлөвлөж байсан. Өнөөдөр экспортын үнэ өөрөө нүүрсний үнэ унаад 72 долларт унаад, 30 гаруй хувь уналттай болчихлоо. Дагаад эдийн засаг бас уначихсан байж байна. 5,5 хувь дээр ярьж байгаа. Ерөөсөө энэ бол 1 л уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унангуут дагаад бүх эдийн засаг ингээд хямрах гээд байна. Энэ маш шокийн. Тэгэхээр жил болгон бид нар ийм төсвийн ийм нэмэлт, өөрчлөлт орж ирдэг ийм нөхцөл байдалд орохгүй байхын тулд бид нар энэ бусад үйлдвэрлэлийн тулгуур салбаруудаа жигд хөгжүүлэхгүй бол ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Энэ дээрээ бид нар анхаарах хэрэгтэй. Ер нь энэ намар болтол бид нар энэ гал алдахгүй байхын тулд нэгэнт л энэ нүүрсний үнэ ханш унасан юм биет хэмжээгээ нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ дээр манай бусад яамнууд яаж ажиллаж байна. Жишээлбэл, Зам, тээврийн яам, Гадаад харилцааны тэгээд боомтууд энэ бүх салбарууд бүгдээрээ бүтээгдэхүүнийхээ хэмжээг нэмэгдүүлэх тал

дээр ажиллах ёстой юм байна. Тэгж байж бид нар энэ он гартал бас энэ төсвийг таслахгүй авч явах тал дээр манай яамнууд ямар бодолтой байна.

2 дугаарт нь миний хэлэх 1 санаа бол инфляц. 6 хувьд бид нар төлөвлөчихсөн байсан. Тэгтэл 9,9 хувь гээд бараг 10 хувь хүрлээ шүү дээ. Жил болгон бид нар хэдэн парламент дамнаад ерөөсөө мөнгөний хатуу бодлого л бариад байдаг инфляц буураагүй, буурахгүй. Ерөөсөө инфляцыг өрдөөд байгаа гол эзэн өнөөдөр төр, төрийн өмчийн компаниуд. Энэ төсвийн маш том үрэлгэн зардал. Энэ бол инфляцыг өөрөө өрдөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар төрийн өмчийн энэ 123 аж ахуйн нэгжүүд дээр жилдээ 16 их наяд төгрөг ороод, гардаг энэ их хэмжээний мөнгө чинь эдийн засагт орж гарахдаа ерөөсөө бүх юмны үнэ ханшийг өсгөөд, инфляцыг өртөөд гарчаж байгаа юм. Бид нар өнөөдөр 3,2 их наядыг л бууруулах талаар ингэж том асуудал болж байна шүү дээ. Тэгэхэд тэнд 16 их наяд төгрөг байгаа. Тэгэхээр бид нар ерөөсөө энэ төрийн өмчийн хэдэн компаниудыг томуудаас нь парламентын хяналт руу оруулж ирэхгүй бид нар байнгын энэ инфляцын асуудалд өртөөд, эргээд ард түмэн л энд хохирдог. Аж ахуйн нэгжүүдэд зээл олддоггүй. Яагаад гэхлээр Монголбанк мөнгөнийхөө хатуу бодлогыг бариад байдаг. Одоо бол Монголбанк энийг бол үнэхээр хазаарлаж дийлэхээ больсон байхгүй юу. Тэгэхээр бид нар төрийн өмчийн байгууллагуудаа хяналтдаа оруулах энэ бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Нөгөө талаараа он гартал бид нар энэ нүүрснийхээ хэмжээг нэмэгдүүлэх тал дээр яаж ажиллах юм бэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. 4 дүгээр индэр.

И.Батхүү: Асуултад хариулъя. Оны эхнээс Сангийн сайдаар ахлуулсан экспортыг нэмэгдүүлэх гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэгт бол холбогдох бүх төрийн байгууллагууд, хил гаальтай холбоотой, Зам тээврийн яам, харьяа байгууллагууд зэрэг тээвэрлэлттэй холбоотой бүх байгууллагуудын төлөөлөл оролцоод нөхцөл байдал өдөр тутмаар биет экспортын хэмжээг хянаад, холбогдох арга хэмжээнүүдийг авч Засгийн газрын тогтоол, захирамж, шийдвэрүүд гаргаад ажиллаж байгаа. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдал сайжраагүй учраас энэ экспортын ажлын хэсгийг бас тодорхой хэмжээнд үргэлжлүүлээд ажиллуулах байх гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх үү. Төрийн өмчийн компаниудтай холбоотой асуудал дээр тодорхой хариулт.Пунсалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Пунсалмаа: Би энэ нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх тал дээр яамнуудын яг өнөөдөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд юу байгаа вэ гэдэг талаар бас тодорхой хариултыг авч чадаагүй байна. Тэгэхээр бид нар бас магадгүй энэ гэрээ хэлэлцээрийг нэмэгдүүлэх, зам тэр боомтуудын бололцоог нэмэгдүүлэх гээд олон талд л түвшинд ажиллах ёстой байх. Энэ талаар бас мэдээлэл хараахан авахгүй байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Пунсалмаа гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Нүүрс дээр бол экспортын биет хэмжээ бол яг ноднингийнхоо түвшинд байгаа. Гол нь үнэ л уначхаад байгаа юм. Ноднин 5 сарын 31 гэхэд 35 сая тонн гаргаж байсан. Сая 5 сарын мэдээгээр 34,5 сая тонн бараг ижилхэн явж байгаа. Харин энэ бүтцийг нь

харах юм бол нэлээн өөр болсон байгаа. Ноднин жишээ нь өдийд биржээр бид 12 сая тонн нүүрс зарчихсан байсан. Одоо дөнгөж 2,5. Бараг 6 дахин багасчихсан байгаа. Энэ зөрүүг нөгөө том гэрээнүүд маань л нөхөж байгаа. Энийг ашгүй өнгөрсөн намар бид Улсын Их Хурлаар оруулж танилцуулж, та бүхэн маань дэмжиж баталсан. Яг энэ дээр л манай улсын эдийн засаг явж байна даа. Ашгүй энэ 7 хоногоос нөгөө Чайна Энержигийн нүүрс гарч эхэлж байгаа. Энэ 5 сая тонноор бид нар жилийн эцэс рүү биет хэмжээ төлөвлөснөөс давж гарах ёстой. Тийм учраас энэ үнийн уналтыг биет хэмжээгээр л нөхөх, тэгэхдээ л .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Жигжидийн Батжаргал гишүүн. 2 дугаар индэр.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсөөлөл, мөн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсөөлөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн баригдаж орж ирсэн. Үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Бид сүүлийн он жилүүдэд улс орныхоо эдийн засгийг нэг салбар дээр бараг тухайлсан нэг эрдэс дээр хэт их дулдуйдаж явсан нь энэ дэлхийн улс орнууд өөрийнхөө улс төрийн нөлөөлөл, эдийн засгийн чадамжаа хадгалах зорилготой, дотоодынхоо зах зээлийг хамгаалах, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, улмаар өөрийнхөө бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлийн хэрэглээг нэлээдгүй хэсгийг нь хангах гэсэн энэ их том өрсөлдөөний гол шалтгаан болж гарч ирж байгаа тарифын хязгаарлалтын асуудал Монгол Улсад сүүдрээ өгч, гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд, эрдсийн үнэ дэлхийн зах зээл дээр эрс буурч байна. Үүнээс улбаатайгаар төлөвлөгдсөн орлогууд таашгүйгээр, таамаглашгүйгээр буурч байна л даа. Тийм учраас бид энэ нөхцөл байдалд урьдчилан юмнуудаа бас нэг багцаатай харж, хязгаарлалт, зохицуулалтуудаа зөв хийж байж эрсдэлийг аль болохоор бага хохирол хүндрэлтэй даван туулах ёстой. Энэ бол улс үндэстний эрх ашиг. Тийм учраас би энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллүүдийг өнөөгийн тооцогдож байгаа, урьдчилан таамаглаж байгаа энэ нөхцөл байдалтай нь уялдуулж өөрчилж авч, тэрийгээ дагуулж өөрсдийнхөө бодит нөөц боломж дээр тулгуурлаж зохицуулалтын арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Ингэж байж энэ улс үндэстний эрх ашиг хангагдах ёстой гэж үзэж би дэмжиж байгаа гэдгийг зориуд хэлмээр байна.

2 дугаарт дэлхийн зах зээл дээрх энэ үнийн бууралт нөлөөллүүд бидний эдийн засгийн өсөлтөд ч их тодорхой нөлөө үзүүлж байгаа. Эргээд бас эдийн засгийн агшилтаа дагуулаад төсөв юмаа хэт базах юм бол эдийн засаг улам агшилт нь нэмэгдэж, энийгээ дагаад үндсэндээ энэ инфляц гэдэг юм чинь бас нөгөө талаасаа өндөрсөх боломж нь бий болно. Тийм учраас төсөв дээрээ бас хязгаарлалтаа хийж, тодорхой орон зайг нь гаргаж, бодит эдийн засаг гэдэг юм уу эдийн засгийн салбараа тэтгэх, тийшээгээ чиглэгдэх хөрөнгийнхөө эргэлтийг нэмэх замаар л үүнийг би шийднэ гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас энэ талаасаа авч үзсэн ч хэдүүлээ энэ төсвийн хүрээний мэдэгдэл төсөөллөө баталж авч, тэгээд төсөвтөө тодотгол хийж, ажлаа зөв зохицуулж явах нь зөв. Тэгэхдээ бодит байдлаа их зөв харах ёстой. Өнөө нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно гэдэг байж таарахгүй. Төсвийн тодотгол тэрийг дагасан хуулиуд дээр

бол ярих бас нэг тодорхой бодлогын гэдэг юм уу, ойлголтын нэгтгэлүүд хийж байж явахаар зүйлүүд олон байна лээ.

Ингээд би гишүүдийгээ төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллүүдийнхээ хуулийн төслийг дэмжиж саналаа өгцгөөхийг уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Үдээс хойших хуралдаан 14 цагаас хуулиараа Ерөнхий сайдын мэдээллийн цагаар эхэлнэ.

Өнөөдөр бид төсвийн тодотгол, төсвийн хүрээг эцэслэн хэлэлцэж дуусгах зэрэг олон асуудал байгаа. Гишүүд бүрэн ирцтэй оролцоно шүү. Нэлээн сунаж хуралдана гэсэн үг. 14 цагаас үдээс хойших хуралдаан эхэлнэ.

12.35 цаг.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийнэ.

Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, худалдаа үйлчилгээний салбар манай улсын хөгжлийн бүхий л үе шатад нийгэм, эдийн засагт голлох байр суурь эзэлж ирсэн. Тухайлбал, 2024 оны байдлаар тус салбар ДНБ-ий 31.7 хувь, экспортын орлогын 5 хувийг бүрдүүлж байгаа бол нийт ажиллах хүчний 45.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, орон нутгийн эдийн засгийн 85 хувийг эзэлж байна.

Зөвхөн мал аж ахуйн салбарт гэхэд 308.700 малчин ажиллаж, хөдөлмөрлөж байгаа нь хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь болж байна. Тийм учраас салбарын ач холбогдол, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг харгалзан Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар үндэсний эдийн засгаа хамгаалж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, хүн амаа аюулгүй баталгаат хүнсээр хангадаг экспортлогч орон болох бодлого, зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Үүний хүрээнд хамтран ажиллагч түнш орнуудтай худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэн гадаад худалдааг тэлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл,

худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийг хурдасгахад чиглэсэн олон арга хэмжээг сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж ирсэн.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч Хүнсний хувьсгал, Цагаан алт Үндэсний хөдөлгөөнийг Засгийн газар, Шинэ хоршоо хөдөлгөөнийг, Атар 4 газар тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг санаачлан амжилттай хэрэгжүүлж байгаа нь иргэд, аж ахуйн нэгжийн ажил, амьдрал улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан томоохон үр дүнтэй ажил болсныг онцлон тэмдэглэе.

Эрхэм гишүүд ээ, та бүхэнд мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн үйлдвэрийн салбарын үр дүнг илтгэх тоон мэдээллийг товч танилцуулъя.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар:

Мал тооллогын 2024 оны жилийн эцсийн дүнгээр Монгол Улсын хэмжээнд 57.6 сая тонн мал тоологдсон. 2025 оны 6 дугаар сарын 19-ний байдлаар 19 сая төл мал хүлээн авч, төл бойжилт 98.6 хувьтай байна. Бод малын төллөлт бол үргэлжилж байна. Урьдчилсан төлөвөөр энэ онд 20 орчим сая төл хүлээн авч, мал сүргийн тоо 77.6 сая, хонин толгойд шилжүүлснээр 110 сая толгойд хүрч, мал аж ахуйн салбарт өсөлт гарахаар байгаа хэдий ч бэлчээрийн даацаас 25 сая хонин толгойгоор хэтрэх төлөвтэй байна. Иймд орон нутагт хийсэн судалгааны дүнг үндэслэн хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах асуудлыг оновчтой зохион байгуулах, мал, махны бэлтгэлийг идэвхжүүлэх, гадаад зах зээлийн орчныг өргөтгөх, дотоодын бэлтгэлийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Мал эмнэлгийн хаврын үйлчилгээ арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 60 сая толгой мал хамруулахаас 58.4 сая толгой мал хамруулж, гүйцэтгэл 97 хувьтай байна. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 46.2 сая толгой мал, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад 4.2 сая толгой малыг хамруулж, гоц халдварт өвчний голомтын тоог 49 хувиар, халдвар гаралтыг өмнөх оны мөн үеийнхээс 98 хувиар бууруулсан зүйлтэй байна.

Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын 92 дахь удаагийн Ерөнхий чуулганы үеэр Монгол Улсын шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталгаажуулсан бол Дэлхийн банкны санхүүжилтээр шугаман эсийн технологи нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэн вакцины дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой боллоо.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар:

Энэ оны хаврын тариалалтыг нийт 650.1 мянган га-д хийхээр төлөвлөснөөс 6 дугаар сарын 19-ний байдлаар улсын хэмжээнд 479.5 мянган га-д тариалалт тариалалт хийж, 74 хувийн гүйцэтгэлтэй байна. Урьдчилсан байдлаар 300.1 мянган га-д үр тариа, үүнээс 264.8 мянган га-д улаан буудай, 12.1 мянган га-д төмс, 9.2 мянган га-д хүнсний ногоо, 32.2 мянган га-д малын тэжээл, 126.3 мянган га-д тосны ургамал, нийтдээ 479.5 мянган га-д тариалалт хийгдэж байна. Үр тариа, төмсний тариалалт дууссан. Малын тэжээл хүнсний ногооны тариалалт хийгдэж байна. 2024 оны намрын ургацаас 40.5 мянган тонн хүнсний улаан буудайг хүлээн авч, нийт 70.7 мянган тонн стратегийн нөөцийн хүнсний улаан буудай, 9 сортын 5.5 мянган тонн үрийн буудайн нөөцийг тус тус бүрдүүллээ.

Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Атар 4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор улсын төсвийн 9.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 361.2 мянган ширхэг бетон шонг нийлүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 80 мянган га-д тариалангийн талбайг хашаажуулах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Мөн хөргөлттэй агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 13.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 200-500 тонн багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорины барилга, 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 10 га талбайд жимс, жимсгэнийн суулгац, үржүүлгийн газрыг тус тус байгуулж байна.

Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж, үр бордоог дамжуулан борлуулах үйлчилгээг нэвтрүүлэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлснээр дотоодын бизнес эрхлэгчид болон дилер компаниудын үйл ажиллагаа эрчимжиж, энэ оны эхний хагас жилийн байдлаар 5.6 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж, 9.7 тэрбум төгрөгийн бордоо, 1.3 тэрбум төгрөгийн ургамал хамгааллын бодисыг тариаланчид, фермерүүдэд нийлүүллээ.

Таримлын сэлгээ болон малын өндөр уураг тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 1600 тонн 9 төрлийн тэжээлийн таримлын үрийн нөөцийг бүрдүүлж, дамжуулан зээлдүүлэх үйлчилгээгээр олгож байна.

Хүнсний үйлдвэрлэлийн талаар:

Хүнсний боловсруулах үйлдвэрийн салбарын борлуулалтын орлого 2024 онд 10.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 7.25 хувиар өссөн бөгөөд ДНБ-ий 2.8 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд 17 аймгийн 25 сумд хоногт 904 тонн сүү боловсруулах хүчин чадал бүхий 88 үйлдвэр, цех болон сүү хүлээн авах 82 хүргэлтийн төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд суурилагдсан хүчин чадлын 50 гаруй хувийг ашиглаж, 150.3 сая л литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулсан байна.

Мөн түүнчлэн 940 мянган тонн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 58 гурилын үйлдвэр, цех байгаагаас 9 нь тогтмол үйл ажиллагаа явуулж, нийт хүчин чадлын 30 хувийг ашиглаж байна. 2024 онд 148.4 мянган тонн гурил үйлдвэрлэж, гурилын хэрэгцээнийхээ 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангасан тоон үзүүлэлт гарлаа. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого 600 сая долларт хүрснийг та бүхэнд дуулгахад таатай байна. Цаашид мах, махан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, зах зээлийг тэлэхэд онцгой анхаарч, эдийн засаг, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч чиглүүлж ажиллах болно.

Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд өнгөрсөн хугацаанд сүү боловсруулах 8, мал төхөөрөх, мах боловсруулах 10, гурилан бүтээгдэхүүний 12, бусад нэр төрлийн 9, нийт 39 үйлдвэр шинээр байгуулагдсан. Мөн зоорины багтаамж 15 хувь, үтрэмийн багтаамж 7 хувь, тариалангийн талбай 13 хувь, зуны болон өвлийн хүлэмж 28 хувиар тус тус нэмэгдэж, зарим нэр төрлийн хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах түвшинд хүрээд байна.

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 32, ажлын байр 21, дундаж борлуулалтын орлого 31, дундаж цэвэр ашиг 32, үндсэн хөрөнгө 55, эргэлтийн хөрөнгө 38, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 46, нийгмийн даатгал 60 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нийт 8.4 мянган тонн махыг нөөцөлсөн бөгөөд 2025 оны 5 дугаар сарын 22-ны байдлаар 2.9 мянган тонн махыг борлуулж, 5.4 мянган тонн махны үлдэгдэл нөөцтэй байна.

Сүү боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 14 аймгийн 31 үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн 18.9 сая литр сүү нийлүүлсэн 9.9 мянган малчин, фермерт 18.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон байна.

Хөнгөн үйлдвэрийн талаар:

Бид хөнгөн хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэр, технологийн паркуудыг бүсчлэн байгуулахаар төлөвлөж ажиллаж байна. Тухайлбал, төвийн бүсийн Дархан-Уул аймагт Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн технологийн парк, Баруун бүсийн Ховд аймагт Шинэ Ховд аж үйлдвэрийн парк, Нийслэлд Эмээлт Эко аж үйлдвэрийн парк, Говийн бүсийн Говьсүмбэр аймагт Мал аж ахуйн шинжлэх ухаан технологийн үйлдвэрлэлийн эко парк, Зүүн бүсийн Дорнод аймагт Зүүн бүсийн үйлдвэр технологийн парк байгуулах ажлыг эрчимжүүлж байна. Манай улс мал аж ахуйн салбараас жилд дунджаар 30 мянган тонн хонины ноос, 8 мянган тонн ямааны ноолуур, 1.8 мянган тонн тэмээний ноос, 0.4 мянган тонн сарлагийн хөөвөр, нийт 40.2 мянган тонн ноос, ноолуур бэлтгэх нөөцтэй юм.

2025 оны ноолуур бэлтгэлийн хүрээнд 4.6 мянган тонн түүхий ноолуур буюу нийт ноолуурын нөөцийн 50 гаруй хувийг үндэсний үйлдвэрт бэлтгэн нийлүүллээ. Ноолуур бэлтгэхэд зориулан 61 үйлдвэрт 312.9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгосон бөгөөд Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын үйлчлэх хугацааг 2025 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн нь үр дүнгээ өгсөн гэж үзэж байна. Дэлхийн эдийн засгийн худалдааны тариф, тарифын нөхцөл байдал, зах зээл дэх ноолуурын үнийн бодит байдлыг харгалзан малчдын орлогыг бууруулахгүй байх, ноолуур бэлтгэлийн хугацаанд үндэсний үйлдвэрлэлд хэрэгцээтэй санхүүжилтийг шийдвэрлэх, зээл олголтыг цаг алдалгүй зохион байгуулах зорилгоор арилжааны 2 банкаар 14 тэрбум төгрөгийн векселийн гэрээ байгууллаа. Цаашид нэмүү өртөг шингээн боловсруулсан 2.5 мянган тонн самнасан ноолуурыг экспортолж, 1.5 мянган тонн ноолуурыг дотоодын зах зээлд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглахаар төлөвлөж байна.

2023-2024 онд үндэсний үйлдвэрт нийт 11.9 мянган тонн хонь, тэмээний ноос бэлтгэж тушаасан 45.4 мянган малчин, мал бүхий этгээдэд нийт 13.5 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг, 349.2 мянган ширхэг арьс шир үйлдвэрт нийлүүлсэн, 8.1 мянган малчинд 2.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон байна. Мал аж ахуй Үйлдвэрлэл эрхлэгчдийг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, гэнэтийн гамшиг, ослын үеийн эрсдэлийг бууруулах, малчдын өрхийн амьжиргааг дэмжих орлогыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал, тогтвортой нийлүүлэлтийг бий болгох, хоршоологч, үйлдвэрлэгчдийн

түншлэлийг дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр Засгийн газраас “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн 9.6 мянган хоршоо шинээр байгуулагдаж, 95.1 мянган малчин хоршооны гишүүнээр элссэн нь нийт малчдын 30.8 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд 6.8 мянган хоршооны 23.6 мянган малчинд 798.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг олгож, 300 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргасан байна.

Мөн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 2024-2025 онд 57.4 тэрбум төгрөгийг эргэн төлүүлсэн бөгөөд нийт 395 төсөлд 55.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 1083 ажлын байрыг шинээр бий болгосон.

Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн салбарт цаашид анхаарах асуудлын талаар товч танилцуулъя.

1 дүгээрт Хөдөө аж ахуйн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлж, зардлыг бууруулах;

2 дугаарт уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэж, ногоон хөгжлийг дэмжсэн дэвшилтэт технологи, инновацад суурилсан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

3-д бүсчилсэн хөгжлийг дэмжсэн мал аж ахуй, газар тариалангийн кластер, цогцолборуудыг байгуулж, тээвэр, логистикийн оновчтой сүлжээг бий болгох;

4.Малчдын хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих дундын хоршоог бүсчлэн зохион байгуулах, тэдэнд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

5 дугаарт салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, мал зүйч, малын эмч, агрономич, бэлчээр, тэжээлийн мэргэжилтэн, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн судлаач, мэргэжилтнүүдийг бодлогоор бэлтгэж, орон нутагт ажиллах боломжоор хангах хүний нөөцийн нийгмийн баталгааг салбарын хууль тогтоомжид нийцүүлэх зэрэг асуудлууд байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа бүхэлдээ хүнсний хангамж, аюулгүй байдлыг бүрдүүлэх, чанар стандартын шаардлагыг хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангахад чиглэх учиртай. Үүний зэрэгцээ ард түмний уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн мал аж ахуй, нүүдлийн соёл, иргэншил, түүнийг дагасан биет болон биет бус соёлын өв, мал маллагааны уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, генетик нөөцийг тогтвортой ашиглах, хадгалж хамгаалах асуудалд ч онцгой анхаарах нь зүйтэй байна.

Мөн түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, тэр дундаа цөлжилт, хөрсний доройтол, ган зудын давтамж зэрэг нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, бүтээмж, улсын нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж байгаа тул Засгийн газраас үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэн хөгжлийн бодлогоо оновчтой

тодорхойлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллах болно.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд бодлогын бодитой, тодорхой дэмжлэг үзүүлж, идэвхтэй хамтран ажиллаж ирсэн Улсын Их Хурлын гишүүддээ энэ ташрамд талархал илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад баярлалаа. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 2024 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 31 хувь, экспортын орлогын 5 хувийг бүрдүүлж, нийт ажиллах хүчний 45 хувь нь тус салбарт ажиллаж, орон нутгийн эдийн засагт 85 орчим хувийг эзэлж байгаа томоохон салбар хэдий ч хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа мал аж ахуйн салбарт ажиллаж буй ажиллах хүчний 50 орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур буюу ядуурлын түвшинд хамрагдаж, үлдсэн хэсэг нь ядуурлын түвшний дээхнүүр орлоготой аж төрж байгааг Үндэсний статистикийн хорооны ядуурлын түвшинд танилцуулсныг эхэнд нь эш татъя.

Манай улсын хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь буюу 308 орчим мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа томоохон салбар. Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах гол салбарын хувьд хөгжлийн буруу бодлого, уялдаагүй төлөвлөлт, онцгүй санхүүжилтийн уршгаар энэ салбарын эдийн засгийн үзүүлэлт 2024 онд 28 орчим хувиар унажээ. Гэвч харьяа салбарын яам нь малын тоо, хүлээн авсан төл, тариалсан болоод хурааж авсан ургацын тоон хэмжээний статистик тайлан төрийн гэх нэрээр үргүйдүүлж, үнэ цэн алдуулж буй сонгуулийн далд тогтолцоо өсөх зориулалттай үндэсний тодотголтой гоё нэртэй хөтөлбөр, аян арга хэмжээний өртөг, өртөг өндөртэй зохион байгуулалтаас хэтрэхгүй ажиллаж буй нь ард иргэдээ ядуурлын хонхроос гарч чадахгүй, хий эргэхэд хүргэж байна.

Ерөнхий сайдын мэдээлэлд салбарын яамны бодлого нь өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд мал махны бэлтгэлийг идэвхжүүлэхээр харж, тусгасан байгаа нь мал аж ахуйн салбарын бодлого үндсээрээ буруу байна гэж дүгнэхэд хүргэж байна. Эрх баригчид 1960-1980-аад оны үеийн социалист нийгмийн үеийн нэгдлийн үед үүсгэсэн мал бэлтгэлийн тогтолцоог одоо ч ашиглаж, нийслэлийнхэнд хэн гэх мах нийлүүлж оноо алдахгүй. Гэхдээ малчин иргэдийнхээ хөгжих боломжийг хаасан улс төрчдийн популист амлалтын золиосоор энэ салбарт өрсөлдөөнийг хааж, бүтээгдэхүүн салбарын хөгжлийг боомилж, улмаар бодитоор хөгжиж, экспорт хийж, олон 100 мянган малчдын орлого нэмэгдэж, дагаад боловсруулах үйлдвэрлэл хөгжих харьцангуй давуу талыг царцаасан байдалтай байна. Энэхүү мэдээлэлд хүнсний салбарын борлуулалтын орлого 2024 онд 10 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 7.25 хувиар өссөн байна гэсэн нь 2024 оны жилийн дундаж инфляц болох 6.8 хувийн нөлөөллийг хасаж тооцоход 1 хүрэхгүй хувийн өсөлтийн тухай яриа байна.

Манай Улсын хөдөө аж ахуйн салбарт төрийн бодлого уналтад орсон. Ерөнхий сайдын энэхүү мэдээллийн тоо баримтуудаас харахад бүхэл бүтэн улсын хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа жирийн компанийн тайлан тооцоо, борлуулалтын дүнгийн хэмжээнд очтолоо дорджээ. Төрийн бодлого тогт тогтворгүй, онцгүй явагдаж олон 10 жилийн турш төсвийн хөрөнгө зарцуулан байж урд босгосноо гаалийн татвар тэглэх хуулиар ганцхан жилийн дотор унагаж буй гашуун алдаа ч одоо бидэнд бас явагдсан.

Тэгээд энэ хүрээнд Ардчилсан намын бүлгийн зүгээс бас дараах санал зөвлөмжийг гаргаж байна.

1 дүгээрт нь хөдөө аж ахуйн салбарт суурилсан бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцооны шинэ, бодитой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, санхүүжилтийн оновчтой тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

2.Гадаадын зээл тусламжийн зарцуулалтад хяналт тавих, шинээр авах, зээлийн төлөвлөлт, зориулалтыг зөв төлөвлөх, улмаар салбар хоорондын уялдаа болон гадаадын зээлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хоорондын уялдааг хангах замаар үр өгөөж бүтээмжид илүү чиглэх шаардлагатай болсон.

3 дугаарт нь газар тариалан, мал аж ахуйд усалгаатай тариалалтыг нэвтрүүлж, нэгж талбайгаас илүү их ургацыг тогтвортой авах боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4 дүгээрт нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт төр оролцохоос зайлсхийж, төрийн зохицуулалтыг бодлогын суурь асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлж, салбар хоорондын уялдааг бид нар хангах шаардлагатай.

5 дугаарт нь татаас, хүүгийн дэмжлэгийг зогсоож, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг зах зээлийн жамаар цэвэр өрсөлдөөнөөр нь хөгжүүлэх эрх зүйн орчин талд бид нар бодитой алхмуудыг бас хийх шаардлагатай.

6.Төрөөс малын тоо толгойг өөгшүүлэх бус мал сүргийн чанарыг сайжруулах хөрөнгө оруулах таатай орчин бүрдүүлдэг, тариалангийн талбайд хашаа барьж өгдөг бус нэгж га талбайгаас илүү их ургац авахын төлөө ажилладаг бизнесийн орчныг бий болгох, мах нөөцөлдөг бус экспортолдог тогтолцоог хөгжүүлдэг төр байх нь бодлогын үндэс суурь гэж бид үзэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурал дахь ХҮН намын төлөөлөл Гончигдоржийн Уянгахишиг гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажилтай холбогдуулан Ерөнхий сайдаас Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн мэдээлэлтэй танилцлаа. Гол тоон мэдээллүүдийг өгөхийг зорьсон байгаа ч эдгээр тоон мэдээллийн цаана байгаа бодлогын мэдээллүүд хангалтгүй байн гэж үзлээ. Өмнөх Ерөнхий сайдын мэдээллүүдтэй холбоотойгоор ч мөн хэлж байсан санал маань мөн адил дэлгэрэнгүй мэдээлэл хүсэж байсан билээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр бодлогын шинжтэй нэлээд ажлууд хийгдэж байгаа гэсэн ойлголттой байгаа бөгөөд тоон мэдээллүүдээс харахад ч мөн ахицтай үзүүлэлтүүд олон байна. Цаашид Улсын Их Хурлын мэдээллийн цагаа ашиглан эдгээр тоон үзүүлэлтийн цаана байгаа асуудлын талаар анализ, дүгнэлттэй мэдээллээр хангах нь бодлого тодорхойлогчийн хувьд Улсын Их Хурлын зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх таатай эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлнэ гэж харж байна.

Түүнчлэн өмнө нь дурдаж байсанчлан Ерөнхий сайд болон салбарын сайдаас асуулт асууж, хариулт авсны дараа үг хэлэх боломжийг олгодог бол илүү үр дүнтэй байх болов уу гэсэн саналтай байна.

Ингээд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор дараах саналыг хэлье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хүний нөөцийн бодлогод анхаарах зайлшгүй шаардлагатай байна. Жишээ нь, Ерөнхий сайдын мэдээлэлд дурдсанчлан Монгол Улсын хөдөлмөр эрхэлдэг 4 хүн тутмын 1 нь буюу 308.700 малчид байна. Гэтэл малчдын амь амьжиргаа, амьдралын чанар хангалттай сайн биш. Залгамж халаа муудахад хүрч байгааг бид бүгд ярьдаг, мэддэг. Тиймдээ ч шинэ залуу малчдыг мэдлэгжүүлэх илүү бизнес суурьтай буюу малын ашиг шимийг бүрэн хүртэх боломжтой болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжихийн тулд бодлогын арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

ХҮН намын мөрийн хөтөлбөрт бид мал аж ахуйн салбарт Монгол өрх үндэсний хөгжлийн загвар аж ахуй хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан ба энэ хүрээнд талуудын оролцоог ханган хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгч, зах зээлтэй тэднийг холбох кластерын платформыг хөгжүүлэх, мөн нийлүүлэлт, үйлдвэрлэл, логистик болон маркетингийн нэгдсэн систем бүхий платформыг үүсгэн байгуулах шаардлагатай гэж үзсэн. Түүнчлэн малчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын болон гадаадын зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг хангасан зах зээлийн зарчимд нийцсэн тогтолцоог бүрдүүлэх, бэлчээрийн даацтай уялдуулсан уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх шаардлагатай байгаа билээ. Энэ утгаараа салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах арга хэмжээ авах нь нэн хэрэгцээтэй байна гэж харж байна.

Боловсролын сайдын 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/77 дугаар тушаалаар малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих арга хэмжээг баталсан. Тус арга хэмжээг 2024-2028 он хүртэл аймгуудад үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн билээ. 2025 онд зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад хэрэгжүүлэхээр 150 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэжээ. Энэхүү санхүүжилтээр зүүн бүсийн малчин өрхийн гишүүнийг аймгийн Политехник коллежтой хамтран мал аж ахуйн чадамжийн гэрчилгээ олгох сургалт, ХААИС-тай хамтран энтрепренёрт суурилсан хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт, малчин залуу манлайлагч сургалтыг тус тус зохион байгуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр малчин өрхийн 2407 иргэн суралцсан байна. Энэ мэтчилэн салбар хоорондын үр бүтээлтэй хамтын ажиллагаа, бодлогын дэмжлэгүүд цаашид өргөжих байх гэдэгт итгэж байна.

Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр, логистик, хөдөө аж ахуйн аж үйлдвэр зэрэг салбарын уялдаа холбоог сайжруулан орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, судалгаа санхүүжилтээр дэмжих бодлого баримтлах, компаниудын бүтээмж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлэлтийн сүлжээний дэд бүтэц, мэдлэг, мэдээлэл, хөрөнгө оруулалт зэрэг тасалдалтай хэсгүүдэд эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байгааг мөн анхааралдаа авна уу.

3 дугаарт хөдөө аж ахуйд суурилсан нэмүү өртөг шингэсэн экспортын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шат руу шилжих гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бизнесийн орчныг бүрдүүлэхэд анхаарч шударга өрсөлдөөнд суурилсан компани төвтэй кластерууд хөгжих боломжийг бүрдүүлж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээ, банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн тухайлбал, мах, жимс, жимсгэнэ, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүний онцгой чанарын судалгаанд үндэслэн үндэстний үнэ цэнийн байршил бүхий эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчин, бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгохыг мөн хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл, гишүүд кнопоо даръя. Засагт байдаг намын төлөөлөл дарахгүй. 6 гишүүнээр тасаллаа. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Очирбат: Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцлаа. Тэгээд Ардчилсан намын бүлэг бас дүгнэлтээ танд уншиж танилцууллаа. Тодорхой 3 асуулт асууя.

Шинэ хоршоо хөдөлгөөн гаргасан. Үүний үр дүн ямар байгаа вэ. Салбарын уялдаа холбоог хангах Үндэсний хороо бас ажиллаж байгаа. Энэ хороо шинэ бүтцээр татан буугдсан уу, буугдаагүй юу. 500 орчим тэрбум төгрөг гарсан. Яг айл, иргэдийн орлого нь хэдий хэмжээгээр яаж нэмэгдсэн бэ гэдэг эхний асуулт асууя.

2 дахь нь болохоор өнгөрсөн хавар ноолуурын бэлтгэл ажил дотоодын худалдан авалтыг зохион байгуулах ажлын явц бас нэлээн хүндрэлтэйгээр байсан. Одоо нөхцөл байдал ямар байгаа вэ. Монголбанкнаас вексель гаргасан. Үр дүн нь хэр байгаа вэ гэж асууя.

3 дугаарт нь энэ хөнгөн үйлдвэрийн салбартай холбоотой үйлдвэрлэл технологийн паркийг олон жил хүмүүс ярьж ирсэн. Олигтой, бодитой үр дүн байдаггүй. Таны танилцуулгад дурдсанаар бас 5-6 газарт бүсчилсэн байдлаар дөнгөж байгуулах, эхлэх талаар дурдсан байна. Энэ үйлдвэрлэл технологийн паркийн талаар та ер нь ямар бодолтой байдаг юм. Бид нар бас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр энэ талаар ажлын хэсэг гаргаад, манай Уянга гишүүн ахлаад санал, дүгнэлт боловсруулчихсан байгаа. Тэгээд танихтай хэр зөрөх нь вэ сонсчихъё. Тэгээд тодруулъя. Тодруулахгүй. Ээнэ чинь асуулт нь саналтайгаа хамт явж байгаа.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдаа хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Азжаргал хариулъя. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Очирбат гишүүний асуултад хариулъя. Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүн гээд. Шинэ хоршоо хөдөлгөөн өрнөж эхлээд 1 жил болж байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн хугацаанд нийтдээ Монгол Улсын Засгийн газраас 21 аймаг, 330 сумд байгаа 193 мянган малчин өрх, 300 мянган малчиндаа 2 удаа хүрэх ажлыг зохион байгуулсан. Малчин өрх болгонд хүрч ажилласан. 193 мянган малчны хотонд хүрч ажиллана гэдэг бол бас нэлээн их мөнгө санхүү, хүний нөөц, маш олон нөөц шаарддаг ийм ажил юм байна лээ. Ингээд ажилласан. Ингээд хөдөлгөөн маань эхний 1 жил бол мэдээлэл хүргэх ажил бол маш чухал байсан. Малчдын сегмент бол зүгээр нэг реклам явуулаад ингээд болчихдог биш юм байна лээ. Ерөөсөө яг нүүр тулж уулзаад, ойлгуулаад ингээд маш их ажиллах шаардлагатай ийм сегмент бүлэг хүмүүс байдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд нийтдээ сая Ерөнхий сайдын мэдээлэлд гарсан 798 орчим тэрбум төгрөгийн зээл гарсан. Энэ бол 6 хувийн зээл. Та бүхэн маань мэдэж байгаа. Зээл маань эргээд төлөгдөөд эхэлж байгаа. Бас их олон мэдээлэл явдаг. Эргэж төлөх юм уу, яадаг юм гээд их олон мэдээллүүд явж байдаг. Манай малчид бол маш хариуцлагатай, санхүүгийн сахилга баттай хүмүүс байдаг. Өнөөдрийн байдлаар 20 орчим тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдчихсэн байгаа. Нөгөө 800-аас. Ямар нэгэн хоцрогдолтой, төлөхгүй байгаа ийм хүн бол байхгүй. Одоо бол Монгол Улсад нууц юм гэж байхгүй болсныг та бүхэн мэдэж байгаа. Монголбанктай бид нар 7 хоног болгон мэдээллээ солилцдог. Бүх хүн графикийн дагуу, хуваарийн дагуу зээлээ төлөөд явж байгаа. Эхний хамгийн чухал үр дүн.

2-т нь би танд нэг тоо хэлэх гэсэн юм. Нийтдээ Татварын ерөнхий газраас авсан бид нарын сүүлийн тоогоор 2024 оны эцэст 8 мянган хоршоо татварын тайлангаа ирүүлсэн байгаа. Ингээд 402 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан байна гэдэг тоо гарсан. 570 сая төгрөгийн татвар төлөх ийм тайланг ирүүлсэн байгаад байгаа юм. Энэ бол өмнөх жилүүдийн дунджаас хэд дахин өссөн гэдэг ийм дүгнэлтийг бид нар гаргаж байгаа.

Ингээд ажлын байраар нь бид нар бас аваад үзсэн. Ингээд яг хоршооныхоо үйл ажиллагааг эрхлээд, эдийн засгийн харилцаанд ороод ингээд явж байгаа хоршоод маань нийтдээ шинээр 1109 ажлын байр бий болгосон байгаад байгаа юм. Энэ бас өмнөх онуудынхаа бас их өсөлттэй тоо гарсан. Тэгээд маш олон гишүүд маань үр дүнг асуудаг. Энэ маань өөрөө 5 жилийн хөтөлбөр. Одоо дөнгөж 1 жил болж байгаа. Хүнээр бол дөнгөж мөлхөж эхэлж байгаа. Цаашаа бол хөлд ороод, алхдаг болоод, гүйдэг болоод ингэхэд бол бас их чухал ажлууд хийгдэх шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд 2 дахь асуулт буюу ноолуурын бэлтгэл хангахтай холбоотой асуудлаар мэдээлэл өгье. Хариулт өгье.

Ж.Энхбаяр: Их Хурлын 63 дугаар тогтоол гарч “Цагаан алт” үндэсний хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрийн гол зорилго бол ноос ноолуур, арьс ширнийхээ бэлтгэл, үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх ийм зорилготой буюу үндэсний хөнгөн үйлдвэрийн салбараа шинэ шатанд гаргах ийм хөдөлгөөн өрнөж байна. Энэ дотроос ноолуур онцгой чухал байр суурь эзэлж байгаа. Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлийн үндсэндээ 50 хувийг дангаараа бэлтгэн нийлүүлж

байгаа орны онцлог ийм барааны хувьд бидэнд их өрсөлдөх чадвар өндөр байна. Үүнтэй холбоотой Засгийн газраас техникийн зохицуулалтууд хийгдсэн. Монгол Улс түүхий ноолуур экспортод гарахгүй, зөвхөн угаасан угааснаа 100 хувь угаана, 100 хувь самнана. Ингээд самнасан ноолуурыг экспортод гаргах гэдэг ийм бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлээ. Энэ жил анх удаа сүүлийн 30 жил үндэсний үйлдвэрүүд ноолуурын худалдан авалтыг амжилттай зохион байгуулж чадлаа. Ноолуур үндсэндээ 100 мянгаас 165 мянган төгрөгийн хооронд ханш тогтож, бүс бүс, чанар, өнгөний үнэ гарлаа буюу малчдынхаа хөдөлмөрийг үнэгүйдүүлэхгүй байх, хамгаалах их том арга хэмжээ үүний цаана явсан. Учир нь юу вэ гэвэл өмнө ноолуурын зах зээлд урд хөршийн үйлдвэрүүд нэлээн авдаг гол тоглогч байсан. Худалдааны дайнтай холбоотойгоор өндөр тарифын хязгаарлалтад орсон. Энэ нь өөрөө манай Монгол Улсын ноолуур 50-70 мянга дээр үнэ тогтоох ийм эрсдэл учирч байсан. Харин “Цагаан алт” хөдөлгөөнийг бид нар цаг үеэ олж, шуурхай зохион байгуулсантай холбоотойгоор үндсэндээ ноолуурын үнэ өмнөх оны үнээс ижил түвшинд явагдлаа. Ингээд мөн ноолуурт зориулж бид 121 үндэс .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ер нь дэгээрээ бол ийм шүү. 3 минутад багтааж асууна. Хариултыг 5 минутад багтааж өгнө гэдэг дэгтэй. Тэгэхээр 2 юм уу, 3 хүн хариулт өгч байгаа бол аль болох товчхон, тодорхой хариулт өгөх зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр оновчтой хариултыг товчхон өгөх шаардлагатай байна. Дараачийн хүний асуулт дээр Ерөнхий сайд тэр үйлдвэр технологийн паркттай холбоотой асуудлаар товч нэмээд хариулчих нь зүйтэй байх гэж бодож байна. Бид дэгээ барьж ажиллаж байх нь чухал байгаа учраас. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өөрийнхөө мэдээллийн цаг дээр мэдээлэл өгсөнд баярлалаа. Өмнөх Ерөнхий сайд бас өөрийнхөө цаг дээрээс орж ирэхгүй, би ч бас их шүүмжлэлтэй ханддаг байсан хүний 1. Тэгэхээр ер нь манай парламент дотор энэ мал, малчин ярьдаг асуудал их бага. Ялангуяа Ерөнхий сайдын мэдээлэл хийх цаг Хөдөө аж ахуйн байнгын хороон дээр л яригддаг асуудал. Гэтэл уг нь манай улсын нийт хөдөлмөр эрхлэгчийн 4 хүний 1 нь мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа маш том салбар. Яах вэ эдийн засгийнхаа цар хүрээгээр бага ч гэсэн яг хөдөлмөр эрхлэлтийнхээ талбарт бол маш том салбар байдаг. Тэгээд манай хөдөө аж ахуйн салбар чинь хавартаа нэг ноолуур, намартаа нэг махнаас жоохон мөнгө олдог. Энэ жил яг үнэндээ ноолуурын үнэ бас их маргаан дагуулсан шүү. Манай Дорноговь, Говийн бүсэд лав 110 мянгаас дээш гарсангүй. Нөгөө талдаа миний асуух гээд байгаа асуулт махны үнийн асуудал байгаа юм. Одоо энэ нөөцийн мах гэдэг юмаа болиоч ээ. Нөөцийн мах гэдэг чинь төрөөс үнийн хэлбэрт оролцож байгаа хэлбэр мөн шүү дээ. Хүний өмчид холбож байгаа хэлбэр байхгүй юу. Цаашдаа энэ чөлөөт зах зээл рүүгээ орж, махныхаа үнийг чөлөөлөхгүй бол нэг талдаа төрөөс дэмжээд байгаа юм шиг мөртөө нөгөө талдаа нөөцийн мах гээд үнийг нь хатуу тогтоогоод байдаг. Энэ тал дээр ямар байр суурьтай байх юм бэ гэдгийгээ 1 дүгээрт тодорхой хэлчихмээр байгаа юм.

2 дугаарт нь энэ шинэ хоршооны талаар сая тэнд нэг хүн бас ярьж байх шиг байна. Энэ 798 тэрбум төгрөг буюу бараг их наяд төгрөг. Үүний чинь 308 мянган нь өнөөдөр хөдөлмөр эрхэлж байгаа малчиндаа хуваагдахад 1 малчинд 2.1, Монгол Улсын бүх малчдад 2.6 сая төгрөг өгөх хэмжээний ийм их мөнгө байгаа байхгүй юу. Үр дүн хараахан гараагүй байгаа байх. Нэг жил болж байна л гэж байна. Гэхдээ яг эзнээ олж очиж чадаж байна уу, үгүй юу. Уржнан жилийн тэр зуднаар Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговийн зүүн тал тэр чигээрээ зудад өртсөн. Өнөөдөр малгүй болсон иргэд зээлээ төлж чадахгүй байж байхад малжуулах хийгээд шинэ хоршоо

байгуулъя гээд явж байхад нь баахан шинэ хоршоо байгуулчихсан зээл нь олдохгүй л байж байна шүү дээ. Өнөөдөр энэ шинэ хоршоо хоршоогоо байгуулчихаад мөнгөө авъя гэхэд мөнгө нь байгаа юу. 2 дахь асуулт нь энэ.

Ер нь цаашдаа бид нар энэ салбарыг, ялангуяа манай мал аж ахуйн салбар бол маш эмзэг салбар. Үнийг нь чөлөөлж өгөх хэрэгтэй. Гадагшаа тэр экспорт хийх боломжийг нь хангаж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй төрөөс оролцоод байгаа юм болгон дампуурдгийн жишээ бол Монголын хөдөө аж ахуйн салбар шүү дээ.

3 дахь асуулт нь болохоор газар тариалан. Саяхан би Хөвсгөл, Булганаар яваад ирлээ. Гандуу байна. Сэлэнгэ ямар байгааг мэдэхгүй. Яг энэ таны мэдээлэлд орж байгаа шиг энэ жил бид нар идэх гурилаа, нөөцөө бүрдүүлж чадах чадах уу. Газар тариалангийн салбар чинь бас өнгөрсөн жилийн сая бид нарын баталдаг хуулиас болоод бас хүндрэл учирсан шүү. Тэгээд ийм 3 асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Шинэ хоршоо 4 дүгээр индэр. Товчхон хариулт өгнө шүү.

Ё.Азжаргал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Зарим хоршоологчдод бас зээл олдохгүй байгаа, эх үүсвэр байгаа юу гэж асууж байна. Эздэдээ олчхож байгаа юу гээд. Энэ өөрөө хөрөнгө оруулалтын зээл. Та мэдэж байгаа. Хөрөнгө оруулалтын зээл. Эх үүсвэр өөрөө арилжааны банкны эх үүсвэр. Тэгэхээр арилжааны банкны тодорхой хэмжээний шаардлагыг хангасан хүмүүс маань өнөөдөр зээлээ хэвийн аваад явж байгаа. Зээл хэвийн байгаа. 2 үндсэн шаардлага байгаа. 1 нь бол малын А данстай байх ёстой. Нөгөөх нь хоршооны гишүүн байх ёстой. Ингээд энэ 2 шаардлагыг хангасан бол арилжааны банктай харилцаанд ороод явна гэсэн үг. Ямар нэгэн арилжааны банкны шийдвэрт бол хажуугаас нь оролцох боломжгүй. Шийдвэр бол өөрөө цэвэр бизнесийн зарчмаараа гараад явж байгаа. Эх үүсвэртэй холбоотой асуулт. Арилжааны банкны эх үүсвэр бол байгаа. Өнөөдөр бол арилжааны банкнууд хэвийн олгож байгаа. Гэхдээ мэдээж банк тодорхой хэмжээний шаардлага тавина. Тэгэхээр энэ дунд зарим нэг хүмүүс маань шаардлага нь хангахгүй, надад өгөхгүй байна, гомдсон иймэрхүү зүйлүүд бол өнгөрсөн 1 жилийн хугацаанд гарсан. Тэгээд энэ болгон дээр ойлгуулаад ажилласан. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Улаан буудайтай холбоотойгоор нийт 2024 онд бид нар гурилын хэрэглээнийхээ 59.1 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 40.9 хувийг импортоор хангасан. Энэ жилийн тариалалтын талбайг дундаж ургац ингээд тооцоод үзэхэд бид нар 2025 оны ургацын урьдчилсан тооцооллоор гурил үйлдвэрлэлд 154 мянган тонн улаан буудай ноогдож байгаа. Энэ нь бол өмнөх оныхоос даруй 25 хувиар бага буюу гурилын хэрэгцээнийхээ 44 хувийг л дотоодын үйлдвэрээр хангах ийм төлөвтэй байна. Тэгэхээрээ бид багаар бодоход ахиад 150-160 мянган тонн улаан буудай импортоор авахаас аргагүй байдал үүссэн.

Мах бэлтгэлтэй холбоотой мах бэлтгэлүүд орон нутаг өөрөө өөрсдийн эх үүсвэрээр нөөцөө бэлдэх ийм тогтолцоо ажиллаж байгаа. Яамнаас нөөцийн мах бэлтгэх ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохгүй байгаа. Экспортыг бүх чиглэлээр урамшуулж байгаа. Экспортлоход ямар нэгэн татварын бөгөөд квотын хязгаарлалт байхгүйгээр махны экспортыг идэвхжүүлж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 600 сая долларын мах экспортолж чадсан. Энэ бол өмнө нь бид 10-20 сая

доллароос илүү гарч үзээгүй. Одоо бол энэ махны экспортыг бүх талаар идэвхжүүлж байна. Яагаад гэвэл малын тоо боломжийн байна. 20 сая төл авч байна. Үндсэндээ 77, 78 сая малтай болох нь. Бэлчээрийн даац хонин толгойд шилжүүлснээс 20-25 саяар хэтэрч байна. Иймд бид нар хонь, ямаа, адуу гэсэн энэ 3 төрөл дээр сүргийн бүтцийн тоог хэмжээг нэлээн багасгах ийм бодлого стратеги барьж байгаа. Иймд аль болох экспортын бодлогоор энийг, тоог багасгах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэх, нөгөө талдаа малчдын орлогыг нэмэгдүүлэхэд махны экспортыг бол бүх талаар явж байгаа. Махны экспорт тун боломжийн байгаа. Энэ нь өөрөө мал эмнэлгийн ажил үйлчилгээ цаг хугацаатай, малын гоц халдварт өвчнийг үндсэндээ хяналтад авч чадсаны үр дүнд махны экспорт маш сайн нэмэгдэж байгаа. Ер нь хөдөө аж ахуйг бол цаашид зөвхөн экспортын чиг баримжаатай болгож байж, өөрөө энэ нь малчдын, тариаланчдын орлогыг олон улсын зах зээл, экспортын үнэтэй уяж өгөх нь ерөөсөө л орлого нэмэгдэх гол суурь болж байна. Ингээд мах экспорт нь амжилттай гараад ирэхээр малчдын орлого үндсэндээ энэ 600 сая долларын мах өөрөө малчдын орлого болж очсон. Ноолуур үндсэндээ бид нар 100 хувь самнадаг болсноор үндсэндээ ноолуураа бид нар цэвэршүүлж байна гэсэн үг. Зэсээр бол цэвэр зэс гэдэг шиг цэвэр ноолууртай болчихож байгаа юм. Энэ мөн адилхан энд өгөөж, эргээд л нөгөө малчид үйлдвэрлэл дээр нэмэгдээд байгаа. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын өсөлт их ... /минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга нэмэлт хариулт өгье.

Г.Занданшатар: Эхлээд Ганбатын Очирбат гишүүний асуусан нөгөө аж үйлдвэрийн парктэй холбоотой асуултад товч хариулчихъя. Аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц, инженерийн бүтцийн санхүүжилт тодорхойгүй, хангалтгүй, татвар, зээлийн хөнгөлөлтийн бодлого хангалтгүйгээс аж үйлдвэрийн паркууд бүрэн утгаараа ажиллаж байгаа парк алга байна. Энэ паркуудыг өнөөдөр хөнгөлөлт, чөлөөлөлт төсвийн дэмжлэг үзүүлж чадвал байгуулж чадвал 400-500 тэрбум төгрөгийн орлого оруулах бололцоотой гэж үздэг. Тийм учраас энэ аж үйлдвэрийн паркийн эрх зүйн орчныг нэгтгэх, уялдаа холбоог сайжруулах ийм цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа. Энэ бас гадаад гэрээ хэлэлцээртэй ч уялдана.

2 дугаарт нь Гомбын Ганбаатар гишүүний асуусан асуултаас ер нь яг үндсэндээ махыг чөлөөллөө гээд дундаас нь яг малчин биш, үйлдвэрлэгч биш ченжүүд илүү хождог гэсэн ийм тооцоо судалгаатай. Ер нь энэ зах зээлийн төрийн зохицуулалт зайлшгүй шаарддаг. Одоо яах вэ, аймаг, нийслэл мах бэлтгэл, махны нөөцийг бэлтгэж байгаа л даа. Тэгэхээр энэ нөөц бэлтгэлийн ажил бол улирлын шинж чанартай, зоорь бүтээмж, худалдаа, тээвэр логистиктой холбогддог асуудал учраас энийг илүү нээлттэй, ил тод, хяналттай болгож зохицуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ талаар нийслэлд махны хангамжийг сайжруулах асуудал үе үед яригдаж ирсэн. Энийг нээлттэй, ил тод болгох нь хамгийн чухал байх гэж бодож байна.

2 дугаарт газар тариалангийн районд гандуу байгаа. Ийм учраас өнгөрсөн бүтэн сайн өдөр ажил аваад 2 хоногийн дараа Улсын онцгой комиссыг хуралдуулж энэ ган, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тодорхой арга хэмжээ авах үүрэг даалгавар өгсөн. Үүний дагуу Цаг уурын газраас маш шинжлэх ухааны үндэстэй тооцоо судалгаа хийж, үүлэнд нөлөөлөх арга хэмжээ газар тариалангийн районд явуулах үүрэг өгсний дагуу Сэлэнгэ аймагт бороо 1, 2, 3 гэсэн экспедиц гаргаж, үүлэнд нөлөөлөх үйл ажиллагаа явуулсны үр дүнд энэ сумдад Баруунбүрэн,

Хушаад, Зүүнбүрэн, Түшиг, Бугант, Сүхбаатар, Орхон, Орхонтуул, Баянгол, Мандал сумдад 1.2мм-ээс 18мм хүртэл бороо орсон. Ер нь бол гандуу нөхцөл байдлаас шалтгаалж 3-30 хувиар алдах эрсдэлтэй гэж тооцогддог. Ийм учраас улаан буудай, гурилын хангамжийн асуудалд онцгой анхаарч байна.

Малчдын хувьд улирлын шинж чанартай орлоготой малчдыг тогтворжуулахад малчдын орлогыг тогтворжуулахад мал аж ахуй эрсдэлийг давах чадавхыг бэхжүүлэхэд мал эрүүлжүүлэх, чанаржуулах, дээр нь малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих Цагаан алт, Хүнсний хувьсгал хөтөлбөрүүдийг бас гадаад зах зээл гарахад бол Евро-Азийн зах зээлд 12 тэрбум долларын арьс шир, ноос ноолуур, мах махан бүтээгдэхүүний импортоор авдаг зах зээл юм байна лээ. Үүний 20 хувьд хүрнэ гэж тооцоход 2.4 орчим тэрбум долларын гадаад зах зээл нээвэл аяндаа борлуулалттай бол дотоод зах зээлийн стандарт, техникийн зохицуулалт, үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл бүрдэж, энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Ер нь Энхбаяр сайд аа, Цогтгэрэл даргын түрүүний хийсэн дүгнэлт, түрүүн Уянгахишиг гишүүний хийж байгаа дүгнэлт бол бас нэг зүйлийг хэлж байгаа шүү дээ. Хөдөө аж ахуйн яам бодлогын томоохон өөрчлөлт хийгээч ээ, боловсон хүчнийг шинэчлэх, мэргэжлийн боловсон хүчин ажиллуулах тал дээр анхаараач ээ гэдэг зүйл яригдаад байгаа юм. Үнэндээ бол бас яг салбарт жоохон реформын шинжтэй бодлого хэрэгжүүлэхгүй бол цаашаагаа Хөдөө аж ахуйн яам явахад их хэцүү болчихсон шүү. Би бас Хэрэг эрхлэх газрын даргаар ажилласан. Тодорхой асуудлууд дээр зуд, зудын дараах энэ малчдын амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой асуудал дээр 1 хэсэг хамтарч ажилласан. Мэргэжил, боловсон хүчний хувьд бол бас их гологдсон, дутагдсан ийм нөхцөл дээр бол яалт ч байхгүй оччихсон. Үүнтэйгээ өөрсдөө сайхан эвлэрээд, шинэчлэлээ Энхбаяр сайд минь зоригтой хийгээд явах хэрэгтэй. Их Хурлаас таны энэ бодлогыг дэмжээд явахад бэлэн. Одоо жишээ нь Гомбын Ганбаатар гишүүний асууж байгаа нөөцийн мах бэлддэггүй тогтолцоо гэдэг чинь өөрөө малчин өрх өдөр бүр зах зээлд мал, мах, бүтээгдэхүүн нийлүүлж чаддаг тийм болно л гэсэн үг шүү дээ. Зөвхөн хавар, намрын цагтаа махаа нийлүүлчхээд, өвөл, хавар, зун хөлдөөсөн мах идээд сууж байдаг ард түмэн байна шүү дээ. Тэгсэн мөртөө мал аж ахуйн эх орон гэж байгаа. Энэ шинэ хоршоо хөдөлгөөний чинь гол зорилго малчдыг төрийн гарыг харж амьдрахаас л гаргаж өгч байгаа юм. Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зовцгооё л гэж байна. Урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл аваад, өөрсдийнхөө аж амьдралыг төрийн гарыг харахгүйгээр авч явдаг болох бололцоог гаргаж өгсөн. Харамсалтай нь манайд нэг сул тал байдаг. Өөр хүний санаачилсан ажлыг өөр хүн хийдэггүй, дэмждэггүй, болж өгвөл унагаах гээд яваад байдаг. Тэгээд ийм бодлогыг л хэдүүлээ цааш нь байлгахгүйн тулд ажиллах хэрэгтэй.

Харин нэг зүйлд талархалтай хандаж байгаа нь Төрийн банк, Хаан банк 2 арилжааны зориулалтаар 3 жил хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийг малчны малыг нь барьцаалаад, зээлийн батлан даалтын сангаар батлан даалтыг нь гаргаж байгаад олгодог болсонд их талархалтай байгаа юм. Тэгэхгүй бол малчид маань ерөөсөө зөвхөн малчны өндөр хүүтэй зээлээс өөр ямар ч боломжгүй амьдралтай байсан. Жилийн 24 хувийн хүүтэй зээл авна. Намар малаа бойнд шилжүүлэхээрээ 1 зээлээ төлнө. Хавар ноос ноолуурын цагаар зээлээ төлнө. Тэгээд л ерөөсөө жилд 24 хувиар банкны мөнгийг өсгөж өгдөг хүмүүс болчихсон байсан.

Одоо бол харин урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл аваад, түүгээрээ бизнес эрхлэх боломжийг гаргаж өгсөн гэдгийг маш сайхан тодорхой ойлгоод авах хэрэгтэй гэж. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Тэгээд 2 асуулт байна.

1 хүний сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх олон улсын стандарт нормоор тооцоод үзэх юм бол Монгол Улсын сүүний жилийн хэрэгцээ 170 мянган тонн, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ 190 мянган тонн байгаа юм. Тэгээд манай улсад улсын хэмжээнд бол 17 аймгийн 25 сумд сүү хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий 88 үйлдвэр, цех, 82 сүү хүлээн авах хөргөлттэй төв үйл ажиллагаа явуулж байгаа юм байна. Эдгээр үйлдвэр, цехүүд суурилагдсан хүчин чадлынхаа 50 гаруй хувийг ашиглан үйлдвэрлэл явуулж, жилдээ 60 мянган тонн сүү, 90 мянган тонн сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна. Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн сүү бол ингээд 140 мянган тонн. Ингээд үүнээс харах юм бол бид сүүнийхээ дотоодын хэрэгцээг ер нь бол 100 хувь хангаж байна. Сүүн бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг 53 хувь хангаж байна. Үлдсэнийг нь болохоор импортоор авч байна гэсэн үг. Тэгээд хэдийгээр сүүний хэрэгцээгээ дотоодоосоо бүрэн хангаж байгаа боловч нөөц бололцооныхоо 30 хүрэхгүй хувийг л бид ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл малчид маань сүүлийн үед үнээгээ ер нь саахаа больчихсон. Яагаад гэвэл дотоодын зах зээл хэрэгцээ нь ханачихсан. Тэгээд энийг үнэ бас хямд хэтэрхий хямд байгаагаас болоод л үнээгээ саахгүй байгаа юм. Тэгэхээр асуулт нь ингэх гээд байна. Хөдөө аж ахуйгаа бэлдэх сүүний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд ер нь бол шуудхан хэлэхэд бид нар малчдынхаа сүүг сааж борлуулах сонирхолтой болгохын тулд бид нар боловсруулах үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрэлтийг бий болгох шаардлагатай байгаад байгаа юм. Эхний ээлжид тэгээд сүүн бүтээгдэхүүнээ дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангахад, цаашлаад экспортод гаргах чиглэлд боловсруулах үйлдвэрлэлийг төрөөс ер нь хэрхэн дэмжих юм бэ. Ер нь бол бид нар малчдыгаа малаа саахгүй байна гэх биш ер нь саасан сүү нь үнэд хүрдэг болох л ер нь зөв зарчим шүү дээ. Ингэж байж бид нар малчдыгаа яг бодитоор дэмжинэ.

2 дугаарт энэ шинэ хоршоо хөдөлгөөнийг ерөөсөө хир халдаахгүй л явуулах гээд байгаа юм. Ер нь бол хоршоогоор хөгжсөн улсууд бол эхлээд зах зээлээ маш тодорхой болгосон байдаг. Худалдан авагчид нь бэлэн байдаг. Тэрийгээ дагаж байж энэ хоршоогоор дамжуулж, анхан шатын боловсруулсан түүхий эдээ бэлдэж, тэр үйлдвэрүүдээ босгож ирдэг. Гэтэл өнөөдөр бид нар хүнс, хөнгөн үйлдвэрийн 1 ч үйлдвэрээ босгож чадаагүй байж байж хоршоогоор дамжуулаад 1 жилд 800 тэрбум төгрөг гаргачхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 800 тэрбум төгрөгт хүүгийн татаас нь хэдэн төгрөг яг төсвөөс гарч байгаа вэ. Энийг хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Хоршооны хүүгийн татаас ер нь батлагдсан эх үүсвэр 1 их наяд байгаа. Өнгөрсөн жил 500 тэрбум гараад, маш богино хугацаанд олгогдоод, тэгээд шинэ эх үүсвэр шаардлага үүссэн. Ингээд 500-г нэмж баталж өгсөн. Ингээд үндсэндээ 1 их наяд төгрөг хүртэл энэ хоршоог дэмжих хөнгөлөлттэй зээл явна. Үүний 1 их наяд төгрөгийг олгуулахын тулд бид дандаа хүүгийн бодлогоор дэмжиж өгч, арилжааны банкнаас эх үүсвэрээр шийдэж байгаа. Төсвөөс гарч байгаа зардал нь 100 тэрбум төгрөг байгаа буюу зээлийн хүүгийн 10 орчим хувийг төсөв дээр

даагаад, арилжааны банк бол бусад 6 хувийг нь гаргаад хүүгийн. Тэгэхээрээ 100 тэрбумаар бид нар 1 их наяд төгрөгийн эх үүсвэрийг гаргаж байгаа гэсэн үг.

Сүүн дээр бол улсын хэмжээнд 17 аймгийн 25 суманд хоногт 904 тонн сүүн хүлээн авах, боловсруулах хүчин чадалтай 88 үйлдвэр, цех байна. 150 сая литр сүүг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар боловсруулсан байна. Сүүнд бид нар сэрүүний улиралд литр тутамд урамшууллыг олгож байгаа. Энэ урамшуулал олгох асуудлыг хугацааг нэмэх ийм санал их байгаа. Нөгөө талаас сүүний хангалт малын тоогоор тооцоод, дэлэнд байгаа сүүг тооцоход хангалттай юм шиг байдаг боловч яг төвлөрсөн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангахад хангаж чадахгүй байгаа юм. Импортоор их хэмжээний хуурай сүү, сүүн бүтээгдэхүүн авч байгаа. Энийг шийдэх гол арга бол ерөөсөө л байнгын маллагаатай, байнгын саалийн горимд байдаг сүүний фермүүдээр, үнээний фермүүдээр, газар тариалангийн бүс нутгийн тэжээлийн бааз дээрээ тулгуурлаж, хөгжүүлж байж л энэ сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангана. Ингэхийн тулд бид нар энэ “Атар 4” дүгээр аяны хүрээнд газар тариалан, мал аж ахуйг хослуулах эрчимжсэн аж ахуй байгуулах ийм төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Юуны өмнө бол үхэр сүргийнхээ чанарыг сайжруулах ашиг сонирхлыг нэмэгдүүлэх үүднээс 200 хүртэл мянган толгой мах, сүүний үхрийг сайжруулагчаар бид авах ийм шаардлага байгаа. Эхний нийлүүлэлтүүд хийгдээд эхэлсэн. Төсөв мөнгөний хувьд жоохон хүрэлцээ хязгаарлагдмал байгаа тул бас тоо жоохон бага байна. Хувийн хэвслүүдийн зээлийн хүрээнд бас ажлууд эхэлсэн. Тун удахгүй эхний 1500 саалийн Алаг Холштейн үйлдвэрийн үнээ, өсвөр малууд энэ 7, 8 сард цуураад, Монгол Улсад нийлүүлэгдэхээр бэлтгэл ажил хангагдаад явж байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: 2024 онд эдийн засгийн өсөлт бидний хүлээснээс, төсөвлөснөөс харьцангуй бага байсан. Тэр дундаа хөдөө аж ахуйн салбар 2024 онд 25 хувь агшсан гэсэн мэдээтэй байгаа. Тэгээд хөдөө аж ахуйн салбар бол Монголын маш олон малчин айл өрхүүдийг тэтгэдэг ийм салбар байгаа. Тэгээд эдийн засгийн өсөлт хөдөө аж ахуйн салбар ингэж агшсан нь болохоор ер нь эдийн засгийн өсөлтийг ч сааруулж байгаа. Малчин өрхүүдийн орлогыг ч бууруулж байгаа. Тэгэхээр энэ тал дээр ерөөсөө Ерөнхий сайдын мэдэгдэлд бас дурдагдаагүй байна. Мэдээж хэрэг ноднин өвлийн зудтай холбоотой, мал хорогдолтой холбоотой ийм асуудал гарсан гэж хэлэх байх. Гэхдээ өнгөрсөн 30 хэдэн жилийн хугацаанд бид нар олон гоё нэртэй хөтөлбөрүүдийг зөндөө олныг хэрэгжүүллээ. Төсвөөс бол байнга татааснууд өгч ирсэн хөдөө аж ахуйн салбарт. Тэгээд ганц хүнд өвлийн зудыг давж чадахгүй, 25 хувиар агшина гэдэг бол энэ салбарын бодлого ерөөсөө бүхэлдээ буруу байна л гэсэн үг. Тэгээд л 30 жилийн туршид л ерөөсөө экспортод бараа бүтээгдэхүүн гаргана, кластераар хөгжүүлнэ гэсэн юм яриад л яваад байдаг. Зах зээлээ тэлнэ гээд л яриад яваад байдаг. Тэгээд өнгөрсөн 8, 9 жилийн хугацаанд МАН-ын дарга нар бүгдээрээ дор бүрнээ нэг ийм гоё нэртэй хөтөлбөртэй боллоо. Цагаан алт л гэнэ, Шинэ хоршоо л гэнэ, Хүнсний хувьсгал л гэнэ, Атрын 4 дүгээр аян л гэнэ. Тэгээд энэ хөтөлбөрүүдийн чинь үр дүн ер нь ямар байгаа юм бэ. Салбарын нэгдсэн бодлого чинь юу байгаа юм бэ. Тэгээд ганц жилийн зуд нар 4-ний 1-ээр агшихдаг ийм салбартай сууж байна шүү дээ. Тэгэхээр шинэ Ерөнхий сайд ер нь энэ хөдөө аж ахуйн бодлогоо яг бүхэлд нь хэрхэн яаж харж байгаа вэ.

Энэ олон татаас, энэ олон хөнгөлөлтүүд чинь ерөнхийдөө танай намын сонгуулиар санал авах тийм арга хэрэгсэл шиг л харагдаад эхэлчихлээ шүү дээ.

Тэгээд жишээлэх юм бол энэ банкны салбар дээр бол бас тодорхой хэмжээний ачааллууд бас ирэхээр байна л даа. Яаж байна вэ гэхээр өнгөрсөн зудтай холбоотойгоор 1 жилээр малчдын зээлийн эргэн төлөлтийг хойшлуулчихсан байж байгаа. Тэгээд энэ 5 сараас малчид зээлээ эргэн төлж байгаа. 1.3 их наяд төгрөгийн зээл байгаа. Тэгсэн чинь энэ Засгаас янз бүрийн бодлого дотроо хоорондоо уялдаагүй бодлогууд яригдаад, ноолуурын ч гэсэндээ асуудал бас гарсан. Ноолуурын орлогын. Тэгээд дээрээс нь шинэ хоршоо хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтүүд орж ирж байгаа. Тэгээд манай малчид чинь ер нь зээлээ төлж чадах нь уу, яах нь. Тэгээд би энэ болгоныг Ерөнхий сайдаас асуугаад байгаа шүү.

3 дугаарт. Сая ноолууртай холбоотой асуудал яригдаж байна. Тэгээд энэ Ерөнхий сайдын мэдээлэл дээр болохлоор ноолуурын эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 310 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 5 мянган тонн ноолуур бэлтгэсэн гэнэ. Тэгээд 310 тэрбум төгрөгийн эргэлтийн зээл яг ямар ямар компаниудад, ямар ямар үнийн дүнтэйгээр олгогдсон бэ. Уг нь бол манай энэ ноолуурын салбар чинь бол гадагшийгаа экспорт дээрээ хамгийн ийм харьцангуй давуу талтай салбар шүү дээ. Тэгсэн хэр нь дандаа л ингээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нийт 121 үндэсний үйлдвэрт энэ ноолуур бэлтгэх зээл олгогдсон. Амжилттай болсон. Ахиад хэлье. Анх удаа Монгол Улсын үндэсний үйлдвэрүүд ноолуураа бүрэн авч чадсан. Угаагаад гаргадаг байсан бол 100 хувь самнадаг болсон. Зөвхөн угаадаг самнадгийн зөрүүнд 200 гаруй сая доллар буюу 700 тэрбум төгрөгийн нэмүү өртөг, орлого, ажлын байр татвар болж Монгол Улсад шингэж байгаа юм. Бид ноолуураа цэвэршүүлж чадсан. Нөгөө цэвэр зэс гэдэг шиг цэвэр болгочихсон. Одоо энэ бол цэвэр самнасан ноолуур маань яг олон улсын зах зээлд үнэлэгддэг бараа. 1кг нь өнөөдрийн ханшаар 106 орчим доллар. Энэ бол манай маш сайн давуу тал. Үүний цаана чинь үйлдвэрлэл, үүний цаана чинь малчдын орлого гээд олон зүйл тогтворждог. Дотоодын үйлдвэрлэл үнэхээр эрс өөрчлөлт хийсэн юм шүү. Маш сайн.

Энэ жилийн 1 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарын өсөлт 36 хувьтай гарч байгаа юм. Одоо уул уурхайн мөчлөгийг сөрж, хөдөө аж ахуйн салбарын өсөлт энэ жил хамгийн өндөр гарна. Жилийн эцэс гэхэд. Энэ олон хөтөлбөрийн чинь үр дүн одоо яг гарч ирж байна. Хөрөнгө оруулалтаа хийгээд, үйлдвэрлэлээ өргөтгөөд, бүтээмжээ нэмэгдүүлээд, хүнээ бэлдээд ингээд явж байна.

Нэг зүйл байна. Би дахин дахин Их Хуралд хэлдэг. Хүний нөөцийн бодлого яамнаас гадуур байгаа. Харьяалагддаггүй. Салбарын хөгжүүлэх шинжлэх ухааны, хөдөө аж ахуйн шинжлэх ухааны хүрээлэнгүүд яамнаас гадуур байгаа. Үнэхээр салбарт хүний нөөц дутаж байна. Хүний нөөц бэлтгэгдэж чадахгүй байна. Тэгэхээр энэ тогтолцоог эргэн хараад Хөдөө аж ахуйн яамыг бүрэн хүчтэй зэвсэгтэй болгоод өгөөч ээ гэж би Их Хурлаас хүсэж байна.

Хөгжүүлэх шинэ инновац, технологи нэвтрүүлэх шинжлэх ухаан эрдэмтдийн тэр хүч чадал чинь энэ салбартаа ирж үйлчлэхгүй байна шүү дээ. Бүр салгаад салгаад өөр өөр яамнуудад салгаад тавьчихсан. Тэгэхээр салбар өөдрөг байгаа. Нийт Монгол Улсын ажиллах хүчний 2-ны 1 нь энэ салбарт ажиллаж байна. Нийгмийн тогтвортой байдлыг хамгийн сайн хангах, нийгмийн баялгийг хамгийн сайн хуваарилж байгаа салбар. Олон 100 мянган хүн энэ салбараас ажиллаж

амьдарч байгаа. Орон нутгийг эзэнтэй байлгаж байгаа. Тэгэхээр энэ салбарын чиглэсэн бодлогыг Их Хурлын үе шаттай баталсан 4 үндсэн гол бодлого байна шүү дээ. Атрын 4 дүгээр аян, Цагаан алт, Хүнсний хувьсгал, Хоршоо. Энэ 4-өө л 3 жил, 2028 он хүртэл тогтвортой хэрэгжүүлэхэд бол салбар бол шинэ өөр дүр төрхтэйгөөр, шинэ зах зээл, 21 дүгээр зууныхаа хөдөө аж ахуйн салбартай хөгжилд нийцээд ингээд гараад ирнэ. Үнэхээр ололт амжилтууд, технологийн шинэчлэлүүд, техникийн шинэчлэлүүд, олон зүйл бүтээмжүүд нэмэгдэж байгаа. Эргэлзэх хэрэг байхгүй. Харин маш богино хугацаанд эрс өсөлтийг авч байгаа салбар. Хүмүүс урам зоригтой байгаа. Хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байгаа. Хүмүүс олон мянгаараа хөдөө орон нутаг руу шилжиж аж ахуй эрхэлдэг ийм сонирхол бий болж байгаа. Ялангуяа Атрын 4 дүгээр аянаар шинээр олгох тэр 200 мянган га талбайг эргэлтэд оруулж байгаа нь маш олон мянган ажлын байрыг, шинэ бүтээмжийг нэмнэ гэдэгт итгэлтэй байгаа. Харин улс төрийн хувьд тогтвортой байлгах сайн бодлогын дэмжлэгийг тогтвортой байлгах нь их чухал байна. Бодлого сайн хэрэгжиж байгаа шүү. Одоо яривал би олон үзүүлэлтийг би ингээд ярьж болохоор байна. Монгол Улсын дотоодын бүтээгдэхүүний 31.7 хувь руу ороод ирлээ шүү дээ. Салбар хангадаг болж байна. Экспорт 100, 100 сая доллар нэмэгдэж байна. Одоо тэрбум доллар давсан экспорт хийдэг болж эхэлж байна шүү дээ. Ноолуурыг 1 тэрбум доллар, махыг 1 тэрбум долларт хүргэх бүрэн бололцоотой байна.

2 Эрдэнэтийн үйлдвэрийг хөдөө аж ахуйн салбар босгох бололцоотой байна. Эрдэнэттэй адилхан борлуулалт хийх бололцоо гарч ирж байна. Ер нь экспортын орон зай сайн нэмэгдэж байна. Энэ чинь энэ хамт олны л хийсэн ажлын үр дүн шүү дээ. Тэр ургамал хамгаалал, мал эмнэлэг, мэргэжлийн тэр ажлууд хийгдсэний үр дүнд л энэ экспортууд, борлуулалтууд ДНБ-ий эзлэх хувь их нэмэгдээд байгаа нь энэ буюу 600 мянган хүнийг ажлын байраар хангаад ингээд тогтвортой хангаж байна шүү дээ. Тэгэхээр энэ салбар луугаа л бодлогын дэмжлэгийг сайн хийгээд баймаар байна. Бид ойлголоо шүү дээ. Уул уурхайгаас ангид эдийн засгийг босгох хэрэгтэй байна. Энэ нь яах аргагүй хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбар юм гэдгийг харж байна. Ялангуяа энэ жил мөчлөг унаж байх үед манайх сөрж, маш сайн өсөлтийг хөдөө аж ахуйн салбар үзүүлнэ.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Жаргалан гишүүний асуултад тодруулж, нэмж л хариулъя даа. Манай Жадамбын Энхбаяр сайд тодорхой бараг хариулчихлаа. Тэгэхдээ 1 зүйлийг би онцлон хэлчихмээр байна. 1990 онд манай улсын экспортын 80 хувь нь нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний аж үйлдвэрийн хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн байсан юм билээ. Одоо 5 хувь ч хүрэхгүй байгаа. Энэ хүртэл буурахад гол нөлөөлсөн шалтгаан нь Монгол Улс тариа ногоо тарих хэрэггүй, гаднаас авчихна, хямдхан. Нөгөө харьцангуй давуу талын судалгаа гэдэг шиг Монгол бол тийм харьцангуй нөгөө Трампын бодлого эсрэг болж байгаа бол тэр үед бусад улсаас импортоор авч байгаа нь ашигтай, чөлөөт зах зээлийн бодлого гэдэг Дэлхийн худалдааны байгууллагад элссэн бүх бодлого маань дотоодын үйлдвэрлэлийг үндсэндээ устгасан. Дээр нь түүхий эд бэлтгэлийн сүлжээ, хоршооны тогтолцоо, тэгээд экспортын тогтолцоо хүртэл бүгд устчихсан учраас 300 мянган хүний ажлын байр байхгүй болж, мал аж ахуй руу шилжсэн байдаг юм. Ингээд мал аж ахуйгаар энийг давсан нь өөрөө манай мал аж ахуй маань өөрөө дундад зууны үе рүүгээ бараг ухарсан ухралт болсон гэж гадаадын эрдэмтэн судлаачид дүгнэсэн байгаа. Яагаад гэвэл амиа аргацаасан мал аж ахуйн энэ хэлбэр

бол өсөж хөгжих хөдөлмөрийн хуваарилалт, экспортод бүтээгдэхүүнээ 1 малчин гаргах бололцоогүй нь ойлгомжтой ийм том өөрчлөлтийн үр дүнг 1 өдөр засах бололцоогүй. Тэгэхдээ энэ олон гоё нэртэй гэж таны шүүмжилж байгаа хөтөлбөр, төслүүд тодорхой үр дүнгээ өгч, олон шинэ аж ахуйн үйлдвэрүүд, дотоодын хүнсний хангамж, үйлдвэрлэлүүд сайжирч, зөвхөн ноолуурын салбар 1 тэрбум долларын бололцоотой гэж байна. Утас ээрэх шат дамжлага болгонд 50 мянган эмэгтэй ажлын байр бий болно. Ард түмэнд юу хэрэгтэй байна. Ажил эрхлэлт, ажлын байр хэрэгтэй байна. Энэ ажлын байрыг бий болгодог салбар бол хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн салбар. Түүхийгээр нь ноолуур экспортлоод байгаа биш, 317 орчим сая долларын түүхий ноолуур экспортолдог байсан бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Жишээлбэл, 1 шат нэмээд, самнаад угаагаад, тэгээд утас ээрэх энэ шат болгонд 30 хувийн нэмүү өртгийн долларын манай экспорт нэмэгдэх, 1 тэрбум доллар хүрэх, махны экспорт одоо 600 сая доллар хүрч ирнэ гэдэг маань шинэ зах зээлд 1 тэрбум долларт хүрэх энэ олон боломжууд нээгдэнэ. Тэгэхдээ энэ дээр одоо хүртэл тэр түүхий эд бэлтгэлийн тогтолцоо чинь яагаад энэ хоршоо хэрэгтэй юм бэ, яагаад тэр малчин өрхийн нэгдсэн холбоо гэдэг хууль батлагдсан юм бэ, энэ бодлогууд бол мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж муу байгааг л шинэчлэхэд чиглэж байгаа. Одоо өнөөдөр үндсэндээ малчид малынхаа сүүний гуравхан хувийг ашиглаж байна. Үхрийн 32, хонины 10 хүрэхгүй хувь. Ийм учраас энэ хөдөө аж ахуйг дэмжих бодлого цогц бодлого байж байж дэлхийн бүх улсын жишиг байгаа. Япон, Солонгос тэгээд энэ Швед, Данийн хоршоо, фермийн бодлогыг бүгдийг нь ажиглаад үзээрэй. Энэ бол мянга мянган хүний хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой асуудал, ажлын байрны асуудал учраас энэ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарын бодлогын тухай бид бүхэн ...

Д.Амарбаясгалан: Микрофон өгье.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Хөдөө аж ахуйн салбарын бодлогын тухай бид бүхэн ярьж байгаа. Тэгээд аливаа салбарыг дэмжих бодлого гэдэг нь бодит утгаараа яг юу гэсэн үг юм бэ гэдгийг харахаар энэ салбарт бол нийлүүлэлтийн сүлжээний эрх зүйн орчин, агуулах сав, эргэлтийн хөрөнгө, татварын бодлого гэх зэрэг томоохон асуудлуудыг Засгийн газар маань шийдэх ёстой байгаад байгаа юм. Гэтэл ингээд салбарын яамны ойлгомжгүй үйл ажиллагаа эрхлээд байдаг юм. Энийг өнөөдөр бас ярихгүй бол болохгүй байна. 2021, 2022 оны тогтоолоор гарсан юм байна. Мал аж ахуй газар тариалангийн салбарт амжилттай ажиллаж байгаа малчид, тариачдад шалгаруулж шагналын билгийн тооллын хаврын тэргүүн сарын 1-ний өдрөөс эхлэн гардуулдаг уламжлалтай. Тэгээд энэ тогтоолын дагуу улсын аварга саальчинд 4 сая төгрөг, аварга фермерт 5 сая төгрөг, улсын аварга малчин, улсын хошоо аварга тус бүрийг дурсгалын цом, мөнгөн аяга, гуулин бүслүүртэй модон хувин, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, үнэмлэх, бусад зүйлсээр 10 сая төгрөг, улсын аварга тариаланч хамт олон тус бүрийг 5 сая төгрөг, улсын аварга тариаланч тус бүрийг 3 сая төгрөг гэх мэтээр шагнахыг бол журамласан юм байна. Үүнийх нь үр дүнд болохоороо сүүлийн 2 жилээр хараад үзэхээр 207 хүнд 2023 онд 1.7 тэрбум

төгрөгийг зарцуулсан байна. 2024 онд бол 292 хүнд 2.4 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамнаас бол гарсан байгаа юм. Тэгээд энэ салбарт бол 300 мянган хүн ажилладаг. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг. Тогтвортой санхүүжилтийн систем үүсгэх боломжгүй учраас маш олон хүмүүс шантарч, энэ салбараас бол гарч байгаа. Тэгэхээр Засгийн газар маань уралдаан зарлаж байгаа юм шиг жилдээ 200, 300 хүнийг түүж аваад, хамгийн түрүүнд нь орсон хүмүүст нь 2.4 тэрбум төгрөгөөр шагнаж байхаар энэ салбарт чинь маш их хэмжээний хийх бүтээн байгуулалтууд байгаа. Тэр утгаараа 300 мянган хүнтэй холбоотой энэ асуудлуудаа шийдээд явбал зүгээр юм биш үү гэж харах юм. Эсвэл одоо энд тавигдаад байгаа төсвөө бид нар татвар төлөгчдийнхөө ачаанаас нь багасгаад ор тас хасчихвал яасан юм. Айлын хүүхэд юугаа алагчилж үзэж байгаа юм шиг бид нар ингэж ялгавартай байдлаар одон медаль тарааж, иргэдээ ингэж талцуулах шаардлагагүй юм шиг харагдаж байгаа юм. Мэдээж хэрэг энэ салбарт ажилласан, энэ шагналыг авсан хүмүүсийг бол буруутгаагүй. Хөдөлмөрөө эрхлээд, хөдөлмөрөө үнэлүүлж байгаа. Гэхдээ бодит байдал дээр бид бүхэн 300 мянган хүн, дээрээс нь 3.5 сая хүний амьдралтай холбоотой энэ чухал асуудал байхад бид бүхэн ач холбогдлоор нь эрэмбэлээд, энэ шагналтай холбоотой асуудлаа цэгцэлчихвэл яасан юм бэ гэдэг санал байна. Тэгээд төрдөө үнсүүлнэ гэж бид бүхэн яриад байдаг. Гэтэл үгүй шүү дээ энэ чинь татвар төлөгчдийн мөнгөөр л бид бүхэн өгч байгаа гэсэн үг. Тэрийг иргэд маань бас маш сайн ойлгоосой гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье. Аварга малчин, аварга саальчин, аварга фермер.

Ж.Энхбаяр: Энэ хөдөлмөрийн хүнийг л урамшуулж байгаа ийм бодлого. Үнэхээр 3.5 сая хүний тэр хоол унд, хүнсийг л гол хангаж байна. Ёстой гадаа гадаж, хөдөө хөхөрч байгаа л хүмүүс шүү дээ. Энэ чинь бас их том уран болдог юм. Бас жишээлбэл, тариаланчид гэхэд 1 шинэ технологи би нэвтрүүлчихье, ийм хөрөнгө оруулалт хийчихье, ийм бүтээмж нэмчихье, ургацаа ингээд нэмчихье. Үүний цаана дандаа нэмүү өртөг, улс орны эдийн засагт хувь нэмэр оруулсан тэр үр дүнг л үнэлээд байгаа юм. Тэр малчин гэхэд л бас өөр бусдыг малжуулсан, орон нутгийн тэр хөгжлийн бодлогод оролцсон, малынхаа үүлдэр угсааг сайжруулсан, 1 малаас авах ашиг шимийг бий болгосон гээд дандаа цаана нь хөдөлмөрийн өгөөж бүтээмжийг үнэлээд байгаа. Тэгээд энэ урамшуулах бодлого цаашдаа явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байдаг. Харин агуулгыг нь жоохон өөрчлөх ийм зайлшгүй шаардлага байгаа. Жишээлбэл газар тариалангийн бүс нутагт бол энэ аварга малчин шалгаруулаад байх шаардлагагүй. Илүү фермерийн аж ахуй, эрчимжсэн аж ахуй, илүү тариалан талдаа яваад, бусад уламжлалт мал аж ахуйтай салбартаа бол энэ аварга малчныхаа бодлогыг цааш үргэлжлүүлээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Гэхдээ болзлыг улам л нөгөө бүтээмж рүүгээ л хөшүүрэгдэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Ашиг шимээ сайжруулсан, бусдад сайн тусалж дэмжсэн, ажлын байраар хангасан тэр талын үр дүнг буюу шагнал олгох тэр шалгуурыг нэлээн чангатгахад бас зүйтэй гэдэгтэй санал нэг байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд ... уучлаарай Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Түрүүнд би нэрийг нь хасаад хаячихсан байсан. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Манай хүнс, хөдөө аж ахуйн салбар ер нь л нэг учраа олохгүй л явж байгаа ийм л салбар. Нөгөө дуунд гардаг. Жилээс жилд жижгэрсэн жаахан буурал ээж минь гэдэг шиг жилээс жилд л эдийн

засагт оруулж байгаа нөлөө, олж байгаа орлого, тэр оролцогчдын ахуй амьдралын түвшин жилээс жилд л жижгэрсэн, салбараас нь залуучууд дайжсан нэг ийм л байдалтай. Тэгээд бид нар арга хэмжээ авахлаараа төрийн дэмжлэг гэдэг. Төрийн дэмжлэг гэхээрээ баахан л зөвхөн санхүү мөнгө л ярьдаг. Бусад арга, барил, арга хэмжээ гэдэг зүйлүүд байдаггүй. Тэгээд юм хийхлээрээ уг нь бол энэ зах зээл чинь эдийн засаг чинь өөрөө эрэлт нийлүүлэлт. Эрэлтийг нь дэмжих үү, нийлүүлэлтийг нь дэмжих үү гэдэг нэг ийм 2 үндсэн бодлого байх шиг байгаа юм. Тэгэхээр бид нар ерөөсөө тэр нийлүүлэлтийн талд дэмждэг, эрэлт буюу нөгөө борлуулалт талаа орхичихдог. Тэгээд 1 ЖДҮ 9 жорын бүтээгдэхүүн нь зарагддаггүй баахан бараа бүтээгдэхүүний түүх өнгөрсөн тийм дампуурсан жижиг ЖДҮ компаниудын түүх л өнгөрсөн хугацаанд асар их. Зээлийн үр ашиггүй байдал олон зүйлүүд. Тэгэхээр би зүгээр янз бүрийн шүүмж биш. Шүүмж хэлбэл зөндөө л юм хэлж болно. Нэг ийм ажил хэрэгч нэг санал хэлэх гэсэн юм. Сая 1 Австралид явж байсан. Тэдний хүнсний бүтээгдэхүүнүүд дээр бүгдээр нь ингээд ийм 5 од рейтинг, үнэлгээ гээд байдаг юм байна лээ. 5 од дотроо 1 одыг 0.5 одоос ирэхээр ингээд 10 янзаар үнэлчихсэн. Энэ боловсруулалтын түвшин, аюулгүй байдал, хадгалалтын түвшин, гарал үүсэл, олон олон зүйлээр нь үнэлдэг. Бүтээгдэхүүн дээр нь ингээд томоор тавьчихсан. Хэрэглэгч эндээс сонголтоо хийдэг. Би яг адилхан 2 бүтээгдэхүүнээс миний авах гэж байгаа бүтээгдэхүүн хэдэн одтой вэ. 5 одтой юу, 4 одтой юу, 3 одтой юу. Сахрын агууламж, цардуул уургийн агууламж энэ жишээ нь ямарваа нэгэн эндээс мөнгө зарахгүйгээр хийж болох жишээ нь ажил. Мөнгө зарахгүйгээр. Бид нар зүгээр зохицуулалт, төрд байгаа мэдээллийн түвшинд. Тэгээд энэ үнэлгээг гаргуулахдаа дахиад хэн нэг нь төрийн албан хаагч, дарга биш, энийг тэр мэргэжлийн холбоод холбогдох байгууллагууд нь нийлээд ингээд гаргачихдаг. Бие биедээ хяналт тавиад явж болдог. Жишээ нь зөвхөн үүнээс гадна дахиад л нэг ийм жишээ нь бүтээгдэхүүний шошго дээр. Одоо энэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хамгийн багадаа Австралиас хэчнээн хувийн ингридент орц орлоо. Зөвхөн энийг гаргах чинь өөрөө үндэсний статистик, гааль, татвар, олон олон зүйлүүдийн мэдээлэл дээр нэгтгээд гаргадаг. Энэ яг бид нарт үндэсний үйлдвэрлэл гэдгийгээ яаж томъёолж байгаа юм, тодорхойлж байгаа юм. Хэдээс дээш хувийн багагүй хувийн орц орж байж энэ үндэсний үйлдвэрлэл болов. Энэ бүхэн нь хамгийн гол нь бараа бүтээгдэхүүний шошго, хаяг дээр очихоор хэрэглэгчийн сонголт дээр, тэрнээс биш бид нар улсаас зээл авчихсан, татаас өгчихсөн. Энийг чи заавал ав гэж тулгах биш энэ хэрэглэгч ингэнгүүт бид нар манай орноос орсон орц найрлага ихтэй 5 одтой, 4 одтой бүтээгдэхүүн. Энийг би авъя гэдгийг хэрэглэгч өөрөө энэ дээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.11-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултыг асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар асуулт асууна. Асуулт асуух, хариулт авах хугацаа 20 минут. Эхэлье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын цаг үеийн ажлын талаар Ерөнхий сайдын хийсэн мэдээлэлтэй холбогдуулаад иргэдээс ирсэн асуултыг асууя.

Иргэн Сарантуяа 2 асуулт асуусан байна. 1 дүгээр асуулт Шинэ хоршоо хөдөлгөөнөөр олгогдсон зээл эздэдээ хүрсэн үү. Малчдад биш сумын төвийн иргэд, аймгийн төвийн иргэд зээл авсан асуудал байгаа гэдэг мэдээлэл байна. Мөнгө угаалт болчихсон юм биш үү гэж. Энэ асуулт асуугаад шууд хариултаа аваад явах уу.

Д.Амарбаясгалан: Шууд хариулт өгье. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Иргэний асуултад хариулъя. Эздэдээ хүрсэн үү, сумын төв, аймгийн төвийн хүмүүс авчихсан гэдэг мэдээлэл байна.

Д.Амарбаясгалан: Асуулт давтахгүй, шууд хариул.

Ё.Азжаргал: Түрүүн хариулсан. Яг 2 үндсэн шаардлага байгаа. Малын А данстай малчин байгаа. Малчин иргэнд өгч байгаа. Мал бүхий иргэнд бол олгохгүй байгаа. Тийм учраас шаардлага нь бол маш тодорхой байгаа. Өнгөрсөн жилийн хугацаанд бол нийтдээ 21 аймгийн 330 сумаас ганцхан сумаас бусад 329 сумд бол зээл гарсан байгаа. Тэгэхээр ингэж өргөн хүрээгээр улс орон даяар ингэж хамарсан.

Д.Амарбаясгалан: Эзэндээ очсон юм уу, очоогүй юм уу. Аймгийн төв дээр амьдардаг иргэд авсан гэж асуугаад байна шүү дээ.

Ё.Азжаргал: Эзэндээ очсон. Аймгийн төв дээр амьдардаг иргэд аваагүй. Мал бүхий иргэд аваагүй. Энэ бол малчныхаа А дансаар нотлогдож байгаа. Баярлалаа.

Да.Цогтбаатар: 2 дугаар асуулт. Хөдөө аж ахуйн салбарын бодит үр дүн, үнэн бодит төрөх, төрөөс үзүүлж буй гэх нэрээр татаас, хүүгийн дэмжлэг, олон улсын зээл тусламжийн хөтөлбөр нэрээр халамжийн бодлого хэрэгжүүлэх болсоор удаж байна. Энэ бодлогоо өөрчилж, шинэчлэх санал санаачилга байна уу гэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Энэ Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо, Атар гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий Улсын Их Хурлаар батлагдсан бодлогыг цаашдаа тогтвортой хэрэгжүүлэх ёстой. Энэ бол салбарыг босгох ийм урт хугацааны бодлого. Өнөөдөртөө зээлийн хүүгийн дэмжлэг, татаас, урамшуулал мэтээр харагдаж байгаа боловч үүний цаана бол олон мянган ажлын байр, олон тэрбум долларын экспорт, олон тэрбум төгрөгийн импортыг дотооддоо орлодог олон үйлдвэр, аж ахуйнууд шинээр бий болж байгаа. Үр дүнтэй хөтөлбөр гэж үзэж байгаа тул энэ хөтөлбөрийг 2028 он хүртэл тогтвортой хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа.

Энд зөвхөн хүнсний хувьсгал гээд хөдөлгөөний үр дүнд 37 хувиар хүнсний бүтээгдэхүүн нэр төрөл өссөн. Үүн дотор сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл 58 хувиар, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 44 хувиар, гурил, гурилан бүтээгдэхүүний нэр төрөл 43 хувиар, мах махан бүтээгдэхүүний нэр төрөл 12 хувиар тус тус нэмэгдэж, хэрэглэгчдэд илүү олон сонголтыг бий болгосон. Газар тариалангийн салбарт гэхэд зоорины багтаамж 15 хувиар, үтрэмийн багтаамж 7 хувиар, тариалангийн талбай 13 хувиар, хүлэмжийн талбай 28 хувиар тус тус нэмэгдсэн байна. Энэ хөнгөлөлттэй зээлийн үр дүнд зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд ажлын байр 21 хувиар, дундаж борлуулалтын орлого нь 31 хувиар, дундаж цэвэр ашиг нь 32 хувиар, үндсэн хөрөнгө нь 51 хувиар, эргэлтийн хөрөнгө нь 38

хувиар, аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар төлөлт 46 хувиар, нийгмийн даатгалын төлөлт 60 хувиар тус тус өссөн гэсэн ийм статистик дүн гарч байгаа буюу салбарт хэрэгжиж байгаа бодлого үр дүнгээ өгч байгаа. Дөнгөж эхлэлийн шатад байна шүү дээ гишүүд ээ. Зарим нь энэ жилээс хэрэгжиж байна. Зарим нь дөнгөж 1 жил болж байна. Тогтвортойнхон шиг 4 жил явуулаадахъя. Бодитой үр дүн гарна. Итгэлтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Дараагийн иргэний асуулт. Иргэн Батбаатар 5 асуулт асуусан.

1 дүгээр асуулт малчдын орлого сүүлийн 4 жилд аймаг бүрээр хэдэн хувиар өссөн талаар мэдээлэл өгнө үү.

Д.Амарбаясгалан: Мэдээлэл хаанаас өгөх вэ. Малчдын орлого нэмэгдсэнтэй холбоотой асуудлаар.

Да.Цогтбаатар: Хөдөө аж ахуйн сайд байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Малчдын орлого бол өнгөрсөн жилийн дундаж орлого бол сарын 1 сая 520 мянган төгрөгийн орлоготой. Малчин өрхийн. Зардал 2 сая 100 орчим мянган төгрөгийн зардал гаргадаг гэдэг статистик мэдээг статистикийн байгууллагаас гаргаж өгсөн байдаг. Тэгэхээр орлого нэмэгдүүлэх арга хэмжээг мэдээж Хөдөө аж ахуйн яамнаас энэ олон төсөл хөтөлбөрүүдээр бол авч хэрэгжүүлээд ажилладаг юм байна лээ. Зүгээр энэ дээр нөгөө статистикийн хүн байхгүй байгаа учраас шууд хариулж болохгүй байх шиг байна. Болорчулуун даргад тоо баримт мэдээлэл байна уу. Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоод зүгээр яах вэ би статистик мэдээ аваад үзэхэд яг малчдаар дамжиж байгаа зээл шүү дээ. Зээлээр дамжсан байдлаар бол жишээ нь зарим аймгууд аймгийнхаа нийт төсөвтэй тэнцэх хэмжээний зээл, хөрөнгө оруулалтыг бол татсан тийм үзүүлэлтүүд бол байгаа. Жишээ нь Говь-Алтай аймаг орон нутгийнх нь төсөв 75 орчим тэрбум төгрөгөөр батлагдаж байхад хоршооноос зээл авсан малчдын зээлийн дүн чинь 60 гаруй тэрбум төгрөг болчихсон байх жишээтэй. Тэгээд энэ чинь өөрөө 2-3 жилийн дараа бодитой үр дүн нь гарч, орон нутгийн хэмжээнд орон нутгийн нийт бүтээгдэхүүн нь 1 хүнд оногдох малчдын хувьд бол илүү сайн үзүүлэлтүүд гарна гэж ингэж бол явж байгаа байх. Дараачийнх нь асуулт.

Да.Цогтбаатар: Их Хурлын дарга хариулчихлаа гэж үзэх үү. 2 дахь асуулт бэлчээрийн даац хэтэрсэн гэсэн мөртөө энэ хүрээнд ямар ч үр дүнтэй ажил хийсэн талаар ямар ч мэдээлэл байхгүй байна. Уриа лоозон шиг Шинэ хоршоо, Атар 4 аян зохион байгуулж байна гэж бичих нь малчдын дунд тулгамдаж байгаа асуудлыг шийдсэн зүйл байхгүй байгаад хариулт өгнө үү гэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үнэхээр бэлчээрийн даац хэтэрсэн байгаа. Одоо 25 сая толгой хонин толгойд шилжүүлснээр даац хэтрээд байна. Иймд энэ сүргийн эргэлтийг төлөвлөхөөр хэрэгжүүлэх ийм том бодлого гарсан. Энэ дээр бол хонин сүргийг 1.7 хувиар жил бүр, ямааг 1.9 хувиар, адууг 0.8 хувиар тус тус бууруулах хэрэгтэй байгаа юм. Харин үхэр сүргийг 0.5 хувиар, тэмээг 0.3 хувиар тус тус нэмэгдүүлэх ийм шаардлага байгаа. Тэгээд бэлчээр хамгаалалттай холбоотой мэдээж жилдээ

650 гаруй сая га бэлчээрийн ургамал хамгаалалтын ажил хийгдэж байгаа. Шавж, өвчин мэрэгчтэй тэмцэх ажлууд хийгддэг. Нөгөө талаар жил бүр 200 орчим гүн худаг гаргаж байна. Гүн өрмийн худаг гаргаж, бэлчээрийг усжуулж, ашиглалтыг сайжруулах ийм ажлууд хийгдэж байгаа. Гол нь бэлчээрийг энэ доройтлоос хамгаалах гол бодлого бол ерөөсөө л мал махны экспортыг л нэмэгдүүлэх. Энэ бодлогыг л улам бид нар бүх талаар идэвхжүүлж байна. Түрүүн хэлсэн сүүлийн 2 жил бид нар 600 сая долларын мах экспортолж чадлаа. Өмнө бид нар жилдээ 10-20 саяас илүү гарч үзээгүй. Энэ чинь огцом сайн өсөлт байхгүй. Энэ бол мал эмнэлгийн ажил үйлчилгээтэй шууд холбоотой. Малын вакцин, өвчнийг хяналтад аваад эхлэхээр эрүүл бүсүүдийг бий болгоод ирэхээр ингээд л экспорт нэмэгдээд байна. Тэгэхээрээ бид нар махны экспортыг улам сайжруулах 1 тэрбум долларт хүрэхийн төлөө л зохион байгуулалт хийгээд явж байна. Ингээд мал экспортод гарах тусам малчдын орлого нэмэгдэнэ. Энийгээ дагаад сүргийн бүтэц нь зөв болоод байгаа юм.

Нөгөө талаар бэлчээрээс гадна тэжээлийн таримлын бид нар эрс нэмэгдүүлж байгаа. Энэ жил гэхэд л 120-оод мянган га-д тэжээлийн таримал таригдаж байна. Илүү ашиг шимтэй, уургийн агууламж сайтай тэжээлийг, нөөцийг бий болгосноор мал сүргээ эрсдэлээс хамгаалах, нөгөө зуд болоод 8, 9 саяар нь хорогдуулдаг биш, тэжээгээд гардаг ийм чадавхыг бий болгох тэжээлийн үйлдвэрүүдийг нэлээн олноор бий болгож байна. Тэжээлийн аж ахуйнуудыг нэлээн дэмжиж байна. Ийм байдлаар хариулъя даа.

Д.Амарбаясгалан: Дараачийн асуулт.

Да.Цогтбаатар: 3 дугаар асуулт. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд зээл авсан малчдаас хэд нь эргэлтэд оруулж ашигтай ажиллаж байгаа талаар судалгаа мэдээлэл байхгүй байна. Энэ талаар тооцоо судалгаатай хариулт өгнө үү гэж байна.

Д.Амарбаясгалан: Азжаргал 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Өнгөрсөн 1 жилийн хугацаанд 2 удаа Засгийн газар малчин өрх болгондоо хүрэх ажлыг зохион байгуулсан. Оны өмнө бол Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын тушаал гарч, 330 сум, нийтдээ 652 төрийн албан хаагч оролцож, 121 шуурхай бүлэг ажилласан. Тэгээд энэ асуумж судалгааны үр дүнг та бүхэндээ танилцуулъя. Ингээд 13.500 малчин айлдаа хүрсэн. Үүнээс бол 96 хувь нь зээлийн зориулалтын дагуу зарцуулж байна. Ингээд энэ зээл маань өөрөө Хөрөнгө оруулалтын зээл байгаа. Ингээд 87 хувь нь өвөлжилтийнхөө бэлтгэлийг хангахад дэмжлэг болсон гээд иймэрхүү судалгааны үр дүнгүүд бол гарсан.

Түрүүн бас хариултдаа халти хэлсэн. Нийтдээ 8 мянган хоршоо татварын тайлан ирүүлсэн. Ингээд 402 тэрбум төгрөгийн борлуулалтын ажил хийж, 570 сая төгрөгийн татвар төлөх тайлан ирүүлсэн байгаа. Дахиад нэг юу хэлэхэд энэхүү хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан нийтдээ 490 хоршоод маань бол татварын харилцаанд орж, сайн жишиг хоршоод бий болсон. 1 зүйлийг нэмээд хэлье. Өнгөрсөн хугацаанд бол хяналт мониторингийн ажлууд бол нэлээн сайн хийгдсэн. Манай Зээлийн батлан даалтын сангийн баг бол нийтдээ 21 аймгийн 1100 хоршооны 1407 зээлдэгчийн төсөлд хэрэгжилтэд хяналт тавьж мониторинг хийж ажилласан байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дараагийн асуулт.

Да.Цогтбаатар: Бид мэдээлэл авдаггүй юм байна. Тэр мэдээлэл авах ажлаа жоохон хүртээмжтэй байдлаар хийвэл бас зүгээр байна. Та хэдэд бол өөрсөд дээр нь компьютер дээр мэдээлэл байгаад байна. Иргэд мэдээлэл байхгүй. Их Хурлын гишүүдэд мэдээлэл авч өгөөч ээ гэж хандаж байгааг бас анхаарч ажиллаарай.

4 дүгээр асуулт. Нийт малчдын дунд залуу малчдын эзлэх хувь 1992 онд 35 хувь байсан бол 2023 онд 24 хувь болж буурсан байна. Малчдын тоо толгойн өсөлт нь малын чанарын өсөлтдөө саад болж байгааг онцлоод мөн боловсруулах үйлдвэр хөгжөөгүйгээс гадна гаднын зах зээлийг түүхий эдээр хангагч хавсарга улс болж хувирлаа. Малын гаралтай түүхий эдийн үнэ унаж, хонины нэхийг гэхэд л тал хайрцаг тамхины үнэд ч хүрэхгүй байна. Үүнийг яаж шийдэх вэ. Энэ засагт ямар шийдэл байна вэ. Ер нь засагт үр дүнтэй хийсэн ажил байхгүй. Төсвийн мөнгийг үр дүнгүй зарцуулж байна гэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулах уу. Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Үнэхээр салбарт хүний нөөц дутагдаж байгаа. Нөгөө талаар Монгол Улсын эдийн засаг маш сайн тэлсэн. Үндсэндээ сүүлийн 10 жил 3 дахин тэлчихлээ шүү дээ. 90 их наядын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй болчихлоо. Үйлдвэрлэлд хүн хүрэлцэхгүй байна. Хүний ажиллах хүчний нөөц өөрөө их дутуу. Бид цөөхүүлээ байна. Тэгээд энэ зовлон бас манай салбарт үнэхээр ирж байгаа. Тэгэхээр мал аж ахуйн салбарыг үр ашигтай байлгах хэлбэрт л оруулах ийм л бодлого явуулж байна. Мал маллах нь ашигтай. Тариа тарих нь ашигтай. Ногоо тарих нь ашигтай. Амьдралын баталгаа болдог тэр бодлогыг л хэрэгжүүлнэ. Тэр бодлого маань одоо бид нарын энэ яриад байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт гэж хөтөлбөрүүд шүү дээ. Жишээлбэл, Цагаан алт хөтөлбөрийн үр дүнд бид нар ноолуураа гартаа хийгээд авлаа. Одоо энэ жил бид нар 30 мянган тонн ноос бэлдэнэ. Ноосоо 100 хувь боловсруулах ийм том ажлууд эхэлж байна. Хивсний үйлдвэрүүд, ноосон эдлэлийн үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтууд, технологийн шинэчлэлүүд сайн явагдаж байна. Зөвхөн хивсэн дээр гэхэд л 200 мянган м2 сүлжих хүчин чадал нэмэгдэж байгаа. Эрдэнэт хивс, Улаанбаатар хивс машины технологийн шинэчлэлүүд хийгдэж байна. Арьсны салбарт ч шинэ шинэ шугамууд ашиглалтад орж байна. Одоо эд угсрагдаж байна. Тэгэхээр үндэсний үйлдвэртэй байж байж л түүхий эд үнэтэй байдаг юм байна. Энэ бол ноолуур дээр харуулсан. Тийм болохоор үйлдвэрийн бодлогоо бол байнга дэмжих нь чухал. Ийм учраас энэ Цагаан алт хөтөлбөр гарсан. Энэ 1990-ээд он, 2000 оны эхээр бидний гол алдаа бол түүхий эдээ гаднын үнийн бодлогод автаж гадагшаа хэт өгсөөр байгаад дотоодын үйлдвэрлэлээ унагааж, тэнд бэлтгэгдсэн боловсон хүчин, тоног төхөөрөмжийг үндсэндээ үрэн таран болгосон. Тэгээд энэ алдааг л засах залруулах үүднээс үндэсний хөдөлгөөнүүд, үйлдвэрлэлийг дэмжих бодлогууд чинь хэрэгжиж байна. Нэлээн үр дүн гарч байна. Ажиллах хүчин бэлтгэгдэж байна. Тэгэхээр 1 зүйл дахиад л хэлэхэд нөгөө хүний нөөцийн асуудал үнэхээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тэр бодлогыг онцгой анхаарч өгөөч ээ гэдэг л хүсэл манай салбар Улсын Их Хурал, Засгийн газарт байнга л тавьж байгаа. Яагаад гэвэл манай салбараас ангид тэр хүний нөөц, боловсон хүчин бэлтгэх бодлого нь шинжлэх ухааны бодлого нь тусдаа яваад байгаа юм. Тэгээд тэр салбартаа их өгөөж муутай яваад байна. Тэрийг эргэж хараач ээ л гэж би хүсэлт тавиад байгаа юм.

Да.Цогтбаатар: Дараагийн асуулт бэлчээрийн талбай 1970-аад оныхоос 20 сая гагаар буураад байна. Нийт бэлчээрийн 40 хувь нь 1-3 дахин, 25 хувь нь 3-5

дахин, 20 хувь нь олон дахин даац хэтэрсэн гэсэн судалгаа байдаг. Нийт бэлчээрийн 78 хувь хөрсний элэгдэлд өртөж, цөлжилт эрчимжиж байна. Энэ хүрээнд хийсэн ажил Засгийн газарт байхгүй байна. Яагаад үүнийг шийдэх ажил хийхгүй байна вэ.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Үнэхээр нийт бэлчээрийн 78 хувь нь хөрсний элэгдэлд орчихсон байгаа. Үнэн. Бид нийт Монгол Улсынхаа нутаг дэвсгэрийн 1 хүрэхгүй хувьд л газар тариалан эрхэлж, бусад 99 хувьд нь бол мал аж ахуй эрхэлж байгаа. Түрүүн хэлсэн 25 сая толгойгоор малын даац хэтэрчхээд байгаа юм. Тэгэхээр ургамлын ургах, нөхөн төлжих тэр чадавх нэлээн малын тоотой холбоотой хязгаарлагдаад байгаа. Тэгэхээр энийгээ бид нар экспортын маягаар орлого олох маягаар энэ малын тоог нэлээн зохистой буулгая. Нөгөө талаас үр ашигтай малын тоог нэмье. 1 малаас авах ашиг шимийг нь сайжруулъя. Ноолуурын гарц, ноосны гарц, махны гарц, сүүний гарцыг нэмж байж. Жишээлбэл, манай дээр гэхэд 70 орчим мянган сүүний үнээ саальд ашиглагддаг юм. Энийг үйлдвэрлэг байдлыг нь сайжруулснаар 25 мянган үйлдвэрлэг үнээгээр солиход л энэ тоо толгойг энэ зохистой хэмжээнд бууруулж, нөгөө талдаа бүтээмжийг нэмэх ийм бололцоо байгаа юм. Энэ чиглэлээр яамнаас хийж байгаа тооноос чанарт шилжих, 1 малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх ийм ажлуудыг хийж байна. Нөгөө талаас энэ Глобал цаг уурын өөрчлөлт, Төв Азийн тэгш өндөрлөгт өндөрт өргөгдсөн Монгол Улсын хувьд бас нэлээн байгаль цаг уурын нөлөөлөл их өндөр гараад, дулаарал нэмэгдээд, ган, зудын давтамж нэмэгдээд, ингээд уламжлалт мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд жоохон эрсдэлүүд учирч байгаа. Энийг хамгаалах гол арга бол газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх, тэжээлийн таримлын нэмэх, тэр тэжээлийн нөөц баазыг өргөтгөх. Тэгж байж энэ байгаль цаг уурын бэрхшээлийг нүүдлийн мал аж ахуйгаа даван туулахад газар тариалангаа холбож тусалж, хамтарч ажиллах ийм зайлшгүй шаардлага байгаа. Энэ чиглэлээр бодлогын үйл ажиллагаанууд бол хийгдээд явж байна.

Да.Цогтбаатар: Дараагийн иргэний асуулт. Улаанбаатар хотын хүнс, махны эрүүл ахуйг сайжруулах тал дээр ямар шийдэлтэй байгааг Энхбаяр сайдаас асууж өгөөч ээ гэж байна.

Ж.Энхбаяр: Яамнаас зохицуулалтын арга хэмжээнүүдийг л ээлж дараалан авч л байна. Жишээлбэл махан дээр гэхэд зөвхөн үйлдвэрийн аргаар хэрэгцээлсэн махыг 8 нэрийн уламжлал дэлгүүрүүдэд худалдаалах ийм техник зохицуулалтыг баталсан. Энийг энэ жилээс мөрдүүлэх ажлууд хийгдэж байна. Тэгээд аажим боловч та бүхэн анзаарч байгаа бол дэлгүүрүүд үндсэндээ бүгд ангилсан мах зардаг болж байгаа юм. Гулуузаар нь гэдэг юм уу, хээрийн бой хийдэг хэмжээ эрс багасаж байгаа. Нөгөө махны экспорт нэмэгдээд бид нар энэ олон 100 сая долларын мах экспортлоод байгаа гэдэг чинь үйлдвэрээр нядлагддаг малын тоо нэмэгдээд байна гэсэн үг. Тэгэхээр үйлдвэрээрээ нядлагдсан мах их сайжраад байна. Юуны тоо нь гэнэ.

Да.Цогтбаатар: Энэ Улаанбаатар хотынхоо хүнсний хэрэгцээг яаж хангах вэ. Технологийг бол ойлгоод байна.

Ж.Энхбаяр: Одоо хүнсний хэрэгцээг мал аж ахуй, газар тариалан суурь салбараасаа л хангаж байна. Импорт өндөр байна. Импортыг л буулгах бодлого явж

байна шүү дээ. Тэгэхээр яаж хангах вэ гэдгийг нь би сайн ойлгохгүй болоод байна л даа.

Да.Цогтбаатар: Иргэнээс ирсэн асуулт нь Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээг яаж хангах вэ л гэж байгаа юм. Яг хэдэн үйлдвэр Улаанбаатар хотыг тойроод байна гэдэг ч юм уу.

Ж.Энхбаяр: Ер нь төвийн бүсэд хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэлийн 99 хувь нь байгаа. Энэ бүсэд л гол нөгөө газар тариалангийнхаа нөөц дээр тулгуурлаад л гол үйлдвэрлэл, хүний нөөц, дэд бүтцээ дагаад энэ төвийн бүсэд Улаанбаатар хотод төвлөрсөн байгаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хүнсний хэрэгцээ хангалттай, тогтвортой, сонголттой, хүртээмжтэй байгаа. Хүнсний хангалт дээр ямар нэгэн эрсдэл гараагүй. суудал үүсээгүй байна.

Да.Цогтбаатар: Ерөнхий сайдаас 1 асуулт. Хөдөө аж ахуйн экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр танай Засгийн газар юу хийх вэ. 2024 оны 6 сарын 5-нд Малчин өрхийн нэгдсэн холбооны буюу Мөн холбооны хуулийг баталсан. Энийг хэрэгжүүлэх чиглэлд бас ямар ажил хийж хэрэгжүүлэх вэ.

Г.Занданшатар: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт гадаад зах зээлийг нээж өргөтгөх шаардлагатай. Гадагшаа мал махны экспорт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нээхийн тулд малыг эрүүлжүүлэх бодлого тууштай хэрэгжиж, дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага болон олон улсын стандартаар сүүлийн 2 жилд бас өвчлөл эрс буурсан, гараагүй, вакцинжуулалтын чанар сайжирсан. Энэ малаа эрүүлжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж байж махны экспорт нэмэгдэнэ. Энэ дотроо бол би дээр дурдсан Евро-Азийн гишүүн 5 орны зах зээл бол 12 тэрбум долларын мал, мах, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн импортоор авдаг гэсэн ийм зах зээлийн боломж байна гэж үзэж байгаа. Энд өрсөлдөхөд бид 20 хувьд нэвтрэхэд 2.4 тэрбум долларын шинэ зах зээл гадаадад нээгдэж байна. Хамгийн гол нь дотооддоо бид үйлдвэрлэлийн хүчин чадал, олон улсын стандарт, техникийн зохицуулалтыг хангах чадавхтай эрүүл малтай үйлдвэрлэлийн чадавхаа сайжруулах ёстой. Ингэж чадвал бид малчдын орлого ч нэмэгдэнэ, үйлдвэрлэлүүдийн хүчин чадал ч сайжирна. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Уг асуудлын асуулт асуух 20 минутын хугацаа дууссан байна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай асуулт асууна.

М.Мандхай: Шинэ хоршоог дундын хоршооны хөгжүүлэх чиглэлээр нэмэлт зээл гарах уу. Хэзээнээс эхлэх вэ гэсэн асуулт байна. Эхний асуулт.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр.

Ё.Азжаргал: Мандхай гишүүний асуултад хариулъя. Одоо байгаа хоршооны гишүүн малчны зээл гээд энэ бүтээгдэхүүн маань бол санхүүгийн ерөнхий гэрээгээрээ зохицуулагдаж байгаа. Энэ гэрээгээрээ бол малчинд зээл гарахаар зохицуулагдсан. Одоо шинэ хоршоо хөдөлгөөний дараагийн үе шат болох дундын хоршооны зохион байгуулалтад оруулж байгаа энэ үе шатыг хийхийн тулд зайлшгүй

санхүүжилтийн ерөнхий гэрээндээ нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Ингээд арилжааны банкнуудтайгаа зөвлөлдөөд, арилжааны банкнууд бол эх үүсвэр боломжтой гэдэг ийм хариуг өгсөн. Ингээд одоо бэлтгэл ажил судалгааг хийгээд, дараагийн үе шат руу оруулах ийм ажлыг зохион байгуулна. Баярлалаа.

М.Мандхай: 2 дахь асуулт. Үйлдвэрийн аргаар махны хэдэн хувиа хангаж байгаа вэ. Гар аргаар хэдэн хувиа хангаж байна вэ. Махны техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа махны үйлдвэрийн аргаар хэзээнээс бүрэн бэлтгэдэг болох вэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр Болорчулуун.

Д.Довчинсүрэн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн байна. Мандхай гишүүний асуултад хариулъя. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр худалдааны техникийн зохицуулалт 2023 оны 1 сарын 1-ээс сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хоол үйлдвэрийн үйлчилгээнд бол хэрэгжээд бол эхэлчихсэн. Сая 2025 оны 1 сарын 1-ээс бүх нийтээр махны худалдаа болон заавал үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах махан бүтээгдэхүүн байна гээд заагдсан байгаа. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ энэ суурь түвшин 2024 оныг бодвол энэ жил бол 15 хувиар бол нийслэлд нэмэгдсэн байгаа.

М.Мандхай: Дутуу л хариулчих шиг боллоо. Махны техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа махаа үйлдвэрийн аргаар бүрэн бэлтгэдэг болох уу гэж байна. Тэгээд гар аргаар хэдэн хувиа хангаж байгаа вэ гэж асуусан асуулт байсан. Тэгээд нэмээд бас хариулчихна биз. Хөдөө аж ахуйн салбарт төрөөс олгож байгаа урамшуулал татаас сүүлийн 30-аад жил олгож ирлээ. ДНБ-д эзлэх хувь буурсан, импортын хүнсний хараат байдал нэмэгдсэн, идэж байгаа хүнс нь хортой, баталгаагүй, үнэтэй байна. Энэ чөтгөрийн тойргоос хэзээ гарах вэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ 30 жил ийм урамшуулал яваагүй л дээ. Сүүлийн жилүүдэд энэ үндэсний хөдөлгөөн гаргаж, энэ хүнсний аюулгүй байдлаа хангахгүй бол дотоодын үйлдвэрлэлээ сэргээхгүй бол ер нь гадаад хамаарал эрс нэмэгдэж байна. Хүнсний чанар аюулгүй байдлын асуудал дордож байна гэж үзээд энэ хүнсний хувьсгал хөдөлгөөн анх Монгол Улсын Төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн санаачилгаар ингээд хэрэгжээд эхэлж байна. Ахиц дэвшил үнэхээр гарч байна. Та бүхэн дэлгүүр хоршоонд ороод үзээрэй. Дотоодын хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл эрс өссөн. 52 үйлдвэр, хүнсний үйлдвэр нэмж ашиглалтад орлоо. 400 гаруй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн бий боллоо. Манайхан бас нэг үеэ бодвол үйлдвэрлэдэг, тарьдаг, ургуулдаг, бүтээдэг болж байна. Аль болох л хүнсний хамаарлын багасгах энэ бодлогыг л бид хэрэгжүүлж байна. Тэрний төлөө л энэ салбар ажиллаж байна. Тэгэхээр үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна. Одоо байгаа явцын үр дүн хөнгөн үйлдвэр дээр мал, мах дээр ч тэр, арьс шир, ноос ноолуур дээр ч тэр, хүнсний бүтээгдэхүүн дээр ч тэр, үр тариа, тэжээлийн таримал дээр ч тэр дандаа ахиц гарч байгаа. Нэр төрлүүд байнга нэмэгдэж байгаа. Экспортын шинж чанартай болж байгаа. Бид махаа сайхан экспортолж байна. Үр тарианы экспорт төрлийн таримлын экспорт 100 сая долларт хүрэхээр болж байна. Ноос ноолуур, арьс шир, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлүүд үйл

ажиллагаагаа явуулж байна. Бэлэн боловсруулсан хүнсийг түрүүчээсээ манайхан экспортод гаргадаг болж байна. Салбар ер нь бодлогын хувьд, үйл ажиллагааны хувьд, үндсэн чиглэлийн хувьд ер нь эрс өөрчлөгдсөн. Ер нь ахиц их сайн гарч байгаа.

М.Мандхай: Бэлчээрийн талхлалд, сум, аймаг дундын бэлчээрийн газрын маргаан нэмэгдсээр байна. Бэлчээрийн тусгайлсан хууль батлагдахгүй явж ирсэнтэй холбоотой гэж боддог. Энэ хууль батлагдах уу гэж асууж байна.

Ж.Энхбаяр: Их Хурлын л бүрэн эрхийн асуудал байх даа.

М.Мандхай: Бэлчээрийн тухай хууль батлагдах уу гэж асууж байна.

Ж.Энхбаяр: Бид батлуулахын төлөө салбарын хуулийг боловсронгуй болгох асуудлуудыг гишүүдтэй хамтраад өргөн бариад явж байна. Хөдөө аж ахуйн суурь хууль, Хүнсний хууль, Хүнсний аюулгүй байдлын хууль. Ингээд Малын хөлийн татварын хууль гээд олон хуулиуд бид нар боловсруулаад, өргөн барьсан. Тэгээд Улсын Их Хурлын хэлэлцүүлгээр л эцэслэн шийднэ шүү дээ. Батлахын төлөө салбар явж байгаа.

Д.Амарбаясгалан: Иргэдээс ирүүлсэн асуултыг асууж, хариулт авч дууслаа.

Нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

15.56 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байгаад санал хураалт хойшилсон. Үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ардын намын бүлгийн хурал арай дуусаагүй байгаад байна уу. Төсвийн байнгын хорооны хурал дуусчихсан. Бүлгийн хурал дуусчав уу. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Үг хэлэх гишүүд үг хэлсэн. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүдийг танхимд дуудъя. Намын бүлгүүдийн хурал дууссан байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Хурууныхаа хээг уншуулъя. Санал хураалт явагдана. Гишүүд ээ, санал хураалтдаа бэлдээдэхье. Төсвийн хүрээтэй холбоотой 2 санал хураалт хураагаад, тэгээд дараачийнхаа асуудал руу орох гээд байна.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 52 гишүүн бүртгэгдсэн байна. Санал хураалт ердийн олонхоор.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Наранбаатар гишүүн хурууныхаа хээг уншуулъя. Санал хураалт. 59 гишүүн дэмжиж, 59.6 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57 гишүүн буюу 57.6 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

16.05 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинээр бүрдсэн Монгол Улсын Засгийн газар төсвийн сахилга бат, ил тод байдал, нэгдмэл байдлыг чанд сахих, зардлаа танах, төрийн бүтцийг цэгцэлж цомхон чадварлаг болгон бэхжүүлэх хариуцлагын тогтолцоог чангатгахаас ажлаа эхэлж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллаж эхлээд байна.

Энэ хүрээнд улсын эдийн засагт тулгараад буй сорилт эрсдэлийг тооцож үзсэний үндсэн дээр Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны төсөвт хийх хэмнэлтийн тодотголыг боловсрууллаа.

Шинэчлэн боловсруулсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн энэхүү төсвийн тодотголыг боловсрууллаа.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын хариуцлагатай албан тушаалд томилогдож, Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж эхэлснээс хойш ердөө 7 хоног өнгөрч байна. Энэ 7 хоногийн хугацаанд геополитикийн сэргэлдөөн мөргөлдөөн улам даамжирч, Иран-Израйлын зэвсэгт мөргөлдөөнөөр өргөжиж, дэлхийн эдийн засгийн төлөв байдалд эрсдэл нэмэгдлээ. Нүүрсний үнийн огцом уналтаас голлон шалтгаалж төсвийн орлого 3.2 их наяд төгрөгөөр тасрах бодит нөхцөл байдал үүссэн байна. Яг 7 хоногийн өмнө танилцуулж байхад нүүрсний үнийн төлөв байдлаас шалтгаалсан төсвийн тодотгол, төсвийн орлогын бууралт 2.3 их наяд гэж тооцогдож байсан бол 7 хоногийн дотор ийм өөрчлөлт гарч байна. Энэ нөхцөл байдал цаашдаа ч даамжирч болзошгүй байна. Хэрэв төсөвт яаралтай тодотгол хийж, төсвийн үр ашиггүй зардлуудыг танаж, тэвчиж болох урсгал зардлуудаа танаж, импортыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахгүй тохиолдолд инфляц улам эрчимжиж, валютын ханш суларч, улмаар энэ нь иргэдийн аж амьдрал, хувийн хэвшил, баялаг бүтээгчдийн хэвийн үйл ажиллагаанд томоохон эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Тухайлбал, төсөвт тодотгол хийхгүй, төсвийн алдагдал оны эцэст 3.2 их наяд төгрөгт хүрсэн тохиолдолд импортын хэмжээ нэмэгдэж, валютын ханш суларч, инфляц үргэлжлэн өсөх эрсдэлтэйг бодит тооцоолол харуулж байна. Олон улсын байгууллагын судалгаагаар Монгол Улсын өрхийн орлого нэмэгдээгүй тохиолдолд үнийн өсөлт, инфляц 1 хувиар нэмэгдэхэд 24 мянга орчим хүн ядууралд өртөх эрсдэлтэй гэж тооцсоныг энд онцлон дурдмаар байна. Өөрөөр хэлбэл инфляц 10 хувиар нэмэгдэхэд 240 мянган хүн амьжиргааны баталгаажих түвшин ядуурлын түвшнээс доогуур орлоготой болох ийм эрсдэлтэй нөхцөл байдал үүсдэг гэж үздэг.

Иймээс эдийн засгаа тогтворжуулж, иргэдийнхээ орлого, амьжиргааг хамгаалах нь Засгийн газрын эн тэргүүний чадавх чансааг шалгасан чухал сорилт болоод байна. Дэлхийн эдийн засгийн нэн эгзэгтэй цаг үед дэлхийн улс орнууд ч гэсэн өөрийн эдийн засгийн онцлог бодлогодоо тохируулсан шаардлагатай тохиргоо, өөрчлөлтүүдийг хийж байна. Тухайлбал, Оросын Холбооны Улс, Бразил, Чили, Өмнөд Африк, Саудын Араб зэрэг түүхий эдийн экспортоос хамааралтай улсууд түүхий эдийн үнийн огцом уналт, геополитикийн хурцадмал байдалтай уялдуулан төсөвтөө тодотгол хийж, эдийн засгаа тогтворжуулах чиглэл баримталж байна.

Ингэхдээ орлогоо дайчлах, зардлаа бууруулах, төрийн албан хаагчдын тоог зохистой түвшинд бууруулах арга замыг сонгож, үр ашиггүй, тэвчиж болох зардлаа танаж, татаас шилжүүлгээ бууруулж, нийгмийн халамжаа оновчтой болгох, хөрөнгө оруулалтын төслүүдээ эрэмбэлэх зэрэг арга хэмжээнүүдийг олон улсын түвшинд дэлхийн улс орнууд авч хэрэгжүүлж нэгэнт эхлээд байна. Ийм учраас Монгол Улсын хувьд ч гэсэн төсвийн нэн шаардлагатай бодлого арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл төсвийн тодотгол хийх зайлшгүй шаардлага үүсэж гарлаа.

Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас нэн хамааралтай. Монгол Улсын экспортын 95 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай. Энэ эдийн засаг маань түүхий эд буюу уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн үнийн өөрчлөлт эмзэг цочмог хэвээрээ байна. Бид эдийн засгаа солонгоруулах, экспортоо төрөлжүүлэх талаар олонтоо ярьж халамжаас хөдөлмөрт, импортоос экспорт, экспортод зэрэг олон уриа лоозон дэвшүүлдэг боловч уул уурхайн бүтээгдэхүүний

үнэ өндөр, мөчлөг дагасан бодлогын үед мөчлөг сөрсөн төсөв, эдийн засгийн бодлогоо өргөжүүлж, энэ эдийн засгаа солонгоруулах талаар бодитой арга хэмжээ хэрэгжүүлж чадахгүй байсан нь өнөөдрийн эдийн засгийн энэ эмзэг байдлыг бас улам нэмэгдүүлж байна.

Бидний хувьд нүүрсний экспорт үргэлжлэн буурах, шатахууны үнэ нэмэгдэх, төсвийн орлого тасалдах, гадаад валютын нөөц багасах зэрэг эрсдэлийн түвшин энэ бүхнээс шалтгаалан эрс нэмэгдлээ. 2025 оны төсвийг баталж байх үед нүүрсний үнийг 105 ам.доллараар төсөөлж байсан бол хөрш орнуудын аж үйлдвэрийн салбарын идэвхжил саарч, нүүрсний үнэ өнөөдрийн байдлаар 40 гаруй доллароор буурч ойрын 1, 2 жилдээ энэ түвшиндээ хадгалагдахыг олон улсын банк санхүүгийн байгууллагууд сануулж байна.

Орос-Украины дайн Европ руу чиглэсэн манай худалдаа экспортын гацаа түгжрэл арилах нааштай хандлага ойрын үед ажиглагдахгүй байна. Ийм тодорхой бус нөхцөл байдалд монголчууд бид орлогоо дайчлах, зарлагаа тэвчих болон нөөцөө дайчлахаас өөр гарц бидэнд байхгүй байна. Ингэлээ гээд үүссэн энэ хүндрэл бэрхшээлийг эгэл ард түмэн, хувийн хэвшил, баялаг бүтээгчдийнхээ нуруунд үүрүүлж таарахгүй. Ийм учраас үнийн эрс өсөлтийг бага боловч тодорхой хэмжээгээр аль болох ахиухан бууруулж, ард иргэд хувийн хэвшлийн нуруун дээр дарамт аль болох бага учруулах замыг сонгож, Монгол Улсын Засгийн газар, төр өөрөө бүсээ чангалах хувилбарыг сонгож байна.

Төсвийн зардлыг хэмнэж, бүтэц бүрэлдэхүүнээ цомхотгох нь дан ганц эдийн засгийн шаардлага бус Монгол төрийн баримтлах ёс зүйн хэм хэмжээний нэгэн илэрхийлэл гэж үзэж байна. Төрийн бүтцийг тооноос чанарт шилжүүлэхдээ төсвийн зарлагыг механикаар танаж, тайрах биш, дунд хугацааны төсвийн тогтвортой байдалд чиглүүлэх бодлогыг Засгийн газар баримталж байна. Энэ бол төрийн бүтээмж, үр ашгийг сайжруулах томоохон шинэчлэлийн эхлэл болно гэдгийг онцлон тэмдэглэе.

Ингэснээрээ бид төрийн бүтээмжийн шинэчлэл, төрийн чадамжийн шинэчлэлийг хэрэгжүүлж, ард иргэддээ ээлтэй ойрхон, тэднийгээ сонсдог, үйлчилдэг төр байх, төрийн албаны шинэчлэлийг бас давхар хэрэгжүүлэхийг зорьж байгаа гэдгээ бас онцлон тэмдэглэж байна. Энэхүү шинэчлэлийг дараах 2 үндсэн хэлбэрээр хэрэгжүүлнэ.

1 дүгээрт. Хэмнэлтийн тодотголоор цомхон чадварлаг бүтээмжтэй төрийн алба бий болгох шинэчлэлийг эхлүүлж байна. Монгол Улсад төрийн албан хаагчдын тоо 2024 оны байдлаар 230 мянгад хүрсэн нь манай улсын нийт хүн амын 6.5 хувь, ажиллах хүчний 16 орчим хувьтай тэнцэж байна. Энэ тоо нийт хүн амын өсөлт, төрийн үйлчилгээний цар хүрээ, хүртээмж, бодит байдлаас хамаардаг нь үнэн. Гэхдээ зохистой түвшинд байх учиртай. Олон улсын стандарт, олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан тооцоо судалгаатай харьцуулахад манай төрийн алба харьцангуй өндөр, ижил түвшний хөгжиж байгаа орнуудаас бол өндөр байна гэж дүгнэж болно. Энэ шалгуурыг бид хангаж чадаж байгаа юу, үгүй юу гэдгийг төр өөрөөсөө асуух цаг нэгэнт болсон гэж үзэж байна. Америкийн Нэгдсэн Улс, Солонгос, Киргиз, Тунис, Франц, Чили, Эстони болон Швед зэрэг дэлхийн олон улс орнууд төрийн бүтэц, бүрэлдэхүүн, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, төрийн албан хаагчдын тоог зохистой түвшинд хүргэх, төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчдын үнэлгээг боловсронгуй

болгоход онцгой анхаарч байна. Тухайлбал, сул орон тоонд хүн нэмж авахгүй байх, төрийн үр дүнгүй албан тушаалуудыг арилгах, цахимжуулах, төрийн албанаас хувийн хэвшилд үе шаттай шилжүүлэх, цалин хөлс, тусламж, урамшууллын бодлогоо сайжруулж, оновчтой болгох зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тиймээс бусад улс орны туршлага, сургамжийг судалж, төрийн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг салбар бүрд хянан шинжилж, хийдэл давхардлыг арилгах шинэчлэлийг эхлүүлж байна. Төрийн албан хаагч тогтвортой мэргэшсэн байх зарчимд нийцүүлж, төрийн албаны бүтээмж, үр ашиг, цалин урамшууллын тогтолцоог цаашдаа улам боловсронгуй болгоно.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй нийцүүлэн багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар хэмнэлтийн тодотголд тусгалаа. Энэ хүрээнд дарга нарын тоог бууруулах, тэтгэвэрт гарсан эсвэл сул орон тоонд хүн авахгүй байх, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, давхардал, хийдлийг арилгах, төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, мөн тогтвор суурьшилтай ажиллуулах гэх мэт арга хэмжээг авснаар төсвийн зардлыг 300 гаруй тэрбум төгрөгөөр бууруулна гэж тооцлоо. Төрийн албан хаагчдын тоог бууруулах нь төр түмнийхээ төлөө зүтгэж буй хувь хүн, айл гэрийн амьдралд тийм ч таатай нөлөө үзүүлэхгүй. Төсвийн хэмнэлтийг төрийн албан хаагчдаа ажил амьдралаар нь хохироох замаар хийж болохгүй гэсэн шүүмжлэл ч гарч байгаа. Гэхдээ төрийн алба гагцхүү ур чадвар, мэдлэг туршлагад суурилсан, цомхон, бүтээмжтэй, бүтээмж өндөртэй, төрийн албан хаагчдын ажлыг бодитой үнэлдэг байх зарчимд бид олон жил ярьсаар ирсэн. Төрийн албаны үнэлгээний журам Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр батлагдсан. Энэ маань бас олон түмэнд нээлттэй, ил тод болгодог, үнэлдэг зарчимд нийцүүлэхээр бид төлөвлөж байгаа. Ийм учраас төр ард түмний харилцан итгэлцлийг бэхжүүлж, төрийг ард түмэндээ ээлтэй, ард иргэдээ сонсдог, ард түмэндээ үйлчилдэг болгон шинэчилж хөгжүүлэхэд манай төрийн албан хаагчдын өөрсдийн манлайлал чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна. Ийм учраас энэ ажлыг яг одоо эхлэх нь Монгол Улсын эрх ашигт нийцнэ гэдэгт бид итгэж байгаа.

Хувийн хэвшил баялаг бүтээгчдийнхээ хувьд ажиллах хүчний дутагдал бол хамгийн тулгамдсан асуудал болоод байгааг холбогдох төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн илэрхийлж байгаа. Иймээс төрийн албан хаагчдын орон тоог бууруулах бодлого нь хувийн хэвшилд тулгамдаад байгаа ажиллах хүчний дутагдлыг нөхөх бодлоготой нягт уялдуулж, цогц байдлаар хэрэгжих ёстой. Энэ чиглэлээр бид Худалдаа аж үйлдвэрийн танхим, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахаар тохирч, ажиллах хүчний дутагдлыг нөхөх чиглэлээр хамтран ажиллахаар тохирсон. Өөрөөр хэлбэл бүтцийн өөрчлөлтөд хамрагдсан төрийн албан хаагчдаа Засгийн газар гудамжинд гаргаад хаяхгүй. Хувийн хэвшлийн бэлэн ажлын байранд зуучлах, сургаж мэргэшүүлэх зэрэг тодорхой арга хэмжээг Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, хувийн хэвшилтэйгээ хамтран хэрэгжүүлнэ. Засгийн газар хувийн хэвшил, баялаг бүтээгчидтэйгээ хамтран ажиллаж, шаардлагатай байгаа ажлын байранд төрийн албан хаагчдыг зуучлан шилжүүлэх бодлогыг бас хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр бусад байгууллага, хувийн хэвшил, баялаг бүтээгчид, мэргэжлийн холбоодтойгоо нягт хамтран ажиллах болно. Мөн төрийн бүтцийг цэгцлэх зорилтыг хэрэгжүүлэхдээ төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг хатуу баримтална. Энэ хүрээнд төрийн ажил, үйлчилгээг цахимжуулах, инновац, хиймэл оюун ухаан нэвтрүүлэх,

бүтээмжийг сайжруулах чиглэлээр Сингапур, БНСУ, Япон, Малайз зэрэг орнуудын шилдэг туршлагыг үе шаттай нэвтрүүлэхээр тооцож байна.

2 дугаарт эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшилд суурилсан тогтвортой, хүртээмжтэй, дархлаатай эдийн засгийг хөгжүүлэх бодлогын шинэчлэлийг эхэлж байна. Энэ шинэчлэлийн үр дүнд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бий болох учиртай. Төр чадварлаг бүтээмжтэй болж, эдийн засаг дахь төрийн оролцоогоо бууруулснаар хувийн хэвшилд тулгуурласан үр ашигтай, хүртээмжтэй, дархлаатай, тогтвортой эдийн засгийн тогтолцоог төлөвших үүд хаалга нээгдэнэ. Хувийн хэвшлийг дэмжих хамгийн бодит алхам энэ мөн гэсэн 2 дахь үнэн, бодит байдал энэ юм. Хувийн хэвшил баялаг бүтээгчдэдээ дэмжих шинэчлэлийн дараагийн том алхам бол төрийн өмчит компаниудад хийх цогц реформ, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулсан татвар нийгмийн даатгалын цогц шинэчлэл байх болно. Цаашид уул уурхайн салбараас хэт хамааралтай, эмзэг эдийн засгийн бүтцээ төрөлжүүлэх, аж үйлдвэржилтийг тууштай дэмжих, экспортын зах зээл, гарцыг төрөлжүүлэх ажлыг бид бодитой, үр дүнтэй эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа Зүүн Өмнөд Ази, Дундад Ази болон Төв Ази болон Европын улс орнууд руу чиглэсэн экспортын гарцыг өргөтгөх, худалдааны саад тотгорыг арилгах, өнгөрсөн хугацаанд байгуулсан гэрээ хэлцлээ үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг анхаарах ёстой. Дээрх орнуудад мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний 15 орчим тэрбум долларын зах зээл байна. Энэ нь Монгол Улсын хувьд зайлшгүй нэвтрэх шаардлагатай зах зээл. Энэ чиглэлээр бид хувийн хэвшил үйлдвэрлэгчдээ дэмжиж ажиллах болно. Иймд хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэл, мэдээллийн технологи, аялал жуулчлал зэрэг салбарт хэрэгжүүлж буй бодлого, төсөл хөтөлбөрүүдийн бодит үр дүнд онцгой анхаарч, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр зорилтот бодлогоо хэрэгжүүлж ажиллана.

Дашрамд дурдахад зуны дэлгэр цаг ирж, аялал жуулчлалын улирал эхэлж байгаа энэ цаг үед төр засаг, түмэн олон маань нэг зүгт харж, үр дүнтэй бодлогоор гаднын жуулчдыг татах, бүтээлч үйлчилгээ, үйлдвэрлэлд нэвтрүүлж, чанар хүртээмжээ эрс сайжруулж эх орондоо валютын урсгал нэмэгдүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд нийт хувийн хэвшлийнхэн, ард иргэддээ уриалж байна.

Эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс төсвийн хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа. Үүний зэрэгцээ нэгэнт хэрэгжиж эхэлсэн хөтөлбөр, арга хэмжээг хэмнэлтийн горимд шилжүүлж, хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр арга хэмжээний зардлыг царцаахаар тооцлоо. Үүн, 1 дүгээрт төсөвт байгууллагуудын түлш халаалтын тарифыг нэмэгдүүлэхээр 2025 оны төсөвт туссан зардлыг 121.9 тэрбум төгрөгөөр,

2.Төрийн тусгай байгууллагуудаас бусад бүх шатын төсвийн байгууллагуудын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэл, хурал зөвлөгөөний зардлыг 28.9 тэрбум төгрөгөөр,

3.Төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр,

4.Бүх шатын төсвийн байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардлыг 104.4 тэрбум төгрөгөөр,

5-д төсвөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасыг 76.8 тэрбум төгрөгөөр,

6-д байгууллагаас олгох 1 удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшууллыг 30.2 тэрбум төгрөгөөр,

7-д бүх шатны төсвийн байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлыг 617.3 тэрбум төгрөгөөр хэмнэхээр тооцлоо.

Ингэснээр төсвийн зардал 1 их наяд 508.4 тэрбум төгрөгөөр буурна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг дуусгаж, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг зогсоох зохицуулалтын хүрээнд Засгийн газар 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Төсвийн хэмнэлтэд тооцох тухай тогтоол гаргасан. Энэ тогтоолд туссан 535.9 тэрбум төгрөгийг нэмж тооцвол нийтдээ 2 их наяд 44.2 тэрбум төгрөгөөр төсвийн зардлыг бууруулж байна.

Мэдээж төсөв нэмэгдэх сайхан, зарцуулах сайхан. Төсөв хэмнэх, зардал бууруулах хэцүү. Аливаа реформ тодорхой өвдөлт, шок өгнө. Гэхдээ ингэхээс өөр аргагүй байгааг манай яам, салбарууд, төрийн албан хаагчид ойлгож хүлээж авна гэж итгэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Хэмнэлтийн тодотгол нь төсөв мөнгөний бодлогын уялдааг сайжруулж, төлбөрийн тэнцэлд учирч болзошгүй дарамтыг 400-500 сая доллароор бууруулж, Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтворжуулах, үнийн өсөлтийг саармагжуулах, валютын ханшийн өсөлтийг бас сааруулах, эдийн засгийн тогтвортой байдал, ард иргэдийн амьжиргаа, баялаг бүтээгчдийн хэвийн үйл ажиллагаанд зохих эерэг нөлөө үзүүлнэ гэж итгэж байна.

Энэхүү тодотгол нь эдийн засгийг тогтворжуулж, дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсөх суурийг тэлэхийн зэрэгцээ гадаад орчинд манай улсын нэр хүнд, зээлжих зэрэглэлийг хамгаалах, баталгаажуулахад давхар чиглэж байгааг онцлон тэмдэглэе.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх алдагдалтай болж байна. Эдгээр төсвийн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангаж байгаа болно.

Иймээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцууллаа. Одоо төсвийн төслийн талаарх Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах 3 шаардлагыг хангасан эсэхэд аудит хийж, дүгнэлтээ танилцуулж байна.

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2025 онд 44.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд нийцэж байна.

2.Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 3 хувиар нэмэгдэх, 34.1.4-д төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх гэж тус тус заасныг үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Уг төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 30 их наяд 209.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.6 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 31 их наяд 575.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.1 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувь байхаар төлөвлөжээ.

Мөн нэгдсэн төсвийн суурь зарлагыг 28 их наяд 401.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 1 их наяд 808.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2 хувийн ашигтай байхаар тооцсон байна. Дээр дурдсан төсөвт тодотгох суурь үзүүлэлтээс харвал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан дээрх өөрчлөлтүүд нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж байна.

Улсын Их Хурлаас энэхүү төслийг хэлэлцэж шийдвэрлэхдээ дараах асуудлыг анхааралдаа авч, Засгийн газарт чиглэл өгөхийг санал болгож байгаа. Үүнд:

1.Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус, эрсдэлтэй байгаа учир уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах.

2.Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албан хаагчдын тоог 9 хувь бууруулахаар заасныг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан энэ оны 2 дугаар хагасаас хэрэгжүүлж эхлэхээр тооцсон нь бодлогын хувьд зөв боловч ажлын байрны чиг үүргийн давхардал, ажлын ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа орон тоонд жигд бууруулах нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулж болзошгүй байна. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломжийг олгох асуудлыг судалж үзэх.

3-д нь төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг шууд бууруулах биш ажлын бүтээмжээс хамаарсан нэмэгдэл урамшуулал болон хуульд заасан нэмэгдэл, үндсэн цалин гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй болгох зэргээр бүтээмж, үр дүнд чиглэсэн цалин хөлсний тогтолцоог бий болгох чиглэлээр судалгаа тооцоолол хийж, зохион байгуулалтын арга арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4-д нь “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заажээ. Энэ нь чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байгааг анхаарах.

5-д нь төрийн нууцад хамаарах байгууллагууд болон орон нутгийн төсвийн байгууллагын орон тоог оруулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад төрийн албаны тухай хуулийн 62.1.4-д заасны дагуу олгох 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмжийн дүнг дунджаар тооцоолж үзэхэд 26.8 тэрбум төгрөгийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн үед хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох шаардлагатай байна. Ингэснээр Улсын Их

Хурлаас хууль батлагдаж, хэрэгжилтийг хангахад төсөв захирагч нарт тулгарах хүндрэлээс сэргийлж чадах юм.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатын стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх тохиолдлууд байнга гарч байгааг анхааралдаа авч, аудитын дүгнэлт гарган Улсын Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг төсвийн тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай байгааг анхааралдаа авахыг хүсье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн гишүүн Амаржаргалын Энхбат танилцуулна. Индэрт урьж байна.

А.Энхбат: Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Юуны өмнө Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг та бүхэнд танилцуулахтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгч байгаа дүгнэлтийг товч танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

1.Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл болон нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2027-2028 оны төсвийн төсөөллийн талаар:

Төсвийн бодлогын чиглэл бодит байдалд нийцэх хандлагатай болж байна. Энэ нь өнгөрсөн жилүүдэд хэт тэлсэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлахад чиглэж, дэлхийн нийтийн болон Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай нийцсэн гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үзэж байна.

Хямралтай гэж тооцсон үеийн ДНБ-ий бодит өсөлт нэрлэсэн хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс жилийн өмнө тооцож байсан бодит төсөөлөлтэй нийцэж байна. Өөрөөр хэлбэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2024 оны 3 дугаар сар, 2025 оны 3 дугаар сард Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлж байсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тайлангуудад макро эдийн засгийн таамаглалыг тусгасаар ирсэн ч Засгийн газрын зүгээс бодит ДНБ-ий өсөлт болон нэрлэсэн хэмжээг Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлийн төсөөллөөс өндрөөр тооцож, Улсын Их Хурлаар тухай бүр батлуулж ирсэн.

Засгийн газар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2025 оны эдийн засгийн өсөлтийг 7.5-5.5 болгон бууруулсан нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны 3 дугаар сард гаргасан төсөөлөлтэй ойролцоо байна. Өнөөдөр төсвийн орлогын өөдрөг төсөөллийн алдаанаас үүдэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлүүдэд өөрчлөлт оруулах нөхцөл үүссэн байна. Гэсэн хэдий ч 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн нөхцөл байдлыг үл харгалзан өндрөө тооцсон хэвээр байна. Дунд хугацаанд макро эдийн засгийн төсөөллийг хазайхгүй, рационал онодог байх зарчмуудыг баримтлан боловсруулахгүй байна. Нэг тодотголыг дагаж 2 төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөж байгааг та бүхэнд харж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10.1.3-д төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх гэж заасан. Гэсэн ч төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн болон тодотголын төсөлд нийцүүлэн өөрчилдөг байдалд дахин дахин давтагдсаар байна. Тухайлбал Төсвийн тогтвортой байдлын тухай хууль анх батлагдсанаас хойш 18 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд одоо 19 дэх удаагаа өөрчлөх тухай яригдаж байна.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын талаар:

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэх, төсвийн нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 3 хувиар нэмэгдэх гэж, мөн 34.1.4 дэх заалтад төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл болж байна гэжээ. Гэвч төсвийн тодотгол хийх практик шаардлага хэмээн дурдаж байгаа урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч, зарлага нэмэгдсэн гэдэг нь хандлага нь нэгэнт тодорхой байсан.

Өмнөх онуудад төсөв батлахтайд тооцож болох зүйл байсан бөгөөд төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж, түүнийг дагуулаад зарлагыг нэмэгдүүлэх боломж хомс гэдгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлт, зөвлөмждөө байнга сануулсаар ирсэн билээ.

Бид хэдийгээр улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг сайтар ойлгож байгаа боловч болзошгүй эрсдэлийг тооцох, хүндрэл бэрхшээл тулгарахад бэлтгэлтэй байх боломжийг ашиглаж чадсан гэдгийг дахин дахин сануулж байна. Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн орлогыг 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 10.6 хувиар бууруулахаар тооцож байгаа нь Засгийн газар тухайн жилийн төсвийн орлогыг анх төсөөлөхдөө макро эдийн засгийн болон гадаад,

дотоод эдийн засгийн нөхцөл байдал, гол нэрийн түүхий эдийн үнэ ханшийн төсөөллийг хэт өөдрөгөөр төсөөлж байсныг залруулах 1 оролдлого гэж харж байна. Энэ нь Засгийн газар, Сангийн яам цаашдаа төсвийн төлөвлөлтийг сайжруулах, мэргэжлийн байгууллагууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хийсэн шинжилгээ таамаглалыг анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Иймд цаашдаа улсын салбарын төсөв, санхүүгийн дунд болон урт хугацааны стратегийг боловсруулж, дунд хугацаанд төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн төслийг батлахдаа мөрдлөг болгодог байх хэрэгтэй. Ялангуяа уул уурхай, эрдэс баялаг дээр тулгуурласан эдийн засгийн бүтэцтэй манай улсын хувьд мөчлөг сөрсөн макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх, төсвийн болон мөнгөний, валютын ханшны бодлогыг зөв тодорхойлох, эдийн засаг, төсөв, санхүүгийн болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх, Голланд өвчин болон баялгийн хараалаас зайлсхийхэд ихээхэн тустай байх болно.

Нийт зарлага, цэвэр зээлийн дүнг 2025 оны батлагдсан төсвөөс 5.4 хувиар бууруулж батлахаар орж ирсэн нь төсвийн орлогын бууралт болох 10.6 хувьтай харьцуулахад бага байгаа бөгөөд цаашид төсвийн нийт орлогын бууралтын хэмжээгээр зардлын дүнг бууруулах зарчмыг баримталж, орлогын таслалаас аль болох зайлсхийх бодлогыг тууштай баримтлах шаардлагатай байна. Өнгөрсөн хугацаанд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг өсгөж, төрийн эдийн засаг дахь оролцоог байнга нэмэгдүүлж ирсэн нь хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн суурийг тэлэх боломжийг хязгаарлах нөхцөл болж байгаа учраас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд цалингаа тавих, татвараа төлөх, өр зээлээ барагдуулах, байнгын дарамтад ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд нүүрсний үнэ, экспортын үнэ, нүүрсний экспортын үнэ, биет хэмжээ, бусад эрдсийн түүхий эдийн зах зээлийн үнэ, уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт нь төсвийн орлого нэмэгдэх шалтгаан болж, харин түүнд дулдуйдсан төсвийн зарлагын хэт тэлэлт огцом явагдсан.

Зөвхөн Улсын Их Хуралд тайлагнадаг байгууллагуудын хувьд тухайлбал аваад үзэхэд 2025 оны нийт зардлын хэмжээ 2020 онтой харьцуулахад 2.3-10.7 дахин өссөн нь үүнийг нотлох баримт мөн. Төсвийн бусад ерөнхийлөн захирагч нарын хувьд ч гэсэн 2020 онтой харьцуулсан 2025 оны зардал мөн адил хэд дахин илүү хэмжээгээр өссөн байгаа харагддаг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 их наяд 994.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 612 төсөл, арга хэмжээнд 2 их наяд 982.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр оруулж иржээ.

Мөн түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад төлөвлөж батлагдсан хөрөнгө оруулалтын дүнгээс 535.9 тэрбум төгрөгийг хэмнэлтэд тооцохоор олон улсын хурал бэлтгэл ажил болон эрчим хүчний гэнэтийн аваар осол зэрэгтэй холбогдуулан 77.3 тэрбум төгрөгийг нэмж тусгасан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд санхүүжилтийн дүнгээр тооцвол энэ оны 6 дугаар сарын 24-ний байдлаар 12 хувьтай байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бусад төслүүдийн хувьд ач холбогдлын эрэмбийг дахин хийх, төсөвт өртгийн тооцооллыг эргэж хангах, онцын шаардлагагүй төслүүдийг жагсаалтаас хасах талаар тодорхой ажлууд хийгдсэн эсэх нь төсвийн тодотголын танилцуулга материалд тодорхойгүй байна.

Макро бодлогын түвшинд харвал бид өнөөг хүртэл төсвийн хүндрэлийг бодлого төлөвлөлтөөр бус тодотголоор даван туулж ирлээ. Тухайлбал 2008 оны эдийн засгийн хямрал, 2018 оны АНУ-ын худалдааны бодлого, 2019 оны ковид тахал зэрэг олон улсын эдийн засаг, хямрал хүндрэлийг тухайн үед нь төсвөө тодотгох замаар зохицуулж ирсэн нь нөхцөл байдал нэгэнт үүссэн үед зайлшгүй гарц мэт боловч төсвийн төлөвлөлтийн онцлог нь хүндрэлийг урьдаас таамаглан төлөвлөхөд оршиж буйг эргэн санах шаардлагатайг харуулж байна.

Эцэст нь тэмдэглэхэд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь эрсдэлт, эмзэг байдлыг бууруулах чадварыг нэмэгдүүлэх замаар сайжирдаг. Манай улс дунд хугацааны төсөвлөлтийн эхний үе шат болох дунд хугацааны макро эдийн засгийн хүрээг нэвтрүүлсэн хэдий ч төсвийн хүрээ нь төсвөө, төсөв нь тодотголоо, даган өөрчлөгддөг байдал үргэлжилсээр байгаа нь төсөв, санхүүгийн эрсдэлийг мэдрэх гол арга хэрэгслийг үр дүнгүй болгож, эмзэг байдлыг нэмэгдүүлэн үндэсний сөрөн тэсвэрлэх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Лхагвын Мөнхбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Батын Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд. Сайд нар танхимдаа цуглая. Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуухаар байгаад сайд нараас. Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Чинбатын Ундрэм Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Доржгочоогийн Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Данхүүгийн Баянбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Максимын Чинбат Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбаатарын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Батаагийн Ганболд Шадар сайдын ажлын албаны дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадоржийн

Оюунбилэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пуушагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хөхөөгийн Отгонжаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Заграагийн Баасанням Авлигтай тэмцэх газрын Тамгын газрын дарга, Амжаагийн Энхболд Татварын Ерөнхий газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Болдын Отгонцэцэг Гадаад харилцааны яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Рэнцэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Лувсандоржийн Гантогтох сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Бат-Өлзийн Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Адьяахишиг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга, Ононгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батдэмбэрэлийн Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Одоо илтгэл дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Одоо ирцээр нь эрэмбэлж байх шиг байна. Нийт 42 гишүүн асуулт асуухаар нэрээ өгсөн байна. Даваагийн Цогтбаатар гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 2, 3 асуулт байна. Төсвийн тодотголтой холбоотойгоор. Бид бол сүүлийн 1 жилийн дотор бас хэдэн ч удаа төсөв хэлэлцэв. Төсвийн тодотгол ярьчихав. Нүүрсний үнэ өсөхөөр зэрэг л бид 1 тодотгол хийдэг. Яамдынхаа сайд нарын тоо, бүтцээ нэмээд явдаг. Нүүрсний үнэ унангуут буцаагаад төсвөө хасаад, алдагдалтай болгоод, ингээд цомхотгол явуулна гээд л явдаг ийм байдлаар ганцхан нүүрс дээр суурилсан эдийн засагтай л ингээд л явлаа. Уг нь бол одоо нүүрсний үнэ, ашигт малтмалын үнэ өндөр байх үед тэндээс орсон орлогоороо аялал жуулчлалын салбар, хөдөө аж ахуйн салбар гээд бусад салбаруудаа уг нь өөд нь татаад ийм хүнд үед бас нөхөх ийм салбартай байх ёстой байсан юм. Ганц арьс шир боловсруулах үйлдвэртэй болчихсон байх ёстой байсан. Аялал жуулчлалаа хөгжүүлээд, аялал жуулчлалынхаа түшиц газрууд дээр нолиос өгсүүлээд тохижилтын ажлууд хийгдсэн байх ёстой байсан. Гэтэл ийм ажлууд хийгдэж чадаагүйгээс болоод ингээд тодотгол хийх зайлшгүй нөхцөл рүү орж байгаа юм.

Ерөнхий сайдын саяын мэдээлэл дотор төрийн албан хаагчдын цомхотгол гэж ярьж байна. 9 хувийн цомхотголыг яаж хийх гэж байна. Тэгшитгэж хийх гэж байна уу. Аль эсвэл давхардсан орон тоо, бүтэц орон тоо хасаж тодотгол хийх гэж байна уу. Үүний хажуугаар төрийн өмчит компаниуд дээр ямар цомхотгол, хэмнэлт хийх юм бэ. Тухайлах юм бол Өмнөговь аймагт төрийн өмчит компаниуд олон байгаа. Тавантолгойн төмөр зам, Зүүнбаянгийн төмөр зам гэх мэтчилэн олон төрийн өмчит. Аль аль нь л 900 гаруй хүнтэй. Гэтэл Дорноговьд байгаа яг тийм хэмжээний 200 гаруй километр төмөр замыг хариуцсан хувийн компани 200 хүнтэй. 4, 5 дахин бага хувийн аж ахуйн нэгж ийм зардлаар адилхан үйл ажиллагаагаа явуулаад явж байна.

Дээрээс нь энэ Өмнөговьд говийн бүсэд байгаа төрийн өмчит компаниуд Улаанбаатар хотод оффистой, бас бие бүрэлдэхүүнтэй байж байдаг. Цалин цавууны хувьд бол маш өндөр. 10 сая гарсан удирдлагууд нь ийм олон удирдлагуудтай, олон шат дамжлагатай. Тэгээд өндөр түрээс, байрны төлбөр төлөөд явж байгаа ийм компаниуд олон байгаа. Тийм учраас энэ төрийн өмчит компаниуд дээрээ ямар хэмнэлтийг хийхээр энэ тодотголд тусгасан юм бэ гэсэн ийм асуулт.

Дараагийн ээлжид энэ улсын төсөвт төвлөрүүлдэг орлого төвлөрүүлдэг аймгийг бас нэмэгдүүлж орж ирсэн юм байна. Тэгээд энэ дотор Дундговь аймаг орчихсон явж байх юм. Улсын төсөвт орлого төвлөрүүлнэ гээд. Тэгээд Дундговь аймагт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаатар гишүүн 1 минут нэмье.

Н.Наранбаатар: Улсын төсөвт ямар орлого төвлөрүүлэх болчихоод энд ороод ирчхэж байгаа юм бол. Булган аймаг бас нэмэгдээд ороод ирчихсэн байх юм. Тэгээд энэ уурхайтай болчхов уу, аль эсвэл өөр ямар орлогын эх үүсвэр шинээр нэмэгдчихэв.

Мөн дараагийн 1асуудал бол төвлөрлийг бид нар сааруулна гэсэн мөртөө улам л дээш нь төвлөрүүлээд яваад байгаа юм. Дагаж орж ирсэн Төсвийн тухай хууль дээр орон нутгийн ерөнхий орлогын данснаас нь шууд одоо энэ төвлөрүүлж байгаа аймгуудын орлогыг нь шууд булаагаад авчихна гээд заалт ороод ирчихсэн. Энэ ямар учиртай юм бэ. Энэ нэгжийн хууль дээр чинь энэ орон нутгийн хурал, Засаг даргын эрх гэж байгаа шүү дээ. Төсвөөр олгогдсон. Тэгээд энд нь шууд халдаад, орон нутгийн энэ ерөнхий орлогын данснаас нь шууд орлогыг нь дээш нь булаагаад татаад аваад байж болж байгаа юм уу. Энэ ямар учиртай ийм өөрчлөлт энэ төсөл дээр орж ирчхээд байгаа юм. Ийм 3 асуултад хариулт авчхаад, дараа нь тодруулъя.

Х.Булгантуяа: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн албыг 9 хувиар орон тоог бууруулах шийдвэр өнгөрсөн 5 сард 2026 оны төлөвлөгөө батлах үед маш тодорхой орсон байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байх үед ч энэ талаар маш тодорхой ярилцаж, шийдвэр эндээс нэгэнт гарсан. Харин энийг 2025 онд одоо энэ тодотголоос эхлүүлэхгүй бол 2026 онд нэг мөр энийг шийдэж бид нар чадахгүй. Тийм учраас одоо тэр 14400 орчим гэсэн тоо гарч байгаа. Энэ дээр дүн шинжилгээ хийж байна. Ажлын байрууд дээр нь судалгаанууд хийж байна. Одоогоор бол и баримтаар харагдаж байгаагаар бол 6600 сул орон тоо байгаа юм. Гэхдээ энэ бол бүгд хүн аваагүй гэсэн үг биш. Дотроо янз янз байгаа. Эхний ээлжид

ямар ч байсан энийгээ шахаад, энэ сул орон тоонууд дээрээ бол шахна. Дээрээс нь энэ жилдээ тэтгэвэрт гарах ийм орон тоонууд дээр мөн нөхөж хүн авахгүй байхаар ч юм уу ийм зохицуулалтуудыг хийгээд явна. Ингээд төсвийн ерөнхийлөн захирагч, сайд нар маань бол энэ дээр нэлээн том даалгавар авч байгаа. Үүнтэй тэнцэхүйц хэрвээ орон тоонуудаа энэ жилдээ сул орон тооноос гадна хэрвээ хасах боломжгүй байвал тэрэнтэйгээ тэнцэх хэмжээний зардлын хэмнэлт хийх ёстой ийм үүрэг авч байгаа. Энийгээ үлдсэн хугацаанд төсвийн хуваарь дээрээ зохицуулалт хийгээд ингээд шийдээд явах юм байгаа юм.

Дундговь аймаг, Булган аймгуудтай холбоотойг Санжаадорж дарга хариулаадах уу. Мөн төрийн өмчийн компаниуд дээр Бямбацогт сайд хариулаад явах уу.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд төрийн өмчтэй холбоотой асуултад хариулъя.

С.Бямбацогт: Төрийн өмчит компаниудын тухайд ер нь томоохон бас бодлогын өөрчлөлт хийхээр өмнөх Засгийн газраас төлөвлөж, хэрэгжүүлж ажиллаж байсан. Түүнийг бас үргэлжлүүлнэ. Энэ дээр төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн, ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Мөн бас бид нар өчигдөр Нийтийн өмчийн тухай хууль Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүний хэлэлцэх эсэхийг нь Улсын Их Хурлаар хэлэлцчих юм бол энэ 2 хуулийг нийлүүлээд, чуулган завсарласан хугацаанд Улсын Их Хурлаас төрийн өмчит компаниуд дээр бас томоохон бодлого, эрх зүйн баримт бичгийг батлуулж авах ийм бодлоготой ажиллаж байгаа. Түүнээс гадна тэрийг хүлээхгүйгээр төрийн өмчит компаниуд дээр бүх бүх төрлийн шинжилгээнүүд хийж байгаа. Санхүүгийн, бүтээмжийн, мөн бас яаж орлого нэмэгдүүлэх вэ, яаж зардал бууруулах вэ, үр ашиг, өгөөж нь нэмэгдүүлэх вэ гэдэг шинжилгээнүүд хийж байгаа. Энэ хүрээндээ бас нэгтгэх, нийлүүлэх .../минут дуусав/

Х.Булгантуяа: Хугацаатай болчихоод байна. Дэгийн дагуу. Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Энэ төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн талаар Нанзадын Наранбаатар гишүүн асуусан. Тэгэхээр энэ төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн тусдаа хөтөлбөр, нийтийн өмчийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Энэ хүрээнд цогц шинэчлэл хийхээр ажиллаж эхэлсэн. Эрчис Монгол, Эрдэнэс Монгол компаниуд дээр тусдаа үүрэг даалгаврууд өгөгдсөн. Ойрын хугацаанд үр ашгаа нэмэгдүүлэх чиглэл төлөвлөгөөг танилцуулна.

Ойрын хугацаанд бол эхний ээлжид төрийн өмчийн 109 компанийг 70 руу оруулах зорилго тавьж байна. Ирэх жилд төрийн өмчит хувьцаат компани 6 байгааг 19-20 болгож нэмэгдүүлнэ. IPO гаргах хувьцаална гэсэн үг. Төрийн өмчийн компанийн зардлыг 15 хувиар бууруулж, бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлэх үүрэг даалгавар өгсөн. Одоо жилийн эцсийн байдлаар 16.9 их наядын зардалтай байсныг 15 хувиар бууруулж ... /минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Тэр төсөвт төвлөрүүлдэг орлого төвлөрүүлдэг аймгуудыг нэмсэн байгаа юм. Тэгээд энэ дээр тодруулаадхаач. Тэгээд тэр орон нутгийн ерөнхий орлогын данснаас нь шууд татаж авч болдог нь яагаад ийм зохицуулалт

хийж байгаа юм. Ер нь орон нутгийн эрх мэдлээ улам л хумиад, төсвийг нь ч татаж аваад, томилгоог нь ч энд татаж аваад байдаг. Нөгөө бүсчилсэн хөгжил, орон нутгийг дэмжинэ, төвлөрлийг сааруулна энэ тэр гэдгийнхээ дандаа эсрэг юмнууд хийж орж ирээд байх юм. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авъя.

Эрүүл мэндийн сайдаас энэ орон нутгийн эмнэлгүүд чинь бүгдээрээ 100 хувь шахуу өр төлбөртэй. Даатгалын санхүүжилт нь хүрэлцэхгүй. Тэгээд оны эцэс рүү ямар ч өр, авлага үүсээд ингээд явж байгаа. Тэгээд энийг яаж шийдэхээр тооцож байгаа юм. Энэ даатгалын сангийн чинь орлого төсөв юм нь хэр өөрчлөгдөж байгаа юм. Нэмэгдэж байгаа юм уу, хасагдаж байгаа юм уу. Энэ үүсээд байгаа хүндрэл бэрхшээлүүдийг яаж шийдэхээр төлөвлөж байгаа юм гэсэн ийм 2 асуулт байна.

Х.Булгантуяа: 4 номер ажлын хэсгийн микрофоноос хариулъя.

М.Санжаадорж: Санжаадорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт бол Дундговь аймгийн хувьд “Эрдэнэс алт ресурс” компанийн үйл ажиллагаа бол идэвхэжсэн байгаа. 2025 онд Сангийн яамнаас тооцсон тухайн үед одоо батлагдсан байгаа энэ төсөв дээр тооцсон хэмжээнээс орлого нь бол нэмэгдсэн байгаа. Тэгэхээр гүйцэтгэлээрээ одоо байгаа түвшнээсээ даваад гарчихсан учраас бид нар тэр тооцоог нэмж оруулсан гэсэн үг.

Булган аймгийн хувьд бол мөн ижилхэн. Үл хөдлөх хөрөнгийн татвар нэмэгдээд ороод ирсэн байгаа. Тэр хэмжээгээр бид нар тооцож орж ирсэн байгаа. Төсвийн тухай хуультай холбоотойгоор бид хэд хэдэн сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх заалтууд оруулж ирсэн байгаа. Улсын Их Хурлаас бол тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг 1 дүгээрт баталдаг. Төсвийн хүрээний мэдэгдлийг баталдаг. Улсын төсвийг тухайн жилийн төсвийг бол баталдаг байгаа. Төсөв дээр юу батлагддаг вэ гэхээр тухайн аймгуудын төвлөрүүлэх орлого эсвэл татаас батлагддаг. Аймгуудын хувьд бол төвлөрүүлэх орлогоо бол .../минут дуусав/

Х.Булгантуяа: Хариултад нэмж минут өгье. 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Улсын Их Хурлаар хуульчлан баталсан орлогыг бол төвлөрүүлэхгүй байх тохиолдлууд бол аймгуудын хувьд гарч байна. Энэ тохиолдолд Сангийн яамны хувьд бол ямар нэгэн арга хэмжээ авах боломжгүй, санкцгүй ийм нөхцөл байдлууд байна. Нөгөө талдаа мөн Төсвийн тухай хууль дээр ямар санкцууд орж ирж байгаа вэ гэхээр Төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлаас нэгэнт баталсан байтал энэ нийт төсвийг төрийн зарцуулах зардал энэ шүү гээд хязгаарласан байтал аймгууд бас орлогоо нэмэгдүүлэх замаар зарлагаа маш ихээр нэмэгдүүлэх. Энэ нь бол төрийн одоо хэрэглээг бас нэмэгдүүлэх ийм зөрсөн бодлого бол яваад байгаа. Тэгэхээр энэ хэсэг дээ Сангийн яам бол хяналтаа тавих зорилгоор ийм зүйл гарч байгаа. Хэрвээ төсвийн захирагч нь өр төлбөр үүсгэх юм бол Төсвийн хуулиар бол өр төлбөр үүсгэхийг хориглочихсон байдаг. Гэхдээ өр төлбөр үүсгэсэн тохиолдолд яах вэ гэдэг санкц байхгүй. Одоо бол аудитын гүйцэтгэл дээр яг энийг гишүүд маш их асууж байгаа. Үүнтэй холбоотой бас санкц орж ирсэн байгаа.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотой Наранбаатар гишүүн сая дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар манай 26 гишүүн ажилласан. Ажлын хэсгээс. Улсын

Их Хурал гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ ганцхан улсын төсвийг хэлэлцээд байгаа. Нэгдсэн төсвийг бид нар баталдаг мөртөө. Тэгэхээр орон нутгийн төсөв ч гэсэн ороод, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг сонсдог болъё гэж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд бас оруулж байгаа юм. Тэгж байж бас энэ бүгд сахилга хариуцлага бүх талаар бас сайжирна гэж бас үзэж байгаа шүү. Манай ажлын хэсгийн гишүүдээс дэгтэй холбоотой мэдээлэл бас ингэж өргөн барьсан байгаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн. Чинбүрэн гишүүнээс нэмэлт хариулт өгөх ёстой байгаа.

Ж.Чинбүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлийн чанарт тулгуурласан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжээд нэлээдгүй төвөг бэрхшээл үүссэн. Тодорхой байгаа. Эмнэлгүүдээ бас гүйцэтгэлийг бүрэн тавьж чадахгүй, зарим эмнэлгүүд өр ширтэй. Ялангуяа өчигдөр бас цалин буусантай холбоотой, дутуу санхүүжилт орсонтой холбоотой Жавхлан сайдтай бид 2 ярилцаад, ямар ч байсан хойноосоо урагшаа татах хэлбэрээр санхүүжилтийг гүйцээгээд өгөхөөр ярилцсан. Одоо тэгээд наадмын баярын өмнө ямар ч байсан санхүүжилтээ гүйцээгээд өгчих ийм зорилго тавьж байна.

Ер нь цаашдаа энэ тогтолцооны алдаагаа засах, өр ширийн асуудлыг цэгцлэх, энэ асуудлаар бас бодлогын том өөрчлөлтийг оруулахаар бас бэлдэж байгаа. Энийг Засгийн газар оруулсны дараагаар Их Хурлын гишүүд та бүхэнд бас танилцуулна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Ямар ч байсан төсвийн тодотголтой холбоотой олон асуудлууд байна. Сая бол Монгол Ардын намын бүлэг хуралдаж, энэ Төрийн албан хаагчдын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг бол бас эргэж харах ийм шийдвэр гаргалаа. Тэгээд энэ бас гэнэтийн шийдвэр байж болохгүй л гэдэг ийм л зарчим бас ярилцлаа. Нөгөө талдаа төсвийн тодотгол хийхэд цомхотгол хийнэ 9 хувь, дээрээс нь “Алт” хөтөлбөр гээд байна. Хөрөнгө оруулалтуудаа зогсоох гээд, ингээд зогсоох юу байх вэ 5 сарын 31-ний өмнө гэрээ байгуулаагүй гээд ийм зүйлүүдээ аль болох л төр хэмнэхийн төлөө байгаа. Бид ганц нүүрснээс шалтгаалж байгаа эдийн засагтай улс маш сайн ойлгож байгаа. Нөгөө талдаа бид ингээд төр чангална гэхээсээ гадна төрд бас авлага гэж нэг юм байгаа. Энэ авлага авах үйл ажиллагааг ер нь эрчимжүүлэх тал дээр ер нь юу хийж байна вэ. Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Боловсролын зээлийн сан, ЖДҮ-ийн сан, ТЭДС гээд энэ авлагагүй сан бол огт байхгүй. Тэгэхээр 1 талдаа бид нар ингээд хөрөнгө оруулалт хамаг юмаа танаад ингээд байгаа юм чинь нөгөө талдаа авлагаа авах асуудлаа ч гэсэн ер нь нэлээн урагшлуулах ёстой гэж би бол ингэж бодож байгаа. Тэгэхээр энэ тал дээр ямархуу байр суурь байна.

2 дугаарт энэ “Алт” аян гэж орж ирээд байгаа. “Алт 3” аян томоохон ордууд руугаа энэ олборлоно гэсэн ийм зүйл ярьж байгаа. Би энэ дээр бас хяналтын тогтолцоо байна уу, үгүй юу гэдэг дээр асуух гэж байгаа юм. Яагаад гэвэл ковидын үед хил, гааль хаалттай байх үед Монголбанканд тушааж байгаа алтны хэмжээ максимумдаа 23.5 тонн хүрч байна. Өнөөдөр бол өнгөрсөн 2024 оныхоор бол 16.5 тонн болтлоо буурсан байна. Алт олборлолт өөрөө зогсчов уу. Энэ ордууд нь ажилласаар байгаа хэр нь Монголбанканд тушааж байгаа алтны хэмжээ ингэж багасаад байна уу. Алтны хууль бус худалдаа байна уу, үгүй юу гэдэг. Хэрвээ бид байгаа бол энийгээ хянаж чадахгүйгээр дараагийн том ордууд руугаа орно гэдэг бол тийм зөв хувилбар биш гэж би харах гэж байна. Энэ дээр ямар зүйл байна вэ.

3 дахь нь одоо 2026 оны төсөв хэдхэн сарын дараа ороод ирнэ. Хөрөнгө оруулалт гэдэг зүйл бол туйлын хүнд болох нь. Гэхдээ бид бас энэ улс орон эдийн засгаа тэлэх томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой. Энэ Засгийн газраас ирсэн танилцуулга дээр гадаад зээлийн ашиглалт бол маш бага хувьтай байна. 12 их наяд төгрөгийг бид ашиглаж чадахгүй зээлийн зарцуулалт байна гэдэг ийм зүйл байгаа. Тэгэхээр бид ер нь 2026 онд улсын хэмжээний томоохон хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхэд энэ гадаад зээл нэгэнт авчихсан зүйлээ ашиглах ямар чиглэл бас баримтлах юм бэ гэдгийг бас би тодруулъя гэж бас бодож байна. Цаг дуусаж байгаа учраас хариултаа авчхаад тодруулъя.

Х.Булгантуяа: Эхлээд Сангийн сайд, дараа нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд хариулахад бэлдэж байгаарай. Сангийн сайд.

Б.Жавхлан: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Гадаад зээлийн ашиглалтыг та их сайн нарийн ойлгож байгаад баярлалаа. 12 их наядын гадаад зээлийн ашиглалт хүлээгдээд байж байгаа. Бидний одоогийн төсвийн дүрмээрээ энэ гадаад зээлийн ашиглалт маань шууд алдагдал нэмэгдүүлдэг, зардалд тооцогддог ийм эдийн засгийн ангилалд багтдаг юм байгаа юм. Бид төсөв дотроо жишээ нь, энэ жил алдалгүй төсөв батлаад, үүнд багтаасан зээлийн ашиглалтын хамгийн дээд боломж маань 1.5 их наяд л байгаа юм. Уг нь бол гадаад зээлийн ашиглалт маань бусад эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын эх үүсвэргүй зардалтай адилтгаж үзэж болохгүй зүйл юм байгаа юм. Ялангуяа бид сүүлийн жилүүдэд эдийн засаг дахь зээл ашиглалт төслүүд маань маш том дүнтэй болж ирж байна. Одоо энэ 12 их наядын бараг тал нь буюу 5.6 их наяд нь ерөөсөө ганц төсөл байгаа. Тэр маань нефть боловсруулах үйлдвэр. 2017, 2018 онд эхэлсэн төсөл. Ингээд ковидын үед төсөвт өртөг нь нэмэгдсэн. Нэмээд зээл авсан. Энийг ямар зогсоолтой нь биш. 2 жилийн дотор бид нар 5.6 их наядыг багтааж гаргах ёстой. Энэ дүрмээрээ бол бид нар багтааж гаргах ямар ч боломжгүй. 90-ээд төсөл байгаа юм. 90-ээд төслийн 12 их наяд. Тийм учраас бид цаашдаа энийг эргэж харж, тодорхой хэмжээний өөрчлөлт хийхгүй бол бид энэ том олон улсын гэрээгээр батлагдсан эдгээр ажлуудаа хийж чадахгүй байх ийм эрсдэлүүдтэй нүүр тулж байгаа. Зарим томоохон улс гүрнүүд жишээ нь Герман улс байна. Герман улсын нэг том онцлог гэх юм бол төсвөөсөө бараг 3 дахин илүү том ийм гадаад зээлийн ашиглалттай явдаг. Тэгэхээр өөрөөр хэлбэл төсвийн орлогоор санхүүждэг биш, өөрөө эх үүсвэртэй эдгээр зээлүүдийгээ гадаад өрнийхөө хязгаарт багтаагаад, харин төсвийнхөө алдагдалд бол тооцдоггүй, гадуур нь бүртгээд явдаг юм байна лээ. Засгийн газрын өрнийхөө хязгаарт бол тооцно. Эрсдэл тооцно. Макро төлөвлөлтдөө оруулж тооцдогоо гэсэн үг юм байгаа юм. Гэх мэт ийм бас улсуудын туршлагауд байна. Хэдүүлээ энийг бас сайн ярилцана. Энэ дээр Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад, энийг бас ажиллаад судлаад яваасай гэж хүсэж байна.

Алт дээр уул уурхайн яам. Мөн энэ авлагууд дээр яамнууд маань ялангуяа нийгмийн даатгалтай холбоотой Аубакир сайд, Эрүүл мэндийн сайд нар маань үүссэн байдаг энэ томоохон авлагууд дээр хэрхэн яаж ажиллаж байна. Ямар үр дүн гарч байгаа талаар мэдээлэл өгвөл сайн байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Манай Дамдинням сайд нэмж хариулна. Тэгэхдээ 1 зүйлийг тодотгож хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа. Олон улсын нягтлан бодох бүртгэлийн аргачлал, стандартаар төсөвт банкибал буюу үр ашигтай өөрөө эргэн

төлөгдөх зээлүүдийг төсвийн зарлага алдагдалд суулгадаггүй жишигтэй. Манай одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрмээр газрын тосны ч юм уу, өөрөө өөрийгөө санхүүжүүлээд эргэн төлөгдөх зээлүүдийг тусгаад алдагдалд бүртгээд яваад байгаа нь бол алдагдлыг өсгөж байгаа ийм өр зүүлт болж харагдаад байгаа юм. Ийм учраас цаашдаа энийг эрх зүйн хувьд зохицуулах ёстой гэж үзэж байгаа.

2 дугаарт нь “Алт 3” аяны талаар манай яам бол их санаачилгатай ажиллаж байгаа. Өнөөдөр 4 тонн хүрэхгүй алт тушаагдсан байна. Тэгтэл эд үедээ бол хагас жил 20 тонн алт манай улс олборлож байсан. 10 гаруй тонн алт олборлож байсан ийм улс. Өнөөдөр алтны ханш хамгийн өндөр 3400 долларт хүрчхээд, валютын ханшийг нөөцийг .../минут дуусав/

Х.Булгантуяа: Минут нэмж өгье. Энэ нөгөө дэгээрээ дахиад 1, 1 минутаар гээд байгаа юм байна.

Г.Занданшатар: Тийм учраас алт олборлолтыг нэмэгдүүлж, валютын нөөцөө бэхжүүлэх зорилго тавьсан. Хууль бус олборлолтыг хумих, байгаль орчны нөхөн сэргээлт хийх шаардлага тусгасан. Сая Хятадад батлагдсан хуулиар нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгөө урьдчилж батлуулаад, байгаль орчинд ямар ч хор нөлөөгүй явуулдаг ийм алт олборлолтыг бол дэмжих ёстой. Ашигт малтмалын газар байнгын хяналт тавьж ажиллана. Ийм учраас ер нь өнөөдөр дэлхий даяараа алтны үнэ хамгийн өссөн ийм металл олборлолт болж байхад манайд энэ алтны олборлолт буурч байгааг хууль бусаар хил гараад байна уу, үгүй юу шалгах үүргийг ТЕГ-т өгсөн байгаа. Хяналт шалгалтын ажил явагдаж байна. Нөгөө талдаа яг бодит нөхцөл байдал, олборлолтын хэмжээ, том уурхайнуудын асуудлыг манай Дамдинням сайд хариулна.

Сангуудыг хувьд бол энэ сангуудыг төвлөрүүлж ил тод болгох зарчим баримталж байгаа. 9 санг нэгтгэж байгаа. Тусгай .../минут дуусав/

Х.Булгантуяа: Идэрбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Идэрбат: Сангуудын авлагын явцыг бол бараг мэдэж байгаа. Одоо харин жоохон хурдлуулах юм байна уу л гэж байгаа. Нэгэнт бид нар цомхотгол хийж байна. Хөрөнгө оруулалтаа зогсоож байна. Бүх бололцоогоо дайчилж байна. Байгаа жоохон алтаа хүртэл ухъя гэж байгаа энэ цаг үед авах юмаа олигтойхон авахын төлөө яваач ээ. Одоо бол наадах чинь ингээд л шүүхийн шийдвэр энэ тэр гээд нэг сунжирсан юм явж л байгаа.

Дараагийн нэг юм аудитын дүгнэлт дээр ч гарч байна. Ерөнхий сайдын үгэн дээр ч гарсан. Энэ махны экспортыг нэмэгдүүлэх тал дээр харин энэ танхимд ярьж байгаа амьдрал дээр байгаа 2-ын хооронд нэлээн зөрүү байгаа шүү. Өнөөдөр манай зүүн бүсэд 8 махны үйлдвэр ер нь ирэх 7 хоногоос бараг хаагдах гэж байгаа юм. Тэгээд би өнгөрсөн Хөдөө аж ахуйн байнгын хороон дээр сайдад нь хэлсэн. Тэгээд Ерөнхий сайд энэ дээр бас нэг анхаараад өгөөрэй. Ямар учир шалтгаан байгаа вэ гэдгийг бас холбогдох хүмүүс нь сайн тайлбарлах байх. Энэ бол нэлээн чухал асуудал шүү гэдгийг хэлье.

Тэр алт дээр бол яагаад ковидын үед тийм өндөр байгаад одоо буурчхав л гэсэн асуулт байгаа юм.

Х.Булгантуяа: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд. Тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хариулах уу. Авлагатай холбоотой.

Г.Дамдинням: Алт аянтай холбоотой тогтоолын төсөл орж ирж байгаа Идэрбат гишүүн ээ. Тэгээд энэ тогтоолын төслийн бас 1 заалт нь бол хууль бусаар экспортлох үйл явцад хил, гаалийн хяналтыг чангатгах арга хэмжээг авах ийм чиглэлийг оруулж ирсэн.

2 дугаарт ер нь манай улсын хайгуулын салбарыг маш удаан хугацаанд барилаа. Тэгээд үндсэндээ олсон нөөц их багассан. Тэгээд үндсэн том ордууд үлдсэн. Нийт нөөцийн 85 хувь нь үндсэн орд, шороон орд 15 хувийг нь бүрдүүлж байна. Байгаль орчны нөлөөлөл нь хамгийн бага нь том ордууд байдаг. Том ордуудад их хөрөнгө оруулалт шаарддаг. Энэ нь алтны үнэ бага байх үед ашиггүй гэж тооцоолол гардаг байсан учраас олборлолт эрс буурсан байгаад байгаа юм. Эрс буураад байгаа юм. Тэгэхээр бид нар хайгуулаа нээх ёстой. Алт аянаа явуулах ёстой. Том ордуудаа байгаль орчноо хамгаалах бодлогын хүрээнд бол давхар хэрэгжүүлээд явахаас өөр гарцгүй л болчхоод байгаа юм.

Х.Булгантуяа: Эхлээд авлагатай холбоотой асуултад хариулчихъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир. Эрүүл мэндийн сайд Чинбүрэн 2 одоо яг хэдэн төгрөгийн авлага байгаа вэ. Авлагаа бууруулахын төлөө юу хийж байгаа вэ.

Т.Аубакир: Капитал, Чингис хаан банкны өрийн үлдэгдэл тодорхой хэмжээний төлөлтүүд хийгээд, одоо нийтдээ 2 банк нийлээд 154.8 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Эрх хүлээн авагч ажлаа хийгээд явж байгаа. Бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон байж байгаа. Тийм учраас манай яам гэхээсээ илүү эрх хүлээн авагч нь өөрсдөө өр барагдуулах ажлуудаа хийгээд явж байгаа. Бидний хувьд бас шахаж ажиллана гэж.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд хариулъя. Эрүүл мэндийн сайд.

Ж.Чинбүрэн: Энэ дутагдаад байгаа мөнгийг нөхөхөд одоо бас энэ авлагатай 2 банкнаас мөнгөө авч чадвал овоо л өр дарагдахаар байгаа. Тухайлах юм бол Капитал банктэй эцсийн үлдэгдэл 75.5 тэрбум төгрөг. Мөн Чингис банктэй эцсийн үлдэгдэл 30 тэрбум. Чингис банктэй 30 тэрбум бол бүр мөнгөн дүнгээр байгаа. Мөн НДЕГ-аас эцсийн үлдэгдэл нь 89.7-оор тохирсон байгаа. Тэгэхээр энэ мөнгө төгрөгийг буцаагаад дансандаа оруулахад өнөөдрийн үүсээд байгаа өр ширнээс бол бүрэн гарах боломжтой. Тийм учраас эцсийн үлдэгдэл нь бэлэн мөнгөөр авч болох Чингис Хаан банк энэ тэр сонсдог бол мөнгөө өгчихмөөр байгаа юм. Бид ажилчдынхаа цалинг өгч чадахгүй байж байхад энэ мөнгийг авчихвал. Энэ буцааж мөнгө авах дээр үл хөдлөх хөрөнгүүд бас оруулж тавьчихаад, тэр нь зарагдахгүй, борлуулагдахгүй эсвэл түрээслээд багахан хэмжээний мөнгө олох барих гээд л нэлээн л тийм төвөгтэй асуудлууд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Идэрбат гишүүн нэмж 1 минут тодруулъя.

Ц.Идэрбат: Хууль нь ийм юм аа Пүрэвдорж гишүүн ээ. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сангийн авлагууд ямар байдаг юм бэ. Би энэ 2 сангийн юуг бол сайн мэднэ л дээ. Тэр дээр би бас тодруулмаар байгаа юм.

Дараа нь энэ бол яах вэ зүгээр санал. Засгийн газрын тогтоол дээр энэ авлага нэмэгдүүлэх тал дээр ер нь бол зүйл заалт ороогүй байна. Дандаа л хэмнэх, хасах, танах. Тийм учраас энэ тогтоол дээр саяын хэлсэн энэ сангуудын авлагыг эрчимжүүлэх, үр дүнг тооцох тийм заалт бас оруулмаар байна. Бид нэг талдаа цомхотгол хийж байна, цалин хөлсний асуудал яригдаж байна, хөрөнгө оруулалтаа ч зогсоож байна. Зөндөө юм болж байж авах авлага дээрээ ийм хүч муутай хандаж болохгүй ээ л гэж миний хувьд бол бодож байгаа юм. Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сан гэхэд тэрийг л авчихвал өнөөдөр бүхэл бүтэн улсын эрүүл мэндийн салбар дээр үүсээд байгаа, бухимдуулаад байгаа тэр бүх зүйлүүд чинь арилах гээд байна шүү дээ.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүний асуултад товчхон хариулчихъя. Энэ сангуудын авлагыг төвлөрүүлэхийн тулд бүх тусгай сангийн дансыг царцааж, 30 хоногийн дотор тайлагнах, давхар санхүүжилтийг хориглож, төрийн сангаар дамжуулан төвлөрүүлэх шуурхай журам мөрдүүлэхээр чиглэл өгсөн байгаа. Зүүн бүсийн махны нийлүүлэлтэд бол малын өвчин, малын махны хадгалалтын дэд бүтцийн сул тал, зах зээлийн зохицуулалт зэрэг хямрал үүсдэг юм байна лээ. Эрүүл мэндийн хяналт хөргүүрт агуулах, стандарт нядалгааг яаралтай нэмэгдүүлэх шаардлагатай. Банкнаас авах тэр 200 тэрбум төгрөгийн авлагыг 60 хоногийн дотор төвлөрүүлэх зорилт тавьж аккредитив, баталгаа, өрийн хуваарилалтыг нэгдсэн байдлаар шалгаж, 90 хувийг төрийн санд төвлөрүүлэх арга хэмжээ авах чиглэл өгсөн байгаа. Боловсрол, тариалангийн сангийн 150 тэрбум төгрөгийн авлагыг 45 хоногийн дотор нэхэмжилж, 80 хувийг бүрдүүлэх зорилт тавьж, өрийн жагсаалтыг цахимжуулж ил тод зарлаж, хуулийн хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгсөн байгаа. Энэ учир төсвөөс гадуур хэрэгжих ажил учраас энэ дотор .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн жил төсөв батлахдаа 83 сая тонн нүүрсийг 105 доллароор зарна. Тэгээд эдийн засгийг 8 хувиар өсгөнө. ДНБ-ийг 93 их наяд төгрөгт хүргэнэ гэдэг ийм зүйл ярьсан юм л даа. Тэгээд би тухайн үед асууж байсан юм. Үгүй ээ, энэ Трамп гараад ирлээ. Трамп хамаагүй. Үгүй ээ, энэ төсвөө зөв тооцсон юм уу. Тооцсон. Энэ Хятадын энэ орон сууцын зах зээл дээр нэлээн хямрал үүсчихсэн. Одоо наадах төмөр энэ тэр чинь хэрэглэгдэхгүй шүү дээ. Тэр бол бид нар нэвтрэх чадлаа сайжруулаад, унасан ч гэсэн нөхчихнө гээд л ийм л юм ярьж байсан юм л даа. Тэгээд яг өнөө жилийн эхний 5 сарын байдлаар 2025 оны 1 дүгээр улиралд бол ДНБ 2.4 хувийн өсөлттэй гарч байна. Экспортын орлого 2025 онд 5.4 тэрбум доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 их наядаар буурчихсан, 1 тэрбум доллароор буурчихсан байна. Урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 11-15 хувьд хүрэхээр болж, энэ маш хүнд хямрал руу ойртох ийм нөхцөл байдал руу очиж байна. Төсвийн орлого 2024 оны эхний 5 сард 12.6 их наяд байсан бол 2025 оны эхний 5 сард 11.6 их наяд болж 1.3 их наядаар буурсан байна. Аж ахуйн нэгжийн татвар өнгөрсөн жил 3.5 их наяд орж байсан бол эхний 5 сарын байдлаар 2.8 их наяд болж, 700 тэрбумаар буурч энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж, дампуурч эхэлж байна гэсэн үг. Тэгээд Монголбанкны тооцоолсноор бол 2.4 их наядын алдагдалтай болно гэж тооцоолж байгаа. Яг одоо манай эдийн засагч, миний зөвлөх Даваадоржийн тооцоолж байгаагаар бол 5 их наядын алдагдалтай болно гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр Монгол Улс

нэгэнт ийм нөхцөл байдалд орж байгаа. Тийм учраас бид нар бол хүний хүн хүрэн бөөртэй гээд суухгүй. Бид нар хамтдаа л энэ асуудлыг давахын төлөө эрх баригч нар ч тэр, сөрөг хүчин ч хамтдаа явах ёстой. Тийм учраас хэмнэлт, хэмнэлт, бас дахин хэмнэлт гэдэг зарчим дээр ажиллах ёстой. Төсвийн үр дүнгүй хөрөнгө оруулалтуудаа хасах хэрэгтэй. Төсвийн зарлагаа хянах, танах хэрэгтэй. Төрийн өмчийн компаниуд дээр байгаа хулгайгаа багасгах хэрэгтэй. Төрийн сангуудаа эргэж харах ийм зайлшгүй шаардлагууд гарч байна. Тэгээд энэ дээр бас тодорхой хариултуудыг авъя. Тэгээд 1 минутаа хариулсны дараа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд эхлээд хариулъя. Эхний хариулт нь их олон минуттай учраас.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Санал нэг байна. Энэ бол Засгийн газрын зовлон ч биш, нэг намын зовлон ч биш. Монгол Улсын зовлон. Дэлхий нийтийн зовлон. Энийг бид хамтдаа бас сөрж биш, хамтарч байж давна. Ийм учраас энэ эдийн засагт тулгамдаж байгаа асуудлууд бол таны хэлсэн тооноос хойш тоо бол их өөрчлөгдөж байгаа. Мал аж ахуйн өсөлт малын хорогдол бага байснаас шалтгаалаад хөдөө аж ахуйн өсөлт гарснаас таны хэлснээс эдийн засгийн өсөлт бол 2.4 биш 4.9 болсон. Энэ бол гол нь малын тоо толгой өссөнөөс, мал аж ахуйн салбарын өсөлтөөс болоод сүүлийн тоо өөрчлөгдөж байна. Тэгэхдээ манай импорт өсөөд байгаа. Төлбөрийн тэнцэл, валютын ханшид нөлөөлж байгаа нэг зүйл жишээлбэл, 5200 ширхэг машин импортолж, 190 сая доллароор машин импорт нэмэгдэж байгаа бол экспорт маань яаж буурч байгааг та тодорхой хэлчихлээ. 1 тэрбум 150 сая доллароор нүүрсний үнийн бууралт шалтгаалж буурч байна.

Алт одоо ийм сайн үнэтэй байгаа ч гэсэн үнэ бараг 2 дахин өссөн ч гэсэн өнөөдөр алтны маань олборлолт багассан, хайгуул зогссон, энэ бүхэн нөлөөлж байгаа. Тийм учраас энэ цаг үед бол бас төр бүсээ чангалаад, энийг давахын тулд нэлээн хатуу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж таарна. Нөгөө талаас энэ чиглэлээр хувийн хэвшлээ дэмжих, экспортыг төрөлжүүлэх. Тухайлбал, махны экспортыг нэмэгдүүлэхэд Махны холбоо энэ малаа эрүүлжүүлэх чиглэлээр бас хамтарч ажиллаж, өнөөдөр гарын үсгийг нь зурж байгаа эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээр бол мал, мах, ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, малчдын орлого, хөдөө аж ахуйн орлогод их бодитой хувь нэмэр оруулна гэж бодож байна. Тэгээд бусад асуудлын талаар дэлгэрүүлээд Сангийн сайд, Уул уурхайн сайд нар хариулчихъя.

Х.Булгантуяа: Сангийн сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүнд талархал илэрхийлье. Энэ нөхцөл байдлыг бас ойлгож дэмжиж байгаад. Бид 2.1 их наядын зардал хэмнэж байгаа юм. Үүнээс дээшээ хэмнэнэ гэхээр бид хүүхдийн мөнгө рүүгээ орох гээд байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж рүүгээ орох гээд байна. Олон улсын гэрээгээр гадаад улсуудын өмнө санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээрээ төлбөл зохих зээл төлбөр лүүгээ орох гээд байгаа юм. Тэр дүн маань 10.9 их наяд байгаа юм. Ерөөсөө огт бид нар хөндөж чадахгүй, хөндөх боломжгүй. Тийм учраас гарцаагүй бид ийм алдагдал хүлээхээс өөр аргагүй болж ирж байна. Нийтдээ бол 3.3 их наядаар орлого дутахаар жилийн эцэс рүү ийм хүлээлттэй боллоо. Тийм учраас бид энэ алдагдлаа хэтрүүлэхгүй, барьж явах бас нэг ийм сорилтод ирж байна гэсэн үг. Гэсэн хэдий ч

бид яг таны хэлснээр хэмнэлт хэмнэлт бас дахин хэмнэлт гэдэг энэ горим руугаа шилжинэ. .../минут дуусав/

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: Би энэ 2.1 их наядыг хасаж байгааг нь дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дотроо би та нарыг хассаны дараа би дахиад бүх газрууд дээрээ тэр сайд нар хоорондоо юм хумаа гүйлгээд янз янзын юм зөндөө хийдэг. Тэрийг чинь би харж байгаад л ер нь бол оноонуудыг нь гаргаж тавина. Тэгэхээр бүх газраас 8 хувиар хасаж байгаа юм байна. Бүх газраас 8 хувь. Гэтэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гав ганцхан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 20.8 хувиар хасаад хаячхаж. Энэ чинь бас нэлээн олон шүүх байгуулах тухай асуудал олон аймгийн шүүхийн хөрөнгө оруулалтын янз янзын асуудлууд байгаа. Тэр бүх зүйлээс нь бүгдээс нь ингэж хасаж болохгүй шүү дээ. Энэ чинь нэг байгууллагыг ингэж харгисалж, нэг нүдээр үзэж болохгүй байхгүй юу даа. Энэ хасалтаа хэлэлцүүлгийн явцад бас гайгүй болгох талаар бас та Сангийн сайд ажиллаач ээ гэж хүсэж байна. Сангийн сайдаас асууя.

Х.Булгантуяа: Сангийн сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Байгууллагын дүнг ажлын хэсгээс хариулчихъя.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг. 4 номерын ажлын микрофон дээрээс хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн төсвийн тодотголтой хамт бол тодотгол хийсэн үндсэн зарчмууд бол бид нар хүрч болохгүй зардлуудаа буюу хүүхдийн мөнгө, ахмадын тэтгэвэр, тэтгэмж эдгээр хүрч болохгүй зардлуудаа үлдээгээд, бусад салбаруудын хувьд бол бүх салбарууд дээр яалгаагүйгээр таналт хийсэн байгаа. Ингэж хийхдээ бол энэ 2025 оны 1-6 дугаар сар буюу эхний хагас жилд хуваариар тавигдсан зардлууд, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зардлууд, эхлүүлсэн зардлуудыг нь үлдээгээд, сүүлийн хагас жилд нь байгаа зардлуудаас бид нар танаж болох зардлуудыг бол танасан байгаа. Яг ижилхэн нэг зарчмаар жишээ нь, томилолт, зочны зардлыг бууруулах, бичиг хэргийн зардлыг бууруулах, шатахууны зардлыг бууруулах гээд ийм арга хэмжээнүүд хийсэн байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд бол янз янзын хувьтай гарч ирж байна. Жишээ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд бол .../минут дуусав/

Х.Булгантуяа: Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: Үгүй ээ, одоо байна шүү дээ. Яг энэ Эрдэнэс Тавантолгойг хэн хариуцдаг юм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хариуцдаг уу. Энэ хүний нүдэн дээр энэ компани ер нь дампуурах нь дээ. Яагаад гэвэл 105 доллароос доошоо үнэ унаж байгаа. Энэ үнэ унаж байгаа тохиолдолд Энержи ресурс ч юм уу аль эсвэл юу байдаг юм тэр Нарийн Сухайт дээр байгаа компаниуд бүгдээрээ үнэ унахтай зэрэгцээд л хурдан хурдан экспортоо хийгээд, хурдан хурдан уналтаараа үнээ шинэчлээд маш их борлуулалт хийгээд явж байгаа. Гэтэл Эрдэнэс Тавантолгой яасан. Бүх юмнаас айдаг. Тэр нөхөд ингээд л бүгдийг нь айлгачихсан. Тэд нар яадаг вэ гэхээр нөгөө үнээ буулгаж чадахгүй, үнээ буулгаж байх, тээнэгэлзэж байх хооронд дараагийн үнэ уналт яваад ингэсээр байгаад ерөөсөө борлуулалтаа хийхгүй наадах чинь мөнгөгүй болж хувирлаа. Юун бид нарын нөгөө

1072 хувьцаа байтугай улсын төсөвт мөнгө оруулдаггүй, бүр улсын төсвөөсөө данхайсан төсвөөрөө буцааж татаас авах маягийн тийм л ...

Х.Булгантуяа: Хүүш ээ, энэ сайд нар бүгдээрээ хааччихав. Энэ урдуур бүр 1 ч сайдгүй болчих шиг болох юм. Тэгээд 3, 4, 5 сайд байх шиг байна. Ухнаагийн Отгонбаяр. Пүрэвдорж гишүүн сая санал хэлсэн. Ухнаагийн Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Та бүгдэд энэ оройн мэндийг хүргэе. Төсвийн тодотгол зайлшгүй хийх шаардлагатай болсон. Энийг бол дэмжиж байгаа. Өнөөдөр маш олон хүнээс, тэр дундаа манай зүүн бүс нутгаас төрийн цэргийн байгууллагын офицер, ахлагч нар маш ихээр мессеж бичиж байна. Энэ төсвийн тодотголд төрийн цэргийн байгууллагын цалингийн нэмэгдлийг 40-өөс илүүгүй хувь, мөн тэтгэвэрт гарахдаа 1 удаа авдаг тэтгэмжийн хэмжээг үндсэн цалингаас тооцохоор тусгасан байна гэдэг асуудлыг маш их асууж байна. Энийг бүр албан ёсоор асууж өгөөч гэдэг асуултыг маш ихээр илгээж байна. Тийм учраас энэ дээр маш тодорхой хариулт өгөөч ээ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. 14400 төрийн албан хаагчийг цомхотгох болж байх шиг байна. Тэгээд эндээс 6600 нь хоосон орон тоо байгаа. Үүний цалингийн хэмнэлт эхний хагас жилийн байдлаар хэдэн төгрөг байгаа юм бэ. Энэ хаашаа шилжиж, ямар зохицуулалт руу орж байгаа вэ гэдэг энэ 2 асуулт дээр тодорхой хариулт өгөөч. Тэгээд араас нь тодруулъя.

Х.Булгантуяа: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Сая Монгол Ардын Намын бүлэг хуралдаад улс төрийн шийдвэр гаргачихсан. Тийм учраас Засгийн газар энийг буцааж бид татах нь уу, эсвэл энэ дээрээ санал хураагаад шийдэх үү аль нэг хэлбэрээр нь бол шийднэ гэсэн үг. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хууль бол ямар ч байдлаар яригдахгүй нь гэсэн үг. Гэхдээ би энд бас яагаад ер нь энэ хууль орж ирсэн бэ гэдэг тал дээр бас тайлбар хэлэхгүй бол болохгүй. Бид төр данхайж байна гэж ярьдаг. Монгол Улс 2.3 сая насанд хүрэгчидтэй. Хөдөлмөрийн зах зээл нь 1 сая 5-аас 1 сая 800 мянга гэж ингэж яригддаг. 230 мянган төрийн албан хаагч байна. Тэгэхээр хувийн хэвшил маань энэ өрсөлдөөнд хүчин мөхөстөж байгаа. Хүчин мөхөстөж байгаа. Хөдөлмөрийн зах зээл дээрээс төрийн алба бол соронз мэт энэ хүний нөөцийг сорж авдаг. Тэгэхээр бид энэ өнцгөөс нь харах юм бол том хөдөлмөрийн зах зээлээ бас хамгаалах хэрэгтэй. Энийг хамгаалах хэд хэдэн арга замууд мэдээж байгаа. Эдийн засгаар нь дэмжих, татвар мөнгөний бодлогоор дэмжих, мөн хүний нөөцийн бодлого, төрийн албаны хуулийн бас шинэчлэлээр бид дэмжиж, энэ тэнцвэртэй болгож авч явах ёстой байгаа юм. Тэгэхээр төрийн албаны хууль дотор хэд хэдэн төрийн албыг илүү их эрэлттэй болгох, мөн энэ хөдөлмөрийн зах зээлийг тэнцвэргүй болгосон хэд хэдэн шалтгааны юмнууд байгаа юм. Жишээ нь тэр 36 сарын тэтгэмж байна. 36 сар хүртэлх. Тэгэхээр энэ анх орж байхдаа бол зорилго нь өөр байсан. Төрийн албан хаагчийг ажлын мөст дээр нь он удаан жил тогтвор суурьшилтай байлгах. Гэтэл энэ зорилго маань олон жилийн явцад зорилгоосоо гажуудсан. Одоо 2 жил, 3 жил, 4 жил, 5 жил тэтгэвэрт гарах насаа дөхөөд ирэхээр энэ хугацаанд ажиллаад тэтгэмжид хамрагдаад явдаг ийм шат дамжлага ийм байдалтай зорилгоосоо гажсан гэсэн үг. Гэх мэтчилэн ийм зүйлүүдийг өөрчилж гэсэн ийм санаатайгаар зорилготой орж ирсэн ийм өөрчлөлтүүд байгаа юм. Гэхдээ одоо бүлэг дээр ийм шийдвэр гарсан учраас бүлгийн шийдвэрийг дагаад

явна гэдэг дээр битгий эргэлзээрэй. Бүлгийн шийдвэр маань энэ хуулийг татаж авъя гэсэн шийдвэр гарсан шүү дээ.

Х.Булгантуяа: Отгонбаяр гишүүн нэмж тодруулъя.

У.Отгонбаяр: Сая аудитын дүгнэлтэд төрийн албыг ажлын бүтээмжээр нь бүтээмж талаас нь авч үздэг энэ тогтолцоог бас бий болгох чиглэлээр санал дүгнэлт хэлж байна. Тийм учраас цаашдаа бол ер нь төрийн албыг цомхон чадварлаг байх ёстой гэдгийг бол би дэмжиж байгаа. Цаашдаа ч ер нь тэр чиглэл рүүгээ явах байх. Тийм учраас ер нь энэ төсвийн тодотгол дээр энэ аудитынхны гаргасан энэ дүгнэлтийг бас манайхан нэлээн нухацтай тал талаас нь бас авч үзэх ёстой гэж би хувьдаа ойлгож байна. Жишээ нь, сая бас дурдагдаж байна шүү дээ. Хэрвээ саяын энэ төрийн албан хаагч нарын цомхотгол явбал энийг дагасан 1 удаагийн тэтгэмж гэхэд чинь 26.8 тэрбум төгрөг гарах юм байна. Жишээ нь энэ одоо хаана, яаж энийг шийдэх юм бэ гээд олон асуултын тэмдгүүд гарч байгаа учраас бид бүхэн цаашдаа энэ аудитын дүгнэлт дээр нэлээн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Отгонбаяр гишүүн санал хэллээ. Баярмагнай Баярбаатар гишүү.

Б.Баярбаатар: Гишүүддээ оройн мэндийг хүргэе. Өнөөдөр төсвийн тодотгол хэлэлцэж байна. Төсвийн тодотголыг бид хэлэлцээд, яаралтай батлаад, ажилд нь оруулах ёстой. Дэмжиж байгаа. Зүгээр өнгөрсөн жил 2026 оны төсөв батлагдах үеэр энэ мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг би бас сая сөхөж харлаа л даа. Тэгээд тэр үед яг л энэ өнөөдрийн нөхцөл байдлыг сануулж байсан юм байна. Манай төсөв чинь ер нь тэгээд нүүрснээс л бүрдэж байгаа шүү дээ. Тэгээд тэр үед нь бид өөдрөг төсөв оруулж ирж батлаад, тэгээд өнөөдөр энэ тодотгол хийх нөхцөл байдал дээр хүрчхээд явж байна. Тэгээд бид нар бол цаашдаа энэ мэргэжлийн байгууллагынхаа дүгнэлтүүдийг бол ер нь өндөр түвшинд харж үзэж байж энэ Их Хурал батлах хууль тогтоомждоо харгалзан үзэх нь зөв юм байна гэж бодож байгаа юм. Гэхдээ яах вэ энэ оны 4 сард бол гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч байсан юм байна. Эдийн засгийн өсөлт нь бас 4 гаруй хувьтай байсан юм байна. Тэр үед бол бас Төсвийн тодотгол хийх шаардлагагүй гэж бол тухайн албан тушаалтнуудад мэдэгдэж байсан нь бас буруу ч биш л юм байна лээ. Тэгээд яг л сүүлийн энэ 2 сарын хугацаанд л нөхцөл байдал бас амаргүй болоод, хүнд болоод ирсэн ийм юм байж байгаа юм.

Тэгээд одоо энэ тодотгол орж ирж байгаа. Тэгээд дээр нь өнгөрсөн хугацаанд бид нар төсвөө өөдрөгөөр төсөөлөөд, урсгал зардлаа нэмчихсэн юм байна лээ. Хөрөнгө оруулалттайгаа адилхан. Тэгээд өнөөдөр энэ урсгал зардлаа танах гээд ингээд орж ирж байгаа. Хөрөнгө оруулалт бол яах вэ, тэр 5 сарын 31-ээр хэмнэлтийн хуулийн дагуу буцаан татагдаж байгаа хөрөнгө оруулалтынхаа 535 тэрбум орчим төгрөг татагдаж байгаа. Энэ бол их зөв юм байна лээ шүү. Ер нь энэ зуны сар 6 биш дээ гэж үг байдаг шүү дээ. Тэгээд бүтээн байгуулалтынхаа сараас өмнө шахаж бид нар тендерээ зарлаж дуусаж, гэрээгээ байгуулж байх энэ хуулийн заалт бол бас их үр дүнтэй юм байна гэж бол харж байгаа.

Энэ төрийн албан хаагчийн юун дээр бол сая МАН-ын бүлэг хуралдаад, Төрийн албан хаагчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг бол Засгийн газар буцааж татаж авах нь зүйтэй гэсэн улс төрийн шийдвэрийг гаргасан. Тэгэхээр одоо Засгийн газар хуралдаад энэ шийдвэрээ бол татаж аваад, магадгүй буцаагаад бас

арай өөр хэлбэрээр, уян хатан байдлаар оруулж ирэх боломжтой. Ер нь бол төрийн алба данхайсан уу гэвэл данхайсан. Би сая 2017 оны статистикийг авч үзэхэд тэр үеийн статистик дээр төрийн албан хаагч 186 мянга гэсэн тоо гарч байсан юм. Тэгээд өнөөдөр 228 мянга. Тэгэхээр энэ жилүүдэд ингээд яаж нэмэгдсэн байгаа шалтгаан нь өөрөө сонин. Зүгээр өнөөдөр тодотгол дагаж орж ирсэн учраас бид нар бас дэмжигдээгүй явчихсан болов уу гэж хараад байгаа юм.

Дээр нь энэ цомхотгол хийх аргачлал нь өөрөө яг тодорхой биш байсан. Яг хэнийг цомхотгох вэ гэдэг аргачлал нь, ямар шалтгаанаар гэдэг аргачлал нь чиг үүрэг давхацсан гэдгээр байсан юм уу гэдэг зүйлүүдийг бас анзаарсан болов уу гэж. Энэ энэ байдлаас болж бас энэ асуудал гацсан болов уу гэж харж байна. Тэгээд 1 минутаа би нэмээд авчихъя. Зүгээр санал хэлж байгаа учраас.

Тэр төрийн өмчит үйлдвэрийн газруудын асуудал дээр ... /минут дуусав/

Х.Булгантуяа: 1 минут нэмж өгье. Баярбаатар гишүүнд.

Б.Баярбаатар: Тэр төрийн өмчит үйлдвэрийн газрын засаглалын шинэчлэл дээр Ерөнхий сайд аа та бүр яаралтай анхаарч өгөөрэй гэж би танаас хүсэж байна. Сая 2 хоногийн өмнө цалингаа мэддэггүй 1 удирдлага ярилцлага өглөө шүү дээ. Би цалингаа авсан чинь 14 сая авдаг юм байна гээд. Өнөөдөр Дээд шүүхийн шүүгч ямар цалин авч байгаа билээ. Төрийн албан хаагч ямар цалин авч байгаа билээ. Энэ хүн 24 цагийн 23 цагт нь ажилладаг болоод ийм өндөр цалин авдаг юм болов уу. Энэ чинь нэг ёсны амьдрах гээд ядаж байгаа, зээлээс зээлийн хооронд лизинг төлөөд явж байгаа ард түмэнд бол аймар том доромжлол байхгүй юу. Хэн нь ингэж ийм өндөр цалин аваад, хэн нь ийм бага цалин аваад байдаг гэдэг л асуудал шүү дээ. Тэгээд энэ тэгш бус байдал гэж л энийг л хэлээд байгаа юм л даа. Тэгэхээр энийг одоо би бас бүр яаралтай анхаарч өгөөрэй гэж би танаас бас төсвийн тодотголдоо хамруулаад энэ асуудлыг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Баярмагнайн Баярбаатар гишүүний асуулт, саналд хариулъя. Ер нь Баярбаатар гишүүн маш чухал асуудал хөндлөө. Манай Засгийн газрын тавьж байгаа тэргүүлэх зорилтуудын 1 бол төрийн өмчийн компаниудын үр ашгийг дээшлүүлэх явдал. Тийм ч учраас би Ерөнхий сайдаар томилогдохдоо төрийн өмчийн компаниудын тоог бууруулах, үр ашигтай болгох тодорхой зорилт саналуудаа хэлсэн. Ийм учраас шууд ажилдаа орсон. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар гэхэд бид 2 төрийн өмчийн компанийг татан буулга, нэгтгэх шийдвэр гаргасан. Одоо бүх компанийн төрийн өмчийн бодлого зохицуулалтын газруудад тодорхой үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Одоо бидний өгсөн үүрэг чиглэлийн дагуу энэ жил компаниудыг IPO-г нь гаргах буюу нийтийн ХХК болгох 16-20 компани ирэх онд. Мөн ирэх онд 109 улсын үйлдвэрийн аж ахуйн газруудыг 30-аар цөөлөх гэх мэтчилэн тодорхой чиглэлүүд ажиллаж байгаа. Үр ашгийг 30 хувиар нэмэгдүүлэх, зардлыг 15 хувиар нэмэгдүүлэх чиглэл өгсөн. Яг таны хэлдэг тэр саналын дагуу төрийн өмчийн компаниудын захирлуудын цалингийн дээд хэмжээг тогтоох даалгавар өгч байгаа. Энийг бас үр ашигтай нь, үр дүнтэй нь, хийсэн менежментийн гэрээтэй нь уялдуулж Канадын менежментийн загвар буюу үр ашгийг дээшлүүлсэн, өр авлагыг барагдуулсан, үр дүнд чиглэсэн ийм менежментийн гэрээний зарчимд шилжүүлэх чиглэлийг өгөөд ажиллаж байна. Бид 10 сард төсөв өргөн барих үедээ Нийтийн өмчийн тухай хууль буюу хуучнаар Төрийн

ба орон нутгийн өмчийн тухай хуулиар компаниудын хуулийг бас шинэчилж байгаа гэдгийг онцолж хэлье. Энэ асуудлаар бол маш тодорхой саналтай байна.

Ер нь таны бас нэг асуултад нэмээд хариулчихад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол тухайн үед нүүрсний үнийг 2 төсөөлөл ирүүлж байсан юм байна лээ шүү. 107 доллар, 122 доллар гэж. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тооцоолол зөв, Эдийн засаг, хөгжлийн яамны, Сангийн яамны тооцоолол буруу гэж бас хэлэх нь өрөөсгөл гэж бодож байна. Энэ бол манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн тоон дээрээ бас ийм саналуудыг өгч байсан. Үнэхээр сүүлийн үеийн нөхцөл байдал бол өнөөдөр бол урьдчилан харагдаж болохгүй тийм нөхцөлүүд өөрчлөгдөж байгаа цаг үе гэдгийг бас онцлон хэлж тэмдэглэмээр байна.

Тэгэхдээ манай баялгийн хараал буюу Голланд өвчний шинж тэмдэг бол ингээд нүүрсний экспорт нэмэгдээд үнэ нь өсөөд, уул уурхайн бүтээгдэхүүн өнөөдөр гэхэд дагаад бүх зардлаа тэлчихсэн. Жишээлбэл сая тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн саналтай санал нэг байгаа юм. Зөвхөн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын хувьд 2025 оны нийт зардлын хэмжээ 2020 онтой харьцуулахад 2.3-10.7 дахин өссөн. Үүний нотлох баримт гээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэсэн. Энэ зардлаа хэт ингэж нэмэгдүүлж ирсэн нь бол үр дүнгүй, өнөөдрийн энэ тодотгол хийх зайлшгүй шаардлага болж байна гэдгийг бас онцлон тэмдэглэж байгаа.

Тэр 36 сар ч гэсэн ер нь бол анхных нь зорилго багш, эмч нарыг тогтвортой ажиллуулах зорилгоор л ийм тэтгэвэр, тэтгэмж олгохоор гарсан шүү дээ. Тогтвортой ажиллаж байгаа. 15 жил, 20 жил. Сүүлдээ энийг өөрчлөөд өөрчлөөд явсаар байгаад бүгдийг нь хамруулаад, тэгээд өөр газар ажиллаж байгаад 5 жил ажиллаад л 5-аар үржүүлсэн хэмжээний цалин тэтгэмж аваад гардаг ийм нөгөө тогтвортой ажиллахад чиглэгдсэн биш, нөгөө үндсэн зорилго, үзэл баримтлалтайгаа нийцээгүй өөрчлөлт гараад байгааг л засах гэж, зохицуулах гэж хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байгааг зохицуулах гэж ийм саналыг манай Сангийн яам боловсруулсан гэж ойлгож байгаа юм.

Х.Булгантуяа: Баярбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Баярбаатар: Сая Ерөнхий сайдын хэлсэн дээр үндэслээд, түрүүн бүлгийн хурал дээр Сангийн сайд бас хэлсэн. Энэ Монголбанкны төсөв чинь ерөөсөө энэ төсвийн төсөвтөө ерөөсөө огт орж ирдэггүй. Өнгөрсөн хугацаанд ч орж ирж байгаагүй. Тэгэхээр Булгантуяа дарга аа танд хүсэлт байна. Санал, хүсэлт. Энэ Монголбанкны чинь орон тоо одоо 600 гаруй болчихсон байгаа юм байна. Хэдэн жилийн өмнө 300-аар ажиллаад болоод байсан юм байна. Баахан газрууд нэмэгдчихсэн юм байна. Тэгээд энэ төсвийн тодотгол Монгол Улсын төсөвтэй бол угаасаа хамт орж ирж байсан түүх байхгүй. Тэгэхээр хурал даргалагчийн хувьд та Эдийн засгийн байнгын хороонд өгч энэ бүтцийн өөрчлөлтийг танилцуулах үүргийг өгөөч гэсэн ийм саналтай байна. Сая Ерөнхий сайд ч гэсэн хэлж байна. Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын төсвийн өсөлтийг ч бас хэлчих шиг боллоо.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотой Улсын Их Хурлаас болохгүй бол ажлын хэсэг гараад, төсөв санхүүжилтүүдийг нь харж бол болох байх. Сая Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дээр бид нар төсвийн дүн шинжилгээ, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой мэдээлэл сонсоход бас яг тийм байсан. Зарим байгууллагууд бол

сүүлийн 10 жилийн хооронд төсөв 4.5 дахин нэмэгдсэн байхад, зардал нь 14, 15 дахин нэмэгдсэн байгууллагууд ч гэсэн бас их байгаад байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Анх удаад ийм хасах тодотгол хийж байгаа биш л дээ. Ер нь зөндөө л ийм хасах тодотгол хийдэг. Гэхдээ бидэнд 1 мартдаг маш ноцтой зүйл байна. Нөгөө шинэ баян цээж өвчтэй гэдэг шиг уул уурхайгаас мөнгө олоод ирэхээр тэгээд л бүх салбар дээр орон тоо нэмээд л, тэгээд л хэрэглээ тал руугаа төсвөө тэлээд л, тэгээд ийм байдлаас үүдэлтэй өнөөдөр өндрөөс унаж байгаа ийм л зүйл болж байгаа шүү дээ. Тэгэхээр энд бол юу гэдэг юм одоо ингээд гэв гэнэт ийм зүйл үүсэж байгаа гэдэг зүйл ерөөсөө биш. Өмнө нь ч бас ийм байсан. Тэгэхээр бид нар яах вэ гэхээр ерөөсөө онош бол их тодорхой байгаа шүү дээ. Зөвхөн нүүрснээс хараат байгаад байна. Тийм учраас ирээдүйд уул уурхайн салбар бол манай тэргүүлэх салбар мөн. Тэгэхээр энэ уул уурхайн салбарын өөр ашигт малтмалуудыг эргэлтэд оруулъя. Тухайлбал, критикал минерал, бусад төрлийн өнгөт металл гээд дэлхийн зах зээл дээр үнэ цэнтэй болж байгаа энэ зүйл рүүгээ ажиллах ийм стратеги ерөөсөө байхгүй. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар салбарын стратеги байхгүй гээд заачихсан. Гэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр нь энэ талаар нарийвчилсан стратеги бодлого байхгүй. Тийм учраас ийм том уналтад ороод байгаа байхгүй юу. Хэрвээ том компани байсан бол ийм зүйл хийхгүй гэж би бол бодож байгаа. Тэгэхээр энэ дээрээ бид нар оношоо зөв тавих хэрэгтэй байна. Энэ бусад эрсдэлтэй үед яах вэ гэдэг энэ зүйлүүдээ одоогоос ингээд бодох хэрэгтэй. Тодотгосны дараа мартаж болохгүй. Бидний том алдаа бол мартчихдаг. Тэгээд мөнгөтэй болохоороо халгиж цалгиж байгаад, тэгээд л мөнгөгүй болохоороо л би ч тэгж хэлж байсан. Тэр үед ч тэгж сануулж байсан гээд л бүгдээрээ ингэж яриад, тэгээд л буруутан хайгаад эхэлдэг. Тийм учраас энэ дээр ялангуяа манай улс төрийн шийдвэр гаргаж байгаа түвшинд улс төрийн албан тушаалтнууд Улсын Их Хурал, Засгийн газар онцгой анхаарах хэрэгтэй. Энд Төрийн жирийн албан хаагчдын Сангийн яамны гэдэг юм уу, төрийн жинхэнэ, жирийн албан хаагчдын буруу ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ дээр бид нар онцгой ингэж анхаарах хэрэгтэй байна.

2 дугаарт нь энэ үр дүн гарсан сонголтоосоо бид нар ухарч болохгүй орон нутгийн нэмэгдлийг 100 хувь хүртэл өгөх боломжийг орон нутагт нээж өгсөн. Энэ том хөшүүрэг болсон. Одоо эргээд үүнээсээ ухрах юм бол энэ орон нутаг чинь дахиад хүн очихгүй. Тэгээд зөв зүйтэй гаргаж байгаа бодлогыг үргэлжлүүлээд явах нь бол Монгол төрийн эрхэм чанар. Тийм учраас энэ дээр бол байр сууриа илэрхийлж байна.

3 дахь нь бол гэрээ хийсэн ажлууд байгаа. 5 сарын 31-ний дотор гэрээ хийгээгүй ажлуудыг цуцална. Мөнгийг нь татна гэдэг зөв. Тэгэхгүй бол хэзээ бүтээн байгуулалтаа хийх юм. 5 сарын 31 .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя. Тэгээд Бадамсүрэн гишүүн тодруулчаарай.

Г.Занданшатар: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн маш чухал бодлого хөндлөө. Бид өнгөрсөн жил төсөвт хориг тавихдаа яг энэ асуудлыг хөндөж байсан. Мөчлөг сөрсөн бодлого явуулах шаардлагатай боллоо. Ийм учраас алдагдалгүй төсөв батал гэдэг шаардлага нь бол үндсэндээ алдагдалгүй төсөвтөө ч биш ийм

нөхцөл байдал үүсвэл төсвийн орон зай үлдээхэд л чиглэгдэж ийм шаардлага тавьж байсан. Хэрвээ тэр үеийнхээр 2, 3 их наядын алдагдалтай төсөв байсан бол өнөөдөр 5, 6 их наядын асуудал болоод сууж байна. Энэ нөгөө Голланд өвчин гэдэг шинж тэмдэг маань яг таны хэлдгээр нөгөө шинэ баян цээж өвчтэй гээд л тэлээд байдаг, зардлаа нэмээд байдаг. Тэгээд урсгал зардал нэн ялангуяа нэмчихээр эргээд буулгаж болдоггүй ийм хавханд орчихдог санхүүгийн. Ийм учраас нөгөө солонгоруулъя. Импортоос-экспортод, халамжаас-хөдөлмөрт гэдэг нөгөө бодлогуудаа л энэ түүхий эдийн үнэ өндөр үед бид хэрэгжүүлж байх ёстой юм билээ. Ийм учраас орон нутагт тэр эрх мэдлийг өгсөн зарчмаас ухарч болохгүй. Энэ зарчмаа бид үргэлжлүүлнэ гэж бодож байгаа. Ирэх жилийн төсвөөс бол. Тийм учраас нүүрсний хамаарлын бууруулж, уран, ховор элемент, критикал минералын экспортыг нэмэгдүүлэх, “Алт” хөтөлбөрийг бас хэрэгжүүлэх, орлогын 30 хувийг Баялгийн сан руу төвлөрүүлэх, Ашигт малтмалын хуулийг шинэчилж, ил тод байдлыг хангаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, орон нутагт бас сонирхлыг бий болгох, орон нутгийн ард иргэдийн оролцоо, сонирхлыг хангах гэх мэт цогц бодлогыг хэрэгжүүлэхээр төвлөрч байна.

Уул уурхай дотор ганцхан нүүрснээс хамааралтай эдийн засаг байж болохгүй шүү дээ. Төсөв байж болохгүй шүү дээ. Ийм учраас л илүү л уул уурхайн салбартаа ч гэсэн хөдөө аж ахуйн салбартаа ч гэсэн бодитой өөрчлөлтүүдийг хийхгүй бол бид яриа хэлбэрээр өргөжиж болохгүй гэж бид үзэж байгаа юм. Ийм учраас бид энэ санхүүгийн хяналтыг тодорхой хэмжээнд дээшлүүлнэ. Орон нутгийн эрх мэдлийг дээшлүүлэх, оролцоог хангах чиглэлээр манай Бадамсүрэн гишүүн шиг туршлагатай гишүүд бас нэн ялангуяа энэ санхүү, төсвийн хуваарилалт дээр бас идэвхтэй хамтарч ажиллахыг хүсэж байна. Ингэж байж бид эдийн засгийн бүтцээ өөрчилж чадна. Эдийн засгийн бүтцээ өөрчлөхгүй бол ганцхан шахуу бүтээгдэхүүнээс экспорт үндсэндээ хамааралтай ийм эдийн засаг тогтвортой байж чадахгүй байна. Нөгөө тогтвортой хөгжил худлаа болно. Ийм учраас бидний энэ төсвийн тодотгол хийж байгаа зайлшгүй шаардлага бол энэ эхлэлийг тавихад бас чиглэгдэж байгаа юм гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ. 3 номерын микрофон байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

И.Батхүү: Гишүүний асуултад нэмж хариулъя. Түрүүн эдийн засгийн тооцоололтой холбоотой нүүрсний үнэ өмнөх он дээрх хэт өндөр тооцоод байна гэсэн тийм шүүмжлэлүүд гарч байсан. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам бүгд энэ тооцоолол гаргахдаа бас хоорондоо албан ёсны макро тоонуудаа солилцож, тухайн үедээ хамтарч ажилладаг. Тэгэхээр оны өмнө 2025 оны төсөв боловсруулах үед бол нүүрсний үнийг тухайн үедээ 2 янзаар өгөгдөж байсан байна. 107, 122 гэдэг дундаж үнийн хувилбартай. Тэгээд экспортын нүүрсний биет хэмжээг 50 сая тонн гэсэн тоонууд өгөгдөж байсан. Үүний дараа 2025 оны 3 сарын үед 2026 оны төсвийн хүрээний нэгдэл боловсруулахад нүүрсний дундаж үнийг 2025 онд 85 ам.доллар, 2026 онд 88 ам.доллар, 2027 онд 92 ам.доллар, 2028 онд 96 ам.доллар гэсэн үнүүд бас тухайн үед гаргаж байсан.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам үүнтэй холбоотой төсвийн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт 1 минут өгье.

И.Батхүү: Төсвийн гүйцэтгэлийг тооцоолохдоо 80 ам.доллараар тухайн үедээ 4 сарын хэлэлцүүлэг, 5 сарын эхээр бас тооцож үзэж байсан. Энэ үед бол төсвийн орлогын тасалдал 2.3 их наяд гарч болох эрсдэлтэй гэсэн тооцоолол гарч байсан. Сүүлийн үед эдийн засгийн нөхцөл байдал, гадаад секторын нөхцөл байдал сайжрахгүй, 4, 5 сарын үед бас нүүрсний худалдаатай холбоотой хүлээгдэж байсан идэвхжил нь бас явагдаагүй учраас нүүрсний энэ оны эхнээс тооцсон дундаж үнэ бол бас 70 ам.доллараар унасан. Үүнтэй уялдуулаад бас оны эцсээр хүлээгдэж буй гүйцэтгэлийг 3.3 их наядын алдагдалтай гэж тооцсон байгаа. Яг нүүрсний дундаж үнэтэй холбоотой гадаад олон улсын байгууллагуудын тооцоолол ч гэсэн бас ойролцоо үнэтэй байгаа. Жишээ нь ОУВС-ийн үнэ гэхэд энэ онд 68 ам.доллар, ирэх онд 73 ам.доллар гээд цаашаа 72, 72 гэсэн үнүүдийг өгсөн байгаа.

Х.Булгантуяа: Бадамсүрэн гишүүн нэмж тодруулъя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр ийм л юм хүсээд байгаа юм л даа. Жишээлбэл Арабын орнууд гэхэд байна шүү дээ Газрын тосны орлогоос орж байгаа орлогоосоо өөр салбар буюу критикал минералыг хөгжүүлэхэд зориулж хөрөнгө оруулалт хийж байгаа байхгүй юу. Манайд энэ уул уурхайн нүүрснээс орж байгаа орлогоос газрын тосны дотоодын үндэсний олборлолтыг дэмжихэд зориулах ёстой. Хятад ямар бодлого хэрэгжүүлдэг вэ гэхээр энэ олдож байгаа уул уурхайн болон бусад орлогоосоо ЖДҮ-лэлийг дэмжих, эргээд мөнгө олдог салбарт хөрөнгө оруулалт хийх ийм бодлогуудаа маш ихээр явуулж байгаа. Тэгэхээр бид нар нөгөө мөнгөтэй болоод ирэхээрээ энийгээ талыг нь нэг зүйлд цацдаг. Зүй нь бол тодорхой хувийг нь эргэж мөнгө олдог салбартаа зарцуулах ёстой. Тухайлбал, газрын тосны үйлдвэр түүхий эдээ яаж бэлдэх юм. Энэ гадаадын хөрөнгө оруулалттай компанид найдаад ингээд 3 жилийн дараа газрын тосны үйлдвэр ашиглалтад ороход хуурай үйлдвэр болох гэж байгаа шүү. Түүхий эд байхгүй болж байгаа шүү. Тийм учраас энийг нэн даруй энэ бодлогыг хэрэгжүүлэх/минут дуусав/

Х.Булгантуяа: Бадамсүрэн гишүүн санал хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: 2.1 их наяд төгрөг бид нар хэмнэх гээд төсвийн тодотгол хийх гээд сууцгааж байна. Тэгээд би эхлээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэг юм асууя гэж бодсон юм. Та бүхний энэ удаагийн төсвийн тодотгол дээр та бүхний хийсэн энэ зөвлөмж, одоогийн Засгийн газрын оруулж ирж байгаа төсвийн тодотголтой ер нь хэр нийцэж байна. Хэр ойртож байна. Та нар энэ дээр ямар бодолтой байна. Зориуд би сонсьё гэж бодож байна.

2 дугаарт нь энэ төрийн албан хаагчдын 14400-аар цомхотгоно гэдэг энэ зөв. Одоо бид нар бага багаар аль болохоор энэ данхар төрөөсөө төрийн албан хаагчдыг хийсвэр тоогоо бас жаахан багасгаж явахгүй бол болохгүй. Ер нь нэг аль нэг газар хэлтэс дээр бол 2-3 л гайгүй ажилладаг хүн байдаг юм шүү дээ. Гол ачааллыг нь авдаг. Бусад нь бол тэгээд аялдан дагалдах, урсгалаар нь явуулах ийм маягтай л байдаг юм. Тэгэхээр зэрэг энэ зарим нэг давхардсан чиг үүргүүдийг нэгтгээд, зохион байгуулаад явахад бол энэ дээр бол буруу юм байхгүй гэж бодож байгаа юм.

Нөгөө талдаа бол сая тэр Бадамсүрэн гишүүний хэлсэн тэр орон нутгийн нэмэгдлийг бол хэвээр үлдээгээд явах бол маш чухал асуудал. Яг үнэндээ бол энэ хөдөө, орон нутагт ажиллаж байгаа хүмүүст бол маш том хөшүүрэг болдог. Энийг бол зориуд бас ингэж хэлмээр байгаа юм. Ялангуяа тэр сумын түвшинд ажилладаг төрийн албан хаагчид. Энэ манай Төрийн албаны зөвлөл ч гэсэн сумд ажиллаж байгаа тэр албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг хөнгөвчлөх, төрийн албаны шалгалтыг бас хөнгөхөн байдлаар авах тэр юмыг бол бас зохион байгуулах хэрэгтэй. Үнэхээр. 1 сумын Тамгын газрын 7, 8 хүн л тухайн сумыг бараг үндсэнд нь аваад явдаг тийм л хэмжээнд оччихсон байгаа зарим сумууд бол. Тэгэхээр энэ дээр бол онцгой анхаарах хэрэгтэй гэж бодож байна.

Сангийн яамнаас нэг юм асуугаадахъя. АМНАТ-ийн татвараар ер нь энэ Монгол Улс хэчнээн хэмжээний орлого төвлөрүүлдэг юм бэ. Эндээс яг аль, аль аймгууд ямар, ямар хэмжээтэйгээр нь төвлөрүүлдгийг хэлээд өгөөч. Тэгээд тэр Дундговь аймгийн тэр “Эрдэнэс Алт Ресурс” компани хэчнээн хэмжээний АМНАТ төвлөрүүлээд, хэчнээн хэмжээний орлого төвлөрүүлээд, тэгээд нөгөө Дундговь аймаг маань төсөв төвлөрүүлдэг аймаг болчихов. Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Болдын Жавхлан сайд. Ажлын хэсгээс юм уу. 4 номерын ажлын хэсгийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Тэгэхээр нэгдсэн төсөв дээр АМНАТ-аас бол нийтдээ 5.6 их наяд төгрөг төвлөрдөг. Тэнцвэржүүлсэн орлого дээр бол 3.9 их наяд төгрөг төвлөрдөг байгаа. Аймгуудын нийт төсвийн бол үндсэндээ 60 гаруй хувь нь зөвхөн Өмнөговь аймгаас АМНАТ бол төвлөрч байгаа. Дээр нь нэмээд Орхон аймаг, Дорноговь аймаг 2 бол дийлэнхийг нь бүрдүүлж байгаа. Үлдсэн бүх аймгууд нийлээд 10 хувиас доош байгаа. 7, 8 орчим хувийг бүрдүүлж байгаа. Дээр нь АМНАТ бол өөрөө орон нутгийн орлого биш. АМНАТ бол 65 хувь нь бол өөрөө Ирээдүй өв сан руу бол шууд орчхож байгаа. 10 хувь нь бол орон нутгийн хөгжлийн санд орж байгаа. Энэ жилийн хувьд бид нар АМНАТ-ыг сая тодотголоор нэлээд бууруулсан. Үүнтэй холбоотойгоор бол нөгөө 10 хувь нь орж байгаа нөгөө орон нутгийн хөгжлийн сан маань бол дагаад буурч байгаа гэсэн үг. Анх батлагдсан орон нутгийн хөгжлийн сан маань 599 тэрбум буюу 600 орчим тэрбум төгрөг байсан. Энэ бол 416 тэрбум төгрөг болоод буурчхаж байгаа гэсэн үг. Тэгэхээр аймгууддаа бол тэр хэмжээгээр бол нөлөөлнө. Ялангуяа АМНАТ орон нутгийн хөгжлийн санг бид нар сүүлд өөрчлөөд илүү АМНАТ төвлөрүүлсэн аймагт нь бол илүү төвлөрүүлж байгаа.

Аймагт болбол илүү их нөлөөлж байгаа нь бол ААНОАТ байгаа. ААНОАТ-ын 40-өөс дээш хувь бол олон жилийн дунджаар 40-өөс дээш хувь нь уул уурхайтай өөрөө холбоотой байгаа. Тэгэхээр уул уурхай сайн явж байгаа аймгуудад тухайн аймгаас нь орж ирсэн орлогынх нь ААНОАТ-ын 40 хувийг буцааж өгөөд, олгоод явж байгаа ийм зарчим бол үйлчилж байгаа. Энэ бол аймгууд дээр шууд орлогод нь нөлөөлөөд явж байгаа.

Яг тухайлан Дундговь аймгийн хувьд бол “Эрдэнэс Алт Ресурс” компани бол одоогийн байдлаар 14.6 тэрбум төгрөгийг ААНОАТ дээр бол төвлөрүүлчихсэн байгаа. Тэгээд энэ нь бол энэ оны эхэнд бид төлөвлөж байсан орлогоосоо бол даваад гарчихсан ийм байдалтай байгаа. Дундговь аймагт.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 номерын ажлын хэсгийн микрофон дээрээс Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Гишүүний асуултад хариулъя. Та бүхэн санаж байгаа. 2024 оны 12 дугаар сарын 8-нд 2025 оны төсвийн төслийг хэлэлцээд, Улсын Их Хурлаар баталсан. Тэр үед бид нар бол төсвийн төсөл дээр нүүрсний үнийг 85 ам.доллараар тооцох гэдэг саналаа бол хэлж байсан. Мөн энэ оны 3 дугаар сард Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлж байсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалд бол нийт төсвийн алдагдлын хэмжээг бол хасах 1 хувь, нүүрсний үнийг 85 хувь, эдийн засгийн өсөлтийн хэмжээг бол 5.5 хувь байх тооцооллуудыг хийж байсан. Энэ байдлаар тус 2 байгууллагад хүргүүлж байсан. Тэгээд өнөөдөр бол яг орж ирж байгаа 2025 оны төсвийн хүрээ .../минут дуусав/

Х.Булгантуяа: 1 минут нэмж өгье.

А.Энхбат: Өнөөдөр оруулж ирж, танилцуулж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл болон Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийн төсөл дээрх хийх өөрчлөлт тодотгол дээр бол энэ тооцоонууд бүрэн сууж нийцтэй байдлаар орж ирж байна гэж харж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэгэхээр зэрэг бид нар энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө зөвлөмж юмыг дагаж явахгүй бол ямар үр дагаварт хүрээд байгаа юм бэ гэдэг л энэ олон удаагийн тодотголын асуудлууд яваад байгаатай л холбоотой гэж бодоод ингэж асууж байгаа юм. Хойшдоо бол энийг онцгой анхаарч явахгүй бол бас болохгүй нь гэдэг ийм зүйлийг бол бид нарт бас мэдрүүлж байна.

2 дугаарт нь энэ уул уурхайн бүтээгдэхүүнээр Монгол Улсын эдийн засаг үндсэндээ бүрдэж байгаа гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөөд байдаг. Тэгсэн хэр нь нөгөө уурхайгаа эрхлээд явуулаад, байгаа бүс нутгийнхаа хамаг юмыг нь хамж аваад л байдаг ийм л юм л үеийн үед байгаад байгаа юм. Өмнөговь аймаг орон нутгийн хөгжлийн сангийн 60 гаруй тэрбум төгрөг очсон. 1.7 их наяд төгрөг төвлөрүүлж байгаа төсөвт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт 1 минут тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэр орон нутгийн хөгжлийн сангийн 60 орчим тэрбум төгрөгөөс нь 16-г нь татаад авчхаж байгаа юм байна лээ. Нөгөө Дорноговь аймаг 50 орчим тэрбум төгрөгийн орон нутгийн хөгжлийн сантай бас 20 гаруй тэрбумыг татаад авчхаж байгаа юм байна лээ. Ингээд нөгөө уул уурхай явуулаад эдийн засгаа бүрдүүлж байгаа аймгуудынхаа хамаг юмыг нь татаж аваад байдаг. Зарим аймагт нь болохоор зэрэг бөөн бөөнөөрөө дарга, сайд нар нь очоод уул уурхай явуулахгүй. Та бүгдийнхээ талд байна гээд байдаг. Нөгөө говийн хэдэн иргэд, малчид маань болохоор тэгээд чимээгүй, дуугай ноомой болохоор нь ингээд байдаг юм уу. Тэгээд энэ тал дээрээ жоохон шударга баймаар байх юм. Ядаж энэ орон нутгийн хөгжлийн сангийнх нь үлдэгдлүүдийг нь тэгээд орхичхож болдоггүй юм уу. Сангийн сайдаас энийг асуумаар байх юм.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Ажлын хэсэг.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Гишүүнтэй бол санал 1 байна. Уул уурхай бол Монгол Улсын хөдөлгөгч хүч бол мөнөөсөө мөн. Нийт төсвийн орлогын маань 1/3 нь уул уурхайгаас явж байгаа. Өмнөговь аймгийн хувьд бол 1.7 их наяд төгрөгийн орлого бол энэ жил анх батлагдсанаараа төвлөрүүлэх тооцоо байсан бол одоо 1.5 их наяд төгрөг болж буурсан байгаа. Орлоготой холбоотойгоор. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг тодотгож бол татаагүй гэж механик аргаар бол татаагүй гэж хэлье. Учир нь юу вэ гэхээр орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр нь өөрөө АМНАТ-ийн орлого байгаад байгаа юм. Тэгэхээр АМНАТ-ийн орлого өөрөө бид нар орлогоо ингээд орохгүй байна гээд бууруулчихлаар тэр нөгөө хуваарилагдах мөнгө маань буураад, тэгээд тухайн аймгууд дээр байгаа орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр буурчхаж байгаа учраас ингээд буурчхаж байгаа гэсэн үг. Энэ томъёогоороо гараад ирчхаж байгаа гэсэн үг. Тэрнээс биш эх үүсвэрийг нь бол бид нар хуульчлаад заачихсан ийм .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Би бол яах вэ энэ төсвийн тодотголын суурь үндсэн зарчмыг бол ойлгож, дэмжиж байгаа. Зарим зүйлүүдийг яг л бодит хөрсөн дээр угаасаа ярихаас өөр аргагүй нөхцөл байдлууд бол байна. Тэгэхээр энэ асуудлуудаа маш зөв ойлголт олон нийтэд өгөөд, төрийг цомхон, бүтээмжтэй, гүйцэтгэл гардаг гүйцэтгэл өндөртэй, гүйцэтгэлийг бас хийж чадсан газар нь бас илүү их цалин, урамшуулал, нэмэгдлээ авдаг энэ зарчим руу орохгүй бол ер нь хавтгайдаа нэг ийм юмнууд салбар салбар бие биетэйгээ барьцаад явчихдаг ийм зүйлүүд байдаг. Нуугаад яах вэ. Би нэг их төрийн албыг буруутгаад ч юм уу, тэд нарт хайргүйдээ хэлээд байгаа юм биш. Адилхан л жаргал, зовлонг нь амсаад л явж байсан ийм хүн. Тэгэхдээ бүтээмжтэй хэсгүүд нь юм бүтээдэггүй хүмүүстэйгээ адилхан цалин урамшилтай яваад байхаар угаасаа байгууллагын соёл жигдэрдэг, бүтээмж жигд бүгд буураад эхэлдэг. Тэгэхээр зүгээр өнөөдрийн энэ тодотгол бол цаашдаа төрийн албаны реформыг хийх, илүү их гүйцэтгэлийг үнэлж сурах тэр зүйл рүү бид нар бас хөтөлсөн ийм реформын эхлэл байх гэж би бодоод байгаа юм. Тийм учраас энийг тал талаасаа маш сайн ярилцаад, яах вэ өнөөдрийн түвшиндээ бас төрийн албан хаагчдынхаа эрх зүйн байдлыг нэг их дордуулахгүйгээр, харин зүгээр гэдэг юм шинээр төрийн албанд орох ч гэдэг юм уу, цаашдаа бас дүрэм журам маш тодорхой байх энэ нөхцөл байдлыг бүрдүүлэхэд бас анхааръя гэдэг зүйлийг нийт гишүүддээ уриалж байгаа юм. Ард түмэн ч энийг хүсэж байгаа. Төр цомхон байгаач ээ, төр бүтээмжтэй байгаач ээ гээд. Тэгэхээр энэ зүйлүүд байгаа шүү гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

Дээрээс нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ер нь Засгийн газар цаашдаа ямар бодлого баримтлах гэж байгаа вэ. Бид өнөөдөр яах вэ, орлого зарлагын харьцаа дээр бас жоохон ойртуулах талын өөрчлөлтүүдийг хийгээд явах байх. Гэхдээ ер нь зүгээр бас энэ орлогыг нэмэгдүүлэх чиглэлд эдийн засгийн тодорхой яг ямар салбарууд дээр илүү их цаг үеийн шинжтэйгээр ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ. Ялангуяа уул уурхайн сайдаас л энийг хариулах байх. Энэ уул уурхайтай холбоотой асуудал дээр орон нутгийн асуудлуудаа ойлголцох хэрэгтэй байна. Тэгээд Монгол төр бас нэг ийм тодорхой үйл ажиллагаа явуул гээд тусгай зөвшөөрөл өгчхөөд, энийг нь бас ямар нэгэн байдлаар хариулт өгч чадахгүй, тодорхойгүй орчинд оруулаад байна гэдэг бол бусад салбар нь угаасаа ингээд

ажиглаад зогсчхож байгаа ийм байна. Тэгэхээр энэ дээрээ бас ямар бодлого байгаа юм бэ гэж.

Тэгээд бас төсвийн тодотголын Ерөнхий сайдын мэдээлэл дээр ч гарч байсан байх. Сангийн сайдын ч мэдээлэл дээр бас 500 тэрбум төгрөгийг тендер худалдан авалтаа зохион байгуулж чадаагүй гээд хураагдаж байна. Тэгэхээр энэ тендерийн хууль тогтоомжийг ер нь бас тодорхой хэмжээнд зөв зохион байгуулж, шинэчлэх зайлшгүй шаардлага байна.

2 дугаарт .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ерөнхий сайд эхлээд хариулъя.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг гишүүний асуултад би эхлээд хариулъя. Уул уурхай асуултад Дамдинням сайд хариулна. Бэлдэж байгаарай.

Тэгэхээр Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Сайнзориг гишүүн бол бас төрийн албаны бүх шатад ажиллаж, төрийн албаны зовлон жаргалыг сайн мэднэ. Өнөөдрийн энэ хийж байгаа төрийн албаны шинэчлэл бол төрийн албан хаагчдаа илүү тогтвор суурьшилтай, мерит чадавхын зарчмыг нь улам дэмжсэн ийм л тогтолцоог нь бүрдүүлэхийг хүсэж байгаа юм. Яг үндсэндээ төрийн албан хаагчид бол нүүдлийн шувуу шиг ирээд, дээр нь суугаад байгаа аттестатчилахгүй байгаа юманд л дургүй болохоос биш өнөөдрийн энэ өөрчлөлт шинэчлэлтийг судалгаанаас үзэхэд дэмжиж байна гэж би ойлгож байгаа. Яагаад гэхээр төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам гэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас баталсан журам байгаа юм. Энэ үнэлгээний журмыг энэ үнэлгээг нээлттэй зарлах ёстой юм байна лээ. Ийм учраас үнэлгээний баг нийт албан хаагчдын үнэлгээний дүнг төсвийн шууд захирагчид энэхүү журмын 6.6-д заасан саналын хамт танилцуулсны дараа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг мэдээлэх хуудасны дагуу 6 дугаар болон 12 дугаар сард багтаан байгууллагын веб хуудсаар дотоод мэдээллийн сүлжээгээр нээлттэй мэдээлнэ гэж байгаа юм. Ингэж төрийн албан хаагчийн үнэлгээг дотооддоо нээлттэй ил тод байлгах мерит зарчмыг барих л энэ зарчмыг ярьж байгаа юм. Ингэж байж энэ нөгөө төрийн алба өөрөө нэр хүндтэй, төрд итгэх ард түмний итгэл сэргэсэн ийм болохгүй бол одоо үндсэндээ төрийн албан хаагчийг ард иргэд авлигач, хулгайч гэж үздэг. 1 үхрийн эвэр доргивол 1 мянган үхрийн эвэр доргино гэж Монгол төрийн төлөө чин шударгаар зүтгэж байгаа нийт төрийн албан хаагчдад 1, 2 хүний алдааг нялзааж, хардаг ийм байдал бий болчихоод байна. Ийм учраас төрд итгэх ард түмний итгэлийг сэргээх хамгийн гол арга чиглэл бол манай энэ төрийн албандаа өөр өөрөө амьд организм шиг шинэчилж, хөгжиж, энэ төрдөө зүтгэж байгаа төрийн албан хаагчдынхаа нэр хүндийг өндөрт өргөдөг энэ зарчмыг оруулах ёстой. Ийм ч учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ зарчмыг оруулж шингээж явсан. Ийм учраас энэ төрийн албан хаагчийн үнэлгээний системийг Төрийн албаны зөвлөлтэй хамтран боловсруулахаар Төрийн албаны зөвлөлд бас саналаа өгөөд, саналыг нь авчихсан. Бид нар энэ ажлыг төрийн албаны шинэчлэлтэй хамт энэ үлдэж байгаа 6 сарын хугацаанд хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчдыг тэгж хоморголон халаад, тоо дугаар өгөөд, тэгээд л доороос нь эхлээд өөрчлөөд бай гэсэн чиглэл өгөхгүй. Харин ч энэ аттестатчилал үнэлгээ дээр тулгуурлаж ард иргэдээ чирэгдүүлдэг биш яг сайн ажилладаг, чадвартай мэргэжилтнүүдээ дэмжсэн, тэдний үр ашиг, цалин хөлсийг улам сайжруулсан

бодлого хэрэгжүүлэхгүй бол тоо нь ихсэх тусам чанар нь муудаад байж таарахгүй. Харин яг ажиллаж байгаа хүнээ үр дүнгээр нь урамшуулдаг, шагнадаг дэвшүүлдэг энэ зарчмаа төрийн албанд нэвтрүүлэх бодлогын эхлэлийг тавихыг зорьж байна. Энэ дээр манай Сайнзориг гишүүн бол нэлээн сайн ярьдаг, үнэлдэг гишүүний хувьд бас энэ мерит зарчим, ил тод байдлыг төрийн албанд мөрдүүлэх талаар энэ хуулийн өөрчлөлт, энэ чиглэлд идэвхтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна. Уул уурхайн асуудалд Дамдинням сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Дамдинням сайд хариулт өгье.

Г.Дамдинням: Сайнзориг гишүүндээ маш их баярлалаа. Тэгээд ер нь судлаачдын үздэгээр бол ДНБ-ий 8 хувиас дээш уул уурхайн салбарын бараа бүтээгдэхүүнээр цуглуулдаг бол байгалийн баялгаас хараатай эдийн засаг гэж үздэг манай улсын хувьд бол 33 хувийн ийм хамаарал орж ирдэг. Өөрөөр хэлбэл 4 дахин их гэсэн үг хамгийн бага үзүүлэлтээс. Тэгээд бидний хувьд бол яг ний нуугүй хэлэхэд хайгуулын салбараа л нээх 1.

2 дугаарт хайлгаад олоод ухуулж байгаа тухайн газар орны ард иргэдэд АМНАТ-ийн тодорхой хувийг илүү түлхүү олгодог хөгжил дэвшилд нь хүрдэг болгох.

3 дугаарт уул уурхайн компаниудад, аж ахуйн нэгжүүдэд нэгэнт өгчихсөн байгаа чөлөө зөвшөөрлийг нь төр хамгаалдаг, өмгөөлдөг.

4 дүгээрт тухайн компаниуд нийгэмтэйгээ ойлгож ажилладаг энэ хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай байгаа. Удахгүй ашигт малтмалын хуулийн өөрчлөлтийг өргөн барина..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 18 цаг болсон байна. Тэгэхээр энэ төсвийн тодотгол, мөн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг өнөөдөртөө хэлэлцэж дуустал чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэхийг санал болгож байна. Гишүүд дэмжиж байна уу. Гараа өргөчихье. Баярмаа гишүүн дэмжиж байгаа юм уу. Ингээд бүгд дэмжлээ. Бусад асуудлыг дараачийн чуулган руу шилжүүллээ гэсэн үг. Чуулганы хуралдааныг сунгалаа.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулга хийе.

П.Сайнзориг: Тэгэхээр би зүгээр өнөөдрийн бас энэ Төрийн албаны хуулийн асуудлууд ярьсантай холбоотой 1 зүйл зарчмыг тогтоочихмоор байгаа юм. Орон тоог маш өндрөөр тогтоож авангуутаа тэр орон тоог нөхөхгүйгээр цалингийн хэмнэлт хийнгүүтээ ер нь төсвийн ерөнхийлөн захирагчид, салбар салбарынхаа хэмжээнд урамшуулал нэмэгдлүүдийг нэмээд яваад байдаг юм. Харин тухайн жилд нь тэр дутуу орон тоотой ажилласан бол зүгээр ажилласан хүмүүс дээр 1 удаагийн хуучнаар бол 13 дахь сарын цалин ч гэдэг юм уу үр дүнгийн урамшууллуудыг өгнө үү гэхээс биш хавтгайд нь цалингаа нэмээд явсаар байгаад, дараа жил нь Сангийн яамандаа шахалт үзүүлээд, сүүлдээ энэ урсгал зардал чинь дийлэхээ байж эхэлж байна. Тэгэхээр энэ зарчмыг ер нь тогтоож авахгүй бол болохгүй байна. 1 дүгээрт.

2 дугаарт. Тэгээд ер нь бас хүүхдийн мөнгө, халамжийн асуудлын бодлогыг бас эргэж хараасай гэж хүсэж байгаа. Одоо тэгээд ингээд хэлэхээр олон нийт шүүмжилнэ. Тэгэхдээ хуучин бол 85 хувийг нь авдаг байж байхад болдог л байсан

юм. Хүүхдийн мөнгө. Огтоосоо маш өндөр орлоготой иргэдийн хүүхдүүдэд бол энэ мөнгө өгөх хэрэг уг нь байхгүй л юм байгаа юм л даа. Тэгээд энийгээ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хүн байна уу. Мөнхцэрэн дарга алга уу.

Энэ төрийн албан хаагчийн үнэлгээний журмыг 2023 онд Засгийн газар бас өөрчилсөн. 2024 оны 1 сарын 1-ээс эхэлж мөрдөхөөр батлагдсан журам байгаа шүү дээ. Яг Сайнзориг гишүүний хэлээд байгаа нийтэд нь хавтгайруулж урамшуулал өгдөг биш, үнэлгээг маш тодорхой болгоод маш сайн, сайн, муу гэсэн энэ үнэлгээ рүү шилжүүлдэг. Сайнаар үнэлэгдсэн хэсэг нь урамшууллаа бодитоор авдаг тэр боломж нөхцөлийг бол Засгийн газар дээр уг нь шийдвэр гарсан байгаа. Тэр талаар ярих байсан юм. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд оройн мэнд дэвшүүлье. Би санал, асуулт 2-оо хамтатгачихъя. Саналтай уялдсан байдлаар хариулт бас өгөгдөх байх гэж бодож байна. Мэдээж хэрэг асуудал нь шийдлээ дагуулдаг учраас Засгийн газар шийдлээ оруулж ирж байна. Энэ шийдлийг бид хэлэлцээд дэмжих нь бол зарчмын хувьд бол зөв байх. Сорилт бол бас боломж дагуулдаг юм чинь боломжоо эрэлхийлээд ийм шийдлүүдийг гаргасан учраас энийг сайн хэлэлцэж байгаад бас бид саналаа хэлээд шийдэх чиглэлд нь бас дэмжээд явах байх гэж бодож байна. Төрийн албан хаагчдын тухайд бол мэдээж хэрэг сүүлийн 10 жилд 45 мянгаар нэмэгдсэн. Тэрний цаана янз янзын хүчин зүйл тэрийг бид хангалттай ярьсан. Одоо нэгэнтээ бид бол энийг аль болох л тоог нь багасгана, цомхотгоно гэдэг асуудал ярьж байна. Гэхдээ энэ бол бидний хувьд бодлогын 1 арга хэрэгсэл байгаа шүү дээ. Зөөлөн газардуулах ёстой. Цаана нь бол их олон айл, өрхийн бас амьдрал ахуй байгаа учраас энийг бас бодох ёстой гэж байгаа юм. Ойрын хугацаанд бол дараах 3 зүйлийг шуурхай хийх ёстой. Би энийг бол зориуд та бүхэнд хэлье. Урьд нь ч гэсэн хийдэг байсан.

1 дүгээрт сул орон тоон дээр бол сонгон шалгаруулалт явуулаад хэрэггүй. Одоо энийг бол сэлгээд жишээ нь тэрийг нь бол ажиллуулдаг энэ аргаа хэрэглэх ёстой.

2 дугаарт бол өндөр насны тэтгэвэрт гарч байгаа хүмүүс бол бий. Энэ 3-6 мянгын хооронд байна гэсэн ийм тоо байлаа. Гарсных нь дараа бид бол мөн адил энэ дээр бол нөхөн томилж бол хэрэггүй, сэлгээд ажиллуулчих юм бол энд бол зохицуулалт бүрэн байж байгаа.

3 дахь зүйл бол их олон байгууллагууд дээр үүрэг гүйцэтгэгч нар байна. Төрийн албаны тусгай болон ерөнхий шалгалт өгөөгүй. Тэрнээс гадна шалгуур хангаагүй их олон хүн ажиллаж байна гэж байна. Тэр тоог бол гаргаад, үүнтэй уялдсан байдлаар эдгээр хүмүүс бол чөлөөлөгдөж таарна. Энэ бол төрийн албаны өөрийнх нь хуулийнх гол үндсэн зарчим шүү дээ. Тэгээд энэ дээрээ бол сэлгүүлэн ажиллуулах байдлаар маш богино хугацаанд энийг хийчихнэ. Үүгээр бол хэдэн хүн байх юм. 7-8 хүн мянган хүн бол байж болох байх гэж бодож байна. Гэхдээ энэ бол харьцангуй зүйл. Энийг та бүхэн судлах байх.

Нөгөө нэг зүйл бол маш богино хугацаанд дараагийн хийх зүйл 4 дэх зүйл. Чиг үүргийн шинжилгээ ажлын байрны шинжилгээг хийчхэж болно. Тэгээд энэ дээр тулгуурласан байдлаар зарим чиг үүргийн давхардлыг, магадгүй зарим чиг үүргийг жишээ нь давхардуулж болохыг бас та бүхэн нягтаршуулж болохыг бол тодорхойлно. Үүний дагуу бол хийх нь зөв байх гэсэн ийм 4 санал байна.

5 дахь санал бол ер нь жоохон дунд хугацаанд хийнэ. Дунд хугацааны санал бол угаасаа яригдаж байгаа. 1 дүгээр зүйл бол цахим шилжилтийг бид цааш нь эрчимжүүлэх ёстой. Сая гаднын улсынхантай бас уулзалт хийж байхад танай цахим шилжилт манайхаас их хурдан байсан чинь буцаад манайх танайхаас сайн болчихлоо. Манайд бол энэ төрийн үйлчилгээний төрийн ажлын хурд бол сайжирсан. Албан хаагчдын ч гэсэн хүнд суртал багассан гэж байна. Энэ дээр бас анхаарах ёстой. Үүнтэй уялдсан байдлаар мэдээж хэрэг зарим чиг үүргийг бол шилжүүлнэ гэж байгаа юм. Гэхдээ энэ бас амаргүй. Бид ингээд төрийн бус байгууллага руу шилжүүлчихнэ. Хувийн хэвшлийг шилжүүлчихнэ гэж байна. Тийм амархан зүйл биш. Энийг нарийн судалж байж бас хийж, шилжүүлэх ёстой. Энэ дээр бас ажиллах ёстой гэсэн ийм санал .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Зулпхар гишүүн бас энэ төрийн албаны шинэчлэл, алсын хараа олон баримт бичигт бас хамтран ажиллаж оролцсон хүн. Тэгэхээр манай Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан дарга Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байхдаа 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр энэ төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам гэж маш сайн журам батлуулсан. Ийм эрх зүйн акт болоод бүртгэгдсэн. Үүний дагуу маш сайн үнэлэгдсэн бол төрийн шагнал тодорхойлох, мөн мөнгөн урамшуулал олгох гэх мэтчилэн бүх журмаар, тэгээд үнэлгээ нь ил тод хэвлэгдэж гарч байх ёстой. Дараагийнх нь хангалтгүй нь бол тэр маш сайн үнэлэгдсэнээсээ мөнгөн урамшуулал нь 50 хувиас хэтэрч болохгүй ч гэдэг юм уу ийм үнэлгээний маш сайн журам гарчихсан байгаа. Өөрөөр хэлбэл энэ аттестатчиллын журам. Тэгэхээр энийгээ энэ 2024 оны 1 сарын 1-ээс эхлээ мөрдөгдөөд явах ёстой. Энийгээ хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөл, бүх аймаг, нийслэлийн чинь улсын хэмжээнд төрийн жинхэнэ албан хаагчийг үнэлэх, дүгнэх журам байгаа юм. Энийг хэрэгжүүлэх нь бол бас төрийн албаны шинэтгэлийн бас нэг зорилго. Энэ залгамж чанарыг хадгалж, энийг хэрэгжүүлэхийн зорилго гэж бид Хэрэг эрхлэх газартаа ийм чиглэл өгч ажиллаж байгаа. Ингэж байж нөгөө ард түмэндээ үйлчилдэг ээлтэй, ардчилсан төрийн зарчим үйлчлэх ёстой гэж бодож байгаа юм. Энэ бол төрийн албаны хуулийн бас үндсэн шаардлага, зорилт, шинэчлэл ийм байх болно. Тийм учраас зүгээр л ингээд төрийн албан хаагчдыг хамруулаад л халаад, солиод байх юм байж болохгүй. Тогтвортой мерит зарчмаар ажилладаг тэр зарчмыг мөрдүүлэх шаардлагатай гэдгийг бас энд онцлон тэмдэглэж хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Энэ журмаар ер нь 90-ээс дээш хувийн үнэлгээ авах юм бол цалингийн 50 хүртэл хэмжээгээр улиралд 1 удаа урамшуулал авна гээд. Тэгэхдээ яг сая Ерөнхий сайдын хэлдэгчлэн үнэлгээг хэн нэгэн дарга ганцаараа гаргахгүй. Хамт олон, байгууллага, үнэлгээний баг гэдэг ийм үе шаттайгаар гаргадаг. 80-аас дээш хувийн үнэлгээ авах юм бол цалингийн 25 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгодог гэдэг. Ийм байдлаар явж байгаа

юм. Тэгээд энэ бол бас их тийм ойлгомжтой болох юм бол төрийн албан хаагчдад илүү чадвартай, мэдлэгтэй, хичээл зүтгэлтэй хүмүүс нь урамшууллаа авч байдаг боломж юм гэдэг талаасаа бас тухайн үед бид гаргаж байсан юм. Нэмэлт хариулт өгөх үү. Батшугар сайд.

Э.Батшугар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд Зулпхар гишүүнтэй санал нэг байна. Цахим шилжилтийг бол улам цаашаа үргэлжлүүлэх ёстой. Өнөөдөр бид нар И-Монголиа платформыг бол иргэд ашиглаад сурчихсан байгаа. 2 сая иргэн бүртгүүлчихсэн. Цаашлаад И-бизнес гэсэн платформыг бас амилуулах ёстой гэж харж байгаа юм. Энэ нь бол яг бизнес эрхлэгч нарт зориулсан яг л И-Монголиатай адилхан бүх л төрийн үйлчилгээг цахимаар авах бололцоог нь нээж өгөх нь зөв гэж харж байгаа юм. Цаашлаад тэр бол Монгол Улсын Ерөнхий сайд бас Дижитал Фөрст гэсэн тийм концептыг бас дэвшүүлсэн. Энэ нь Монгол Улс бүх төрийн үйлчилгээг цахимаар явуулна. Хүнд сурталтыг арилгана. Үүнийг дагаад авлига, хээл хахууль ч гэсэн буурах бололцоо нь байгаа юм. Мөн өнгөрсөн парламентад 109 хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэ нь бол яг л нөгөө дижитал фөрст болон И-бизнесийг амилуулах тийм том концепт нь гарчихсан. Үүний хэрэгжилт дээр нь ч гэсэн бас анхаарч ажиллана гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Төсөв бол танах нь тодорхой байсан. Тэгээд харин энэ тодотгол хийгээд энэ удаа ороод ирж байгаад бол маш их баяртай байгаа. Тэгээд үнэхээр энэ удаа бид нар энэ төсвөө яг гүйцэд тодотгочих хэрэгтэй байх. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтэд бол 3 их наяд 728 төгрөгөөр бууруулж тодотгох ёстой гэж үзсэн байгаа юм. Тэгээд түрүүн бол Сангийн сайд бол яг тайлбарласан. Үнэхээр хэрвээ бид нар энэ буулгаж байгаагаас илүү буулгах юм бол хүүхдийн мөнгө рүү, тэтгэврийн мөнгө рүү, халамжийн мөнгө рүү орчих гээд байгаа болохоор үүнээс илүү бас буулгах боломжгүй байна гэж. Тэгэхээр бид нар нэгэнт бууруулж чадахгүй бол илүү их олох талдаа бас анхаарах хэрэгтэй. Зөвхөн “Алт 3” хөтөлбөр гээд байхгүй, бусад ер нь ямар салбараас, хөдөө аж ахуйгаас яах юм, аялал жуулчлалаас яах юм, цахим хөгжлөөс яах юм бүгдийг нь өрхтэй ялгаагүй. Тийм болохлоор орлого олох талдаа илүү төвлөрөөсэй гэж хүсэж байна.

Тэгээд бас асуух 4 асуулт байгаа юм. НҮБ-ын байнгын хорооны нарийн бичиг нарын хооронд зохион байгуулсан хэлэлцээрийн хүрээнд Коп 17 бага хурлыг 2026 онд зохион байгуулахтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсөвт энэ жил 50 тэрбум тусгасан. Тэгээд энэ нь бол 5 сарын 31-ний дотор худалдан авалт хийгдээгүй тул буцаан татагдаж байгаа тул дахин 50 тэрбум төгрөгийг суулгаж оруулж ирсэн байна. Тэгэхээр энэ 50 тэрбум төгрөгийг чинь 41.8 тэрбумаар нь хурлын барилга байгууламж барихад зарцуулна гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээр тайлбар өгөөч. Энэ 41 тэрбум төгрөгөөр ямар хурлын барилга байгууламж барих гээд байгаа юм. Өнөөдөр Монголд байгаа энэ олон заал, энэ олон байр байгууламж хүрэхгүй юм уу. Тэгэхээр хүндээ зориулах ёстой нөгөө танаж байгаа төсөв маань эргээд дахиад ингээд байр луу 50 тэрбум явчхаж байгаа юм уу. 1 дэх асуулт.

2 дахь нь төсвийн тодотголоор төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуульд олгож байгаа хувьсах зардлын санхүүжилтийг зогсоож, төрийн өмчийн дээд сургуулийн байр ашиглалтын төлбөрийг төсвөөс төлөхийг зогсоож, өртгийг сургалтын төлбөрт

шингээхээр тусгасан байгаа. Ингэхээр чинь 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн төрийн өмчийн их, дээд сургуулийн төлбөр нэмэгдэх үү.

2 дугаарт нь төрийн өмчийн бус цэцэрлэг сургуульд олгож байгаа хувьсах зардлын санхүүжилтийг зогсоосонтой холбогдуулаад хувийн сургууль, цэцэрлэгүүдийн бас төлбөр нэмэгдэх үү. Энэ дээр ямар тооцоолол байгаа вэ. 2 дахь асуулт шүү.

3 дахь нь хавдраар өвчилж байгаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ удаагийн төсвийн тодотголын Их Хурлын дагаж гарч байгаа тогтоол дотор энэ 2 заалт орчихсон байгаа. Тэгээд өнөөдөр төсвийн нөхцөл байдал ийм хүнд үед ингэж орж ирж байгаа. Бид бол уг нь дээд боловсролын хуулиараа төрийн өмчийн их дээд сургуулиудын тогтмол зардалд нь бол дэмжлэг үзүүлэх ийм үүрэг хүлээдэг. Гэхдээ энэ 17 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байсан. Энийг зүгээр цогцлоох гэсэн. Тэгэхээр мэдээж төлбөр дээр нь бол энэ нөлөөлнө. Өнөөдөр их, дээд сургуулиудын төлбөрийг бол удирдах зөвлөл нь өөрсдөө хуралдаж тогтоодог. Эдний бие даасан байдлыг хангах ийм зорилгоор ийм нөхцөл байдалтай байгаа гэдгийг юуны түрүүнд бас хэлье.

Хувийн сургуулийн төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулиудын хувьсах зардлыг бас хагас жилээс хойш зогсоох юм байна. Зогсоох гэсэн ийм чиглэл орж ирж байна. Тэгэхээр энэ бас өнөөдөр жишээлбэл хувийн цэцэрлэгүүд бол 2 дахин илүү хувьсах зардлаа аваад, тэгээд төрийн үйлчилгээг үзүүлж эхэлж байсан. Энэ бол өөрөө амжилттай болоод сугалааны цэцэрлэг байхгүй болсон ийм цаг үе байсан. Гэхдээ энэ дээр бол хагас жилээс хойш зогсох ийм шаардлагатай болж байгаа.

Юуны хувьд бол бид бас энэ үйлчилгээг яг боловсролын үйлчилгээг бол эцэг эхчүүд, хэрэглэгчдэдээ тэгш хүртээмжтэй хүргэх энэ зүйлээ умартаж болохгүй. Тэгэхээр цаашдаа бид төсөв маань өөрөө арай гэгээтэй болоод ирэх үед энэ бол түр зуурын үзэгдэл байх болов уу гэж бодож байна. 2 дугаарт энэ хуулийн заалттай ийм зүйлүүд байгаа. Тэр Улсын Их Хурлын тогтоолын төслөөр ийм зүйл орж ирж байгаа. Харин энэ удаа дагаж байгаа хууль дээр бол маш сайн заалт орж ирсэн нь 1 хувийн тэр татварын хөнгөлөлт дээр бол сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг барихад 1 хувийн татварыг буцаан олгох, хөнгөлөлт эдлүүлэх энэ зүйлийг оруулж ирсэн нь бол туйлын сайшаалтай байгаа. Энэ бол боловсролын салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтыг шууд дэмжиж байгаа ийм үзэгдэл гэж харж байна.

Цаашдаа бид бас энэ сургууль, цэцэрлэгүүдтэйгээ ярилцах шаардлагатай. Гэхдээ энэ удаад бол үнэхээрийн ийм нөхцөл байдалтай болчихоод байгаа. 2.1 их наядаар энэ төсвийг танах шаардлагатай болчихоод байгаа. Энэ байдлаараа бол төсвийн алдагдал 3 их наяд руу хүрч, инфляц 2 оронтой тоог давж, 240 гаруй мянган хүн ядууралд хүрэх ийм аюулын харанга нүүрлэхээд байгаа ийм үед бол бас энэ төсвийн тодотголыг бол Засгийн газраас өргөн барьж байгаа. Энэ хүрээндээ салбар болгон өөр өөрийнхөө үйл ажиллагаанаасаа тануулж байгаа гэдгийг л бас хэлье дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Коп маань ийм юм байгаа юм шүү Баясгалан гишүүн ээ. Маш харамсалтай зүйл болсон. Энэ сая 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татуулна гэдэг бол хайран төсөв шүү дээ. Ноднин хэдүүлээ яаж хэдэн юм баталлаа даа. Тэгээд худалдан авах ажиллагаа нь хийгдэж чадаагүй амжилтгүй болсон. Тэр дотор энэ орчихсон юм. Тэгээд олон улсын өмнө бидний маш хариуцлагатай ийм ажил болж байгаа. Сая гадаад айлчлал, юу хоёроо Ерөнхийлөгч мөн энэ асуудлыг бид хийнэ. Ерөнхий сайд ч гэсэн мөн НҮБ-ын өмнө бол амжилттай хариуцлагатай хийнэ гэдгээ амлачихсан. Одоо ингээд хийхээс өөр арга байхгүй. Нэгэнт тулчихсан юм чинь. Тэгээд 50 тэрбум төгрөгөө бас голоод байгаа шүү энэ төсөл маань. Энэ чинь хаанаа ч хүрэхгүй байна. Нэмж өг гээд. Тэгээд төсвийн орон зай боломж маань энэ байгаа. Энийг буцааж тавихаас өөр арга байхгүй. Тэгээд Батбаатар сайд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Батбаатар сайддаа захиад байгаа. Ээ дээ энэ тавьсан мөнгөө одоо сүүлийн хагас жилдээ зарлагдаж амжих хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол хойтон ер нь баларна шүү гэдгийг нь сайн л хэлээд байгаа. Тэгээд энэ 41.8 тэрбумаас 27 тэрбум төгрөг нь таны асууж байгаа тэр барилга байгууламжид нь орох юм. Түрээслэх хэсэг ч байгаа. Мөн барьж байгуулах хэсэг ч байгаа. Бусад хэсэг нь бол тэр арга хэмжээ болох газрын дэд бүтэц, зам тохижилт ийм ажлууд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн тодруулж асууна.

Ж.Баясгалан: Энд Хөгжлийн банкныхан ирсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр төсөв ярьж байгаа үед бол асуултуудаа бол асуучихлаа. Хавдрын өвчлөгсдийн 64 хувь нь Монгол Улсад 3 дугаар үедээ буюу хожуу үедээ оношлогдож байгаа шүү дээ. 2024 онд энэ маань өмнө нь миний ярьж байсан 4400-аас нэмэгдээд 4755 хүн хорт хавдраар нас барсан байна. Улсдаа ганцхан эмнэлэгтэй. Тэр нь ачааллаа дийлэхгүй. Тэгээд бид нар бол энэ өнгөрсөн төсвийн үед яриад, тэр хашаанд байгаа 4 дүгээр эмнэлэг Хөгжлийн банкны мэдэлд байгаа. Энэ эмнэлэг өөрөө төрийн өмч учраас энийг шилжүүлбэ гээд ярьсан. Үүний үр дүнд 17 тэрбум төгрөг тавиад, эхний ээлжид энэ байгууллагыг авч ашиглая гэсэн. Өнөөдөр хавдар судлалын эмч нар тэнд хөнгөвчлөх үйлчилгээ, химийн эмчилгээгээ 2 давхарт нь хийгээд явж байгаа. Тэгэхэд 3 удаагийн тендер зарласан. Тэр тендерийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Баясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн төсвийн тодотголоор дагалдаж байгаа Их Хурлын тогтоолоор хувийн сургууль, цэцэрлэгт олгох хувьсах зардлыг бол зогсоох ийм зүйл орсон. Тэгэхдээ энэ бол яг зогсоож байгаа асуудал биш. Энэ цаанаа өөрөө хуультай. Тэгээд нийгмийн салбарын төсвийн үр ашгийг сайжруулах чиглэлээр Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн байдлаар энэ асуудлыг оруулж ирж байгаа юм.

Ямар нэгэн байдлаар үүнтэй холбоотой төсөв хассан асуудал бол байхгүй.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн сайд хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Баясгалан гишүүнд баярлалаа. Бас энэ тусламжийн хүртээмжгүй байгаа байдалтай холбоотой, орон байр хүрэхгүй байгаатай холбоотой санаа тавьж байгаа. Маш зөв. Гэхдээ бүх юм хуулийн дагуу хийгдэхгүй бол бас болохгүй. Одоо Хөгжлийн банк ТУЗ нь тэр 4 дүгээр эмнэлгийн асуудлыг борлуулалт хийх, ХСҮТ-д өгөх зөвшөөрөл бол олгогдоогүй байна. Эрүүл мэндийн яам 3 удаа тендер зарлаад, оролцсон байгууллага байхгүй байна. Бид ямар ч байсан урсгал зардал 17 тэрбум төгрөг бол хасагдаагүй, байж л байгаа. Зүгээр бүх юм хууль журмын дагуу үнэ нь бодитой байх ёстой. Жишээлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар битүүмжлэгдсэн байгаа. Дуудлага худалдаагаа гүйцэт хийгээд эхний дуудлага худалдаандаа 160 тэрбум нэлээн тийм баримжаагүй, өндөр үнэ тавьсан. 2 дахь дуудлага худалдаагаа 86 тэрбум. 3 дахиа зарлаагүй байна. Ингээд 3 дахиа зарлаад 50 хувиасаа доошоо болгоод битүүмжлэгдвэл тухайн бодит үнээр нь 4 дүгээр эмнэлгийг ХСҮТ авах энэ бүх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн дахин тодруулж асууя.

Ж.Баясгалан: Тэгэлгүй яах вэ, ойлгож байгаа. Гэхдээ зүгээр 3 удаа зарлахад ер нь Хөгжлийн банкны ТУЗ-өөс ямар нэгэн шийдвэр гараагүй. Оролцох. Тэгээд ер нь ТУЗ-ийн шийдвэр нь болохоор яагаад оролцоогүй вэ гэхээр ирц бүрдээгүй гэдэг тийм шалтаг байгаад байгаа. Тэгэхээр яагаад ирцээ бүрдүүлэхгүй байгаа юм бэ. Энэ дээр чинь ялгаагүй өвчтэй хүмүүсийн л юм яригдаж байгаа. Зүгээр энэ татагдаж байгаа төсөвтэй холбоотой нөгөө талдаа гэвэл эрүүл мэндийн салбар чинь бол эмзэг шүү дээ. Өвдөж байгаа хүмүүс минут, секундээр яригдаж байгаа. Тэгэхээр энэ Хөгжлийн банк бас хариуцлагатай байх хэрэгтэй. Энэ ТУЗ нь хариуцлагатай байх хэрэгтэй. ТУЗ-ийн дарга байгаа бол өөрөө энэ дээр хариугаа хэлэх хэрэгтэй. Яагаад 3 удаа зарлаж байхад гурвууланд нь ирц бүрдээгүй гээд орохгүй байгаа юм бэ. Ороод эсвэл тайлбараа өгч болно. Эсвэл дараагийн дуудлага худалдаанаас бид нар хямдрахаар нь авна гэдэг саналаа хэлж болно шүү дээ. ТУЗ-ийнхэн нь байна уу. Хөгжлийн банк.

Д.Амарбаясгалан: Төсөв хэлэлцэж байгаа үед ирэх үүрэггүй л дээ Хөгжлийн банкны ТУЗ-ийнхөн. Эдийн засаг, хөгжлийн яам. Байхгүй байна. Одоо Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Төсвийн тодотгол алдагдалтай орж ирж байгаа. Тэгээд энэ бол зөв юм. Би бол ер нь манайх шиг эмзэг эдийн засагтай, манайх шиг уул уурхайгаас хамааралтай, манайх шиг дөнгөж хөгжиж байгаа улс орны хувьд бол алдагдалгүй төсөв гэдэг бол утоп юм. Бид нар ямар ч ийм эдийн засгийн тансаглахлын эрх бол байхгүй. Тэгээд ийм учраас алдагдалтай төсөв оруулж ирж, бодит үнэнтэйгээ нүүр тулсанд би бол баяртай байна. Одоо улс төрийн нөхцөл байдлын хувьд ч тэр, үнэхээрийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын хувьд ч тэр төсвийн хориг бол орж ирэхгүй байх гэдэгт итгэлтэй байна.

Би энэ хэмнэлтийн тухай хуулийг эргэн харах ёстой юм гэдэг байр суурь дээрээ байдгаа дахиад бас хэлэх гэсэн юм. Бүтэн жилээр төсвийг нь батлаад өгчхөж байхад 6 сарын 1-ээр худалдан авалтаа хийж чадаагүй, тендерээ бас зохион байгуулж чадаагүй гээд төсвийг нь татаад авч байгаа нь бол үнэхээрийн харамсалтай. Тэгээд яах вэ, Коп буюу олон улсад Монгол Улсын нэр хүндээ хамгаалахын тулд бол Копын зарим төсвүүдийг бол буцаан эргүүлэн тавьсан байна. Эрүүл мэндийн салбараас татагдсан хөрөнгө оруулалтын зардлыг тавьсангүй. Тэгэхээр манай нөгөө асуудлын чухлын эрэмбэ нь хаана явна вэ. Гадаадад нэр

нүүрээ алдахгүй байх нь чухал уу. Эсвэл ард иргэдийнхээ эрүүл мэндэд, хүний хөгжилдөө хөрөнгө оруулах нь чухал уу гэдэг нь бол бас эндээс бага ч гэсэн харагдаж байгаа болов уу гэж бодож байна. Харамсалтай байна. Тэгэхээр энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулиа бас эргэж харж яваасай. Төсвийн хуулиас давсан нэг асуудал байна.

МАН-ын бүлэг хуралдсан. МАН-ын бүлэг бол Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бол буцаах нь зүйтэй буюу татан авах ийм улс төрийн шийдвэрийг гаргасан. Тэгээд зарим хэвлэл мэдээллийн байгууллагуудаар цомхотгол хийхийг МАН эсэргүүцсэн, больсон юм шиг мэтээр зарлаад байна. Тийм биш. Ухаалаг цомхотголыг хийх нь бол зөв. Бид нар цаашдаа ч гэсэн илүү ухаалаг, илүү цомхон байх нь бол зөв гэдэг чиглэлтэй бол явж байгаа. Үүнийгээ бас зөөлөн аргаар хийх нь зүйтэй. Бидний хувьд бол буцааж байгаа асуудал нь яг энэ 36 сарын тэтгэмжтэй холбоотой, цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой, докторын нэмэгдэлтэй холбоотой, зэрэг дэвийн нэмэгдэлтэй холбоотой зүйл заалтууд юм. Тэгэхээр төрийн албан хаагчдын хувьд яаран сандран тэтгэврээ тогтоолгох гээд эсвэл сандраад явах нь бол буруу. Төрийн албанд 15-аас дээш жил ажиллаж байж л тэтгэвэр, тэтгэмжээ авах, 36 сарын тэтгэмжээ авах эрх үүсэх мэт орж ирсэн энэ хуулийг бол МАН .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн хуулиар нийтдээ 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд татагдаж байгаа. Энэ бол бас нэг их баярлаад байх зүйл биш. Үнэхээр харамсалтай. Яах вэ, энэ хууль дээр гишүүд маань янз янз л байгаа юм. Тэгэхдээ ихэнх нь дэмжээд байгаа нь энэ хууль ер нь хэрэгтэй, цаашаагаа байх нь зөв юм байна гэж хараад байгаа. Тэгэхээр энэ өөрөө ерөөсөө л цэвэр хариуцлагын асуудал юм. Төсөв 11 сарын 15-нд батлагддаг. Ингээд 6 сарын 1 хүртэл үндсэндээ бараг 7 сар байхгүй юу. 7 сарын хугацаанд төрийн худалдан авах ажиллагааг тендерийн хуулийн дагуу зохион байгуулах бүрэн боломжтой. Тэгэхээр энэ хаанаас эхлэх вэ гэхээр ерөөсөө төсөв батлах үеэр бэлтгэл ажил нь дутуу, шаардлага хангаагүй ийм хөрөнгө оруулалтын зүйлүүдийг л төсөв дээр хийхгүй байх ёстой юм байгаа юм. Иймэрхүү зүйлүүд орсноос болоод л эдгээр зүйлүүд нь ингээд хугацаандаа хийгдэж чадахгүй болчихоод байдаг ийм өндөр эрсдэл байгаа юм. Тэгэхээр энийг цаашдаа төсвийн ерөнхийлөн захирагч нар, сайд нар маань салбар салбартаа анхаараад илүү их хариуцлагатай болоход бол энэ их зөв хуулийн зохицуулалт байна гэж ингэж харж байгаа. Энэ бол миний яг өөрийн, хувийн байр суурь шүү. Зарчим ингэж цаашаа явна гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Нийт төрийн албан хаагчдадаа дахиад хэлэхэд МАН, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг төрийн албан хаагчдынхаа эрх зүйн байдлыг бууруулахгүй байх, хохироохгүй байх тал дээр хатуу зогсоно. Энэ дээр бол ямар нэгэн байдлаар бүү айж эмээгээсэй гэж хүсэж байна. 9.2 дээр төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээнд төрийн албан хаагчдад олгох цалин хөлс, нөхөн олговор, тусламж, тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөрийн хэмжээг бууруулах түр буюу бүрэн үүссэн зогсох үндэслэл болохгүй гэдэг хуулийн заалт бол хэвээрээ байгаа. Энийг ч гэсэн бас хэвээр нь байлгах дээр бол тууштай байна. Харин төрийн албаны бас илүү ухаалаг байх, илүү өөр реформын шинж

чанартай асуудлуудыг явуулах нь бол эргээд бас хамтдаа хэлэлцэж, цогцоор нь авч үзэх асуудал бол мөнөөс мөн гэдгийг дахин хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ төсвийн тодотголыг мянга мянган төрийн албан хаагч нар үзэж байгаа байх. Чих тавин сонсож байгаа байх. Яагаад гэхээр төсвийн тодотгол хэлэлцэхтэй холбогдуулж ард иргэдийн дунд, төрийн албан хаагчдын дунд төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, зэрэг дэвийн нэмэгдэл, тэтгэвэрт гарах 1 удаагийн тэтгэмжийг бууруулах гэж байна гэдэг ийм мэдээллүүд их явсан. Энэ нь ч Төсвийн хуулийг дагалдуулж орж ирж байгаа Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ийм байсан. Энэ асуудлыг өнөөдөр бас төсвийн тодотгол хэлэлцэхээс өмнө МАН-ын бүлэг бүлэг дээрээ ярьж, энэ асуудлууд нийт 230, 240 мянган төрийн албан хаагч хүн болгонтой холбоотой, хүн болгоны карман, хүн болгоны хэтэвчтэй холбоотой асуудал хөндөгдөж эрх зүй нь дордох байсан учраас энэ асуудлыг хэдийгээр төсөв, санхүү хүнд байгаа ч гэсэн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх хүрээнд энэ хуулиа татаж аваач ээ гэдэг ийм асуудлыг ярьсан учраас ингээд Засгийн газраас энэ дагалдсан Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиа татаж авч байгаа байх. Татна. Тийм учраас төрийн албан хаагч нар маань сэтгэл тайван, ямар ч гэсэн энэ жилийн хувьд энэ олон төсвийн урамшуулал, цалин мөнгөний, зэрэг дэвийн докторын тэтгэмжийн асуудлууд бол энэ жилийн хувьд хөндөгдөхгүй гэж ойлгоорой. Цаашдаа бол Сангийн яам, Засгийн газар бол энэ Төрийн албаны цалин мөнгө, хөлс, урамшуулалтай холбоотой асуудлууд дээр бас бодлого барих юм байна. Тухайлбал жишээ нь жилд энэ жил гэхэд 1100 гаруй хүн тэтгэвэрт гарч байна. Энд төсвөөс 270 орчим тэрбум төгрөгийг 1 удаагийн тэтгэмжид зарцуулж байна. Энэ бол асар өндөр тоо. Тийм учраас энэ бол өөрөө төсөв дээр асар их хэмжээний дарамт ирж байгаа учраас цаашдаа бол энийг яагаад Улсын Их Хурлын МАН-ын бүлгийн гишүүд энийг эсэргүүцсэн бэ гэхээр гэнэт энэ асуудлыг ингэж оруулж ирж байгаа нь өөрөө ард иргэдэд, төрийн албан хаагч нарт гэнэтийн цохилт болж байна. Үе шаттайгаар энэ бодлогоо хэрэгжүүлэх асуудал дээрээ онцгой анхаарч ажиллаач ээ гэдгийг хэлж байгаа юм.

Нөгөө талаар төрийн албаны хуулийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд энэ төрийн алба хаагчийн цалин хөлсний асуудлыг өнгөрсөн хугацаанд 30 гаруй хуулиудаар зохицуулж байна. Салбарын хуулиудаар зохицуулж байна. Энийгээ цаашдаа нэгтгэх асуудал дээрээ Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн хууль 2-оор л зохицуулдаг байх асуудлыг ярихгүй бол бүх салбарынхан өөр өөрсдийн салбар хуулиар цалин мөнгө, нэмэгдэл урамшууллаа олгодог болоод, энэ цалин хөлсний урамшууллын систем тогтолцоо алдагдчихсан юм байна.

Тийм учраас цаашдаа энийг энэ шинэчлэлийнхээ хүрээнд нягт хийх хэрэгтэй байна. Нөгөө талаар шинэчлэл хийе гэж байгаа бол эхлээд тэр анхан шатанд нь төрийн албан хаагчдын ажил үүргийн, чиг үүргийн давхардал юм дээр мониторинг хиймээр байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Би та бүхэндээ сануулъя. Анх төсөв баталж байхад нүүрсний үнийг 149 доллароор бүр анхандаа ярьж байсан. Дараа нь 105 болсон. Тэгээд 80,

70 гээд ингээд цаашдаа явах нь байна. Тэгэхээр энийг Монголд болоод олон улсад гол зах зээл Хятадын дотоод мэдээлэлтэй хүмүүст зөндөө сануулсан. Яг тэр зураг руугаа л орж байгаа. Бодит байдал руугаа ирж байгаа гэдгийг нь нэгд хэлчихмээр байна.

2 дугаарт нь бас нэг бодит байдалдаа очиж байгаа юм бол төсвийн зарлагыг бууруулъя. Янз бүрийн тоо явсан л даа. 3.6. Ингээд буулгая гэхээр шоолоод инээгээд байсан. Тэгээд явж явж байгаад 2.3 их наядаар зардал бууруулахаар шийдвэрлэсэн. Одоо 1.9-өөр дахиад хасахаар энэ 2-ын чинь нийлбэр нь 4 их наяд гараад явчхаж байгаа юм. Энэ бас ингээд нөгөө бодит байдалдаа нийцэж байна гэсэн үг.

Тэгээд 3-д нь бас 1 сануулах зүйл байна. Хил холболтын төмөр зам үнэхээр чухал маш том зүйл бид нар хийж чадсан. Тэрний дагуу орж ирсэн нүүрсний гэрээ дээр маш том дүнтэй, их урт хугацаатай, хөнгөлөлттэй үнэтэй зүйл орж ирнэ. Энэ хэмжээ нь Монголын нүүрсний экспортын 1/3-ээс илүү гарчих юм бол өөрөө өөрийнхөө үнийг унагаана. Тийм учраас индексээр боддог үнийг зөвхөн Монголын нүүрснээс хамааралтай Хятадын хойд хэсгийн зах зээлийн индексүүдийг ашиглахаас гадна өөрсдийн бирж бас Хятадын холхон эсвэл олон улсын индексийг оруулж өгөх асуудлуудыг яриад бараагүй. Одоо энэ хэмжээнээс болоод зах зээлийн хүлээлт өөрөө өөрсдийнхөө үнийг унагаасан. Энэ бол үнэн. Тэгээд цаашдаа энэ бас үргэлжлээд явна.

Харин ямар ч байсан сорчлохгүй гэдэг зүйлийг зөвхөн сайн чанарыг нь авахгүй шүү гэдгийг ямар ч байсан Их Хурал дэмжээд арай гэж оруулж явсан нь их юм гэж бодож байгаа юм. Тэгэхээр цаашдаа Монголын нүүрс хэрэггүй болж байна. Ер нь нүүрс хэрэггүй гэдэг ийм үлгэр яриад, үүндээ итгээд баймааргүй байна. Хятад дэлхийн тал нүүрсний хэрэглээний. Тэр улс өөрсдөө том олборлогч боловч гадаадаас авдаг коксжих нүүрснийх нь талыг нь Монгол нийлүүлдэг. Тийм болохоор манай үнэ нөлөөлнө. Манай яам, манай сайд нар Монголын эдийн засгийг бодоод Монголын нүүрсний үнийг яаж өсгөх вэ гэдэг бодлого, төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй байна. Энийг шинээр бүрдсэн Засгийн газар анхааралдаа авна уу гэж хүсье.

Асуулт нь болохоор 3.3 их наядын орлого тасарсан гэж байгаа. Аж ахуйн нэгжүүд чинь нүүрсний уурхайнууд чинь татвараа төлж чадах юм уу. Нүүрсний үнэ тэд гээд, зардал нь тэд гээд зөрүүнээс нь татвараа бодоод тооцчихсон байгаа байх. Тэгээд эд нар чинь татвараа төлж чадах юм уу. АМНАТ-аа төлж чадах юм уу. Оны төгсгөлд энэ орлогын алдагдал чинь 5 их наяд болох юм биш үү. Энэ дээр ямар тооцоо хийсэн бол гэдэг асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас маань тооцооллуудаа хийгээд, хүрээгээ өргөн барьсан байгаа. Төсвийн хүрээгээ. Тэр дээр орлого ер нь нэлээн муу сценариар тооцоод шүү жилийн эцэс рүү 3.3 их наядаар дутах нь гэдэг ийм тооцоолол хийсэн. Бид ч энийг нь бол зөвшөөрсөн. Энэ хүрээнд л бид нар танаж болох зардал маань 2.1 их наяд байна. Ингээд зөрүүгээрээ бид нар одоо алдагдалтай төсөв батлахаас өөр аргагүй болж ирж байгаа юм. Тийм байгаа юм. Тэгэхдээ бас нэг бүр бүх юм ингээд үүгээр бас хязгаарлагдах гэж ойлгож болохгүй. Засгийн газар хэмнэлт хэмнэлт бас дахин хэмнэлт гэдэг горим руугаа

шилжиж ажиллана. Тийм учраас он дуустал хэмнэж болох, танаж болох зардлуудаа мөн дахин ямар боломжууд байна. Сайд нар маань энэ дээр өөр өөрсдөө хичээгээд ажиллаад явна. Засгийн газрын хувьд, ялангуяа Сангийн сайдын хувьд бол орлоготоо тааруулаад зардлаа танаад явах төсвийнхөө хуваарийг Засгийн газар дээр өөрсдөө хийгээд явах ийм бас бүрэн эрх нь байдаг. Тэр хүрээндээ бас бид хичээж ажиллана Золжаргал гишүүн ээ.

Д.Амарбаясгалан: Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: 1 хүсэлт хэлмээр байна. Дахиад хэлэхэд эрчим хүчний бай, коксжих бай нүүрс, ялангуяа энэ олон улсын эрсдэлтэй үед хэрэгтэй. Үнэ бол өндөр биш байгаа. Тэгэхдээ хэрэгтэй. Манай том хэрэглэгч гол хөршийн найдвартай ар тал байх нь Монголд ч хэрэгтэй, хөршид ч хэрэгтэй. Гэхдээ яаж өөрөө өөрийнхөө үнийг унагаахгүй байх вэ. Яавал Монголд ашигтай байх вэ гэдэг дээр манай салбарын сайд, Сангийн сайд, Ерөнхий сайд бас анхаарч ажиллаасай. Энэ дээр нүүрсний үнийн бодлого бүр тусдаа байх хэрэгтэй байна. Яаралтай нүүрс одоо унаж байгаа, нүүрс хэрэггүй болж байгаа. Тийм болохоор хэдээр ч хамаагүй өг. Бартераар ч хамаагүй өг гэдэг ийм улс төрийн мессеж маш их өргөн сувгаар явсан. Ийм биш ээ. Хэмжээнд нь тааруулаад өөрийн хүчтэй бодлого хэрэгтэй. Үүнийг боловсруулж хэрэглээсэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Хэдүүлээ ковидын дараа тохиосон түүхэнд бас ховорхон тохиох нь уул уурхай, ялангуяа нүүрсний үнийн циклийг бас улс орныхоо хөгжил дэвшилд олигтой ашиглаж чадсангүй дээ. Тийм шинэ баян цээж өвчтэй юм шиг гэдэг загнаад, жоохон байсан санхүүгийнхээ нөөцийг замбараагүй зарцуулаад. Тэгээд өнгөрсөн жилээс хойш 2 дахь удаагаа төсвийн тодотгол, 2 удаа төсөв ингээд жилийн дотор 4 удаа ярилаа. Тэгээд бид нар төсвөө төлөвлөж чадахгүй байна уу, эсвэл аргачлал нь буруу байна уу. Төсвийн тогтвортой байдлын санал, дүгнэлт, зөвлөмж арай өөр гараад л байсан. Анх төсөв ярьж байхад. Сангийн сайдаас би тэр үед асууж л байсан. Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтийг харсан уу гэсэн. Харсан, уншсан. Тэгээд та юу бодож байна гэсэн манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн жоохон улс төржөөд байгаа юм гэж яг хэлж байсныг чинь би санаж байна. Одоо өнөөдөр 4 дэх удаагаа ийм юм яриад сууж байна хэдүүлээ. Тэгэхээр та нар Сангийн яам ямар мэдээллийг ашигладаг юм. Ашиглаж байгаа мэдээлэл аргачлал чинь өөр байдаг юм уу. Яагаад та нарын оруулж ирж байгаа зүйл чинь ингээд өөр байдалтай. Ер нь явж явж тэгэхдээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байна шүү дээ.

2 дахь асуулт нь яг үндсэндээ бол манай улс хэтэрхий их хэт төвлөрчхөөд, тэгээд үндсэндээ Өмнөговь аймаг, Дорноговь аймаг энэ жил 1 их наяд 734 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн юм л даа. Гэтэл энэ төсвийн тодотголоор явж явж нөгөө 2 саалийнхаа үнээг л хамаг мөнгийг нь төсвийг нь хасаад хаячихсан байх юм. Түрүүн тэр Сангийн яамны нэг нөхөр хариулж байгаа харагдана лээ. Үндсэндээ Өмнөговь 16, Дорноговь 20 тэрбум орон нутгийн хөгжлийн сангаас нь хасчхаж байгаа юм байна шүү дээ. Энэ аргачлал нь бас зөв юм уу. Эсвэл хууль нь болохгүй байгаа юм уу. Энэ 2 асуултыг Сангийн сайдаас.

Ерөнхий сайдаас, түрүүн таны хийсэн мэдээлэлд ер нь ойрын 2 жилдээ нүүрсний үнэ өсөхгүй юм шиг байна. Ер нь нүүрсний экспортын орлого огцом буурснаас үүдэх төсвийн алдагдал бол таны энэ шинэ Засгийн газрын хамгийн том

сорилт болох нь. Тэгэхээр ирж байгаа он жилүүдэд энэ улс орон бас төсвөөсөө гадна хөрөнгө оруулалт, ойр зуурынхаа асуудлыг шийдэж явах ёстой. Гэтэл нөгөө талдаа бас хуулийн хязгаарлалт бий бид нарт. Уг нь Хөгжлийн банкныг томоохон төсөл хөтөлбөрүүдээ, мега төслүүдээ санхүүжүүлэх гээд байгуулсан чинь нам дамнасан хэдэн хулгайч нар тоноод, одоо актив байхгүй. 3.Нарантуяа очоод харин жоохон цэгцэлж байх шиг байгаа юм. Гэхдээ одоо тэнд зээл гарч байгаа юу, үгүй юу. Мэдэхгүй, Бараг үгүй байх. Тэгэхээр цаашдаа хөрөнгө оруулалт болоод энэ мега төслүүдээ яг ямар зарчмаар хөдөлгөх гэж байгаа юм. Минут нь дуусаж байх шиг байна. Дахиад 1 минутаа авчихъя.

Танай бүлгийн хурал дээр ярьсан юм шиг байна л даа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 1 минут тодруулгад зориулсан. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Бид хариуцлагаас зугтахгүй. Ноднин өдийд төсөв өргөн барьж байх үед, яг өдийд шүү, өдийд бид нар тооцооллуудаа эхэлж байхад зөвхөн бид биш дэлхий нийтээрээ өөдрөг ийм хүлээлттэй байсан. 9 сарын 1-нд мөн өргөн барихад ч тийм байсан. Олон улсын байгууллагуудаас өгч байгаа эдийн засгийн өсөлтүүдийн төсөөллүүд бүгд л өөдрөг байсан юм. Тэрнээс хойш манай орны онцлог өөрөө уул уурхай эдийн засагтай, хөгжиж буй орны хувьд биднээс шалтгаалах түүхий эдүүдийн үнэ гэж ерөөсөө огт байхгүй. Өдөр өдрөөр өөрчлөгдөж байна. Тодорхойгүй байдлууд маш их байна. Хэрвээ бид нар зүгээр энгийнээр бодоход шүү. Хэрвээ 2 сард, 3 сард тодотгол яригдсан бол 1 их наядаар тодотгол хийгдэх байсан байх. 5 сард бол 2.3 бараг байсан байх. Одоо 3.3 их наяд буюу ДНБ-ий 3 хувьд хүрээд, яг одоо хуулийн нөхцөл үүсэж байгаа. Тодотгол хийх. Тийм учраас энэ удаа бид хэмнэлт, хэмнэлтийн тодотгол маань яах аргагүй энэ гадаад нөхцөл байдлаас шалтгаалсан ийм зүйл дээр бид үүнийг харин бас боломж гэж хараад, ингээд хэмнэлтийн тодотгол, цаашдаа мөн л хэмнэлт, хэмнэлт, бас дахин хэмнэлт гэсэн ийм горим руугаа Засгийн газар шилжээд, мөн энэ хүрээнд бас хийж болох реформын шинжтэй салбар салбарын ийм өөрчлөлтүүдийг мөн бас хийх нь зөв гэж ингэж харж байгаа.

Өмнөговь болон ер нь бусад бүх аймгууд дээр л мөн энэ хэмнэлтийн хүрээнд хэмнэлт, таналт хийгдэж байгаа гэдгийг хэлье. Тоонуудыг Ганбат Төрийн нарийн бичгийн дарга хэлчих үү.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс нэмэлт хариулт өгье.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2025 оны төсвийн тодотголд АМНАТ-ийн дүнг батлагдсан дүнгээс 1.7 их наяд төгрөгөөр бууруулаад, 3.9 их наяд төгрөг болгож өргөн мэдүүлж байгаа. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд яг энэ буурсан дүнгээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн санг бол 182.7 тэрбум төгрөгөөр бууруулах ийм тооцоо хийгдсэн. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд орлого хуваарилах энэ аргачлал бол ямар нэгэн хүний оролцоо байхгүй, томъёогоор бодогддог ийм хуваарилалтын тогтолцоо байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу. Тодруулж асуух юм уу. Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Гомбын Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь бидний байнга ярьдаг бөгөөд чаддаггүй 1 зүйл бол эдийн засгаа төрөлжүүлнэ, солонгоруулна гээд. Ийм учраас хөдөө аж ахуйн экспортыг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дээр нь аялал жуулчлал, IT салбар зэрэг салбарыг ДНБ-ий 20 хувьд хүртэл өсгөж хөгжүүлэх ийм төлөвлөгөө боловсруулах даалгавар өгсөн. Энэ чиглэлээр ажиллаж байна. Намар төсөв боловсруулах үед оруулж ирнэ. Ер нь томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эх үүсвэрийн хувьд бол ер нь нүүрсний зах зээл ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл 5 хувиар буурсан. Нийтдээ 4.7 тэрбум эрчим хүчний нүүрсний хэрэглээтэй, 580 орчим сая тонны коксжих нүүрсний хэрэглээтэй БНХАУ. Үүнээс 110 саяыг нь импортоор авдгийн манайх 46 хувийг нь экспортолж байсан ийм улс. Тэгэхээр ер нь цаашдаа бас энэ дэлхийн эдийн засгийн байдал тогтворжоод, сүүлийн үеийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Г.Занданшатар: Тийм учраас Монголын нүүрсний экспортын үнэ Хятадын өмнөд, дунд бүсийн үнэ баталгаагүй биш. Харин хойд боомт Бахай бүсэд илүү уян хатан дунджаар 87-88 доллар хүрч тогтворжиж байна. Монголын коксжих нүүрсний үнэ Хятадын үнээс 20-50 хувь өндөр. Харин эрчим хүчний нүүрс нь түүнээс бага байдаг.

Мега төслүүдийг хөдөлгөхдөө Ерөнхий сайдын хувьд дотоод хөрөнгө оруулалтыг татах, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн өмчийн компанийн оролцоог хязгаарлаж, ил тод, нээлттэй санхүүжилтийн схем баримтлах бодлого баримталж байна. Мега төслүүдийг хөгжүүлэхдээ 5 тэрбум долларын гадаад эх үүсвэр, 1-2 тэрбум долларын дотоод хөрөнгө, 30 хүртэл хувийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн оролцоотой концессын хэлбэрийг хослуулан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Ер нь бидний хувьд одоо хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тодорхой бодлогод нэн ялангуяа эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих ийм тодорхой яриа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Г.Занданшатар: Хэдийгээр их цаг тулгуу ч гэсэн Монголын эдийн засгийн форумыг энэ 7 сарын 8-9-ний хооронд зохион байгуулна. Гадаад түнш хөрөнгө оруулагчдыг урьж байна. Эгийн голын УЦС болон томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр амжилттай яриа хэлэлцээнүүд эхэлсэн байгаа. Нааштай үр дүнгүүд энэ ондоо багтааж гарна гэдэгт итгэж байна. Тэгэхдээ энэ бол 1-2 жилийн хугацаанд суурь нь тавьж хэрэгжих хамгийн багадаа ийм төслүүд.

Ер нь ирээдүй гэрэлтэй болохоор энэ хямралыг боломж болгож ашиглахын тулд өнөөдрийн төсвийн тодотголоос эхлээд төсвийн тодотгол хийсний дараа хямралыг боломж болгож ашиглаж, эдийн засгийн шинэ өсөлтийн бүтцийн 1 бүтээгдэхүүнээс хамааралтай экспортын зах зээлийг төрөлжүүлэх, өргөжүүлэх шийдвэртэй арга хэмжээнүүдийг бид хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: Яах вэ, бид хариуцлагаас зугтахгүй л гээд байна. Дахиад төсөвт ахиад гар хүрэхгүй гэх баталгаа байгаа юу. Хэрвээ дахиад оны эцэс рүү, намар тийшээ дахиад төсвийн тодотгол хийвэл хэн хариуцлага хүлээх вэ.

Нөгөө талдаа Ерөнхий сайдаас түрүүнд энэ гишүүдийн яриаг би сонсоод сууж байхад танай намын бүлэг дээр л ярьсан юм шиг байна. Төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр их ухаалаг цомхотгоно гэж яриад байх юм. Би тэрийг чинь сайн ойлгосонгүй. Таны ярианаас бол 9 хувь буюу нийтдээ 230 мянгаас 9 хувь гэдэг чинь 21 мянга орчим хүнийг цомхотгох тухай та ярьсан шүү дээ. Төрийн албан хаагчдыг. Тэгээд ухаалаг цомхотгоно гэдгийгээ жоохон тодруулаад өгчих.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгөх үү. Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн ээ, тэр ухаалаг цомхотгол гэж юм яриагүй л дээ. Би мэргэжлийн үнэлгээ буюу аттестатчилал хэрэгжүүлнэ. Эхний ээлжид аваагүй орон тоон дээр тэр Сайнзориг гишүүн яриад байсан орон тоогоо өсгөчхөөд, тэндээ орон тоо авахгүй цалингийн санг нь ашигладаг ийм үзэгдлүүдийг таслан зогсоож, эхний ээлжид аваагүй орон тоонуудыг цомхотгоно. 6 мянга орчим гэж тооцож байгаа. Дээр нь төрийн албаны шинэчлэл байна. Тэгээд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, цахимжуулах, энэ давхардлыг арилгаж, жишээлбэл, өнөөдрийн 28 хороог татан буулгаж байгаа, 9 санг татан буулгаж байгаа энэ бүх өөрчлөлтүүдийн үр дүнд бид нар энэ жилдээ эхний ээлжид 6 мянга, ирэх жилд 7, энэ оны эцсийн мэргэжлийн үнэлгээ аттестатчилалтай хослуулан төрийн албыг илүү цомхон чадварлаг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 сайхан мэдээ дуулгая. 3*3-ын сагсан бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн Монгол Улсад анх удаа зохион байгуулагдаж, “Сүхбаатар”-ын талбайд 2 дахь өдрөө үргэлжилж байна. Тэгээд энэ тэмцээнд Монголын эмэгтэй тамирчдын баг маань маш амжилттай оролцож байна. Өнөөдөр хасагдах шатны тэмцээнд БНХАУ-ын багтай маш ширүүн өрсөлдөөн өрнүүлсний эцэст илүү цагт оноогоор хожсон байна. Ингээд 1/8 шигшээд шалгарсан байна. Тэгээд эмэгтэй баг тамирчдадаа Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе. Амжилт хүсье.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Надад 4 асуулт байна.

1 дүгээрт нэгдсэн төсвийн зарлагыг 1.8 их наядаар бууруулахаар төлөвлөж орж ирж байгаа. Тэгээд энэ үр дүнд эдийн засгийн өсөлтөд ер нь ямар нөлөө гарна гэж тооцож байгаа вэ. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллийн тооцоо судалгааг хийсэн юм болов уу.

2 дугаарт бид нар уул уурхайн салбараас хамааралтай эдийн засагтай. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнээс хамаарсан хүндрэлийг яаж давах вэ гэдэг дээр өнөөдөр бас тулаад байна. Тэгэхээр ер нь уул уурхайн бус орлогыг нэмэгдүүлэх, уурхайн бус орлогын татварыг нэмэгдүүлэх талаар ямар бодлого барьж байгаа вэ. Тухайлах юм бол энэ цахим платформ дээр байдаг цахим арилжаа худалдааны хэрэгслүүд бол нэлээдгүй дэлгэрчихлээ л дээ. Бид нар энийг барьж татвар ноогдуулах, орлогоо бүрдүүлж чадах ийм боломж байхгүй юу. Нөгөө талдаа энэ чинь маш олон ард иргэд чанаргүй бараа бүтээгдэхүүнд хууртагдаж, хохирдог

асуудал бас дагаад үүсэх нь л дээ. Ямар ч татварын тооцоолол, татварт ноогдуулахгүй орлого олоод яваад байдаг үйл ажиллагаанууд манайд бас нэлээдгүй байна. Би ганцхан жишээ хэллээ. Энэ чиглэлээр ер нь ямар бодлого барьж ажиллая гэж бодож байгаа вэ. Энэ чиглэлийн төлөвлөлт юм энэ удаа орж ирсэн юм болов уу, үгүй юм болов уу.

3 дахь асуулт бид нар төсвөөсөө нэлээдгүй олон зардлуудыг хасаж байгаа. Тэгээд саяын та бүхний танилцуулж байгаа энэ тооцоолол дээр төсвийн ерөнхийлөн захирагчдын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгодог тодорхой хэмжээний санхүүжилт байдаг. Энэ бол 5 сайдын багц дээр байгаа байх. Гол нь ард иргэдэд олгож байгаа зээл хөнгөлөлтийн л асуудлууд байгаа гэж ойлгож байгаа. 5 сайдын багцаас хөдөө аж ахуйн сайдын сайдын багц бол үндсэндээ 40 тэрбумаар буурсан. Тэгээд энэ нь өөрөө хөдөө аж ахуйн салбарын төсөл хөтөлбөрүүд нөгөө зээл тусламжууд, янз бүрийн байдлаар олгодог зээлүүд, ЖДҮ-лэлийг дэмжих зээл маань энэ хэмжээгээр буураад, ингээд үйлдвэрлэлийнхээ асуудлыг эргээд хумьчих гэж байгаа юм биш биз дээ. Энэ 40 тэрбумд ямар нэгэн сөрөг эрсдэлийг ер нь тооцсон тооцооллууд байна уу. Ямар нөлөө дагуулна гэж тооцож байгаа вэ.

Сүүлийн асуулт 14 мега төсөлтэй холбоотой. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бид нар 14 мега төслийнхөө ажлыг хэрэгжүүлж байж, эдийн засгийн өсөлтийг хангана, ДНБ-ийхээ өсөлтийг хангана гээд ингээд тооцчихсон явж байдаг. Би бараг 3 сар гаруйн өмнө Эдийн засаг, хөгжлийн яам руу албан бичиг явуулаад, энэ 14 мега төсөлтэй холбоотой материалуудыг өгөөч гээд тал хагасыг нь олж авчхаад сууж байгаа. Тэгээд үндсэндээ энэ 14 мега төсөл эхэлчихсэн 1 хэсэг нь байна. Зураг төсөв хийгдээд бэлэн болчихсон 1 хэсэг байна. Ямар ч тооцоо судалгаа байхгүй, зураг төсөв ч үгүй юм бас байна гэж ажиглагдаад байгаа юм. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам бол материалуудаа нэгтгэж аваад, яамнуудаасаа цуглуулаад өгнө гээд байгаа юм. Тэгээд энэ эрэмбэлэгдсэн эрэмбэ байна уу. Ямар түвшинд явж байгаа юм бол.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эхлээд Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Үүрийнтуяа гишүүн бас яг эдийн засгийн хүн учраас их нарийн тодорхой асуулт асуулаа. Энэ төсвийн тодотголын үр дүнд бол Монголбанкны тооцооллоор ДНБ-ий өсөлт 0.7 хувиар буурах тооцоололтой. Өөрөөр хэлбэл 1.9 их наядаар зарлага танагдсанаар ДНБ-д үзүүлэх өсөлт бол 0.7 хувиар буурна гэж тооцож байна. Гэхдээ тодотгол хийхгүй тохиолдолд төлбөрийн тэнцлийн алдагдал 550 сая доллароор нэмэгдэж, ханш сулрах, инфляц нэмэгдэх эрсдэлтэй. Ханшид үзүүлэх дарамт 14 хувиас дээш байна гэж тооцож байгаа юм. Тэгэхээр энэ тодотгол бол макро эдийн засгийг тогтворжуулах хэмнэлтийн тодотгол. Уул уурхайн бус эдийн засгийн салбарыг дэмжиж, бид ойрын 5 жилд 2 дахин нэмэгдүүлэх энэ хүнсний хувьсгал хүнсний салбар, хүнс экспортлогч орон болох IT-ийн салбар, аялал жуулчлалын салбаруудыг дэмжих замаар хөдөө аж ахуйн салбарыг дэмжих замаар бид энэ хувийн жинг 20 хувьд хүргэх шаардлагатай гэж үзэж байгаа. Ийм төлөвлөгөө боловсруулах даалгавар өгсөн. Энэ чиглэлээр ч гэсэн мега төслүүдийг экспорт, импортын тэнцэл, төлбөрийн тэнцэл, макро эдийн засгийн тогтвортой байдалтайгаа уялдуулж манай Эдийн засаг, хөгжлийн яам мега төслүүдийг эрэмбэлэх ажлыг одоогоор хийж байна.

1 дүгээрт энэ ТЭЗҮ хийгдсэнээр нь;

2 дугаарт экспорт, импортод үзүүлэх дарамт боломжоор нь;

3 дугаарт Монголын эдийн засгийн шаардлагаар нь эрэмбэлж байгаа.

Энэ дотроо эрчим хүчний төслүүдийг эхний ээлжид эрэмбэлэх энэ чиглэлээр яриа хэлцлүүд хийх чиглэл өгчихсөн. Ойрын үед бас цахилгаан станцуудын чиглэлээр бол эрчим хүч экспортлогч орон болох зорилт бол амжилттай хэрэгжүүлэх ийм чиглэлийг барьж ажиллаж байна. Ер нь цаашдаа бид арьс шир, ноос ноолуур, мах махан бүтээгдэхүүний экспортыг 2 тэрбум долларт хүргэх ойрын хугацааны зорилтыг хэрэгжүүлнэ.

2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан 14 мега төслөөс Гашуунсухайт-Ганц мод төмөр зам, Эрдэнэбүрэнгийн УЦС, Эгийн голын УЦС, нефть боловсруулах үйлдвэр, Хөх нүүрсний цахилгаан станц зэрэг 5 нь хэрэгжиж эхэлсэн. Энэ усны төслүүд бол ТЭЗҮ, зураг төсөл, үр өгөөж, байгаль орчны үнэлгээтэй хамт боловсруулагдан бэлэн болсон нь зарим төслүүд хангалттай судалгаатай байгааг бол харуулж байгаа. Харин үлдсэн төслүүдийн ТЭЗҮ, техникийн судалгаа дутуу, зарим нь огт хийгдээгүй байна. Ийм учраас feasibility study буюу судалгаа бүрэн хийгдсэн төсөл 4-6 орчим, бусад нь хангалтгүй судалгаатай байгаа зэрэг нь бол эрэмбэлэх шаардлагатайгаа харуулж байгаа юм. Таны хэлсэн саналуудаар. Хөдөө аж ахуйн салбарын сайдын багцад тусгасан 40 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт буурснаар бол мал аж ахуй, ургацын хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт тасалдаж, үйлдвэрлэлийн эрсдэл буюу гарал үүслийн баталгаажуулалт, тэжээлийн хүртээмж муудах эрсдэл нэмэгдэх магадлал өндөртэй. Ийм учраас хөдөө аж ахуйн салбар дээр энэ талаар онцгой анхаарч ажиллах чиглэл өгчихсөн байгаа.

Энэ дашрамд ганц зүйл хэлчихье. Ингээд манай Ганхуяг гишүүн орж ирж байна. Монголчууд бас дандаа юм буураад, муураад байгаа юм биш ээ. Бас монголчууд зөв замдаа орж байгаа хөгжин сэргэн мандах эхлэл тавигдаж байгаа гэж бодож байгаа. Сая одоо 3*3-ын баг нь хожлоо. Монгол Зи баг дэлхийд нэрээ цуурайтууллаа. Дэлхийн их гүрнүүдтэй үзэж, Монголын шатрын баг Арабад түргэн тоглолтын дэлхийн аварга боллоо. Монголын залуучууд, монголчууд маань гэрэл гэгээтэй байна. Ийм учраас мега төслүүд бол хүний хөгжил бол манай Засгийн газрын хамгийн том мега төсөл байна гэж хэлсэн. Ядуурлыг бууруулж, эдийн засаг хөгжсөн маш том төслийг бид хэрэгжүүлж Монголын ард түмнийхээ саруул ухаанд итгэж байгаа. Монгол Улс ирээдүйн хөгжил гэрэлтэй байгаа гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Манай үндэсний хөтөлбөрүүд байгаа. Хөдөө аж ахуйн яам дээр байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт гээд эдгээр хөтөлбөрүүд бол манай үндэсний аюулгүй байдлын маш чухал асуудал болж ирж байгаа. Цаашдаа ер нь хэзээ ч ковид гарч болзошгүй, хэзээ ч бид хилээ хаалгаж болзошгүй. Тэр үедээ өөрсдөө хоолтой, ундтай байна гэдэг бол манай улсын тусгаар тогтнолын бас нэг ийм баталгаа болох ёстой. Тийм учраас эдгээр хөтөлбөрүүд дээрээ бид онцгой анхаарч байгаа. Энэ жилийн хувьд бол оны төгсгөл рүү гарах ёстой зээлүүдийн хэмжээ дээрээ бол бид онцгой анхаарч байгаа. Яах вэ, эхний хагас жилд бол зээлүүд нэлээн бага гарсан байгаа. Тэндээс бол тодорхой хэмжээний хэмнэлт хийх боломж үүссэн. Ингээд тэндээс 7.5 тэрбум төгрөгийн ийм

хэмнэлт хийсэн байгаа. Үлдсэн хугацаанд бол эдгээр хөтөлбөрүүдийн санхүүжилт, хүүгийн дэмжлэгүүд бол тасрахгүй үргэлжлээд явна. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: 2 асуудал дээр бас тодруулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

1 дүгээрт энэ сая Сангийн сайд хэлэхдээ бол тэр Эрүүл мэндийн яам жишээлэх юм бол хөрөнгө оруулалт нь 70 орчим тэрбум төгрөгөөр хасагдаж байгаа шүү дээ. Энэ бол тодотголоор биш ээ, төрийн хэмнэлтийн хуулиар хасагдаж байгаа юм гэж байгаа юм. Төрийн хэмнэлтийн хуулиар байх. Гэхдээ ард нь орон нутагт мянга мянган ард иргэдийн эмчилгээ, үйлчилгээ авах ёстой боломжууд хязгаарлагдаж, энэ хэмжээгээр эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сулрах эрсдэлийг дагуулж байгаа. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бол бас их хариуцлагагүй мэдэгдэл хийж байна лээ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын асуудал дээр бас санаа зовоод байгаа юм.

2 дугаарт энэ хөдөө аж ахуйн салбарын эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг бид нар бас анхаарч, эрсдэлийг тооцож байхгүй бол эргээд бид нар хөдөө аж ахуйн салбараа дэмжиж байж бас маш их олон тооны ажилчдыг ажлын байртай болгох бодлого барьж байгаа. Энэ зүйл маань эрсдэлд орох вий.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засгийн 1 дүгээр улирлын тоо мэдээ гарч байна. Хөдөө аж ахуйн салбар 35.6 хувийн өсөлт үзүүлсэн байгаа. Тэгэхээр бидний хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд үр дүнтэй болж байна л гэсэн үг. Бусад бүх салбар унасан. Ганцхан хөдөө аж ахуйн салбар 1 дүгээр улиралд Монгол Улс ДНБ 2.4 хувь өссөний 50 хувийг нь хөдөө аж ахуйн салбар дангаараа бүрдүүлж байна. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбараа дэмжих нь ямар ач холбогдолтой гэдгийг харуулж байгаа юм. Ажиллах хүчний хувьд 1 дүгээр улиралд хөдөлмөрийн зах зээл дээр өмнөх үеэс 48 мянган хүнээр ажлын байр нэмэгдсэн. 48 мянгын 37 мянга нь хөдөө аж ахуйн салбар дангаараа нэмэгдүүлсэн тоо гарч байна. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарыг л үнэхээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр бид энэ уул уурхайн мөчлөг дагасан эдийн засаг хэт хараат байдлаа бууруулах гол арга ухаан бол хөнгөн, хүнсний үйлдвэр, хөдөө аж ахуйн салбараа л жоохон бэхжүүлье. Экспортын бололцоо байна. Зах зээлд Монгол хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн өрсөлдөх чадавхтай болж байна. Манай технологи сайжирч байна. Монголчууд тарьдаг, ургуулдаг, бүтээдэг, хийдэг болж байна. Тэгэхээр энэ салбарын дэмжлэгийг эдийн засаг хүндрээд унаж байгаа бол бас зөрж 1 салбараа босгох хэрэгтэй. Тэр босгох салбар бол хөрөнгө оруулалтыг илүү анхаарах салбар бол хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар байх ёстой гэж үзэж байгаа. Мэдээж амаргүй байгаа. Цомхотгол, төсвийн тасалдал нэлээн зүйлүүд бас багасаж байгаа. Бид нарын хэрэгжүүлэх хөтөлбөр тодорхой хэмжээнд жоохон сааралт, хурд удааширна. Гэхдээ бол гол нуруугаа аваад гарч байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Их Хурлын дарга, Ерөнхий сайд аа, бас нэг сайн мэдээ байгаа шүү. Сагснаас гадна. Өчигдөр Франц улсын Парис хотноо Ой Си Ди-ийн хурал болсон. Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын. Үүгээр улс бүрд зээлийн эрсдэлийн ийм шинжилгээгээр оноо өгдөг байгаа. Ингээд сүүлийн 20 жил манай үнэлгээ ерөөсөө огт хөдлөөгүй байсан. Өчигдрийн хурлаар 1 шат сайжирсан байгаа шүү. Тэгээд энэ бол их сайн мэдээ. Цаашдаа манай зээлийн эрсдэл Засгийн газрын ялангуяа өрийн бүтэц бол цаашаа сайжрах ийм маш том боломж нэмэгдэж байна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өнөөдрийн төсвийн тодотголыг дагаад бүгдээрээ дан л уул уурхай, тэгээд нүүрсний талаар бол ярилцаж байгаа. Тэгээд яг энэ үедээ бол нэг зүйлийг бүгдээрээ ойлгоод авчих нь зөв байгаа юм.

Монгол Улсыг яг ингээд бодоод үзэх юм бол зүгээр 5 төрлийн бараа зардаг л дэлгүүр шиг байгаад байгаа байхгүй юу. Зүгээр Си Ю-тай харьцуулаад бодоод үзэх юм бол тийшээ яваад ороход хэчнээн төрлийн бараа хэдэн 100-аар нь бид нар авч болдог билээ. Тэгтэл Монгол Улсыг бүхэлд нь бодоод үзэхэд нүүрс зарж байна. Зэсийн баяжмал зарж байна. Төмрийн хүдэр зарж байна. Жонш зарж байна. Алт зарж байна. Голлох бүтээгдэхүүнээ ярих юм бол энэ 5 л байгаа байхгүй юу. Тэгээд хэр их зарах вэ, хэр их орлого олох вэ гэхээр ерөөсөө л урд хөршөөсөө хамааралтай байгаад байдаг. Тэгээд яах вэ, манайхан төрөлжүүлэе гээд оролдож байх шиг байна л даа. Тэгээд дахиад л Ховд аймгийн Халзан Бүргэдэй төслийг Их Хурлын чуулганы индэр дээрээс 2 дахь удаагаа ярих болж байгаа. Тэгээд яг энэ Халзан Бүргэдэй төсөл нь болохоороо энэ 5 нэрийн барааны дэлгүүрээ л 6 болгочихъё гээд явж байгаа төсөл байтал тэгээд тэмцлийн хурц хэлбэрт ороод, очих болгонд нь л янз бүрийн асуудал үүсчихдэг. Тэгээд яг үнэн хэрэгтээ бол энэ төсөл яг олборлогдох эсэх нь тодорхойгүй шүү дээ. Дэд бүтэц нь байхгүй. Эрчим хүч нь байхгүй. Очоод судлаадахъя гэхэд л зөвшөөрөхгүй. Тэгээд уг нь ашиглаад эхлэх юм бол Өмнөговь аймаг шиг л Ховд аймгийг хөгжих байх гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгээд Эрдэнэт хотыг бас бүгдээрээ бодох хэрэгтэй. Тэгээд нөгөө янз бүрээр л яригдаад байдаг Өмнөговь аймгийн Цогтцэций сумд хүртэл хэчнээн олон кофе шоп байдаг гэж бодно. Тэнд бол амьдрал буцалж байгаа байхгүй юу. Уул уурхайн салбарыг дагаад хөгжиж байгаа. Тэгээд асуудлууд бол мэдээж байгаа. Тэд нар нь бол шийдэгдэнэ. Тэгтэл нөгөө олон ястны өлгий нутаг гээд байдаг Ховд болохоороо ширээний ард суудаггүй. Дандаа л тэмцэл болоод байдаг. Тэгээд энийгээ эргэж харах цаг болсон юм болов уу л гэж боддог доо. Тэгээд яах вэ, зүгээр өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа учраас төсвийн тодотголтой холбоотойгоор бас л энэ уул уурхайг ойлгоод, дэмжээд явуулж байгаа энэ аймгаас төвлөрүүлж байгаа төсвийг огт дэмждэггүй газрууд руу өгч байгааг ерөөсөө хүлээн зөвшөөрч чадамгүй байгаагаа илэрхийлэхийг хүсэж байгаа юм.

Ингээд улсын төсөвт төвлөрүүлж байгаа аймгуудаа харангуут одоо энэ тодотголтой холбоотойгоор төвлөрүүлж байгаа төсвийнх нь 70 хувь нь үлдээд байгаа байхгүй юу. Энэ аймгуудад бол Булган орж байна, Дорноговь орж байна, Дорнод, Дундговь, Дархан-Уул. Тэгээд Улаанбаатарыг бас оруулж болж байгаа. Тэгтэл Өмнөговь аймгийн бүрдүүлж байгаа төсвийн 4 хувь нь л үлдэж байна. Орхон аймгийн 28 хувь нь л үлдэж байна. Тэгээд Өмнөговьос болохоороо 1.6 их наяд

төгрөгийг төвлөрүүлнэ гэчихжээ. Тэгээд одоо ер нь гүйцэтгэл нь ямар байгаа юм бол. Сангийн яамнаас хамгийн эхлээд асуумаар байгаа зүйл нь энэ гүйцэтгэл нь энэ ондоо багтаад яг энэ 1.6 их наяд нь төвлөрөх юм уу. Тэгээд энэ төвлөрүүлж байгаа мөнгөнөөс нь түрүүн дурдсан Ховд аймгаа дурдах юм бол 4 тэрбумаар дэмжлэг үзүүлээд өгөх гээд байгаа байхгүй юу. Энэ дээр эхлээд хариултаа авчхаад тодруулъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ бол манай улсын төсвийн тогтолцооны л онцлог л доо. Бид Америк шиг ийм штатуудын нэгдсэн улсын ийм төсөвтэй биш. Аймгууд маань бие даасан ийм төсөвтэй биш. Нэгдсэн байдлаар төвлөрүүлээд, аймаг, аймгууд дээр мөн салбар, салбарууд дээр ийм хуваарилалтуудаа хийдэг ийм л онцлогтой улс юм байгаа юм.

Өөрөөр хэлбэл Өмнөговь аймгаас төвлөрсөн орлогоор бид нар Сүхбаатар аймагт, Баян-Өлгий аймагт төрийн албан хаагч нарын цалинг нь тавьдаг. Тэнд хөгжлийн бодлого, хөгжлийн бүтээн байгуулалтуудыг хийдэг ийм л төсөвтэй улс. Цаашдаа ч ер нь их олон жил ингэж явах байх. Тэр яг тоонуудтай холбоотой асуултыг нь манайхан хэлээдэх дээ. Тэр төвлөрүүлэлт нь хэдэн хувьтай байгаа вэ.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс хариулт өгье.

Л.Ичинноров: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров. Уянга гишүүний асуултад хариулъя. Өмнөговь аймгаас эхний 5 сарын байдлаар 737 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс одоогоор 427.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Харин тийм ээ. 1.6 их наяд төвлөрөх болов уу даа. Тэгээд ер нь бол нүүрснээс тэгээд бусад түрүүний хэлсэн, асуултад асуусан ашигт малтмалаас хамааралтай байгаа эдийн засгаа тэлэхийн тулд уул уурхайн салбар дээр энэ критикал минерал буюу чухал ашигт малтмалын талаарх бодлогыг дэмжиж явуулах ёстой байгаад байгаа. Тийм учраас Их Хурал дээр Их Хурлын гишүүдээс бүрдсэн энэ критикал минерал буюу чухал ашигт малтмалын талаарх бодлого тодорхойлох эрх зүйн орчин бүрдүүлэх ийм дэмжих бүлгийг байгуулж байгаагаа бас энэ чуулганы индэр дээрээс гишүүддээ дуулгая. Тэгээд 2024-2028 оны Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд бол нийгэм, эдийн засагт шинэ тутам үүсэж байгаа харилцааг зохицуулах энэ хуулийн төслүүдийг оруулж ирэх тогтолцоог бүрдүүлнэ гэж тусгасан байгаа. Тэгэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас орж ирэхээр хүлээгдэж байгаа хуулиудад чухал ашигт малтмалын асуудлыг оруулахаар ийм дэмжих бүлэг байгуулж байгаа юм. Тэгээд эрхэм гишүүд хамтарч ажиллахыг хүсвэл дэмжиж гарын үсгээ зурахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүний энэ санаачилж байгаа хуулийн төсөл их хэрэгтэй төсөл санагдсан. Зүгээр гишүүд бас төсөлтэй танилцаад, олуулаа дэмжээд тэгээд хамтдаа өргөн баривал энэ төслийг бас намрын чуулганд оруулаад хэлэлцээд явах боломжтой гэж бас харж байгаа. Тэгэхээр бас гишүүдэд ажлын хэсэг, Байнгын хороо, бусад шугамаар бас танилцуулгууд хийвэл, хэлэлцүүлгүүдийг

зохион байгуулбал бас их зөв болов уу гэж бодож байгаа. Одоо Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Хассуурийн Ганхуяг гишүүнд бас юуны өмнө талархал дэвшүүлье. Манай Ганхуяг гишүүн, Дамдинням гишүүн тэргүүтэй залуучууд 2017 оноос эхлээд энэ Монголын 3*3 энэ сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх үйлсэд бол үнэтэй хувь нэмрээ оруулсан. Өнөөдөр дэлхийн аваргад амжилттай, маш хүчтэй өрсөлдөж байгаа энэ багийг бас анхлан үүсгэн байгуулсан. Тэгээд улс орныхоо нэрийг олон улсын түвшинд гаргах ийм багийг бас олон жилийн туршид дэмжиж, өнөөдрийг хүртэл ингэж авч явсанд бас Монголчуудынхаа, ард иргэдийнхээ нэрийн өмнөөс, Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс тусгайлан талархал дэвшүүлж байна.

Ингээд Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Тэгээд сэтгэл хөөрөөд, тэнд байсан хүмүүстэйгээ тэврэлдээд бас жоохон асуудалд ороод байгаа. Тэгээд өнөөдөр бас яалт ч үгүй их сайхан өдөр байлаа. Тэгээд цөмөөрөө асуудал руугаа эргэж ороход 5 асуулт байна.

Төсвийн байнгын хороо дээр бол төсвийн ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Тэгээд яг өнөөдрийн нөхцөл байдал бол нэлээн яг ний нуугүй хэлэхэд амаргүй байна гэж харахаар байна. Татварын орлого бол 3.7 их наядаар тасарчихсан. Аж ахуйн нэгжүүд ер нь бол үндсэндээ татвараа төлж дийлэхгүй байна. 7 их наяд төгрөгийн авлагатай байна. Валютын нөөц хэд болсон юм бэ. Сүүлд Ерөнхий сайд хэлэхдээ бараг хасах руу орсон гэж ярьсан уу, үгүй юу. Тэгээд оны сүүл гэхэд одоо бид нар ер нь тодотгол хийгээд байдаг. Яг ханшаа ер нь хэдээр тооцож байгаа юм. Бид нар 2025 оны төсөв бол 3400-аар тооцож байсан. Одоо бол ханшаа алдаад яваад байдаг. Өнөөдрийн манай төсвийн орлого бол 2.3 их наядаар тасарсан гэж үзэж байгаа боловч хэрэвзээ бид нар бас энэ ханш 10 хувиар унаагүй бол нөхцөл байдал нэлээн хүндрэхээр байсан байх. Бид нар өнөөдөр 2.3-аар таналаа гэж бодоход оны эцэс гэхэд манай валютын ханш ямар ханштай байх юм. Нөөц хэдтэй байх юм. Инфляц хэдтэй байх вэ гэдэг асуулт байна. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт бол би Ерөнхий сайдыг томилогдож байхад ганцхан асуудлыг л ярьсан байгаа. Тэгээд хариуцлагын асуудлыг л ярьсан. Танд бол одоо бүрэн эрх байгаа. Өнөөдөр үндсэндээ бид нар 4 дэх удаагаа төсвөө хэлэлцэж байна. 1 жилийн дотор 4 удаа, 3 сар тутам төсөв хэлэлцээд явна гэдэг бол бас би бол хэвийн үзэгдэл биш гэж харж байгаа. Хуучин бол төсвийн хуулиар бол буруутай тооцоолсон, буруу төлөвлөсөн бол тодорхой хэмжээнд хариуцлагын асуудал байдаг байсан бол тэр заалт бол байхгүй болсон байгаа. Одоо энэ 2023 оны байна уу, 2024 оны өөрчлөлтөөр. Тэгэхээр цаашдаа энэ тал дээр бас та анхаарал хандуулаач ээ гэдэг асуудлыг бас танд хэлж байгаа юм.

Эрүүл мэндийн Чинбүрэн сайдаас 1 асуулт байгаа юм. Тэр эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтаас 63, 64 тэрбум төгрөг хасагдсан байдаг. Тэгээд ерөөсөө нэн шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй юм уу. Ингээд хасагдчихаар танай салбар асуудалгүй 1 жилийн хугацаанд асуудалгүй явчихаар байгаад байгаа юм уу. Энэ чинь бас 3 чиглэлээр бас хөрөнгө оруулалтыг бол нэмэгдүүлсэн байна лээ шүү дээ. Хэрэвзээ асуудал байхгүй юм бол яах вэ энүүгээр нь бид нар ингээд аваад явъя. Асуудал байвал төсвийн ажлын хэсэгт та бас саналаа гаргаж өгөөрэй гэж хэлмээр байгаа юм.

Дараагийн асуудал бол энэ төсвийн тодотголоос харахад бол яг Засгийн газрын шинэ бодлого гэх юм бол Алт 3 гэдэг хөтөлбөр хэрэгжих гэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд хариулт өгөх үү. Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Ганхуяг гишүүн манайхаас асуулт байхгүй. Асуугаагүй биз дээ. Эрүүл мэндийн яамнаас асуусан.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн сайд хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Ганхуяг гишүүнд бас баярлалаа. Ер нь эрүүл мэндийн салбарын төлөө бас санаа зовж байж байгаа, хөрөнгө оруулалтын асуудлыг хөндөж байгаад баярлаж байна. Геополитикийн асуудал ханш, инфляц, дайн тулаан. Тэгээд ганц зүйлээс хамаардаг эдийн засаг маань өөрөө хүндэрчихсэн. Болдог бол нэмээд л баймаар байна. Хөрөнгө оруулалтаа. Дутагдаж байна. Хэрэгтэй байна. Гэхдээ энэ чинь нийтээрээ болохгүй байгаа учраас ганцхан би кабинет дотроо тэгэхгүй гээд орилох өөрөө боломж алга. Тэгэхээр бүсээ чангалаад, байгаа нөөцөө ашиглаад хамгийн шаардлагатай, хамгийн чухал тусламжуудаа алдахгүй л явчих юм сан гэсэн. Мөн энэ тодотгол хийсний дараагаар олон олон гаргалгаанууд гарахаар бас хичээх бодлогуудыг бас та бүхэнд танилцуулах гэж байна. Ингээд зүгээр байхгүй ээ. Бид бас нөөц боломж тухайлах юм бол банкнуудаас байгаа авлагууд байна шүү дээ. Нийлүүлээд бодохоор 110-аад тэрбум төгрөгийн авлага байгаа шүү дээ. Тэгэхээр Их Хурлаас бүр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхээр нэгэнт шийдчихсэн, авлага авах ёстой болсон зүйлүүдийг хурдан шийддэг энэ тогтоолын төслийг хүртэл та бүгдийг санаачлан бариасай гэж хүсэж байна. Боломжууд байна. Нийгмийн даатгалын 89 тэрбум төгрөг нийгмийн даатгалын сантай бид үзэглээд, яг хоёулаа өглөг, авлага ийм байна гэдгээ тохирчихсон байгаа. Ингээд авлагуудаа аваад явбал бид бас гарцууд бүүр байхгүй мухардсан гэж хэлэхгүй. Тийм учраас Засгийн газрын гишүүд бид бас гаргалгаа олох нь үүрэг байх л гэж бодож байна. Хэцүү гээд хойшоо суух биш, харин боломжтой бүх нөхцөлүүдийг хайж ажиллана л гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энд нэг асуудлыг тодорхой хэлэх нь зүйтэй байх. Өнөөдөр OECD-ийн "Country Risk Classification" буюу энэ үнэлгээгээр 2025 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хамгийн өндөр эрсдэлтэй улсад ангилагдаж байсан. Өнөөдөр манай засаглал нөхцөл байдлыг үнэлээд, энэ эрсдэлтэй үнэлгээг бол сайжруулсан гэдгийг сая манай Сангийн сайд хэллээ. Ер нь 1 жилийн хугацаанд төсөв 4 удаа тодотгож байгаа нь санхүү төлөвлөлт, санхүүгийн сахилга, хариуцлага сул, урьдчилсан тооцоо, эрсдэлийн удирдлага, бас нэг бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засгийн бүтэц 1 өдөр бий болчхоогүй. Уул уурхайгаас хамааралтай эдийн засаг маань өөрөө ийм нөхцөлийг бүрэлдүүлж байна. Өнгөрсөн 30 жилийн эдийн засгийн бүтцийн бодит байдал маань ийм. Үүнийг л өөрчлөх гэж бас өнөөдөр энэ дохио санамжийг бид өгч байна. Ер нь өнөөдрийн 1, 2 .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад нэмж минут өгье.

Г.Занданшатар: Тэгээд валютын нөөцийг асуусан. Валютын нөөц бол үндсэндээ яах вэ, 5.2 тэрбум долларын валютын нөөцтэй байгаа. Өчигдрийн

байдлаар 240 сая долларын зээл бас Хөгжлийн банкнаас авч байгаа гэсэн мэдээлэл орж ирсэн. Энэ хэмжээгээр бодит нөөц нэмэгдэхээр боловч, эргэж төлөгдөх зээлүүд маань бол валютын цэвэр нөөцөд тооцогдохгүй. Төлбөрийн тэнцлийн алдагдал тодотгол хийхгүй тохиолдолд 550 сая доллароор нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн алдагдал 1 тэрбум долларт хүрэх эрсдэлтэй гэж бид тооцсон. Ийм учраас төсвийн тодотгол хийж байна. Төлбөрийн тэнцлийн алдагдлыг хязгаарлахын тулд төсвийн тодотгол хийхэд нээлттэй хандаж энэ гадаад валютын нөөцөө хамгаалах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, ялангуяа уул уурхайн бус уулын уурхайгаас гадна хөдөө аж ахуй, алт, ноолуур зэрэг салбарын орлогыг өсгөж, валютын урсгалыг нэмэгдүүлж, экспортоо төрөлжүүлэх бодлого баримталж, зардлыг оновчтой түвшинд барих, үр ашиггүй хөрөнгө оруулалтуудыг танах олон улсын хөрөнгө оруулагч .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Итгэлийг хадгалах зорилготойгоор энэ төсвийн сахилга хариуцлагыг чангатгаж байгаа нь олон улсад бас манай нэр хүндийг санхүүгийн нэр хүндийг дээшлүүлж байна гэж үзэж болно. Энэ дотроо бид ч хөрөнгө оруулалт бас түрүүн зарим нь яриад байсан. Жишээлбэл, эрүүл мэндийн бол 60 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт царцсан. Төсвийн хэмнэлтийн хуулиар зогссон. 210 тэрбум төгрөгөөр Засгийн газрын ордон барих гэх мэт хөрөнгө оруулалтууд, бас импортыг өдөөх хөрөнгө оруулалтууд бол үндсэндээ бас царцаж байгаа. Ийм учраас ийм богино хугацаанд бүх юмыг эдийн засгийн бүтцийг өөрчилж чадна гэж байхгүй. Тийм учраас би өнөөдөр индэр дээрээс ч гэсэн аялал жуулчлалыг дэмждэг ард түмэн байя. Ирж байгаа зочдыг соёлын бүтээлч үйлдвэрлэл угтах, үдэх ёслолоос авхуулаад монгол хүний зочломтгой зан харуулж байна гэдэг маань бидний бас чадах аялал жуулчлалын салбараа ядаж хот, хөдөөгүй өөд нь татчихдаг, хүнд үйлчилдэг, нийтээрээ хүчин зүтгэдэг энэ жижиг алхмаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Би 2026 онд төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор л 1 л асуулт асууя. Одоо тэр Евро-Азийн гэрээнд нэгдэнэ, хэлэлцээрт нэгдэнэ гээд бас яваад байх шиг байна. Үүний үр нөлөөг ер нь хэр сайн тооцсон байгаа вэ. Бид нар чинь бол зөвхөн татварын орлого гэхэд 350 тэрбумаар тасалдахаар байгаа шүү дээ. 600 гаруй мянган иргэн ажилладаг хүнсний өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, худалдааны салбар нэлээн эрсдэлд орно шүү дээ. Тэгээд энэ бол дараа жилийн төсөв бүрдэхэд, ажлын байр бий болоход, ажлын байр алга болоход маш том нөлөөтэй шүү. Энэ дээр нэлээн сайн нухацтай ярилцаж байгаад цөмөөрөө соёрхон батлах ёстой шүү л гэдэг байр сууриа илэрхийлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулт байна уу. Батхүү Төрийн нарийн бичгийн дарга. Төсвийн тодотгол болохоор ингээд Эдийн засаг, хөгжлийн яамныхан чинь ирэхгүй болчихдог юм. Төсвийн хүрээн дээр орж ирээд. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төсвийн тодотгол хийх нь бол зайлшгүй ээ. Энэ дээр бас санаа зовж байгаа нэг зүйл нь энэ олон мянган төрийн албан хаагч нар бол маш ихээр хандаж байгаа. Төрдөө ажиллаад, мэргэшээд бас багагүй хэмжээний төрийн

зардал, цаг хугацаа өөртөө шингээчихсэн, хүн капитал болсон хүмүүс маань цаг зуурын хүндрэлээс болоод төрийн албанаасаа чөлөөлөгдөх юм байна гэдэг ийм айдас бол дээр дооргүй л байна. Тэгэхээр Ерөнхий сайд бол ер нь болж өгвөл давхардсан дарга нарын бүтэц ийм зүйлээс бол эхэлье гэж одоо хэлж байсан. Бас зарим тал дээрээ, яг начир дээрээ дунд, доод шатдаа аваад үзсэн нөгөө муу ядарсан шүүр барьсан, газу барьсан, хүрз барьсан хүмүүсээсээ эхэлнэ гэдэг байдал руу ороод эхлэх юм бол энэ бас буруу тийшээгээ явчих байгаа. 4 жилийн өмнө төрийн үйлчилгээний албан хаагчдыг хувь руу шилжүүлнэ гээд сургууль, эмнэлэг, цэцэрлэгийн баахан хүмүүсээр нэлээн сэтгэл санаанд нь хүлээлт, эрсдэл үүсгэсний улмаас иргэд олдохгүй болсон байсан. Хүүхдийн цэцэрлэгт ажиллах хүмүүс. Энэ шиг эргээд уг нь сая Ерөнхий сайд хэллээ. Тэр Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим энэ тэртэй нийлээд хувийн хэвшил санал болгох байдлаар гээд. Тэгэхээр үүнийг бол яг дагаж хийх ёстой. Үүнээс гадна Хөдөлмөрийн тухай хуультай учраас энэ хэлэлцээр явах ёстой юм. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт хэлэлцээр яг энэ үед явах ёстой. Өөрөөр хэлбэл хувийн хэвшилд хэчнээн ажлын байр хэрэгтэй байна. Тийм тэтгэмж байна. Ийм хүмүүсийг бол түр хугацаанд шилжүүлж ажиллая. Мөн байгууллагууд дээр орон тоо болон зарим цомхотголыг хийхэд бол хамт олноос нь асуугаад үзвэл их зүгээр байгаа юм. Зөвхөн дарга өөрөө мэд гэхихээр дарга өөрөө өөрийгөө тойруулаад байгаа хүмүүсээ үлдээгээд, бусдыг нь халчих гэдэг юм уу ийм юм руу явчихвал их буруу юм болох байх гэдэг зүйлийг бол хэлмээр байна.

36 сарын тэтгэмж гэдэг энэ зүйлээр бол нэг их айхтар оролдоод хэрэггүй байх. 20, 30 жилийг бид нар өрж авчирч ирсэн, бага багаар дээш нь авчирч ирсэн. Тэгээд сая бол Төрийн албаны дагалдах хуулийг бол татчихлаа гэж бол ойлгож байна. Тийм учраас энэ дээр дахиж тодруулаад байх зүйл бол алга. Тэр 500 тэрбум төгрөгийг бол алдчихсан. Тэрний цаана эрүүл мэнд, маш чухал чухал салбарууд дээр худалдан авалт хийж чадаагүйгээрээ хасагдчихсан нь жоохон харамсалтай. Түрүүлээд хийчихсэнүүд нь одоо азтай гэх юм уу, юу гэх юм. Яг жингийн туухай дээр тавиад үзэх юм бол хамгийн үр ашигтай, хамгийн түрүүнд хийж байх ёстой юмаа цаг хугацаа энэ тендерийн асуудлаас болоод алдчихсан юм байгаад байгаа юм.

Энэ цомхотгол энэ бусад зүйлийг дагаад энэ ХХОАТ, нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад эдийн засагт дам болон шууд нөлөө үзүүлэх ийм сөрөг үр дагавруудыг хэрхэн яаж тооцож байгаа вэ. Цаашдаа энэ төрийн алба болон төрийн албан дотор байгаа хүмүүс чинь цаанаа бас хүн, амьтан тэжээж байгаа. Нийгмийн хамгааллын асуудлуудыг нь хэрхэн яаж тооцож байгаа вэ гэдэг дээр асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Эрдэнэбат гишүүнд төсвийн тодотголыг дэмжиж байгаадаа талархлаа. Бид 2026 оныхоо төлөвлөгөө дотроо үүнийг оруулаад аль хэдийн баталчихсан байгаа. Би тантай санал нийлж байна. Тийм учраас аль болох зөөлөн буулгаж, бид одоогоос эхлэхгүй хойтонгийн төсөв өргөн барих үед энэ төлөвлөгөөний дагуу бид үүнийг шууд 100 хувь 1 дор хийж чадахгүй. Энэ бол бүр их хүнд тусна. Тийм учраас одоо ядаж сул орон тоонуудыгаа хасаад, энийгээ шахаад, тэгээд түрүүн Ерөнхий сайд хэд хэдэн удаа хэллээ. Энэ дээр зохицуулалтаа маш оновчтойгоор, ухаалаг байдлаар хийх ёстой. Одоо байгаа төрийн албан хаагч нарыгаа ямар нэг хүндрэл учруулахгүйгээр хөдөлмөрийн зах зээл дээр зөв байдлаар хувийн хэвшилд шилжүүлэх ямар боломжууд байна вэ. Орон тооны давхардлууд юу байна вэ. Энэ жил тэтгэвэрт гарах орон тоон дээр нэмж хүн оронд нь зөрүүлж авахгүй байхаар, мөн цахим шилжилт хийнэ гэж байгаа гэх мэт ийм

төлөвлөгөөнүүд дээр ажиллах учиртай. Ямар ч байсан төсөв дээр хэмнэлтийг нь бол баталчихна. Харин энэ дээр орон тоогоороо хэмнээд явах уу, эсвэл өөр бусад зардлуудаараа энийгээ нөхөөд явах уу гэдгийгээ төсвийн ерөнхийлөн захирагч нар маань бол өөрсдөө шийдээд, төлөвлөгөө гаргаад ингээд явах юм.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр яах вэ бид нарт сургамж өгч байгаа учраас цаашдаа төрийн албан хаагч нар болон төрийн өмчит үйлдвэрийн газар албан орон тоонуудыг хэрхэн яаж үе шаттай шилжүүлэх вэ гэдгийг маш зөөлнөөр магадгүй 5, 6 жилээр гэдэг юм уу ийм төлөвлөгөө гаргах, энэ дээрээ бусад ажилчдын төлөөллийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын байгууллага, хөдөлмөрийн зах зээлийнхээ таамгийг харж байгаад бид аажмаар энэ рүүгээ очих ёстой байгаа. Тийм учраас энэ тал дээр тодорхой ажлын хэсэг энэ цомхотгол юмыг үр ашигтай, хохирол багатайгаар давахад хамгийн оновчтой уулзах цэгийг нь олох тийм чиглэлээр давхар ажиллах шаардлагатай юм болов уу гэж бодож байна. Одоо болохоор яаж байна гэхээр бүх байгууллагууд шууд автоматаар тоо өгөөд энэ тоогоо бууруулж чадахгүй бол өөр зардлаасаа хас гээд тавьчихаар тэгээд хэт бас тулсан ийм байдал болоод байна гэдэг л юм ярьж байна л даа. Тийм учраас энэ тал дээр бол тийм санал байна. Тэгээд Ерөнхий сайд бас энэ тал дээр анхаараад ажиллавал бас сайн байна гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Тогтмолын Мөнхсайхан гишүүн асуулт асууя.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Тэгээд юуны өмнө энэ төсвийг бол дэмжиж байгаа. Эрүүл мэнд, боловсролын салбараасаа таналт, хасалт хийхгүй гэж байгаад баяртай байгаа. Гэхдээ яг бодит байдал дээрээ жоохон өөр байгаад байна. Эмч, эмнэлгийн ажилчдаас цомхотгол хийхгүй гэсэн боловч эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнээс бусад мэргэжилтнүүдээс нь 9 хувийн таналт хийнэ гэж байгаа юм. Гэтэл энэ ажилтнууд чинь тухайн байгууллагын бараг 20 хүрэхгүй хувийг эзэлцгээдэг. Тэгээд олдоц муутай. Энэ мэргэжлээс нь 9 хувь хасчихаар энэ чинь өөрөө эргээд эмнэлгийн үйл ажиллагаа доголдоход бүр их сөрөг нөлөө үзүүлээд явчихаар байгаа юм. Тэгэхээр үүнийхээ тоо баримт, асуудлуудыг Эрүүл мэндийн сайд Сангийн сайдад сайн ойлгуулсан уу. Тэгээд нийт албан хаагчдын тооноос 9 хувь. Тэгээд эмнэлгийн биш ажилтан хасна гэх юм бол бараг тэгээд эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнээс өөр ажилтан хүрэхээргүй байгаа. Тэгэхээр энэ 9 хувиа яг яаж тооцож хасах юм. Тэрийгээ нэг тодорхой хэлээд өгмөөр байна.

Дараагийн 2 дахь асуудал энэ 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2025 оны төсөвт тавиулах гэж Жавхлан сайдаас би маш их гуйж, яг одоогийн байгаа нөхцөл байдлыг тайлбарлаж, Жавхлан сайд ч үүнийг маш сайн ойлгож, эрүүл мэндийн салбарыг дэмжиж, энэ 60 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг дийлэнх хувийг нь орон нутагт нийлүүлэхээр тавьж өгсөн. Ингээд 1 сарын 24-нд худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалтыг сайдын тушаалаар батлаад гаргачихсан. Тэгээд 1 сарын 24-өөс хойш худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд хийж амжуулаагүй энэ хүмүүстэйгээ, Төрийн нарийнд үүнийг худалдан авалтыг зохион байгуулж ажиллахыг үүрэг даалгавар болгосон тушаал гарчихсан. Тэгээд энэ хариуцлагагүй хандсан хүмүүстээ Эрүүл мэндийн сайд хариуцлага тооцох уу. Тэгээд нэгэнт хасагдсан гэж байгаа юм чинь тэр чигээр нь үүнийг бас бүтнээр нь хасуулчих бас хайран. Энэ дээр нэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжүүд

байгаа. 20, 30 хувийг нь ч болтугай буцааж тавьж өгөх тал дээр Сангийн сайд маань энэ дээр анхаарч өгөөч ээ гэж хүсэх байна.

Тэгээд эрүүл мэндийн салбараас энэ 60 тэрбумын хөрөнгө оруулалтаас гадна дахиад 40 гаруй тэрбум төгрөгийн хасалтыг хийсэн байна. Тэгээд 100 гаруй тэрбум төгрөг хасчихаад байна. Өнөөдрийн бодит нөхцөл байдал хүнд байгаа. 2024 оны эцсийн байдлаар бүх өр төлбөрийг дарагдуулж дууссан боловч, 2025 онд дахиад үүссэн энэ хүнд нөхцөлд дахиад 43 тэрбум төгрөг хасчихаар юу болох вэ. Тэгэхээр яг нийт хэдэн тэрбум төгрөгийг эрүүл мэндийн салбараас хасалт хийгээд байна. Үүнийг бас та бүхэнд хэлж өгөөч ээ гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн яам 4 дүгээр индэр.

Ж.Дэлгэржаргал: Мөнхсайхан гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал. Эрүүл мэндийн сайдын багц дээр хөрөнгө оруулалт дээр энэ жил 193 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалтууд батлагдсан. Эрүүл мэндийн тоног төхөөрөмж 60 тэрбум тэрбумаас 54 тэрбум хасагдсан. Гэрээ байгуулсан дүнгээрээ 5 тэрбум үлдсэн байгаа. Дээрээс нь хавдрын эмнэлэгтэй холбоотой тоног төхөөрөмжийн зардал 6.8 тэрбум, мөн хавдрын эмнэлгийн дэд бүтэц, хашаатай холбоотой санхүүжилт 5 тэрбум хөрөнгө оруулалтын зардлаас, мөн тендерийн хэмнэлтүүд гээд нийтдээ 69 тэрбумаар буураад, 132 тэрбум болсон байгаа.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн сайд Чинбүрэн нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Одоо бид Эрүүл мэндийн сайдын багцаас 33.5 тэрбум, хөрөнгө оруулалт 69.8 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сан 47, нийтдээ 150 тэрбум хасагдчихаад байгаа шүү дээ. Одоо тэгээд хариуцлагын асуудал яривал хаана ямар алдаа гарсан гэдгийг бол тодотгол хийсний дараагаар, процессын шинжилгээ анализ хийнэ. Ямар тэрний, үүний гээд ямар хов живээр хийлтэй биш. Бүх процесс ямар шатлалтай, үе шаттай явсан, ямар шийдвэрүүд гарч байсан, яасан бэ гэдэг тэр хариуцлага тооцож амжина.

Боловсон хүчний хувьд бол бид аль болохоор эмч, сувилагч, эмнэлгийн гол ачааг үүрч байгаа үйлчлэгч нарыг хасахгүй байх зарчим барьж байгаа. Харин харьяа эмнэлгүүдийн албадын дарга нарыг цөөлөх, баахан олон дэд дарга нарыг цөөлөх. Ер нь өнгөрсөн 21-ээс өнөө хугацаанд нийт ажилчдын орон тоо 14 мянгаар нэмэгдсэн байх жишээтэй. Энэ дээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ж.Чинбүрэн: Гол ажил хийдэг хүмүүсийн олж ирсэн мөнгийг зүгээр суугаад авчихдаг хэдэн албадын дарга нарыг цөөлнө. Харьяа байгууллагууд бас байна. Мөн давхацсан улс төрийн баахан томилгоотой. Аймгийн эрүүл мэндийн газрууд, зарим нэг шаардлагагүй зүйлүүдийг шигшинэ. Тэгэхдээ таны хэлж байгаа үнэн. Бид 9 хувьд хүргэнэ гэдэг бол асар хүнд. Асар хүнд. Нийтдээ 24 тэрбум төгрөг салбарын цалингийн хэмнэлт хийх гээд байна шүү дээ. Энэ бол асар хүнд. Тийм учраас энэ асуудлаа бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд бол ярьж байгаа. Тэгээд аль болохоор л тусламж, үйлчилгээний доголдол гарчихгүй байх, бодлогын алдаа гарчихгүй байхын төлөө хичээж ажиллаж байгаа.

Тоног төхөөрөмжүүд авч үлдэхийг хүссэн. Хүсэлгүй л яах вэ. Тэгээд энэ чинь бүгдэд, нийтэд нь үйлчилж байгаа журам. Бас л харамсалтай л байна. Хэлэх үг алга.

Д.Амарбаясгалан: Тогтмолын Мөнхсайхан гишүүн тодруулж асууя.

Т.Мөнхсайхан: Тэгээд тэр 9 хувийн цомхотгол хийхдээ тэр дэмжих албадынх нь тооноос 9 хувиа дор хаяж хийхгүй бол нийт ажилтан, албан хаагчдаас нь хийчих юм бол бусад ажилтнууд эмнэлгийн биш мэргэжилтнүүд үлдэхгүй болно шүү дээ. Тэрийгээ та хэд маань сайн бодоорой.

Тэгээд тэр хөрөнгө оруулалтын алдаа дутагдал гарсан зүйлүүд энэ Эрүүл мэндийн яам дээр чинь бүх гарсан тушаал, шийдвэр бүгдээрээ байж байгаа. Бүгдээрээ архивлагдаад хадгалагдаж байгаа. Хаана, хэний тушаал шийдвэр хэзээ гарсан, хэн хариуцлага алдсан гэдэг зүйлүүд тодорхой шүү дээ. Өнгөрсөн хугацаанд нэлээдгүй яригдлаа. Үүнийг тодорхой болгочихоор хугацаа өнгөрлөө. Та энийгээ бас богино хугацаанд тодорхой болгоод, ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаад, хаана хариуцлага алдсан, тэр дээр нь хариуцлагаа тооцоод, эргээд Сангийн яамнаас бас тодорхой хэмжээний нэн шаардлагатай санхүүжилтээ тавиулах тал дээр ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн сайд хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Засгийн газар бүрдээд, ердөө 10-аад хоног болж байна. Энэ хугацаанд бид бас хамгийн түрүүнд авч хэрэгжүүлж арга хэмжээ бол улаан бурхантайгаа тэмцэх асуудал бас нэлээн ноцтой асуудал байлаа. Өнөөдөр бид хэн нэгний хариуцлагын асуудлыг хөөхөөс илүү бушуухан улаан бурхнаа голомтод нь бариад авах, нөхөн дархлаажуулалтаа хийх гээд асар их яаралтай ажлууд байлаа. Өнөөдөр 17 хоногийн дотор л 1500-1600 тохиолдлоор нэмэгдэж байна. Өнөөдөр 10 мянга болчихлоо. Харин азаар манай эрүүл мэндийн салбарын эмч нарын ур чадвар сайн тулдаа эндэгдлийг 7-оос илүү гаргаагүй өнөөдөртөө барьж байна. Маргааш 8 болчих вий гэж айж байна. 9 болчих вий гэж санаа зовж байна. Тийм учраас бид вакцинжуулах ажлаа эрчимжүүлэхээр нэлээдгүй ажил хийгээд харин Засгийн газрын нөөц хөрөнгөөс 5 тэрбум, нөгөө алдагдаж байгаа мөнгөнөөсөө 10 тэрбумыг татаад бас нийтдээ 15 тэрбум зарцуулахаар бас овоо нааштай ажлууд бас урагшилж байгаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Ерөнхий сайд, Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн сайд болон Сангийн сайдаас асууя.

НҮБ-ын цөлжилтийн эсрэг 17 дугаар бага хурал Монгол Улсад 2026 оны 8 сард болно. Үүнийг 50 хүрэхгүй тэрбумаар барилга байгууламжийн асуудлыг оруулж ирээд, төсвийг нь хасаад, буцаагаад оруулаад ирсэн юм байна. Энэ бол бага мөнгө шүү дээ. Үүгээр хэрвээ бид нар Коп 17 хийж байгаа бол сайн. Өмнө нь АСЕМ-ыг бид нар 395.7 тэрбумаар хийж байсан байхгүй юу. Тэгэхээр энэ Коп 17-г Монгол Улсад хийгдэж байгаа дээр манайх хэдэн тэрбум, хэдэн их наядын орлого олох вэ. Одоо Орхон-Онги, Хэрлэн-Тооно усны төсөл чинь 2.7 их наяд байхгүй юу. Энэ мөнгийг Коп 17-оос босгох ямар нэгэн төсөл, төлөвлөгөө байгаа юу. Эндээс ер нь байгаль орчин, уур амьсгалыг эсрэг хэчнээн мөнгө төгрөг босгож чадах вэ. Дэлхий нийтээрээ өнөөдөр эко төсөл, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэж байгаа. Мөнгө хаана

байгаа вэ. Энд байгаа. Гэтэл өнөөдөр бид нар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаасаа 115 тэрбум төгрөг хасчихсан байна. Энд миний хамгийн их харамсаж байгаа нь хөв цөөрөм 333 төсөл 6.5 тэрбумаас нь 4.7 тэрбумыг нь хассан байна. Өгий нуурыг цэвэрлэх, аврах ажиллагаа нь 1.4 тэрбумаас нь бас л хасчихсан байх юм. Яагаад ингээд усны эсрэг төслүүдээ хасаад байдаг юм. Энэ Хөв цөөрөм чинь манай Өмнөговь аймгийн хэд хэдэн сумдад хэрэгжээд, их хөөрхөн явж байсан шүү дээ. Говийн бүсэд энэ ус асар их хэрэгтэй.

“Алт 3” аян хийх юм шиг байна Дамдинням сайд аа. 45 алтны үндсэн ордыг тэгээд 25 аж ахуйн нэгжийг ажилд оруулж, 129.4 тонн алт олборлохоор зорьж байх шиг байна. 1кг алтыг 4 тонн усаар олборлодог. Усны нөөцөө тооцож үзсэн үү. Хэчнээн тонн усны нөөц орох вэ. Өнөөдөр Монгол Улсын “Алт 3” аян, дээрээс нь нүүрс, зэс бүгдийг нь олборлоход ус хэрэглэдэг. Тэгэхээр манай улс яагаад энэ байгаль орчин, уур амьсгалын эсрэг хэрэглэх төсвөө хасаад байгаа юм. Яагаад 2.7 их наядыг босгох төслөө өнөөдрийг хүртэл танилцуулахгүй байгаа юм. Ерөнхий сайд аа, Коп 17 дээр энэ мөнгийг босгож чадах уу. Ямар ямар мөнгө босгох зорилттой байгаа вэ.

Байгаль орчны сайдаас асууя, Г.Дамдинням сайдаас асууя, Ерөнхий сайдаас асууя, Сангийн сайд тэгээд дандаа манай говийн төсвийг хасдаг юм даа. Өмнөговь аймгийн хөгжлийн сангаас авах мөнгийг 17 тэрбумаар, Дорноговийг 22.3 тэрбумаар хасаад хаячихсан. Говьсүмбэрийг 2.7. Монгол Улсын 80 их наядын дотоод .../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулт авчхаад, нэмээд тодруулчихъя. Болдын Жавхлан сайд. Батбаатар сайдын микрофоныг өгье.

Б.Батбаатар: 2025 оны төсөв дээр Коп 17-г санхүүжүүлэх зорилгоор бэлтгэл ажлыг хангах зорилгоор төсөвт 50 тэрбум төгрөг тавигдсан. Энэ 50 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Улаанбаатар хотын ахирагч, Засаг даргад эрхийг нь шилжүүлэх ажлыг Байгаль орчны сайд шилжүүлсэн юм байна лээ. Энэ шилжүүлсэн төсвөөс 8.1 тэрбум төгрөг нь гэрээ хийгдээд 05 сарын 31-ний дотор 41.8 тэрбум нь гэрээ хийгдээгүй. Гэрээ хийгдээгүй учраас төсвийн хэмнэлтийн хуулиар буцаан татагдсан. Энэ буцаан татагдсан мөнгө одоо төсвийн тодотголд эргүүлэн оруулж ирж байгаа. Гэхдээ төсвийн тодотголоор нэмэлтээр оруулсан хөрөнгө төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагаанд зориулагдах ёсгүй гэсэн Төсвийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх заалт байгаа. Энэ үүднээсээ эрхийг нь бол Улаанбаатар хот руу дахиад шилжүүлнэ. Тэгээд энэ нь өөрөө зарагдаж болох уу, үгүй юү гэдэг дээр Сангийн яамнаас тодруулгууд байнга нэхэгдэж байгаа. Энэ дээр тодруулга ямар боломжууд байх вэ гэдгийг хуулийн хүрээнд гаргах ёстой гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Өчигдөр Коп 17-ийн Үндэсний хороо хуралдаад, Сангийн яам, Хууль зүйн яам, хот болон бусад холбогдох газруудад бол шаардлагууд тавигдсан. Ер нь Коп 17 хийгдээд юу болдог юм бэ гэж. Одоо өмнөх Коп 16-д Саудын Арабд болсон. Энд бол 500 сая долларын төсөв зарцуулаад, одоо Монгол Улсад шилжүүлж өгөх хугацаандаа 10 тэрбум долларын хөрөнгө оруулалт босгож байгаа юм байна лээ. Энэ 10 тэрбум долларын хөрөнгө оруулалт бол тухайн газар нутгийн цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад бол зарцуулагдана. Тэгэхээр Монгол Улс энэ дээр анхаарал хандуулбал бид дараагийн Коп 18 хүрэх хугацаанд Цөлжилтийн конвенцын удирдлагаар ажиллахдаа тодорхой хэмжээний хөрөнгө санхүү босгох тийм боломж байгаа. Өнөөдөр энэ Коп 17-г зохион байгуулахад хандив хүлээж авах данс байхгүй. Төсвийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд өчигдөр Коп 17-ийн

Үндэсний хорооны хурал дээр бол боломжгүй болсон. Төсөвт буцаан татагдах данс буюу одоо Сангийн дансанд донор байгууллагууд буюу гаднын хандивлагч нар хөрөнгө, санхүү хандив, тусламж үзүүлэх боломжгүй. Энэ асуудлыг ирэх долоо хоногт Засгийн газрын хурлаар оруулж юм уу, яаралтай шийдвэрлэхээр одоогийн байдлаар ажиллаж байна.

Х.Булгантуяа: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням сайдын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Манай Мөнхбаясгалан гишүүн маш чухал асуудлыг ярьж байна. Уул уурхайн баяжуулалтын технологид олборлолтод ус бол хамгийн чухал. Тэгээд бид энэ Улсын Их Хурлын тогтоолыг оруулж ирж байгаа “Алт 3” аяны хүрээнд зөвхөн үндсэн ордуудын асуудал яригдаж байгаа. Зөвхөн үндсэн ордууд гэдэг бол усыг дахин ашиглах тухай асуудал байдаг. Үндсэн ордын ашиглалтад ер нь усыг 90 хувь хүртэл хамгийн багадаа дахин ашиглах ийм технологиуд гарчихсан. 1 дүгээрт.

2 дугаарт, уул уурхайн хаалтын барьцаа, дэнчин хөрөнгийг нь бол тултал нь авна гэсэн ийм л төлөвлөлттэй байна. Мөн тогтвортой хөгжлийн чиг баримжааг барьсан хариуцлагатай уул уурхай гэж томъёолол байгаа. Энэ нь өөрөө байгаль орчны олон улсын стандартыг хангасан энэ төслүүдийг л хөдөлгөнө гэсэн ийм шалгуураа тавьчихаад байгаа юм. Энэ магадгүй нөгөө жоохон мэргэжлийн үгнүүд байгаа учраас бас тэгж харагдаад байгаа байх. Тэгээд тантай санал нэг байгаа

Х.Булгантуяа: Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. АМНАТ-тай холбоотой хэсэг ийм юм байгаа юм шүү Мөнхбаясгалан гишүүн ээ. Энэ жил 5.6 их наяд төгрөгийн орлого орно гэж тооцсон. АМНАТ-аар. Гэтэл бид 1.7 их наядыг алдахаар ийм тооцоо гарч байна. Төсвийн тодотголоор АМНАТ-ийн орлого маань 3.9 их наяд болж буурч байгаа юм. Тэгэхээр нөгөө АМНАТ-аас хуваарилагддаг орон нутгийн хөгжлийн сангууд маань энийгээ дагаад буурч байгаа юм шүү. Тэрнээс биш танаж байгаа асуудал биш. Өмнөговь аймаг маань бол хамгийн том дүнгээр орон нутгийн хөгжлийн сангаа зузаатгал авдаг. Тэр дүнтэй нь л яг ингээд хувилахаар тэгж хасагдаж байгаа юм шүү. Тэр дүнгүүдийг нь Золбоо дарга хариулчихъя.

Х.Булгантуяа: Нэмээд тодруулчихаар хариулчихъя. Тэгэхгүй бол 4 минут 1, 1 гэдэг дэгтэй. Мөнхбаясгалан гишүүн нэмж тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Коп 17-оор 10 тэрбум доллар. Тэгээд үүнийг авах данс байхгүй гэнэ үү. Энэ 10 тэрбум доллар орж ирэх юм бол үүнээс говийн усны төсөлд оруулах уу. Яагаад гэвэл Монгол Улсын 80 их наядын дотоодын нийт бүтээгдэхүүний 6.2 их наядыг бүтээдэг ард түмэн. Дээрээс нь говийн бүсэд Засгийн газрын 14 мега төслийн 6 нь хэрэгжиж байгаа. Одоо дахиад стратегийн ордууд орж ирэхэд 9 нэмэгдээд манайд нийтдээ 14 стратегийн орд ажиллах юм Ерөнхий сайд аа. Тийм учраас би энэ говийн усны төсөл Хэрлэн-Тооно, Орхон-Онги төсөл 2.7 их наяд байхгүй юу. Энэ дээр та яг юу бодож байгаа вэ. Энэ 10 тэрбум доллар чинь их л аятайхан мөнгө байна даа. Үнэн бол.

Х.Булгантуяа: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Коп 15-ыг зохион байгуулсан орон бол 2.5, копоо зохион байгуулж дуусахад 100 сая доллар буюу тэгээд дараа нь 2 жилийн дотор 2.5 тэрбум долларын цөлжилтийн эсрэг хөрөнгийг олон улсын зах зээл дээрээс босгож авч чадсан. Коп 16-г зохион байгуулсан Арабд 500 сая долларыг Коп-16-г зохион байгуулахад зарцуулаад, өнөөдрийг, ирэх оныг хүртэлх хугацаанд 10 тэрбум долларын эх үүсвэрийг босгож авч чадаж байгаа. Энэ бол Саудын Арабын олж байгаа мөнгө. Харин манайх энэ Коп-17-г зохион байгуулахад урьдчилсан төсөөлөл, бэлтгэл ажлын хэсгийн гаргасан дүнгээр 356 тэрбум төгрөгийн буюу 100 сая долларын зардал гарна гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Одоогийн байдлаар бол 40, 50 тэрбум төгрөг тавигдсан. Бид нар хандив Коп 17-г зохион байгуулах хандивыг бий болгоход Монгол Улсын өнөөдрийн хууль тогтоомж, Сангийн яамны хууль дагаж явж байгаа энэ хүрээ дотор .../минут дуусав/

Х.Булгантуяа: Мөнхбаясгалан гишүүн нэмж тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Нэгэнт Коп 17 чинь цөлжилтийн эсрэг юм чинь говийн бүсэд хийчихье л дээ. Тэр 50 тэрбумыг чинь манай говийн бүс гаргачихъя Ерөнхий сайд аа. Тэгээд тэр 10 тэрбум доллароо ... тэгж болно биз дээ. Та нэг хариулаач Ерөнхий сайдаа.

Х.Булгантуяа: Говийн бүс чинь дөнгөж саяхан мөнгө татлаа гэснээ гаргачихъя гэж байна. Ерөнхий сайд нэмж хариулах уу. Ерөнхий сайдыг хариулуулъя гэж байна. Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Та 2 ер нь 10 тэрбум доллар энэ тэр гээд аятайхан аятайхан юм их л яриад л байна. Тэгээд говийн бүсэд хийчихье л гэж байна. Тэгэхдээ энэ чинь сая манай Батбаатар сайд хэллээ. 500 сая доллар зарж байж, Коп хийсэн гэж байна шүү дээ Саудын Араб. Бид нар 500 сая доллар биш, 50 тэрбумаар энэ жилийн хувьд 50 тэрбум сууж байгаа шүү. Үүнээс ч их мөнгө зарцуулагдана. Энэ цэцэрлэгт хүрээлэнд хийхээр одоо эхлээгүй байгаа ажил. Энгийг чинь олон улсад амлалт авахдаа 2 жилийн өмнө өөрсдөө юмаа хийчхээд барих газраа барьчхаад, төлөвлөчхөөд хийдэг ажил. Тэгээд одоо хийгээгүй байгаа ажлаа бид нар ирэх жил хийнэ гээд үндсэндээ одоо төсөвт суулгаад энэ зуныг алдчихвал ирэх жилийн 8 сард Коп хийнэ гэдэг 2 жилийн өмнө авсан амлалтаа яагаад авсан юм, яаж хэрэгжүүлэх юм гэдэг чинь өөрөө тусдаа хэрэг. Тэр Саудын Арабын босгосон 10 тэрбум доллар бол тусдаа хэрэг.

Ер нь зүгээр яах вэ, Green Climate Fund болон GGGI /Global Green Growth Institute/ гээд олон улсын байгууллагууд Дэлхийн Банк, Эй Ди Би зэрэг олон .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж 1 минут өгье.

Г.Занданшатар: Олон улсын сангаас Орхон-Онги, Хэрлэн говь төслүүдийг ус дамжуулах томоохон төслүүдэд 100-150 сая доллар татах урьдчилсан санал яригдсан ч гэрээ хэлцэл бүрэн батлагдаагүй. Энэ төслүүдээр ярина. Улсын төсөвт эдгээр төслийн хөрөнгө оруулалтыг 2025 оны улсын төсөвт суугаагүй ч гэсэн гадаад эх үүсвэрээс ЖАЙКА, ADB, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн сан, Green Climate Fund-аас босох боломжийг үлдээсэн. Ерөнхийдөө Орхон-Онги зэрэг төслүүд улсын төсөвт бүрэн багтаагүй ч гадаад санхүүжилтээр татах байдлаар үргэлжлэх ийм чиглэлтэй байгаа. Ер нь яах вэ, Коп 17-оор Монгол Улс 10 тэрбум долларыг татах зорилт урт хугацааны, дунд, урт хугацааны тийм зорилт дэвшүүлж байгаа ч

гэсэн ойрын хугацаанд 100-150 сая долларын санхүүжилт төсөлд босгохоор олон улсын түншүүдтэй яриа хэлцэл хийж байна. 10 тэрбумаа та хариулчих.

Х.Булгантуяа: Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Ер нь бол зүгээр Коп 17-г зохион байгуулах ажил бол Гадаад харилцааны сайд, Улаанбаатар хот, Байгаль орчин, уур амьсгалын сайд, 12 дэд хороо гээд ажлууд бол ерөнхийдөө нэгдмэл удирдлагын хувьд бага зэрэг тарсан байгаа. Нөгөө талдаа бас Байгаль орчин, уур амьсгалын яам өөрөө ажиллахад туйлын хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байгаа. Бид нар бол 3 газар яам хуваагдаж ажиллаж байгаа. Одоо өөр өөр байшингуудад ажиллаж байна гэсэн үг. Ер нь зүгээр дэлхий нийтэд карбон хүлэмжийн хийн асуудал дээр гэхэд 500 тэрбум долларын үүрэг амлалт авчихсан. Олон улсын хэмжээний үндэсний уул уурхайн бусад үйлдвэрлэлийн компаниуд байж байдаг. Энэ 500 тэрбум доллараас Монгол Улс бол татаж авах бүрэн боломж байгаа. Үүн дээр бол Коп 17-ийн ач холбогдлыг оруулж чадвал бид бол зүгээр 10 тэрбум уу, 1 тэрбум уу ямар ч байсан тодорхой хэмжээ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр.

Г.Хосбаяр: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Төсвийн тодотголоор 500 гаруй тэрбум төгрөгийн бас хөрөнгө оруулалт хасаж байх шиг байна. Тэгээд би бол уг нь үүний эсрэг байгаа юм. Энэ бол хувийн хэвшилд очих мөнгө. Энэ бол ямар нэгэн бүтээн байгуулалт хийгдэх мөнгө. Энэ улс оронд чинь хийх ажил зөндөө байгаа. Тийм учраас төсвийн шаардлагагүй зардлууд, тэр хэмнэж болох зардлаа бол хасах хэрэгтэй. Эсрэгээр нь жоохон тавигдсан төсвийн хөрөнгө оруулалтаа хасахгүй байх, илүү боломж байвал нэмэгдүүлэх энэ талд Засгийн газар уг нь ажилламаар байгаа юм л даа. Тэгэхгүй бол өнгөрсөн оны төсвийн тодотголоор ч тэгж байсан чаддагаар нь, хөрөнгө оруулалтаасаа л хасчихдаг. Шинэ хөрөнгө оруулалт ерөөсөө хийгдэхгүй. Тэр дундаа хөдөө орон нутагт маш их хийх ажил байна л даа. Тэгээд энэ ажлыг ер нь энэ жил, хойтон жил, хойтон 2026 онд ер нь шинэ хөрөнгө оруулалт хийгдэхгүй юм байна гэж ойлгож байна. Тэгээд нөгөө талдаа хувийн хэвшилд очих мөнгө багасаж байна. Хувийн хэвшлийн орлого багасаж байна. Хувийн хэвшил орлого багасаад, мөнгөгүй болохоор татвар шимтгэл төлөлт нь багасах байх. Тэгэхээр улсын төсвийн орлого багасна гээд олон хүчин зүйл байгаа. Тийм учраас бас чамлахааргүй олон хүн ажиллаж байгаа хувийн хэвслээ, хувийн аж ахуйн нэгжүүдээ бас жоохон бодож баймаар байна. Тийм учраас энэ хөрөнгө оруулалтаа хасахгүй байх, төсвийн тодотголоор хасахгүй байх боломж байгаагүй юу гэдэг асуултыг бас асууя.

2 дугаарт нь, аймгууд бонд гаргах асуудал байгаа. Нийслэл бонд гаргаад ажил хийж болоод байна. Бас зарим ажлууд нь хүмүүсийн талархлыг хүлээж байна. Бас мөнгө байвал ажил хийж болдгийг харуулаад байна шүү дээ. Тийм учраас энэ аймгууд бонд босгох, бонд гаргах энэ ажил нь юу болж байна. Ер нь гаргасан аймаг байна уу.

3 дугаарт нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвараасаа бас нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийвэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх ийм хууль гарчихсан байгаа. Тэгээд Сангийн яам дээр 1 журам хүлээгдэж байгаа гэж ойлгосон. Энэ журам гарсан уу. Үүгээр ер нь хэр их ажил хийгдэх боломжтой вэ. Одоо том том аж ахуйн нэгжүүд бий болсон. Аж ахуйн

нэгжийн орлогын албан татварт ашгаасаа маш их татвар төлж байгаа. Энэ мөнгөнөөсөө бас нийгмийн хариуцлагын хүрээнд бүтээн байгуулалтын ажлууд, хөрөнгө оруулалт хийчихвэл татвараас чөлөөлөгдөхөөр байгаа. Тэгэхээр энэ журам гарсан уу. Үүгээр ер нь яг ажил хийгдэхээр байгаа юу.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Ганбатын Хосбаяр гишүүн ээ, энэ хөрөнгө оруулалтыг бол төсвийн тодотголоор танасан, хассан юм биш шүү дээ. Энэ чинь өөрөө төсвийн хэмнэлтийн хуулиар хасагдчихсан юм. Тэр саяын Эрүүл мэндийн яамны яриад байгаа 60 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж импортоор орж ирж таарна. Валютын ханшийг чинь нөлөөлж таарна. Тэгэхдээ өөрөө хасагдчихсан хөрөнгө оруулалт. Засгийн газрын ордон барина гээд төлөвлөчихсөн 210 тэрбум төгрөг 05 сарын 30-ны байдлаар гэрээ байгуулагдаагүй бүх хөрөнгө оруулалтууд хэмнэлтийн тухай хуулиар царцаад хасагдчихаж байгаа юм. Тэгээд тэр жилдээ тэр чинь ажил нь хэрэгжиж эхлэхгүй учраас төсвийн хэмнэлтийн хууль тэгж тусгасан юм шиг байгаа юм. Тэгээд энэ нөгөө зуныг алдчихна. Хөрөнгө оруулалтын ажил нь эхлэхгүй. Ийм учраас хассан юм биш, өөрөө хасагдчихсан юм гэдгийг нь ойлговол зохино. Тэр бусад асуудлыг Жавхлан сайд хариулчихъя.

Х.Булгантуяа: Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сая Ерөнхий сайд маань бараг хэлчихлээ дээ. Тэрийг хүмүүс буруу ойлгоод байгаа юм. Ингээд нөгөө тодотголтой давхцаж яригдаж байгаа учраас тодотголоор хасчихлаа гэж ойлгоод байх шиг байгаа юм. Тэгээд тодотголтой, тодотголгүй 05 сарын 31-нд хуулиараа хэмнэлтэд орчихсон байгаа. Тэрийг яг тоог нь баталгаажуулж, Засгийн газар дээр танилцуулаад л ингээд дуусчхаж байгаа асуудал. Тодотгол бол тусдаа шүү. Өөр асуудлууд байгаа гэдгийг тодруулж хэлье.

Аймгуудын бонд эрх зүйн хувьд бол нээлттэй байгаа. Одоогоор Өмнөговь аймаг бол тийм хүсэлт гаргаад, энэ бол анхны тохиолдол болох учраас дээрээс нь бонд гаргах асуудал маань бол нэлээн нарийн мэргэжлийн бас экспертүүд шаарддаг ийм ажил учраас Сангийн яамнаас туслаад, бид нэгдсэн ажлын хэсэг гаргаад ажиллаад явж байгаа шүү. Өөр аймгууд дээрээс ийм хүсэлт одоогоор ирээгүй байна.

Тэр татварын хөнгөлөлт 1 хувьтай холбоотой асуудал дээр Сангийн яамнаас бол ямар ч журам гарахгүй. Харин бүх яамнууд өөр өөрсдөө тус тусдаа журмаа гаргаад, бүгд гаргачихсан байгаа. Гаргаад .../минут дуусав/

Х.Булгантуяа: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Тэгээд тэр яамнууд дээр тус тусдаа журам гарсан гэж ойлголоо. Яг энэ хүрээнд хийгдсэн ажил байгаа юу. Жишээлбэл надад ирсэн мэдээллээр “СУ” дэлгүүр гэхэд сургуулиудын 00-ийг засварлая ч гэдэг юм уу, өөр том том уул уурхайн аж ахуйн нэгжүүд тухайн орон нутагтаа бас Соёлын ордон, Соёлын төв, бүтээн байгуулалтууд хийе гэсэн ийм саналууд явж байгаа. Ерөөсөө ажил хэрэг болохгүй байгаа гээд байгаа. Тэгэхээр энэ дээр бас хариулах хүмүүс байвал яг одоо ажил хийгдсэн үү. Ямар шатдаа явна. Хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт явж байгаа юм. Энэ талаар мэдээлэл өгөөч.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс хариулах уу. Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ 1 хувийн татварын хөнгөлөлтийн дотоод тэр шаардлага журам нь гараад, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээд, хүчин төгөлдөр болоод эхэлж байгаа. Яах вэ, ганц нэг жишээ дурдахад ХААН банк өөрөө манлайлаад яг ийм багийн бага сургууль гээд хил орчим газруудад бага сургууль байгуулах ажлыг эхлүүлж байна. Энэ хагас сайн өдөр бид Юнисефтэй хамтраад нээлтээ хийхээр төлөвлөчихсөн явж байна. Мөн “CU” сүлжээнийхэн бас энэ сургуулийн жорлонг сайжруулах ийм төслийг хэрэгжүүлэе гээд хуучирсан ийм нийслэлд байгаа жорлонгуудыг бол олон улсын жишигт нийцсэн ийм цэвэрхэн жорлон болгох ажлуудыг эхлүүлж байх жишээтэй. Иймэрхүү тодорхой жишээнүүд байна. Ер нь бол хуульдаа бид бас дагаж гарч байгаа хуульдаа түрүүнд хэлсэнчлэн нэмэлт оруулаад, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж дээр энэ бас хэрэглэгдэхээр болж байгаа. Энэ бас том дэвшил гэж бид харж байгаа.

Х.Булгантуяа: Татварын ерөнхий газраас нэмж мэдээлэл өгье. Нийт ер нь хэчнээн хэмжээний төсөл хөтөлбөр ингэж хэрэгжсэн бэ гэж асууж байх шиг байна.

А.Энхболд: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газрын Дэд дарга Энхболд. Нийт 87 татвар төлөгч хамрагдсан байгаа. Энд болохоор 7 татвар төлөгч нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа. Боловсролын яаман дээр 18 аж ахуйн нэгж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр 6 аж ахуйн нэгж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам дээр 45 аж ахуйн нэгж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам дээр 5 аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн яаман дээр 4 аж ахуйн нэгж, Зам, тээврийн яам дээр 2 аж ахуйн нэгж, нийтдээ 87 аж ахуйн нэгж хөнгөлөлт эдлэх байгаа. Энд нийт хөрөнгө оруулалтын дүн байхгүй. 44.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр байгаа.

Х.Булгантуяа: Энийг ер нь нийт хөрөнгө оруулалтын дүнг бас нэгтгэж гаргамаар юм байна Жавхлан сайд. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Төсвийн тодотголыг дэмжиж байгаа. Энэ төсвийн тодотгол дээр өөрсдөө төсвөө бүрдүүлдэг орон нутгийн төсөв дээр ер нь ямар зарчим баримталж хуваарилж байгаа вэ гэдэг асуулт байгаад байна. Жишээлбэл, Дорнод аймгийн хувьд сонсохоор төсвийн зардлыг нь болохоор 9 тэрбум төгрөгөөр бууруулаад, орлогын төлөвлөгөөг нь бол 1 тэрбум төгрөгөөр л бууруулсан байгаа юм. Тэгээд ингээд бодоод үзэхээр тэртээ тэргүй улс орны хэмжээнд уул уурхайн салбар ерөнхийдөө унаж байгаа. Тэгэхээр тухайн орон нутгийн уул уурхайн компаниудаас оруулж байгаа орлого багасна. ХХОАТ-ын бас орлого багасна гээд бодоод үзэхээр тухайн орон нутагт зөвхөн 1 тэрбум төгрөгийн орлогыг нь багасгаад, 9 тэрбум төгрөгөөр төсвийн зардлыг нь бууруулчихаар арай л пропорцын хувьд болохгүй байгаа юм шиг харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр 1 тайлбар өгөөч гэж асууя.

Х.Булгантуяа: Болдын Жавхлан сайд хариулах уу. Ажлын хэсэг 4 номерын микрофон.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Соронзонболд гишүүний асуултад

хариулъя. Тэгэхээр орон нутгийн төсвийн суурь зарлагыг бол бид энэ удаагийн тодотголоор 698.1 тэрбум төгрөгөөр бууруулсан байгаа. Энэ нийт бууруулалтыг хийхдээ бид яг улсын төсөв дээр зардлыг нь бууруулсантай ижил зарчим баримталсан. Орон тоо болон бусад аймгийн суурь зарлагад туссан үйл ажиллагааны зардлуудыг бол 7 дугаар сараас он дуустал хүртэлх төсвүүдийг нь тодорхой хувь хэмжээгээр бууруулсан. Энэ дээр бол нийт аймгуудын хувьд нийслэл Улаанбаатар хотыг оролцуулахгүйгээр бүх аймгийн хувьд дунджаар 18 хувиар суурь зардал нь бол буурсан байна. Орлогын хувьд яг аймгуудын ААНОАТ, ХХОАТ болон бусад энэ төлбөрүүдийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл дээр нь үндэслээд бууруулалтыг хийсэн байгаа. Ийм зарчмаар бол орон нутгийн төсвийн суурь орлого, суурь зарлагыг бууруулаад, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг болон төвлөрүүлэх орлогыг тооцож гаргасан. Баярлалаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр нөгөө төсвөө өөрсдөө бүрдүүлдэг гэдгийг нь харгалзаж үзэхгүйгээр адилхан зарчим баримталсан юм уу гээд байхгүй юу. 21 аймагт чинь зарим аймаг нь бол уул уурхайн орлого нь өндөр байгаа шүү дээ. Зарим аймагт бол огт уул уурхайн орлого олдоггүй бас аймаг байгаа. Тэгэхээр тэрийг нь бас жоохон харгалзаж үзэх ёстой байсан уу гээд байхгүй юу. Жишээлбэл, 9 тэрбумаар нь нэг талынх нь зарлагыг нь багасгачхаад, нөгөө талд нь орлогыг нь зөвхөн 1 тэрбумаар нь бууруулчихаар чинь уул уурхайн салбар адилхан л унаж байгаа тохиолдолд орлого нь орж ирэх нь хэцүү юм биш үү гээд байхгүй юу. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ч тэр, ХХОАТ ч тэр. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг ажиллах нь анхаарах ёстой байх л гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий сайд аа, өнөөдөр бид нарын яриад байгаа энэ 30 их наяд төгрөгийн төсвийг бүрдүүлж байгаа газрууд бол манай аж ахуйн нэгж, байгууллагууд байгаа. Өнөөдөр энэ 30 их наядын 40 орчим хувь болох 12 их наяд төгрөгийг 110 мянган хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд бүрдүүлж байгаа. Үүнийгээ татвараараа дамжуулж буюу аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, цаашлаад НӨАТ гэх мэтчилэн татвар дээр хувь нэмэр оруулж бүрдүүлэлцэж байгаа. Энэ түрүүний яриад байгаа уул уурхайн салбараас 2 дахин их гэсэн үг. Ингээд байж байтал өнөөдөр одоо дөнгөж сая Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хэлэхдээ төсөв бүрдүүлэлтээ тэр татварын бүрдүүлэлт дээр бол хувийн хэвшил дээр хүнд дарамт ирнэ гэдгийг бас хэллээ. Нөгөө талдаа одоо та бүхэн ч мэдэж байгаа байх. Хувийн хэвшлээс ирж байгаа маш олон саналууд байгаа. Сая бас энэ ордонд хийсэн НӨАТ-тэй холбогдолтой хэлэлцүүлэг дээр бас хэлж байсан. Ижил тэгш татвар дээр зарчим үйлчлэхгүй байна. Одоо хуулийн дагуу татвараа мэдүүлээд явж байгаа байгууллагуудынхаа үйл ажиллагааг доголдуулах маш их асуудлуудыг гаргаж байна. Ингэхдээ данс хааж байна. Ингээд данс нь хаагдчихаар энэ байгууллагууд тогтвортой үйл ажиллагаа явуулахад маш хүндрэлтэй. Банкныхаа хүүг төлж чадахгүй эсвэл урсгал зардлаа гаргаж чадахгүй, цалин хөлсөө тавьж чадахгүй. Монголд бизнес эрхлэх бол эр зориг, тэвчээрийг шаардсан ийм хүнд асуудал болж байна гэж байна. Тэгэхээр ингээд хуулийн дагуу татвараа төлөөд, нийгмийн даатгалаа төлөөд, дээрээс нь НӨАТ-ынхаа татварыг төлөөд явж байгаа аж ахуйн нэгжүүдтэйгээ нэг талдаа болохоор бид нартай хамтраад ажиллаач ээ бид нар та нарт татварын хөнгөлөлт үзүүлье. Та бүхэн

нийгмийн хариуцлагынхаа хүрээнд боловсролын салбар, соёлын салбарт үйл ажиллагаа эрхлээд, хөрөнгө оруулалтуудыг хийгээд өгөөч ээ гээд байдаг. Нөгөө талдаа болохоор үйл ажиллагааг нь тэлэх, үйл ажиллагааг нь тогтвортой явуулах энэ байдлыг нь бид нар энэ татварын хуулиараа дарамт шахалт үзүүлж байна. Энэ дээр Ерөнхий сайд та ямар бодлого барьж цаашид ажиллах юм бэ. Хэрвээ бид нар нийт бид нарын энэ ярилцаад байгаа төсвийн орлогын 40 орчим хувийг бүрдүүлж байгаа 110 мянган аж ахуйн нэгжээ ингэж боомилж цаашаа явах юм бол энэ аж ахуйн нэгжүүдийн хувьд үйл ажиллагаа явуулах, тогтвортой байхад өнөөдрийн байгаа эдийн засгийн хувьд, өнөөдрийн өндөр хүүтэй арилжааны хүү, бодлогын хүү ямар түвшинд байгаа билээ, инфляц ямар түвшинд байгаа билээ. Энэ нөхцөлд бол аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж, татвараа төлөхөд хүндрэлтэй болж байгаа гэдгийг та бас анхаарч, энэ дээр татварын хуулиуд дээр ямар өөрчлөлтүүд цаашид оруулж, төсвийн орлогоо аль аль талдаа амархан байдлаар бүрдүүлэх боломжийг бий болгох вэ гэдэг асуулт байна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Чинбатын Номин гишүүний асуултад хариулъя. Номин сайд бас энэ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр, аялал жуулчлалын чиглэлээр бодит эдийн засгийн салбарыг дэмжих чиглэлээр бол бас тодорхой санаачилгатай ажиллаж байсан учраас сайн мэдэж байгаа байх. Миний бодлогыг бол мэдэж байгаа байх гэж бодож байна. Одоо бид татварын реформыг намрын чуулганаар оруулж ирэхээр төлөвлөж байгаа. Татвар тэгш шударга байх ёстой. Төлдөггүй нь хождог, төлдөг шударга нь татварын дарамтаа авдаг ийм шударга бус татварын тогтолцоо, бас татвар хураалтын процесстой холбоотой хүчлэл албадлагын шинж чанартай асуудлууд. Саяын 1 хувийн хөнгөлөлт ч гэсэн яг үнэндээ төсвийн хууль зөрчиж байгаа. Төсөв төвлөрөөд үүнийг Улсын Их Хуралд зарцуулах ёстой юм. Тэрүүгээр 1 хувиар савирч байгаа тийм цоорхойноос авхуулаад энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлт шударга бус байдлыг бий болгож байгаа гэх мэтчилэн энэ цонх суваг нүхүүдийг хааж байж, татварыг тэгш шударга системтэй болгож, нийтээрээ тэгш төлдөг ийм зарчим руу оруулахгүй бол манай татварын тогтолцоонд бол гажуудал үүссэн байна гэж үзнэ. Ийм учраас татварын реформыг татварын бааз суурийг өргөтгөх замаар илүү тэгш, шударга ёсны зарчимд нийцүүлсэн ийм татварыг бий болгоно. Жишээлбэл, баялгийн татварыг бий болгоё гэж төлөвлөж байгаа. Өсөн нэмэгдэх АМНАТ-ийг баялгийн татвар болгож нэмэгдүүлэх гэх мэтчилэн татвар бол зөвхөн төсөв бүрдүүлэхэд чиглэгдсэн биш, нийгмийн дундаж давхаргыг дэмжих, орлогын хэт ялгааг багасгахад чиглэгдсэн ийм нийгмийн шударга ёсны татвар гэж үздэг энэ татварын реформыг намрын чуулганаар өргөн барихаар төлөвлөж байна. Ингэснээрээ хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсээ дэмждэг, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хувийн хэвшлээ дэмждэг ийм татварын реформыг бид намрын чуулганаар оруулж хэлэлцэхээр төлөвлөж байна. Одоо хаврын чуулган завсарлаж байгаа учраас амжихгүй байх.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулъя.

Ч.Номин: Ерөнхий сайд татварын гажуудалтай асуудлыг намрын чуулганаар оруулж ирж, засна гэж хэлж байна гэж ойлголоо. Цаашлаад 2 дахь асуулт маань байна. Өнөөдрийн байдлаар бид нар 623 хөрөнгө оруулалт буюу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа юм байна. Үүний 110 нь яг шинэ 2025 онд одоо хэрэгжиж байгаа хууль дээр орж ирсэн. Үүний 4 хувь нь хэрэгжилт хангасан буюу санхүүжилтээ авсан. Гэтэл өнөөдөр бид нар дахиад 612 төсөл арга хэмжээ орж ирж

байгаа. Энэ нь дахиад 110 шинэ төсөл хөтөлбөр, арга хэмжээ орж ирж байна. Дахиад 1 орчим их наяд төгрөг. Үүнийг бид нар яг бодитоор хэрэгжүүлж чадах уу. Сая бол бид нар хэрэгжүүлж чадахгүй өнгөрлөө. Одоо төрийн худалдан авах дээр нийт худалдан авах ажиллагаа төвлөрсөн. Тэгэхээр энэ төвлөрлөөс болоод энийгээ хэрэгжүүлж чадах уу Сангийн сайд аа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Үгүй ээ, 612 төсөл арга хэмжээ одоо хэрэгжээд явж байгаа төсөл арга хэмжээ шүү дээ. Тийм ээ. 2.9 их наядын санхүүжилтийг олгохоор энэ төсвийн өөрчлөлт нь орж байгаа нь одоо гэрээ хэлцэл нь хийгдээд явагдаж байгаа хөрөнгө оруулалтууд гэж байгаа. Энэ төсвийн тодотголоор 3 хөрөнгө оруулалт л нэмэгдэж байгаа.

1 дүгээрт энэ 3 дугаар цахилгаан станцад болсон дэлбэрэлттэй холбогдуулаад 3 дугаар цахилгаан станцын 9 дүгээр турбиныг засахтай холбоотой хөрөнгө оруулалтын зардал;

2 дугаарт, энэ Коп-ын хөрөнгө хураагдчихсан зарцуулж амжаагүй, саяын яриад байгаа 41.8 тэрбум гээд 50 тэрбум гээд яриад байгаа энэ хөрөнгө оруулалт;

3 дахь нь бол Засгийн газрын нөөц хөрөнгө. Энэ зуншлага, ган, өвөлжилтийн байдалтай холбоотой ийм 3 хөрөнгө оруулалтын зардал гарцаагүй шаардлагаар нэмэгдэж байгаа. Бусад арга хэмжээ, төсөл бол одоо гэрээ нь байгуулагдаад, хэрэгжээд явж байгаа. Та бүхэн сайдаар ажиллаж байхдаа зураад зарлаад, хэрэгжсэн ажлууд явж байна гэсэн үг.

Х.Булгантуяа: Номин сайд нэмж тодруулъя.

Ч.Номин: Би дахиад тодруулчихъя. Би жоохон буруу ойлгуулаад байх шиг байна. Энэ 2025 оны төсвийг батлахдаа бид нар бүгдээрээ хамтдаа 110 шинэ төсөл, арга хэмжээгээ баталсан. Үүний санхүүжилтийнх нь хувь нь өнөөдрийн байдлаар ерөөсөө 4 хувийн санхүүжилттэй явж байгаа гэж байгаа. Тэгээд бид бүхэн өнгөрсөн онд бол төрийн худалдан авах ажиллагаа дээр бүх худалдан авалтаа төвлөрүүлсэн. Өнөөдөр бид нар энийгээ үргэлжлүүлээд явна гэж байна. Тэгэхээр энэ гүйцэтгэл амжиж энэ он дуусахаас өмнө гарч, нийт 1 их наяд төгрөгийнхөө санхүүжилтийг бүрэн хэрэгжүүлж чадах болов уу гэдэг асуулт байгаа юм. Би зүгээр ийм хоосон орон зайг хадгалаад аваад үлдэх гэж байна. Яагаад вэ гэхээр манай Сангийн сайд бас зовлонгоо ярилаа шүү дээ. Одоо бид нар 1.3 их наядын алдагдалтай төсөв баталж байна. 3.3 их наядаар цох орлого дутаж байна гээд. Тэгэхээр энэ 1.1 их наяд орчим төгрөгийг бид нар зарцуулж чадах болов уу гэдэг асуулт байгаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг 4 номерын микрофоноос хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Номин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал. Бид нар одоо яг төсвийн төсөл дээр тавьсан төслүүд бол гэрээ нь хийгдчихсэн. Ялангуяа энэ 2025 оны төсвийн онцлог бол өмнөх жилүүдийн төсвийн төсөлд тусгадаг байсан хөрөнгө оруулалтын тооны хувьд бол 50 хувь бага 623, 110 төслийн 42 нь л яг бүтээн байгуулалт, барилга байгууламжийн ангилалд, бусад нь бол тоног төхөөрөмж, их засвар, ТЭЗҮ байгаа. Тийм учраас бид нарын тооцооллоор хүлээгдэж байгаа гүйцэтгэл 85 хувьтай буюу одоо шинэ хөрөнгө оруулалтууд маань

эхний хагас жилд гэрээ нь хийгдчихсэн, сүүлийн сарууддаа гүйцэтгэл нь гарна буюу гүйцэтгэл гарч амжина гэж тооцоолж байгаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Номин гишүүний асуултад нэмж хариулъя. Одоо гүйцэтгэл 5 сарын сүүлээр 15 хувьтай явж байгаа юм. Тэгэхээр өдийд иймэрхүү л тоотой байдаг. Ер нь 20 хүрдэггүй. Ингээд сүүлийн хагаст гүйцэтгэл нэлээн түлхүү гардаг. Энэ жил нөгөө 6 сар гэхэд гэрээ нь хийгдэж амжаагүй төслүүд бүгд ингээд зогсчхож байгаа, хэмнэгдчихэж байгаа учраас гүйцэтгэл энэ жилийн хувьд бол нэлээн өндөр гарах байх. Ер нь олон жилийн дунджаар 85 хувьтай гардаг. Тэгэхээр энэ жил ер нь дор хаяж 85 хувь, 90 хувьтай гарна гэж ингэж хүлээж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Эрхэлсэн ажилдаа хариуцлагатай байх, хариуцлага гэдэг ойлголт ер нь зүгээр энэ танхимд үг болоод хувирчихжээ. Энэ тодотгол хийж байгаа шалтгааныг янз янзаар тайлбарлаж байна. Хууль дээр яах вэ, зайлшгүй шаардлага үүссэн тохиолдол. Мэдээжийн хэрэг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн солигдож байгаа тохиолдолд зайлшгүй шаардлага мөн. Гэхдээ энэ бол зөвхөн өнгөн хэсэг нь. Яг үнэндээ ингээд манай Засгийн газар, Ерөнхий сайд нар тайлбарлаад л байна. Хаа хамаагүй Трамп, тариф энэ тэр. Энэ тодотгож байгаа төсвийг анх хэлэлцэж байхад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд мэргэжлийн байгууллага нь хэтэрхий өөдрөг төсөөлөөд байна, ингэж болохгүй ээ, эдийн засгийн өсөлт чинь та нарынх шиг энэ 7.5 биш, 5.5-аараа байна. Ингэж баталж болохгүй гээд зөндөө сануулж хэлж байсан. Зүгээр ээ л гээд баталсан. Ингээд он гараад асуудал хүндрээд, одоо тодотгох уу гэсэн Сангийн сайд үгүй ээ, тийм хүндэрсэн асуудал байхгүй л гээд байсан. Одоо тодотгол орж ирж байгаа. Тодотгол орж ирээд шалтгааныг асуухаар Трамп тариф, хаа хамаагүй Трамп яриад.

Энэ дээр тодорхой хэдэн тоо ярья. Сая хэдхэн хоногийн өмнө Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн 2 газрын дүгнэлт хоёулаа бас зөрүүтэй. Одоо энд аудитаас хүн байна уу. Аудитын газраас энэ санхүүгийн тайлан дотор нийт 9 их наядын алдаа зөрчил байна гэж тайлан дээрээ байж байгаа. Тэгэнгүүт Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь болохоор 15 их наядын зөрчилтэй байна гэж. Энэ 2 байгууллага хоёулаа яг одоо хариулаад өгөөрэй. 1 нь яаж 9.5-ыг гаргасан юм. Нэг нь яаж 15-ыг гаргасан юм. Хоёулаа адилхан тайлан дээр гаргасан 2 дүгнэлт нь хүртэл зөрүүтэй. Гишүүд дээр ийм өөр 2 цаас ирж байгаа байхгүй юу. 2 өөр тоотой. Тэгээд алинд нь итгэх вэ.

Тэгээд Ерөнхий сайдаас асуух гэж байгаа юм. Энэ хариуцлага ер нь ярих юм уу, ярихгүй юм уу. Энэ чинь ерөөсөө тэр хаа хамаагүй Трамппай холбоотой биш, ерөөсөө л буруу тооцооллоос болж байна гэдгийг нь мэргэжлийн байгууллагууд нь хангалттай хэлээд байна шүү дээ. Буруу тооцоолол. Энийгээ хэлэхгүй нөхцөл байдал ийм байна гээд худлаа хэлээд байдаг. Энэ 2 байгууллага тодруулаад хэлэхээр тодруулга авъя.

Х.Булгантуяа: Занданшатар Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүнд хариулъя. Энэ тооцооллыг түрүүн Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам 2 тодорхой хэлсэн л

дээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нүүрсийг чинь 104 доллар, 85 доллар гээд 2 тоо хэлсэн гэж ойлгосон шүү дээ. Тэрийгээ түрүүн хэлсэн. Одоо өнөөдөр өөр болсон байна. Эдийн засгийн яам бас хэлсэн. Тухайн үеийн дундаж 104 доллар байсан гээд. Өнөөдөр 70 доллар болчихоод тооцоолол байна. Үүнийгээ Эдийн засаг, хөгжлийн яам, Тогтвортой байдлын зөвлөл яг хэд гэж хэлсэн юм бэ тоо баримтаар нь хэлчих хэрэгтэй байна.

Харин мөчлөг сөрсөн төсвийн бодлого явуулах нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж, энэ алдагдлыг бууруулж, ийм эрсдэл гарч болзошгүй гэж хориг тавьсан нь зөв байна гэдгийг өнөөдрийн тодотгол нотолж харуулж байна. Тэр үед алдагдалгүй төсөв батлахдаа ч гол биш, ийм нөхцөл байдал үүсэж болзошгүй эрсдэл улс төрийн нөхцөл байдалд байна гэж үзэж болгоомжтой байх, хянуур байх ийм зорилгоор гарсан.

Тэгээд Трампын тариф огт нөлөөлөөгүй гэж хэлэхгүй л дээ. Дэлхийн эдийн засаг бүгд харилцан холбогдчихсон, уялдчихсан. Тэр үед дунджаар 104 доллар байсан нүүрсний үнэ өнөөдөр уначхаад байна. 4.7 тэрбум тонны хэрэглээтэй Хятад улс эрчим хүчний нүүрсний, 580, 590 сая орчим тонн коксжих нүүрсний хэрэглээтэй. Дотооддоо 470 орчим сая тонныг Хятад улс өөрөө олборлодог. Энэ Хятадын олборлолт 6 хувиар нэмэгдсэн. Дотоодын нийлүүлэлт нэмэгдчихсэн. Тэгтэл гангийн үйлдвэрлэл болон нүүрсний эрэлт нь буурчихсан. 5 хувиар буурчихсан. Манай нүүрсний борлуулалт үнэ нь ямар болсон үнэ нь Цагаан хадан дээр зарагдчихсан өндөр үнэтэй нүүрснийх нь ханш уначихсан ийм нөхцөл байдал бол одоо бодит байдал бий болоод үүсчихсэн байгаа. Тэгээд энэ талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Сангийн яам, Эдийн засгийн яам тоо прогнозоо тайлбарлаж хэлэх нь зүйтэй байх. Яг уналт бол 5 сард сая нүүрсний үнэ 2 дахин унаснаас боллоо гэдгийг бас хэлсэн. Тэгэхдээ бас энэ тооцооллын алдаанууд, бас хэт өөдрөгөөр төсөвлөсөн, зардлаа хэт тэлсэн, нэг ёсондоо тансагласан ийм үр ашиггүй зардлууд, үрэлгэн байдал нэмэгдсэн нь бодит үнэн. Ийм учраас л өнөөдөр төсвийн тодотгол хийх зайлшгүй шаардлага үүссэн.

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн нэмж тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Нэмээд 1 зүйл асууя. Энэ 14400 төрийн албан хаагчийг бас энэ хэмнэлтийн үүднээс ажлаас цомхотгох тухай ярьж байгаа. Ерөнхий сайд аа, энэ төрийн албан хаагчдыг цомхотгохоор энд чинь нөгөө 36 сарын тэтгэмжийн асуудал яригдана. 14400 хүнийг ажилгүй болгоод, тэгээд тэтгэмж өгөхөөр эргээд энэ чинь 40 гаруй хүн мянган хүний 1 жилийн ажлын хөлс бас гарахгүй юу. Энэ хэмнэлт яг мөн үү. Ер нь энэ 36 сарын тэтгэмж дээр ер нь ямар бодлого цаашдаа баримтлах юм бэ. Ер нь анх энэ бодлогын зорилго нь юу вэ гэхээр Монгол төрд бас чадвартай, авьяастай, мэдлэгтэй хүмүүсээ тогтоон барья, ажиллуулъя, амьжиргаандаа санаа зовохгүйгээр төрдөө зүтгүүлье гэдэг ийм бодлого байсан. Тэгээд энэ маань ер нь юу болж байна вэ. Нэгд хэмнэлт мөн үү. Цаашдаа ер нь үүнийг яах вэ. Дахиад нэмж тодруулна.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя. Ерөнхий сайдын микрофон.

Г.Занданшатар: Тийм энэ 2 өөр асуудал байна. 14400 хүнийг цомхотгох гэдэг шийдвэрийг Улсын Их Хурал та бүхэн баталчихсан. Жилийн төлөвлөгөөнд. Жилийн төлөвлөгөөний дагуу төсөв боловсруулах ёстой. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиараа. Гэхдээ үүнийг яаж цомхотгох вэ, яаж хэрэгжүүлэх вэ гэдэг талаар

дэлгэрэнгүй түрүүн ярьсан учраас 28 үндэсний хороог цомхотгох, 9 санг татан буулгах гэх мэтчилэн дарга нарын тоог, давхардлыг, чирэгдлийг арилгах ийм цогц бодлого хэрэгжүүлж байна. Бас сул орон тоонуудыг цомхотгоно гээд тодорхой ярьсан. Тэгэхдээ энэ халагдсан хүмүүс чинь 36 сарын тэтгэмж өгөх юм биш байхгүй юу. 36 сарын тэтгэмж чинь тэтгэвэрт гарахад нь өгдөг тэтгэмж байгаа юм. Анх үүнийг багш, эмч нарыг тогтвортой ажиллуулах зорилгоор хөдөө, орон нутаг ч бай, хотод суурьшилтай ажиллуулах зорилгоор баталсан чинь энэ өргөжсөөр байгаад бүх төрийн албан хаагчдыг хамардаг болчихсон. Сүүлдээ бүр тогтвортой ажиллах .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж 1 минут өгье.

Г.Занданшатар: Зарчмаасаа яагаад өөрчлөгдчихөөд байна гэж үзэж байгаа вэ гэхээр хуулийн үзэл баримтлал өөрчлөгдөөд байна гэхээр Дээд шүүхийн шийдвэр энэ тэр ч гэсэн хүмүүс шүүхдээд, заргалдаад улс төрийн албан тушаалтнууд авъя ч гэж, сумын Засаг дарга нар ч авах ёстой. Насаараа бас төрд ажиллаж байгаа ингээд нөгөө барьцах сэтгэл зүй үүсчхэж байгаа юм. Дээр нь шударга ёсны зарчим ч үүсэж байгаа юм. 5 жил ирж ажиллачхаад 5-аар үржүүлсэн тэтгэмж аваад гарчхаж байгаа юм. Сарын цалингаа. Ингээд байгаа нь нөгөө төрд анх тогтвортой 10, 20 жил ажиллуулах гэсэн тэр бодлогоосоо илүү 36 сарын тэтгэмжээ тэтгэвэрт гарахдаа ахиу мөнгө авах гэсэн хандлага болчхож байгаа учраас үүнийг засаж, залруулъя гэж манай Сангийн яам бодсон юм билээ. Гэхдээ өнөөдөр бас бүлгээр хэлэлцээд, нийгмийн байдлыг дордуулахгүй гээд хэлэлцэж байгаа учраас яг үнэндээ доктор байх нь ч гол биш, ажлын үр дүнгээр нь санхүүжүүлдэг зарчмыг бид сонгочихсон. Тийм байх ёстой. Тийм зарчим нь ажлын үнэлгээгээрээ. Ажлаа сайн хийж байвал илүү цалин нэмэгдэл авах ёстой болохоос биш .../минут дуусав/

Х.Булгантуяа: Лодойсамбуу гишүүн нэмж тодруулахаар хариулт өгчих.

Ч.Лодойсамбуу: Нэмэх нь энэ төсөвт тодотгол дагаж орж ирсэн энэ “Алт 3” аянтай холбоотой Дамдинням сайд аа, таны мэдэгдлийг хараад бас урам орж байлаа л даа. Энэ тогтоолын төслийг би хараад ерөөсөө яг юу хийх гээд байгааг нь ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ тодорхой юм яг байна уу. Энэ протоколын алтыг хууль бусаар экспортлох энэ тэр гээд байдаг л гадаад валютын нөөцийг богино хэмжээнд нэмэгдүүлээд ингээд олборлолтоо нэмэгдүүлье гээд протоколын хэдэн үг оруулчихсан. Үүнийгээ тодорхой болгоод ороод ирж болдоггүй юм уу. Зоригтойгоор. Ер нь цаашдаа хэдүүлээ Засгийн газар 1 сонголтыг яг хиймээр байгаа юм. Энэ төр энэ цагаас хойш. Тэртээ тэргүй 80, 90 хувийн уул уурхайгаас хамааралтай эдийн засагтаа бид нар 1 бол уул уурхайгаа ашиглая, эсвэл ашиглахгүй гэдэг сонголтоо хиймээр байна. Ашиглахгүй бол энэ ашиглаж байгаа энэ том том төслүүдээ бүгдийг нь нүхийг нь бөглөмөөр байгаа юм. Ашигламаар байгаа юм бол зоригтойгоор ингээд шийдээд явмаар байгаа юм. Хаана хаана, ямар төслүүдийг яаж хэрэгжүүлэх гээд байгаа юм бэ. Тэрийгээ даалгаврыг нь их .../минут дуусав/

Х.Булгантуяа: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Лодойсамбуу гишүүн ээ, одоо яах вэ, Засгийн газрын түвшиндээ бид ярьж байгаад, хамгийн тодорхой байж болох хувилбараар нь л оруулж ирж байгаа юм. 6 дугаар зүйл дээр нь байгаа шүү дээ. Гадаад валютын

нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлж, үр өгөөжөө өгөх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах. Манай улсад тийм олон алтны үндсэн орд байдаггүй. Шууд ашиглаад явчих ордууд нь бүр цөөрөөд явчихна. Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоол бол ерөнхий утгаар гарах ийм л төлөвлөгөөгөөр бид нар оруулж ирсэн. Гэхдээ зүгээр Их Хурлын дарга өглөө хэлж байсан. Тэгээд бас бид нар ярилцаж байгаа. Улсын Их Хурал дээр энийг тодорхой болгоё гэдэг Их Хурлын гишүүд танаас авхуулаад байгаад их талархалтай байна. Та бүхэн маань нэг ажлын хэсэг байгуулаад, бид нартай суугаад, манай яамныхантай суугаад бүр тодорхой болгоод хийх эрх нь та бүхэнд бол бүрэн байгаа шүү. Манай яамны зүгээс Засгийн газрын зүгээс бол хамтарч ажиллая.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Лодойсамбуу гишүүний асуултад нэмж хариулъя. Тодотголын цаг хугацааны хувьд бол одоо оройтоогүй, бас эрт ч биш яг тодорхой цаг үедээ хийж байна гэж хэлж болно. Хагас жилийнхээ гүйцэтгэлийг харж байгаад үлдсэн хагас жилдээ хэрхэн яаж орлогоо хуваарилах вэ гэдгийг л бид нар тодотгож байгаа. Би хавар хэлж байсан. Хэрвээ хавар хууль зөрчөөд тодотгол хийсэн бол одоо дахиад тодотгол ярьж байх байсан. Тухайн үед бол 1 их наядаар л хийх байсан байх. 5 сард хийсэн бол 2.3 их наядаар хийх байсан байх. Одоо ингээд 3.3 их наядаар дахин дахин тодотгол гэж ярихгүйгээр ингээд нэг мөсөн засаад, янзлаад цаашаа явъя гэдэг ийм тодотгол гэж ойлгоорой. Энэ удаа хэмнэлтийн тодотгол. Өөрөөр хэлбэл сая 5 сарын 31-ээр гүйцэтгэл гарахад, төсвийн алдагдал 259 тэрбум төгрөг. Хагас жилээр 259 гэсэн үг. Өөрөөр хэлбэл бид нар орж ирж байгаа орлогодоо тааруулаад, зардлаа тохиргоо хийгээд явдаг ийм бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл он дуустал ч ингээд .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгээд он дуустал тэгээд тийм горимоор ч явж болох байсан. Гэхдээ энд удаа хэмнэлтийн тодотголоо хийгээд, мөн бусад өөр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгөндөө гар хүрэлгүйгээр алдагдалтай төсөв өргөн бариад, тодотгол явж байгаа шүү гэдгийг тодруулж хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Оройн мэнд. Сая яг Жавхлан сайдын хэлсэн дээр би зөрүүлээд дахиад асууя гэж бодож байна. Бид ковидоос хойш ер нь Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд байх үед ч тэр манай дайны нөхцөл байдал хүнд байна. Ингээд Америк-Хятадын худалдааны асуудал хүнд байна гээд энэ асуудлуудыг ерөөсөө эдийн засаг бас хүндрэх шинжтэй байна гэдэг асуудлыг ярьсаар л ирсэн. Тэгсэн хэдий ч өнөөдөр бид нар бол Сангийн яам дээр ч тэр ер нь бусад яг энэ төсвийн төлөвлөлтийг хийж байгаа баг хамт олон бол угаасаа чадавхтай гэж би боддог. Тэгээд төсвөө ерөөсөө орлогоо бодитой, яагаад ер нь ингэж тодорхойлоод гараад ирж чаддаггүй юм бэ гэдэг дээр бас үнэхээр эргэлзээд байгаа юм. Хэт өөрсдөө өөдрөг тавьчихаад, энэ олон эрсдэлүүдийг гадаад нөхцөл байдлыг ярьсаар ирсэн мөртөө өөдрөг орлого дээрээ зардлаа өндөр тавьчихдаг. Ингээд яг бодит байдал дээр хэрэгжээд ирэхээр төсвийн алдагдалд хүрч байгаа юм. Одоо энэ удаагийн нэгдсэн төсвийн үр дүнг харах юм бол 1.4 их наядын алдагдалтай. Улсын төсвийг харах юм бол 2.7 их наядын алдагдалтай төсөв шүү. Жил бүрийн төсвийн алдагдал

нь юу хүрдэг вэ гэхээр эцэстээ Засгийн газрын өрийг бид нар нэмэгдүүлээд дуусдаг. Одоо 2024 оны байдлаар Засгийн газрын өр бол 96.4 хувь гадаад өр эзэлж байгаа. Одоо ялангуяа Хятадын дайны нөхцөл байдал улам даамжирна. Хятад Улсын энэ эдийн засаг, тэр дундаа аж үйлдвэр, гангийн үйлдвэрлэл нь буурахаас эхлүүлээд нүүрсний эрэлт, үнэ ч гэсэн цаашид ийм бодитой эрсдэл гарахаар харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ удаагийн тодотгол бол илүү орлогоо дахин бууруулж, төлөвлөх шаардлагатай байгаад байгаа юм. Бид нар хэмнэлтийн төсөв гээд яриад байгаа боловч хэмнэгдсэн нь яг төсвийг нь харахаар хэмнэгдэх шаардлагатай төсвүүд нь хэмнэгдээгүй байгаад байгаа юм. Жишээлбэл, энэ зардлаа бууруулах дээр би бодитой тоо хэлье л дээ. 2025 оны улсын төсөвт зөвхөн тоног төхөөрөмж 2025 онд бол 817.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг тусгаж байгаа юм. Энэ нь өмнөх онтой харьцуулах юм бол 3.4 дахин өссөн үзүүлэлт. Их засварын зардал 290.7 тэрбум. Энэ нь өмнөх оноос харах юм бол 2 дахин нэмэгдсэн ийм төсөв байгаад байгаа юм. Одоо айл бол орлого нь буураад ирэх юм бол тансаг хэрэглээгээ хүн танадаг шүү дээ. Гэртээ засвар хийхгүй л байхгүй юу. Гэртээ шинэ тоног төхөөрөмж, хөргөгч шаардлагатай бол угаалгын машинаа ч гэсэн шинэчлэхгүй хүлээнэ биз дээ. Бүсээ чангалаад. Тэгээд энэ дээр ерөөсөө яг ийм бодитой яг зардлыг хэмнэчихсэн харагдахгүй байгаад байна. Тэгэхээр ... /минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Мэндбаярын Мандхай гишүүн ээ, энэ асуудлыг та 10 сард төсөв батлахдаа уг нь ярих ёстой асуудлууд байжээ. Энэ хөрөнгө оруулалтын зардлууд чинь гэрээ нь байгуулагдаад, 5 сарын 30 хүртэл зарцуулагдчихсан. Хэмнэх бололцоогүй зардлууд байхгүй юу. Өөрөөр хэлбэл одоо 5 сарын 30-аар хэрэгжээгүй саяын хөрөнгө оруулалтуудыг л хэмнэж байна шүү дээ. Саяын хэлж байгаа тоног төхөөрөмжүүд байна. Энэ чинь эмнэлгийн ч тоног төхөөрөмж байж болно. Багшийн ч тоног төхөөрөмж байж болно. Тэгээд энэ хөрөнгө оруулалтууд бол өнгөрсөн 10 сард батлагдаад 1 сараас хойш хэрэгжээд явж байгаа ийм хөрөнгө оруулалтууд учраас хэмнэх бололцоогүй болчихсон. Гэрээ нь байгуулагдчихсан, төр үүрэг хүлээгээд, зарим нь мөнгийг нь шилжүүлээд, ажил нь явчихсан гэсэн үг.

Харин хэмнэж болох зардлуудыг бол өнөөдөр дэс дараагаар нь бүх гадаад дотоод томилолтоос авхуулаад хурал зөвлөгөөний зардлыг хүртэл бүхий л зардлыг 1.8 их наяд төгрөгийн зардлыг хэмнэххээд байна. Тэр дотроо 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 210 тэрбум төгрөгийн Засгийн газрын ордон, байшин барих, тэр Номтын аманд байшин барих зардал гэх мэт хэмнэгдэж болох бүх зардлуудыг хэмнэсэн. Үүнээс цааш хэмнэвэл хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр тэтгэмж рүүгээ орох учраас энэ зайлшгүй зардлуудыг гаргаж төр санхүүжүүлэх ёстой гэсэн ийм зарчмаар энэ төсвийн тодотгол хийгдсэн. Энэ талаар Сангийн сайд дэлгэрүүлж хариулна.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр үргэлжилж байгаа, гэрээ нь хийгдчихсэн ийм төслүүдийг бид нар хасах, хэмнэх ямар ч боломж байхгүй. Энэ чинь цаана нь гэрээгээр ажлаа хийх гэж байгаа хувийн компани байж байна. Тэр нь аль хэдийн зээл авчихсан, ажлаа төлөвлөчихсөн. Энэ жил төсвөөс тэдэн төгрөг авна гээд ажлаа эхлүүлж байгаа ийм л ажлууд байгаа. Үргэлжилж байгаанууд нь бол 2, 3 жил гээд өмнө нь бүр хийгдчихсэн ийм ажлуудыг бид нар дундуур нь царцааж болохгүй. Царцаах тусмаа энэ эрсдэлд ордог. Удах тусмаа үнийнх нь төсөвт өртөг нь нэмэгддэг маш

эрсдэлтэй ийм зүйлүүд байдаг. Тийм учраас 2, 3 жилийн дотор бушуухан дуусгаад авах нь л чухал байдаг. Нэгэнт эхэлчихсэн ажлуудыг бол. Ялангуяа их засвар, урсгал засварууд өөрөө ийм стандарттай байдаг. Барилгууд дээр хэрвээ тэрийг нь хийхгүй бол дараагийн их засвар нь бүр их үнэтэй болдог. Иймэрхүү зарчмуудыг барьж ингэж явж байгаа гэсэн үг. Харин сая энэ төрийн хэмнэлтийн хуулиар бол маш сайн хэмнэгдлээ. 535 тэрбум төгрөг гэдэг бол бага мөнгө биш. Дээрээс нь бас хэмнэчихлээ гээд бас баярлаад байх зүйл биш. Үүний цаана салбар салбарын .../минут дуусав/

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Яах вэ, бид нар одоо болохоор ингээд алдагдалтай төсвөө дэмжээд яриад байна л даа. Ерөнхийлөгчийг хориг тавихад бол алдагдалгүй төсөв батал гээд шийдвэр гарахад алдагдалгүй төсвийг батлаад л бид нар явсан. Яг энэ хэцүү үед одоо байна шүү дээ бид нар яг үнэнээ хэлэхэд энэ намар гэхэд дахиад энэ нөхцөл байдал хүндрээд, бараг энэ төсвийн орлого сүүл гэхэд Сангийн яамны оруулж ирснээс илүү ихээр буурах эрсдэл өндөр байгаад байгаа. Бараг намар дахин тодотгол ч хийх эрсдэл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ төлөвлөгөөгөө дахиж нэг хараад, дахиад бас танах боломжтой. Би үргэлжлээд явж байгаа хөрөнгө оруулалтын төслүүдийг ерөөсөө яриагүй. Би шинээр зоож байгаа төсвүүдийг, ялангуяа яамны их засварын ажлууд. Үгүй ээ, энэ бол хүлээж болно шүү дээ. Зөвхөн их засвар гэхэд маш их хэмжээний тэрбум төгрөгийн цоо шинээр энэ төсөвт орж ирж байгаа юм.../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Төсвийн тодотголоор 1 төгрөгийн ч их засвар, урсгал засвар нэмэгдэж орж ирээгүй байгаа. Өмнөх гэрээнүүдийн ажлуудын энэ жилийн дүнгүүд явж байгаа гэдгийг тодруулж хэлье. Түрүүн та алдагдалтай гээд 2.7 их наяд, 1.0 хэд гээд хаанаас ямар тоо хараад хэлэв. Би тэрийг сайн ойлгосонгүй. Энэ жилийн төсөв бол алдагдалгүй батлагдсан байсан. Одоо тодотголоор бол 1.3 их наядын алдагдалтай ийм төсөв өргөн барьсан байгаа.

Х.Булгантуяа: Мандхай гишүүн нэмж 1 минут тодруулъя.

М.Мандхай: Сая гишүүд ч гэсэн хэлээд байна л даа. Маш их маргаантай, материалууд нь зөрүүтэй. Одоо ингээд гишүүдийн тарагдчихсан байгаа материалд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт дээр төсвийн алдагдалтай, төсвийн тэнцэл гээд улайм цайм 1.4 их наядын алдагдалтай. Улсынх нь төсөв нь 2.7 их наядын алдагдалтай. Энэ тэгээд яг ямар материал тарааж өгсөн юм бэ. Эсвэл танд байгаа материал бид нарт тарааж өгсөн материал нь өөр байгаад байгаа юм уу. Бүр харин гайхчихлаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэмж тодруулъя. Ажлын хэсгээс хариулах хүн байхгүй юу. Хэн хариулах юм. Гэхдээ Мандхай гишүүний хэлж байгаа бас үнэн шүү. Улсын Их Хурал дээр төсвийн зарлагыг нэмээд, өнөөдрийн нөхцөл байдалд бол хүргэсэн зүйл бол байхгүй шүү дээ. Төлөвлөлтөө зөв хийсэн юм уу л гэж асууж байх шиг байна. Ерөнхий сайд хариулъя гэж байна.

Г.Занданшатар: Би хариулъя даа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн материал, аудитын өгсөн материал зөрүүтэй байна гэж түрүүн гишүүн хэлсэн

Мандхай гишүүн ээ. Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдал, Аудитын газар, Сангийн яам Мандхай гишүүнд энэ тоогоо сайн тайлбарлаад өгчих за юу. Тэгэхгүй бол энэ нөгөө өнгөрсөн жилийн гүйцэтгэлийн тайлан чинь алдагдлын хэмжээ өөр байна шүү дээ. Түрүүн өнгөрсөн жилийн гүйцэтгэлийн тайланг яриад байсан. Өнгөрсөн жилийн гүйцэтгэлийн тайлан, одоогийн тайлан 3 материалын тоотой зөрүүг Сангийн яамныхан аудиттай, Тогтвортой байдлын зөвлөлтэй нийлээд одоо очоод тайлбарлаад, тоонуудын зөрүүг нь, цаасыг нь харж байгаад, тоог нь харж байгаад Санжаадорж, Ганбат дарга нар тайлбарлаад тооны зөрүү гаргачих. Түүнээс биш яг тараагдсан материал дээр тэгж зөрүүтэй байх ёсгүй. Тоонуудынхаа зөрүүг гаргаад өгчих.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Бүлэг дээр хэд хэдэн асуултынхаа хариултыг авчихсан учраас хариулт авч чадаагүй л асуултаа асууя. Сангийн сайд бараг гадарлаж байгаа байх. Яг төсвийн таналт руу орохоос өмнө бас нэг зүйлийг Ерөнхий сайдад бас дуулгахад эмэгтэйчүүдийг дэмжихэд яаж амжилт гаргаж байгааг та бүхэн бас бүгдээрээ харж байгаа байх. Магадгүй засаг дээрээ бас бид нарын тавьсан шаардлагыг хүлээж авсан бол магадгүй энэ таналт өөрөө маш мэдрэмжтэй орж ирсэн байхыг бас үгүйсгэхгүй гэдгийг бас та нэг бодчихоорой гээд гол асуудалдаа оръё.

Төсөв танасныг, төсвийн хэмнэлт тээ. Хэмнэлтийг ингээд хувьчлаад бодоод үзэхээр Сангийн сайдын багц 7.3 хувиар, Сангийн яамных 4.6 хувиар, Ерөнхийлөгчийнх 12 хувиар гэж явж байснаа хамгийн өндөр нь Шүүхийн ерөнхий зөвлөлийнх 20.6 хувиар. Тэгээд гол нь энэ хэмнэлт өөрөө шударга байгаасай гэж хүсэж байна. Бүх төрийн албан хаагчдад шударга мэдрэмжийг төрүүлээсэй. Бид нар бүгдээрээ эх орондоо хайртай. Тийм учраас зайлшгүй хэмнэх ёстой гэдгийг бол бүгд ойлгож байгаа. Маш сайн ойлгож байгаа. Гэхдээ яг нөгөө шударга биш байгаа учраас бас ийм асуулт зайлшгүй гарч ирээд байгаа гэсэн үг. Тэгээд яг ингээд шүүх эрх мэдлийн байгууллага чинь өөрөө Үндсэн хуулийн байгууллага. Үнэндээ өнөөдөр ингээд Сангийн яамнаас, Сангийн сайдаас шүүхийн төсвийг асуугаад сууж байдаг ийм улс орон ховор шүү дээ. Ардчилсан Үндсэн хуультай байгууламжтай газруудад. Тэгээд арайхийж Шүүхийн тухай хууль дээрээ шүүхийн төсвийн хууль зүйн баталгааг нь гаргаад өгсөн чинь одоо ерөөсөө тэр Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлдэггүй. Шүүхийн тухай хууль дээр Хууль зүйн байнгын хорооны баталсан төсвөөс доошоо буулгахгүй гэсэн одоо тэгээд ерөөсөө дандаа буулгана. Одоо бүр сүүлдээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаасаа бүр илүү өндөр 3, 4 дахин өндөр. Сангийн яамны өөрийнх нь хэмнэлтээс 5 дахин өндөр хэмнэлтийг шүүхээс хасаж байна. Үүнийгээ тайлбарлаж өгөөч ээ. Тэгээд бүр болохгүй бол тэгээд Үндсэн хуулийн цэцийн өмнө л бүгдээрээ очих болох гээд байна л даа.

Үүнтэй холбоотой 2 дугаарт, Монголбанкны төсвийг би ерөөсөө эндээс хайгаад олоогүй. Гэтэл Монголбанк ерөөсөө энэ төсвийн хэмнэлтэд ордоггүй юм гэнэ. Монголбанк ерөөсөө Их Хуралд энэ санхүүгийн тайлангаа тавьдаггүй юм байна. Зөвхөн Эдийн засгийн байнгын хороонд тавьдаг юм байна. Энэ одоо яадаг газар вэ. Энийг ерөөсөө анхаарахгүй бол болохгүй нь.

3 дугаарт хүүхдийн төсөв хасагдаагүй гэж ойлгож байгаа. Аубакир сайд энэ дээр яг тодорхой байр суурь илэрхийлээсэй. Нотлох баримт болгож үлдээмээр байна.

4 дүгээрт хувийн сургуулийг хэдий болтол манай улс дэмжих юм бэ. Одоо дахиад сургууль барих юм бол татвараас нь хөнгөлнө гээд. Сургууль бариад улсад өгвөл татвараас нь хөнгөлөхө. Өөрөө өөртөө сургууль барьж байгаа хувийн сургуулийн бизнесийг бид нар дэмжмээргүй байна. МАН социал демократ үзэл баримтлалтай нам. Боловсрол дээр .../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Ажлын хэсгээс хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг энэ удаагийн төсвийн тодотголд Сангийн яам, Засгийн газраас 20.6 хувийн ийм бууралтаар төсөвлөж оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ 20.6 хувийг бууруулахад хамгийн гол том нөлөөтэй зүйл нь бол 1 дүгээрт хөрөнгө оруулалтын зардал байна.

2 дугаарт, үйл ажиллагааны урсгал зардлаас эд хогшил, урсгал засварын зардал бол өндөр дүнтэй буюу нийт 22.8 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 20.2 тэрбум төгрөгийг бол хасахаар төлөвлөсөн. Энэ бол улсын төсвийн 37, орон нутгийн 22 ингээд нийт 59 төсвийн ерөнхийлөн захирагч дээр яг адилхан баримталсан зарчмын дагуу 7-12 сар дээр байгаа энэ төсвийг нь бол хэмнэлтэд тооцоод бууруулахаар ингэж төлөвлөсөн ийм зардал байна.

Дараагийн өндөр дүнтэй буурч байгаа зардал бол шүүхийн нөхөн олговрын зардлыг бол бид 2025 оны төсвийн тодотгол дээр мөн бууруулахаар төлөвлөсөн байгаа. Энэ бол энэ зардлын гүйцэтгэлтэй нь уялдуулаад ингэж бууруулахаар төлөвлөсөн ийм бууралтыг хийсэн байна. Ингэснээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв бол тодотгосны дараагаар 261.8 тэрбум төгрөг болж байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Боловсролын сайд Наранбаяр нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ саяын энэ хуулийн өөрчлөлт бол өмчийн хэлбэр үл харгалзан гэгчихсэн байгаа. Тэгэхээр зэрэг хувийн ч байна уу, улсын ч байна уу хоёулаа л орно гэсэн үг. Өнөөдөр хувийн сургуулиуд бол 71 мянган хүүхэд сургаж байна. Тэр хэмжээгээрээ төрийн ачааллаас үүрэлцэж байгаа. Хувийн сургуульд өгч байсан хувьсах зардал бол 10 саяас дээш бол өгөхгүй байгаа шүү дээ. Тийм интервалтай байгаа. Тэгээд энэ удаагийн төсвийн тодотголоор үнэхээрийн өнөөдрийн урсгал зардлаасаа их танаж хасаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ салбар болгон л ийм хэцүү байдал үүсэж байгаа. Тэгээд цаашдаа хувийн сургууль, цэцэрлэгт олгож байгаа хувьсах зардлыг нь зогсоох гэсэн Их Хурлын тогтоолын төсөл орчихсон явж байгаа. Энийг хариулъя. Түрүүн би хэлсэнчлэн хэрвээ энэ ингээд үргэлжлэхээр цэцэрлэг бол бүр хүндрэхээр байна гэдгийг хэлээд байгаа. Ер нь бол энэ чинь бас төрийн ачааллаас үүрэлцэж, өнөөдөр энэ ачааллыг хамт ингэж авч явж байгаа бас нэг ийм .../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт 1, 1 минутаар л нэмж хариулахаар байгаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир хариулъя.

Т.Аубакир: Хүүхэдтэй холбоотой зардлаас бол 1 ч төгрөг тодотголоор хасагдаагүй. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 32.1 дээр Засгийн газар хүүхэд хамгааллыг тогтвортой санхүүжилтээр хангах үүрэгтэй. Мөн төрийн хэмнэлтийн тухай хууль дээр ч гэсэн энэ хүүхэд хамгааллын санхүүжилт бол энэ хуульд хамаарахгүй зэрэг хуулиар хамгаалагдчихсан байдаг. Манай салбарын хувьд бол

мэдээж хэрэг урсгал зардлаас тодорхой хэмжээний хэмнэх бололцоотой зардлуудаас тодотголоор хасагдаж байгаа. Хэмнэж байгаа болохоор зардлууд. Мөн хүүхэд хамгааллыг хариуцсан бид нар саяхан бас орон тоог нь 833-аар баталж өгөөд, хүүхдийн нийгмийн ажилтан гээд шинэ орон тоо бий болгосон. Ялангуяа хөдөө орон нутгийн хүмүүс маань эдгээр нийгмийн ажилтнуудад бол маш ам сайтай байгаа. Гэрт нь явж орж ирээд л танай хүүхэд сургууль, цэцэрлэгт хамрагдсан уу, хүчирхийлэлд өртөж байна уу зэрэг хараа хяналттай болсон учраас бид нар энэ 833 орон тоог бий болгосноороо хүүхэд хамгаалал талдаа давуутай болж байгаа. Тийм учраас товчхон хариулахад хүүхдийн салбараас 1 ч төгрөг бол хасагдаагүй гэж хэлж байгаа.

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Миний гол хэлэх гээд байгаа санаа Сангийн яамныхан бас нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Бусад төрийн байгууллагатай яг адилхан зарчмаар шүүхийн төсвийг хасаж байгаа гэдэг ойлголт ерөөсөө байж болохгүй. Би хэлээд байна шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулийн тусдаа эрх мэдлийн байгууллага. Шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, Их Хурал хууль тогтоох гэсэн хэр нь ингээд Сангийн яамнаас төсөв гуйгаад, төсвийг нь царайчлаад байж байдаг ийм улс орон харин байхгүй байхгүй юу. Шүүхийн тухай хуулийг зөрчиж байгаагаа тайлбарлаач. Тэрийг юу гэж тайлбарлах вэ.

2 дугаарт, тэр төсөв 22 тэрбумаас 20 тэрбумыг нь хасаж байгаа гээд ирэх жил хуулиараа хүүхэд, гэр бүлийн шинэ шүүхтэй болох гэж байгаа. Монгол Улс анх удаагаа. Дэлхийн бусад улс орнууд хүүхэд, гэр бүлийн шүүхтэй болоод 60, 70 жил болж байгаа. Арайхийж Монгол Улс анх удаагаа энэ шүүхтэй болох гэж байгаа, түүнтэй холбоотой тоног төхөөрөмж бүх зардлууд нь хасагдчихсан. Цаад энэ утга учир, цаанаа ямар зориулалт байна гэдгийг нь ерөөсөө харахгүй. Тэгээд .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Төсөв ярих бүрд л энэ асуудал босож ирдэг юм. Одоо аль ч салбар өөрийн бие даасан хуультай байлаа гэсэн бид төсвийн хуулиа л барина. Энэ бол төсвийн байгууллага. Татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг ийм байгууллага. Тийм учраас бидний хувьд бол төсвөө төлөвлөхдөө, гүйцэтгэлээ гаргахдаа энэ суурь хуулиа, зарчмаа л барина. Тийм учраас яг ижил хэмнэлт, ижил тодотголын үеэр бас л санхүүгийн төсөв дээр гарч байгаа хүндрэлүүд нь адилхан л очдог. Тийм учраас энэ зарчмаа барина.

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Харин миний гол хэлээд байгаа юм энэ л дээ. Үндсэн хуулийн байгууламж гээд байна шүү дээ. Бусад төрийн байгууллагын бусад салбартай битгий адилтгаач гээд байгаа шүү дээ. Энийг ерөөсөө бүгдээрээ ер нь тэгэхдээ ойлголцохгүй байх шиг байна. Тэгэхээр энийг бас арай өөр түвшинд энэ асуудлыг Үндсэн хуулийн түвшний асуудлыг ярих ёстой болж таарч байх шиг байна.

Дээрээс нь энэ дагаж орж ирсэн тогтоол дээр семинар, хурал зөвлөгөөн, дотоод албан томилолт, бүх төрийн байгууллагын сургалтын зардлыг хэмнэлтэд оруулж байх шиг байна. Хуулийн салбар ерөөсөө томилолтгүйгээр, сургалтгүйгээр,

ерөөсөө төсөөлөгддөггүй салбар. Бүр хуулиараа сургалтад заавал хамрагдах үүрэгтэй байдаг салбар. Тэгээд ерөөсөө энэ хуулийн байгууллагын системийн өөр ялгаатай байдал гэдгийг ерөөсөө ойлгохгүй байна. Тийм учраас Үндсэн хуулиар зориуд эдийн засгийн баталгааг нь Үндсэн хуулиар хамгаалсан байдаг гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр Шүүхийн тухай хуулийн тэр холбогдох заалтыг зөрчиж байгаагаа бол таныг би тайлбарлаж хэлж чадахгүй байна гэж бодож байна. Тэгээд хэрвээ Хууль зүйн сайд байсан бол бас Хууль зүйн сайдыг үүнд анхаараасай гэж бодож бас зориуд энэ үгийг протоколд тэмдэглэж үлдье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Баасанжаргал гишүүн үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Ерөнхий сайдаасаа 2 гуйлтыг бүр маш товч бөгөөд тодорхой 2 зүйлийг гуйх гэсэн юм. Мөн хариулт авах гэсэн юм.

1 дүгээр зүйл болохоор энэ “Эрчис Монгол” гээд энэ компанийг эрчим хүчний салбараас хол байлгаж өгөөч ээ. Энийг үнэхээр гуйя. Өнгөрсөн Засгийн газар “Эрчис Монгол” гээд компанийг байгуулаад, эрчим хүчний компаниудыг төвлөрүүлж удирдах ийм маш буруу, хариуцлагагүй шийдвэрийг гаргасан. Өнөөдөр тэрний гор нь ингээд 50мвт-ын бүхэл бүтэн эх үүсвэр шатсан. Эрдэнэт хүний амь эрсэдсэн. Үүний хариуцлагыг хүлээх эзэн өнөөдөр олдохгүй байна. Гэтэл өнөөдөр дахиад л “Эрчис Монгол” дээр эрчим хүчний компаниудыг төвлөрүүлэх тухай асуудлыг яриад сууж байгааг харахаар үнэхээр бүр хэлэх ч үг олдохгүй ийм байдалтай байна. Төрийн өмчит энэ компаниудын үйл ажиллагааг сайжруулахыг зорьж байгааг бол үнэхээр ойлгож байгаа. Гэхдээ энэ авч байгаа арга барил чинь, авч байгаа арга хэмжээ чинь буруу байна гэдгийг би маш олон удаа хэлсэн. Буруу гэдгийг өнөөдөр энэ гараад байгаа маш аймшигтай осол баталж харуулаад байна шүү дээ. Үүнийг яагаад ойлгохгүй байгаа юм бэ. Үүний цаана ямар эрх ашиг байгаад байгаа юм бэ. Бидэнд нэг л зүйл маш ойлгомжтой байхгүй юу. Яавал энэ төрийн оролцоог багасгах вэ, яавал энэ төрийн өмчийн компаниудын бие даасан байдлыг дээшлүүлэх вэ. Яавал өөрөө өөрийнхөө үйл ажиллагааг өөрөө хариуцаад явдаг, өөрөө сайжруулаад явдаг, хийсэн үйлдэлдээ өөрөө хариуцлагаа үүрээд явдаг тийм боломжийг бүрдүүлэх вэ гэж бодохынхоо оронд дахиад л нэг төрийн өмчтэй 1 дарга, компанийг бий болгодог хэн ч бодсон ийм буруу шийдвэрийг гаргасан. Тэгээд буруу шийдвэр нь батлагдчихаад байхад дахиад өнөөдөр яриад сууж байгаа юм. Тэгээд мэргэжлийн хүмүүсийнхээ үгийг сонсооч ээ. Өнөөдөр бид нар Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг сүүлийн 8 сарын хугацаанд бүтэн цагаар ажиллаад, бүхэл бүтэн 8 улсын эрчим хүчний салбарын хууль, эрх зүйн орчныг нь, эрчим хүчний компаниудыг нь, уялдаа холбоог нь маш нарийвчлалтай судалсан. Тийм ч учраас бид нар энэ чинь буруу байна гээд мэргэжилтэн хүний хувьд хэлээд, яриад байгаа байхгүй юу. Яг л хаданд цуурайтаж байгаа юм шиг ерөөсөө сонсохгүй. Тэгээд энэ “Эрчис Монгол”-ыг байгуулах үндэслэлийг гаргасан хүмүүс Сингапурын ганц компанийг л яриад байгаа юм. Ямар ч үндэслэл байхгүй. Тэгэхээр бүр хичээнгүйлэн гуйя. “Эрчис Монгол”-ыг эрчим хүчний салбараас хол байлгаж өгөөч. Өөр юу хүсээд байгаа юм бэ. Бүхэл бүтэн 50мвт-ын эх үүсвэр байхгүй болчихлоо. Эгэл жирийн инженер хүн амь насаа алдчихлаа. Өөр юу хүсээд байгаа юм бэ гэж хэлэх гээд байгаа юм.

2 дугаар гуйх юм би 1 минутаа нэмээд авчихъя.

Х.Булгантуяа: Эхлээд хариулт авч байгаад минутын тодруулга авна шүү. Хэн хариулах вэ. Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Эхлээд Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүний түрүүний асуултад хариулчихъя. Ер нь бүгд Үндсэн хуулийн институцүүд шүү дээ. Шүүгч засаглал ч тэр, гүйцэтгэх засаглал ч тэр, хууль тогтоох засаглал ч гэсэн тэр. Тэгэхдээ шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангана гэсэн үгтэй. Энийг хэлэлцүүлгийн үед авч үзнэ биз.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүнд хэлэхэд энд бүх төрийн өмчийн компаниуд хугацаатай даалгавар өгч байгаа. Эрдэнэс Монголтой уулзсан, хугацаатай даалгавар өгсөн. Үр ашгийг сайжруулах. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт үүрэг өгсөн. “Эрчис Монгол” компанид үүрэг өгсөн. Та оролцсон. “Эрчис Монгол” компани бол зөвхөн эрчим хүчний компани биш. Жишээлбэл, МИАТ компанийн хувьчлал, IPO гаргах томоохон төслийг хэрэгжүүлбэл гэдгээ хэлсэн. Тэгэхээр энэ салбар дундын компанийн эрчим хүчний асуудлаар зөвхөн гаргаж ирэхгүй.

2 дугаарт нь, та бас тийм их ажил хийсэн, сайн байгаа. Тэр судалгаа тооцоо, баримт материалуудаа бидэнд өгөөд, хуулийн төсөл боловсруулсан дүгнэлт материалуудаа бид нар бас яриад байгаа. Тэгэхээр бид нар дандаа энэ нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж байхын тулд бодит төсөл баримтуудаа бид нарт өгч, эрчим хүчний асуудлаар бол тусдаа ажлын хэсэг байгуулж ажиллахад бэлэн байна гэдгийг танд хэлсэн. Сайдтайгаа, Эрчим хүчний сайдтай холбогдох компанийн удирдлагуудтай ажиллах чиглэл өгсөн. Эрчим хүчний салбарт бол нэн ялангуяа 3 дугаар цахилгаан станц дээр онцгой дэглэм тогтоож, салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд оруулаад, тусдаа бие даасан үйл ажиллагаа явуулж байгаа. Харин өнөөдөр чинь хэчнээн судалгаа хийгдээд хийгдээд ийм үр дүн гарчхаад байгаа нь, ийм аваар осол гарчхаад байгаа нь бас л энэ бодит байдал. Тийм учраас энэ зөвхөн нэг компаниас болсон уу, бас сахилга хариуцлага олон асуудлуудыг нотолгоонд суурилж хяналт шалгалтын ажил, хууль хяналтын байгууллагууд, ТЕГ, холбогдох газрууд хяналт шалгалтын ажил явуулж байгаа. Дүгнэлт нь гарахаар илүү тодорхой хариултууд өгөгдөнө. Ийм учраас энд зохих ажлууд явагдана.

Харин тэр МИАТ, Био комбинат гээд олон компаниудын асуудал энд байж байгаа. Тимосек гээд Сингапурын компанийн жишгээр байгуулсан юм байна лээ. Үүнийг бид баримт нотолгоо дээр үндэслээд, үүнийг татан буулгах уу, үгүй юу 7 хоногийн дотор үр ашгийг сайжруулах төсөл төлөвлөгөөгөө боловсруулж ирэх үүрэг даалгавар өгөгдсөн. Ингээд хугацаатай үүрэг даалгаврын дагуу энэ компаниудын ажлуудыг цэгцлээд явна.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Баярлалаа. 2 дугаар гуйлт болохоор ер нь эрчим хүчний салбарт үе үеийн улс төрчид маш их хүмүүсийг шахаж ажилд оруулсан. Тэгэхээр энэ хүмүүсийг эрчим хүчнээс зайлуулж өгөөч гэж гуйх гэсэн юм. Яагаад гэхээр эрчим хүчний салбар бол маш нарийн мэргэжлийн инженерүүд, инженер, техникийн ажилчид ажилладаг ийм онцлог салбар. Тэгэхээр сүүлийн жилүүдэд ялангуяа үе үеийн улс төрчид маш их мэргэжлийн бус хүмүүсийг шахсан. Тэр мэргэжлийн бус хүмүүс хаана ажилладаг вэ гэхээр нөгөө “Эрчис Монгол”-ыг байгуулах гол үндэслэл болоод байгаа нөгөө захиргаа удирдлагын хэлтэс, санхүүгийн хэлтэс, хуулийн

хэлтэс, гадаад харилцаа гээд өнөөдөр маш тодорхой яриад байсан. Тэгэхээр тэр дээр ажилладаг юм. Тэр бүтцийг чинь данхайлгаад байгаа юм. Тэгэхээр энэ эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх, орон тоог багасгах энэ асуудал дээр тэр улс төрчдийн үе үеийн улс төрчдийн шахаасыг эрчим хүчний салбараас .../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулт авчхаад, шаардлага хангахгүй байна гэж үзвэл нэмж 1 минут тодруулахаар байгаа юм. Бямбацогт сайд хариулах уу. Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга. Эрчим хүчний сайд байхгүй байгаад байна. Эрчим хүчний салбараас мэргэжлийн бус хүмүүсийг холдуулж өгөөч ээ. Одоо их нарийн мэргэжлийн салбар юм. Энд улс төрийн томилгоо хийгээд байна гэсэн асуулт, санал хэлж байна. Энхцэцэг гишүүн.

С.Бямбацогт: Ер нь эрчим хүчний салбар хэтэрхий хаагдмал, хэтэрхий юу гэдэг юм дотроо цус ойртчихсон гэдэг юм уу тэгээд Ардын нам ч байна уу, Ардчилсан нам ч байна уу, хөгшин ч байна уу, залуу ч байна уу ерөөсөө л бие биеэ хамгаалдаг. Хэн нэгэнд буруу өгдөггүй ийм болсон юм байна лээ. Тэгээд либералчлал хийе гэхээр үнээ нэмдэг, үнээ өсгөдөг, үнэ өсгөхөөс өөр аргагүй гэж хэлдэг. Гэтэл дотоодод нь зардлыг нь бууруулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх, хүнд суртлын алга болгох олон ажлууд байгаа. Тэр ажлуудыг өөрсдөө хийхгүй байгаа учраас, хийхийг хүсэхгүй байгаа учраас энд “Эрчис Монгол” компани байгуулж, энэ дээр тодорхой төлөвлөлт менежмент бодлого, үйл ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, энэ чиглэлд нь “Эрчис Монгол” компаниар бас ингээд хөндлөнгөөс зөвлөх үйлчилгээ үзүүлэх байдлаар бодлогыг нь авчихъя гэж энэ компани байгуулсан юм байна лээ. Тийм болохоор энэ асуудал дээр бас Энхцэцэг гишүүн, Цэнгүүн гишүүн бид нар бас Ерөнхий сайдаар уулзсан. Цаашдаа тодорхой бодлого гаргаж, илүү үр өгөөжтэй .../минут дуусав/

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүн нэмж 1 минут тодруулъя.

М.Энхцэцэг: Тэгээд ямар ч байсан эрчим хүчний салбарт бол маш тодорхой байгаа. Улс төрчдийн үе үеийн шахаа өнөөдөр энэ эрчим хүчний компаниудыг данхайлгасан. Тэгээд тэр данхайлгасан юмаа засахын тулд “Эрчис Монгол”-ыг ингээд төрийн өмчтэй дахиад 1 компанийг байгуулах гол үндэслэлээ болгоод явдаг чинь буруу. Тухайлбал эрчим хүчний нэг компанид жишээ нь хэдхэн жилийн өмнө Захиргаа удирдлагын хэлтэс нь 7, 8 хүнтэй байсан, 20 гаруй хүнтэй болсон. Тэгээд нөгөө 20 гаруй хүнээ нуухын тулд Захиргаа удирдлагын хэлтэс, Санхүүгийн хэлтэс гээд бүр 2 салгаад явж байна гэж байна шүү дээ. Тэгэхээр үүнийг сүүлийн 5 жилийн хугацаанд яаж мэргэжлийн бус хүмүүс хаана хаана байрласан юм бэ гэдгийг бүр маш тодорхой судалгааг нь гаргачихсан угаасаа байж байгаа. Тэгэхээр энийг үндэслээд, одоо тэгээд нөгөө орон тоог багасга гэсэн чинь нөгөө дандаа улс төрчийн шахаачид нь халагдахгүй, нөгөө хэдэн инженерүүдээ, монтеруудаа хална, цомхотгоно гээд сууж байна гэж байна шүү дээ. Энэ бол үнэхээр байж болохгүй асуудал. Өнөөдөр энэ салбарт мэргэжлийн ажилтан олдохоо больсон. Цалин багатай. Ажлаасаа гарч байна. Гадагшаа явж байна. Тэгэхээр энэ дээр .../минут дуусав/

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Яг таны ярьж байгаа асуудал байж болзошгүй гэж үзсэн учраас таныг өөрөө оролцооч ээ гэж байгаа юм. Та өөрөө оролцоод, яг мэргэжлийн

чадвартай хүмүүсийг нь үлдээгээд, тэр мэргэжлийн бус, улс төрчдийн шахааг нь цэвэрлээд өгөөч ээ. Энд хамтраад оролцооч ээ л гэж хэлж байгаа юм. Яг та хэлж байгаа, таны тэр өрсөлдөөн байх ёстой гэдэг дээр санал 1 байгаа. Өрсөлдөөн дээрээс нийлүүлэлт нэмэгдэж, үйл үйл ажиллагаа, үйлчилгээний чанар сайжирдаг, үнэ хямдардаг. Тийм болохоор эрчим хүчний салбарт бид өрсөлдөөнийг бий болгоё гэж байгаа таны тэр санал, санаачилгыг дэмжье. Өрсөлдөөнийг бий болгоё. Ингэхийн тулд нийлүүлэлтийг нэмэгдүүлье. Эндээс үнэ хямдарна. Эцэст нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай аюулгүй ажиллагаа хангагдана. Энэ рүү та бас өөрийнхөө мэргэжлийн мэдлэг чадвар, туршлагаараа оролцоод өгөөч ээ. Зүгээр эндээс шүүмжлээд суух биш, дотор нь ороод ажиллаад өгөөч ээ. Тэр “Эрчис монгол”-той, Эрчим хүчний яамтай, эрчим хүчний компаниуддаа өөрийн мэдлэг чадвараа бас зориулаад хамтраад өгөөч ээ гэ би бас Цэнгүүн гишүүн болон та гээд бусад гишүүдийг бас урьж байгаа. Тэгээд бүгдээрээ хамтраад ажиллацгаая.

Х.Булгантуяа: Дэгээрээ 2 л удаа тодруулга авахаар байгаа юм. Тэгээд 2 удаа тодруулгаа авчихсан. Лутаагийн Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Та бүхэнд оройн мэндийг хүргэе. Өнөөдөр хэмнэлтийн тодотголыг ярьж байна. Ерөнхийдөө зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Өмнө ч би бас ярьж байсан Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 535 тэрбум төгрөгийн 130 төсөл, арга хэмжээнүүд бол хэмнэлтэд тооцсон байна. Харамсалтай. Сайд маань ч гэсэн бас их харамсалтай гэж хэлж байгаа. Үүнд бас Эрүүл мэндийн сайдын багцаас 60 тэрбум гээд энэ жил зөвхөн 3 тэрбумаар тоног төхөөрөмж авах юм байна л даа. Мөн бусад нийгмийн салбараас ер нь энэ багцаас хэчнээн хасагдсан бэ. Ялангуяа энэ боловсрол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны багцаас хэчнээн хэрэгжээгүй төслүүд хасагдсан бэ. Ер нь энэ Төрийн хэмнэлтийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй. Ялангуяа төсвөө хасахдаа энэ ач холбогдлоор нь тэгээд эрэмбэлж хасахгүй бол нийгмийнхээ салбарын төсвүүдээ, арга хэмжээнүүдээ хасаад байж болохгүй байна. Цаана нь иргэдийн бас тусламж үйлчилгээ, чанар бас алдагдах нь.

Шинээр энэ орж байгаа төлөвлөгөө, төсөл, арга хэмжээ дотор бас нэг асуух юм. Энэ аудитын дүгнэлт дээр ийм заалт орсон байна. Дүгнэлт орсон байна. Ялангуяа шинээр нэмэгдэж байгаа НҮБ-ын Коп бага хурлыг зохион байгуулах хөрөнгө оруулалт 41.8 тэрбум төгрөг. Тэгээд энэ дотроо хөрөнгө оруулалт нэрээр нэмж туссан боловч магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь дахиад буцаад хасагдах магадлалтай байх юм уу. Яагаад одоо хүртэл зураг төсөв нь байхгүй байгаа юм бэ. Энэ чинь өмнө бас 50 тэрбум орчхоод хасагдаад, хэмнэгдээд буцаад орж ирж байгаа.

3 дугаарт энэ дулааны 3 дугаар цахилгаан станцтай холбоотой их засвар, тоног төхөөрөмж гээд 35.5 тэрбум төгрөг оржээ. Энэ осол, гэмтэлтэй холбоотой дүгнэлтүүд нь гарсан уу. Тэр дүгнэлтийг харж, ирэх өвлийг бол саадгүй давна гэж бодоод энэ төлөвлөгөөний дагуу энэ төсвүүдийг тусгасан уу. Ер нь мэргэжлийн байгууллагуудын техникийн үзүүлэлт, хяналт, төлөвлөгөөг харж үзсэн үү гэсэн ийм 3 асуулт байна. .

Х.Булгантуяа: Эхлээд Эрүүл мэндийн сайд Чинбүрэн хариулъя.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалттай холбоотой 69 тэрбум төгрөг хасагдсан. Бүгд л 1 зарчим, хууль үйлчилж байгаа. Хэмнэлтийн тухай

хууль. 5 сарын 31-ний дотор багтаж, худалдан авах үйл ажиллагаа явуулаад, гэрээ хийсэн байх ёстой гэдэг. Нийтдээ энэ маань бас бүр ч тас хоосон биш л юм л даа. Хөрөнгө оруулалт нийтдээ 193 тэрбум төгрөгийн төсөв тавиад, тодотголоор 69.8-ыг хасаад 123 тэрбум буюу 6 сар сарын 1-ээс өмнө 123 тэрбум төгрөгийн худалдан авалт бас хийчихсэн байгаа.

Тэгэхээр энэ шигээ л гүйцээгээд л хийчихсэн байсан бол маргаангүй л болчих байлаа л даа. Тэгээд бусад салбарыг хэдэн хувь яаж гарсан гэж би нарийвчилж харсангүй. Бас үнэхээр ажил их. Энэ олон тоо, дээрээс нь улаан бурхан гээд бусад салбарын хэчнээн хасагдсан энэ тэр гээд харьцуулж харсангүй. Э

Х.Булгантуяа: Эхлээд Жавхлан сайд хариулчихъя. Тэгээд Наранбаяр сайд

Б.Жавхлан: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ, одоо юу гэдэг юм салбар, салбараар нь ямар нэг сонголт хийгээд ч юм уу, эсвэл үзэмжээрээ ч юм уу, хасагдаж байгаа, хэмлэгдэж байгаа зүйл ерөөсөө огт биш шүү. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 05 сарын 31-нд гэрээ хийгдээгүй бүх төсөл хөтөлбөрүүд хэмнэлтэд орж байгаа юм. Үүнийг би салбар салбараар нь хэлье. Эрүүл мэндийн сайдын багцаас 69.9, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцаас 57, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцаас 36, Боловсролын сайдаас 33 тэрбум, Зам, тээврийн сайдаас мөн 33, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас 19.7, Монгол Улсын Тэргүүн Шадар сайдаас 17.4, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас 12.4, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нараас нийлээд 255.4 тэрбум төгрөг. Мөн энд бас нөгөө нууцтай холбоотой зардлууд байгаа учраас ил хэлж болохгүй байна. Ингээд нийтдээ 5 .../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулах уу.

П.Наранбаяр: Ер нь бол хөрөнгө оруулалтын багцаас нь хэмнэгдсэн гэдэг юм уу, хэмнэлтийн хуулиараа хэмнэгдсэн нь бол 33 тэрбум төгрөг хасагдсан. Үүнээс бол 18.4 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмж. Үлдсэн нь бол царцсан барилгууд байгаа. Зүгээр яах вэ, нэг зүйл хэлэхэд 05 сарын 31 бол хагас сайн өдөр байсан. 6 сарын 2 нь 1 дэх өдөр. Тэгээд Төрийн худалдан авах газар дээр бүх тендерүүд зарлагдаад, тэндээсээ зарим нэгэн компаниуд нь бас гомдол гаргасантай холбоотойгоор 6 сарын 2-ны өдөр бол болж харамсалтай нь хэмнэлтэд орчихсон ийм сандал, ширээ, сургуулийн самбар эд нар гэсэн ийм төслүүд бас байна. Тэгэхээр энэ бол туйлын харамсалтай хэрэг юм. Би яг Чинбүрэн сайд шиг л харамсаж байна. Ийм нөхцөл байдал үүссэн.

Х.Булгантуяа: Энхнасан гишүүн нэмж тодруулах байсан уу. Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас хэмнэлтийн хуульд хасагдсан төсөв байгаа юм уу. Зардал, багц.

Х.Булгантуяа: Сайд нь байхгүй байна. 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр тоног төхөөрөмжийн зардлаас 3.5 тэрбумаар буурсан байгаа. Энэ нь гэрээ байгуулаагүй дүнгээр бууруулсан.

Х.Булгантуяа: Би эндээсээ л асуулт асуучихъя даа. Би хэдэн зүйл асуух гэсэн юм.

1 дүгээрт манай хүүхэд хамгааллын зардлаас, хүүхдийн зардлаас бас хасагдаагүйд их баяртай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байхдаа манай Ундрам гишүүн, Одонтуяа гишүүн бид бас хамтраад энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийг манай Идэрбат гишүүн ажлын хэсгийг ахлаад батлуулж байсан. Түүний үр дүнд түрүүн Аубакир сайд бас хэлж байна. 833 хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан сум болгон, хороо болгонд ажилладаг болсон. Хүүхэд хамгаалал хөгжлийн зардал 8 тэрбумаас 21 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн гээд. Ингээд ямар ч хэмнэлт болсон үүнтэй битгий ноцолдоорой. Энэ бол тийм их мөнгө биш. Тэр арьс ширний урамшуулал жилдээ 23, 24 тэрбум төгрөг байлаа. Малын асуудал хариуцсан хүн сум болгон 5 хүн байгаа. Тэгэхээр үүнтэй битгий та бүхэн маань хэмнэлт гаргах гэж оролдоорой гэж 1 дүгээрт хүсэх гэсэн юм.

2 дугаарт, тусгайлан би ганц 2 төсөл хөтөлбөрүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас асуух гэсэн юм. Энэ дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр гээд Улаанбаатар Хан-Уул дүүргийн 2013 онд эхэлсэн 2026 онд дуусна гэж байна. Энэ 15 тэрбум төгрөгийн анхны төсөвт өртөгтэй байсан. Одоо 75 тэрбум төгрөг болсон гэж байна. Үндэсний аудитын газар, хэн хариулах ёстой юм. Яахаараа ингээд зарим барилга байгууламжийн төсөв нь 5 дахин нэмэгдээд явдаг юм бэ. Цаг хугацаа нь энэ дээр бас нэлээн гарсан юм шиг байна. 1 дүгээрт.

2 дугаарт, энэ татварын хэлтсийн барилга гээд Улаанбаатар хотод гээд 2020 оноос 2025 онд хэрэгжиж дуусахаар шууд 15.9 тэрбум төгрөг гээд тавьчихсан. Яах вэ төдийгөөс өдий болтол энэ төсөл хөтөлбөр яваагүй юм шиг байна. Тэгээд энэ жил ерөөсөө эхлээгүй юмаа энэ жил шууд дуусгана гэж үзэж байгаа юм шиг байна. Үлдсэн хагас жилийнх нь хугацаанд. Ер нь ингээд хэмнэсэн зардлуудыг харахад үнэндээ өмнөх 2025 оныхоо төсвийг батлуулахад ялангуяа түрүүн Мандхай гишүүн бас хэлж байсан урьд хожоод байгаагүй их тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн шүү гээд. Тэр дүнгээ тэр чигээр нь ерөөсөө 2025 онд бүх худалдан авалтыг тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ гээд тавьчихсан байсан. Ингээд худалдан авалтуудаа 1 дүгээрт хийж амжихаа байсан юм шиг байгаа юм. Тэгээд санхүүжих дүнг нь арай багаар тавиад 20 тэрбумын худалдан авалт хийнэ гэсэн байсан бол 10 тэрбумыг энэ жил тавиад, үлдсэн нь тэгэхээр ирэх оны төсөв дээр тавигдана л гэсэн үг. Энэ бол их олон төсөл хөтөлбөрүүдийг хасахаасаа илүүтэйгээр санхүүжих дүнг нь хойш нь 2026 он руу тавьсан асуудал. Энэ бол 2026 оны төсөв дээр ачаалал болж орж ирнэ л гэсэн үг. Тэгээд энэ бүгд дээр та бүхэн маань бас анхаараарай.

Ерөнхий сайд бас ирэх жил боловсролын жил болгоно гэдэг маань 1 дүгээрт бас хэвээрээ байгаа юу. Тэгвэл түүнийг урьдаж та бүхэн маань энэ оны төсөв дээр үүнийхээ бэлтгэлийг хангах ер нь ямар гол ажлуудыг бас хийж байгаа юм бэ гэдгийг Наранбаяр сайдаас бас асуух гэсэн юм.

Би бол энэ төсвөөс 500 орчим тэрбум төгрөг хэмнэгдлээ. Энэ бол хайран. Эдийн засагт орох байсан мөнгө гэдэгтэй бол санал бол нэгдэхгүй байгаа юм.

Эсрэгээрээ. Улсын төсөв ерөөсөө эдийн засгийг гол тэжээдэг эх үүсвэр байх юм бол бид нар алдаатай ажиллаж байна гэсэн үг. Хэрвээ 500 тэрбум төгрөгөөр бизнесийн зээл банкнаас 23, 24 хувьтай гарч байх шиг байна. Хэрвээ 13 хувийг нь төрөөс даана гэх юм бол 3.8 их наяд орчим төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг бид нар гаргах боломж бололцоо бий болох байсан. Магадгүй энэ бол бизнесийн салбарт эсрэгээрээ эдийн засгийг нөгөө хувийн хэвшлээр илүү их сайн түрж дэмжих бодлого бол яг эсрэгээрээ яг ингэж явах ёстой байсан юм биш үү гэдэг ийм хэдэн саналыг хэлэх гэсэн юм. Тэгэхээр тэр төсөл хөтөлбөртэй холбоотой асуултуудыг хэн хариулах вэ.

4 номер ажлын хэсгийн микрофон.

Ж.Дэлгэржаргал: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ж.Дэлгэржаргал. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дүүргүүдийн нэгдсэн цогцолборын хувьд бол 2013 онд анх 15 тэрбумаар төсөвт тусгагдаж байсан. Тухайн үедээ бол 4 тэрбумын санхүүжилт аваад, энэ төсөл 3, 4 жил царцсан. 2023 оны төсөв батлагдахад Улсын Их Хурлын тогтоолоор өртөг нэмэгдсэн барилгууд дээр үндэсний аудитын газрын дүгнэлт гаргуулж, шийдвэрлэх ийм Их Хурлын тогтоол батлагдсан. Үүний дагуу Үндэсний аудитын газраас дахиж хийсэн магадлалыг дахин хянаад, 2024 оны төсөв батлагдахад 75 тэрбумаар тусгагдсан. 2025 оны төсөв, 2025 оны тодотгол дээр ямар нэгэн өртөг дээр өөрчлөлт ороогүй.

Татварын барилгын хувьд бол 2020 онд анх 3 аймаг, Улаанбаатар хотын 2 дүүрэгт татварын барилгууд барихаар тусгагдсан. Ингээд ашиглалтад орсон төслүүдийг бид нар байршлуудын хувьд хасаад, одоо ганцхан Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хувьд мөн 2024 оны төсөв батлагдахад аудитын дүгнэлт болон магадлалын ерөнхий дүгнэлтээр өртөг нь нэмэгдсэн санхүүжилтийн үлдэгдэл 1 тэрбум нь энэ онд өгөгдөөд дуусна.

Хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд хуулийн хавсралт, өртгийн хувьд бид нар өнгөрсөн оноос илүү нөгөө төсөвт өртгийн өөрчлөлтийг харуулахаар 3 багана тавьдаг болсон байгаа. Анхны гэдэг бол тэр төсөл анх хууль дээр батлагдаж эхлэхэд хэдэн өртөгтэй байсан. Сүүлийн гэдэг нь 2025 оны төсөв батлагдахад хэд байсан. 2025 оны гэдэг багана бол тодотголоор хэд болж байгаа. Тэгэхээр сүүлийн болон 2025 оныг харьцуулахад бүгд буурсан буюу тендерийн хэмнэлтийг бид нар хассан. Нэмэгдсэн төсөвт өртгийн нэмэгдэл 1 ч төсөл дээр байхгүй байгаа.

Х.Булгантуяа: Бас нэг асуултыг тодруулъя. Бусдаар гүйцэтгүүлэх ажил гэж сая 2025 оны төсөв батлагдахад хамгийн их гишүүдийн ярьсан асуудал. Энэ бол 1.9 орчим их наяд төгрөг. Бид нар сая бараг 2 их наяд төгрөг 2025 оны төсөв дээр баталсан. Эндээс бол ерөөсөө хэмнэх юм байхгүй гээд байсан. Одоо бол 534 орчим тэрбум төгрөгөөр хэмнэж байгаа юм байна. Тэгээд уг нь эхнээс нь ороод ирчихсэн байсан бол энэ олон төсөл хөтөлбөрүүд нэгэнт тендер нь зарлагдаад, гэрээ нь байгуулагдсан учраас хувийн хэвшлийг бид нар хохироож болохгүй. Тэгээд одоо ингээд бас хэмнэлт гаргаад явж байгаа юм байна. Одоо ийм хэдэн санал нуудыг л хэлье дээ. Боловсролын сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр боловсролыг дэмжих жил бол хэвээрээ байгаа. Энэ бол ирэх жилээс хэрэгжих ёстой. Монгол Улсын Ерөнхий сайд бас ирэх жилд 1 мега төсөл нь бол хүний хөгжлийн төсөл байх болно гэж байр сууриа илэрхийлж байгаа. Ер нь бол Засгийн газарт бид тогтоол оруулахаар бэлдэж байна.

Энэ боловсролыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөө, ерөнхий хүрээг тогтоох зорилготой ажлын хэсгийг бол Улсын Их Хурлын гишүүдийг оролцуулаад, Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан. Дотроо дэд 2 ажлын хэсэгтэй. 1 нь боловсролын хүртээмж, 1 нь боловсролын чанарын асуудлыг ингэж үзсэн. Үүний ерөнхий дүгнэлт нь бол бэлэн болоод, Засгийн газарт танилцуулахад бэлэн болж байгаа. Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бол нийтдээ 45 сургууль, 45 цэцэрлэг, 17 дотуур байр, багшийн хөгжлийн 3 тулгуурт бодлогыг бол тусгачихсан байгаа. Ер нь бол цаашдаа бид бас төсвийнхөө хязгаарыг 565 тэрбум төгрөг гэж .../минут дуусав/

Х.Булгантуяа: Би нэмж тодруулъя. Тэгэхээр та хариулчхаарай. Тэгэхээр Боловсролын сайд саяынхаа асуудлыг та нэмээд тайлбарлачхаарай. 2026 төсвийн хүрээг саяхан бид нар бас баталсан. Одоо дагаад төсвийн хүрээ дээр өөрчлөлт орж байгаа учраас зарим 1 өөрчлөлтийг оруулаад батална. Тэгээд 2026 оны төсөв дээр та бүгдээс хүсэхэд сая манай Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гол бас хэлсэн санаа нь зарим аймгууд үнэхээр муу төсвийн хөрөнгө оруулалттай байна шүү. Сүүлийн 15 жил тасралтгүй муу хөрөнгө оруулалттай. Тэгээд эдгээр аймгууд ядуурал ч ихтэй, ажилгүйдэл ч ихтэй. Хүн ам нь үргэлж аймаг орон нутгаасаа дайжсан. Баруун аймгаас гэхэд Говь-Алтай аймаг хамгийн муу хөрөнгө оруулалттай. Хамгийн өндөр ядууралтай. Хангайн бүсээс, төвийн бүсээс Булган аймаг хамгийн бага хөрөнгө оруулалттай. Хамгийн их ядууралтай. Говийн бүсээс Говьсүмбэр аймаг хамгийн бага хөрөнгө оруулалттай, хамгийн их ядууралтай. Зүүн аймгаас Дорнод аймаг хамгийн бага хөрөнгө оруулалттай, хамгийн их ядуурлын түвшинтэй. Тэгэхээр энэ харилцан уялдаатай байгаа дээр та бүхэн маань анхаараад энэ хөрөнгө оруулалтуудыг төрийн нийтлэг үйлчилгээг, тэгээд дээрээс нь нэмээд аймаг орон нутгийн хөгжлийг дэмжих дээр ажиллаарай. Энэ хөрөнгө оруулалтыг татах бол ганцхан Улсын Их Хурлын гишүүдийн бас хөөцөлдлөгөөгөөр хийгддэг ажил ерөөсөө байх ёсгүй. Эдийн засаг, хөгжлийн яам ингэх гэж уг нь байгуулагдсан гэдэг ийм хэдэн саналыг хэлэх гэсэн юм.

Энэ хурал даргалж байгаа хүн чинь их хэцүү юм байна шүү. Наранбаяр сайд нэмээд хариулчихъя.

П.Наранбаяр: Тэгэхээр бид төсвийн хязгаараа тэгээд батлуулсан байгаа. Тэгэхээр энэ дээр нэмэх нь 2030 он гэхэд даруй 88 мянгаар нэмэгдэх нь хүүхдийн ачааллыг ерөнхий боловсрол дээрээ, үүнийг шингээхийн тулд бидэнд бас шинэ хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ нь нийтдээ бол 729 тэрбум төгрөг эхний ээлжид шаардлагатай гэж бид үзсэн. Тэгэхээр бид бол энийгээ биелүүлэхийн тулд бас энэ төсөв дээрээ нэмэх нь гаднын зээл, тусламжийг, ялангуяа Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг энэ донор байгууллагууд, олон улсын санхүүгийн инструментээс бид бас хөрөнгө оруулалт татах боломжийг судалж байгаа. Энэ хүрээндээ 100-аад сая долларыг нэмж, хэрвээ зээлжих эрхийг өгөх юм бол боломжтой гэсэн ийм зүйл яригдаж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая. Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байгаа. Орлогоо ойролцоогоор 3.3, зарлагаа 1.9, алдагдлаа 1.4 орчим их наяд байхаар тооцож оруулж ирж байгаа юм байна лээ. Амаргүй, эгзэгтэй ийм цаг үед ийм зохицуулалтыг эртхэн хараад хийчихсэн нь дээр. Эрсдэлийг хохирол багатай давахад хэрэгтэй юм гэж. Үгүй ээ, байдал хүнд байгаа. Ойлгоод байна. Тэгвэл энэ

тооцож байгаа орлогоо ямарваа нэгэн сааталгүй гэдэг юм уу, дахиад буурчихгүй байхаар оруулах талаар тэр татвар төлөгч нараа яаж дэмжиж, яаж цаг хугацаанд нь татварыг нь төлүүлж гэж бодож байна вэ. Цуглуулна гэж бодохоосоо өмнө тэр хүмүүсийг юм хийлгээд орлоготой байлгаад, орлогоос нь татвараа авах тухай л ойлголт байхгүй юу. Энийгээ яаж хийнэ гэж бодож байна. 1.

2 дахь зүйл үнэхээрийн л амаргүй л байгаа бол өнөө төрийн мэдэлд байх ёстой ард түмэнд үр өгөөж нь явж байх ёстой стратегийн ордуудыг яаж ашиглах гээд байна. Нүүрс чинь дэлхийн зах зээл дээр үнэ нь буучхаад байгаа юм байна. Тэгвэл наад зэс, алт чинь нэлээн үнэ нь гайгүй өсөөд байгаа юм байна лээ шүү дээ. Тэгвэл тэр Оюутолгой гэж 1 том компани Монголд бараг татвар төлөхгүй болчихсон. Орлого нь Монголоор дамждаггүй. Монголд захирагддаггүй. Монголын хуулийн этгээд. Тэрийг яаж жоохон чихийг нь зөөллөж оруулж ирж, авах ёстой юмаа авах ёстой юм бэ.

Дараа нь энд тэнд овоолгууд байна. Арга технологийг нь олоод хүмүүс жоохон үйлдвэрлэл явуулаад, орлого бүрдүүлээд, төсөвт юм хийе гээд байна. Хаачхаад байх юм. Нөгөө “Ачит эх”-ийг яах юм. Тэр урд байж байгаа хэдэн угаах, баяжуулах үйлдвэрүүдээ ажиллуулахгүй юм уу энэ хүнд үед. Тэгж байж энэ орлогын чинь эх үүсвэр, бааз суурь жоохон өргөтгөх юм биш үү. Энэ тал дээр ер нь ямар бодол байна вэ.

Дараагийн нэг зүйл. Баялгийн сан гэж байгуулсан. Хуримтлалын санд хэдэн төгрөг оруулж байгаа. Бүгдийг нь дандаа орон сууц болгох гээд яах вэ дээ. Ер нь хэдэн барилгын компани, хэдэн улс төрчдийг дэмжээд байгаа юм биш үү. Барилгын метр квадратын үнийг бодлоготойгоор өсгөөд, худалдан авагч, иргэдэд дарамт учруулаад. Тэгвэл тодорхой хэсгийг нь боловсролд шаардлагатай, эрүүл мэндэд шаардлагатай байгаа тэр төсвийн эх үүсвэртээ ашиглая л даа. Хөрөнгө оруулалтын эх үүсвэртээ. Угаасаа тэгж заасан шүү дээ хуульд. Энэ талаар ямар байр суурь байна. Ерөнхий сайдаас би тэр стратегийн ордууд, баялгийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн талаар тов тодорхой мэдээлэл авмаар байх юм. Жоохон ингэж дуугарахгүй бол болохоо байлаа хэдүүлээ. Төрийн өмчтэй компаниуд энэ чинь алийгаа алдсан орон тоотой, цалин хөлсөө мэдэхээ байчихсан захирлууд, албан хаагчидтай гээд яриад байх юм. Үгүй ээ, наад нэг юмнуудаа жаал хумиад, зардлыг нь бууруулаад. .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Манай Жигжидийн Батжаргал гишүүн бас Үндэсний баялгийн сангийн хуулийг хамт бид баталсан хамгийн чухал асуудлыг бас хөндлөө. Тэгэхээр Үндэсний баялгийн сан бол олон улсын жишгийн хөрөнгө оруулалтын корпорац хэлбэртэй байдаг. Энэ хөрөнгө оруулалтын корпорацад газар доор байгаа баялаг үржихгүй, өсөхгүй учраас тэрийг үрждэг, өсдөг актив болгоод ингээд хөрөнгө оруулалтаар өөрөө өсөж байдаг ийм активыг л Үндэсний баялгийн сан болгож хувиргаж байгаа хэлбэр. Ийм учраас юуны өмнө би албан даалгавар гаргаж, бараг уншаад өгчихсөн нь зөв байх гэж бодож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлийн баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж заасныг баримтлан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд, хууль хяналтын

байгууллагуудад албан даалгавар гаргаж байгаа. Энэ бол Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг арилгах цогц арга хэмжээний төсөл боловсруулж, 2025 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, цогц арга хэмжээ авч шийдвэрлэх. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг ашиглаж шамшигдуулсан, уул уурхайн лицензийг шамшигдуулж авсан нийтийн албан тушаалтнууд болон холбогдох этгээдүүдэд хариуцлага тооцох, хууль бусаар олсон хөрөнгийг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар танилцуулах. Хууль бусаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хууль бусаар авсан, олгосон, стратегийн ач холбогдол бүхий орд газрууд, ашигт малтмалын орд газруудтай холбоотой асуудлыг судалж, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, улсын өмч болгох, цаашид энэ талаар авах арга хэмжээний талаар санал, дүгнэлтээ боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэх гэсэн ийм албан даалгаврыг гаргаж, үүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, ТЕГ, ЦЕГ, АТГ, Ашигт малтмалын газрын тосны Хэрэг эрхлэх газарт тус тус даалгасан ийм албан даалгавар гаргаж, үндэсний баялгийн санг бодитой мөнгөжүүлэх, тэр бүх орд газруудтай холбогдох яриа хэлэлцээг дуусгаж, нэг зарчим тогтоох ийм үүрэг даалгаврыг өгч ажиллахаар энэ албан даалгаврын төслийг өнөөдөр албажуулж байна. Ингэж бид хуулийн хүрээнд ажиллаж, Үндэсний баялгийн сангаа мөнгөжүүлнэ.

Энэ дотор бүх орд газрууд, стратегийн болон бүх орд газрууд, үүсмэл ордууд бүгд хамрагдаж байгаа. Орд тус бүрээр нь бодлого гаргаж, хууль хяналтын байгууллагуудын материалтай танилцаж, мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх үүрэг өгсөн байгаа.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тэр төрийн өмчтэй хэдэн компаниудаа зардлыг нь бууруулаад, үр ашгийг нь дээшлүүлээд, өөрөө өөрийгөө авч явдаг чадварыг нь сайжруулаад, болж өгвөл улсын төсөвт жоохон хувь нэмэр оруулдаг болгоё. Энэ нээлттэй байдлаа яаж хийх вэ нөхөд өө.

Дараагийн нэг зүйл бас бид нэг юм хийхээрээ нэг тийшээ савах гээд байдаг. Хэн нэгэндээ янз бүрийн нэр хоч өгч байгаад, үйл ажиллагааг нь зогсоогоод, марзан юм болоод явчихдаг. Улсад учруулсан хохирол байдаг юм бол тэрийгээ тогтоогоод ав, үйл ажиллагааг нь явуулаад татвараа ав. Тэгж байж дэмждэг шүү дээ энэ улс орон чинь. Тэрнээс биш энэ төрөөс төрчихсөн тэрбумтан байна. Энэ баялаг хулгай хийчихсэн хүн байна гээд үйл ажиллагааг нь хаачихаар хаанаа ч үр дүнгүй юм болдог байхгүй юу. Тэр үйл ажиллагааг нь явуул, улсад учруулсан хохирлыг нь ав, татвараа ав. Ингэж байж зөв явдаг. Тийм учраас олон компанийн үүд хаалга битгий хаачхаарай. Энэ талаар ямар бодол байна. Асууя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд. Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя.

Г.Занданшатар: Мэдээж хааж зугтаалгах биш, улсын орлого болгож, улс оронд ашигтай байх, ард түмэн байгалийн баялагтаа эзэн байх энэ хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд төрийн өмчийн компаниудыг ч гэсэн 16.9 их наяд төгрөгийн зардалтай 2023 онд гэхэд ажилласан байгааг зардлыг 15 хувь

бууруулсан. Бууруулах 4.9 орчим их наяд төгрөгийн ашигтай ажиллаж байгаа ашигт ажиллагааг ингэснээрээ 6.5 их наяд хүргэж, 1.5 их наядаар ашгийг нэмэгдүүлэх ийм төлөвлөгөө, хуваарийг баталж, 30 хувиар үр ашгийг нэмэгдүүлэх ийм Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиглэл гаргасан юм байна лээ. Үүнийг тууштай хэрэгжүүлнэ. Энэ ч гэсэн нөгөө төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, ингэснээрээ улсад төлөх ногдол ашиг, орлогыг нэмэгдүүлэх ийм цогц арга хэмжээг энэ төрийн өмчийн компаниудын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр Нийтийн өмчийн тухай хуулийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн ээ, одоо энэ сүүлийнх нь тодруулга. Дэгийн хуулиараа.

Ж.Батжаргал: Дахиад нэг бий биз дээ. Төрийн зардлыг бууруулахад төрийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүнийг зөв тогтоох тухай асуудал байгаа юм. Тэгэхээр энэ судалгааг ахиухан явуулж зөв хиймээр байна. Би Төрийн албаны хуульд оруулах гэж байгаа нэмэлт, өөрчлөлтөө татаж авъя гэж байгаад чинь баяртай байгаа. Би тийм шийдэлд хүрч байгаа юм байна гэж ойлгосон. Тэгээд нэлээн ултайхан судлаад, зөв шийдэл гаргаад, жоохон чиг үүргийн давхардал илүү, дутуу юмнуудаа арилгаад, бас төрийн чиг үүргийг зөв бүтцээр, зөв бүрэлдэхүүнээр хүргэж чаддаг байх энэ юмаа хийгээд авбал зөв. Бид ер нь жоохон орлого амьжиргаа аятайхан байх үед дэндүү бялуурцгаагаад, төсөв дээр дулдуйдаад, юмны үнэ цэн гэдгийг мэдэхээ байчихсан байсан. Харин энэ цаг үе Монголчуудыг сэргээгээд, мөнгө төгрөгийнх нь үнэ цэнийг мэдрүүлээд, зөв бүтэц рүү нь оруулах тийм сайн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Батжаргал гишүүний асуултад Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүний хэлсэн сайн цагийн эхлэл байх гэсэн Монгол хүн амны бэлгээрээ гэдэг ерөөл билигт талархаж байна. Үнэхээр өнөөдөр бас бид эргэж харж, урагшаа алхах ийм цаг болсон. Тийм ч учраас төрийн өмчийн компаниудын үр ашгийг нэмэгдүүлээд, төрийн албаны шинэчлэлтэйгээ уялдуулж, Төрийн албаны хуулийг бас цогцоор нь авч үзэж шинэчлэх ёстой юм байна гэж үзэж, Төрийн албаны хуулийг эргүүлэн татах саналыг гаргахаар шийдвэрлэлээ. Үүнийг тэгэхдээ процедурын дагуу шийднэ. Яагаад гэхээр төрийн албаны шинэчлэл бол цогцоор нь харахгүй бол жишээлбэл, докторын зэрэгтэй байж болно. Тэр хэмжээгээрээ хүн илүү ур чадвартай, илүү сайн ажиллаж, гүйцэтгэл нь сайн байвал илүү цалин авах ёстой болохоос биш, зүгээр докторын зэрэгтэйгээрээ илүү сайн ажилладаг хүнээс илүү цалин аваад, 20, 40 хувийн нэмэгдэл аваад байгаа нь шударга юм уу гэдэг асуудлыг л төрийн албан хаагчид асуугаад байгаа юм. Ийм учраас л энэ асуудал хөндөгдсөн. Тэгэхдээ энийг бүр цогцоор нь харж байж, төрийн албаны гүйцэтгэл үнэлгээтэйгээ үнэлгээ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Ерөөсөө л төрийн албаны шинэчлэлийн гол зарчим бол илүү сайн ажилладаг нь илүү сайн авдаг, цалин урамшууллаа авдаг, гүйцэтгэлээрээ санхүүждэг гүйцэтгэлийн үнэлгээний энэ 2023 онд баталсан зарчмыг аттестатчилал буюу үнэлгээний зарчимтай нийцүүлж хэрэгжүүлэх шаардлагатай. Бас ард олныхоо санал асуулгаар ч гэсэн энэ үйлчилгээний чанар стандартыг тодорхойлж байх, чанарын судалгаа ч авч байх зайлшгүй шаардлагууд гарч болж байна. Ингэж байж

төр ард түмний итгэл бэхжих учраас төрийн албаны шинэчлэлийг илүү цогцоор нь хийх ёстой гэж үзэж байна. Ийм учраас дутуу дулимаг, яаруу сандруу бас оруулсан байж болзошгүй учраас Төрийн албаны тухай хуулийг буцааж татъя гэж нэмэлт, өөрчлөлтийг буцааж татаж, цогцоор нь авч үзье гэсэн ийм бүлгийн саналыг бас харгалзан үзэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ оройн амрыг эрье. Тэгээд гишүүн болсноос хойш, шинэ парламент бүрдсэнээс хойш 1 жил хүрээгүй хугацаанд бид нар 4 дэх удаагаа төсөв баталж байгаа нь 1 талаасаа одоо эмгэнэл юм уу. Уйлмаар санагдаж байна. 4 өдөр бид нар 4 удаа ингэж шөнө дөл болтол төсөв хэлэлцэж суулаа. Нөгөө талаасаа бас туршлагаждаг юм шиг байна. Тэгэхээр бас гайхаад байна л даа. Би 1 юмыг ойлгохгүй болчихлоо. Төсвийн гүйцэтгэлээ яагаад хэлэлцэхгүй орхиод, шууд тодотгол руу орчхов. Гэтэл энэ төсвийн гүйцэтгэл дээр чинь 2024 онд гэхэд чинь л 15.7 их наядын алдаа, зөрчил гарсан буюу өмнөх оныхоос 93 хувиар их гэж байна шүү дээ. Бараг 2 дахин их ийм алдаа, зөрчил гарчихсан явж байхад тэрийг бид нар эхэлж зүй нь хэлэлцэж байгаад ийм ийм алдаа зөрчил гарсан юм байна. Дахиж энийг гаргахгүйн тулд энэ тодотголоо ийшээ чиглүүлье ч гэдэг юм уу. Мэдэхгүй. Логикоор бол ингэж явбал зүйтэй санагдсан боловч харамсалтай нь төсвийн гүйцэтгэлээ ярилгүй орхиод, ийшээ орчихлоо. Би дөнгөж гишүүн болсныхоо дараа Америкийн Конгресийн гишүүнтэй уулзахад ерөөсөө төсвөөс илүү гүйцэтгэл чухал байдаг. Америкт бол гүйцэтгэлийг л маш олон хоногоор ярилцдаг, хэлэлцдэг гэж хэлж байсан. Тэгэхээр энэ гүйцэтгэлдээ бид нар ач холбогдол өгч, хариуцлагын асуудлыг ярихгүй байх юм бол бид нар мянга төсөв тодотгоод, мянга хэдэн шөнөөр суугаад ч тусыг эс олохоор санагдаж байна.

Тэгээд мэдээж 4 удаа төсөв батална. 2 нь тодотгол, 2 нь төсөв гэж үзлээ гэхэд л энэ чинь бид нар өнөөдөржингөө л ярилаа. Ерөөсөө төлөвлөлт буруу байна. Орлогоо буруу тооцож байна. Хэтэрхий өөдрөг байна. Хэт их зардал гаргаж байна. Төсөв дагасан байна. Сөрсөн бус байна гээд байнга яриад байдаг. Гэтэл ингээд ер нь хариуцлагын механизм гэж байгаа юм уу. Ямар нэгэн хуульд тусгагдсан юм байгаа юу.

Би эндээс Төсвийн тухай хуулиас 1 зүйл, заалт оллоо л доо. 70.4 гээд. Төсвийн төслийг боловсруулж батлуулахдаа үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурлаж батлуулсан нь төсвийн гүйцэтгэлээр тогтоогдсон бол уг албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлнө гээд. Тэгэхээр өмнө ингээд 4 удаа төсөв баталж байна гэдэг нь өөрөө төсвийг чинь буруу, зөрүү тооцоолсны улмаас батлаад байна гэж бид нар өнөөдөржингөө ярилаа л даа. Ашгүй гишүүд маань бүгд бас ойлгоод, нэг вайбтай байгаад баяртай байна. Өмнөх 11, 12 сарын төсвийн үеийнхтэй харьцуулбал. Тэгэхээр энэ дээр хэнд, ямар хариуцлага тооцох юм бол. Хариуцлага тооцохгүйгээр бид ингээд цаашаа яваад л байвал хэзээ ч энэ төсвийн хариуцлага сайжрахгүй. Төсвийн энэ алдаатай, мадагтай төлөвлөлт хэзээ ч засрахгүй.

2 дугаар асуулт, энэ аудитын бөгөөд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүдээс уншихад төсвийн орлогыг 10.6 хувиар бууруулж бодсон байна гэж байгаа юм. Тэгсэн мөртөө .../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулчхаад, нэмэлт тодруулга хийе. Хэн хариулах вэ. Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Жудагийн Баярмаа гишүүний саналтай бол зарчмын хувьд нэг байна. Ер нь агуулга нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд болон Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан санаа нь 6 сард гүйцэтгэлээ хэлэлцээд, 9, 10 сард төсөв хэлэлцэх үедээ, дараа жилийн төсөв хэлэлцэх үедээ харгалзан үзэх зорилгоор төсвийн тодотгол биш, дараа жилийн төсөв хэлэлцэхдээ өмнөх жилийн гүйцэтгэлийг хэлэлцдэг ийм зарчмаар суулгасан. Олон улсын жишиг байдаг байх. Энэ удаа бол төсвийн тодотгол давхацчихлаа. Тэгэхдээ энэ төсвийн тодотгол бол төсвийн гүйцэтгэлтэй шууд холбоотой гэж байгаа юм биш. Үүнийгээ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал бөгөөд энэ аудитын газраас хийсэн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа. Засгийн газрын өмнөх жилийн төсвийн гүйцэтгэл бол та бүхэн хэлэлцэж ярих байх гэж бодож байна.

Зүгээр 4 дэхэд байгаа төсөв баталж байгаа бол тэгэхдээ төсөв батлах бол Улсын Их Хурлын хамгийн гол онцгой бүрэн эрхийн 1. Энэ хүрээндээ татвар төлөгчдийн мөнгийг яаж, үр ашигтай зарцуулах вэ, зарцуулсан бэ гэдэг 2 асуудлыг ярьж байгаа учраас энэ бол бас ард түмний төлөөлөгчдийн үндсэн үүрэг гэж бодож байна.

Гүйцэтгэлийг бүрэн хэлэлцэж, дараа нь үнэлсний дараа тодотгол, төсвөө батлах ёстой гэсэн зарчим бол биелж байна. Ер нь төсвийн зарлага, орлогын биелэлт хангалттай тайлагдаагүй, бодит, гүйцэтгэлийн суурь дүгнэлт хийгээгүй байхад дараа жилийн төсвөө хэлэлцэж болохгүй л гэсэн санаа. 2026 оны төсөв дээр яригдаж байна гэсэн үг. Энэ жилийн хувьд бол бид 2025 оны төсвөө тодотгож байна. 2025 оны төсвийн гүйцэтгэлийг харин бид нар та бүхэнд тайлагнаж, та бүхэн ирэх 2026 онд хэлэлцэнэ. Тэр үед бол бид сайн тайлан, гүйцэтгэл үзүүлэхийг зорих ёстой гэж бодож байна.

Х.Булгантуяа: Баярмаа гишүүн нэмж тодруулъя.

Ж.Баярмаа: Тэгээд буруу тооцоолсон гэж үзэж байгаа юм уу, үзэхгүй байгаа юм уу гэдэг дээр Жавхлан сайдыг хариу өгнө үү гэж хүсэж байна.

Дараагийнхаа асуултыг асуучихъя. Энэ орлогын бууралтыг 10.6 хувь гэххээд, зарлагаа 5.4 хувиар бууруулсан байна. Ер нь айл өрхөөр бодсон ч гэсэн, аж ахуйн нэгж ч гэсэн байнга л энэ чинь орлогоо тооцчихоод, зарлагаа түүндээ тохируулж тооцдоггүй юм уу. Тэгээд бид нар ийм цөвүүн цагт маш их асуудал дагуулаад, хүн болгон амтай болгон яриад, нийгэм тэр чигээрээ энэ төсвийг сонирхдог болсон шүү дээ. Тэгээд ийм үед орлогодоо тохирсон төсвөө баталж болдоггүй юм уу. Уг нь Ерөнхийлөгчтэй хавсаадаж байгаад бараг алдагдалгүй төсөв баталсан. Тэгээд ядаж алдагдалгүй оруулж ирж болохгүй байсан юм уу. Тодотголоо. 1.3 их наядын алдагдалтай гэж ойлголоо.

2 дугаарт, орлого талаа нэмэх тал дээр ямар ажил хийх вэ. Энэ их асар олон тэрбумын нөгөө Чингис банк, нөгөө Капитал, Капитрон банканд алга болсон энэ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Төсөв төлөвлөх аргачлал маань өөрөө хуультай шүү. Хуулийн дагуу л хийгддэг. Эдийн засаг, хөгжлийн яам дээр төсвийн хүрээгээр дамжаад, макро төлөвлөлт хийгдэнэ. Тэр хүрээний хүрээнд

төсөв өөрөө салбар салбарынхаа зохицуулалтаар хийгдээд явдаг ийм байгаа. Ноднин төсвөө төлөвлөж эхэлж байх буюу яг өдийд ганц Монгол Улс биш, дэлхий даяараа ковидын дараах сэргэлт гээд төсөөллүүд их өөдрөг байсан. 9 сарын 1-нд өргөн барихад ч өөдрөг байсан. Харин 11, 12 сараас байдал нэлээн өөр болсон. Он гараад бүр ч хэцүүдлээ. Энэ дэлхий нийтээрээ ийм төлөвлөлтөд орчихсон л явсан шүү. Ганцхан Монгол Улсад тохиолдож байгаа асуудал биш. Энэ удаагийн эдийн засгийн сааралт дэлхий нийтээрээ учирч байна. Эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь дэлхий нийтээрээ учирч байгаа ийм зүйлүүд. Энэ дээр улс бүр өөр өөрсдийнхөө бодлогоор, өөр өөрсдийнхөө боломжоор тохиргоонуудаа .../минут дуусав/

Х.Булгантуяа: Баярмаа гишүүн нэмж 1 минут тодруулъя.

Ж.Баярмаа: Та яах вэ, дандаа л тэгж хэлж байгаа л даа. Гэхдээ тэр 11 сар төсөв батлах үеэр чинь энэ эдийн засагчид, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, мэргэжлийн хүмүүс бүгд л хэлж байсан шүү дээ. Хэтэрхий өөдрөг байна. Энэ чинь үнэ нь унах нь ээ гээд. Тэгэхээр урьдчилж хараагүй биш, харж байсан. Гишүүд бид нар бишгүй хэлсэн. Та ерөөсөө үг аваагүй. Тэгэхээр энэ дээр та мянга зөрөөд нэмэргүй л дээ.

Дахиад тэр хариуцлагын асуудлаа ер нь хэрэгжүүлж, энэ 70.4 гэдэг энэ заалтаа хэрэгжүүлж явахгүй бол ерөөсөө энэ заалтаа Төсвийн тухай хуулиасаа авч хаях хэрэгтэй. Хэн ч хариуцлага хүлээхгүй. Тэгээд дандаа төсөв хэлэлцээд, бид нар ч гэсэн ерөөсөө орой болгон жилд 4 удаа төсөв хэлэлцэнэ гэдэг чинь маш зовлонтой байна шүү дээ.

Дахиад орлого тал дээрээ юу хийхээр төлөвлөж байгаа юм бэ. Одоо 68 орчим их наядын хөрөнгө төрийн өмчит компаниудад байна. Эд нараасаа зарж, үрэх ажил хийхгүй юу. Гүрж яаж амжилтад хүрсэн бэ гэвэл эдийн засгийн сайд нь сүнснээсээ бусад төрийн өмчийг зар гэж хэлсэн байдаг шүү дээ. Тэр шиг .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Мэдээж орлого талдаа бүх нөөц боломжуудаа дайчилж ажиллалгүй яах вэ. Ялангуяа төрийн өмчийн компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх. Төрийн өмчийн компаниудын хувьд бол төсөвтэй харьцдаг ерөөсөө ганц суваг нь ерөөсөө ноогдол ашиг байдаг. Ноогдол ашиг. Мөн эдийн засгаа шууд өөр өөрсдийнхөө чиглэлээр дэмжих ийм үндсэн үүргүүдтэй гэсэн үг. Төрийн өмчийн компаниудыг хувьчлах замаар орлого олно. Эсвэл одоо төрийн өмчийн компаниуд дээр байгаа эд хөрөнгүүдийг зарж борлуулаад, төсөвт орлого төвлөрүүлнэ гэдэг. Энийг тусдаа ярих хэрэгтэй. Одоогоор бид төрийн өмчийн компаниудын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр нэлээдгүй бас ажлуудыг зохион байгуулаад ингээд явж байгаа. Харин хөрөнгийг нь зарж, төсөв дээр орлого төвлөрүүлнэ гэдэг. Энийг компаниудтай нэлээн тулж сууж байж хариулах нь зөв байх. Тэрнээс одоо шууд энэ дээр хэлэх юм бол алга байна. Бусад орлогын хувьд бол уул уурхайн бус салбар .../минут дуусав/

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Уул уурхайн бус салбараас орлогыг нэмэгдүүлэх, дээрээс нь уул уурхайн салбар дотроо ч тэр нүүрснээс бусад үнийн өсөлттэй байгаа үнэ нь зах

зээлийн хувьд сүүлийн жилүүдэд байгаагүй, ялангуяа алт дээр ч юм уу, эдгээр салбарууд дээр дайчлах, эдгээр салбаруудыг дэмжих, тэр дээр гацсан байгаа олон зүйлүүдийг нь хөдөлгөх байдлаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бусад бүх боломжууд дээр ажиллах болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Бид нар энэ төсвийг хэмнэлттэй төсөв оруулж ирэх гэж байна. Тэгээд энэ асуудал дээр эрүүл мэндийн салбараа ярья даа. Нийгмийн салбар энэ дээр бас хүнд. Тэр дотроо ялангуяа өнөөдөр эмнэлэг дээр үүсээд байгаа нөхцөл байдал, тэгээд санхүүгийн нөхцөл байдлаасаа хамаараад шийдэхийн тулд тусламж, үйлчилгээг 20-25 хувиар яах аргагүй нэмэхээс өөр аргагүй байна гэж сайд хэлсэн. Энэ дээр ингээд шууд эмнэлгүүдийн санхүүгийн нөхцөлийг хараад хувиас гарах төлбөртэй тусламж, үйлчилгээг 20-25 хувь нэмнэ гэдэг дээр маш болгоомжтой хандах хэд хэдэн бас үндэслэл байгаа. Энийгээ ярих хэрэгтэй. Жишээлбэл, энэ хувиараа шууд төлбөр хийгээд, ингэснээрээ тусламж, үйлчилгээний хүртээмж, ялангуяа энэ тэгш бус байдлыг улам нэмэгдүүлдэг. Ингэснээр иргэд, аж ахуйн амьдралын хүний чанарт нөлөөлж, орлого багатай иргэд нөгөө ядуурал руу гулсан ордог үндсэн гол шалтгаан болж байгаа гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрчихсөн байгаа. Ингээд хувийн төлбөрөөс болоод өвчтөн өөрөө аль болохоор эмнэлэгт үзүүлэхгүй байх, цаг алдах, хойшлуулах, хэрэгтэй лабораторийн шинжилгээгээ хийлгэхгүй байх, тэгснээрээ хүндрээд бүр өндөр өртөгтэй эмчилгээнд шилжих, халдварт өвчний тохиолдол бол бүр бусдад тарааж, халдвар халдварлуулах, ингэснээрээ хувь хүн, олон нийт, нийгмийн эрүүл мэндийн том асуудал болдог. Энийг бүүр эрүүл мэндэд *fork and care* гэж бүр нэрлэдэг тийм нэршилтэй юм. Одоо манай судлаачдын өөрсдийн хийсэн Жавхланбаяр, Баярсайхан энэ тэр судлаачид 9 жилийн өмнө 2016 онд *international journal for equity in health* гээд энэ дээр хэвлүүлсэн ажил нь байгаа. Энэ үнэлгээгээр эрүүл мэндийн хувийн төлбөрөөс болоод жил болгон 20 мянга гаруй иргэд ядуурч байгааг тооцож гаргасан байдаг. Тэгэхээр энэ тооцоо тооцоолол одоо бол энэ нөхцөл дээрдээгүй дордож л байгаа нөхцөл харагдаж байгаа учраас энэ дээр бид нар болгоомжлох зайлшгүй шаардлагатай гэдгийн 2 дахь үндэслэл нь энэ юм.

Ер нь энэ эрүүл мэндийн санхүүжилт дээр хувийн төлбөр 25 хувиас дээш байгаа дэлхийн бусад улс орнуудыг харахад энэ ядуурлын бууруулах, эрүүл мэндийг бүх нийтийн хамралтад хүргэх гэсэн энэ хувийн төлбөрөө бууруулж чадахгүйгээр байгааг ДЭМБ болон бусад эрүүл мэндийн байгууллагууд энд нь маш сөргөөр нөлөөлөлтэй, зөвхөн хувь хүмүүс ч юм уу, эмзэг бүлгийнхэнд биш нийгэм, эдийн засаг тухайн улсдаа маш сөрөг гэдэг асуудлуудыг маш тодорхой тусгасан байдаг. Жишээлбэл, манай улсын хувьд энэ эрүүл мэндийн ядуурлын дэвшил нь 40 орчим хувь байгаа. Одоо юу гэдэг юм нийт зардлын гэсэн нэг тийм тооцоо байна л даа. Эхний байдлаар энэ асуултдаа авчхаад, тэгээд дараагийнхыгаа ярья.

Х.Булгантуяа: Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн хариулъя.

Ж.Чинбүрэн: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь бол анхан шатны тусламж, үйлчилгээ бүгдэд хүртээмжтэй байх, *universal health coverage* гэдэг энэ бодлогоосоо ухрахгүй. Ингэхийн тулд бид анхан шатны тусламж, үйлчилгээ дээр өнөөдрийн байдлаар санхүүжилтийн тогтолцоо бол бүр эвдэрчхээгүй байгаа. Энэ дээр бид бол ямар нэгэн хамтын төлбөрийн асуудал ярихгүй.

Дараагийн асуудал бол төлбөртэй тусламж, үйлчилгээ 300 төрлийн л юм байгаа. Энэ бол бүгд орохгүй. Зүгээр харин төлбөрийн тогтолцоо одоо үйлчилж байгаа шүү дээ. Энэ тогтолцоог инфляцтай уялдуулж, 20-25 хувьд хүргэвэл, дээрээс нь нэмэх нь таны бас хэлж байгаа, болгоомжилж байгаа хамтын төлбөрийн асуудал. Хамтын төлбөрийн асуудлыг 15 хувиас ч хэтэрч болохгүй. Тэрэнтэй санал 1 байгаа. Жишээлбэл, зарим өндөр өртөгтэй үйлчилгээ байна. Тухайлах юм бол өндөр өртөгтэй хагалгаанууд, эрхтэн солих хагалгаа. Тэр дээр хувилах юм бол энэ мөнгө чинь бүр талийгаад өгнө. Жишээлбэл 110 сая төгрөгийн өртөгтэй хагалгааг 20 хувь гэх юм бол энэ чинь юу вэ бүр 25 сая төгрөг эргэн төлөх болно шүү дээ. Тийм учраас бүх юм пропорцтой, аль болохоор иргэнд санхүүгийн дарамт үзүүлэхгүй байх энэ том бодлогоос ухрахгүй. Ер нь бид нарын гол зорьж байгаа зүйл бол Монгол хүн өвчин тусаад, мөнгөтэйгөөсөө үл хамааран эмнэлгийн тусламжийг ядуурлын түвшинд хүрэхгүйгээр авдаг байх энэ том зорилго энэ Засгийн газрын том зорилго хэвээрээ байгаа. Тийм учраас бас тантай санал нэг байгаа. Энийг буулгана, энэ босгыг эвдэнэ гэсэн зорилго байхгүй байгаа. Тэр ч утгаараа бас энэ хөнгөлөлттэй эмийн ч бодлого төсөв ерөөсөө хасагдаагүй. 170 тэрбум, төрөөс даах 40 тэрбум төгрөг, эмийн хөнгөлөлтийн 130 тэрбум бүгд үйлчилж байгаа. Тийм учраас бид энэ судалгаа, нотолгоотой зүйл дээр тулгуурлаж, ер нь бол ийм хамтын төлбөрийг бага хэмжээгээр оруулах асуудлыг бид судална гэж би хэлсэн шүү. Яг одоо тэгчихнэ гэж хэлээгүй. Энэ бол мэдээж кабинет дотроо ярьж, саналаа танилцуулж, тэгээд Засгийн газраас гарах шийдвэр. Түүнээс би ганцаараа хэлээд л шийдчих асуудал биш. Нөгөө талаасаа ард иргэдэд учрах санхүүгийн дарамтыг заавал тооцсон байна. Ард иргэд ядуурал оруулахгүй байх гэсэн том зорилго тантай санал нэг байгаа. Энэ үндсэн зарчмаасаа гажихгүй. Харин нэгэнт санхүү хүрэхгүй байгаа тохиолдолд тухайлах юм бол лавлагаа шатлалын эмнэлгүүдийн төсөв гээд л харахад та бүхэн гүйцэтгэлийг нь хараарай. Дандаа өртэй, дандаа буруу гарчихсан. Тэгвэл аймаг, дүүрэг дээрээ эмчлүүлж болох өвчнөө эмчлүүлчихдэг. Лавлагаа шатлал дээр очиж ачаалал үүсгээд багасгадаг. Аймаг, дүүргийн эмнэлгийн хүчин чадлыг сайжруулах чиглэлд бид ямар бодлого тавих вэ. Зарим 1 санхүүгийн механизмууд байгаа. Жишээлбэл, олгой, цесний хүүдий авхуулах гээд 3 дугаар шатлал буюу лавлагаа шатлалын эмнэлэг дээр очоод байх шаардлага байхгүй. Аймаг, дүүргийн эмнэлэг дээрээ сайн эмч нарыг ажиллуулаад, гүйцэтгэлээрээ илүү их санхүүжилт аваад ажиллах тэр боломжийг нь хангах, харин лавлагаа шатлалын эмнэлэг рүү очих юм бол хамтын төлбөр төлөөд, бага хэмжээний төлбөр төлөөд, тэр бүр өөр шатлалын эмч нар дээр очиж хийлгэнэ гэвэл ийм зохицуулалтыг хийж аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн бас санхүүг хамгаалдаг ийм тогтолцоо бидэнд бас дутагдаад байгааг бас хэлье.

Мөн тэгээд чанар бол мэдээж их чухал. Тэгэхээр үр дүнг чанартай уялдуулсан тогтолцоогоо хэдүүлээ хийж өгөхгүй л бол зүгээр замбараагүй тооны араас хөөцөлдсөн тогтолцоо буцаагаад бас салбараа залгиад байгаа юм. Тийм учраас энэ дээр бас их болгоомжтой ажиллана. Тэгэхээр бол шууд тэгээд хэлчихсэн зүйл байхгүй шүү. Тэгээд энэ дээр нэлээн бодлогын уралдаан, мэтгэлцээнүүд хийнэ. Нэгэнт хүрэхгүй байгаа санхүүжилтийг яаж зөв байлгах вэ гэдэг эрдэмтэн, мэргэдийн бас дуу хоолойг бас сонсоно. Энэ дээр та ч гэсэн бас оролцох ёстой гэж бодож байна.

Х.Булгантуяа: Ганмаа гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганмаа: Баярлалаа. Их сайн байна. Ялангуяа иргэд, эмзэг бүлгийнхнийгээ хамгаалж, санхүүгийн дарамтад учруулахгүйгээр хийж байгаа тэр 1 худалдан

авагчийнхаа тогтолцоог үргэлжлүүлээд, эндээсээ ухрахгүй, яг энэ зарчим дээрээ явна гэдгийг сонсоход таатай байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль гэж батлагдсан. Тэндээс нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээ авах нөгөө “Өвчний хяналт, сэргэлтийн төв” буюу CDC /Centers for disease control/-г байгуулна гэсэн заалт орчихсон байгаа. Энэ CDC- байгуулах заалтад нь яг одоогийн нөхцөл байдал нь яг ямар байгаа вэ. Хаана байгаа юм. Бэлтгэл нь ямар байгаа юм. Зүгээр Төрийн нарийн бичгийн дарга дээр энэ асуудал зангидагдаж явж байгаа гэсэн. Би бас мэдээлэл асуусан байгаа. Энэ байгууллага мэдээж байгууллагынхаа бид нар байшин барих ч юм уу, тоног төхөөрөмж авах ч юм уу, юу гэдэг юм урсгал зардлаа тэлээд хаях тийм асуудал бол яригдахгүй байх. Ялангуяа энэ хэмнэлтийн хуультай холбоотойгоор. Одоо бид нар ер нь энэ асуудлыг .../минут дуусав/

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Ер нь энэ өвчин судлалын төвтэй байж бид ер нь ирээдүйд өвчлөл ер нь яах юм гэдгийг зөвхөн Монгол Улсдаа өвчлөлийн биг дата дээр ажиллаад зогсохгүй, дэлхий нийтийн өвчлөл, халдварт өвчний тархалт ямар байгаа гэдгийг байнга мэдэж, тандаж байдаг. Одоо манай Сангийн яам, Эдийн засгийн яам эд нар чинь бол нүүрс, нөгөө эдийн засгийн хөгжил хаашаа байна, индексүүдээ бүгдийг нь тооцдогтой ижил ийм тогтолцоо манай эрүүл мэндийн салбарт дутаад байгаа юм. Бодлогын тархи нь дутагдаад байгаа. Тийм учраас энийгээ хийх энэ бодлого Дэлхийн эрүүл мэндийн суурин төлөөлөгчийн газар дээр хамтраад Эрүүл мэндийн яам CDC байгуулах төсөл явж байгаа. Би бас цухас танилцсан. Ер нь бол давхардсан чиг үүргүүд энэ дээр их байгаа. Хөгжлийн төв, Нийгмийн Эрүүл мэндийн Үндэсний төв, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, дандаа тандалтын албууд нь хоорондоо давхардсан. Тэгвэл энэ нь бүгдийг нэг болгож, нэг том уураг тархи болгоно.

2 дахь зүйл бол халдварт өвчнийг төсвөөс санхүүжүүлж, эмчилдэг байх энэ тогтолцоог нэвтрүүлнэ.

Х.Булгантуяа: Ганмаа гишүүн дахин 1 тодруулъя.

Д.Ганмаа: Санал хэлье. Энэ манай улсын хувьд ер нь эрүүл мэндийн нийт зардлын 40 орчим хувь нь хувийн төлбөрөөр санхүүжиж байгаа. Үүнээсээ ч болоод 3 хүн амын 1 нь ядуу байгаа гэсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын, бусад улсын судлаачдын мэдээлэл байдаг юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ төлбөрийг нэмэх асуудлын огт ярихгүй гэж тооцоолоод, хүн амынхаа амьдралтай холбосон нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөг нь харж, том зургаар нь нотолгоонд суурилсан байдлаар асуудалдаа хандаад явах нь их чухал гэдгийг дахин 1 хэлчихье.

2 дугаарт, CDC-тэй холбоотой саяын хэлэх гэж байсан зүйл маань бид нар ихэвчлэн асуудалдаа яг хөтлөгдөж явчих гээд байдаг. Яг үнэндээ бид нар нөгөө урьдчилан сэргийлэх, тооцоолох, энийг асуудлыг үүсэхээс нь өмнө бүх бэлэн байдлыг нь үүсгэчихсэн байх, улаан бурхан, одоо үүсээд байгаа халдварт өвчний асуудал дээр ч бай, ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд. Тэгснээрээ яг бодлогоо хэрэгжүүлж явах нь маш чухал байгаа гэдэг дээр бүгд салбарынхан .../минут дуусав/

Х.Булгантуяа: Санал хэллээ. Ганмаа гишүүн. Одоо Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл

О.Цогтгэрэл: Төсвийн тодотгол ярьж байна. Энэ төсөв өргөн баригдаад, хэлэлцэгдээд батлагдаж байх үеэсээ л бараг тодотголын тухай тухайн үедээ л гарч байсан. Энэ төсөв чинь хэт өөдрөг төсөөлөлтэй байна. Хэт улс төрийн зорилго тавьчихсан, эдийн засгийн бодит утгагүй байна. Гадаад, дотоод нөхцөл байдал, хөршүүдийн чинь нөхцөл байдал, олон улсын нөхцөл байдал чинь илт болохоо байчихлаа л гэж байсан тухайн үед, бүр өргөн баригдаж байхад нь, батлагдаж байхад. Нөгөө зүйрлээд хэлэх юм нэг өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэдэг юм л болж байна л даа. Тэр үед аль хэдийний үүл нь гараад, бороо орох нь тодорхой болчихсон нөхцөл байдал ийм л байсан. Харин ч одоо тэр үеийн үүл чинь улам зузаарчихсан, одоо бараг аянга, цахилгаантай орох гэж байгаа юм уу. Инфляц нь 2 оронтой тоо руу ороход тодорхой болчихсон. Яг үнэндээ Монгол Улсын чинь валютын цэвэр нөөц гэдэг зүйл чинь бараг хасах руу орчихсон. Нүүрсний үнэ одоо 70 доллар л гээд тавьчихсан байна. Өнгөрсөн долоо хоногийн арилжаанууд чинь 60 хэдээрээ зарагдахгүй, дахиад дараачийн тодотгол бас удахгүй л хүлээж байгаа байх. Нөхцөл байдал нэг ийм л байна л даа. Тэгээд цагийн юмыг цагт нь хийгээгүйгээс нөхцөл байдал улам л хүндэрчихсэн. Ер нь тэгээд энэ өнгөрсөн цаг хугацааны ийм сүржин сүржин пи ар-тай олон төсөл хөтөлбөр, тэр төсвийн тэлэлт, олон зүйлээс л энэ бүхэн болж байгаа шүү дээ. Тэр мега төслийн санхүүжилтийн арга хэрэгслүүд. Мега төсөл гэдэг дээр жишээ нь төсвийн эхний шат явж байгаа болохоор бас байр сууриа хэлчихье.

Мега төслийн санхүүжилт олон зүйлүүд дээр миний хувьд мега төсөлдөө биш, санхүүжүүлж байгаа арга хэрэгсэлд нь би асар их шүүмжлэлтэй л ханддаг. Жишээ нь мега төслийн хамгийн боломжтой гэж байгаа тэр Эрдэнэбүрэнгийн төсөл гэхэд зүгээр миний бодлоор болдог сон бол тэр УЦС-ын ТЭЗҮ-г харж байхад 10 гаруй жилийн эргэн төлөгдөх хугацаатай, хөрөнгө оруулалтаа нөхчихнө гэсэн тооцоо тухайн үед харагдаж байсан. Хэрвээ үнэн бол. Жишээ нь ийм төслийг бид нар тэр барих-ашиглах- шилжүүлэхээр нь гадна, дотнын гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй зарлаад, тэрний дараа 10 жил ашгаа олох нөхцөлийг нь тавиад, улсын төсөв дээр өр зээл авахгүйгээр яагаад энэ талуудын арга хэрэгслийг бид нар ер нь өнгөрсөн хугацаанд ерөөсөө тэр арга хэрэгслүүдийг бид нар ашигладаггүй. Улсын төсвөөс зээл авна, барина, дараа нь төрийн өмчит компани байгуулагдана. Тэр төрийн өмчит компанийнхаа авлига, идсэн, уусныг дараа нь хөөцөлддөг нэг ийм л чөтгөрийн тойрогтой. Тэр Орхон-Онги гээд бас л мега төсөл дээр явж байдаг. Энэ төсөл ч гэсэн болдогсон бол тэр Эрдэнэс Тавантолгойн нүүрсний уурхай нь байна уу, Оюутолгой нь байна уу, энэ том компаниудтай худалдан авалтыг нь тэр усных нь гэрээ төлбөрийг нь хийгээд, энийг зах зээлийнх нь замаар улсын төсөв дээр өр зээл олон зүйлийг нь нэмэхгүйгээр л бид нар явуулах арга барил, арга хэрэгслүүдийг боломж бололцоог эрэлхийлэх л ийм л нөхцөл байдал байгаа юм. Тэгээд бид нарын хувьд бүхий л зүйлүүдийг арга барилын хувьд төр л бүгдийг хийх ёстой. Санхүүжилт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Цогтгэрэл гишүүн санал хэллээ. Төсөвтэй холбоотойгоор. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Шишүүддээ энэ оройн мэнд хүргэе. Өнөөдөр бид нар 2025 оны төсвийн тодотголыг хэлэлцэж байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор төсвийн урсгал зардалтай холбоотойгоор асуулт, санал хэлье гэж бодсон юм.

Тэгээд Засгийн газраас төрийн албаны орон тоог 2026 онд 9 хувь бууруулна гээд зарлачихсан. Тэгээд энэ 2025 оны төсвийн тодотгол хийж байгаатай холбоотойгоор энийгээ хэрэгжүүлээд явна гэж бас Сангийн сайд мэдэгдсэн. Тэгээд яах аргагүй бол төрийн алба данхайсан. Төр хамгийн том ажил олгогч болчихоод байгаа нь бол үнэн. Гэхдээ бид нар бас энийг танаж болно. Бас ингээд жоохон бодлоготой явахгүй бол бүх салбарт очоод танайх орон тоогоо тэдэн хувиар тана гээд хэлж байгаа нь ер нь ямархуу үр дагавартай байдаг юм бол доо л гэж бодож байгаа юм. Тэгэхээр надад ийм бас юу байгаад байгаа юм. Аймгуудын Засаг дарга, Тамгын газрын бүтцийг Засгийн газрын тогтоолоор баталдаг байгаа. Хамгийн сүүлийнхийг нь 2025 оны 1 сарын 29-ний өдөр баталсан. Тэр дээр одоо хэрэгжиж байгаа бүтцээс харахаар маш олон хийдэл, давхардлууд бас байна гэж анзаарагдаад байгаа юм. Жишээлбэл, аймгийн ЗДТГ-т Төрийн захиргаа, удирдлагын хэлтэстэй хууль, эрх зүйн хэлтсийг бол нийлүүлчхэж болмоор л юм шиг. Салбарын хяналт зохицуулалтын хэлтэстэй Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийг бас нийлүүлж болмоор. Соёл урлаг, аялал жуулчлал залуучуудын газартай Биеийн тамир, спортын газрыг бас нийлүүлж болмоор. Хүнс, хөдөө аж ахуйн газартай Мал эмнэлгийн газрыг, Улсын бүртгэлийн хэлтэстэй Архивын хэлтсийг, Нийгмийн даатгалын газартай Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг, Орон нутгийн өмчийн газартай Худалдан авах ажиллагааны газрыг нэгтгэх гээд маш олон аймгуудаар дүүрэн ийм жижиг агентлагийн дарга нар бий болсон л доо. Тэгээд энийг дагасан бас урсгал зардлууд явж байдаг. Эндээс бас бодит хэмнэлт гарах боломж байна л гэж харж байгаа юм. Тэгээд яг орон нутагт бол үнэндээ ажил нугалдаг ер нь цөөхөн хүн байдаг шүү дээ. Маш цөөхөн хүн байдаг. Тэгтэл маш олон дарга нар тэнд бий болчихоод байгаа юм. Одоо тэгээд нэн хэрэгцээтэй тэр газрын даамал, эмч, багш гээд маш их дутагдалтай хүмүүс байгаа. Тэр дээрээ яаж илүү анхаарах вэ гэдгээ орон нутаг дээр бас бодвол их зүгээр байгаа юм.

Тэгээд 2-т нь би энэ Боловсролын зээлийн сангийн журмыг шинэчлэх ажлын хэсэгт нь орж ажилласан юм. Тэгээд өнөөдөр энэ Боловсролын зээлийн сангийн сонгон шалгаруулалт болоод, битүү хэл ам болж байх шиг байна. Тэгээд Монгол Улс нэг талдаа бодлого гаргачхаад, дэлхийн топ 100 их сургуульд тэнцсэн хүүхдүүдээ явуулна гээд бодлого гаргачихсан. Гэтэл төсвөөсөө болоод тэр хүүхдүүдээ явуулж чадахгүй. Одоо ингээд өөр янз бүрийн журмаас гадуур эрэмбэлээд, бөөн хэл ам үүсгэж байгаа байхгүй юу. Үнэхээр Монгол Улс бодлого гаргачихсан юм бол тэрийгээ хэрэгжүүлэх төсвөө Засгийн газар олдог баймаар байна. Энэ дээр бас Ерөнхий сайдын бодлыг авмаар байна. Уг нь энийг бид нар хэрэгжүүлээд явах ийм нэн чухал бодлого гэж хувь хүнийхээ хувьд бол боддог юм.

Х.Булгантуяа: Хэн хариулах вэ. Бямбасүрэн гишүүний асуултад Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Боловсролын зээлийн сантай холбоотой жишээ нь энэ жилд 124 тэрбумын төсөвтэй үүнээс бол 33 тэрбумыг нь өөрсдөө буцаан төлөлт, бусад хандив, бусад эх үүсвэрээс цуглуулах ийм үүрэг хүлээсэн байдаг. Тэгээд энэ жилийн тухайд 74 хүүхдийн квоттой байгаа. Тэгээд аль болохоор энэ төсвөө хүргэх ийм бодлого барьж байгаа. Ингээд тэр шалгуулсан сургуульдаа урилгаа авчихсан, бичиг баримтын бүрдэл нь бүрэн байгаа ийм шалгуулагчдын тухайд бол асуудалгүй бүгдийг нь оруулах ийм бодлого барина. Харамсалтай нь бичиг баримт нь яг дутуу байх, үндсэн ангид нь ороогүй байх ч гэдэг юм уу иймэрхүү асуудлууд бас байдаг.

Тэгэхээр ийм 1 зүйл байгааг бас анхаарах хэрэгтэй. Цаашдаа бид нийтдээ 14 мянган хүний мэдээллийг Монголбанканд хүргүүлсэн. Ингэснээр бол эргэн төлөлт сайжирсан гэдгийг бол хэлье. Ноднин жил 14.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлт орж ирж байсан. Энэ жил хагас жилийн байдлаар 6 сар гэхэд 8 тэрбум гарчхаад явж байна.

Тэгэхээр энэ жил бол арай түлхүү эргэн төлөлт нь нэмэгдэнэ гэж харж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бас асуудал бас их хурцаар тавигддаг. Энэ дээр энэ жил бол нэлээн олон иргэн хүсэлтээ өгсөн. Тэгээд энэ болгонд нь өөрөө цаанаа хуулийн заалттай. Аль болохоор хүргэж, аль болохоор яг асуудалгүй, бичиг баримт нь одоо бүрэн байгаа хүмүүст бол тэнцэх гэдэг юм уу, тэтгэлгийг нь олгох ийм бодлогыг барьж байгаа. Бид ер нь цаашдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуулийн 1 заалт байдаг. Энэ хууль дээр бас тодорхой хэмжээнд ярилцаж, энэ дээр жоохон өөрчлөлт оруулахгүй бол цаашдаа төсөв арай дийлэхгүй ийм хэмжээнд хүрэх юм байна лээ. 1 хүн бүрэн сурахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол буцаан төлөх үүрэг хүлээхгүй, бүрэн тэтгэлэг хэлбэрээр суралцдаг. Тэгэхэд ойролцоогоор 4 жилдээ 1 тэрбум төгрөг болж байх жишээтэй. Ийм байдаг. Тэгэхээрээ зарим нь бол түрүүн хэлсэн. Тэр журмын шаардлага хангаагүй ийм тохиолдлууд бол ихэвчлэн үндсэн ангид нь ороогүй ч юм уу, хэлний бэлтгэлдээ суух, хэлний бэлтгэлтэй орж ирэх ийм зүйлүүдээс болж, бичиг баримтынхаа шалгалтын явцад хасагдаж байгаа тохиолдол гарч байгаа. Энэ жилийн Боловсролын зээлийн сангийн журамд бид өөрчлөлт оруулаад, урьд нь бол шилдэг 100, 50-д тэнцчихсэн байхад англи хэлнийх нь шалгалтыг давхар авдаг байсныг болиулсан. Хүнээс хамаарах янз бүрийн ийм шалгалт авдаг байсныг болиулаад, зөвхөн бичиг баримтынх нь шалгалтаар шалгаруулж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Бямбасүрэн гишүүний сая ярьсан асуудал яг үнэн. Үүнийг бид нар нэлээн тийм зоригтой, нэлээн ил тод ярих ёстой цаг болсон. 20 жилийн өмнө төрд ажиллаж байсан төрийн албан хаагчдын тоо, төрийн байгууллагын урсгал зардлыг 20 жилийн дараа өнөөдөр байгаа байдалтай бас харьцуулж, нэлээн том судалгаа хийж хармаар юм шиг байгаа юм. Дарга нарын тоо бол маш ихээр нэмэгдсэн. Төрийн байгууллага, төрийн байр, түүнийг дагасан урсгал зардлын хэмжээ бас асар их нэмэгдсэн. Ийм байгаад байгаа юм. Урьд нь таны хэлж байгаа орон нутагт аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд сая таны ярьж байгаа тэр олон агентлагууд бүгдээрээ багтдаг байсан. Бүгд багтаад 1 байшин дотор 3 давхар, 4 давхар байшинд. Одоо тэгвэл тэр сая хэлсэн байгууллага болгон чинь тус тусдаа байшинтай. Тэр тусдаа байрыг чинь дагаад хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааных нь зардал, урсгал зардал, тог цахилгаан, дулаан, харуул хамгаалалт, манаач, цэвэрлэгч гээд л .../минут дуусав/

Х.Булгантуяа: Бямбасүрэн гишүүн нэмж тодруулъя.

Ш.Бямбасүрэн: Би Боловсролын зээлийн сантай холбоотой ерөнхийдөө яг тодорхой л юм асуугаад байгаа юм. Ер нь маш тодорхой хариулаад сурчихмаар байна манай сайд нар. Төсөвтөө хязгаарлагдаад, нэмэлт журам гаргаад байгаа байхгүй юу ер нь. Бид нар ингээд Боловсролын зээлийн сангийн журмын төсөл дээр нэлээн сайн суугаад боловсронгуй болгосон юм. Гэтэл өнөөдөр яг тэр журмынх нь дагуу тэнцсэн хүүхдүүдэд нь төсөв хүрээгүйн улмаас өөр нэмэлтээр шаардлагууд тавиад байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ энийгээ ер нь цаашдаа ер нь яах юм

бэ л гэж би асуугаад байгаа юм. Ер нь манай Монгол Улсын Засгийн газар 1 гаргаж ирсэн бодлогоо уг нь хэрэгжүүлээд явчихмаар байгаа юм. Мөнгөний эх үүсвэрээ ямар нэгэн байдлаар олоод. Тэгэхгүй бол бид нар хүүхдүүдээ ямар юмаар уралдуулахаа мэдэхээ больчихоод байгаа байхгүй юу. Нөгөө журмынх нь дагуу маш олон хүүхэд тэнцчихээд байдаг. Тэгэхдээ бас энийгээ хэрэгжүүлмээр байдаг. Тэгтэл нөгөө төсвөөсөө болоод бид нар чинь хязгаарлагдмал болчихоод байгаа байхгүй юу. Энэ дээр бас би Ерөнхий сайдыг бас ер нь мөнгөө олж ирээд уг нь .../минут дуусав/

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулах уу. Маш их өндөр шалгуурууд байгаа. Түүнд нь хүүхдүүд тэнцэхгүй байна. Сургуульдаа тэнцчихээд байгаа мөртөө, мундаг, сайн сургуулиудад тэнцчихээд байгаа мөртөө Боловсролын зээлийн сангийн шалгуурыг хангахгүй байна. Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Энэ жилээс Боловсролын зээлийн сангийн журам нь өөрчлөгдөөд, ерөөсөө нэмэлтээр өөрсдөө шалгалт авахаа больчихсон. Одоо 100 хувь байлаа гэхэд 80 хувийг нь тэр цаад талаас ирсэн материал дээр нь үндэслээд, 20 хувь дээр нь өөрсдөө шалгалт авдаг байсан. Тэрийг нь бүр болиулчихсан. Тэгэхээр тэр дээр тэнцчихсэн хүүхдүүд бол явж болно гэсэн үг. 74 хүүхдийн квот байгаа. Ер нь ноднин жил бол бараг тэнцсэн, бичиг баримт нь асуудалгүй байсан хүүхэд болгон бол явсан. Энэ жилийн тухайд бол төсвийн хязгаарлалт байгааг бол үгүйсгэхгүй. Гэхдээ энэ яг дүн нь гараагүй байна. Энэ жил бол хэрвээ хасагдсан бол үндсэн материалынх нь шалгууртаа өөрсдөө материал нь дутуу байсан, эсвэл материал нь өөрөө асуудалтай байсан ийм л юмнууд байгаа. Зүгээр цаашдаа бид эргэн төлөлтийг нь сайжруулах замаар ер нь саналаа гаргасан, явахыг хүссэн бүхий л хүнд боломжийг нь олгохоор л ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа.

Д.Пүрэвдаваа: Оройн мэнд хүргэе. Ерөнхий сайдаасаа асуулт асуумаар байна. Таныг Ерөнхий сайдад нэр дэвшиж байхад би асуулт асууж байсан. Та санаж байгаа байх бараг. Үндэсний аудитын газраас хийсэн тайланд 2024 оны жилийн эцсийн аудитын дүгнэлтүүд гарсан. Тэнд дийлэнх яамнууд төсвийн ерөнхийлөн захирагч нар ялангуяа том том улсын үйлдвэрийн газрууд хязгаарлалттай дүгнэлт авсан. Та нэр дэвшиж байхдаа тэдгээрт хуулийн хариуцлага үүрүүлнэ гэсэн. Та дээрээс нь үнэн байна гэсэн. Миний хувьд бол энэ төсвийн тэлэлтээс болоод хохирогч нь энгийн төрийн албан хаагчид, бизнес эрхлэгч нар болж таарлаа гэж харж байгаа. Иргэд. 2024 оны төсөв 30 их наядаар тодотгож баталсан. Тухайн үед эдийн засгийн өсөлтийг 8 хувьтай байна. Өнөөдөр тараасан материал дээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 2.4 байна гэсэн. Энэ дээр буруу тооцоолсон этгээдүүд маань ямар хариуцлага үүрэв.

Дээрээс нь санхүүгийн сахилга бат, төсвийн сахилга бат зөрчсөн, үндсэндээ зөвшөөрөлгүй мөнгө үрсэн, эсвэл хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, хэтрүүлэн үрсэн этгээдүүд дээр ямар хариуцлага үүрсэн юм бэ. Дийлэнх сайд нар нь эргээд кабинетдаа ороод ажилласан. Өнөөдөр бизнес эрхлэгчдийн дансыг нь хааж байна.

Татварын ерөнхий газрын даргаас асуумаар байгаа юм. Ямар татварын асуудал үүссэн нөхцөлд дансыг нь хаадаг юм бэ. Урьдчилж хэлж болдоггүй юм уу. Хаах, хязгаарлах шийдвэр гаргахаасаа өмнө хэлэлцэх, зөвшилцөх, тохируулах, захиргааны арга хэмжээ авч болдоггүй юм уу.

Дараагийнх нь 1 санал байна. Оюутолгой тогтворжуулсан гэрээтэйд нь АМНАТ 5 хувь. 2009 онд гэрээ хийж байхад зэсийн баяжмалын үнэ ямар үнэтэй байсан бэ. Өнөөдөр бол 9 мянган доллар гараад явчихсан. 5 хувь алдаж байгаа. Жилийн борлуулалтын орлогыг 5 тэрбум доллароор төсөөлөх юм бол бид нар авч болох ёстой, жилд 250 сая доллар авах боломжтой гэж харж байгаа. Дараа нь тодруулъя.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд эхлээд хариулъя.

Г.Занданшатар: 2024 оны аудитын дүгнэлт өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байна. Ингээд Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд тодорхой дүгнэлтүүд гарсны дараа энэ хуулиараа хязгаарлагдмал дүгнэлт авсан бол хэрвээ захиргааны зөрчил гэж үзвэл залруулах, хариуцлага тооцох, эрүүгийн шинж чанартай бол АТГ луу шилжүүлдэг. Ийм учраас би тэр хариултыг хэлсэн. Үнэн байна гэдэг бол үнэнийг хэлж байна л гэдгийг хэлж байгаа юм. Хэцүү, хүнд байгааг нуухгүй гэдгээ л хэлж байгаа юм. Ийм учраас одоо хэлэлцэж байгаа энэ аудитын дүгнэлтийг ер нь энэ хязгаарлагдмал дүгнэлтүүд, олон их наядын зөрчил дутагдлуудыг ярьж байна. Энэ асуудлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэх болно. Энэ бол Авлигатай тэмцэх газарт эрх зүйн зөрчилтэй актууд бол шилждэг. Түрүүчээсээ шилжиж шалгагдаж байгаа асуудлууд байгаа юм билээ. Мөрдөн байцаах ажиллагааны нууцтай холбоотой асуудлууд ил тод болсны дараа энэ талаар тодорхой мэдээлэл өгнө.

Ер нь энэ бизнес эрхлэгчдийн дансыг хаадаг Татварын ерөнхий газартай бол татварын реформоор энэ хуулийг өөрчлөх хэрэгтэй байгаа юм. Татвар төлөөгүй бол мэйлээр мэдэгдсэн болоод, уг нь бол сонсох ажиллагаа хийгдэх ёстой. Мэдэгдэх ёстой. И-мэйлээр сонсох ажиллагаа хийгдсэн болоод, мэйл явуулчихаад, тэгээд хаачихдаг гэсэн ийм гомдол бизнес эрхлэгчдийн дундаас их ирж байгаа. Үүнийг татварын процессын хууль, татварын реформын хүрээнд шийдвэрлэх ёстой. 1 талаасаа татвар төлүүлэхийн тулд тэгж байгаа гэж байгаа боловч, татварын хуулийн шаардлага нь ийм гэж тайлбарладаг юм билээ. Ийм учраас татварын хувь, хэмжээг бууруулахаасаа гадна татварын процесс, хүнд суртал, чирэгдэл, дарамт шахалтуудыг бас цэгцэлж ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай гэсэн ийм санал, дүгнэлттэй байгаа. Үүнийг Татварын хууль, татварын реформыг өргөн барих үеэрээ хэлэлцүүлнэ. Гэхдээ төр бол өөрөө албадлагын машин. Төр буй дор татвар буй гэж бий. Татвар мэдээж шахалт, шаардлага, хуулийн хүрээнд төлөгдөх ёстой. Ийм учраас энэ 2-ын тэнцвэр, үнэн бодит байдлыг хангаж ажиллах ёстой. Татвараас зайлсхийх явдал түгээмэл байгаа. Би Засгийн газарт ажиллаж байх үедээ Оюутолгой дээр яагаад татвар тавигдахгүй байсныг тэр 1 их наядын татварын актыг би тавиулж байсан. Тэгэхдээ өнөөдөр хүртэл шийдээгүй. Олон улсын арбитрт хандчихаад, 9 сард энэ асуудал шийдэгдэхээр байгаа юм билээ. Гэхдээ манайх дундын насанд байх ёстой 1 их наяд төгрөгийг нь аваад зарцуулчихсан. Иймэрхүү харилцаа ийм хамгийн том татвар төлөгч дээр гарч байгаа харилцаа нийт бизнес эрхлэгчдэд түгээмэл байгаа ийм татварын хүнд суртал, чирэгдэл татварын хууль тогтоомжтой холбоотой асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Энийг Татварын хуулийн талаар Улсын Их Хурлын гишүүдтэй тодорхой хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, та бүхний саналыг авч ажиллах болно. Татвар ч тэр, аудитын гүйцэтгэлийн тайлан ч гэсэн Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэгдэнэ.

Х.Булгантуяа: 4 номерын номерын микрофоныг нэмж өгье.

А.Энхболд: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газрын дэд дарга Энхболд. Аж ахуйн нэгж татварын тайлангаа гаргана. Татварын тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор, НӨАТ-ын тайлангаа дараа сарын 10-ны өдрийн дотор төлөөгүй тохиолдолд татварын өр тооцно. Татварын нэхэмжлэлийг хүргүүлнэ. Хүргүүлснээс хойш 30 хоногийн өдөрт нэхэмжлэл хүргүүлнэ. Цахим хаягаар хүргүүлнэ. Нэхэмжлэл бол 10 өдрийн дотор төлөх талаар дурдах ба төлөөгүй тохиолдолд өр хураах үйл ажиллагаа хийнэ. Энэ жил татварын алба маань зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлж байгаа. Энийг аль болох татварын төлөгчийг эрсдэлд оруулахгүйн тулд зөвлөн туслах үйл ажиллагаа эрхэлж байгаа. Ер нь бол татвар төлөгч 1 жилийн хугацаа буюу хугацааны татвараа төлөх хөнгөлөлт үзүүлдэг.

Х.Булгантуяа: Пүрэвдаваа гишүүн нэмж тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Оюутолгойн талаар та тодорхой хариулт, байр сууриа илэрхийлсэнгүй.

Дараагийн зүйл нь юу гэхээр хариуцлагын асуудал. Нөгөө Эдийн засаг, хөгжлийн яамны оруулж ирсэн тоон мэдээ чинь маш зөрүүтэй байгаа. Хохирогчид нь 14 мянган төрийн албан хаагч, дээрээс нь төрийн захиргааны албан хаагч чинь 10 хувь нь байгаа. 22 мянган хүн. Төрийн тусгай албан хаагч 20 хувь байдаг юм байна гэж ойлгосон. Багш, эмч нийлээд 70 мянга орчим байгаа гэж ойлгосон. Аль салбараас нь 14 мянгыг хасаж байгаа юм бэ. 9 хувилж тэгшитгэж хасаж байгаа бол бас маш их хийдлийг үүсгэх байх гэж харж байгаа.

Дээрээс нь Хэмнэлтийн тухай хууль зөрчсөн олон тооны хөрөнгө оруулалтууд энэ төсөл дотор тусгагдсан байна. Жишээгээр дурдваас тоног төхөөрөмж Онцгой байдлын газар 16 тэрбум, ШУА 4 тэрбум, ГЕГ 9 тэрбум, Татварын ерөнхий газар 6 тэрбум төгрөгийн .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Ер нь Ерөнхий сайдын байр суурь бол тодорхой илэрхийлсэн. Санхүүгийн сахилга батыг зөрчиж, төсвийн хөрөнгийг үрэгдүүлсэн албан тушаалтнуудад хуульд заасан хариуцлагыг хатуу хэрэгжүүлж, шаардлагатай бол албан тушаалаас нь чөлөөлөх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна гэсэн. 2024 оны аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллага, албан тушаалтнуудтай холбоотойгоор Ерөнхий сайдын байр суурь бол санхүүгийн сахилга, тайлагналыг ил тод, чанд мөрдөхийг үүрэгдэж, хариуцлага тооцохдоо санхүүгийн зөрчлийг засаж залруулах, хугацаа өгөх, заасан хугацаанд биелүүлээгүй бол сахилгын шийтгэл, шаардлагатай албан тушаалаас чөлөөлөх, хуулийн байгууллагад шилжүүлэх зэрэг шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж мэдэгдсэн. Ер нь төрийн албан хаагчдын хувьд бол маш тодорхой шүү дээ. Би маш тодорхой тоонууд энд явж байгаа. 28 хороод, 9 сан, тэдгээрийн дарга бүх яамнууд өөрсдийн санаачилгаар үүрэг даалгавар өгөөд, бид Засгийн газар дээр ярьж шийдэж байгаад .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайдад нэмж минут өгье.

Г.Занданшатар: Эхний ээлжид бол дарга нарын тоог цөөлсөн. Жишээлбэл, Эдийн засаг, хөгжлийн яам 28 газар, хэлтсийн даргатай байсан. Бүх яамдад

стандарт тогтоож, дарга нарын тоог цөөлсөн. Мэдээж энэ чинь 14400 хүрэхгүй. Тэрийгээ дагаад тэр даргад үйлчилдэг байсан Үндэсний хороод, сан, зөвлөл гэх мэт олон шат дамжлагууд буурсан. Тэгээд эхний ээлждээ 6 мянган аваагүй байгаа орон тоог цомхотгож байгаа байхгүй юу. Оны эцэс хүртэл миний дахин давтан хэлээд байгаа төрийн албан хаагчдын үнэлгээ явуулах журмын дагуу төрийн албан хаагчдын аттестатчилал буюу үнэлгээ явуулж шийдвэрлэнэ. Учир зүггүй бүгдийг нь тоо өгөөд шугамдаж байгаад тайраад байгаа юм байхгүй. Ер нь бол энэ хүрээндээ Сангийн яамнаас тодорхой санал, судалгаануудыг төрийн албан хаагчдаас авсан зүйл байгаа. Ингээд илүү тодорхой зүйлийг Сангийн сайд хариулна. Эдийн засгийн яам 14400 гэдэг бүтээмжийн судалгаа хийгдсэн. Бүтээмж, чиг үүрэг, давхардлын судалгаанууд хийгдэж байж энэ .../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос ажлын хэсэг нэмж хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны батлагдсан төлөвлөгөөнд бол төрийн албан хаагчдыг 9 хувиар бууруулах, үүнд багш, эмч орохгүй гэсэн ийм төлөвлөгөө батлагдсан байгаа. Яг энэ дагуу бол төрийн захиргааны албан хаагчдыг 10 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчдыг 9 хувь, төрийн тусгай албан хаагчдыг 25 хувиар цомхотгох ийм тооцоолол бол байсан. 2025 оны төсвийн тодотгол дээр Сангийн яам, Засгийн газар энэ арга хэмжээг оруулж ирэхдээ багш, эмчээс бусад төрийн албан хаагчдыг 9 хувиар буюу төрийн захиргааны албан хаагчдыг 2.9 мянга, төрийн тусгай албан хаагч 9 хувь буюу 1.5 мянга, төрийн үйлчилгээний албан хаагч 8.2 мянга, улс төрийн албан хаагч 186 гээд 12.8 мянган мянган орон тоог бууруулахаар төслийг оруулж ирсэн.../минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Энэ дээр 14.4 мянга, 12.8 мянга гэсэн ийм 2 зөрүүтэй тоо явж байгааг бас тайлбарлах нь зүйтэй байх. Хууль зүйн салбар бол яг төсвийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлсний дараагаар бол бид яг энэ жилдээ орон тоог бол ийм олноор нь бууруулах бас үе шаттайгаар энийгээ хэрэгжүүлэх нь зөв юм гэсний үндсэн дээр хууль зүйн салбарын бууруулах орон тоог бол цөөлсөн. Тэгэхдээ яг энэ орон тоог бууруулсантай холбоотой буцаж байгаа цалингийн сантай дүйцэхүйц хэмжээний өөр зардлыг хууль зүйн салбараас бууруулаад, яг энэ хууль зүйн салбараас бууруулах нийт дүнгийн хэмжээ бол өөрчлөгдөөгүй байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Оройн мэнд. Төсвийн байгууллагуудын урсгал зардал бол ямар ч баталгаагүй ийм л асуудалтай л юм шиг л харагдах юм даа. Одоо жишээлбэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой 5 зардал хасахаар оруулчихаад байгаа байхгүй юу. Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэл ерөнхий газрынх, хүүхдийн сэргээн засах төв дээр 1.1 тэрбумыг зардал хасахаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв орон нутагт 1.3 тэрбум гээд би багцаалж байна. Ингээд хасагдчихаад байх юм. Тэгэхээр энэ ямар шалтгаанаар хасагдчихав. Юу нь хасагдчихав гэдэг асуудал дээр манаач шиг асууж тодруулахгүй бол ерөөсөө болохгүй байна. Аягүй бол хэсэг хугацааны дараа нөгөө хүнд байгаа хүүхдүүдэд зориулсан эмчилгээ, зарим нэг үйлчилгээ нь тасалдаад л ирвэл энэ чинь маш хэцүү. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол

манай улсын сэхээнд байгаа хүн ам мөн шүү дээ. Энэ асуудал дээр тодруулмаар байна.

2 дахь асуудлыг болохоор Эрүүл мэндийн яамнаас тодруулмаар байгаа юм. Энэ зардлын таналтын хувь гэдэг юм уу, энэ зардал нийгмийн эрүүл мэнд рүү чиглэсэн нь хэдэн хувь хасагдаж байгаа вэ. Одоо жишээлбэл нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ хамгийн бас эмзэг үйлчилгээ байгаад байдаг. Тэгэхээр бас л хэдэн хувь нь жин дарж хасагдаж байгаа гэдэг тодорхой мэдээлэл, дараа нь яах юм бэ гэдэг асуудал байгаа. Бид нар чинь нийгмийн эрүүл мэндийн хуулиа бүр хэрэгжүүлээ ч үгүй, одоо тэгээд бүүр үндэсний хороо ч байхгүй, нөгөө үндэсний хороо нь хуралдаа ч үгүй, төлөвлөгөөгөө гаргаач үгүй, стратеги ч байхгүй ийм байгаа шүү дээ. Одоо яана гэдэг. Энэ дээр сайдын байр суурийг сонсмоор байна.

3 дугаарх нь Боловсролын сайдаас асууя. Төрийн өмчийн сургуулиудын урсгал зардалд тогтмол зардал зогсож байгаа юм байна. Таналтаар гэж ойлголоо. Анагаах дээр жишээлбэл тодотгол дээр ч харагдаж л байна. Тэгэхээр цалинг энэ чинь тэгээд тогтмол зардал нь хасахаар чинь цалин нь хасагдана гэсэн үг. Эсвэл тэрийгээ сургалтын төлбөрөөрөө зарцуулна гэсэн ийм чиглэлтэй гэсэн байх юм. Тэгэхээр 1 бол оюутны төлбөр нэмэгдэх хэрэгтэй болно. 1 бол багш нарын цалинг хасах хэрэгтэй болно гэдэг ийм юм руу орох юм уу. Ийм сонголт ирж байгаа юм байна гэдгийг ерөөсөө бичээд байна л даа. Тэгэхээр энэ дээр мэдээлэл өгөөч. Энэ яг юу болж байна вэ.

Х.Булгантуяа: Эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир. Тэгээд Эрүүл мэндийн сайд хариулъя.

Т.Аубакир: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Манай яамны хувьд 2025 оны батлагдсан төсвийн урсгал зардал 4.4 их наяд төгрөг. Үүнээс 32.6 тэрбум төгрөг хасагдсан. Нийт зардлын 0.7 хувь болж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын төсвөөс 5.7 тэрбум төгрөг хасагдсанаас орон тоо 9 хувиар буурууллаа гэж тооцоход 1.1 тэрбум төгрөгийн зардал хасагдаж байгаа юм. Яах вэ бас гишүүд санаа зовоод хэлээд байх шиг байна л даа. Нийтдээ улсын хэмжээнд 14400 хүнийг одоо яг ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг хасчих болов уу гэж. Жишээлэхэд манай салбар дээр 541 хүний ажлын байр цомхотголд орж байгаа. Гэтэл үүнээс 420 сул орон тоо байж байгаа. Мөн энэ ондоо тэтгэвэрт гарах мэдэгдлээ өгчихсөн 120 гаруй хүн. Ингээд үндсэндээ 541 хүнийхээ тоог барьчихаж байна гэсэн үг. Тийм учраас эдгээр хүмүүсийн урсгал зардал, цалин, шимтгэл гээд тодорхой хэмжээнд зардлууд буурч орж ирж байгаа. Яг үүнтэй адилхан хөгжлийн бэрхшээлтэй агентлагаас бас яг 9 хувиар бодоход сул орон тоо нь гээд тооцож үзэхэд 1.1 тэрбум төгрөг хасагдчихаж байгаа юм. Ерөнхийдөө хасагдсан зардлууд бас зүй ёсны хасагдах ёстой зардлууд л байгаа юм л даа. Жишээлэх юм бол их засварыг бол энэ тодотгол дээр энэ удаа тэвчье гэсэн. Тийм учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлаг дээр энэ мөнгө маань яг хасагдаж орж ирж байгаа. Энэ дээр би бас санаа зовоод, манай яамныхан маань бас Сангийн яамтай тэр өдөртөө шөнөжингөө сууж ажилласан байж байгаа. Энэ дээр 1 зардал та сая хэллээ. Аймаг дээр 1.3 тэрбум гэж. Энэ дээр хараагүйчүүдийн үйлдвэрийн их засвар саяын 1.3 тэрбум төгрөгт ороод явчхаж байгаа юм. Мөн Хэмнэлтийн хуулийн 13.1.1-тэй холбоотой тендер нь зарлагдаагүй, амжаагүй байсан хөрөнгө оруулалт татагдаж байгаа. Энэ маань 871.4 сая төгрөг. Одоо таны сая асуусан асуулт дотор гэх зэргээр бид нар бол яг одоо үйл ажиллагаа явуулж байгаа тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ агентлагаас, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил

бусад янз бүрийн юманд зориулсан төсвөөс бол ерөөсөө бодитойгоор хасагдаагүй. Сая орон тооны хэмнэлт, мөн тендер нь зарлагдаж амжаагүй хэмнэлтийн хуулийн дагуу гэх зэрэг зүйлүүд хасагдсан байгаа учраас Саранчулуун гишүүн ээ санаа зовох зүйл бол байхгүй. Агентлагийнхантай би уулзсан. Мөн Сангийн яамныхантай манай яамныхан очиж ажилласан байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Чинбүрэн сайд нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Ер нь бол өнгөрсөн парламент Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль баталсан. Одоо бас Ерөнхий сайд байж байна. Бид ажлаа аваад, Засгийн газар байгуулагдаад ердөө 10 хонож байгаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуульд заасан хамгийн чухал зүйл бол Үндэсний нийгмийн эрүүл мэндийн зөвлөл байгуулагдах ёстой. Энэ ажлаа яаравчлаад хийнэ. Төсөвт ойролцоогоор 33 тэрбум төгрөг хасагдсан. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа. Аз болоход эрт илрүүлгийн төсөв хасагдаагүй байгаа. Эрт илрүүлэг хийдгээрээ 40 тэрбумаараа хийдгээрээ хийнэ. Энэ хасагдсан юмнуудаа харахаар голдуу тандалт судалгаа, ерөөсөө л түрүүн бас Ганмаа гишүүн ярьсан. Өвчин судлалын төв буюу CDC-гийн үйл ажиллагаа, өвчлөлийг тандах, судлах, дээрээс нь судалгааны ажлууд давхацсан, бас гэмтэл согог, хавдар судлал, халдвартын тандалтын төсвүүд энэ тэр гээд хасагдсан. Харин сүүлийн 1 том .../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд нэмэлт 1 минут тодруулж болно.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр бас 1 чухал зүйл бол улаан бурхантай холбоотой 10 тэрбум төгрөг нэмээд тавьсан. Засгийн газрын нөөц хөрөнгөөс 5 тэрбум, нийтдээ 15 тэрбум бас орчхоод, ямар ч байсан энэ олон нийтийг хамарсан өвчлөлтэйгөө тэмцэх санхүүжилт бол ямар ч байсан хангалттай болоод 9 сарын 1 гэхэд нөхөн вакцин хийлгэх ёстой 240 гаруй мянган хүүхдүүдээ хичээл, сургууль ороход вакцинтай оруулчих ийм боломж бүрдэхээр байгаа.

Х.Булгантуяа: Жавхлан сайд нэмж хариулах юм шиг байна. Наранбаяр сайд. Дэгээрээ ингэх нь байна шүү. Саранчулуун гишүүн та эхлээд нэмж тодруулж асуух хэрэгтэй 4 минут, 1, 1 байхгүй юу. Тэгэхээр Чинбүрэн сайд 2 удаа 1, 1-ээр хариулчихсан. Саранчулуун гишүүн нэмээд тодруулчихъя. Тэгээд Наранбаяр сайд хариулъя.

О.Саранчулуун: Төрийн өмчийн их дээд сургуулийн зардалтай асуудал яригдаж байгаа. Энэ дээр цалин, оюутны байр гээд яг энэ төрийн өмчийн сургууль дээр л нэлээн хүнд ачаа орж ирэх гээд байна. Энэ дээр тодруулж, тайлбар хүсэж байна.

Х.Булгантуяа: Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

П.Наранбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн өмчийн их, дээд сургуулийн байр ашиглалтын төлбөрийг төсвөөс төлөхийг зогсоож, өртгийг нь төлбөрт шингээх гэсэн байдлаар бас чиглэл нь орж ирсэн. Нийтдээ 7 их сургууль, МУИС, ХААИС, МУБИС гээд голлох 7 төрийн өмчийн их сургуульд нийтдээ 13 тэрбум төгрөгийн байр ашиглалт тогтмол зардал дээр нь тавигдсан байсан нь болохгүй болж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр тэр сургалтын төлбөрөө бол тухайн сургуулиудын Удирдах зөвлөл нь өөрөө хариуцдаг. Нэмэх эсэхийг бол өөрсдөө

хариуцаж явдаг. Тэгэхээр энэ тооцоогоо одоо хийж, сургалтын төлбөрөө нэмэхээс өөр аргагүй байдал руу бас орох байх гэж зарим хэсэг нь бол. Ер нь багшийн хөгжил, судалгаа шинжилгээний зардлууд бол нэлээн дутмаг байдаг. Тэгээд ер нь энэ ректорууд, их сургуулийн талаас бол яг хагас жилээрээ ядахдаа авмаар байна гэсэн ийм юм байгаа.

Х.Булгантуяа: Нэмэлт 1 минут.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ дээр бас хагас жилээр нь энэ зардлаа аваад, үлдсэнийг нь төсвийн тодотголд оруулж болохгүй юу гэсэн ийм бас дуу хоолой нэлээн байгаад байгаа. Энэ дээр бас Сангийн яамны зүгээс тодруулаад хэлээд өгвөл их сайн байна.

Нөгөө талдаа бол бас олон улсын гэрээгээр хүлээчихсэн Монгол-Японы эмнэлгийн төрөөс олгох татаас, мөн Монгол-Германы технологийн их сургуулийн бас татаасны асуудал ч гэсэндээ нэлээн хүндэрч байгаа. Монгол-Германых бол 570 сая төгрөгөөр ахиад буурч байна. Монгол-Японы эмнэлэг бол ахиад 1 тэрбум гаруй төгрөгөөр бас татаас нь буурч орох гээд байгаа. Тэгэхээр энэ олон улсын гэрээ хэлэлцээр хүлээчихсэн үүрэгтэй ийм газрууд дээр бас бид сайн ойлголцож явах ийм шаардлага бас гарч байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: Нэгэнт төсөв ярьж байгаа учраас Засгийн газрын нийт өр зээлийг бас зайлшгүй ярих шаардлагатай. Тэгэхээр Засгийн газрын нийт өр 33.4 их наядад хүрсэн байна. 8, 9 жилийн өмнө бол энэ тоо 20 орчим их наяд байсан санагдаж байна. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд эдийн засгийн өндөр өсөлттэй үед түүхий эдийн үнэ хамгийн өндөр байх цаг үед бид нар бол өр зээлээ бууруулаагүйгээр үл барам 2 дахин нэмэгдүүлчихсэн сууж байна. Тэгээд энэ жилийн хувьд болохоор 2025 оны төсөвт 1.5 их наяд төгрөгийн гадаад зээлийн ашиглалт ороод ирчихсэн явж байгаа. Нэмээд 1.5 их наяд буюу 500 сая долларын бонд нийслэлээс гарчихсан явж байгаа. Тэгэхээр эхний асуулт Ерөнхий сайд маань энэ өрийн удирдлагын асуудлаа ер нь юу гэж харж байна. Бид ер нь цаашид энэ зээлийн үйлчилгээний төлбөрт бараг 2 шахам их наяд төгрөг төлдөг болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ өр зээлээ бууруулах бодлого дээр ямар бодлого барьж байна.

Тэгэхээр энэ жилдээ болохлоор 3 их наяд төгрөгийн өр нэмж тавьж байна гэж байгаа шүү дээ тийм үү. Яах вэ, энэ мөнгө хэрэв эдийн засгаа тэлэх, дотоодын аж ахуйн нэгжүүдээ томруулах, ажлын байр бий болгох, татварынхаа бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлд зарцуулагдаж байсан бол бас болж байгаа юм. Гэтэл сүүлийн жилүүдэд тавигдаж байгаа өр зээл бол ерөөсөө хувийн хэвслээ дэмжих битгий хэл ер нь тодорхой салбаруудыг боомилох бодлогод зарцуулагдаад байна гэж харагдаж байгаа юм. Тухайлах юм бол барилгын салбарт төрийн оролцооны улмаас маш олон гажуудал сүүлийн жилүүдэд үүсэж байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эксим банкнаас 5 мянган айлын орон сууцын Солонго 1, 2 гэдэг төсөл хэрэгжээд явж байгаа. Энэ төслийн нийт өртөг нь болохоор 912.9 тэрбум төгрөг байгаа. Тэгээд төр болохоор гадаадаас ийм хөнгөлөлттэй нэртэй зээл аваад, тэгээд гаднын аж ахуйн нэгж төслийн ерөнхий гүйцэтгэгчээр шалгараад, тэгээд зээлийнх нь нөхцөл нь болохоор хөнгөлөлттэй мэт байвч гадаад аж ахуйн нэгж төслийн ерөнхий гүйцэтгэгч, дотоодын аж ахуйн нэгжүүдэд мөнгө төгрөгөө цаг тухайд нь өгдөггүй гэх мэт жил нь зөндөө олон асуудлууд ярьж байгаа. Тэгээд энийг үндсэндээ төр л

бариад байна гэсэн үг шүү дээ. Төр захиалаад тэгээд ийм орон сууц бариад байгаа юм. Үүнээс гадна бас Солонгосын Засгийн газрын зээлээр Баянголын аманд 2007 айлын орон сууц бас баригдана л гээд байгаа юм. Тэгээд тэр л бас мөн ялгаагүй нөхцөлтэй. Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд манай барилгын салбар бас хөл дээрээ босчихсон юм шүү дээ. Дотоодын тэр девелоперууд өөрсдөө төслүүдээ боловсруулаад, мөнгө төгрөгөө босгоод, том том хотхон орон сууц, хорооллууд барьдаг болчихсон. Гэтэл яагаад төр оролцоод, зээл тавиад, тэгээд гадаад компаниудыг ингэж шалгаруулаад яваад байдаг юм бэ. Үүнтэй холбоотойгоор саяын миний дурдсан нийслэлээс гаргасан 500 сая долларын бондыг мөн ялгаа байхгүй Шинэ сэлбэ .../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд хариулчхаад, тэгээд нэмье. Эхлээд Болдын Жавхлан сайд. Нийслэлээс хүн байсан уу.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. 2017, 2018 оны Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн дараа бид 3, 3 жилээр гадаад зээлийнхээ өрийн удирдлагын стратегийг батлуулдаг болсон байгаа. Өөрөөр хэлбэл гэрийн даалгавраа авч явдаг гэсэн үг. Яг тэрний дагуу бид 2 ч удаагийн стратегийнхаа даалгаврыг 6 жил өнгөрчхөөд байна. Үүний үр дүнд 2013 онд зээлжих зэрэглэлээ алдаж байсан бол 13 жилийн дараа буцааж, арайхийж тэр үзүүлэлт дээрээ очлоо. 2015 онд Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 91 хувь хүрч байсан. 91 хувь. 2024 оны гүйцэтгэлээр 41 хувь хүрлээ. 2015, 2016 онд гадаад зээлийн хүүгийн төлбөр дүн нь төсвийн дунджаар 10 хувь байдаг байсан бол 2024 оныхоор 3.9 хувь болж буурсан байгаа. Тэгэхээр зээлийн дүнг, зээлийн бодлого хэмжээндээ чухал биш. Хамгийн гол нь дотоодын нийт бүтээгдэхүүнд зээлж байгаа хувь хэмжээ болон зээлийн ашиглалт, үр өгөөж дээрээ л хамгийн чухал юм байгаа юм. Би түрүүн 1 сайн мэдээ хэлсэн байгаа. Өчигдөр Францын Парис Хотноо Ой Си Ди-ийн ээлжит хурал болоод, манай эрсдэлийн үнэлгээг 1 шатаар сайжруулсан байгаа. Энийг өнөөдөр бидэнд албан ёсоор мэдээллүүдээ авлаа. Тийм учраас сүүлийн жилүүдийн хувьд бол гадаад өрийн менежмент бол стратегийнхаа хүрээнд их сайн байгаа шүү. Энийг бид нар өөрсдөө дүгнэж байгаа биш, олон улс талаас, гадна талаас ингэж дүгнэж байгаа. Одоо энийгээ харин бид энэ эдийн засгийн сорилттой үед хэвээр хадгалах нь хамгийн чухал ийм зорилт болж ирж байна. Тэгээд өчигдрийн Парисын хурал бол бид нар намар зээлжих зэрэглэлүүдээ хамгаалахад бол маш их хэрэгтэй. Энэ удаагийн төсвийн тодотгол маань ч гэсэн намар бид зээлжих зэрэглэлүүдээ хадгалж үлдэхэд бол маш их хэрэгтэй ийм алхмууд болж ирж байгаа шүү.

Тэгээд сүүлийн жилүүдэд бид төсөл хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор бонд босгоогүй. Өндөр хүүтэй, богино хугацаатай ийм бондуудыг бол босгоогүй. Харин нийгмийн чиглэлийн болон бусад яг эдийн засагт үр өгөөжтэй, төлбөрийн тэнцэл дээр эерэг үр дүн авчрах нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гэх мэт зөвхөн яг ийм прожект файнанс дээр л бид нар гадаад зээлүүдийг авч байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Нийслэлээс байхгүй. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Бат-Амгалан.

Э.Бат-Амгалан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Төр ер нь яагаад хувийн хэвшилтэйгээ хамт зэрэгцээд гаднаас мөнгө босгоод орон сууц бариад байдаг юм бэ гэдэг ийм асуудал тавьж байна. Ер нь яах вэ зүгээр төрийн оролцоо бол ерөөсөө энэ хямд өртөгтэй, орлогод нийцсэн орон сууц барих ийм л гол бодлого

баримталж байгаа. Та бүр жишээ татаж ярилаа. Барилга, хот байгуулалтын яам дээр хэд хэдэн төслүүд явагдаж байгаа. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Ногоон нуурын тэнд 1008 айлын орон сууц энэ жил хүлээлгэж өгөхөөр амжилттай төсөл хэрэгжээд явж байна. Тэр Солонгосын Засгийн газрын дэмжлэгт .../минут дуусав/

Х.Булгантуяа: Бат-Амгалан сайдын микрофоныг нэмэлт 1 минут.

Э.Бат-Амгалан: Солонгосын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Солонго 1, 2 орон сууцын төсөл явж байгаа. Энэ маань бол ерөөсөө 40 жилийн хугацаатай, маш бага хүүтэй зээл явж байгаа. Тэгээд энэ дээр бол ерөөсөө л иргэдийн маань санхүүгийн боломж бололцоо харилцан адилгүй байгаа шүү дээ. Тийм болохоор төр энэ дээр орж, орлогод нийцсэн ийм орон сууц барих энэ чиглэл дээр явж байгаа. Та энийг бас зөв ойлгоорой. Мэдээж байршлаасаа шалтгаалаад, хотын төвд, хотын захад барилгын үнэ ямар байгаа билээ. Тийм болохоор энэ дээр энэ төслүүд нь эхнээсээ бас амжилттай явж байгаа гэдгийг бас хэлье.

Х.Булгантуяа: Жаргалан гишүүн нэмж тодруулъя.

Б.Жаргалан: Би зээлжих зэрэглэл асуугаагүй Жавхлан сайд аа. Зүгээр ер нь Засгийн газрын нийт өр чинь абсолют тоон утгаараа 2 дахин нэмэгдчихээд байна. Бид нар жил болгон зээлийн үйлчилгээний төлбөрт маш их хэмжээний мөнгө төлөөд байна. Тэгээд яагаад энэ өндөр өсөлттэй жилүүддээ тэрийгээ хийхгүй байсан юм бэ. Цаашид яах юм бэ гэсэн байгаа.

Саяын тэр метр квадратын асуудал дээр хямд өртөгтэй гээд байгаа чинь бас хямд өртөгтэй биш болчихоод байна. Энэ төслүүдийн чинь дундаж өртгийг нь бодоод үзэх юм бол 3, 4 сая төгрөг байгаа метр квадрат нь. Тэгэхээр хувийн хэвшлийн борлуулж байгаа үнээр та нар орон сууц бариад байгаа юм. Тэгээд Ерөнхий сайд сая томилогдохдоо барилгачидтай уулзсан. Ялангуяа энэ Шинэ сэлбэ дэд төв дээр зарлагдаж байгаа тендерүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүдийг оруулах тал дээр бодлого баримтална гэж бас хэлж байсан. Тэгэхээр энэ тал дээр та яг өөрөө хариулт өгөөч. Яагаад вэ гэхээр маш өндөр дүнтэй нийт 2 гаруй их наяд төгрөгийн төсөл хэрэгжиж байгаа. Тэгээд 20 хувьд нь л Монгол компаниуд оруулна гээд маш өндөр дүнтэй тендерүүдийг зарлаад, зарим нэг багц дээр нь Хятад аж ахуйн нэгжүүд шалгарчхаад байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ яах юм бэ.

Х.Булгантуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Жаргалан гишүүн ээ, таны асуултад нэмж хариулъя. Өрийн удирдлагын менежмент ярихаар зээлжих зэрэглэл л ярина шүү дээ. Эцсийн үр дүнг тэрүүгээр л хэмжинэ. Та тэрэнд эмзэглэх хэрэггүй ээ. Энэ чинь факт шүү дээ. Бид нар 13 жилийн дараа зээлжих зэрэглэлээ эргэж олж авлаа. Энэ бол маш үнэтэй байхгүй юу. 13 жил бид нар алдсан. Одоо энийгээ цаашаагаа бид нар хамгаалж явах хэрэгтэй. Тэгвэл энэ өрийн удирдлага улам сайжирна. Ийм л юм байгаа юм.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Г.Занданшатар: Батбаярын Жаргалан гишүүний өрийн удирдлагатай холбоотой асуултад эхлээд хариулъя. Энэ өр тооцдог аргачлал бас янз бүр байгаа юм. Манай энэ 100 гаруй орны эрсдэлийн үнэлгээг хийгээд, 3 орны эрсдэлийн үнэлгээг өөрчилсөн. Нөгөө country risk assessment classification. Тэр дотор бол

Сенегал, Бангладеш 2-ын зэрэглэлийг бууруулаад, Монгол Улсыг бол өндөр эрсдэлтэйгээс зээлийн эрсдэлийн үнэлгээг сайжруулсан цорын ганц улс болсон. Энэ дотор бас олон хүчин зүйл нөлөөлсний 1 нь жишээлбэл Монголбанкны свопыг Хятадын Ардын банкнаас авсан свопыг бид бол гадаад өрдөө тооцохгүй, таны наад тоонд чинь тооцохгүй яваад байгаа юм. Бид нар 6 тэрбум юань буюу бараг 1 тэрбум долларын өрийг бид Улсын Их Хурлаас чиглэл өгч төлүүлсэн юм. Энэ бол манай өр буурсан бодит жишээ. Харьцангуй өндөр хүүтэй, гадаад өрийн дарамт буурсан ийм бодит жишээ. Тэгэхээр энэ огт буураагүй, төлөгдөөгүй гэж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ерөнхий сайд гүйцээгээд хариулчихъя.

Г.Занданшатар: Өндөр хүүтэй зээлүүдийг restriction буюу deed restriction буюу хямд хүүтэй зээлээр сольсон өрийн удирдлагын менежментийн хувьд сайжруулсан үзүүлэлт байгаа учраас л энэ OECD-ийн “Country Risk Classification” гэдэг үнэлгээгээр 7 дугаар түвшин гэж хамгийн өндөр эрсдэлтэй түвшнээс 6 руу ингээд буурч байна гэж ойлгож болно.

Тэр барилгын хувьд бол би хэлсэн. Хотын даргатай ярьсан. Барилгачдын ассоциацитай туслан гүйцэтгэгчээр оруулах, барилгачдын холбоо нь арай жижиг үйлдвэрлэгчид нь дараагийн тендерт оруулахаар томоохон аж ахуйн нэгжүүдтэй нь тохирсон гэж Нямбаатар дарга хэлсэн. Цаашдаа орон сууцжуулалтын банк бол үндэсний барилгын компаниудыг дэмждэг ийм тусдаа тогтолцоо бий болгохоор ажиллаж байна гэж хэлсэн. Төлөөлөл нь ороод ажиллаж байгаа. Энэ талаар яривал их том дэлгэрэнгүй төсөл болох учраас жич ярих нь зүйтэй байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Төсвийн тодотголыг бол дэмжиж байгаа. Дэмжихийн дээдээр дэмжиж байгаа. Түрүүн ганц 2 гишүүд төсвийн тодотголыг 2, 3 хийчихлээ пүү паа гэж байна лээ. Төсвийн тодотголыг хэдэн удаа хийсэн ч болно. Тийм учраас төсвийн тодотголыг би дэмжиж байгаа. Зүгээр дахиад тодотгол хийх нөхцөл байдал үүсэх вий дээ гэж болгоомжилж байгаа. Бас тооцоолол, төлөвлөлт энэ тэрээ бас маш сайн хийсэн байх гэж Жавхлан сайдад найдаж байгаа шүү гэдгийг бас 1 дүгээрт хэлчихье.

2 асуулт байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас юм уу. Төрийн албаны зөвлөлийн дарга сая энд сууж байсан. Сая төрийн албан хаагчдын 9 хувь цомхотгоно гээд шугам татсан юм шиг юм ярилаа шүү дээ. Надад 1 ийм л санал байна. Сүүлийн 10 жилд төрийн албан хаагчдын тоо эрс нэмэгдсэн. Би 3 жишээ хэлчихье. Монголбанк жишээлбэл 10 жилийн өмнө 300 орчим ажилтантай байсан бол одоо 750 болсон явж байгаа.

Санхүү, эдийн засгийн яам гэж байсан. Хуучин Сангийн яам чинь Эдийн засгийн яамтай хамт байсан шүү дээ. Тэгэхэд 120, 130 хүн ажиллаж байсан. Одоо тус бүрдээ 160 хүн ажиллаж байгаа.

Манай Их Хурлын Тамгын газрынхан уучлаарай. Би 2006 онд Их Хурлын Тамгын газар ажиллаж байсан. Тэгэхэд 120 хэдүүлээ ажиллаж байсан. Одоо 300 хүн ажиллаж байгаа. Тэгээд энэ дүн шинжилгээ хийж үзсэн юм уу. Манай төрийн албаны зөвлөлийнхөн ер нь. Энэ ер нь яагаад нэмэгдээд байна. Эсвэл Их Хурлын ажил ингэж нэмэгдсэн юм уу. Эсвэл Засгийн газрын ажил ингэж огцом нэмэгдэв үү.

Эсвэл Монголбанкны ажил тэгж их хэмжээгээр нэмэгдэв үү. Энэ бодитой өсөлт үү, ямар өсөлт вэ. Энэ дээр Төрийн албаны зөвлөлийнхөн дүрэм журам батлаад суудаг юм уу, эсвэл ажлын байрны энэ зураг авалт хийж тодорхойлдог юм байна уу, үгүй юу. Энэ дээр хариулж өгөөч. Бас Хэрэг эрхлэх газрын дарга бас энэ дээр нэмж хариулж өгвөл их сайн байна гэж. Эхний асуулт нь ийм байна.

2 дугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд хэдэн хүн сууж байна. Улсын Их Хурлаас томилогддог, сүртэй байгууллага байна. Баахан эрдэмтэн, докторууд орсон. Тэгээд та бүхэн Засгийн газарт төсөвтэй холбоотой санал, дүгнэлтээ өгч байгаа юу. Өгч байгаа бол та бүгдийн үг энэ тэрийг авч байна уу, үгүй юу. Тэрийг бодитой хариулж өгмөөр байна. Хэрвээ авдаггүй бол ийм байгууллага байж суугаад ч хэрэг байхгүй. Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн та нар ямар хэмжээний санал, дүгнэлтийг Засгийн газарт гаргаж өгч байгаа. Та нарын үг энэ тэр ер нь энэ засагт нөлөөлж байна уу, үгүй юу гэсэн ийм 2 асуултыг асуучихъя.

Х.Булгантуяа: Эхлээд Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга Бямбацогт сайд хариулъя. Дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 номерын индэр дээр.

С.Бямбацогт: Алдаржавхлан гишүүн маш чухал асуудал хөндөж байна. Ер нь сүүлийн 20 жил юу гэдэг юм 2005 онд Монгол Улсын хүн ам 2 сая 500 гаруй мянга байсан. Өнөөдөр бол 3 сая 500 мянга болсон байгаа. Ингээд 20 жилийн хугацаанд аваад үзэх юм бол 40 хувиар өссөн байгаа. 40 хувиар. Тэгвэл төрийн албан хаагчийн тоо 2005 онд 120 мянга байсан. Өнөөдөр үндсэндээ бол 230 мянга шахуу хүрч байгаа. Үүнийг аваад үзэх юм бол 80 бараг 90 хувиар өссөн. 90 хувиар. Мөн бас төрийн албан хаагчдын авдаг цалин 2005 онд дунджаар 900 орчим мянга байсан бол одоо 2 сая 200 мянга болсон. Энэ дээр аваад үзэх юм бол бас 2.5 дахин нэмэгдсэн гэх мэтчилэн ерөөсөө нэмэгдээд л байгаа юм л даа. Энд төрийн албан хаагчдыг бас улс төрийн албан хаагч нь 2005 онд 2500 байсан бол 2025 онд 3800 болсон байгаа. Төрийн захиргааны албан хаагч 2005 онд 9400 байсан бол 2025 онд 21 мянга болж нэмэгдсэн. Төрийн тусгай албан хаагчдын тоо 2005 онд 22 мянга байсан бол 2025 онд 49 мянга болсон. Төрийн үйлчилгээний албан хаагч нар буюу багш, эмч нар 2005 онд 85 мянга байсан бол өнөөдөр 152 мянга болж нэмэгдсэн. Үндсэндээ 2 дахин, төрийн үйлчилгээ бол ойлгож байгаа. Төрийн тусгай албан хаагчийг бас ойлгож байгаа байх. Яах аргагүй хүн амын тоо өсөж байгаатай холбогдоод төрийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжтэй байдал бий болгох, цагдаа, цэрэг бас аюулгүй байдал, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг хангах гээд хүн амын тоотой бас уялдах байх.

Энэ дээр 1 нэмэгдэж байгаа юм бол сая таны хэлж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тоо. Монголбанк 350 байж байгаад 750 болсон. Улсын Их Хурлын Тамгын газар 120 байж байгаад 300 гаруй болсон гээд ярьж байгаа. Энэ хэмжээгээр бүтээмж нэмэгдсэн үү. Цалин бол нэмэгдсэн байна. Байгууллагын тоо бол нэмэгдсэн байна. Урсгал зардал 2005 онд 500 гаруй тэрбум байсан бол өнөөдөр 24 их наяд болж, 44 дахин нэмэгдсэн. Гэхдээ яах вэ, энд бас мөнгөний ханшны уналт тооцогдох л байх л даа. Тэгэхээр энэ дээр л бид нэлээн том дүн шинжилгээ хийж үзэх хэрэгтэй байгаа юм. Ингэж байж цаашдаа бас илүү анхаарч ажиллахгүй бол энэ зайлшгүй анхаарах ёстой. Даргын тоо бас нэмэгдсэн. 1995 онд, 1997 онд байгуулахдаа толгой байгууллагатай байсан бол 2019 онд 4374, 2024 онд 4276 гээд дарга нарын тоо ингэж нэмэгдсэн. Сая таны түрүүн хэлсэн нөгөө газар, хэлтсийн

дарга нар гээд их олон даргатай болсон.1 хүнд ноогдох даргын тоогоор дэлхийд тэргүүлж байж магадгүй. Тийм болохоор л энэ дээр анхаарах ёстой.

9 хувийн орон тооны цомхотголын асуудлыг бол сая 2026 оны төлөвлөгөө хэлэлцэж байх үед Эдийн засаг, хөгжлийн сайд маань оруулж ирсэн. Бид нар үүнийг бас баталчихсан. Үүнийг л хэрэгжүүлэх хүрээндээ ярьж байгаа. Гэхдээ энд ямар нэгэн хүнийг цомхотгоод, ажилгүй болгохгүй. Одоо байхгүй байгаа сул байгаа орон тоог нэмж хүн авахгүй, царцаах замаар үндсэндээ аль болох төрийн албан хаагчдыг хохироохгүй байхаар ийм зөөлөн газардуулах ийм бодлогыг хийж, хэрэгжүүлж, тодорхой хэмжээний бас төрийн албыг цомхон, чадварлаг болгох энэ талд бас анхааръя гэж байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас цаашдаа илүү саяын хэлсэн тоонууд дээр илүү нарийвчилсан судалгаа хийж, цаашдын шинэ шийдэл, бодлого бас гаргана гэсэн тийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. 3 номерын индэр. Их Хурлын гишүүд 3 номерын индрийг чөлөөлж өгөөрэй. Сандаг-Очир гишүүн хамт хариулах гээд байна уу.

А.Энхбат: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 7 дугаар сарын 7-нд өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтөөр бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл орон тооны байгууллага 7 гишүүнтэйгээр томилогдож ажиллаж эхэлсэн байгаа. Өөрөөр хэлбэл 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын Их Хурлын 4 дүгээр тогтоолоор энэ 7 гишүүн маань томилогдсон. Өнгөрсөн хугацаанд 2024 оны 3 дугаар сарын 15-нд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.5} дээр үндсэн 6 чиг үүргээр ажиллахаар хуулиар заачихсан. Энэ дагуу бол төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэг таамаглалыг боловсруулах, жилийн төсвийн төсөл дүгнэлт өгөх, мөн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут өгье.

А.Энхбат: Улсын төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх гэх зэрэг чиг үүргээр ажиллаж ирсэн. Тухай бүр эдгээр танилцуулга, дүгнэлт, зөвлөмж, материалуудыг Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлж ирсэн. Өнгөрсөн хугацаанд миний та бүхэнд тавьсан хэлэх үгэн дотор бол Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам маань ноднин жил бол манай дүгнэлтийг тодорхой хэмжээгээр хүлээж аваагүйгээр төсвийн төслөө боловсруулж, батлуулж байсан. Баярлалаа.

Х.Булгантуяа: Төрийн албаны зөвлөлөөс. Алдаржавхлан гишүүнд бас мэдээлэл өгөхөд дэгийн тухай шинэ хуулиар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд бас эртхэн мэдээллийг хүргүүлдэг, дүгнэлтээ сайн танилцуулдаг эрх зүйн орчныг бас нэлээн сайжруулсан. Тэгэхгүй бол энэ мэдээллүүдийг авч чадахгүй байгаа байхгүй юу. Төсөвтэй холбоотой мэдээлэл. 4 номерын ажлын хэсгийн микрофон.

Л.Цэдэвсүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Тоо баримтуудыг сая Бямбацогт сайд хэлчихлээ. Ер нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газартайгаа Төрийн албаны зөвлөл, Сангийн яам тоо баримтуудынхаа цэгцлэлтийг нэлээн сайн хийж байгаа. Системийн шинэчлэлийн хүрээнд.

Төрийн албаны зөвлөлөөс энэ төрийн байгууллагуудын болон төрийн албан хаагчийн тооны нэмэгдэлтэй холбоотой зөвлөмж болон саналуудыг тухай тухайн үед Засгийн газарт болон холбогдох байгууллагуудад өгдөг. Гол юм нь юу байдаг юм бэ гэхээр мэдээж улсын хүн амын хөгжлийн болон хүн амын тоотой уялдуулж төрийн албан хаагчдын тоо нэмэгдэнэ. Тэгэхдээ ялангуяа сүүлийн 5, 10 жилд бол төрийн захиргааны албан хаагчдын тоо эрс нэмэгдэж байгаа дээр дүн шинжилгээ хийж, чиг үүргийн шинжилгээнүүдийг ялангуяа яам, агентлаг, ЗДТГ-т хийх нь зүйтэй байна. Энэ дээр бид нар хяналт шинжилгээ хийсэн. 2 ч тайлангаа бол холбогдох байгууллагуудад бас хүргүүлж байсан. Тэгээд одоогийн энэ Их Хурлаар хэлэлцэж байгаа 9 хувийн орон тооны бууралт болон/минут дуусав/

Х.Булгантуяа: Тодруулах уу. Алдаржавхлан гишүүн нэмж тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Сая манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн бидний саналыг тодорхой хэмжээгээр аваагүй гэж хэлж байна. Ер нь аваагүй л юм байна. Тэгвэл та хэд маань бас Сангийн яамтайгаа сайн хамтарч ажилламаар байна. Санал энэ тэрээ түрүүлж өгөөд, өөрсдийгөө байгаа гэдгийг бас мэдрүүлж ажилламаар байна. Би төрийн албан дээр ийм шаардлага тавиад байна шүү дээ. Төрийн албаны зөвлөлийн дарга аа. Та хэд маань миний саяын хэлсэн ийм жишээнүүд байна шүү дээ. Монголбанкныхаа 10 жилийн дотор 350 төрийн албан хаагч нь 700 болчихлоо гээд байна шүү дээ. Яг яагаад ингэж өсөв гээд бүтцийн шинэчлэл өөрчлөлтүүдийг судалж үзмээр юм биш үү. Автоматаар 9 хувь хасъя гэж байхаар энэ өссөн байгууллагууд яагаад 2 дахин өсчхөв. Ажил нь үнэхээр нэмэгдсэн юм уу, нэмэгдээгүй юм уу гэдгийг үзэхгүй бол бид нар ингээд аажим аажмаар нэмэгдсээр байгаад төрийн албаны тоо чинь хэдэн 100 мянга болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэд маань Төрийн албаны зөвлөлийнхөн зөндөө ажилтнуудтай. Та бүгд энийг үзэж болохгүй юу.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд. Хэрэг эрхлэхийн дарга.

С.Бямбацогт: Алдаржавхлан гишүүний хөндөж байгаагаас бол маш зөв. Бид нэлээн томоор нь, цогцоор нь дүн шинжилгээ хийж үзээд, цаашдаа шинэ шийдэл бас бодлого гаргах цаг нь болсон байгаа юм. Одоо төрийн албан хаагчдын авч байгаа цалинг түрүүн би 2 сая 200 дунджаар гэж хэлсэн. Гэтэл янз янзын нэмэгдлүүдийг нь бас нэмээд яриад үзэхээр хамгийн дээд тал нь 280 хувийн нэмэгдэл авч байна. 2 сая төгрөгийн цалин авдаг. Үндсэн цалин нь. Дээрээс нь нөгөө олон төрлийн янз янзын Төрийн албаны хууль, бусад хуулиудаар нэмсээр байгаад ингэчихсэн. Тэр нэмэгдлүүд нь аваад үзэхээр хамгийн дээд тал нь 280 хувь буюу үндсэн цалин нь 2 сая нэмэгдэл цалинтайгаа 5 сая 600 мянган төгрөгийн цалин авдаг болчихсон. Энэ чинь л үндсэндээ нөгөө төсвийн зардлыг нэмэгдүүлээд, тэгээд бүтээмж нь бас яг түүнтэй адилхан байна уу гээд үзэхээр бас бүтээмжийг нь бас дахиж үнэлж үзэх ёстой. Дахиад юу гэдэг юм мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан гээд олон давуу талууд бий болсон байж байгаа. Энийг аваад үзэх юм бол илүү бүтээмж гарах ёстой. Гэтэл .../минут дуусав/

Х.Булгантуяа: Төрийн албаны зөвлөл нэмж хариулъя.

Л.Цэдэвсүрэн: Гишүүний асуултад нэмж хариулъя. 2024 он, 2025 оны эхний 3 сард Төрийн албаны зөвлөлөөс өмнө нь байгуулагдчихсан байсан нийт 16 яам болон ЗДТГ-т яг энэ чиг үүргийн шинжилгээгээ зөв хийж, орон тоогоо зөв тогтоосон эсэх дээр шалгалт хийж, зөвлөгөө, зөвлөмжүүдийг өгсөн. Өгөөд ерөнхийдөө нийт

алдаа дутагдлын 60 гаруй хувь нь засагдаад явж байна. Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хорооноос манайд бас үүрэг өгчихсөн байгаа. Улсын Их Хурлын харьяа бүх байгууллагуудад яг энэ шалгалтыг хийгээд, ямар давхардал, зөрчил байгааг илрүүлж гаргаж ир гэсэн үүрэг өгчихсөн. Бид нар энэ дээр бол одоо ажиллаад явж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Ингээд бид нар 126 гишүүнтэй парламент чинь бараг л анхныхаа төсвийн тодотголоо ярьж байна уу. Тийм юм шиг байна. Ер нь өнөөдөр чинь 5 дахь өдөр. Монгол Улсын Ерөнхий сайд орж ирж суугаад, асуултад хариулаад л байж байгаа нь сүүлийн 5 жилд хараагүй юм болж байх шиг байна. Энэ бас сайн тал руугаа л явж байна гэж ойлгож байна л даа. Гэхдээ би бол ер нь бараг л олон удаа хэлж байсан. Ер нь ийм болно. Нүүрсний үнэ унана. Унасны дараа та нарын яриад байгаа тэр үлгэрүүд чинь байхгүй болно л гэж хэлж байсан. Одоо тийм л болж байна л даа.

Тэгээд төсвийн тодотгол орж ирж байна. Энэ төсвийн тодотголын цаана ямар бодлого байна вэ. Бодлого байгаа юу, үгүй юу. Эсвэл тэгээд 1 орлого нь багасчихаар тэр хэмжээнд нь тааруулаад юм хумаа хасаад байна уу. Яаж байна. Тэрийг тодруулъя.

Нөгөө талаар бол нүүрсний үнэ бол унасан. Гэхдээ бусад түүхий эдийн үнэ гайгүй л байгаа шүү дээ. Өсчихсөн л байгаа шүү дээ. Алтных өсөж байгаа. Зэсийнх өсөж байгаа. Хэзээ ч бүх цаг үеийн дээд түвшинд хүрчихсэн байгаа. Энэ сайд нар өлбийгөөд байлгүй, олигтойхон баймаар байна. Тэр “Алт 3” хөтөлбөрөө нэгмөсөн сайн оруулаад ир л дээ. Үнэхээр 3400 хүрчихсэн байна. Илүү ч нэмэгдэхээр байна. Энэ үед тэр байгаль орчныхоо хамгаалалтыг бид нар сайн хийж чадна шүү дээ. Дандаа ийм юм байхгүй. Ойрын 2, 3 жил ийм байгаа байх. Энэ үед нь оруулаад ир. Зэсийн үнэ 9 мянга, бараг 10 мянга хүрэх гэж байна шүү дээ. Тэгэхээр Цагаан суварга энэ тэрийг яаралтай оруул. Тэгээд гаднаас 51 хувийг аваад ирдэг хувийн хэвшлийнхэн. Тэгээд тэд нарыгаа ад үздэг. Ер нь сүүлийн 10-аад жил их жонхуурч байна даа. Энэ юм хумаа боливол яасан юм бэ. Бид нар хангалттай коксожсон нүүрстэй. Нүүрс бол хангалттай байгаа. Хэрвээ тээвэр сайн байгаа бол бид нар дэлхийн зах зээлд хүргэж чадна. Гэтэл зориуд саад болох гэж байгаа юм шиг энэ бүхнийгээ өргөн төмөр замаар холбодог. Энийгээ одоо нарийн болго л доо. Хамгийн том зах зээлтэй холбогдож байж, тэрийгээ зориуд ийм байлгаад байдаг. Энэ чинь ямар учиртай юм бэ. Энийгээ өөрчлөх үү яах вэ.

Тэгээд энэ төрийн албан хаагчид гээд нэр өгчхөөд хуучин бол .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганбат гишүүний асуултад Ерөнхий сайд хариулъя.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн маш тодорхой асуудал хөндлөө. Төсвийн тодотгол хийх зайлшгүй нөхцөл шаардлага үүссэн гэдэг талаар бид танилцуулгадаа танилцуулсан. Тэгээд одоо санал хураалт явуулна. Санал хураалт юу гэж явуулах вэ гэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн дагуу жилийн төлөвлөгөөтэй нийцсэн үү, үгүй юу гэсэн санал хураалт явуулдаг. Дэгийн хуулиараа ийм. Жилийн төлөвлөгөөнд нь юуг нийцүүлэх ёстой вэ гэхээр төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгоо гээд баталчихсан байхгүй юу. Тийм учраас энэ Улсын Их Хурлаас өгчихсөн энэ үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн үү,

үгүй юу санал хураалт явуулахаар тэр нийцүүлж орж ирэхээс өөр аргагүй. Төрийн албанд өнөөдөр ажиллаж байгаа 226.895 төрийн албан хаагчид сүүлийн 10 жил бүх салбарт өссөн боловч 2024 оны Үндэсний аудитын газрын дүгнэлтээр чиг үүргийн давхардал, тэнцлийн шинжилгээ хийгдээгүй байна.

Ер нь төрөөс цалин авч ажиллах нөхцөлөөр хангагдсан ч гэсэн төрийн албан хаагчийн тоонд ороогүй, ангилал тодорхойгүй олон нэгжүүд байна. Мөн төр зарим чиг үүргээ хувийн хэвшлээр хийлгүүлэх зорилт тавьсан боловч төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниуд, хороо, зөвлөл, комиссын тоо нэмэгдэж, тэр хэмжээгээр төсвийн урсгал зардал нэмэгдсэн байна гэж дүгнэсэн. Ийм учраас энэ бүхэнтэй нийцээд, өөрчлөлтүүд орж байна. Гэхдээ төрийн албаны шинэчлэлийн асуудал саяын хэлсэн олон давхардлууд жишээлбэл үр дүнгээр цалинжуулах, гүйцэтгэлээр үнэлэх Засгийн газрын эрх зүйн акт гарчихсан боловч тэрүүгээр биш, нөгөө олон нэмэгдлүүд нь тэнцвэртэй бус байдал үүсгээд байгаа мэт олон асуудал байгаа учраас энэ Төрийн албаны тухай хуулийг дараа жич оруулж ирж, багц цогцоор нь шийдье гэсэн олон гишүүдийн саналыг дэмжиж, Төрийн албаны тухай хуулийн тэр 36 сартай холбоотой хэсгийг бид эргүүлж татаж аваад, тэгээд төрийн албаныхаа реформыг цогцоор нь шийдэх хүрээнд оруулж ирье гэж үзэж байгааг бас эцэст нь тодотгож хэлмээр байна.

Ер нь олон улсын нөхцөл байдал, Хятадын дотоодын нүүрсний эрэлт буурч, нийлүүлэлт нь нэмэгдэж байгаа зэрэг олон хүчин зүйлийн шалтгаанаас манай үндсэн экспортын болон төсвийн орлогын гол эх үүсвэр маань нүүрс болчихоод байгааг төрөлжүүлэх шаардлагатай. Ганбат гишүүний саналыг дэмжиж байна. Та бүхэн хэлэлцүүлгийн үед ажлын хэсэг байгуулаад, “Алт 3” төслөөр тодорхой саналуудаа оруулаад, нэмээд ороод явж болно. Алтны үнэ ийм сайн байхад 3400 доллар гарчхаад байхад энэ жил Монгол Улсад тушаагдсан алт үндсэндээ бараг ноднингийнхоос 2 дахин бага байна. Оргил үеийнхээсээ бараг 3 дахин бага байна. Тийм учраас зайлшгүй валютын нөөцөө нэмэгдүүлж, төгрөгийн тогтвортой байдлыг хангаж, инфляц, ханшийн өсөлтийг барихын тулд алтны нөөцөө нэмэгдүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Энэ та бүхэн бас ажлын хэсэгт ороод, Ганбат гишүүн нар энэ саналаа хэлэлцүүлээд ороод явах бололцоотой байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Та бүхний энэ сүүлийн 10-аад жил ажилласны үр дүнд ийм л болчихоод байгаа юм л даа. Төрийн албаны чинь нэр усыг нь ч гэсэн солимоор байгаа юм. Нийтийн алба гэж нэрлэмээр байгаа юм. Одоо бүгд бизнес хийхээр гардаг үе байлаа шүү дээ. Бүгд хувийн хэвшилд очихыг хүсдэг байлаа. Гэтэл одоо тийм биш болчихжээ. Энийгээ өөрчил өө. Энийгээ бид нар 126 гишүүнтэй парламент сууж байхад төр засаг нь хамаг юмыг нь хийчих юм шиг, болох гэж байгаа юм шиг ийм л юм яриад, бүтэн өдөржингөө яриад сууж байгаа байхгүй юу. Одоо энийгээ больё хэдүүлээ. Хэр ардчилсан улс орон яаж хөгждөг юм тэр замаар нь хөгжмөөр байна шүү дээ. Амьдармаар байна шүү дээ бид нар. Энийгээ зоригтой хий. Хийж чадахгүй бол бид нартай нийлж хий. Ийм л шаардлага тавигдаад байна. Энийг ойлгож байна уу, ойлгохгүй байна уу. Одоо тэгсэн чинь юу гэлээ тайван газардуулна ч гэх шиг сонин сонин юм яриад байх юм.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тантай бас санал 1 байгаа. Ер нь төсвийн орлого бүрдүүлж байгаа татвар төлөгчид. Төрийн албан хаагчдын цалинг хэн бүрдүүлж байгаа вэ. Баялаг бүтээгчид. Тийм болохоор бид нар бас хувийн хэвшлээ дэмжих ёстой. Хувийн хэвшлээ дэмжих ёстой. Нөгөө талдаа өнөөдөр бас төрийн үйлчилгээг ард иргэддээ хүргэж байгаа төрийн албан хаагчийг бас төрдөө бас сэтгэлтэй, тогтвортой, хариуцлагатай ажиллах бас бололцоо, боломжийг бүрдүүлэх ёстой. Энэ үүднээсээ цаашдаа бол Төрийн албан хаагчдын цалин үндсэндээ хувийн хэвшлээс илүү бараг өндөр шахуу болсон. Төрийн алба руу хүмүүс тэмүүлдэг болсон байна. Энэ хэмжээгээр нөгөө талд нь илүү хариуцлагатай, илүү бүтээмжтэй, илүү сэтгэлтэй, төрийн үйлчилгээг ард иргэддээ хүргэхийн төлөө ажилладаг ийм чадварлаг ийм төрийн албан хаагчтай болох ёстой. 1 талдаа төрийн алба рүү тэмүүлж байгаа гэдэг нь сайн. Эндээс бид нар хамгийн их сэтгэлтэй, хамгийн хариуцлагатай, хамгийн чадвартай хүмүүсээр энэ төрийн албандаа төрийн үйлчилгээг ард иргэддээ хүргэ гэдэг дээр шахаж .../минут дуусав/

Х.Булгантуяа: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Тэрийгээ тэгээд зөв зүйтэй хийгээрэй. Бас арай л өөр. Наад хандлагаа өөрчилнө шүү. 1 юм байна бас. Энэ Улаанбаатар хот Бээжингээс бараг Уралын нуруу хүртэл 2 л хот байна шүү дээ. 1 сая 500-аас дээш хүн амтай. Хөх хот байна. Улаанбаатар хот байна. Энийг нөгөө хэн билээ. Фронт руу манай шилдгүүд нь явлаа гээд 2 жилийн өмнө тэгж яриад нөгөө Нямбаатар эндээс яваад байсан л даа. Тэгээд одоо тэр Нямбаатар чинь ажлын хувцас өмсчхөөд л яваад байх шиг байна. Коммунист царайлаад. Тэгээд энэ аятайхан хотод амьдармаар байна шүү дээ. Тэр юу билээ тойрог зам билүү. Тэрнийх нь мөнгө төгрөгийг шийдээд өгчихсөн юм уу. Яах юм. Тэгээд орон нутгийн сонгуулиар 40 суудалтай болсон. Яаж ч юм ялаад байх шиг байгаа юм. Хэзээ нэг хотынхоо даргыг Улаанбаатарчууд сонгодог болох юм. Тэр үед их сайхан болох байх л даа. Тэр тойрог замыг нь хийх юм уу .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тойрог зам хийнэ гэж байна лээ. Ирэх долоо хоногт Байнгын хороо, ажлын хэсэг дээр ярилцана гэсэн. Ирэх долоо хоногт ажлын хэсэг тойрог замын асуудлаа шийдэх юм байна лээ.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 7 гишүүнээр тасаллаа. Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Бид нар нэлээн хэдэн цаг бас төсвийнхөө тухай тодотголоо нэлээн ярилаа. “Алт 3” төсөл, цаашдаа бид төсвийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд нүүрснээс бусад эрдэс баялгийнхаа олборлолт, хайгуулыг нэмэгдүүлье гэж ярьж байгаа юм. Тэгээд энэ дээр би 1 зүйл хэлэх гээд байгаа юм. Энэ аливаа уул уурхайн төслөөс орон нутагт үлдэж байгаа энэ өгөөжийг нь нэмэгдүүлж өгөөч ээ. Хэрвээ ингэхгүй бол цаашаа үнэндээ энэ төслүүд чинь явахгүй шүү. Одоо бэлээхэн жишээ байгаа шүү дээ. Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг харахгүй юу. Өнөөдөр Монгол Улсын төсөв бараг Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэр дээр байгаа Тавантолгойн ордоос л бараг төсөв бүрдэж байгаа гэж хэлж болно шүү дээ. Бид нар чинь бусад аймгуудад, бусад газрууд, бүсүүддээ энэ уул уурхайн нөөц, тэр алт чухал ашигт малтмалаа олборломоор байдаг. Тэгээд өнөөдөр бодит байгаа байдал нь Цогтцэций сум нь өөрөө сургуульгүй, цэцэрлэггүй, тоос шороондоо холилдчихсон. Усгүй, бэлчээргүй ийм байдалтай байхад чинь яаж бусад аймгууд нь

бусад бүсүүд нь уул уурхайг дэмжих юм бэ. Өнөөдөр бодитойгоор тэр Ховд аймагт гарч байгаа ард түмний эсэргүүцэл байна шүү дээ. Халзан бүргэдэй дээр. Тэгэхээр чинь энэ Ашигт малтмалын хууль, Төсвийн хууль энэ тэрдээ өөрчлөлт оруулж, энэ ашигт малтмал АМНАТ-аас орж ирж байгаа орлогын тодорхой хувийг нь тэр суманд нь, багт нь, аймагт нь үлдээдэг байхгүй бол энэ цаашаагаа бид нар уул уурхайн үйл ажиллагаагаа солонгоруулна. Эдийн засгаа солонгоруулна гээд яриад байгаа чинь ерөөсөө цаашдаа бүтэхгүй ийм л хий хоосон яриа болж л хувирна гэж би ойлгодог юм. Тийм учраас Улсын Их Хурлын даргын захирамжаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад, мөн Эрдэс баялгийн яам дээр дэд хэсэг байгуулагдаад, ингээд шинэ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бэлэн болсон. Тийм учраас энийг яаралтай Засгийн газар нь өргөн барих юм уу, ажлын хэсэг нь өргөн барих юм уу, яам Засгийн газар, Улсын Их Хурлын даргын зөвлөлөөс шийдийг нь гаргаад өгчих юм бол энэ Ашигт малтмалын хуулиа цааш нь бид нар өөрчлөөд, аль болохоор байгаль орчинд хор хөнөөл багатай, орон нутагт нь үр өгөөжтэй, төсвийн орлогод нь нэмэртэй, хөрөнгө оруулалт нь тухайн орон нутагт нь илүү бас хуваарилагддаг ийм юм байхгүй бол энэ чинь цаашаа явахгүй шүү дээ.

Уул уурхайгаас орж ирж байгаа АМНАТ-ыг бүх аймаг, сумд нь тэнцүүхэн хуваарилчихдаг. Тэгэхээр зарим аймгууд нь болохоор уул уурхайн төслийг огт дэмжихгүй. 1 ч лиценз өгөхгүй гээд байж байдаг. Зарим нь өөрийнхөө газар нутгийг ухуулаад байж байдаг. Тэгээд нөгөө дэмжээгүй аймгуудад нь ялгаа байхгүй адилхан тэгшилдэг гээд хуваачихдаг. Тийм учраас энэ чинь уул уурхайг дэмжихгүй байгаа байхгүй юу. Аль өөрийнхөө байгалийг ухуулж байгаа, байгалийг сүйтгүүлж байгаа орон нутагт нь илүү төсвийг нь хуваарилаад, өөрийнхөө асуудлыг шийдэх бололцоог нь олгоод өгөх юм бусад аймгууд чинь дагаад бас тодорхой уул уурхайн төслүүдийг дэмжих ийм магадлал бий болно гэж ингэж л хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Бид бүлэг дээр асуудлыг ярилцаад, яг энэ Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулахаар оруулж ирсэн заалтуудыг буруу юм гэдгийг маш их удаан ярьж байж больсон. Одоо татаж авах байх. Ер нь дараагийн асуудал дээр орж ирэхлээр санал хураах юм уу, татаж авах юм уу. Эсвэл буцаах юм уу. Хойшлуулах юм уу нэг юм болох байх. Зүгээр би сайд нарын болоод Ерөнхий сайдын хариулт дээр өөрийгөө зөвтгөх, дараа нь дахиад оруулж ирэх юм шиг ийм хариултууд хэлээд байгаа учраас энэ дээр нь бас Ерөнхий сайдад хандаж бас үг хэлэх гэсэн юм.

Сангийн яамны оруулж ирж байгаа бодлого бүхэн зөв байдаггүй юм шүү. Та энэ дээр бас наанатай, цаанатай хандаж, хэлж байгаа асуудлуудыг нь бас шалгаж байхгүй бол зүгээр яаралтай, нэн ялангуяа ийм яаралтай оруулж ирж байгаа асуудал дээр алдаатай тоо, алдаатай бодлого, буруу ойлголт өгөх явдлууд их байдаг юм гэдгийг би сайдаар 2 жил хамтран ажиллаж байсан хүний хувьд хэлье.

Доктор, докторуудыг ер нь жоохон үгүйсгээд л бай байх юм. Би тэгээд танд энэ тоог нь бас хэлж өгдөг юм уу гэж бодоод байна л даа. Ер нь Боловсролыг дэмжих жил гэж зарласан Засгийн газар. Ер нь доктор, эрдмийн зэрэг яагаад чухал юм бэ. 226.895 төрийн албан хаагч байхад 1215 докторын зэрэг хамгаалсан хүмүүс байгаад байгаа юм. Төрийн үйлчилгээний албанд 152.641 хүн ажиллаж байгаа бол тэрний 778 нь л докторын зэрэг хамгаалсан байна. Төрийн тусгай албанд 49.081 хүн

ажиллаж байхад 243 л доктор эрдмийн зэрэг хамгаалсан байна. Төрийн захиргааны албанд 21.350 хүн ажиллаж байхад 142 доктор л байна. Төрийн улс төрийн албанд 3.823 хүн ажиллаж байхад 52 л доктор байна. Үнэхээрийн энэ докторууд уг нь эрдмийн зэрэг хамгаалаад, өөрийгөө хөгжүүлээд, бас арай л өөр байгаа юм. Тэгээд үүнийхээ илүү авчихсан юм шиг, 40 хувийн нэмэгдэл авдаг гэж та хэлнэ лээ. Үгүй шүү дээ. 10 хувийн л нэмэгдэл авдаг юм. Тэгээд уг нь эрдмийн зэрэг хамгаалдаг байх тал дээр нь хөшүүрэг болгох, өөрийгөө хөгжүүлэхэд нь олон улсын судалгаа хийхэд нь энэ чинь судалгаа хийх аргачлалд нь шинжлэх ухаанч байх тал дээр нь анхааруулж байгаа байхгүй юу. Сангийн яаманд байна шүү дээ. 1 л доктор байдаг юм гэсэн. Тэгээд тэр нь хөөрхий Захиргааны ямар албан дээр ажилладаг юм бэ дээ. Тэгээд чааваас тэр л илүү аваад байгаа юм байх. Тэр доктор хамгаалсан хүнийгээ албан тушаалыг нь л буруу сонгочихсон юм биш үү. Тэгээд чулуу шидвэл 1 докторын толгой онох юм гэнэ. Үгүй ээ, хар л даа. 227 мянган хүн байхад 1200 л хүн доктор хамгаалсан байна шүү дээ. Үгүй ээ, энэ төрийн үйлчилгээний хувьд багш нар чинь яагаад ийм бага байгаа юм. 152.641 хүнээс 778 доктор байна шүү дээ. Үгүй ээ, олон доктор болох тусмаа энэ чинь эрдмийн зэрэг хамгаалснаараа илүү өгч байгаа мэдээ мэдээлэл, боловсруулж байгаа хууль тогтоомж нь сайжрах юм бус уу гэж л би бодох юм. Тэгээд үнэхээр тэр докторыг худалдаж аваад байгаа юм тэр докторын зэргийг худалдаж авахгүй байх тал дээр нь анхаарах ёстой болохоос биш хөөрхий муу докторуудаа ингээд буруу гэм хийчихсэн юм шиг бас доош нь хийгээд байх нь буруу юм. Боловсролыг дэмжих жил гэж зарласныг чинь бас сануулмаар байна.

Төрийн албан хаагчдад олгодог зэрэг нэмэгдэл 260 хувийн нэмэгдэл авч байгаа хүмүүс байна л гэх юм. Үгүй ээ, гаргаад ир. Ямар албан тушаалд, ямар хүмүүс, хэчнээн хүн тийм нэмэгдэл аваад байгаа юм бэ. Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байсны хувьд хар даа. Төрийн албан хаагчид олгох нэмэгдэл. Хөөрхий муу төрийн тусгайгийнхан л хамгийн олон нэмэгдэл авч байгаа байхгүй юу. Би хамгийн өндрөөр нь тооцож үзэхэд зэвсэгт хүчин, хилийн цэрэг бүх олгогдож байгаа онцгой зэрэг дэв, бүх ур чадвар бүгдээрээ нийлээд нийлээд, хамгийн ихээр нь бодоход 170 хувь байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэгээд энэ төрийн тусгайгийнхнаа дэмжиж болдоггүй юм уу. Өөр хүн байхгүй шүү. Тэгээд энэ хүмүүсийн 40 хувь л нэмэгдлийг нь авах юм гэх юм бол одоо тэгээд яах уу. Цалин нь буурна биз дээ .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чинбатын Номин гишүүн үг.

Ч.Номин: Та бүхэндээ шөнийн мэнд хүргэе. Ерөнхий сайд аа, би төсөв дэмжмээр байгаа. Гэхдээ жаахан шүүмжлэлтэй хандах гэж байна. Урьдчилаад бас хүлцэл өчье.

1 дүгээрт таны Засгийн газрын хамгийн том мега төсөл бол хүний хөгжлийн асуудал гэж удаа дараа чуулган дээр хэлж байгаа. Өнөөдөр хүний хөгжлийн 6 тулгууртай байдаг олон улсын стандартаас 3 том салбараа хамгийн ихээр төсвийн таналт хийж байна. Соёл, спорт энэ 2 нийлээд 16 хувиар төсвийн таналтад орж байгаа. Үүнд ямар нэгэн хөрөнгө оруулалт яригдаагүй байгаа. Үүнээс гадна цахим хүртээмж, цахимжилт, технологийн салбар 33 хувь бас төсвийн таналтад орж байгаа юм байна. Бид хүний хөгжил, залуучуудынхаа ирээдүйгээс огт хэмнэж, харамлаж болохгүй. Өнөөдөр бид нар бүгдээрээ улс орон даяараа бахархаад, өнөөдөр энэ чуулган дотор баяр хүргээд байгаа 3*3-ын шигшээ баг, цаашлаад Монгол Зи гээд цахим тоглоомын салбарт байгаа шигшээ баг, аль аль нь олон улсын тэмцээн уралдаанд орох бүх зардлаа хасуулсан байгаа. Мөн олон улсын бэлтгэл, олимпын бэлтгэлд явах бүх зардал хасагджээ.

Ингээд ДЭМБ-аас гаргасан судалгаанаас би бас хэлье. Спортод зарцуулсан 1 доллар болгон ирээдүйн эрүүл мэндийн салбараас 3.2 долларын зардлыг хэмнэдэг. Мөн үүнээс гадна залуучуудын хөгжил зориулж хийж байгаа. Соёл, спортын салбарт оруулж байгаа бүтээлч энэ салбарыг зориулсан нэг доллар болгон 3.6 долларын ирээдүйн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хэмнэдэг. Тэгэхээр та бүхэн цаашдаа нийгмийн хэрэгцээ шаардлага болсон хүний хөгжлийнхөө салбараас танахгүй байх дээр анхаарна уу. Одоо бас сайд нь цаашдаа анхаарч ажил ажиллаасай гэж хүсэж байна. Ингэхгүй бид нар зөвхөн хүмүүсийнхээ биеийн эрүүл мэндийг бодчихоод сэтгэцийн буюу оюун санааны эрүүл мэндийг орхигдуулаад, ирээдүйд бид нар нийгэмд гараад байгаа бухимдал, ёс зүйгүй байдлыг улам дэвэргэнэ. Ийм учраас энэ салбарууд дээр анхаарч ажиллана уу гэдэг санал тавьж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлье.

М.Мандхай: Би түрүүн хэлсэн юмаа дахиад шалгасан. Тэгээд 2025 оны тодотголоор төсвийн тэнцлийн алдагдал 1.4 их наяд төгрөг. Энэ нь нэгдсэн төсөв, тэгээд улсын төсвийн тэнцлийн алдагдал өөрөө 2.8 их наяд байгаа. Тэгэхээр би юунд санаа зовоод байгаа вэ гэхээр ингээд батлаад явчихаар дахин тодотгол хийх эрсдэл гарах вий гэдгийг би бас протоколд үлдээчихмээр байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн орлого одоо биш, одоо байгаагаасаа оны сүүл гэхэд өшөө илүү буурч ирэх эрсдэл байгаа учраас одоо байгаа, ялангуяа их засвар, тоног төхөөрөмж 2025 онд шинээр тусгасан 1.1 их наяд төгрөгийн төсвөө дахиж нэг хараад танаач ээ гэж хэлмээр байгаа юм.

Түрүүн Ерөнхий сайд хэлсэн. Одоо бид нар сөрөн тэсвэрлэх ийм чадвартай резилент бас төсөвтэй байхаар төлөвлөсөн. Тэгвэл дахиад нэг тоон дээр анхаараач ээ. Өсөж ургуулдаг хөдөө аж ахуйн салбарынхаа төсвийг 86.2 хувиар хасчихсан. Энэ дотроо 11.8 тэрбум төгрөгийн Мал, эмнэлгийн ерөнхий газрын төсвийг танаад суучихсан. Нөгөө сөрөн тэсвэрлэх чадвар буюу бид нар малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгийн гол төсвөө таначихсан сууж байгаа. Одоо тэгээд нөгөө шүлхий өвчин, хонины цэцэг, үхрийн арьс товруутах гээд бүх гоц халдвар үүсэхэд бид нар яах вэ гэдгийгээ яг үндсэндээ бид нар шийдэж чадахааргүй түвшинд ийм төсөв оруулж ирсэн байна. Тийм учраас өсөж ургуулдаг, хамгаалдаг энэ ач холбогдолтой салбарынхаа төсвийг битгий танаач ээ. Энийгээ дахиж хараач ээ. Их засварын ажил хүлээгдэж болно. Тоног төхөөрөмжийг хүлээж болно. Энэ яамнуудын олон засварын ажлуудыг бид нар тэвчиж болох зардал мөн байхгүй юу. Тэгэхээр энийгээ дахин анхаарч хараач ээ гэдгийг бас анхааруулж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Түрүүний асуулт дээрээ цаг хугацаандаа амжаагүй хэд хэдэн зүйлийг Ерөнхий сайдад хандан хэлмээр байна. Хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллах ёстой төрийн албан хаагч. Тэгэнгүүт энэ тарааж өгсөн тодотголын материал дээр Хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн олон удаагийн үйлдлүүд байна. Ялангуяа энэ давтан давтан орж ирж байгаа. Тэгээд жил болгон их засвар. Яагаад вэ гэхээр зэрэг их засвар чинь бол зураг төсөв батлагдахгүйгээр төсвийн захирагч өөрөө захиран зарцуулах эрх бүхий дүн гэж хараад байгаа юм. Маш тийм жижиг эргэх бололцоотой. Тийм учраас их засвар, дээрээс нь энэ тоног төхөөрөмж худалдаж авах зардлууд ихээр тусгагдсан байна. Дээрээс нь иргэдэд үйлчлэх төв гэдэг ийм сум, аймагт байдалтай эдгээр дээр нийцлийн болон явцын аудит

оруулмаар байна. Яг үйл ажиллагаа нь тодорхойгүй, төсвөөс мөнгө зараад байдаг ийм зүйлүүд байна. Өнгөрсөн 2024 онд нийт улсын үйлдвэрийн газруудаас 30 орчим хувь нь алдагдалтай ажилласан ийм тоо баримт тараагдсан байна. Энэ дээрээ та бүхэн маань бас дахиад яг энэ тодотгол явахтай зэрэгцүүлээд Засгийн газрын тогтоол гаргаад, нийт төсвийн ерөнхийлөн захирагч нарт явцын болон нийцлийн аудит хийх шийдвэр гаргаж өгнө үү гэж хэлэх байна.

Тэгээд хамгийн сүүлд нь бизнес эрхлэгч нар, татвар төлж байгаа иргэд маань яг өнөөгийн нөхцөл байдал дээр эдийн засгийн маш хэцүү байдалд байгаа. Ялангуяа НӨАТ, дээрээс нь нийгмийн даатгалын шимтгэлээс болоод татварыг нь хаадаг асуудлыг та нэг тодорхой хэмжээгээр, үе шаттайгаар бас бүгдийг нь нийтээр нь хамруулдаггүй. Жишээгээр тогтмол 20 жил үйл ажиллагаа явуулсан байгууллагын дансыг ямар ч анхааралгүйгээр шууд хаачихдаг. Өнөөдөр дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа компани, 20 жил татвар төлсөн компани 2-ын хооронд маш том ялгаа байгаа шүү Ерөнхий сайд аа. 20 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа компани ямар нэгэн эдийн засгийн нөхцөл байдлаас болоод хугацаа хоцроох тохиолдолд дансыг нь хаачихдаг. Анхааруулдаггүй, сануулдаггүй, хэлдэггүй. Тэгэнгүүт өөрсдийн энүүхэндээ гэж хэлэхэд намын үзэл баримтлал нэгтэй нөхдийнхөө хаацайлах тийм болзошгүй нөхцөл байдал байна гэдэг дээр иргэд хардаад байна. Энэн дээр та анхаарч өгнө үү гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Ингээд арай л өөр байгаасай л гэж бодоод байгаа юм л даа. Энэ чинь 4 жилийн өмнө улсын төсөв чинь 20 хүрэхгүй их наяд л төгрөг байлаа шүү дээ. Тэгсэн чинь одоо 33 их наяд, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 90 их наяд гээд байгаа юм л даа. Тэрний бараг 30, 40 хувь нь. Үүнээс гадна тэр төрийн өмчтэй компаниа нэмнэ. Дээр нь энэ зарлаж байгаа тендерүүдээ нэмнэ. Энэ улс чинь тэгээд тэр чигээрээ социализмд амьдарч байгаа юм шиг л ийм болчихоод байна шүү дээ. Нөгөө зах зээлийн нийгэм, чөлөөт эдийн засаг, хувь хүний нөгөө идэвх, хувийн хэвшил энэ юман дээр чинь явдаг ийм юм байхгүй болчихжээ. Энийгээ жоохон өөрчилье гэж хэлэх гээд байна л даа. Тэгэхгүй бол 3 сая 500 мянган хүнтэй ийм баян, ийм хөдөө аж ахуй нь ингээд 70 сая малтай, хажууд нь дэлхийн хамгийн том зах зээл байж байгаа ийм байхад бид нарыг ингэж амьдруулна гэдэг чинь үнэхээр яаж ингэж амьдруулж чадаад байна. Гайхаж байгаа байхгүй юу.

Ийм өндөр IQ-тай. Хар л даа, сая гараад л тоолоход эрэгтэй, эмэгтэй багууд талбай дээр бүх газрыг ялаад л байж байна шүү дээ. Тэгээд залуучууд жагсаал хийж байна. Жагсаал хийхэд тэд нарын ярьж байгаа юм, байгаа байдал энэ тэр бол шал өөр болчихжээ. Энэ 126 дотор бол арай л сонин юм яриад, вакумд орчихсон юм шиг л байна шүү. Одоо энэ төсвийн тодотгол энэ юмнаасаа эхлээд жоохон өөрчилье. Нэгэнт хэлэлцэх эсэхээ ингээд шийдчихлээ. Олон өөрчлөлтүүдийг бид нар хийж болохоор байна. Засаг захиргааны өөрчлөлтийг хиймээр байна. Энэ олон сумуудаа нэгтгэмээр байна. Энэ боловсролын ч гэсэн өөрчлөлтийг хийчихмээр байна шүү дээ. Бүх станы орнууд латин үсэгт шилжчихлээ. Уйгаржин Монгол бичгээ аваад, хажуугаар нь латин үсэгт шилжчихье. Тэгвэл энэ ойр хавийн бүгд ирээд, Монгол Улсад боловсролоо дээшлүүлнэ гээд л байж байна шүү дээ. Гэх мэтчилний олон ажлууд байна.

Энэ хамгийн том зах зээлтэйгээ нүүрс чинь бол байж л байна шүү дээ. Энэ чинь тээврийн бизнес байхгүй юу. Хэрвээ Тяньжиний боомт, Далианий боомт

хүргэчихвэл Си Жин Пин дарга чинь 20 жилийн өмнө ирээд, та нар 20 тэрбумд хүргэ энэ энэ экспортоо гэж хэлсэн. Одоо болтол хүрээгүй л байгаа байхгүй юу. Өөрийнхөө нутаг дэвсгэр дээгүүр далайд гарцгүй орон юм чинь дотоодын тарифаар гаргах хэрэгтэй гэсэн. Яагаад ийм юмнуудаа ашигладаггүй юм бэ. Яагаад зориуд бид нарыг Монголын ард түмнийг ядуу байлгаад байдаг юм бэ. Ямар бодлого байна. Энийгээ өөрчилье. Энийг бараг 5 жил хэллээ. Тэр Монгол Улсын Ерөнхийлөгч орж ирээд хэлсэн шүү дээ Битгий ард түмнийг шар махтай нь хатаагаад байгаа гэж. Үнэхээр Монголын ард түмнийг ёстой шар махтай нь хатааж байна даа. Зориуд ядуу байлгах бодлогыг явуулж байна. Энийгээ больчихмоор байна шүү нөхөд өө. Өөрчилмөөр байна.

Тэр хотыг ч гэсэн даргыг нь хотын иргэд нь сонгодог болчихмоор байна. Бусад улс орон тийм л байгаа шүү дээ. Ардчилсан орон нэртэй мөртөө уг нь бүгд байх юм. Шүүх нь байх юм. Их Хурал нь байх юм. Засгийн газар нь байх юм. Гэтэл хэдэн дарга нар л баяжаад байна. Одоо дундаж давхарга гэж байхгүй. 30, 40 хувь нь хэчнээн ядуу байх юм бэ.

Энэ хууль хяналтын байгууллага нь олигтой ажиллахгүй. Шүүхийг ч гэсэн шүүх шиг байлгахгүй. Ийм юмаа өөрчлөх цаг болсон шүү. Энэ Их Хурлынхаа дэгийг ч гэсэн өөрчил л дөө. Үг хэлж ерөөсөө болохгүй шүү. Тэгээд 2, 3 өдрийн өмнө нэрээ өг чих шиг. Энийг өөрчлөөрэй та нар.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 55 гишүүн буюу 57.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороод мөн Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүллээ.

Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулна. Намын бүлгүүд, бүлэггүй намууд төлөөллүүдээ, нэрээ Тамгын газарт одоо ирүүлнэ.

Өнөөдөр чуулганы хуралдаан дуусахаас өмнө ажлын хэсгийг албан ёсоор байгуулаад, ажилдаа орно. Мөн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх явцад шаардлагатай хууль, тогтоолын төсөл дээр бас тусад нь дэд ажлын хэсэг байгуулах боломжтой гэж үзэж байгаа. Дараагийн асуудал дээр энэ асуудлыг ярья.

22.23 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэхээр байгаа.

Тэгээд өдөр 18 цаг болж байна гээд хэлэлцэх асуудлыг энэ 2 асуудлыг хэлэлцээд чуулганахаа хуралдааныг өндөрлүүлье гээд гишүүдээс асуугаад алх тогшихсон.

Хууль зүйн байнгын хорооноос Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшсэн 2 хүний танилцуулгыг хийхээр Улсын Их Хуралд ирсэн. 2 долоо хоног бас чуулганы хуралдаанаар хэлэлцэж амжихгүй, яаралтай асуудлууд орж байгаа учраас хойшлоод байгаад байсан. Тэгээд өнөөдөр танхимд байгаа гишүүд зөвшөөрвөл өнөөдөр 3 дахь асуудал нь болгоод өнөөдөртөө хэлэлцээд дуусгачихвал яаж байна. Танилцуулга. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөчихье. Гишүүд дэмжлээ. Тэгвэл 3 дахь асуудлыг нэмлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт 3 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдэд дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд,

1.Боловсролын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зориулалтаар барилга, байгууламж шинээр барьсан бүх аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт олгох зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд;

2.Жилийн төсвийн хуулиар баталсан төвлөрүүлэх орлогыг дайчлах, төсвийн сахилга батыг чангатгах зохицуулалтыг төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд;

3.Төсвийн сахилга бат, зардлын хэмнэлт, үр нөлөөтэй санхүүжилтийн үндэс суурийг тавихад чиглэсэн цогц арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд;

4.Алтны геологийн судалгаа, эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлж, гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлэх Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг “Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тус тус тусгалаа.

Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Мөн Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлтийг мөн өргөн барьсан байсан. Энийг буцаан татахаар Засгийн газрын шийдвэр гарч байгаа учраас танилцуулгад дурдаагүйг та бүхэн анхаараарай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хамт өргөн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээс Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас эргүүлэн татахаар болсон гэдгийг бас энд мэдээлье.

Хууль, тогтоолын төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 3 хууль, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор цэцэрлэг, сургуулийн барилга, байгууламж шинээр барихад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэр харгалзахгүйгээр орлогын албан татвараас хөнгөлөхөөр, мөн төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хэм хэмжээг салбарын хуулиудад давхардуулан хуульчилсан, түүнчлэн төрийн алба хаагчдын хооронд орлогын тэгш бус байдал үүсгэсэн болон цалин хөлс, шагнал урамшуулал, 1 удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой зарим зохицуулалтыг цэгцлэх, түүнчлэн төсвийн ерөнхийлөн

захирагч хооронд төсвийн зохицуулалт хийхийн зэрэгцээ төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах, төсвийн сахилга батыг чангатгахтай холбоотой зохицуулалтуудыг тус тус тусган хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах, үр ашигтай, оновчтой бүтцэд шилжүүлэн үйл ажиллагааны давхардлыг арилган нийгмийн салбарын санхүүжилтийг илүү үр дүнд чиглэсэн байдлаар зохион байгуулах нь зүйтэй гэж үзэн Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.10-д алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина гэсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн болон төгрөгийн ханшийн дарамтыг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн “Алт 3” аяныг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа хуулийн төсөлд цомхотгохоор тооцсон төрийн албан хаагчдын тоог бодитой гаргасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг төсвийн тодотгол хэлэлцэхэд Ерөнхий сайд бодлогоо танилцуулж, Улсын Их Хурлаас хэрхэн дэмжиж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин төсвийн тодотголоор урсгал зардлыг нэмэгдүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын шагнал урамшууллын асуудлыг цэгцлэх, мөн орон нутгийн бие даан хөгжих боломжийг бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлж, саналыг нь авах нь зүйтэй бөгөөд хуулийн төсөлд төрийн албан хаагчдын тоог бууруулахаар тооцохдоо бүтцийг зөв тодорхойлох, мөн цэцэрлэг, сургуулийн барилга барьсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх бус төрийн ачааллыг хуваалцаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, “Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээтэрийн Б.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Бат-Өлзийн Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 3 гишүүний нэр ирсэн байна. Дарааллын дагуу Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Ноднин ээлжит бус чуулганаар 2024 оны төсвийн тодотгол баталж байхад бас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулаад, тэгээд аж ахуйн нэгжүүдэд нийт орлогынхоо 1 хувьтай тэнцэх татварын хөнгөлөлт үзүүлэх ийм заалт орж ирсэн.

Нэгдүгээр асуулт. Энэ заалттай холбоотой өнөөдрийн байдлаар хэчнээн аж ахуйн нэгж ямар төрлийн хөнгөлөлтүүд авсан байгаа вэ гэдгийг асууя. Тэгээд одоо энэ оруулж ирж байгаа хуулийн төслөөр сургууль, цэцэрлэг барих асуудлыг бас энд татварын хөнгөлөлтөд хамруулж байгаа юм байна. Миний хувьд бол ямар байр суурь баримталж ирдэг вэ гэхээр сургууль, цэцэрлэг барина гэдэг бол төрийн Засгийн газрын хийх үндсэн үүргүүдийн 1. Тэгэхээр энийг заавал хувийн хэвшлээр ингэж хөнгөлөлтийн зарчмаар хувийн хэвшлээр бариулъя гэж зүтгэхээсээ илүү хувийн хэвшлээсээ татваруудаа авдгаараа аваад, тэгээд төр өөрөө энэ сургууль, цэцэрлэгийнхээ хөрөнгө оруулалтуудыг хийх ёстой гэсэн байр суурьтай байдаг. Тэгээд яагаад заавал энэ сургууль, цэцэрлэгийг ингэж оруулж ирээд байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Тэгээд өнөөдөр олонхын бүлэг хуралдаад Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаа татаж байгаа юм байна. Гэхдээ тэр хойно

байгаа Засгийн газар чиглэл өгөх тогтоол дээр чинь болохоор төрийн албатай холбоотой саяын хуулийн чинь үзэл санаатай ойролцоо бас тийм зүйл заалтууд байгаад байна шүү дээ. Тэгэхээр энийгээ бас яах юм гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дугаарт нь, болохоор Засгийн газарт чиглэл өгч байгаа Улсын Их Хурлын тогтоол байна л даа. Тэгээд энд бол нэлээн өргөн хүрээтэй асуудлуудыг томъёолчихсон байгаад байгаа юм байна. Тэгээд энэ дээр болохоор 1 заалт бас анхаарал татаж байна. Нийгмийн салбарын төсвийн үр ашгийг сайжруулах чиглэлээр төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуульд олгож байгаа хувьсах зардлын санхүүжилтийг зогсоох гэсэн асуудал байгаад байна. Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд бол төрийн үйлчилгээний хүртээмж сул байсантай холбоотой, эцэг, эхчүүд арга буюу хувийн сургуулиудад хүүхдүүдээ өгч бас боловсролд нь анхаарч ирсэн. Тэр утгаараа ч тэр ялангуяа манай сэхээтэн, дундаж давхаргын эцэг эхчүүдийн дийлэнх өрхийн зардлынх нь хэсэг нь сургуулийн төлбөрт явдаг. Тэгээд ер нь бол бид нар чинь Боловсролын тухай хуулиараа бүх хүүхэд үнэгүй боловсрол эзэмших эрхтэй гээд заачихсан байж байдаг. Тэгэхээр энэ зардал бол сургуулиуд, хувийн сургуулиудад өгч байгаа зардал биш шүү дээ. Яг хүүхдүүдэд өгч байгаа зардал. Тэгэхээр энэ бол маш их тийм маргаантай, үзэл санааны хувьд асуудалтай ийм заалт гэж харж байна. Тэгээд үүнийг одоо бас ямар/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Асуулт Асуулт, үгээ хамт явчихъя. Ер нь хангалттай ярьсан. Төрийн албаны тухай хуулийг татан авахтай холбоотойгоор дэгийн зарчмын асуулт асуух гэсэн юм. Хурлын дарга аа. Татна гэдгээ илэрхийлсэн. Гэхдээ татаж аваагүй буюу Засгийн газар хуралдаж байж татах шийдвэрээ өгнө. Тийм үү. Тэгэхээр яг одоо процессын хувьд та хойшлуулах гээд байна уу, хойшлуулах эрх байгаа юу, үгүй юу гэдгийг асуумаар байна. Даваа гарагт Байнгын хороод дээр энэ асуудал хэлэлцэх учраас бас шийдвэр гаргаагүй байхад даваа гаргийн Байнгын хороодын хурал яах вэ гэдэг ийм асуудал байна. Уг нь бидэнд ямар боломж байна вэ гэхээр яах вэ хэлэлцэх эсэхийг нь дэмжихгүй байх буюу буцаах. Тэгсэн тохиолдолд надад бас юу гэдэг юм нэг таалагдах шийдвэр нь юу вэ гэхээр хууль санаачлагчид хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх процесс дээр дэмжихгүй буцаах юм бол 1 жилийн хугацаанд яг энэ асуудлаар хууль өргөн барьж болдоггүй. Тэгэхээр ядаж 1 жил төрийн албан хаагчид амар тайван амрах, амар тайван ажлаа хийх ийм нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр энэ дээр яг надад хариулт хэрэгтэй байна.

Ер нь төрийн албаны тухай аливаа асуудлыг, хүмүүсийн амьдралтай холбоотой аливаа асуудлыг ингэж хууль дагуулж, ийм муйхраар хандаж болохгүй. Төрийн албаны реформыг хийх гэж байгаа бол тусгайлсан бие даасан хуультай, дэгтэй Хууль тогтоомжийн тухай хуулийнхаа дагуу ном журмаар нь хийх хэрэгтэй. Тэрнээс биш ийм байдлаар хүмүүсийн амьдралыг хохироож болохгүй гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бас хариулт хүсье. Улсын Их Хурлаас.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь өнөөгийн цаг үед төрийн албанд итгэх ард түмний итгэлийг сэргээх, төрийн жинхэнэ албан хаагчдынхаа мерит зарчим, ажлын гүйцэтгэлийг ажлын гүйцэтгэл үр дүнгээр цалинждаг, урамшуулдаг, энэ олон улсын нийтлэг зах зээлийн зарчимд шийдэх зарчмыг бид тууштай мөрдөх учиртай. Төрийн албаны хуулийн зарчим ч гэсэн ийм. Ийм учраас Ариунзаяа гишүүн ч гэсэн өөрөө

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ажиллаж байх үед чинь төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журам гээд эрх зүйн акт баталчихсан байгаа. Төрийн албаны хуулийн дагуу. Үүгээр төрийн албан хаагчийн ажлыг үр дүн, гүйцэтгэлээр нь урамшуулж, шагнаж байх, тэр 40 хувь байна, 50 хувь байна, 60, 100 хувь байж болно. Дээр нь тэр дотроо мэргэжил, ур чадвар, түүнийгээ ахиулсан үр дүнгээр нь үнэлэх, өөрийнхөө тэр ажилд тохирсон мэргэжлийн ур чадвар үнэлэх гээд байхгүй юу. Түүнээс биш мэдээж докторыг огт үгүйсгэж байгаа юм байхгүй шүү дээ. Эрдэм боловсролыг үгүйсгэж байгаа юм огт байхгүй.

Харин ч тэр ажил гүйцэтгэлтэйгээ холбогдоно уу гэхээс биш зах зээлийн нийгэмд хувийн хэвшил ч гэсэн доктор зэрэгтэй л бол илүү цалин өгөөд байна гэхээс биш, докторт ур чадвар нь мэргэжлийн ур чадвар, доктор нь тэр ажлаа илүү гүйцэтгэлтэй, илүү сайн хийж байвал түүгээрээ илүү сайн цалин авдаг ийм гүйцэтгэлийн цалинжуулалтын үр дүнг үнэлгээний баг гаргаж байгаад ингээд үнэлж шагнаж урамшуулж байна гэсэн ийм сайн журам батлаад мөрдүүлж эхэлчихсэн байгаа юм. Энэ чинь өөрөө төрийн албаны аттестатчилал, үр дүндээ чиглэсэн цалин урамшуулал авч байх том бодлоготойгоо, сайн ажиллаж байгаа нь илүү цалин авдаг энэ зах зээлийн зарчмыг хатуу мөрдүүлэхийг зорьж байгаа болохоос биш боловсролыг, докторын зэргийг огт үгүйсгэж байгаа юм байхгүй. Харин ч энэ мэргэжил ур чадвараараа үнэлээд авдаг тогтолцоог цаашдаа мөрдүүлэх хэрэгтэй. Мэдээж боловсрол, мэдлэг чадвартай хүн ажиллаж байх тусмаа сайн. Энэ агуулгаараа ингэж ярьж байгаа шүү. Ийм учраас цаашдаа ч гэсэн энэ төрийн албаны ард иргэддээ үйлчилж байгаа байдал, үр дүн, гүйцэтгэлээр цалинжуулдаг энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталчихсан энэ үнэлгээний журмыг мөрдүүлж ажиллана гэж бодож байгаа. Үүгээр аттестатчилал явна. Энэ дагуу хэрэгжинэ. Энэ эрх зүйн акт бол мөрдөгдөж байгаа. Тэгэхдээ төрийн албаны тухай хуулийг бол оруулж байгаа өөрчлөлт журмыг болбоос бид нар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, эргүүлэн татъя. Өмнө ч гэсэн ингэж эргүүлж татах болно гэдгээ мэдэгдээд, хэлэлцэхгүй орхиод, бусад хуулиа хэрэгжээд явж байсан зөндөө тохиолдол практик бий. Их Хурлаас, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулиудыг ингэж хэлэлцээд явдаг жишигтэй. Энэ талаар Улсын Их Хурлын даргатай бас бид ярилцаад, Засгийн газрын хуралдаанаар ирэх 3 дахь өдөр юм уу хэлэлцээд татчихна.

Тэгэхээр энэ хууль үлдэхэд төсөвт үзүүлэх нөлөө байхгүй учраас ингээд үлдээгээд явчхаж болно гэж үзсэн. Ийм учраас санал хураахгүйгээр үлдээххэж болно гэж үзээд ийм санал тавьсан юм.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гишүүдийн болон бүлгийн саналыг харгалзан үзээд, Засгийн газраас хуулийн төслийг эргүүлэн татъя гэдэг шийдвэрийг, саналыг Улсын Их Хуралд илэрхийлсэн. Мэдээж Засгийн газар цаг үргэлж хэлэлцүүлэг болгон дээр хуралдаад шийдвэрээ гаргаад байх боломжгүй. Эрх бүхий албан тушаалтан өргөн барьсан салбарын сайд энэ дээр бас Ерөнхий сайд ч татна гэж хэлж байгаа учраас санал хураах шаардлага байхгүй. Угаасаа аль ч хуулийн төслийг хэлэлцүүлгийн аль ч шатнаас хууль санаачлагч нь татах бүрэн эрхтэй байдаг учраас бас үүгээр асуудал нь шийдэгдээд явах нь зүйтэй гэж үзэж байна.

Жаргалан гишүүний асуултад хариулт өгөлгүйгээр үргэлжлээд явчихсан байна. Уучлаарай. Болдын Жавхлан сайд Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Тэр татварын хөнгөлөлтийн хууль өнгөрсөн жил 9 сард батлагдсан. Батлагдмагцаа хууль үйлчилж эхэлсэн байгаа. Ингээд 2024 оны жилийн эцсийн тайлангаар 87 аж ахуйн нэгж тайлан ирүүлсэн байгаа. Ингээд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам дээр 7 төсөл, Боловсролын яаман дээр 18 төсөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр 6 төсөл, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам дээр 45 төсөл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам дээр 5 төсөл, Эрүүл мэндийн яам дээр 4 төсөл, Зам, тээврийн чиглэлээр 2, ингээд нийтдээ ийм 87 тайлан ирүүлсэн байгаа процессын дагуу явж байгаа.

Ирэх жил боловсролын жил болгон зарлаж байгаа. Тэгэхээр төсөв маань нэлээдгүй хумигдаж, хөрөнгө оруулалтууд бас нэлээн хумигдах ийм төлөвтэй байгаа учраас бид боловсролын жил болгон зарлачхаад юу ч хийхгүй сууж байж болохгүй. Тийм учраас энэ боломжууд дээр нь мөн сургууль, цэцэрлэг гэж зааж өгсөн байгаа. Тэгэхээр сургууль, цэцэрлэг бид одоо жишээ нь Боловсролын яам дээр гаргасан тоогоор 102 тийм ээ. 108 ийм сургууль, цэцэрлэг дутмаг байна гэж байгаа. Эд нарыгаа оруулчих юм бол ер нь ээлжийн хувьд бол нэлээн боломжийн зорилт түвшиндээ ирчихнэ гэсэн ийм судалгаа ирсэн байгаа. Тэгэхээр эдгээр хөрөнгө оруулалтуудыг бид төсөв дээрээ дангаараа авч явж чадахгүй. Ойрын лав 10 жил авч явж чадахгүй байж магадгүй. Тийм учраас төрийн зарим чиг үүргийг ялангуяа хөрөнгө оруулалтынхаа чиг үүргүүдийг хувийн хэвшил хийж болно. Тэр дээр нь хөшүүрэг нь энэ байж болох юм гэдгийг зааж байгаа гэсэн үг. Хамгийн гол нь цаашаа урсгал зардлаа ч гэсэн хувийн сектор өөрөө аваад, бизнесийн зарчмаар явах байхгүй юу. Тэгэхээр хөрөнгө оруулалтын зардал цаашдаа олон жил явуулах, хөрөнгө оруулалтынхаа зардлаас хэд дахин илүү гарч ирдэг урсгал зардлаа ч гэсэн хувийн хэвшил өөрөө авч яваад, яг үүгээр бодитойгоор төсвийн ачааллууд буурна гэсэн үг.

Тэр тогтоол дотор Төрийн албаны хуультай зүйлүүд бас байгаа. Тэрийгээ тэгээд ажлын хэсэг дээрээ тогтоолоо бол янзалчхаж болно. Хуулийг нь татаад авчхаж байгаа учраас. Энэ хувьсах зардал дээр ч гэсэн тэр шууд тогтоолоор хасчхаж байгаа юм биш шүү. 2026 оны төсөв өргөн барихдаа та нар үүнийг бодолцож үзье. Тийм учраас энэ дээр ажиллаадах гэсэн үүргийг бид нар Улсын Их Хурлын тогтоолоор засаг авч байна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Энэ хөнгөлөлт татварын хөнгөлөлт олгох процесс ер нь яаж явж байгаа юм бэ. Тэр сургууль, цэцэрлэг ч юм уу ямар нэгэн зүйл барья гэдэг саналуудыг нь хувийн хэвшлүүд өөрсдөө өгч байгаа юм уу. Эсвэл тухайн яамнууд нь санал тавьж байгаа юм уу. Тэгээд тэр одоо яг процесс нь яаж явж байгаа юм. Тэгээд тэнд тендер зарлагдаж байгаа юм уу.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Яамд бол журмаа гаргаад, Хууль зүйн яамандаа бүртгүүлээд, тэгээд л журам нь ажиллаад эхэлж байгаа юм. Тэгээд яамнуудын оролцоо өөрөөр ерөөсөө байхгүй. Тэрийгээ харж байгаад тэр шаардлагадаа хангасан хөрөнгө оруулалтуудаа өөрсдөө хийгээд, тэгээд л тухайн хугацааныхаа тайландаа тусгаад, татвар дээрээ хүргүүлнэ. Тэгээд татвар дээр шийдчихнэ. Тэнд олон өөр тийм хүнд сурталтай, шат дамжлага яам дээрээс очоод, зөвшөөрөл авах гээд л энэ нь

хангагдаж байна уу, хангагдахгүй байна уу гэж яам дээр гүйх ямар ч шаардлагагүйгээр ингэж зохицуулалт хийгдсэн байгаа. Өөрсдөө л хийнэ. Тэрнээс биш яам хязгаарлаад л, жагсаалт гаргаад л, газрыг нь зааж өгөөд тэнд, энд тэгээд тийм оролцоо бол байхгүй.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд намын бүлгийг төлөөлж үг хэлнэ. Үг хэлэх гишүүн алга байна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд бэлэн болсон байна. Санал хураалт.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53 гишүүн буюу 53 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 54 гишүүн буюу 54 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 56 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 55 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ.

Энэ 5 дахь асуудал буюу энэ ““Алт 3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулах санал намын бүлгүүдээс гарсан. Тэгэхээр энэ дээр бас намын бүлгүүд орж ажиллах гишүүдийн нэрийг ирүүлье. Өнөөдөр бас ажлын хэсэг албан ёсоор байгуулна. Тэгээд төсвийн ажлын хэсэгтэйгээ уялдаж, хамтарч ажиллах ийм ажлын хэсгийг байгуулна.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудал.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулна.

Нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Мөнгөнцэцэг: Их Хурлын дарга, эрхэм Их Хурлын гишүүд та бүхний оройн амгаланг айлтгая.

Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Цогийн Очийг танилцуулгыг хийе.

1.Товч намтар.

Нэр дэвшигч Цогийн Оч 1978 онд Улаанбаатар хотод төрсөн, 47 настай эрэгтэй, ам бүл 6. 1986-1996 онд нийслэлийн 18 дугаар дунд сургууль, 1996-2001 онд Улаанбаатарын Эрдэм дээд сургууль, эрх зүйч бакалавр, 2009-2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Тэрээр 2001-2002 онд “Энигма” ХХК-д хуульч, 2002-2006 онд Монгол Улсын дээд шүүхэд шүүгчийн туслах, 2006-2008 онд БГД-ийн шүүхийн шүүгч, 2008-2012 онд Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч, 2012-2013 онд Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч, 2013-2015 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Эрүүгийн хэргийн Давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна.

Нэр дэвшигч нь төрийн албанд 24 жил, шүүгчээр 19 жил 2 сар, үүнээс давж заалдах шатын шүүхэд 12 жил 05 сар ажиллаж байна.

2.Хуульд заасан шалгуур хангасан байдлын тухайд нэр дэвшигч Оч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатын шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Хууль зүйн дээд боловсролтой байх.

Нэр дэвшигч Оч нь 1996-2001 онд Улаанбаатар Эрдэм дээд сургуульд эрх зүйч, бакалавр, 2009-2021 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

35 нас хүрсэн, Монгол Улсын иргэн байх.

Нэр дэвшигч Оч нь 1978 оны 12 сарын 15-ны өдөр төрсөн. 47 настай. Монгол Улсын иргэн.

Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх.

Нэр дэвшигч Оч нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 10/524 дүгээр албан

бичиг, мөн эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай И-Монголиа цахим мэдээллийн сангийн 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн лавлагаагаар тус тодорхойлогдоно.

Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй байх

Оч нь Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол УЕПГ-ын 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 4/2142 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн.

Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх.

Нэр дэвшигч Очийг эрүүл мэнд, сэтгэцийн талаарх холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2025 оны 2 сарын 11-ний өдрийн дүгнэлтээр эрүүл, тэнцэнэ гэж дүгнэсэн.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх

Нэр дэвшигч Оч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй. Монголын Хуульчдын Холбооноос 2014 оны 7 сарын 7-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2107 дугаартай гэрчилгээг шинэчлэн олгосон. Нэр дэвшигчийн хуульчийн гэрчилгээ хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2025 оны 2 сарын 28-ны өдрийн 2/203 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн байна.

Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар ёс зүйтэй байх

Нэр дэвшигч Оч нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 50.71 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26.52 оноо авч, Хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх

Нэр дэвшигч Оч нь шүүгчээр нийт 19 жил 2 сар ажилласан. 2006-2008 онд БГД-ийн шүүхийн шүүгч, 2008-2012 онд Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч, 2012-2013 онд Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч, 2013-2015 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа туршлагатай.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх

Нэр дэвшигч Оч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 72 дугаар зарлигаар шүүгчийн албан тушаалд томилогдож, өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй шүүгч байх.

Энэ шаардлагын тухайд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан. Нэр дэвшигч Оч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул дээрх шаардлагыг бол хангаж байна.

3. Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу шүүгчид нэр дэвшигчдээс авсан шалгалтад Оч нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 50.71 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26.52 оноо, нийт 77.23 оноо авч тэнцэн 1 дүгээрт эрэмбэлэгдсэнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 05 сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 05 сарын 26-ны өдрийн хуралдаанд бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан хяналтын шатны шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Цогийн Очийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна.

2 дахь нэр дэвшигч Энэбишийн Золзаяагийн танилцуулгыг хийе.

Нэр дэвшигч Энэбишийн Золзаяа 1970 онд Улаанбаатар хотод төрсөн. 55 настай, ам бүл 4. 1978-1988 онд Нийслэлийн 18 дугаар сургууль, 1988-1994 онд ОХУ-ын Москва хотын Нийтийн ахуй үйлчилгээний улсын академи, Инженер техникийн ухааны магистр, 1996-1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр, 2009-2016 онд МУИС-ийн Хууль зүйн их сургуулийн Хууль зүйн Хууль зүйн ухааны магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Тэрээр 1999-2004 онд Нийслэлийн шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 2004-2006 онд Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, 2006-2013 онд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, 2013-2014 онд Дүүргийн иргэний хэргийн анхан шатын 1 дүгээр шүүхийн шүүгч, 2014-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна. Нэр дэвшигч нь төрийн албанд 26 жил 4 сар, шүүгчээр 20 жил 7 сар, үүнээс Давж заалдах шатын шүүхэд 11 жил ажиллаж байна.

Хуульд заасан шалгуур хангасан байдлын тухайд.

Нэр дэвшигч Золзаяа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Хууль зүйн дээд боловсролтой эсэх.

Нэр дэвшигч Золзаяа нь 1996-1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр, 2009-2016 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

35 нас хүрсэн, Монгол Улсын иргэн байх.

Нэр дэвшигч Золзаяа нь 1970 оны 06 дугаар сарын 30-ны өдөр төрсөн. 55 настай. Монгол Улсын иргэн.

Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх.

Нэр дэвшигч Золзаяа нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2025 оны 2 сарын 25-ны өдрийн А/524 дүгээр албан бичиг, мөн эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай И-Монголиа цахим мэдээллийн сангийн 2025 оны 2 сарын 12-ны өдрийн лавлагаагаар тус тус тодорхойлогдоно.

Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй байх.

Золзаяа нь шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол УЕПГ-ын 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 4/2349 дүгээр албан бичгээр лавлагаа ирүүлсэн.

Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх.

Нэр дэвшигч эрүүл мэнд, сэтгэцийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2025 оны 2 сарын 5-ны өдрийн дүгнэлтээр эрүүл, тэнцэнэ гэж дүгнэсэн.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх.

Нэр дэвшигч Золзаяа нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй. Монголын Хуульчдын Холбооны 2014 оны 7 сарын 7-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн 2194 дугаартай гэрчилгээг бол шинэчлэн олгосон. Нэр дэвшигчийн хуульчийн гэрчилгээ хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2025 оны 2 сарын 28-ны өдрийн 2/203 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн.

Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх.

Нэр дэвшигч Золзаяа нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 54.54 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 22.17 оноо авч, хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх.

Нэр дэвшигч Золзаяа нь шүүгчээр нийт 20 жил 7 сар ажилласан. 2004-2006 онд Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, 2006-2013 онд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, 2013-2014 онд Дүүргийн иргэний хэргийн анхан шатын 1 дүгээр шүүхийн шүүгч, 2014-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн

шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа туршлагатай.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх.

Нэр дэвшигч Золзаяа нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 156 дугаар зарлигаар Шүүгчийн албан тушаалд томилогдож, өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй шүүгч байх шаардлагын тухайд.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан.

Нэр дэвшигч Золзаяа нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул дээрх шаардлагыг хангаж байна.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал.

Нэр дэвшигч Золзаяа нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоолд заасны дагуу хүчинтэй байгаа 76.71 оноогоор 2 дугаарт, эрэмбэлэгдсэнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан хяналтын шатын шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 2 дугаарт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд ийнхүү танилцуулж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсэгт Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл

Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хуралд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэр дэвшигч Ц.Очийг танилцуулах тухай 01/983, Нэр дэвшигч Э.Золзаяаг танилцуулах тухай 01/984 тоот албан бичгээр ирүүлсэн танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан журмын дагуу Хууль зүйн байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа танилцлаа.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүх засаглал хараат бус байж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэх, гүйцэтгэх засаглалаас шүүгдэгчийн хараат бус байдалд нөлөөлж болзошгүй үйлдэл гарч байгаа эсэх, Шүүхийн ерөнхий зөвлөлд хуульд заасны дагуу шүүхийн хараат бус байдлыг хангах үүргийн хүрээнд ямар ажил хэрэгжүүлж байгаа талаар, нэр дэвшигч шүүгчдийн хөдөө орон нутагт ажиллаж байгаа туршлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нэр дэвшигчийн шүүгчийн аль салбарт эрх зүйн чиглэлээр мэргэшсэн талаар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчийг сонгон шалгаруулалтдаа тодорхой салбар эрх зүйгээр ангилдаг эсэх, шалгалтад тэнцсэн шүүгчийн анхан заагдсан чиглэлээс өөр танхимд шилжүүлэх тохиолдол байдаг эсэх талаар, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг шүүхийн оролцоо, шүүхийн чиг үүрэг, ач холбогдлын талаар нэр дэвшигчид ямар байр суурьтай байгаа талаар, шүүхээс хэрэг буцаахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх нь хэр оновчтой талаар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх нь шүүхийн эрх мэдлийн байгууллагад байх эсэх асуудал дээр нэр дэвшигчээс байр суурийн талаар асуусан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг өмнө нь нэр дэвшиж байсан шүүгч дахин нэр дэвшиж буй шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд шүүхийн индексийн судалгаагаар 2021 онд Монгол Улсын шүүх 100 онооноос 51.94-ийн оноо, 2003 онд 53.22 оноо авсан бол 2025 онд энэ нь Улсын шүүх 100 онооноос 51.4 хувийн оноо, 2023 онд 53.2 оноо авсан бол 2025 онд энэ оноог өсгөх чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөл ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар, шүүхэд итгэх иргэдийн итгэлийн судалгааг сайжруулах, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр ямар ажил хийж байгаа талаар, Шүүхийн шийдвэрийг тодорхой үндэслэл сайтай тайлбарлах зарчмыг хэвшүүлэх чиглэлээр ямар ажил хэрэгжүүлж байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Дээд шүүх нь засаглалын тэнцвэрийг хадгалах чухал институт бөгөөд иргэдийн итгэл нэмэгдэх тусам төрийн тогтвортой байдал Үндсэн хуулийн цэцэд бичих боломжтой талаар, шүүхийн бие даасан байдал хараат бус ажиллагааг хангах нь шударга ёсыг тогтвортой хадгалах талаар, шүүгчид нь олон талын анализ хийж зөв бурууг дэнсэлж итгэл үнэмшилтэйгээр асуудалд хандсанаар шүүхийн нэр хүнд өсөж, нийгмийн үзэн ядалт, улс төрийн савлагаанаас ангид байх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Шүүгчдийн хараат бус байдал, шүүхийн тогтвортой байдлыг хангах талаар, Шүүхийн сахилгын хорооны дарга болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг жил бүр ээлжлэн томилох нь хэр үр дүнтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг дээд шүүх нь эрх зүйн тогтолцооны тогтвортой байдалд нөлөөлдөг бөгөөд шүүхийн шийдвэрээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж чадвал хууль тогтоомжийг засахгүйгээр тогтвортой хэрэгжүүлэх боломжтой талаар, хууль тайлбарлах эрх мэдэл нь Улсын дээд шүүхэд төвлөрөх нь нэн чухал бөгөөд энэ нь хууль тогтоомжийн субъектив байдлаар ашигтай тайлбарлах боломжийг хязгаарлах гол механизм болж буй талаар, эрх зүйн тогтолцооны тогтвортой байдлыг хангадаг талаар, Улсын Дээд

шүүх нь зөвхөн эрх зүйн хэрэглээг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг нэгтгэхээс гадна хууль тогтоомжийг боловсронгуй болгоход манлайлал үзүүлэх шаардлагатай талаар, шүүгч нь нийгмийн дарамтаас ангид, бие даасан байдлаа хадгалж, шударга ёсны зарчмыг тууштай хамгаалах талаар тус тус үг хэлж, байр сууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын дээд шүүхэд нэр дэвшиж байгаа шүүгчтэй танилцсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Цогийн Оч, Энэбишийн Золзаяа нар хүрэлцэн ирсэн байна. Хууль зүйн байнгын хорооноос танилцуулга Их Хурлаар хэлэлцүүлэхээр ирээд бараг 2 долоо хоног өнгөрсөн. Дандаа яаралтай асуудлууд орж ирсэн учраас асуудал бас орж танилцагдаж амжихгүй явж өнөөдөр ирлээ.

Тийм учраас өнөөдөр бас гишүүдийн олонхын саналаар өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцэж дуусгая гэж ингэж шийдсэн байгаа гэдгийг бас дахин тодруулж хэлье.

Одоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 2 гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Өнөөдөр үгүй ээ, бас Монгол Улсын төр чинь ерөөсөө ард түмнээс сонгогдсон Улсын Их Хурал өнөөдөр Улсын Их Хурал шиг байна. Бас өдөр, шөнөгүй гадаа байгаа олон асуудлыг ярилцаад шийдвэрлэе. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуулт байгаа. Нэр дэвшигчээс асуулт байна. Энэ шүүх засаглал. Энэ чинь юу шүү дээ. Бид нар чинь олон жил ингээд л баахан социализмаар явчихсан. Тэгээд шүүх засаглал гэдэг утгаа нэг их сайн ойлгохгүй байгаа юм. Энэ хүмүүсийн цалин нь бага байх ёстой, шударга ёс хамааралгүй байх ёстой юм шиг тийм ойлголтыг өгөөд байдаг. Энэ одоо болохгүй л дээ. Өнөөдөр улсын төсвийн тодотгол ярьж байна. Энэ шүүхийн урсгал зардал энэ бүх юмыг бид нар хасах ёсгүй шүү. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс юу орж ирж байна. Тэрийг нь хянаад, шалгаад, батлаад явах ёстой шүү. Энэ дээр анхаарах ёстой. Энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөл тэр тайлбараа хийгээрэй. Нөгөө талаар энэ сонгон шалгаруулалтаа яаж авав. Хэчнээн олон хүн өрсөлдөөд, хэдэн хүн тэнцэж байна. Улсын Дээд шүүхэд. Тэр нөөцөөс орж ирнэ гэдэг нь ямар учиртай юм бэ. Хэзээний шүүгч нар хэзээ орж ирээд байгаа юм. 1 ийм асуулт байна.

Нэр дэвшигчээс асууя. Бид нар ил тод байдлын талаар баталсан өнгөрсөн хугацаанд. Ер нь шүүгч нар бол маш их эрхээ хасуулдаг. Тэр орцонд ч юм уу, лифтэнд оцгоноод явж болохгүй. Тийм ч учраас шударга ёс үнэтэй. Харж байгаа. Ил тод нээлттэй байдлын талаар сүүлийн үед ер нь ямар байна вэ. Тэр болгон шүүгч нартай асуугаад, яриад байх боломж байхгүй. Бид нар протоколтой уулзаж байх ёстой. Хууль тогтоох засаглал бол. Ингээд гүйцэтгэх засаглал янз бүрийн байдлаар их дайрдаг. Хууль хэрэглээний байдал ямар байна вэ. Анхан, давж заалдах нь асуудлыг шийдчихсэн байдаг. Гэтэл хяналтын шат нь шал өөрөөр шийдэх юм. Энэ ямар учиртай, яагаад ингэдэг юм бэ. Энэ орж ирж байгаа авлига, хулгай энэ тэр

юмны шийтгэл нь яагаад ийм бага байдаг юм бэ. Шударга ёс яагаад тогтохгүй байна вэ. Би нэгэнт болчихсон хэргийн талаар асуугаад байгаа шүү. Тэр нүүрсний хэрэг, ногоон автобус, ард түмний хулгай луйвар ингээд явчихсан байхад тэр шударга ёс байх ёстой шүүх дээр шал эсрэгээрээ шийдчихсэн ч байдаг юм уу ийм байх юм. Энэ одоо хэн нь буруутай гэж үздэг вэ та нар гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Мөнгөнцэцэг. 3 дугаар индрээс хариулт өгье.

Н.Мөнгөнцэцэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн төсвийн тодотголтой холбоотой байр суурийг асууж байна.

2 дугаарт, сонгон шалгаруулалтын талаар, мөн нөөцөөс нэр дэвшигч гээд ямар утга учиртай вэ гэдэг талаар ийм 3 асуулт асуулаа гэж ойлголоо.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2021 онд Шүүхийн хууль шинээр батлагдаж, бид хэд Монгол улс, өөрөөр хэлбэл шүүхийн шинэтгэлд бол эргэлт буцалтгүйгээр орсон. Мөн 2024 оны шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурал шүүхийн шинэтгэлийг дэмжиж, томоохон өөрчлөлтүүдийг бол хийсэн.

1 дүгээрт бол шүүхийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр шүүх байгуулах тухай хуулиа бол баталсан. Үүнд шүүхийг тойргийн зарчмаар, мөн дагнасан шүүхийн тогтолцоог байгуулахаар бий болгосон. Үүнд, орон нутаг дахь, аймаг дахь шүүхүүд маань бол ердийн журмаар, нийслэл дэх шүүхүүд маань бол тойргийн журмаар байгуулагдсан. Мөн түүнчлэн дагнасан шүүх буюу хялбар ажиллагааны шүүхийн иргэн, иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатын тойргийн шүүхийг бол байгуулсан байгаа. Мөн 2026 оны 1 сарын 1-ээс Гэр бүл, хүүхдийн шүүхийг байгуулахаар бид хэд анхан болон давж заалдах шатны шүүхийг байгуулахаар бэлтгэл ажлаа бол хангаад байж байна. Тэгээд энэ өөрчлөлтүүдтэй холбоотойгоор төсөв бол сайн батлагдсан гэж үзэж байгаа. Тэгээд энэ ажлыг дэмжиж, бид нартай хамтран ажиллаж байгаа Их Хуралдаа бас талархах нь зөв байх.

Гэвч энэ 2025 оны төсвөөс одоо тодотголоор Гэр бүл, шүүхийн асуудал, цахимжилт мөн түүнчлэн ил тод, нээлттэй байдлыг хангах хүрээнд шүүх хуралдааныг нээлттэй явуулж байгаад энэ ажлыг хангах хүрээнд бол тоног төхөөрөмж болон эд хогшил, урсгал засвар, тоног төхөөрөмжийн зардлыг бол тансан, хассан ийм үзүүлэлт бол байгаа. Мөн түүнчлэн цахимжуулалттай холбоотой өндөр хурдны сканер, тоон гарын үсгийн тоног төхөөрөмж, сүлжээний ажлууд зэрэг тоног төхөөрөмжийг бол хассан байгаа. Бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээ дээр яг шүүхийн яг шүүн таслах ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны үндсэн зардал бол иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, орчуулагч, шинжээчийн зардлыг бол хассан ийм үзүүлэлт байгаа. Мөн түүнчлэн орон тоо, хүний нөөцтэй холбоотой цалин хөлс, урамшууллыг бол хассан.

Бусад байгууллагаас ямар ялгаатай юм бэ гэхээр энэ дээр бол заавал хэлэх ёстой 1 асуудал байгаа. Шүүгчийн сонгон шалгаруулалтын тухайд бид нар 2022 оноос хойш нийтдээ 9 удаагийн сонгон шалгаруулалт явуулж байна. Ингээд 53 дугаар тогтоолоор бол нийт 699 шүүгч байх ёстойгоос бид 2025 оны төсөвт 624 шүүгчийн цалин урамшууллыг төсөвт батлуулж чадсан. Гэвч энэ төсвийн

тодотголоор яах аргагүй шүүгчийн орон тооноос хасахаар орж ирж байгаа. Асуулт гарч ирж байна. Яагаад шүүгчийнхээ орон тоог нөхөж чадахгүй байгаа вэ гэхээр 9 шүүгчийн сонгон шалгаруулалт болоход нийт 10 хүрэхгүй хүн энэ сонгон шалгаруулалтад тэнцэж байна. Тэгээд сул орон тооны нөхөн бүрдүүлэлт бол шүүгчийн тухайд болохоор 36 хувь байгаа гэж хэлж болно. Захиргааны ажилтны тухайд бас мөн асуудал дагуулаад, 216 захиргааны ажилтныг цомхотгохоор, 216 ажилтны цалин, урамшуулалтыг хасахаар орж ирж байна.

Тэгээд захиргааны ажилтны тухайд бол 2000/минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Эрхэм гишүүд ээ, би та бүхнээс нэг анхаарал хандуулахыг хүсэж байна. Өдөр болгон энэ шүүгч гэдэг хүмүүст Дээд шүүхийн шүүгчээр томилогдоод байдаггүй учраас та бүхэнд жоохон хүндэтгэлтэй хандмаар байна. Энх-Амгалан прокурор энэ танхимд хэлж байсан юм. Энэ танхимаас шударга ёс, ёс зүй жишээ татагдаж байх ёстой гээд. Та бүхэн энэ Дээд шүүхийн шүүгч томилогдож байх энэ процесс дээр нь яг өөрсдийнхөө бодит жишээг харуулж байна шүү дээ. Би хууль зүйн сургуульд сурч байхад Хуульчийн ёс зүй гэдэг хичээл дээр прокурорын ёс зүй, хуульчийн ёс зүй гэдэг журам эд нарыг судалж байсан. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн үүдэнд Хуульч хүн хүн байх ёстой гэдэг нэг ийм Чимэд гуайн эшлэл үг байдаг. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бид хүний танилцуулгыг сонсож чадахгүй байна шүү дээ. Хууль зүйн сайдаа, Мөнхбаатар сайдаа, танай салбарынхан томилогдох гээд анхаарал хүсээд байхад анхаарч чадахгүй байна шүү дээ. Энэ бол маш ноцтой, юу гэдэг юм хүнээ хүндэтгэхгүй байгаагийн жишээг бид нар харууллаа шүү дээ. Тэгээд санал хураахгүй өнөөдөр, зүгээр сонсоод эдгээр хүмүүсийг гаргах ёстой. Ер нь цаашдаа ч энэ Улсын Их Хурлаар прокурор томилох, АТГ-ын дарга томилох, шүүгчийг томилох бол хараат бусаар бид нар санал хураахгүй шууд ер нь томилоод явж байх ёстой.

Тэгээд би нэр дэвшиж байгаа, энэ салбартаа олон жил ажилласан, үр дүн гаргасан, шалгалтаа давсан энэ хуульчдад амжилт хүсье. Тэгээд ялангуяа саяын энэ зүй бус үйлдэл гаргасан этгээдүүдээс буюу энэ улс төрчдөөс хараат бус байгаарай гэж захимаар байна. Хуульчийн тавигдах хамгийн том шалтгаан нь бол хуульч хүн бол шүүгчийн ёс зүй, дээрээс нь хүн байх ёстой гэдэг дээр анхаарах ёстой гэж харж байгаа юм. Тэгээд та бүхэнд амжилт хүсье. Асуулт алга. Асуулт асуух ямар ч тийм асуулт асуугаад, хариулт авах тийм нөхцөл алга байна шүү дээ. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Батбаатар: Сая ер нь асуулт асууж, үг хэлэхээ больчихдог юм уу гэж бодож байгаад асуухгүй бол болохооргүй болчих шиг боллоо. Парламент бол бага ард түмэн. Бас энэ үгийг бүгдээрээ мэднэ. Аль нэг үгээр нь нөгөөдхийг нь нэгээр нь нөгөөдхийг нь унагаадаг байж болохгүй. Тэр утгаараа танилцаж байна гэдэг утгаар томилгооны асуудал Улсын Их Хурал дээр байхгүй. Шүүгчид дээр. Танилцаж байх нь буюу энэ шүүх, прокурор, авлигатай тэмцэх газрын хүмүүс орж ирэхэд Улсын Их Хурлын гишүүд ер нь ихэнх нь бүгдээрээ амжилт хүсдэг юм шүү дээ. Шүүмжлэл юм уу, санал юм уу алтернатив хувилбар хэлж өгдөггүй шүү дээ. Бодвол өөрсдөд нь асуудал байдаг ч юм уу, байдаггүй ч юм уу, алга таших маягтай, гоё сайхан амжилт хүсэх маягтай үг хэлдэг.

Дээд шүүхийг би Дээд шүүх шүүх үүргээ гүйцэтгэхээс гадна хуулиар олгогдсон зарим өөр үүргийг гүйцэтгэдэг. Тэр нь юу вэ гэхээр улс төрийн намуудад жишээлэхэд бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүртгэлийн үйл ажиллагаа явуулахдаа Дээд шүүхийн бүх гишүүдийн хурлаар журам гаргаад, журмаараа хэлэлцүүлж асуудлаа шийддэг. Шүүх засаглал бол улс төрөөс их хол байх ёстой засаглал. Улс төрийн намын бүртгэлийг аваачаад наачихсан нь зөв, буруу гэдэг маргаан бол байнга байж байдаг. Тэгэхээр энэ улс төрийн намуудын бүртгэлийн асуудлуудыг журам нь сүүлийн жилийн дотор 2, 3 өөрчлөгдсөн. Хамгийн сүүлд Ардчилсан намтай нэгдэж нийлж байсан шинэ намыг бүртгээгүй. Тэгэхээр нөгөө улс төрийн намын дотоод юм уу, тэр шийдвэр гаргалтын процесст нь оролцоод байх нь өөрөө их тийм асуудал дагуулна. Хууль тогтоогчдыг бүрдүүлж байгаа газар бол улс төрийн нам. Дээд шүүх энэ бүртгэлийн үүрэг дээрээ нөгөө шүүх байгууллага учраас өөр хүмүүс давах аргагүй эцсийн шийдвэр болчихдог. Энийг хуульчлах процесс дээр та бүхэн анхаарах уу. Энэ талд нь бас илүү ойлгомжтой болох чиглэл рүү байхгүй бол ингээд журмууд нь өөрчлөгдөөд байхаар бас буруу юм гэж ингэж бодож байна.

Тэгээд та бүхний тодорхойлолт дээр орж ирж байгаа үг нь бол сүүлийн 6 жил улс төрийн намын харьяалалгүй байсан хүмүүсийг тодорхойлж оруулж ирдгийг бол тодорхойлолт дээр бичээтэй байдаг. Тэр утгаар нь би Улсын Их Хурлын дарга ч гэсэн захирамж гаргаад ажлын хэсэг байгуулаад, Их Хурал ажлаа хийгээд энэ процессын хуулийг ч гэсэн цэгцэлмээр байгаа. Одоо энэ жил бүх намууд хуралдана. Бүгдээрээ Дээд шүүх дээр материалаа аваачиж өгнө. Ямар нэг байдлаар улс төрийн нөлөөлөл орчихвол энэ чинь утгаа алдана.

Д.Амарбаясгалан: Шүүхийн ерөнхий зөвлөл бас энэ гишүүдийн хэлж байгаа саналууд дээр анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй. Пүрэвдаваа гишүүний хэлдэг үнэн. Дээд шүүхийн шүүгч нарын асуудал өдөр болгон парламентаар орохгүй. Парламентаар орж ирж байгаа энэ цаг үе дээр Улсын Их Хурлын гишүүд ард иргэдийн хүсэж байгаа тэр шударга ёсыг хангах, шүүх алагчлалгүй ханддаг байх тэр зарчмыг хэрэгжүүлэх тал дээр гишүүд яалт ч үгүй үгээ хэлэх ёстой. Орон нутгаас болон тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, мөн жагсаалтаар сонгогдсон гишүүд сегментийн уулзалтууд хийгээд явахад шүүх засаглалын илүү шударга зарчимтай ажиллах ийм шаардлагуудыг бас их тавиад байдаг.

Гэхдээ мэдээж энэ нь өөрөө зөвхөн шүүхээс хамаарсан асуудал бас биш байдаг. Эрх зүйн орчин ажиллах нөхцөл, хараат бус байх тэр боломж зэргийг бүрэн хангаж өгсний үндсэн дээр эдгээр асуудал хангагдах нэг чухал үзүүлэлт юм байна гэдэг талаасаа нэг хардаг. Нөгөө талаасаа ард иргэдийн зүгээс манай хуулиуд хэтэрхий их ерөнхий. Энгийн иргэн уншаад ойлгох хэмжээнд байхгүй байгаа учраас хуулиар өөрийгөө хамгаалуулах боломжийг гаргаж чадахгүй байна гэдэг асуудлыг байнга ярьдаг.

Тэгэхээр энэ хоёр асуудал дээр анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай. Өнөөдөр Улсын Их Хурлаар хууль тогтоомжийн хууль батлагдсан. Нэмэлт, өөрчлөлт орсон. Үндсэн зорилго өдөр тутамд нийгмийн харилцааг зохицуулж байгаа хуулиуд нь иж бүрэн зохицуулалтаа өөрөө хийж чаддаг болох ёстой л гэдэг зорилгыг тавьж байгаа юм. Нэг ёсондоо хууль дагасан, хуулиас давсан эрх мэдэл хэрэгжүүлдэг журам гэдэг зүйл байхгүй болох ёстой. Хууль нь иж бүрэн зохицуулалтаа хийлгэдэг, энгийн хуульч биш иргэн хуулиа уншаад ойлгож, өөрийгөө хамгаалуулж чаддаг байх тэр нөхцөл боломжийг бүрдүүлэх ёстой гэдэг үүднээс бид

энэ Хууль тогтоомжийн хуульд том өөрчлөлтийг хийж чадсан. Энэ бол хууль зүйн салбарт том философийн өөрчлөлт орох эхлэл суурь тавигдсан гэж Их Хурлын зүгээс үзэж байгаа.

Миний хувьд Улсын Их Хурлын даргын хувьд Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг Шүүхийн ерөнхий, Шүүхийн сахилгын хороо 2-т үүрэг өгсөн байгаа. Улсын Их Хурлын тавьж байгаа энэ зорилго стратегийг хэрэгжүүлэхийн тулд шүүх байгууллагын түвшинд хэрэглэгдэж байгаа хуулиас давсан журмуудыг хуульд шингээх ажлыг хамгийн түрүүнд гардаж авч хийх ёстой гэдэг шаардлагыг тавьж байгаа юм. Ингэж байж шүүх засаглал ард иргэдэд шударга, эрх тэгш үйлчлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж өгнө гэдэгтэй та бид бүгд санал нэг байгаа. Тэгэхээр энэ дээр шинээр бас өнөөдөр танилцуулагдаж байгаа шүүгч нар бас Ерөнхийлөгчөөс томилгоо аваад ажилласан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл энэ Улсын Их Хурлын өмнөө тавьсан стратегийг хэрэгжүүлэхийн төлөө энэ үүрэг даалгаврыг албан ёсоор авч ажиллах ёстой гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүдийн үгэн дээр бас нэмж хэлэхийг хүсэж байна.

Шүүгч нарыг бүгд шударга бус ажиллаад байна гэж ард түмэн дүгнээд байдагтаа биш. Ерөөсөө шүүх засаглалын түвшинд хэрэглэгдээд байгаа хуулиуд нь иргэнийхээ эрхийг хамгаалахад бүрэн дүүрэн байна уу гэдэг дээр л ард иргэд эргэлзээд байдаг гэдгийг та бүхэн маань бас их сайн ялгаж, субъектив биш илүү объектив байдлаар нь авч асуудалд хандаж ажиллаарай гэдгийг бас Та бүхэнд хүсье.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцлаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өндөрлөснийг мэдэгдье.

00.26 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ